ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ



АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР

НЭГДҮГЭЭР БОТЬ



Бид Авид бурхантай адил гэрэл гэгээтэй, гэгээрсэн байх ёстой. Очирваань бурхантай адил билиг ухаантай, хүч чадалтай байх ёстой. Арьяабал бурхантай адил энэрэнгүй сэтгэлтэй байх ёстой.

(“Арьяабалын аргаар бясалгахын ач тус” айлдвараас)



Чин Хайн өдрийг тэмдэглэх үеэр Их Багш маань бясалгагчдын хамт цаасан бууны солонгорсон үзүүлбэрийг сонирхож байгаа нь. Формосагийн бясалгалын төв. 1995.10.25.

Жинхэнэ сүнслэг дадал бясалгал хийдэг хүний хувьд газар бүхэн дивааажин, хаа сайгүй ариун орон болно.

(“Үйл түйтгэр хаанаас үүсэлтэй вэ?“ айлдвараас)



Их Багш маань Хятадын Чин улсын Эзэн хааны хувцсаар гоёод олонтой хамт баяр тэмдэглэж байгаа нь. Хятадын цагаан сар. 1995 он.

Та нар бол ханхүү. Тиймээс өвөрийн ордныг хайж олоод хаан болох хэрэгтэй.

(“Унэн ёс ба худал ёс” айлдвараас)

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР

Нэгдүгээр боть

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг

АГУУЛГА

Намтрын өмнөх үг 5
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн товч намтар 6
Өмнөх үг 10
Үнэн ёс ба худал ёс 11
Чанагуух ертөнцийн аялгуу 30
Чанагуух ертөнцийн гэрэл 46
Цэцэг дэлгэрвэл Бурханыг харна гэдгийн учир 68
Арьяабалын бясалгалын аргаар бясалгахын ач тус 82
Үйл түйтгэр хаанаас ирсэн бэ? 103
Аливаа сүнслэг дадал бясалгалын арга бүгд Арьяабалын бясалгалын арга мөн 122
Билгийн мэлмийн нууц 141
Асури төрөлтөн 160
Гэгээрэх гэж юу вэ? 183
Бурхан гэж хэн бэ? 201
Гурван ертөнцийн доторх тойм байдал 223
Буян хийж, өглөг өгөх нь туулан ангижруулж чадахгүй 242
Бурхандмөргөөд Бурханболжчадахгүй 256
Багш асуултад хариулж байна 271
Авшиг хүртэхүй- Арьяабалын бясалгалын арга 279
Таван сахил 281
Веган хоолны ач тус 282
Эрүүл мэнд ба хоол хүнс 283
Экологи ба хүрээлэн буй орчин 286
Дэлхийн өлсгөлөн 287
Амьтны зовлон зүдүүр 287
Гэгээнтнүүд ба Үйлс нэгтнүүд 288
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном хэвлэлийн жагсаалт 290
Бидэнтэй хэрхэн холбогдох вэ? 294

НАМТРЫН ӨМНӨХ ҮГ

Ихээр билиг нээгдсэн нэгэн Их Багшийн дэсийг эгэл хүний чадвар ба энэ ертөнцийн үг хэлээр илэрхийлэх боломжгүй байдаг. Түүний бүхий л амьдрал, үзэл санааг хичээнгүйлэн тодорхой дүрсэлсэн ч бүрэн гүйцэд өгүүлэх аргагүй. Эрт цагт Энэтхэгийн нэгэн бясалгагч Багшийнхаа намтар түүхийг бичихээр томилогджээ. Хэдэн сарын дараа бичиж дууссан эсэхийг түүнээс асуухад дуусаагүй гэв. Дахин хэсэг хугацаа өнгөрсний дараа мөн л асуухад: “Миний багш эгэл ертөнцөөс хэтийдсэн төрөлтөн болохоор түүний дэсэд хүрч байж л би Багшийнхаа дүрстэй, дүрсгүй ажлыг жинхэнээр ойлгож чадна. Тийм болохоор энэ ажлыг хэзээ ч дуусгах аргагүй юм.” гэжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн урьдын амьдралын түүхээ дурдсан нь тун бага. Гэвч олон орны шавь нар нь Багшийнхаа намтрыг ихэд сонирхож, янз бүрийн асуултыг давтан тавьдаг учраас өөрийн түүхээ ярихаас өөр аргагүй болдог билээ. Энэхүү товч намтарт Их Багшийн амьдралын замнал, түүхээс нь эмхэтгэн цуглуулж, найруулан бичсэн байна. Иймээс бүрэн гүйцэд биш байхыг үгүйсгэх аргагүй тул хүлцэл өчье.

ТОВЧ ИЛГЭЭЛТ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай нь уран бүтээлч, оюун санааны агуу хөтчийн хувьд сүнслэг гоо сайхныг илэрхийлэх бүхий л хэлбэрт дуртай. Иймээс Тэрээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” гэж нэрлэдэг. “Ау Лак” нь Вьетнамын эртний нэр бөгөөд амар амгалан амьдрах гэсэн утгатай. Харин “Формоса” (үзэсгэлэнтэй сайхан) гэдэг нэр энэхүү эрдэнийн арал болоод ард түмнийх нь гоо сайхныг бүрэн дүүрэн илэрхийлнэ. Эдгээр нэр нь тухайн газар нутаг, ард иргэдэд сүнслэг дэвшил, буян хишгийг авчирна гэж Их Багш үздэг юм.

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ТОВЧ НАМТАР

ХАЙР ЭНЭРЛИЙН ЗАМ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол дэлхий дахинаа алдар суу нь түгсэн оюун санааны их удирдагч, уран бүтээлч, хүмүүнлэгийн үйлстэн юм. Их Багшийн хайр энэрэл хүн төрөлхтний соёл, ёс заншлын хил хязгаарыг давж, дэлхий даяар түгж байдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Ау Лакын (Вьетнам) төв нутагт мэндэлж, Европт очиж суралцсан бөгөөд тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт ажилласан байна. Тэрээр энэ хугацаанд дэлхий дахин зовлон зүдүүрээр дүүрэн байгааг даруй олж мэдээд үүнээс ангижрах арга замыг эрэн хайхаар шийдсэн нь Түүний амьдралын эрхэм дээд зорилго болсон байна.

Тэрбээр тухайн үед герман эмчтэй гэр бүл болж, аз жаргалтай амьдарч байсан ч тус тусын зам мөрийг хөөх хэн хэндээ амаргүй шийдвэрийг гаргаж, нөхрийнхөө чин сэтгэлийн ерөөлийг өвөрлөн, өөрийн зорилгоо биелүүлэх аяндаа морджээ. Ийнхүү Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай үнэнийг эрэн хайж, сүнслэг гэгээрлийн зам мөрөөр замнаж эхэлсэн байна. Эцэст нь Энэтхэгийн Хималайн ууланд нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш түүнд дотоодын Гэрэл ба Аялгууг ажих “Арьяабалын Бясалгалын Арга”-ыг уламжилжээ. Ийнхүү тэрбээр хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасны эцэст Төгс Гэгээрэлд хүрчээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гэгээрлийн сургаал номлолыг удирдлага болгосон Олон улсын нийгэмлэг 1980 онд байгуулагджээ. Хүмүүсийн чин сэтгэлийн хүсэлтээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг уламжилж, тэднийг өөрийн дотоод дахь бурханлаг чанараа нээн илрүүлэхэд нь дэмжин зоригжуулж эхэлсэн юм. Удалгүй Америк, Европ, Ази, Австрали, Африк зэрэг таван тив ба Нэгдсэн

Үндэсний Байгууллагаас Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг ном тайлуулахаар урин залах болжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэрэн нигүүлсэх сэтгэлээрээ зовж зүдэрсэн олонд бүх талаар хайр энэрэл, тус дэмжлэг үзүүлдэг бөгөөд Түүний хүмүүнлэгийн ажил нь бүхий л хориг саадыг даван туулж, дэлхийн өнцөг булан бүрийн орон гэргүй ядуучууд, дорой буурай амьдралтай өндөр настнууд, шоронгийн хоригдлууд, хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой иргэд, дүрвэгсэд, Америкийн ахмад дайчид зэрэг хүмүүст түгэн хүрчээ.

Дулаарлаас үүдэлтэй элдэв хямрал дэлхий дахинд нүүрлээд байгаа өнөө үед Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өгөөмөр сэтгэлээр олон сая долларын хүмүүнлэгийн тусламжийг үзүүлдэг бөгөөд байгалийн элдэв гамшигт нэрвэгдэгчдэд туслуулахаар нийгэмлэгийнхээ гишүүдийг дэлхийн бүхий л оронд илгээж байна. Үүнээс гадна Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэ дэлхийд бидэнтэй зэрэгцэн оршигч эрхэм ариун амьтад болон хүрээлэн буй орчны асуудалд ихэд санаа тавьдаг билээ.

Их Багшийн энэрэл хайр, асрал нигүүлсэл олон сая хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, бусдын төлөөх харамгүй сайхан сэтгэл нь тэдний даган дуурайх үлгэр жишээ болж байна. Их Багш өөрийн уран зураг, дэнлүү чимэглэл, хувцасны загвар, үнэт эрдэнийн гоёл зэрэг урлагийн бүтээлүүдийнхээ орлогоороо тусламж хэрэгтэй Эзэн Бурханы үр хүүхдүүдийг дэмжин тэтгэдэг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн жилүүдэд бичсэн “Шувууд миний амьдралд”, “Миний амьдрал дахь ноход”, “Эрхэм ариун амьтад” хэмээх гурван ном нь дэлхийн хамгийн их борлуулалттай номоор шалгарч, олон хэлээр орчуулагдаад байна. Их Багш телепат холбоо болон сүнслэг ажиглалтаараа эрхэм ариун амьтдын сэтгэл хөдлөл, бодол санааг гүн гүнзгий ойлгож, тэдний эрхэм дээд санаа зориг, хэзээ ч хариу үл нэхэх өгөөмөр хайрыг эдгээр бүтээлүүддээ тод томруун тусган харуулжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш хүмүүст үлгэр дуурайл болох зөв ёс зүйтэй сайн үйлсийг урамшуулан сайшааж 2006 оны 3 сард “Дэлхийн Гэрэлт Манлайлагч” шагналыг, мөн удалгүй “Дэлхийн Гэрэлт Баатарлаг Үйлстэн”, “Дэлхийн Гэрэлт Нигүүлсэнгүй Үйлстэн+”, “Дэлхийн Гэрэлт Шударга Үйлстэн”, “Дэлхийн Гэрэлт Зохион Бүтээгч” зэрэг олон цол шагналуудыг бий болгожээ. Эдгээр нэр төртэй шагналыг хувь хүн, албан байгууллага, улс орнуудад олгодог бөгөөд тэдний үлгэр дуурайлтай ажил үйлс нь манай гарагийг улам гоо үзэсгэлэнтэй, эв зохиролтой болгож,

дэлхийн тогтвортой хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна. Тухайлбал: Словени Улсын хоёр дахь Ерөнхийлөгч доктор Янез Дрновшек, АНУ-ын 45 дахь Дэд ерөнхийлөгч, 2007 оны Нобелийн Энх тайвны шагналт, НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны гишүүн Аль Гор, НҮБ-ийн Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны тэргүүн бөгөөд Энэтхэг улсын Эрчим Хүч, Эрдэс Баялгийн Хүрээлэн (TERI)-гийн тэргүүн, НҮБ-ын Хүний суурьшлын хөтөлбөрийн 2010 оны шагналт, доктор Ражендра К.Пачаури, АНУ-ын Сансар Судлалын Үндэсний Төвийн (НАСА) тэргүүн, 2009 оны Карл Густаф Россби судалгааны шагналт, доктор Жэймс Е Хансен, Английн нэрт доктор, бичний овгийн хөхтөн амьтан судлаач Жэйн Гуудал нарын олон хүн эдгээр шагналыг хүртсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай амиа үл хайрлан аюул эрсдэлийг сөрж, бусдын амь насыг аварсан бидний эрхэм анд нөхөр амьтдын баатарлаг үйлсийг нь сайшаан “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт Оюун Ухааны шагнал”-ыг олгодог бөгөөд үүгээр амьтдын баатарлаг зориг, сэргэлэн ухаан, хайрын сэтгэлийг илчлэн харуулдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн хөгжил дэвшилд оруулсан сүнслэг болон материаллаг асар их хувь нэмрийг олон улс орны төр засгийн газар, хувийн байгууллагууд өндрөөр үнэлэн шагнаж хүндэтгэлээ илэрхийлсэн байна. Тухайлбал: Гуси Энх Тайвны шагнал (2006 он), Теллигийн 27 дахь жилийн шалгаруулалтын Мөнгөн Эрдэнийн тэргүүн шагнал (2006 он), Лос Анжелесын Хөгжмийн Долоо хоногийн Сайшаалын гэрчилгээ (2002 он), Дэлхийн Оюун Санааны Удирдагчийн шагнал (1994 он), Дэлхийн Хүний Эрхийг Дэмжигчийн Шагнал (1994) зэргийг дурдаж болно. Түүнчлэн АНУ-ын төр засгаас жил бүрийн 2 дугаар сарын 22 болон 10 дугаар сарын 25-ны өдрүүдийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” болгон тэмдэглэж байхаар зарласан юм. Их Багшийн дэлхийд өргөсөн тусламж, түүний бие сэтгэл харамгүй их үйлсийг олон орны төрийн тэргүүн, ард иргэд өндөр үнэлэн талархлаа илэрхийлсээр байдаг билээ.

Их Багш Чин Хай бол өөрийн билиг ухаан, баатар зоригоороо цаг уурын өөрчлөлтийн сэдвийг зоригтой хөндөж тавьсан өнөө үеийн хүрээлэн буй орчныг хамгаалагчдын манлайлагч юм. Үнэн хэрэгтээ хориод жилийн өмнөөс хүрээлэн буй орчныг хамгаалахыг уриалж байсан бөгөөд “Та ийм амьдралыг сонгож болно.”, “SOS-дэлхийн дулаарлыг зогсоох нь.” зэрэг үйл ажиллагааг

санаачлан эхлүүлжээ. Түүнчлэн дэлхийн цаг уурын өөрчлөлтийн хуралд зочин илтгэгчээр оролцож, дэлхий ертөнц дээр өнөө үед тасралтгүй гарсаар байгаа байгалийн гамшгийн үндсэн шалтгаан болон түүнийг шийдвэрлэх гол арга болох нигүүлсэнгүй веган амьдралын хэв маягийг сонгоход олны анхаарлыг хандуулж байна.

Олон нийтэд хэдийнээ танил болсон “Веган болж, энх тайвныг цогцлооё.” хэмээх уриаг Их Багш Чин Хай дэвшүүлсэн билээ. Хоол хүнсний сонголт нь цаг уурын өөрчлөлтөд асар их нөлөөтэйг үндэслэн энэрэнгүй, тогтвортой амьдралын хэв маягийг сонгоход нь хүмүүст туслахын тулд “Loving Hut” веган хоолны сүлжээ ресторанууд Их Багш Чин Хайн урамшуулал дэмжлэгээр амжилттай өргөжин тэлсээр байна. Олны таашаалыг хүлээсэн энэ хоолны газрууд дэлхий даяар тархаж, олон төрлийн эрүүл тэжээллэг, хямд үнэтэй, амтлаг веган хоолоор үйлчилдэг. Гараг ертөнц, түүний оршин суугчид, зэрэгцэн оршигч төрөлтнүүд болоод бидний үр хойчийг дэлхийн дулаарлаас үүдсэн сүйтгэгч нөлөөнөөс аврахын тулд үүний эсрэг хамгийн үр дүнтэй арга болох эрүүл энэрэнгүй хоол хүнсийг дэлгэрүүлж байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүн төрөлхтөнд хосгүй гайхамшигт энэ гараг дэлхийдээ гэрэлт ирээдүйгээ цогцлоох үйлсэд нь амь биеэ огоорон, эцэс цуцалтгүйгээр тусалсаар байгаа билээ.

ӨМНӨХ ҮГ

Их Багш Чин Хай гүн утгатай, ойлгоход хэцүү үг хэллэг хэрэглэхээс ямагт зайлсхийж, хамгийн ойлгомжтой яриан хэлбэрээр ном тайлдаг. Түүний ном хэвлэлүүд нь уран яруу илэрхийллийг бус уншихад хялбар ойлгомжтой байхыг урьтал болгодог. Их Багшийн адислалын хүчийг бууруулахаас эмээж түүний шавь нар эгэл хүний ухаанаар номын агуулгыг өөрчилдөггүй.

ҮНЭН ЁС БА ХУДАЛ ЁС

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар. Формосагийн Тайбэй хотын Цаглашгүй гэрэлт бясалгалын төв. 1986 оны 10 дугаар сарын 20

(Эх нь хятад хэлээр)

Ном дэлгэрүүлэхэд энэ биедээ найдна, унаа тэргэндээ найдна. Тэгээд ирж ном сонсох хамаг амьтанд найдна. Хамаг амьтан ном сонсохоор иртэл тэрэг маань хөдлөхгүй болчихож мэднэ. Тэрэг маань хөдөлж байсан ч жолоодох хүнгүй болчихож магадгүй. Жолоодох хүнтэй, сонсох хүнтэй ч Багш нь өвдсөн байж мэднэ. Багш нь өвдсөнөөс болоод номоо тайлаагүй удаа байсныг та нар сонссон уу? Үгүй байх аа. Зарим үед өвчтэй байсан ч заавал гарч ном тайлдаг. Тиймээс та нар сонсоогүй. Энэ дэлхий дээр ном дэлгэрүүлэх нь тийм ч амар бус, учир нь дээрх бүх зүйл Маягийн материалаас үүссэн.

"Маягийн материалаас үүссэн" гэдгийн учир юу вэ? Энэ нь бидний бие махбод, хоол унд, хувцас хунар энэ бүхэн Маягийн хүч буюу оршихуйн сөрөг талаас үүдэлтэй гэсэн үг. Ном дэлгэрүүлэхийн тулд бид энэхүү сөрөг хүчээр бүтсэн зүйлсийг ашиглах ёстой болдог тул энэ хэцүү. Ном гэж юу вэ? Тодорхой тайлбарлахад бэрх. сайндаа л жаахан дөхүүлэн ярьж болох нүдэнд харагдахгүй гарт баригдахгүй зүйл. Учир нь чанагуух ертөнцийн тухай Үнэн буюу Номыг энэ ертөнцийн үг хэлээр илэрхийлэн тайлбарлах нь угтаа боломжгүй зүйл юм. Иймээс энэ бие махбод болон бусад материаллаг зүйлийг ашиглан ном дэлгэрүүлэх нь хялбар бус. Ихэнх материаллаг зүйлс нь билиг ухааны түвшнийх биш тул тэдгээрийг ашиглан агуу их амьд сургаалийг илэрхийлэхэд үнэндээ боломжгүй.

Нэгдүгээрт, ном тайлж буй хүн өөрийн бие махбод гэх болхи багажийг ашиглан хязгааргүй их билиг ухааныг тайлбарлах нь хэдийнээ тун хэцүү хэрэг. Нөгөөтэйгүүр, сонсож буй хүмүүст ч энэхүү эрхэм дээд, сэтгэшгүй ном сургаал хийгээд агуу билиг

ухааныг ойлгоход бас амаргүй. Ном тайлахад надад амаргүй, ном сонсоход та нарт амаргүй, хоёуланд нь хэцүү болохоор Үнэн ёсыг ойлгоход үнэхээр бэрх.

Тиймээс Үнэн ёсыг ойлгохыг хүссэн хэн боловч билиг ухаанаа дайчлан байж л ухаарч, хүртэх учиртай. Үнэн ёсыг үг яриа хэрэглэн уламжлах аргагүй, заавал билгүүн чанараар "Сэтгэлээр сэтгэлд уламжлах" ёстой. Бурханд мөргөх, магтаал дуу дуулах, маани мэгзэм, ном судар унших нь ердөө л цагаан толгой төдий юм. Цагаан толгойгоо нүдэлчихээд сониуч зан чинь хөдлөн илүү ихийг ойлгож, дэвшихийг хүсэх атал нөгөөх л хэдэн үсгээ давтаад суувал хайран юм. Тийм ч учраас Гэрэл аялгууны бясалгалын "Авшиг" хүртэх нь зайлшгүй чухал. Энэ бол Үнэн ёсны сургаал, билиг билгүүнийг уламжлах манай арга юм.

Арга гэж нэрлэвч угтаа "арга" гэх юм үгүй. Ярьж тайлбарлах буюу юу хийхийг зааварчлах зэрэг наана болж буй зүйл гол нь биш хамгийн чухал нь "сэтгэлээс сэтгэлд" дамжуулан авшиг уламжлах явдал юм.

Авшиг уламжлах үед Багш нь та нарт чухам юуг "хийж болохгүй"-г зааж өгнө. "Болно" гэх юмгүй болж, бүгдийг л "болохгүй" гэнэ. Багш нь та нарт үүнийг ч болохгүй, түүнийг ч болохгүй, бүх зүйл хэрэггүй, бүгдийг огоорч орхин, юуг ч хүсэх аваас та нар өөрийн мөн чанар, Бурхан чанараа олно гэж заана. Их зөрчилтэй сонсогдож байна уу? Үгүй. Ихэнх хүн гадаад дэг жаяг хэлбэрийн чанартай, зүйлээс хамааралтай болж, өөрөөсөө бусад ямар нэг зүйл, эсвэл хэн нэгэнд залбирах замаар өөрийн Жинхэнэ Мөн чанараа хайдаг. Манай номонд, та нарыг өнгөн талын зүйлсээр дахиад хөөцөлдүүлэхгүйн тулд Багш нь ингэх ч хэрэггүй, тэгэх ч хэрэггүй гэж сургана. Гэвч зөвхөн "хэрэггүй, болохгүй" нь ч бас бясалгалын арга, эцсийн зорилго биш. Гэхдээ л, ганцхан агшинд ч бүхнийг жинхэнэ ёсоор огоорч чадвал бид гэгээрлийг мэдэрч ахуй ойлголттой болох нь бас бий.

Авшиг уламжлах нь маш энгийн үйл явц, гэхдээ бас хялбар бус. Авшиг хүртэнгүүтээ агшин зуурт гэгээрэх тул амархан. Гэвч эхлээд авшиг уламжилж чадах хүн хайж олох хэрэгтэй. Тийм хүнийг эрж олох нь хялбар бус. Авшиг уламжлах нь төвөгтэй, билиг нээгдэх нь бүтэшгүй зүйл гэж байгаа юм биш. Харин бидний билгийг нээж чадах хүнийг олох нь жинхэнэ амаргүй хэрэг юм.

Их Багш хэн болохоос хамаарч авшгийг олон хүнд эсвэл ганц хүнд авшиг уламжилж болно. Тиймээс ч зарим эртний даяанч багш нар цөөн хэдхэн шавьтай байсныг бид мэднэ. Луузыг маш

цөөхөн хүн мэддэг байсан, Бодьдарма таван шавьтай, Хүй Нөн түүнээс арай олон шавьтай байсан. Шагжамуни Будда бүр илүү олон шавьтай байсан. Есүс Христ арван хоёр их шавьтай байж. Тэрээр нэлээд олон хүнд ном уламжилсан байж магадгүй ч, хамгийн их билиг нээгдсэн нь арван хоёр шавь нь байв.

Авшиг хүртсэн бүх хүний билиг нээгддэг ч, яагаад зарим хүний билиг их, заримынх нь бага нээгддэг вэ? Зарим хүн Багшийгаа залгамжлан ном уламжилж чадах байтал, зарим нь яагаад чаддаггүй вэ? гэж та нар олонтаа гайхширч байсан байж мэднэ. Энэ бүхэн цөм сүнслэг дадал бясалгал хэрхэн дадуулахтай л холбоотой. Авшиг дөнгөж хүртээд төгс гэгээрэхгүй. Авшиг ердөө билгийн мэлмийг тань нээн, дотоодын бурхан чанарыг тань ухааруулан гэгээрүүлнэ. Та цаашид үргэлжлүүлэн тасралтгүй бясалгах шаардлагатай. Авшгийн үед тэр даруй чанагуух үнэний тухай арвин их ахуй ойлголттой болох аргагүй. Билиг их нээгдсэн, бага нээгдсэн аль аль нь цаашид тасралтгүй бясалган дадуулах хэрэгтэй. Бид хэдий чинээ их бясалгана, төдий уг мөн чанараа илүү таньж, дэсээ улам сайн мэдэх болно.

Үлгэрлэвэл, хааны хүү бага балчраасаа ордноо орхин гарч, гуйлгачин даган гэрт нь өссөн тухай түүх байдаг. Тэрбээр хааны хүү гэдгээ мэдэхгүй тул өдөр бүр хоол гуйж явдаг байжээ. Харин хаан эцэг нь хүүгээ ихэд санаж, өдөр бүр хүн томилон эрж хайлгадаг байжээ. Хааны хүү биедээ ямар нэгэн онцгой тэмдэгтэй байсан байх. Нэгэн өдөр хааны томилж явуулсан хүн түүнийг эрж олоод: “Чи гуйлгачин биш. Миний хэлсэнд итгэ. Би чамайг ордонд чинь хүргэж өгье. Чи ирээдүйн хаан болно.” гэжээ. Хааны хүү гуйлгачны гэрт өсөж бойжоод, нэгэнт гуйлгачин амьдралдаа дассан учраас их түшмэлийн үгэнд итгэхгүй байв. Тиймээс элч түүнд итгүүлэхийн тулд асар их чармайж. “Та бол хааны хүү лавтайяа мөн. Хүсвэл одоохон баталж харуулъя. Ханхүүгийн хувцас өмсье гэвэл энэ гэж өдөр бүр түүнд сануулан хэлдэг байжээ. Хүү удаан хугацаанд гуйлгачин байсан тул өөрийгөө ханхүү гэж бодож зүрхлэхгүй байв. Иймд их түшмэл тэвчээртэйгээр: “Хааны ордон элбэг баян сувд эрдэнэстэй, чамин тансаг орд харштай, тэр бүгд таных.” гэж байнга хэлсээр л байж гэнэ. Гэтэл ханхүү балчир наснаасаа гуйлгачны гэрт өссөн тул ийм юмтай гэдгээ төсөөлж ч чадахгүй. Их түшмэл түүнийг ханхүү болгох гээгүй. Гуйлгачин хүү угаасаа л ханхүү байсан.

Нэгэн өдөр гуйлгачин хүү түшмэлийн саналыг хүлээж авахаар шийдэж: “За би азаа үзсэн ч яах вэ? Танд амьдрал, хувь заяагаа даатгаад, юу болохыг харъя.” гэнэ. Тэрээр ханхүүгийн хувцас

өмсөн, мориндоо мордоход бусад түшмэд даруй ирж, түүнд ёслон мөргөхөд ханхүүд жаахан итгэл төрсөн боловч бүрмөсөн итгэж чадсангүй. Их түшмэлийн хувьд гуйлгачин байсан ханхүүг хааны ордон гэрт нь хүргэж, гуйлгачны дорд амьдралаас болж хүний өөдөөс эгцлэн харж чадахгүй түүнийг ордны амьдралын өндөр дээд ёс жаяг, эрхэмсэг ёс суртахуунд сургах замд саад бэрхшээл байсаар л байлаа. Тэр хувийн гадаад төрх байдлаас авахуулаад дотоод билиг ухааныг хүртэл асар их зүйл сурах хэрэгтэй болно.

Үүнтэй нэгэн адил бид угаасаа Бурхан байж, гэвч төрөл төрөлдөө Маяагийн хүчинд захирагдан асар их зовлон зүдгүүр туулж иржээ. Амьдралаас зайлах замгүй, хаа ч очсон асуудал бэрхшээл дүүрэн байдаг. Өнөөдөр дээрдэвч маргааш саад тотгор гарч, нөгөөдөр дажгүй байвал цаад өдөр нь бүр ч дордож мэднэ. Ийм их зовлон амсах мөртлөө чухам яагаад гэдгийг мэддэггүй. Идэх хоол өдөрт сайндаа гурав, дөрвөн аягаас хэтрэхгүй. Сольж өмсөх хувцас ч хэдхэн. Ердөө энүүхний төлөө өдөр шөнөгүй ажиллах албатай, тэгэвч дуусахгүй. Яагаад ийм их зовлонтой байгаагаа ч мэдэхгүй.

Бидний энэ гуниг зовлонг харсан учраас л Бурхан Бодьсадва энэ ертөнцөд хувилгаан биеэрээ залран ирдэг. Бид угаасаа түүний төрөл садан тул тэд биднийг аврахаар ирнэ. Гэвч бидний эрхэм дээд Бурхан чанарыг ахархан хугацаанд бүр мөсөн таниулах аргагүй тул: "Та угаасаа эрхэм дээд эрх чөлөөт Бурхан байсан юм." гэж зоригжуулан маш их тайлбарлах хэрэгтэй болдог. Тэд үргэлжлүүлэн: "За, Би танд хэрхэн Бурхан чанараа таньж, гэтэлж гэгээрэх аргыг зааж өгье." гэнэ. Тийнхүү та авшиг хүртвэл, төрөлхийн бурхан чанараа нээж, энэхүү жинхэнэ мөн чанараа цаашид аажмаар бүрэн танин мэднэ. Үг хэлээр тавьж буй ном сургаал бол та нарыг бясалгалаа дадуулсаар эрхэм дээд Мөн чанараа бүрэн онож мэдэх тэр цагийг хүртэл урам зориг өгөх л зорилготой.

Үлгэрт гарах ханхүүгийн хувьд ч адилхан. Хааны ордон хүрэх хол тул ханхүү замын дундаас санаагаа өөрчлөн: "Би танд цаашид итгэж чадахгүй. Хаантай уулзаж зориглохгүй нь. Ингэж яаж болох билээ? Би угаасаа гуйлгачин хүн. Гуйлгачин болоод арван хэдэн жилийн нүүр үзлээ. Яаж гэнэтхэн ханхүү болж чадах юм бэ?" гээд замаасаа буцаж, урьдын гуйлгачин амьдралдаа орохыг хүсэж мэднэ. Өнгөрсөн хамаг амьдрал нь түүнийг хүнд дарлуулж, хань нөхөр, хамаатан садан, хайрлах хүнгүй гуйлгачин байсан гэдгийг байсан гэдгийг л сануулна. Өөрийгөө ханхүү гэж итгэхэд нэн бэрх. Түүнийг эрхэм дээд ханхүү болгох Хааны их

түшмэлийн хувьд хэчнээн амаргүй хэцүү хэрэг гэж санана.

Ийм учраас эрт дээр үеэс Их багш нар залран ирж хотол түмэнд ном тайлах нь хэзээ ч амар хялбар байсангүй. Тэд элдвийн бүх саад тотгортой тулгарч, хүмүүсийн дадал зуршил, үзэл бодлын хүлээстэй тэмцэх хэрэгтэй болдог. Их Багшийг залрахад сургаал номыг нь хүмүүс тэр бүр талархаж сонсдоггүй. Ирж сонссон хүмүүсээс зарим нь Багшид итгэхгүй, тэр байтугай гэртээ хариад гүтгэж гүжирдэнэ. Учир нь тэд тулга тойрсон сэтгэлгээтэйгээ зууралдсаар байдаг. Эрт дээр үеэс хүмүүс Их Багшийн хэлсэн Үнэн ёсонд итгэхийн оронд галын сахиус, нарны сахиус, салхины сахиус зэргийг тахин шүтэж иржээ. Учир нь хүмүүс уг Мөн чанараасаа (Уг дүр) салж өнчрөөд, уужим агуу ертөнц болоод учир нь тайлагдахгүй бүхнээс айж эмээх болжээ. Халуун нарнаас ч эмээнэ, хүрсэн бүхнээ шатаагч галаас айна.Уул яагаад ийм өндөр сүрлэг юм бэ?, Далай яагаад ийм хөлгүй гүнзгий, хөвөө хязгаар нь харагддаггүй юм бэ? салхи яагаад ийм их хүчтэй, ямар ч юмыг эвдэн сүйтгэж, бүдүүн модыг хүртэл үндсээр нь сугалж, гэр байшинг ганхуулан дайвуулдаг юм бэ? гэцгээнэ.

Өөрсдийн мөн чанар болох бүхнийг чадагч их хүч, Уг дүрээс тасран салснаар бид хээр харанхуйд төөрөөд гэрээ олохгүй байгаа хүүхэд шиг юм бүхнээс маш их ганцаарджээ. Үүний улмаас мухар сүсэгтэй болж, энэ нь чөтгөрт мөргөж, сахиусыг шүтэх нөхцөлийг бүрдүүлжээ. Эртнээс аваад эдүгээ хүртэл ийм л байна. Ийм учраас Их Багш заларсан үедээ энэхүү мухар сүсэгтэй хатуу ширүүн тэмцэл хийж, урт хугацааны дараа л ялж тэрхүү үзлийг нэлээд өөрчилж болдог. Гүн гүнзгий мунхаг сэтгэл, мухар сүсгийг өөрчлөх нь тун амаргүй ч тийм хүмүүсийг ч бас гэтэлгэх хэрэгтэй. Багшид итгэдэг хүмүүсийн хувьд гэтэлгэхэд арай хялбар байдаг.

Мухар сүсгийг өөрчлөхийн тулд галт зэвсгээр биш үзэл бодлоор тэмцдэг тул улс төрийн дайнаас ч илүү адармаатай бөгөөд аймшигтай. Тиймээс хамаг төрөлтнийг гэтэлгэх хэцүү гэж бид байнга ярьдаг ч хамаг төрөлтнийг биш тэдний оюун ухааныг гэтэлгэхэд хэцүү. Ийм учраас л Бурхан багш “Хамаг төрөлтнийг гэтэлгэх хэцүү.” гэж айлджээ.

Учир нь энэ оюун ухаан угаасаа биднийх биш. Энэхүү тархи, оюун ухаан нь зөвхөн дэлхийн ажлыг хийхэд бидэнтэй хамтран ажилладаг болохоос туулан гэтлэхийг эрэлхийлдэггүй. Энэ нь бидний эрх чөлөөнд саад болж: “Та юунд номын мөр хөөнө вэ? Энэ дэлхийд танд хэрэгтэй бүхэн байна. Идэх хоолтой, өмсөх хувцастай, гэр бүл найз нөхөдтэй, тавтай сайхан. Та

бясалгаж суугаад яах юм бэ?, Туулан гэтлээд хаачих нь вэ? Энэ ертөнцөөс өөр ертөнц эсвэл Диваажин гэж үнэхээр байдаг гэж яаж мэдэж байгаа юм? Энэ Их Багш мэхэлж байгаа юм биш биз?" гэхчилэн асууна. Эргэлзэл дүүрэн бодол санаа ийнхүү хаа сайгүй хэсүүчилнэ.

Иймээс өнгөрсөн үеийн даяанч багш нар шавь нараа олон удаа туршин шалгадаг байжээ. Яагаад ингэж шалгадаг вэ? Тэдний оюун санааг дадуулахын тулд эхлээд хуучин дадал зуршлыг нь угаан цэвэрлэнэ, дараа нь шинэ үр тарьж суулгана. Ногоо тарих газрыг урьдчилан бэлтгэдэг шиг оюун санааг нь шинэ сэтгэлгээнд бэлтгэдэг. Уулан дахь бясалгалын төвдөө бид ногоо тарьдагтай адил юм. Биднийг очихоос өмнө тэр газарт удаан хугацаанд хэн ч амьдардаггүй, зам харгуй нь мэдэгдэхгүй, өвс ногоо өтгөн шигүү, зэрлэг өвс хаа сайгүй өндөр ургасан байсан. Бид очмогцоо өвсийг нь хадаж, зэрлэгийг үндсээр нь зулгааж цэвэрлэх хэрэгтэй болсон. Элдэв зэрлэг ургахгүй цэвэр газар бэлтгэж бордон, ногоо тарьсан нь одоо хэдийнээ ургаад идэж болохоор болжээ.

Үүнтэй адил ямар нэгэн шинэ үзэл санаа эсвэл Үнэн ёсыг түгээхэд эхлээд хуурамч үзэл баримтлалыг арилган цэвэрлэх хэрэгтэй болдог. Учир нь Үнэн ёс, хуурамч үзэл санаа зэрэгцэн оршиж чаддаггүй. Үүний нэгэн адил идэшний ногоо, зэрлэг ургамалтай зэрэгцэн эрүүл сайхан ургаж чадахгүй. Зэрлэг өвс хэтэрхий их бол ногоо тарих нь бүү хэл алхаж гишгэх ч газар олдохгүй. Ногоогоо тарьсны дараа өдөр бүр арчилж тордон зэрлэг өвс ургах, хорхой идэхээс сэргийлнэ. Зэрлэг ургамал зөвхөн газраас ургахгүй, тэнгэрээс унах нь ч бий. Хаа нэгтэйгээс салхиар хийсэж ирсэн зэрлэг ургамлын үр манай ногооны хашаанд унахад харж хандалгүй хоёр хоноход л элдэв өвс ургачихдаг байлаа.

Тиймээс авшиг хүртсэнийхээ дараа заавал үргэлжлүүлэн бясалгаж дадуулах хэрэгтэй болдог юм. Тууштай, эрч хүчтэй бясалгах зоригдлоо сэргээхийн тулд Их Багшийнхаа номыг байнга сонсож, Их Багш болон авшигтнуудтайгаа долоо хоног бүрт, эсвэл сар болгон уулзаж, даяануудад оролцож байх хэрэгтэй. Эс бөгөөс шинэхэн авшигтнууд номоо умартаж, энэ ертөнцийн эргүүлгэнд маш амархан орно. Энэ нийгэм нь урхидан татах хүч ихтэй.

Хамгийн эхэнд миний хэлсэнчлэн энэ дэлхий дээр Маяагийн хүч тун их. Учир нь энэ ертөнц Хуурмаг оршихуйн хааны (Маяа) улс орон, түүний нутаг дэвсгэр. Садан төрлөө хар хүчний боолчлолоос чөлөөлөн ариусган гэгээрүүлж Гэрт нь дагуулж харихаар энэ дэлхийд дээд ертөнцөөс бууж ирсэн Аугаа

Бурхад угтаа энэ хар хүчний хэрэгт хөндлөнгөөс оролцож, нутаг дэвсгэрт нь зөвшөөрөлгүй нэвтэрсэн хэрэг. Тэд Маяатай тулалдах шаардлагатай болдог, учир нь Гурван Ертөнцөөс гэтэлж буй төрөлтнүүд хар хүчнээс илүү өндөр дээд байр суурьтай болж, энэ харанхуй ертөнцөд хэзээ ч эргэж ирж зовлон амсахгүй болно. Энэ нь Маяа нэг сүнс, нэгэн сайн боолоо алдлаа гэсэн үг. Нэг хүн гэтэлбэл гурван ертөнцийн доторх хамаг амьтан нэгээр хорогдох тул ихэд дургүйцэж бүхий л аргаар саад түвэг учруулдаг.

Эртнээс эдүгээ хүртэл хамаг амьтныг гэтэлгэхээр энэ ертөнцөд заларсан жинхэнэ Их Багш болгон ихээхэн зовлон туулсан байдаг. Энэ хорвоогийн хамаг амьтдыг гэтэлгэх нь хэзээд амаргүй. Хязгаарлагдмал тооны төрөлтөнг гэтэлгэхэд ч хүртэл тэд маш их саад барцад, хэл амтай учирна.

Шэньшиүгийн шавь нар бурханы шашинтан бөгөөд гэрээс гарагсад байсан атлаа Их Багш Хүй Нөнг гүтгэн хорлож байв. Шагжамуни Будда эхэн үедээ олон хүнд гүтгэгдэн муушаагдаж байв. Зарим нь түүний амийг хороохыг эрмэлзэж, нөгөө зарим нь буруу номтон хэмээн шүүмжилж байв. Тэдний нэг нь түүнээс бие давхар болсон хэмээн гүжирдэж байв. Есүс Христ хэдхэн жил номоо тайлаад цовдлогджээ. Күнзийг олон муж нутгаас хөөж байсан бол Луузад итгэх хүн тун цөөхөн байсан. Одоо цагт Луузын нэр хоёр мянган жилийн тэртээгээс илүү алдартай болжээ. Амьд сэрүүн байхад нь мэдэх хүнгүй байсан Тэрбээр нас барснаасаа хойш ихээхэн хугацаа өнгөрсний дараа л олонд алдаршсан юм.

Яагаад эрт үеийн Багш нар, одоогийн Багш нараас илүү нэр алдартай байдаг вэ? Нэгэн Их Багш ертөнцөөс ангижирмагц Маяа дорхноо түүний нэрийг ашиглан аливаа хэргийг үйлдэж, Үнэн ёсыг Маягийн ёс болгон хувиргадаг. Их Багш ертөнцөд залрахдаа зөвхөн Үнэн ёсыг л түгээдэг гэдгийг бид мэднэ. Гэвч хожим нь аажмаар мухар сүсэг болж хувирдаг байна.

Луузаар жишээ авъя. Тэр угаасаа өөрийгөө болон ямар нэг зүйлийг тахин шүт гэж номлоогүй, өөрт нь өргөл болгож амьтан алах тухайд бол бүр ярилтгүй. Тэрээр өөрийгөө хүмүүсийг адисалж чадна гэж хэлээгүй, нас барсных нь дараа Өөрт нь өргөл өргөж, тахиж шүтээрэй гээгүй. Даодэжин (Мөр ёсны судар) нь зөвхөн хүмүүсийг энэхүү “Дао” (Мөр ёс)-г эрж олох, “Дао”-тай нэвтрэлцэж, “Дао”-тай хамт байвал бид сая Үнэн ёсыг эрж олно гэж сургадаг. Лууз “Даодэжин”-д үүнийг л хамгийн их чухалчилсан бөгөөд энэ нь эрхэм үзэл санаа маргаангүй мөн.

Гэтэл энэ эрхэм дээд үзэл санаа хэрхэн уналтанд орсныг өнөөдрийн Даоизмаас (Бумбын шашин) харж болно. Эдүгээ Даогийн сүм хийд болгонд амьтны махаар тахил өргөдөг. Хэнд тахил өргөж буйг би мэдэхгүй. Лууз айгаад нэгэнт зугтчихсан. Түүн шиг агуу их энэрэнгүй Их Багш юунд мэдрэл мэдрэхүйт амьтны мах идье гэж бодох вэ? Күнзийн сургаалтан ч ялгаагүй болсон. Уг нь хүмүүсийг өндөр ёс суртахуун болон их эрдэм мэдлэгтэй болгохын төлөө сургаал юм. Гэтэл одоо гахай, үхэр зэрэг олон зүйлийн амьтны махан тахил үйлддэг болж хувирчээ.

Бурханы шашин бараг л адилхан болсон байна. Одоо ихэнх буддист улс оронд Бага хөлгөний урсгалыг баримталж, гэрээс гарагсад бүгд мах идэцгээж, бас гэрлэж байгаа нь ч цөөнгүй. Ном балрах цөвүүн цагт ёс бус гажууд зүйл их олон болжээ.

Бурханы шашин Төвөдөд анх дэлгэрэхдээ нутгийн уугуул иргэдийг номонд оруулах зорилготой байсан боловч эсрэгээрээ Бурханы шашин орон нутгийн шашны урсгалд автаж Ламаизм болжээ.

Эх газрын Хятад бол бичиг соёл, ёс суртахууны хөгжлийн олон мянган жилийн уламжлалтай гүрэн агаад Бурханы шашин Хятадад нэвтрээд үтэр түргэн түгж, өргөн дэлгэрч урт хугацаанд мандан бадарч, хожим нэн их эсэргүүцэлтэй тулгарч уналтанд оржээ.Одоо манай жижигхэн амтат төмс (Формоса)-д л жинхэнэ уламжлалт Бурханы шашны жижиг урсгал байх шиг байна. Гэрээс гарвал гэрлэхгүй, мах идэхгүй, архи уухгүй. (Тийм эсэхийг би баттай сайн мэдэхгүй, тийм байх гэж таамаглаж байна. Хэрэв Формосад тийм биш бол жинхэнэ уламжлалт Бурханы шашныг энэ дэлхийн чухам хаанаас хайж олох вэ?)

Гэвч Формосагийнх бас л жинхэнэ Бурханы шашны жинхэнэ анхдагч хэлбэр биш. Яагаад гэвэл Бурханы шашин нь Даоизмтай хослоод шашны гүн ухаан ба аж төрөх сургаалын холимог болсон. Уламжлалт Энэтхэгийн Бурханы шашинд урьд нь өглөө оройн уншлага залбирал гэж байгаагүй. Эдүгээ газар бүрт л байх болжээ. Уг нь Бурханд залбираад л болдог байв. Энэ их уншлага муугүй зүйл байж болох ч өглөө, оройн уншлага залбирлыг уг нь нам сэлүүн дадал бясалгал хийж буй гэрээс гарагсад л уншдаг байсан.

Ау Лакт гэрээс гараагүй хүмүүсийг “Баатараа явагч их хөлгөн тарни (Surangama mantra)”, “Зүндийн тарни” болон бусад тарнийг уншихыг хорьдог. Би гэрээс гараагүй байхдаа л сүнслэг дадал бясалгал хийж, цагаан хоол идэн өдөр бүр Бурханд мөргөж, ном

сударт, маани тарни уншдаг байсан ч “Баатараа явагч их хөлгөн тарни”-ийг унших, өглөө, оройн уншлага залбирал хийхийг багш маань зөвшөөрдөггүй байсан. Харин сүүлд нь зөвшөөрсөн. Багш надад: “Нэгд, гэрээс гараагүй хүн эхнэр, нөхрийн харилцаатай байдаг. Хоёрт, гэр орны байдал сүм хийдийнхээс өөр тул тарни уншсан ч нэмэргүй, харин ч эргээд муу үр дагавар авчирч мэднэ. Бид бүрэн ариусаагүй тул тарнийн хүч гарахгүй, харин ч ад чөтгөрийг өдөөх эрсдэл буй.” гэж хэлсэн.

Эдүгээ энэ тал дээр ихээхэн дэг жаяггүй болжээ. Зарим хүн Шагжамуни Буддагийн юм уу, өөр бусад бурхдын хөргийг залаад түүндээ өдөр бүр мөргөж, өглөө, оройн уншлага залбирал хийн, усыг тарнидан рашаан болгоод хамаг амьтанд хүртээдэг. Ингэж буй нь сайн зүйл биш. Нэгд, тэд рашааныг хүртэж чадахгүй. Хоёрт, хэрэв хүртэж чадлаа гэхэд өдөр болгон хүртэхээр ирдэг болно. Ингээд ад сүг олноор хурж тухайн газрыг нэн их сөрөг эрчимтэй болгоно. Энэ ном уншиж засал хийдэг хүмүүст ад чөтгөрийг хязгаарлах хүч үгүй. Тийм ч учраас тарни уншдаг олон хүн сэтгэцийн өөрчлөлттэй болдог.

Ийм асуудалтай олон хүн Багшийг нь хайж ирдэг. Би заримд нь туслаад зарим дэндүү ноцтой, надаас хэтэрхий их цаг хугацаа шаардах тохиолдолд тусалж чаддаггүй. Тиймэрхүү хүмүүс “Их бодьсадва” болж бусдыг “аврахыг” санаархан хүмүүсийн хэрэг явдалд оролцох дуртай. Гэтэл өөрсдийгөө л эхлээд аварчихвал болно.

Багш нь маш их хүч, цагаа гарздан ийм төвөгтэй зүйлтэй ороцолдохын оронд бусад номын мөр хөөж, үтэр түргэн гэгээрэхэд илүү бэлэн хүмүүсийг туулан гэтэлгэсэн нь дээр. Ганцхан хүнийг аврахын төлөө зуун хүнийг орхих нь хүчээ дэмий үрж буй төдийгүй шударга бус явдал билээ.

Формосад ч ийм байдал их гардаг. Өглөө оройн уншлага залбирлын номоо авч хариад дураараа уншина. Бас элдэв гарын чагж сураад бирдийг гэтэлгэж болно гэж санадаг. Эсвэл долоо хоног Буддын номын хуралд суучихаад эсвэл долоо хоногийн Зэн даяаны дараа гэртээ хариад дуурайж үйлдэнэ. Мөн сүм хийдэд очиж хоёр гурван өдөр мөргөл үйлдэн бага сага юм мэдэж аваад өөрөө номын багш болчихдог. Сүм хийдийн нөхцөл байдлыг гэрийнхтэй зүйрлэж болохгүй. Иймэрхүү зан үйлийг гэртээ хийж буй хүн аюулд өртөхгүйн тулд жинхэнэ бодит хүчтэй байх хэрэгтэй. Бирд хооллож байгаа хүн тэдгээр төрөлтнүүдийг дарах чадалтай байж гэмээ нь өөрийнхөө сэтгэл мэдрэлд нөлөөлж, гэр бүлд нь хорлол хүрэхээс сэргийлнэ. Формосад сүнснүүдийг

авран хамаг амьтныг гэтэлгэхийг хүсдэг хүн их олон бий. “Хамаг амьтныг гэтэлгэх хэрэгтэй.” гэж ярихыг би очсон газар бүхэндээ сонсдог. Хамаг амьтныг гэтэлгэе гэсэн санаа нь их сайн хэдий ч чадах уу, үгүй юу гэдэг нь өөр асуудал юм.

Зарим хүн “Эрдэнийн мандалт судар”, “Очироор огтлогч судар” -аас бясалгал хийхийн чухлыг ойлгож аваад өөрөө таамгаар бясалгадаг. Эсвэл сүм хийдэд санваартан хүний бясалгаж байхыг хараад гэртээ ирж дуурайна. Үүнийг ямар бясалгал гэх вэ? Энэ бол бясалгал биш бясалгаж буй “аяглал”. “Аяглаж” бясалгаад буруу замаар орвол их уршигтай. Тиймээс ч ингэж бясалгасан олон хүн сэтгэл мэдрэлийн өвчин тусдаг. Энэ нь зарим багш нууц тарни болон нууц тарнийн аргыг дэндүү ил болгож, энгийн хүмүүс сурвал үүсэж буй оюун санааны хүчний учрыг олж чадахгүйн улмаас ач тус болохоосоо илүү хор уршиг болдог тийм аргыг ч хүртэл нийтэд дэлгэснээс болсон хэрэг.

Иймээс дээр үеийн Их Багш нар ном уламжлахдаа тун хянамгай болгоомжтой ханддаг байв. “Ирээдүйн шавь”-аа олон удаа шалгаж удаан хугацаагаар нарийн ажигласны эцэст түүнд ном уламжилдаг. Ингэх нь харьцангуй аюул багатай бөгөөд шавь нь гадуур дотуур зоргоороо шүүмжилж явахгүй болно.

Сүнснүүдийг гэтэлгэх нууц тарни урт хугацааны турш уншвал хоёр янзын эсрэг нөхцөл байдал үүсдэг. Нэгд, уншсаар байгаад мэдрэлийн өвчтэй болж тун болзошгүй. Хоёрт, уншсан ч урьдынх шигээ хэвийн байдалтай байна. Буян хүрэхгүйн зэрэгцээ , “би” үзэл хэт ихтэй бол мэдрэлийн өвчтэй болно. “Би” тийм сайн, “би” ийм их нигүүлсэнгүй сэтгэлтэй, “би” хамаг амьтныг гэтэлгэнэ, “би” тарни уншиж хамаг амьтныг гэтэлгэж чадна, “Би” өдөр бүр бирдэд өглөг өгдөг гэцгээнэ. Би үзэл хэт их тул “би”-гээс болсон мэдрэлийн өвчтэй болдог. Маани, тарни уншчихаад өөрийгөө бусдаас дээгүүрт бодож бардам сэтгэл үүсгэснээр ад түйтгэрт баригдана. Маяа сөрөг хүчийг төлөөлдөг хэдий ч тэрээр ийм сөрөг, омог бардам хүмүүст дургүй болохоор ухаан санааг нь үймүүлж самуурууулахаар ирдэг.

Харин хүн насан туршлаа нууц тарни уншсан ч мэдрэлийн өвчтэй болдоггүй шалтгаан бол, тухайн хүн урд төрөлдөө сүнслэг дадал бясалгалаа сайн хийж, үлэмж их буян хураасан байж мэднэ. Гэвч туулан гэтэлж Бодьсадва болох түвшинд хүртэл сайн дадуулаагүй тул дахин хүний төрөл авч гэр бүлтэй болоод эгэл ертөнцийн элдэв дадалд баригддаг. Хэдий тийм ч урд төрлүүддээ хураасан буян нь байсаар байдаг.

Жинхэнэ нигүүлсэнгүй сэтгэлээр хамаг амьтныг аварч

гэтэлгэе гэж боддог хүн хэзээ ч омог бардам байдаггүй.Үнэн сэтгэлээсээ хамаг амьтанд тусалж, бирдийг гэтэлгэхийг хүсэж, үхэгсдийн сүнсийг гэтэлгэхийн төлөө тарни уншдаг хүмүүсийг Бурхан бодьсадва болон Маяа ч оролдохгүй.

Гэхдээ энэ төрөлдөө сүнслэг дадал бясалгал хийгээгүй хүмүүс өмнө хураасан буянаа барж дуусгаад үхэхийн цагт юу ч үгүй хоцордог. Дээд заяанд төрөл авах буян хүрэхгүй. Ихэнх хүн Үнэн ёсны номыг ойлгож чадаагүйн улмаас ийм уршиг дагаврыг мэддэггүй.

Үүнийг гүнзгийрүүлэн тайлбарлахын тулд хоёр зүйрлэл би хэлье. Эхнийх нь, төдий л мөнгөгүй ч баян болж харагдахын тулд өдөр болгон мөнгө зээлж, нэр алдар магтаал сайшаал олж авах гэж өөртөө болон бусдад түүнийгээ зориулдаг нэгэн. Өдөр болгон улам ихийг зээлж цацсаар зээлсэн мөнгөө төлж чадалгүй, цагдаад баригдан шоронд ордог. Удаах нь, өөрөө ажил хийж мөнгө олдоггүй, эцэг эхийн үлдээсэн өв хөрөнгөнөөс өөр илүү юмгүй атлаа ядуучуудад жинхэнээсээ өглөг өгөх хүсэлтэй. Өв хөрөнгөө өдөр бүр хэсэг хэсгээр үрсээр эцэстээ юу ч үгүй үлддэг.

Үүнтэй адил буян хишгийг ч бас барж, үргүй цацаж болдог юм. Иймээс өртэй эсвэл гар хоосон хоцрохгүйн тулд бид хэмжээлшгүй буян хишгийн хязгааргүй сан хөмрөгийг зайлшгүй олж түшиглэх хэрэгтэй. Үүнийг олчихвол хэчнээн их зарцуулсан ч асуудалгүй. Гэвч тийм хэмжээлшгүй буян хишгийг олоогүй бол элдэв янзын дэмий юм бүү хий. Эс бөгөөс элдэв үйлийг хамаагүй хийх нь аюултай. Тэр хэмжээлшгүй буян хишиг нь өөрийн эх сурвалжтай. Энэхүү эх сурвалжийг олоод холбогдчихвол бид бүх юмтай болж, тэр бүү хэл тоо томшгүй олон амьтанд түгээж болно.

Багш нь дөнгөж сая хэлсэнчлэн, энэхүү хэмжээлшгүй буян хишгийн эх сурвалжийг олчихвол та нар өөртөө хохиролгүйгээр хэн бүхэнд хүссэн хэмжээндээ түгээх буянтай болно. Гэхдээ дундаршгүй буян хишгийн эх сурвалжийг олж чадсан хүмүүс хэзээ ч хамаг амьтныг аврахын тулд чангаар тарни уншиж, хэнгэрэг цан дэлдэхгүй. Ингэх шаардлага байхгүй. Энэ бүхэн бол Маяагийн сэдсэн зүйл. Шагжамуни Будда ингэж номлоогүй, Есүс Христ ч ингэхийг заагаагүй. Ийм зүйлийн явдал угаасаа байгаагүй. Бурханы шашны цэвэр хэлбэр мухар сүсэгтэй холилдоод эдүгээ Формосад ийм байдалтай болж хувирсан байна. Энэ нь Бурханы шашин бусад улс оронд уламжлагдсантай адил хэдийн цэвэр байдлаа алдсан байна. Энэ нь Бурханы шашин нь өөр төрлийн мухар сүсэгтэй холилдож, яг л Төвөдөд дэлгэрсэнийхээ дараа Ламаизм руу хэлбийж, цэвэр байдлаа алдсантай эгээ ижил юм.

Жинхэнэ цэвэр ариун Бурханы шашинтнууд тиймэрхүү зүйлс хийдэггүй. Өөрийнхөө мөн чанар, Уг дүрийг жинхэнэ ёсоор олж таньсан хүн бас ингэхгүй. Их Багш Хүй Нөн өглөө, оройн уншлага залбирал хийж байсныг, эсвэл бирд, сүнс гэтэлгэх тарни уншиж байсныг та нар сонссон уу? Тиймэрхүү зүйл огт хийж байгаагүй. Бодьдарма юу хийж байсныг та нар харсан уу? Тэр зөвхөн хана харж нам суун бясалгадаг байсан. Зэн Багш Бай Жан ч мөн адил. Тэр оршуулган дээр хойтхыг даан чанга дуугаар ном судар уншиж байсан уу? Үгүй. Шагжамуни Будда өглөө, оройн уншлага залбирал, өөр бусад гадна талын өнгөц зүйлсийг хийж байсныг би сонсоогүй. Хийдэг байсан байлаа гэхэд Шагжамуни Будда Өөрөө хамаг амьтныг гэтэлгэх чадалтай тул хийж болно. Бидэнд тийм чадал байхгүй. Бид Будда биш, Түүний адил өндөр дээд дэсэд хүрч амжаагүй. Тиймээс ном уншлаа гээд ямар тус байх вэ? Будда угаас иймэрхүү зүйлийг "үйлдэх" ч шаардлагагүй. Тэр суусан газраасаа л хамаг явдлыг хийж чадна. Түүнд тусгай газар очиж, тарни унших шаардлагагүй, бүхнийг болгоогч сэтгэлээрээ л "үйлдэнэ". Тэрээр юу ч хийсэн өөрийн хүчээр хувилгаан биеэрээ хийнэ. Иймээс Шагжамуни Буддаг үй түмэн хувилгаан (гэрлэн) биетэй гэж ярьдаг. Тэр хуруугаа ч хөдөлгөх хэрэггүй.

Багш нь "ирэх нь үгүй, явах нь үгүй" байтал зарим хүн Багшийг нь шаардлагатай гарцаагүй үед ирж тусалж буйг харсан байдаг. Тэр бол энэ бие нь уулнаас бууж очоод хийсэн хэрэг биш, хувилгаан бие юм. Өнөөдөр Багш нь өөрийн жинхэнэ биеэрээ энд ном тайлж байна. Хэрвээ та нар цохивол Багшийнх нь махан бие өвдөх болно. Гэтэл ихэнх бусад ажлыг хувилгаан биеэрээ хийдэг.

Иймээс Уг дүрээ жинхэнээр эрж олсон үед, өөрөөр хэлбэл төгс гэгээрсний дараа л хамаг амьтныг жинхэнэ гэтэлгэж эхэлнэ. Хамаг амьтныг гэтэлгэгч, агуу төрөлтөн гэж сүр бадруулахгүй, гараа ч хөдөлгөхгүй. Хамаг амьтантай нэг болж, Би болон хамаг амьтан ялгаагүй болж, юуг ч бодолгүйгээр, аливаа явдал бүгд аяндаа хийгдэнэ. Тиймээс Лууз "Үйлдэхгүйгээр үйлдэх" гэж хэлжээ Энэ нь "Хийхгүйгээр хийх" гэсэн утга санаатай.

Багш нь саяхан хэлсэнчлэн, Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш ангижирсны дараа амьд байх үеэсээ илүү алдаршдаг. Учир нь Маяа (Хуурмаг оршихуйн хаан) үнэнийг хайгчдыг будилуулахын тулд хорлон сүйтгэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлж, сургаалд нь худал ёсоо хавчуулан шашин болгоод энэ бол Бурханы шашин гэж хамаг амьтанд итгүүлдэг. Үүний харгайгаар хамаг амьтан сансрын хүрдэнд эргэлдэж, Маяагийн албат хэвээр үлддэг. Үүнд тэр их баярлаж, бидний сэтгэлийг тайтгаруулах шашинтай болгоод

Үнэн ёсыг эрж олох чин хүслийг нь сарниулан мартуулдаг байна.

Олон хүн Үнэн ёсыг эрдэг ч хаанаас, хэрхэн яаж хайхаа мэддэггүй. “Буддад залбирч, Бурханы хөшөөнд мөргөвөл Үнэнийг онож, туулан гэтэлнэ.” гэж дуулаад тэд хязгааргүй баярлана. Энэ сургаалын санааг дагаж, Буддад л найдахгүй бол өөр хэнд найдах билээ гэж бодно. Тиймээс ч хоёр мянга гаруй жил өнгөрсөн ч Шагжамуни Будда алдартай хэвээр. Энэ бүхэн Маяагийн заль мэх юм. Тэр бидний дотоодын жинхэнэ Бурханыг хайлгуулахгүй, харин гаднах Бурханыг эрүүлж хайлган элдэв зүйлийг хийлгэдэг байна. Ингээд бид өөрсдийгөө тайтгаруулж, өөрийгөө номч сэтгэлтэй хүн, өдөр бүр өглөө, оройн уншлага залбирал хийдэг, сүнслэг дадал бясалгал сайн хийдэг гэж боддог. Эцэст нь энэ бүгд Маяагийн арга заль, гурван ертөнцийн доторх зүйлс болохыг мэддэггүй. Хэрвээ ингээд байвал түм буман жил өнгөрсөн ч туулан гэтэлж чадахгүй.

Их буян хишигтэй, чин сэтгэлтэй хүн хамгийн сайндаа л хоёрдугаар ертөнцөд хүрнэ. Гуравдугаар ертөнцөд хүрч чадахгүй. Гуравдугаар ертөнцийг давах талаар ярихын ч хэрэггүй. Хоёрдугаар ертөнц бас л Маяагийн орон нутаг. Гуравдугаар ертөнц ч түүний харьяаных. Яагаад гэвэл энэ дэлхийг гурван ертөнцийн дотор бүтээсэн. Бидний бие махбод, толгой тархи ч гэсэн гурван ертөнцийн бүтээл. Гурван ертөнцийн гадна бие махбод, толгой тархи, нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэлийг хэрэглэхгүй. Энд л бид ийм олон багаж хэрэгсэл ашигладаг. Багаж олон болох тусам улам ярвигтай болдог. Толгой тархи байхгүй бол сайн хэдий ч энэхүү ертөнц дээр энэ бие махбод, оюун ухаангүй бол бид оршин тогтнохын аргагүй.

Иймээс бид хамаг амьтныг гэтэлгэе, ямар нэгэн тарниар хамаг амьтан, ад сүнс бүхнийг гэтэлгэе гэвэл өөрөө урьдаар Бурхан болж, өөрийн Бурхан чанар, угийн их хүчээ олж, бидний Уг дүр юм уу “Дао”-г олсны дараа Буддатай адил хамаг амьтныг аварч чадна. Зарим тарни хүчтэй, гарын чагж хийх нь ч бас хүчтэй гэж чамд хэлж магадгүй. Гэвч бид түүнийг даган ямар нэгэн гарын чагж, хөлийн чагж хийхэд ямар ч үр дүн гарахгүй.

Жинхэнэ Их багш иймэрхүү элдэв зүйлийг заахгүй. Эхлээд өөрийн Уг дүр, Бурхан чанараа эрж ол, тэгээд юу хийхээ өөрөө шийд гэж бидэнд сургадаг. Яагаад гэвэл “Бурханы хүч”-тэй болсон цагт юу ч хийж, хэнийг ч аварч болно. Хувилгаан биеэрээ хаана ч очиж хамаг амьтныг гэтэлгэнэ. Харин зовж зүдрэн байж өдөр бүр хоёр цагийн өглөө оройн уншлага залбирал, гарын чагж хийх нь төдийлөн ашиг тусгүй. Зөвхөн өөрөө өөрийгөө хорлож

байгаа хэрэг. Үргэлж зав чөлөөгүй, бясалган дадуулах, өөрийн Уг дүр, Бурхан чанараа эрж олох цаггүй болно. Хүч тамираа барж, урьд төрлийн цуглуулсан жаахан буян хишгээ үрэн таран хийнэ. Эцэстээ юу ч үгүй болж гар "хоосон" буцаж, дахиад л сансрын хүрдэндээ эргэлдэн ад чөтгөр, мал адгуус, тэнэг мунхаг, ядуу дорой хүн болж төрнө. Энэ чинь үнэхээр хөөрхийлэлтэй, өрөвдмөөр биш гэж үү?

Энэхүү бие махбодыг байхад амжиж түргэн дадуулан бясалгах хэрэгтэй. Бурхан болсны дараа Ганга мөрний элс шиг тоолшгүй олон төрөлтнийг, гэтэлгэж болно, харин зөвхөн хэсэг бүлэг ад чөтгөр буюу хэсэг бүлэг хүмүүсийг гэтэлгэх төдий биш, бүхий л тэнгэрийн орныг ч гэтэлгэж болно. Буг чөтгөрийг гэтэлгэж болно, тэнгэрийн төрөлтнийг ч гэтэлгэж болно, хүн зоныг ч бас гэтэлгэж болно. Иймээс Буддаг "Тэнгэрийн болон хүмүүн төрөлтний жолоодогч Багш, дөрвөн төрөхүйн энэрэлт Эцэг." гэдэг.

Миний сая ярьсан ханхүүгийн үлгэрийн адилаар, их түшмэл ханхүүд бага сага мөнгө, өмсөх хувцас, унах морь өгөхөд тэрээр хэрэггүй гээд авалгүй бүгдийг нь өөр хүнд өгчихжээ. Эхлээд энэхүү мөнгө, хувцас, морьтой байж сая хааны ордонд хүрч, улсын хаан болно. Тэгээд ордны их сангаас хамаг амьтанд тараан өгч болно гэдгийг санаж бодсонгүй.

Их түшмэл ирэхдээ түүнд тийм их мөнгө авчираагүй. Зөвхөн ганц хоёр хувцас, бага зэргийн мөнгө өгчээ. Ханхүү амин хувиа бодон бусдыг хайхрахгүй байгаа юм бус. Хааны ордонд очтол энэ мөнгийг зарцуулж, очсоныхоо дараа хэчнээн ч мөнгө төгрөг, өглөгийг хамаг амьтанд өгч болно. Иймээс бид оюун ухаандаа бодож тунгаах хэрэгтэй. Бусдын яриаг сонсох хэрэггүй. Тэдний хийж буйг даган дуурайх ч хэрэггүй. Энэ хэрэг явдлыг хийх нь зүйтэй юу? Ингэх нь тустай юу, үгүй юу? Хэр зэрэг тустай вэ? Иймэрхүү ач тус хязгаартай юу, үгүй юу? гэж заавал бодох ёстой. Чухам яавал хамгийн их ач тустай, саад бэрхшээл багатай байх вэ? гэдгийг заавал бодож үзэх хэрэгтэй.

Би гэрээс гараагүй байхдаа олон хүнд тусалж байсан. Үүнийг ярихдаа өөрийгөө дөвийлгөж байгаа юм биш. Тэр үед Ау Лакын эх орон нэгтнүүд маань Германд их бэрхшээлтэй тулгарч байсан. Тэд дөнгөж Германд очсон учраас герман хэл мэддэггүй байв. Англи, франц хэл мэддэг хүн байвч герман хэлтэй хүн ховор тул би хэлмэрч хийдэг байлаа. Өдөр бүр өглөөний 7 цагаас оройн 11 цаг хүртэл ажиллаж заримдаа хоол идэх ч завгүй, талхаа явуут дундаа иддэг байв. Тэр үед би өөрийгөө жинхэнээсээ мартаж бүгдийг

тэдний төлөө зориулж байлаа. Зарим үед толгой маань жигтэйхэн хатгуулж байвч, тэдний шүд, гэдэс өвддөг тул би өвчнөө тэсвэрлэн тэднийг дагуулж эмч рүү явахдаа өвдөлтөө ч мартчихдаг байв. Цаг завгүй учраас эмчийн өгсөн аспириныг уухаа мартчихдаг байлаа. Хүмүүсийг хоёргүй сэтгэлээр халамжилсны дараагаар толгойны өвчин ч байхгүй болчихдог байсан.

Заримдаа бүтэн өдрөөр юм олж идэхгүй их зүдэрдэг байлаа. Би уг нь гэрээс гаръя гэж бодож байсан. Гэтэл тухайн үед дүрвэгсэд олон байсан тул би гэрээс гараад хэрэггүй юм байна гэж бодсон. Өдөр бүр маани уншиж, бясалгал дадуулах нь тэдэнд төдийлөн тустай биш, харин өөрөө дүрвэгсдэд туслах нь илүү дээр, илүү хэрэгтэй гэж бодсон билээ. Тэр үед би алсын хараагүй, зөвхөн дэргэд байгаа зовж зүдэрсэн хүмүүст л туслахыг бодож байсан. Өдөржингөө завгүй тул ном судар унших цаггүй байв. Зовлон зүдгүүртэй хүмүүс олноор ирэх тусам, улам л завгүй болж байлаа.

Дараа нь Улаан загалмайн нийгэмлэгт ажиллаж байхдаа улам олон золгүй дүрвэгсэдтэй нүүр тулав. Зөвхөн Ау Лакчуудаар зогсохгүй Африкчууд, Афганчууд зэрэг хүмүүс байлаа. Олон улсын байдлаас болоод өдрөөс өдөрт улам олон төрөлтөнтэй уулзаж, тэдэнд тусалж чадахгүй бол яах билээ гэж бодох болов. Энэ үед Шагжамуни Будда санаанд маань орлоо. “Гэрээс гарах нь хамгийн их буян эрдэм, ингэвэл Бурхан болж чадна. Бурхан болсны дараа нэн олон төрөлтөнд тусалж чадна. Эгэл хүний хүч хязгаартай тул тийм олон хүнд тусалж чадахгүй.” гэж Будда хэлсэн болохоор тэр үед л би гэрээс гарахаар шийдсэн.

Олон сүмд очиж үзээд гэрээс гарах нь учир утга багатай шиг санагдав. Өдөр бүр өглөө, оройн уншлага залбирал, гарын чагж, толгойн хэлбэр дүрс чагж, хөлийн чагж хийдэг. (*Бүгд инээв.*) Ямар сүнс ирж, юуг нь зооглохыг ч харсангүй. Хамаг амьтанд ямар ач тустай болохыг үзсэнгүй. Энэхүү өглөө, оройн уншлага залбирлыг би багаасаа сурч, олон ном судар уншсан. Хүүхэд ахуйгаасаа Бурханы шашны ном судрыг уншиж байсан учир, ингээд бүтэхгүй юм байна гэж бодов. Буддагийн шавь нар маш их ахуй ойлголттой болохыг “Баатараа явагч их хөлгөн судар”-аас олж мэдсэн. “Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”-т Будда олон түвшнийг дурдаж, ямар нэгэн аялгууг олж сонсоно гэжээ. Бодьсадва дадуулан бясалгаж маш олон сонсголонт аялгууг олж сонсдог бөгөөд бас Эсэрваа тэнгэрийн аялгуу ч бий. Нүдээрээ Эсэрваа тэнгэрийг харж болно, бас тийм гэрэлтэй гэсэн байна. Гэтэл би өдий хүртэл сүнслэг дадал бясалгал хийчихээд

яагаад юу ч олж хараагүй юм бэ? Яагаад ямар ч аялгуу олж сонсоогүй юм бэ? гэж өөрөөсөө асуув.

Би иймэрхүү маягаар дадуулан бясалгаж байгаадаа сэтгэл дундуур санагдаж, цаашид ингэж болохгүй юм байна гэж бодоод явж "Төгс Гэгээрсэн Их багш"-ийг эрэхээр шийдэв. Би заавал Буддагийн дурдсан гэрэл болон түвшнийг үзнэ, Буддагийн хэлсэн аялгууг өчүүхэн төдий боловч сонсоно гэж өөртөө хэлсэн. Би тэр дорхноо Бурхан болох, бүхий л орчлон ертөнцийг тэр даруй үзье гэсэн шуналын сэтгэл өвөрлөөгүй. Харин Буддагийн ном сударт дурдсан нотолгоо, ахуй ойлголтыг бага ч атугай мэдэрвэл сэтгэл санаа маань амарч явж буй замаа зөв болохыг, зөвхөн үүгээр явбал гэртээ лавтайяа харьж чадахыг нотолж болох юм гэж бодсон билээ.

Хэрвээ баталгаа болох зарим зүйлийг үзэхгүй бол үнэхээр гэр лүүгээ харих зам уу?, эсвэл буруу номтны зам уу? гэдгийг би ялгаж мэдэхгүй. Гэр лүү буцах замд ямар нэгэн онцгой тэмдэг байх ёстой. Жишээлэхэд, манай Буддын сүмийн гадна том гүүр бий. Гадна талын онцгой тэмдгийг нь л олоод харчихвал сүмд удахгүй хүрэх гэж байгаагаа мэдчихнэ.

"Баатараа явагч их хөлгөн сударт" өгүүлсэн ахуй ойлголт надад байхгүй, "Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн сударт" дурдсан ахуй ойлголт ч бас байхгүй. Арьяабал бурханы нэрийг уншвал "галд унавч шатахгүй" гэж "Хотол зохилдогч зүйл"-д өгүүлжээ. Нэг чүдэнз асааж хуруугаа дээр нь баринга Арьяабал бурханы нэрийг уншиж шатах эсэхийг туршаад үз. Зөвхөн нэг л хуруугаараа туршаарай. Хоёр гараа битгий тавиарай, шатчихна шүү! Иймээс би хүнийг хууран мэхэлж болохгүй гэж бодсон. Би тэр үед ахуй ойлголттой болохыг хүссэн ч тэгэх аргагүй байв. Би угаасаа усанд сэлж чаддаггүй. "Хотол зохилдогч зүйл"-д: "Арьяабал бурханы нэрийг уншвал усанд унасан ч хөвж гарна." гэжээ. Усанд унангуутаа живж эхлэхэд хүн ирж авраагүй бол би тэр дороо ангижирчих байсан.

"Иймэрхүү янзтай байж болохгүй. Бага ч гэсэн ямар нэгэн баталгаа байх ёстой. Тэгвэл үргэлжлүүлэн бясалгаж болно." гэж би бодов. Би бага ч гэсэн итгэлтэй байх хэрэгтэй. Хэрэв ангижрах үед Авид бурхан ирж тосохгүй бол яана? Одоо надад хэрэглэхэд хүрэлцэхүйц бага сага мөнгө хэрэгтэй. Хэрэв мөнгөгүй бол намайг ангижрах үед эзэн маань хэчнээн их мөнгө өгсөн ч хэрэг болохгүй. Бас тэр өгөхгүй ч байж магадгүй.

Тэр үеэс эхлэн, намайг ном сударт өгүүлсэн тэр бүх ахуй

ойлголттой болгож чадах нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшийг эрж эхлэв. Нэг хоногийн дотор бүхий л ахуй ойлголттой болж мэдээж чадахгүй. Бага зэргийн ойлголттой болчихвол угаасаа хангалттай. Учир нь сүнслэг дадал бясалгал хийхэд урт удаан хугацаа хэрэгтэй. Нэг өдрийн дотор Бурхан болж чадахгүй. Шагжамуни Будда зургаан жил дадуулан бясалгажээ. Иймээс сэтгэлийг маань тайвшруулах бага ч атугай ахуй ойлголт, баталгаа болох зүйл бидэнд байх хэрэгтэй. Энэхүү ахуй ойлголт нь биднийг баяр баясгалантай болгоод байгаа юм биш. Харин ахуй ойлголттой болсноор бидний дэс өөр болж, бид баяр жаргалтай болдог. Бид өөрчлөгдсөн байдаг.

Энэ нь их түшмэл ханхүүг эрж олсонтой адил. Хэдийгээр түүний сэтгэл санаа төдийлөн өөрчлөгдөөгүй байж магадгүй ч гадна төрх нь мэдэгдэхүйц өөрчлөгдөн, өмсөх сайхан хувцастай, зарах мөнгөтэй, унах морьтой, асрах хүнтэй, аливаа бүгд урьдынхтай адилгүй болжээ. Тэрээр хааны ордонд очсоны дараа хэрхэн өөрчлөгдөхийг та нар лавтайяа мэдэж байгаа.

Иймээс бид ядахдаа ханхүүгийн хувцсыг жаахан ч гэсэн өмсөж, зарах бага сага мөнгөтэй байх хэрэгтэй. Үгүй бол ангижирсны дараа ханхүү болж хувираад ч хэрэггүй. Тэгээд ч тэр үед бид өөрсдийгөө ханхүү мөн үү, биш үү? гэдгээ ойлгохгүй болно.

Багш нь тэрхүү баяр баясгалантай байдлыг хэдийнээ олчихсон учраас та нартай бас хуваалцах ёстой. Мэдээ дамжуулагч их түшмэл бол улсын хаан биш. Тэр та нарыг ханхүү болгож чадахгүй. Зөвхөн мэдээ дамжуулж: “Та бол ханхүү. Өөрөө хааны ордноо эрж олоод хаан болоорой.” гэж хэлж өгнө. Их Багшаас суралцах нь үүнтэй адил. Их Багшийн хариуцлага бол та нарт хэн болохыг чинь хэлж өгөх явдал. Иймээс та нар Их Багшийн гадаад төрх, явдал суудлыг анхаарах хэрэггүй. Их Багш хоолоо яаж идэж байна?, Их Багшийн яриа сонирхолтой юу, үгүй юу? зэрэг нь танай улс орон, хаан эзэнд хамаагүй. Та нарын байр суурьт ч хамааралгүй юм. Та нарын өөрсдийн чинь байр суурь тун өндөр, энэ ертөнцийн хамгийн эрхэм дээд нь. Хэрвээ өөрийнхөө жинхэнэ байр суурийг эргүүлэн олъё гэвэл би та нарыг дагуулж явъя гэж хэлэх гэж ирсэн.

Тиймээс нэгэн Их Багшаас суралцъя гэвэл үйлдлийг нь шүүмжилж болохгүй, гадна төрхийг нь өөчилж гоочилж болохгүй, хийж буйг нь шүүж болохгүй. Тэрээр зөвхөн томилогдож ирсэн их түшмэл төдий. Та нарыг дагуулан байх ёстой байр суурийг чинь сэргээж өгөх тул Түүнийг дагаад л явбал болно. Их Багшийн

ажилд оролцох хэрэггүй. Түүний өмссөн хувцас нь гоё эсэх, алхаа гишгээ нь хурдан эсэх зэрэг нь та нарт хамаагүй. Та нар түүнийг дагаад явахад л болно.

Гэвч олон хүн Их Багшийг эрж хайхдаа зөвхөн түүний гадна төрхийг л харж алдаа хийдэг. Сүр жавхаагүй бол багшлуулахгүй.

Гэлэнмаагаар багшлуулахгүй, гэлэнг бол хүлээж байгаад ч хамаагүй багшлуулна. Гэлэнмаа намхан нуруутай бол таашаахгүй. Төв аялгаар ярихгүй юм уу, эсвэл түргэн зантай бол, өөртэй нь таарч зохицохгүй бол таалагдахгүй байна гэнэ. Гэтэл эдгээр нь бидний уг чанартай ер хамаагүй. Түүнийг сонсох, сонсохгүй нь Их Багшид ерөөсөө хамаагүй байдаг.

Их Багш хүмүүнийг сургахаасаа өмнө тэрхүү явах зам бартаатай хамаг амьтныг гэтэлгэхэд бэрх, түмэн зовлон бэрхшээлтэй тулгарна гэдгээ аль хэдийнээ мэдэж байдаг. Гэвч Их багш төрөл төрөлдөө хамаг амьтныг гэтэлгэхээр ирдэг билээ. Учир нь хамаг амьтан цөм бидний төрөл садан юм. Хэрэв аав ээж, ах дүү нар маань алдаа гаргасан ч мөн л төрөл садан учраас бид тэднийг хүндэтгэнэ, хайрлана, тусална, аварна. Тийм үү? Хэрэв манайх дэггүй хүүхэдтэй байгаад, уг хэл авахгүй зүггүйтээд байвал бид түүнийг гол руу түлхээд орхичихож чадах уу? Чадахгүй. Харин ч өдөр бүр асарч, хооллож хувцаслана. Тэр биднийг харааж загнавал бид хэдийгээр дургүйцэх боловч маргааш нь урьдын адил хайрлаж халамжилна.

Олны дунд сайхан үг ярьдаг хүн зөндөө байдаг. Харахад их ёсорхог, тун эелдэг зөөлөн байдаг хэдий ч уг дүрээ эрж олоход маань тэд тусалж чадах уу? Чадахгүй. Тиймээс энэ сайхан үг, эелдэг зөөлөн зан, ёсорхог яриа нь дадал бясалгалтай холбоогүй. Бид хүний гадаад төрхийг харах хэрэггүй. Их багш сайн, муу байх нь бүгд бидний үйл түйтгэр юм. Хэрэв үйл түйтгэргүй бол Их багшийн хувийн чанар болно. Ганц хоёрхон хүний төлөө Их багш өөрийнхөө хувийн чанарыг өөрчлөхгүй. Хэрэв өөрчилдөг юм аа гэхэд нэгнийх нь санаанд нийцэж байхад нөгөөх нь дургүйцэж болно. Тэгвэл яах вэ? Их багш хүн бүрийг баярлуулах боломжгүй. Тийм үү?

Иймээс хамаг амьтныг гэтэлгэхэд тун бэрх. Тэдний элдэв янзын дадал зуршилтай тэмцээд зогсохгүй дур сонирхолтой нь ч бас тэмцдэг. Их багшийг шар өнгийн хувцас өмсөхөд нэг нь дуртай байхад, нөгөө нь улаан өнгийн хувцсанд дуртай, өөр нэгд нь ногоон өнгийн хувцас таалагддаг байх жишээтэй. Тэд олон хувцас худалдан авч Багшдаа өмсгөх гэдэг. Хэрэв Багш нь өмсөхгүй бол тэд санаа зовдог. Идэх юм авчраад Багшдаа өгөхөд

нь идэхгүй бол багш надад дургүй болохоороо авчирсан юмыг маань идэхгүй байна гэж боддог. Сүнслэг дадал бясалгалд тийм мугуйд байж болохгүй. Үйл түйтгэр нь хэтэрхий их байдгаас зарим хүн Их багшийг хэсэг хугацаанд дагасны дараа Багшийн хувийн чанар тэдний таашаалтай нийцэхгүй байна гээд салж явдаг. Энэ бол өөрийгөө хорлож байгаа хэрэг. Би юу хийж чадах билээ? Ганцхан хүн яаж бүх төрөлтний санаанд тааруулж чадах вэ?

Амьтны хувьд ч бас адил. Зарим хүн шувуунд дуртай байхад хөрш нь дургүй байдаг. Өдөржингөө жиргээд байхаар нь хор өгч хөнөөх арга олсон ч түүнийг шувуундаа маш хайртайг нь хараад яаж ч чаддаггүй. Та нар сүнслэг дадал бясалгал хийе гэвэл өөрсдөө жинхэнэ ёсоор дадуулан бясалгах хэрэгтэй. Их багшийг хараад хэрэггүй. Их багш замчилж байгаа болохоос "Дао" биш. Энэхүү бие махбод, оюун ухаан, дэлхий ертөнц, нийгэм ийм л байх ёстой, өөрчлөх аргагүй.

Та ийм Их багшийг жинхэнээсээ эрж олсон бол өөрөө хичээнгүйлэн бясалгаарай. Хэсэг хугацааны дараа дотоодын Их Багшаа харах бөгөөд биднийг дээд түвшинд дагуулан аваачна. Үнэн ёсыг жинхэнээр сурна. Ингэвэл жинхэнэ сайн Их багш болно. Үнэн ёсыг таньчихвал нийгмийн янз бүрийн үзэл бодол, ёс уламжлалд хүлэгдэхээ болино. Нилээд хугацаагаар бясалган дадуулсны дараа өөрийнхөө жинхэнэ Их багшийг дотооддоо олж харна. Тэр үед энэхүү дотоодын Их багш нь ганцхан чинийх л байх болно. Их багш энэ дэлхийд залрахдаа энэхүү бие махбодыг ашиглан хамаг амьтдыг сургадаг. Хүмүүс хоорондоо ялгаатай, тэдний хувийн чанар мэдээж адилгүй тул, ганцхан чамд онцгойлон хандаж, хүсэл сонирхолд чинь нийцүүлэх боломжгүй.

Шагжамуни Будда ч хамаг амьтныг баярлуулах боломжгүй. Есүс Христ ч мөн адил. Иймээс тэр загалмайд цовдлуулсан билээ. Хэрэв Есүс Христ шиг агуу хүнийг хүн бүр хайрлаж байсан бол тэр загалмайд цовдлуулахгүй байх байсан. Тэрбээр олон шидийг үзүүлж, гайхамшигт нууцлаг зүйлүүдийг үйлдэж байсан. Өвчин эмчилж, үхсэн хүнийг амилуулж, усыг архи болгож, олон юмыг хоол хүнс болгон хувиргаж, хүмүүст тарааж байсан. Тийм агуу, нэр алдартай хүн эцэстээ хамаг амьтны гарт цовдлуулжээ.

Иймээс зөвхөн Багшаа хараад байж болохгүй. Та нар өөрсдөө сүнслэг дадал бясалгал хийсэн нь дээр. Багш нь та нарт нотолгоо өгнө. Анхны ахуй ойлголтыг өгч та нарт итгэл төрүүлнэ. Дараа нь өөрсдөө сайн дадуулан бясалгах хэрэгтэй. Багшийнхаа гадна төрхийг харах хэрэггүй, энэ нь туулан гэтлэхтэй хамаагүй.

ЧАНАГУУХ ЕРТӨНЦИЙН АЯЛГУУ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар. Формосагийн Пэнхү. 1987 оны 4 дүгээр сарын 24 (Эх нь хятад хэлээр)

Гэгээнтнүүд ээ, найзууд аа ! Та бүхэнтэй анх уулзаж байгаа ч Бурханы шашны үйл үрийн хуулиар бол бид сайн найзууд билээ. Учир нь урьд төрөлдөө бид хэдийнээ сайн найзууд байсан болохоор одоо дахин уулзаж байгаадаа би баяртай байна. Та нар баярлаж байна уу? (*Хүмүүс баяртай байна гэж хариулав*.) “Ган шиа” (*талархлаа гэсэн утгатай, Багш формоса аялгаар хариулав*.) (*Бүгд инээв*.)

Бурханы шашинд үздэгээр бид их барилдлагатай хүмүүс юм. Барилдлага гэж юу вэ? Урьд төрөлдөө хамт байж, хоорондоо ямар нэгэн холбоотой байсныг хэлж байна. Бид ганцхан удаа хүн болж төрж байгаа юм биш, дахин ирж буцаж, сансрын хүрдэнд олон удаа эргэлдсэн. Бидэнд төрөл авах бүрд тун олон найз нөхөд, төрөл садан, эр нөхөр, эхнэр хүүхэд байсан. Иймээс одоо бүгдээрээ энд ирж буй нь танихгүй хүмүүс уулзалдаж байгаа юм биш, зөвхөн хувцсаа сольсон төдий юм. Энэ (*Их Багш биеэ заав*.) бол нэг төрлийн хувцас. Бидний дотоод дахь жинхэнэ эзэн нь энэ махан бие биш. Ирэх бүртээ өөр хувцас өмсдөгөөс бие биеэ танихгүй болжээ. Гэвч бид сүнслэг дадал бясалгалаа сайн хийвэл өнгөрсөн, одоо, ирээдүйгээ харж чадах бөгөөд бид хоорондоо холбоотой, хамт байх жинхэнэ барилдлагаа харилцаатай байснаа мэднэ.

Энд ирж ном сонсож буй хүмүүсийн дунд өөр шашны төлөөлөгчид болон сүсэгтнүүд байна. Тухайлбал, Католик болон Даогийн шашинтан байна. Та нар үйлийн үр байдагт итгэхгүй байж мэднэ. Үнэндээ бол Есүс Христ ч “Үйлийн үр”-ийн тухай ярьсан байдаг. Библид Тэрээр хэлэхдээ: “Би бол эртний нэгэн Их Багшийн хувилгаан дүр.” гэжээ. Тэрээр мөн: “Их Багш нар

хувилгаан биеэрээ ирээд үргэлж та нартай цуг байдаг. Гэвч та нар түүнийг таньдаггүй.” гэжээ. Түүний санаа нь маш тодорхой бөгөөд үйлийн үр, сансрын хүрдийг зааж байгаа юм. Тэрээр: “As you sow, so shall you reap” гэж хэлсэн нь: “Чи юу тарина, түүнийгээ л хураана.” гэсэн утгатай. Энэ нь үйлийн үр биш бол, өөр юу байх бэ? Бурханы шашинд ярьдагтай адилхан л байна шүү дээ.

“Даодэжин” (Мөр ёсны судар)-д ч гэсэн үйлийн үрийн тухай ярьдаг. Эртний хятад хэлийг нэлээд хэцүү учраас та нар ойлгохгүй байх. Хичээнгүйлэн уншвал ойлгоно. Жишээлбэл, Лууз: “Энэхүү “Дао” (Мөр ёс) угаас төв дундыг баримталдаг, гэхдээ Тэр сайхан санаа сайтай хүн рүү хэлбийнэ.” гэжээ. “Даодэжин”-гийн далан есдүгээр бүлэгт: “Тэнгэрийн ёс садан үгүй, ер сайн хүнтэй хамт.” гэжээ. Үүний утга нь бас үйлийн үрийг зааж байна. Учир нь энэхүү “Дао” сайн хүмүүст л тусалж, буян ерөөл соёрхдог. Үүний санаа нь бас “үйл байвал үр байх”-ыг хэлжээ.

Иймээс бид гүнзгийрүүлэн бодвол шашин бүр адил зүйл ярьдгийг ойлгоно. Багшийнх нь ярьсан ч үүнтэй адил. Лалын шашин ч бас ижил зүйлийг сургадаг. Гэвч бидний өнөөдрийн зорилго шашны асуудлыг хэлэлцэх явдал биш болохоор энэ талаар нурших шаардлагагүй.

Шашнууд үнэн хэрэгтээ бүгд адил болохыг яагаад түрүүлж ярьсан бэ? Хэрэв энэ гол зүйлийг хэлэхгүй бол шашин шүтлэгээ өөрчлөөд, Бурханы шашинтан бол гэж биднийг ятгахаар иржээ гэж ном сонсохоор ирсэн хэсэг хүмүүс бодож магадгүй. Үгүй, үгүй. Надад тийм хүсэл байхгүй. Миний бодлоор нэр нь адилгүй ч бүгд л Бурханы шашинтан. Бурханы шашин, Католик шашин, Даогийн шашин, Лалын шашин бүгдээрээ сайн. Гэвч миний санаа нийлдэггүй нэг зүйл бол одоогийн Бурханы, Католик, Даогийн, Лалын шашинтнуудын ихэнх нь сургаалын эзнийхээ номлолыг буруу ойлгосноос олон урсгалд хуваагдаж, марган зөрчилдөх болсон явдал. Шашнуудын дотоодын маргаан, зөрөлдөөн тасрахгүй байхад, шашин хоорондын мөргөлдөөний талаар ярихын ч хэрэггүй. Үүнд би гүнээ харамсаж байна.

Нэгэн сургаалын эзэн энэ ертөнцөөс ангижирсны дараа Үнэн ёсыг уламжилж чадах гарамгай шавь байхгүйгээс сургаал ном нь улам доройтож өөрчлөгдсөөр өдийг хүрчээ. Бид шашнуудыг өөр гэж боддог ч үнэндээ ижил. Эдгээр сургаалын эздийн сургаал номлолыг үнэн зөвөөр ойлговол Үнэн ёс бүгд адил болохыг мэднэ. Шашин нь адилгүй ч бясалгал дадуулах арга нь нэг адил.

Миний бодоход ямар ч шашин шүтсэн Арьяабалын бясалгалын аргаар бясалгаж болно. Би яагаад ингэж хэлэх

болов? Яагаад заавал Арьяабалын бясалгалын аргаар бясалгах ёстой гэж? Бясалгахгүй байж болох уу? Мэдээж болно. Шашин шүтэхгүй байж ч болно. Харин яагаад заавал бясалгал хийх ёстой вэ? Нэлээд юм боддог, асуудлыг эргэцүүлэх чадвартай зарим хүн: "Би хаанаас ирсэн бэ?, Нас нөгчсөний дараа хаачих вэ?. Яагаад би энэ дэлхийд хүн болж төрсөн юм бэ? Хүн болох нь зовлонтой юм бол болохгүй байж болох уу?, Энэ ертөнцөөс илүү сайхан газар байна уу? Бие дааж сонголт хийх эрх надад байна уу?. Энэ дэлхийг орхиё гэвэл дураараа орхиж, өөр газар амьдаръя гэвэл хүссэн цагтаа явж, үхэх төрөхийн орчилд хүлэгдэхгүй бие даасан, эрх чөлөөтэй байж чадах уу?" гэж өөрөөсөө байнга асуудаг.

Хэрэв бидэнд иймэрхүү асуулт байвал хариулж чадах хүнийг эрэх нь мэдээж. Тиймээс ихэнх хүн шашны мяндагтнууд дээр очдог. Жишээлбэл, Католик шашинтан ариун эцэг, гэлэнмаа дээр, Бурханы шашинтан гэлэн, гэлэнмаа эсвэл гэрээс гараагүй Бодьсадва дээр очиж асуух юм уу, шавилдаг. Ихэнх хүн тэдгээр шашин номын газраас хангалттай хариу авч чаддаггүй тул өөр газраас хайсаар нэгэн багштай учирч магадгүй. Бид түүнийг гэгээрсэн багш гэдэг. Түүнээс суралцах хэрэгтэй. Учир нь энэхүү багшийн хариулт илүү тодорхой тул асуудлаа шийдвэрлэхэд бидэнд тусалдаг.

Хэрэв та орчлонгийн мөнх бусыг эргэцүүлж, учрыг нь олохыг хүсдэг бол Арьяабалын бясалгалын аргыг танд уламжилж чадах гэгээрсэн багшийг олоод уг аргаар дадуулан бясалгах хэрэгтэй. Арьяабалын бясалгалын арга нь орчлон ертөнцийн болоод мөнх бусын бүхий л асуултын учрыг тайлж өгөөд, хариуг өөрөөр нь олуулдаг хорвоод хосгүй түлхүүр юм. Хариултыг заавал өөрөө ухаарч ойлгох хэрэгтэй. Зөвхөн бусдын яриаг сонсох төдий ч биш, хүссэн үедээ энэ ертөнцийг орхих ч биш, бусад газар руу санасан цагтаа дур зоргоороо явах бүр ч биш.

Урьдаар дээдийн бясалгалын аргыг хайж олоод тасралтгүй сайн дадуулсны дараа туулан гэтлээд, тийм чөлөөтэй болж санасан газартаа саадгүй хүрч болно. Энэ нь ямар ч оронд чөлөөтэй зорчих визтэй болсонтой адил. Заавал Формосад байнга оршин суух албагүй. Арьяабалын аргаар дадуулан бясалгасны дараа хаанаас ирснээ, энэ ертөнцийг орхисны дараа хаа очихоо мэдэх болно.

Жирийн үед таагүй явдал тохиолдохгүй л бол ямар ч асуудалгүй байна. Харин бие өвдөх, төрөл саднаа нас барах үед бид сул дорой, тусламж дэмжлэггүй мэт санагдан, хүчин мөхөстөж, тэднийг үлдээхийг хүсэвч чадахгүй. Бидний эцэг, эх

явахаа хүрвэл яваад л өгнө, хэн нь ч үлдэхгүй. Өөрөө явмааргүй байсан ч боломжгүй, цаг нь ирвэл баян ядуу, дээдэс доодосгүй бүгд энэ ертөнцийг орхих хэрэгтэй болдог. Тэр үед ямар ч сонголтгүй тул их зовлонтой. Төрөл садандаа сэтгэл хоргодовч ямар ч аргагүй.

Хэрэв та амьд байхдаа нэгэн Төгс Гэгээрсэн Их багшийг даган Арьяабалын бясалгалын аргаар дадуулж байгаад удалгүй нас нөгчсөн ч бясалгалын хүч хүрэлцэхгүйгээс өөрийн эрхээр туулан гэтэлж чадахгүйд хүрвэл Их багш ирж чамайг мөнхийн эрх чөлөөт газарт дагуулан аваачих болно. Арьяабалын аргаар дадуулан бясалгаж гэгээрсний дараа та хүмүүсийг аваръя гэвэл аварна. Энэ ертөнцийг орхисны дараа дахин буцаж ирээд зовж зүдэрсэн хамаг амьтдыг аварсан ч болно. Энэ үед та эрх тааваараа өөрийнхөө эзэн байх бүрэн эрхтэй тул ирье гэвэл ирж, явъя гэвэл явна. Иймээс Арьяабалын бясалгалын арга бол сэтгэшгүй, хосгүй бясалгалын арга. Тэр бол бүтээгчийн хүч, хамгийн дээд, хамгийн анхдагч мөнхөд орших хүч юм.

Хэрвээ бид бясалгал хийдэггүй бол бид төрөл саднаа ертөнцөөс ангижрах үед: “Тэр яагаад явчихав? Яагаад өөр хүн биш, заавал тэр явах ёстой гэж?” хэмээн өөрөөсөө асуун хариулт олохыг хичээдэг. Хүн болж төрөх нь дэндүү уйтгартай, зүгээр л өдөр болгон идэж, ажиллаж, унтаж, тавь жаран жилийг өнгөрөөнө. Их удлаа гэхэд зуун жил болоод л хорвоог орхидог. Яагаад ийм байдгийг ойлгодоггүй. Иймээс бид туулан гэтэлж, билиг ухаанаа нээх хэрэгтэй.

Юуг билиг нээгдэх гэх вэ? Ухаарах нь ойлгох гэсэн санаа. Бид дараах асуултуудыг тодорхой ойлгох хэрэгтэй. Яагаад заавал хүн болох ёстой юм бэ? Яагаад орчлон ертөнц тийм зовлонтой байгаа юм бэ? Яагаад дайн дажинтай байгаа юм бэ? Яагаад, чухам яагаад ийм байгаа юм бэ? Католик шашинтнууд ийм асуулттай тулгарвал сүмд очиж ариун эцэг, гэлэнмаатай хамт бурханы магтаал дуулж, Эзэн Бурхандаа залбиран Библи уншдаг. Ингэж л чадна, өөр арга байхгүй. Энэ нь бидний сэтгэл санаанд дэмтэй, зовлонт хүсэл сэтгэлийг маань бага ч гэсэн тайтгаруулна. Заримдаа залбирлын хариу бага сага мэдрэгддэг. Бид гуниг зовлонтой, өвчтэй үедээ чин сэтгэлээсээ залбиран даатгадаг учраас нөхцөл байдал сайжирч, сэтгэл санаа бага ч атугай амардаг.

Бурханы шашинтан бол сүм хийдэд очиж мөргөдөг. Тэнд өглөө, оройн уншлага залбирал хийх, Авид бурхан, Арьяабал бурханы маани уншихыг заана. Ихэнх газар ийм л байдаг. Арай чадалтай багш бол бясалгах, ном хаялцахыг зааж, “Хэн бэ?”

гэдгийг чинь лавлуулна. Энэ асуултыг чамд тавиад өөрөөр чинь асуулгана. Үүнийг ном хаялцах гэдэг. Хэрвээ бид “хэн болох”-оо мэдсэн бол багшаас асуух хэрэг юун? Тийм үү? Олон хүн ном хаялцахад оролцоод ямар ч үр дүнгүй, өөрийгөө хэн болохыг ойлгохгүй үлддэг.

Жишээлбэл, хариугүй цангаж үхэх гэж байгаа хүн чамаас уух ус гуйвал чи түүнд ус өгөхгүй, харин “ус гэж юу вэ?”, “ус хаана байна?” гэж түүгээр өөрөөр нь асуулгах, эсвэл “Усыг бүү хайхар, март, бүү бод.” гэх нь цангаж үхэх гэж байгаа хүнд хэтэрхий харгис хандсан хэрэг болох биш үү? Харин Арьяабалын бясалгалын аргыг уламжлагч Их багш чамд тэр даруй уух ус өгөөд, ус хаана байгааг зааж өгнө. Тэгвэл чи Их Багшаас хамааралгүй болж, усаа өөрөө олж уух төдийгүй өөр бусад цангасан хүмүүсийг аварч болно. Энэ бол Арьяабалын бясалгалын аргаар дадуулан бясалгаад тэр даруйдаа олдог баталгаатай үр дүн юм.

Ном хаялцахад идэвхийлэн оролцсон ч ямар ч хариултыг биеэрээ мэдрэхгүй. Бусад аргаар бясалгаад олон зүйлийн ахуй ойлголттой болж болох ч эдгээр нь хамгийн төгс нь биш байдаг. Жишээлбэл, харсан гэрэл нь бүгд хоёрдугаар дэсийнх, очсон түвшин нь мөн л доогуур дэсийнх байдаг. Доогуур гэдгийг нь бид ямар нэгэн шашны ном судраас лавлавал ойлгоно.

Ном хаялцахад хүн бүр оролцож чадахгүй, цөөн хэд нь л оролцдог. Үүний тулд хүн урьдаар их мэдлэгтэй болох хэрэгтэй. Хэрэв тийм их эрдэм мэдлэггүй бол ном хаялцахад оролцож чадахгүй. Одоогийн даяан урьдынхтай адилгүй. Хэрэв даяанч нартай бясалгах бол эрүүл чийрэг байх ёстой. Өвчтэй хүн завилан сууж чадахгүй тул бясалгаж чаддаггүй гээд даяанч багш чамайг хүлээж авахгүй.

Би Америкт ийм “даяанч багш” гэгчтэй таарсан. Зарим хүн түүнээс: “Би завилан сууж чадахгүй, Очироорт завилгаагаар сууж чадахгүй, танд шавь орж болох уу?” гэсэнд тэр багш: “болохгүй” гэв. Тэр хүн: “Сандал дээр суугаад бясалгаж болох уу?” гэж асуусанд мөн л “болохгүй” гэв. Иймээс өнөөгийн даяаны дэг жаяг нь бясалгахыг хүсдэг энэ цагийн ихэнх хүмүүст тохирохгүй байгааг харж болно. Завилж суух нь хүмүүсийн төрөлхийн чадвар биш болохоор зарим нь завилж чаддаггүй. Ингэж сурахад нэлээд удаан дасгал сургууль хийх хэрэгтэй. Угаас завилан сууж байгаагүй болохоор нас ахисан, эсвэл дунд эргэм насанд ойртсон үедээ яаж тэр дороо завилж чадах вэ? Сүнслэг дадал бясалгалыг зөвхөн бие махбод төдийгүй “сэтгэл”-ээрээ дадуулах нь хамгийн чухал юм.

Иймээс биеийн учир шалтгааны улмаас бясалгал хийж болохгүй гэдэг нь зүйд огт нийцэхгүй. Жинхэнэ сайн бясалгалын арга бол ямар ч хүн бясалгал хийж болох ёстой. Хүүхэд ч гэсэн болно. Миний шавь нарын дотор зургаан настай хүүхэд ч бий. Тэдний дадал бясалгал маш сайн бөгөөд хүрсэн түвшин нь өндөр. Өндөр настан ч бясалгаж болно. Миний шавь нарын хамгийн өндөр настай нь хэдийнээ ная гарсан ч дадал бясалгал нь тун сайн, бас ахуй ойлголттой. Өвчтэй хүн хэдийгээр завилж чадахгүй ч адилхан бясалгаж болно. Нэгэн ахмад настан надаас: "Би завилж чаддаггүй, бясалгаж болох уу?" гэхэд би болно гэж хэлсэн. Тэр хүн ахуй ойлголттой болж, билиг нь нээгдсэн. Сүнслэг дадал бясалгал хийж болохгүй хүн гэж байхгүй.

Маш сайн багштай л учрахгүй бол хаана ч очсон саад бэрхшээл тохиолдоно. Зарим даяанч багш нар өндөр настныг хүлээж авдаггүй. Америкт надтай тааралдсан тэр багш жар гарсан хүмүүсийг хүлээж авахгүй байсан. Түүнтэй долоо хоногийн даяан хийж болохгүй, түүнээс бясалгал сурч болохгүй. Харин тэдэнд Авид бурханы зүрхэн тарни уншихыг заадаг. Үнэндээ нас ахисан хүн Авид бурханы зүрхэн тарнийг л зөвхөн унших биш бас дадуулан бясалгаж болно.

Ном судар, маани, тарни унших нь өөр өөрийн ач тустай. Бурханы магтаал дуулах, Есүс Христ, Гэгээн Марияд залбирах нь бас л ач тустай. Харин үүрд гэтэлье гэвэл, хамгийн дээд түвшинд хүрч үүрд эргэж ирэхгүй гэвэл ингэх нь хангалтгүй. Заавал Арьяабалын бясалгалын аргаар бясалгах хэрэгтэй. Шагжамуни Буддагийн үед Энэтхэгт олон ном судар байсан ч, Тэр зөвхөн судар ном, маани тарнид найдалгүйгээр яагаад зургаан жил хатуу бясалгасан юм бэ? Хожим Тэрээр их шавь нартаа болон хамаг амьтанд Арьяабалын бясалгалын аргаар сүнслэг дадал бясалгал дадуулахын чухлыг онцлон хэлсэн байдаг.

Есүс Христ ч бас адил. Шүтлэгтэй гэр бүлд мэндэлж багаасаа цагаан хоолтон байсан. Хэрэв бид Есүс Христийн намтрыг үзвэл түүнийг Essene clan (шүтлэгтэй овог)–д мэндэлсэн болохыг мэдэж болно. Энэ овог хэдэн мянган жилийн турш цагаан хоолтон байсан. Багаасаа цагаан хоол иддэг Энэтхэгийн бярмануудтай адил. Есүс Христ нь Essene-ийн овогт мэндэлж, цагаан хоолтон байсан юм бол яагаад Энэтхэгт очиж Хималайн ууланд хатуужилтайгаар арван хэдэн жил шаргуу дадуулан бясалгаж төгс гэгээрэлд хүрсэн юм бэ?

Иймд зөвхөн ном судар, маани, тарни унших, залбирал үйлдэх, бурханы магтаал дуулах нь хангалтгүй. Эдгээр нь бүдүүн

үйл түйтгэрийг бага зэрэг арилгадаг. Өөрөө ч мэдэрч чаддаггүй маш нарийн үйл түйтгэрийг арилгах аргагүй. Зөвхөн Арьяабалын бясалгалын аргаар сүнслэг бясалгал дадуулж байж л энэхүү мөнхөд орших "Аялгууны урсгал"-аар угааж арилгахгүй бол бид сансрын хүрднээс чөлөөлөгдөх аргагүй байдаг. Ийм учраас заавал Арьяабалын аргаар дадуулан бясалгах хэрэгтэй гэж би онцлон чухалчлаад байгаа юм.

Учир нь бид ямар ч маани тарни, ямар ч ном судар уншсан бүгд л эгэл ертөнцийн үг яриа, эд юмс тул эдгээр эгэл ертөнцийн багаж хэрэгслийг ашиглан яаж энэ ертөнцөөс хэтийдэн гэтлэх вэ? Багшийнхаа санааг ойлгож байна уу? Жишээлбэл, Пэнхү арал дээр мотоцикл, унадаг дугуй, машин тэрэг хэрэглэдэг. Явган явсан ч болно. Гэвч Формосад очъё гэвэл заавал далайг гатлах хэрэгтэй тул эдгээр хуурай газрын тээврийн хэрэгслийг ашиглаж болох уу? Мэдээж болохгүй. Формосад очъё гэвэл нисэх онгоц, усан онгоцонд суух хэрэгтэй. Усан онгоцонд суувал далайг гатална, нисэх онгоцонд суувал агаарын орон зайг туулна.

Үүнтэй адил бид энэ ертөнцөөс хэтийдье гэвэл энэ ертөнцийн багаж хэрэгсэл, үг хэлийг хэрэглэж болохгүй. Бие, хэл, сэтгэлд хамаарах зүйлс нь бүгд энэ ертөнцийн багаж хэрэгсэл, эгэл хүний багаж хэрэгсэл болно. Учир нь Авид бурхан, эсвэл Есүс Христэд залбиран даатгахад ч энэ ертөнцийн үг хэлийг хэрэглэж, ном судрууд ч бас ертөнцийн үг хэлээр бичигдсэн болохоор бүгд мөнх бусын зүйл болно. Мөнх бус бясалгалын аргыг хэрэглэвэл мэдээж мөнх бус болж хувирна.

Аялгуу яагаад тийм чухал байдаг вэ? Одоо эгэл хүний ертөнц бидэнд ямар нөлөөтэйг тайлбарлаад дараа нь чанагуух ертөнцийн сэтгэшгүй нөлөөтэй харьцуулж үзье.

Дөнгөж төрсөн нярай хүүхэд дуу аялгуунд дуртай байдгийг бид мэднэ. Хүүхдээ уйлахад ээж нь бүүвэйлбэл тэр дороо уйлахаа болино. Хэрэв дахиад уйлбал ээж нь жижиг хонх юм уу эсвэл ямар нэгэн дуу гаргадаг зүйлийг бариулбал бас уйлахаа болино.

Нялх хүүхэд яагаад дуу аялгуунд дуртай байдаг вэ? Хүүхэд эхийнхээ хэвлийд байхдаа чанагуух ертөнцийн хэлбэргүй дуу аялгуу буюу "Эзэн бурхан", "Дао", "Угийн их хүч","Бурханы хүч"-тэй холбоотой байдаг. Энэхүү аялгуу бол Бурханы хүч, Бүтээгчийн хүч мөн. Эхийн хэвлийд буй ураг хоолгүй, агааргүй, наргүй, тонгоруу байрлалтай байдаг атлаа яадаг ч үгүй. Тэр загас биш ч ургийн усандаа хахаж цаддаггүй. Юм идэхгүй ч маш түргэн өсдөг. Хэрвээ хэвлийд байсан хурдаараа өсвөл удалгүй тэнгэрт тулна. (*Бүгд инээв.*) Утгыг нь ойлгож байна уу?

Хүүхэд хэвлийд байхдаа чанагуух ертөнцийн аялгуутай хамт байдаг тул энэхүү аялгуу нь түүнийг өсгөн бойжуулж, харж хамгаалдаг. Төрөнгүүт энэхүү аялгуутай холбоо тасардаг тул зовж шаналан таагүй санагдаж, тэр даруй ганцаардал, айдас зовлонг мэдрэн уйлдаг. Инээж төрдөг хүүхэд байдаггүй. Та нар төрөхдөө уйлсан уу, инээсэн үү? (*Мэдээж уйлсан гэж нэг хүн хариулав.*) Тийм, тийм, бараг бүгдээрээ л уйлдаг. Өсгөж тэтгэсэн хүчнээсээ холбоо тасарсан болохоор тэрээр хамгийн их тайтгарал, дэмжлэгээ алдсанаа мэдэрч маш их уйтгар зовлонтой санагдан, хэтэрхий эмзэг бие махбод нь энэ ертөнцийн агаартай хүрэлцэнгүүт их өвдөлтийг мэдэрдгээс төрөнгүүтээ час хийн орилдог. Ярьж чадахгүй болохоор нь бид ч ойлгодоггүй.

Дөнгөж төрсөн хүүхэд ямар нэгэн дуу авиа сонсмогцоо дотоодын аялгуугаа гэж бодоод түр зуур санаа нь амарч уйлахаа больдог. Зарим хүн эмзэг сэтгэлтэй байдаг учраас эмч түүнд уянгалаг зөөлөн хөгжим сонсгоход сэтгэл нь тайвширдаг. Бид өдөржингөө ажиллаж ихэд ядран, харьж ирээд амрахдаа дуу хөгжим сонсвол сэтгэл тайвширч, хөнгөрөхийг мэдэрдэг шүү дээ. Иймээс манай энэ ертөнцөд дуу хөгжим тун чухал. Эртнээс нааш хүн төрөлхтөнд дуу хөгжим зайлшгүй чухал байсаар иржээ. Эгэл ертөнцийн ийм дуу аялгуу тийм чухал байхад, чанагуух ертөнцийн аялгуу бидэнд маш чухал, нэн шаардлагатай байж таарна.

Бид гэртээ хэдийгээр телевизор, радио хүлээн авагч, дүрс бичлэгийн хуурцаг үзэж, шинэ дуу хөгжим сонсож болох хэдий ч амралтын өдрүүдээр. байгалийн сайханд очиж шувуудын жиргээ, усны чимээ, далайн түрлэгийн дуу, навчсын сэрчигнээн, гадил жимсний бороонд цохигдох чимээ, мэлхий, жирхний дууг сонсох дуртай байдаг. Эдгээр дуу чимээ бидэнд тун сайхан санагдаж хөгжим сонссоноос ч илүү аятай мэдрэмж төрүүлдэг.

Зарим хүн гэртээ шувуу, муур, нохой тэжээж, цэцэг ногоо тарьдаг нь нэгэн хэвийн хотын ахуйгаас уйдсандаа биш, харин байгалийн дуу чимээ, орчин нөхцөлд илүү дуртайдаа тэр. Бид ой хөвчид очиж шувуудын жиргээ, салхины исгэрээ, усны хоржигнох чимээг байнга сонсож чадахгүй тул гэртээ тэдгээр ургамлыг тарьж, амьтдыг тэжээдэг. Эдгээр нь байгаль дэлхийг бага ч атугай санагдуулж, бидний дотоодын уг чанарт нийцэн, сэтгэл санааг амарлиулдаг. Эс бөгөөс тэсэхийн аргагүй болох биз ээ. Иймд улс орнууд эко систем, байгалийн гоо үзэмжийг хамгаалах санаачилга гаргаж, мод тайрах, зэрлэг амьтныг агнахыг хориглож байгаа нь байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалахын төлөө юм.

Эгэл ертөнцийн дуу чимээ ийм их татах хүчтэй байхад, бидний бүхий л хүсэл мөрөөдөл, асуудлуудыг шийдэж чадах чанагуух ертөнцийн "Бүхнийг чадагч" сэтгэшгүй өөр нэг аялгуу байдгийг мэдэх хэрэгтэй. Яагаад? Яагаад гэвэл бид болоод түмэн бодис бүгд энэхүү аялгуунаас бүтсэн. Библид: "In the beginning was the «word» (sound), and the word was with God, and word was God, everything was made by this, and nothing was not made by this" гэсэн байдаг.

Та нар хариад Библи уншвал ойлгоно. Үүний утга нь: "Орчлон хорвоо үүсэхэд энэхүү аялгуу байсан. "Word" нь энд аялгуу гэсэн утгатай. Энэхүү аялгуу нь Эзэн Бурхантай хамт байдаг. Энэхүү "Аялгуу" бол Эзэн Бурхан мөн. Орчлон хорвоогийн түмэн бодис бүгд энэхүү аялгуунаас үүссэн. Түүнээс үүсээгүй зүйл үгүй."

Бурханы шашны ном сударт ч бас энэхүү аялгууны тухай дурдсан байдаг. "Баатараа явагч их хөлгөн судар"-т: "Бүх Бурхад энэхүү "Аялгууны урсгал"-аар буун ирж хамаг амьтныг гэтэлгэдэг. Бодьсадва болон хамаг амьтад энэхүү "Аялгууны урсгал"-аар эх сурвалждаа буцдаг." гэжээ. (Наймдугаар боть: "Түүнчлэн ирэгсэд урсгалыг сөрөн ирвээс, бодьсадва нар урсгалыг уруудан бууж, эхний ухаарал болон сайн ухаарал солилцох мөчийг үнэхээр гэгээрсэн гэнэ.) "Хотол зохилдогч зүйл"-д: "Эсэрваагийн эгшиг, далайн түрлэгийн чимээ, чанагуух ертөнцийн ялгуусан дуун" гэж дурдсан байдаг. "Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар"-т номын багшийн буян эрдмийн зүйлд бас тийм дотоодын аялгууг дурджээ. Жишээлбэл, хонхны дуу, хэнгэргийн дуу, цангийн дуу зэрэг нь бүгд дотоодын аялгуу болно. Гэвч эдгээр нь дээд түвшний аялгуу биш, анхны түвшний аялгуу төдий л юм. Дээд түвшний аялгууны талаар энд ярьж болохгүй.

Дээд дэсийн аялгуу нь дээд түвшний ертөнцийг төлөөлнө. Ийм аялгууг сонссон хүн бүхэлдээ хувиран өөрчлөгддөг. Энэхүү аялгуу бидний бүхий л амьдралд нөлөөлж, амьдралын хэв маягийг өөрчилнө. Үйл түйтгэрийн гинжийг таслан, биднийг эрх чөлөөтэй, баяр баясгалантайгаар гэтэлгэнэ. Үүнийг олон жил хүлээхгүйгээр, ахархан хугацаанд биеэрээ мэдэрнэ. Учир нь энэ аялгууг зөвхөн бидний чих л сонсдог юм биш, далд ухамсар ч энэ аялгуугаар угаагдан цэвэршиж, өнгөрсөн төрлүүддээ бичиж хураасан бүх үйл түйтгэр, таагүй дурсамж сэтгэгдэл бүхлээрээ угаагдан ариусна. Яг л усны урсгал хувцас хунар, хир буртгийг угаан цэвэрлэдгийн адил дотоодын "Аялгууны урсгал" бидэнд үйл түйтгэрээ угааж цэвэрлэхэд тусална.

Үйл түйтгэр гэж юу вэ? Тэр бол таагүй хэрэг явдлууд

тухайлбал, бидний өнгөрсөн төрөлдөө хийсэн элдэв зүйлийн буруу хэрэг эсвэл төрөл төрөлдөө гадаад орчноос санамсаргүйгээр олж авсан муу сэтгэгдэл, дурсамж юм. Үүнийг одоо мэдэх хүнгүй ч бидний оюун ухаан хэдийнээ бүгдийг бичиж шингээсэн байдаг. Энэ бол Бурханы шашинд ярьдагчлан "үйл түйтгэр мөн бөгөөд бас католик шашныхны "анхны ял" болно. Бид төрөхдөө анхны ял буюу урьд төрлийн нүгэл хилэнц, үйл түйтгэрээ авч төрдөг. Багш нь өөр газар тавьсан айлдвараа дараа та нарт тарааж өгье. Аль ч шашинд Арьяабалын бясалгалын аргын талаар дурдсан байдаг. Зөвхөн нэрлэсэн нэр нь адилгүй боловч үнэндээ бүгд энэхүү дотоодын аялгууг заан дурдсан байдаг. Та нар удахгүй лавлах материал авах тул одоо ихийг ярилгүй, зөвхөн энэхүү аялгууны ач тусыг ярья.

Яагаад энэ аялгуу бидний тэр их үйл түйтгэрийг угаан цэвэрлэж чаддаг вэ? Учир нь аливаа бүх юм энэхүү аялгуунаас бүтсэн. Энэ аялгуу бол нэг зүйлийн хэлбэлзэл, их хүч юм. Хэлбэлзэл доогуур бол аялгуу болж хувирна. Дээд дэсийн аялгууг "Дотоодын билиг ухаан"-аараа л сонсоно. Харьцангуй доод дэсийнх нь шувуудын жиргээ, ус урсах чимээ, салхины исгэрээ, аянгын дуу болдог. Энэ дэлхий дээр бол ертөнцийн дуу чимээ болно. Дээгүүр түвшний ертөнц илүү өндөр дэсийн аялгуутай. Гэвч бидний эгэл хүмүүс энэ дэлхийн иргэн болохоор тэрхүү өндөр дэсийн аялгууг сонсож чадахгүй. Сонсъё гэвэл бид өөрийн түвшинг өндөр дэсийн ертөнцийн иргэдийнхтэй ойролцоо болтол дээшлүүлсэн үед л сонсож чадна.

Одоо энэ танхимд та нар зөвхөн багшийнхаа дуу хоолойг сонсож байна. Хэрэв далайн түрлэгийн дууг сонсъё гэвэл яах вэ? Далайн эрэгт очвол сонсож чадна, тийм үү? Үүнтэй адил бид өндөр дэсийн аялгууг сонсож, дээд түвшнийг харъя гэвэл өндөрт гарах хэрэгтэй. Тэнд очиход ямар арга хэрэглэх вэ? Энэхүү "Аялгууны урсгал"-ийг хэрэглэж байж л сонсоно. Бүхий л орчлон ертөнц энэ аялгуугаар хоорондоо холбогддог. Учир нь бүгд энэхүү аялгууны урсгалаас бүтсэн. Үйл түйтгэр ч бас энэхүү аялгууны урсгалаас бий болсон. Иймээс бид "Аялгуу"-г хэрэглэн угаас байгаагүй үйл түйтгэрээ угаан арилгаж чадна.

Жишээлбэл, сансрын хүрдэнд олон удаа эргэлдсэнээс бид тун их үйл түйтгэртэй болжээ. Гэвч хамгийн анхандаа үйл түйтгэр яаж байсан байж таарах вэ? Иймээс угаас үйл түйтгэргүй. Аливаа бүгд энэхүү аялгуунаас үүссэн. Бидний хийсэн гэм буруу муу нөхцөл байдлын нөлөөллөөс болсон байж магадгүй. Тэгэхээр аялгуунаас бүх юм бүтсэн юм чинь "гэм ял" ч бас үүний гадна

оршихгүй. Иймээс бидний алдаа биш. Багшийнхаа хэлсэн санааг ойлгож байна уу?

Хэдийгээр та нар багшийнхаа ингэж ярихыг сонсож байвч үйл түйтгэр чинь тийм түргэн арилахгүй. Та нар зөвхөн сонсоод ойлгосон төдий. Үйл түйтгэрээ арилгая гэвэл заавал энэхүү аялгуугаар угаах хэрэгтэй. Багшийнхаа ном тайлахыг сонсвол нэлээд бүдүүн түвшний үйл түйтгэр чинь арилах нь мэдээж. Үүнийг та нар харахгүй байсан ч хамаагүй, би итгүүлэх гэж зүтгэхгүй. Та нарт ойлгуулахын тулд бага сага ярьж, лавлагаа болгож байгаа юм.

Багшийгаа харах буюу хамт байх үед бүдүүн түвшний үйл түйтгэр цэвэршдэг. Харагдаж мэдрэгдэхгүй, гүн үндэстэй, маш нарийн түвшний таагүй дурсамж, сэтгэгдлийг заавал харагдаж мэдрэгдэхгүй, нарийн түвшний аялгууны урсгалаар угаан цэвэрлэх хэрэгтэй. Учир нь энэхүү аялгууны урсгал сэтгэшгүй хүчтэй. Үүнтэй холбогдвол бохир бүхэн ариусах болно.

Үл үзэгдэх хүч гэж энэхүү аялгууг хэлж буй бөгөөд энгийн нүдэнд харагдахгүй, энгийн чихэнд сонсогдохгүй тул бид дэсээ дээшлүүлж өндөр түвшинд хүрвэл энэхүү дээд дэсийн аялгууг сонсоно. Энэ дэлхийд бид зөвхөн энгийн дуу аялгууг сонсдог. Жишээлбэл, шувуудын жиргээ, хорхой шавжийн дуу чимээ, далайн түрлэгийн дуу, эсвэл манай ертөнцийн дуу хөгжим зэрэг.

Дээд дэсийн дуу хөгжмийг сонсъё гэвэл дээд дэсийн хүн болох хэрэгтэй. Дээд дэсийн хүн болъё гэвэл дээд түвшинд хэдийнээ хүрсэн хүнийг олж дагах хэрэгтэй. Тэр бидэнд тусалж хаалгыг онгойлгон, биднийг оруулах болно. Тэрээр орчны байдлыг сайн мэддэг замч шиг гэр хаана байгааг мэддэг бөгөөд бас цоожийг онгойлгох түлхүүртэй. Гагцхүү бид орохыг хүсвэл тэр хаалгыг онгойлгож өгнө. Утгыг нь ойлгож байна уу?

Иймээс бид Төгс Гэгээрсэн Их Багшийг эрэх хэрэгтэй. Дээд дэсэд хүрэхийн тулд ном судар унших нь тэгтлээ тус болохгүй. Уншлаа гэхэд зөвхөн доогуур дэсэд хүрээд л тэндээ зогсох болно. Ном судар унших нь бидний сэтгэл санааг бага зэрэг таатай болгох төдий л юм. Ертөнцөөс хэтийдье гэвэл заавал Төгс Гэгээрсэн Их багшийг олох хэрэгтэй. Түлхүүртэй хүнийг олж чадвал тэрээр дээд түвшний хаалгыг онгойлгон биднийг дээш гаргана. Хаалга хаана байгааг Тэр мэддэг болохоор онгойлгомогц бид дээд түвшний аялгуу болон нөхцөл байдлыг биеэрээ мэдрэх болно.

“Үйл түйтгэр” байдаг ч тэр нь бидний алдаа бус, үйл түйтгэр угаас байхгүй гэж би яагаад хэлсэн бэ? Бүх юм энэхүү аялгуунаас

үүссэн, үйл түйтгэр ч аялгууны “алдаа”-гаар бүтсэн. (*Багш инээв.*) Иймээс бид аялгуугаар өөрийнх нь алдааг засуулах хэрэгтэй. Бид угаас үйл түйтгэргүй, гэм зэмгүй гэдгийг одоо та нар ойлгосон байх.

Жишээлбэл, хоёр хоногийн өмнө (*Багш шавиа заав.*) багшийгаа ихэд хайрладаг нэгэн авшигтан эмч намайг багадаа аршийн алга идэх дуртай байсныг сонсоод жимс авчирч арилгаад надад өгсөн. Аршийн алга өргөс ихтэй. Тэр их үнэнч сэтгэлтэй тул түүнийг нь авч идтэл нүдэнд харагдахгүй нарийн өргөс хэлийг минь хатган ихэд өвтгөв. Яагаад ингэж өвдсөн бэ? Угаасаа өвдчихсөн байсан уу? Үгүй. Өргөс хэлэнд шигдсэнээс өвдсөн. Одоо яавал дээр вэ? Аспирин уувал тус болох уу? Толгой өвдсөн бол энэ эм тустай байж магад. Гэтэл энэ нь дотроосоо биш, гаднаасаа өвдөж байгаа. Тэгвэл яах вэ? Өргөсийг нь сугалаад хаячихад л болно шүү дээ!

Өөрсдийгөө үйл түйтгэртэй гэж бид байнга ярьдаг. Яаж үүнийгээ мэдсэн юм бэ? Амьдрал их зовлонтой. Заримдаа ямар ч учир шалтгаангүйгээр зовдог. Хэдийгээр амьдрал сайн, мөнгөтэй, нөхөртэй, эхнэртэй, үр хүүхэдтэй, харахад сайхан мэт ч бас л зовлонтой. Учир нь бид урьдын үйл түйтгэрийн нөлөөнд автсан, бас угийн хүчнээсээ холбоо тасарснаас ихэд ганцаардаж, сэтгэл дундуур байдаг. Энэ ертөнцийн юунд ч түүний сэтгэл ханахгүй, хаан болсон ч ханахгүй. Та нар маш баяр баясгалантай хааныг харсан уу? Тун цөөн, сэнтий нь өндөрсөх тусам үүрэг хариуцлага нь ихэсдэг. Энэ дэлхийн өндөр зиндааны хүмүүс тийм ч их баяр баясгалантай байдаггүй.

Учир нь энэ дэлхий дэх байр суурь хамгийн төгс төгөлдөр нь биш, бидний эрж хайж буй тэр зүйл ч биш. Төрийн тэргүүн болсон ч удлаа гэхэд тавин жил л болно. Зуу хүрвэл өндөр насалсанд тооцогдоно. Эгэл ертөнцийн юу ч мөнх бус. Тиймээс бүх зүйл баталгаагүй санагдаж өдөр болгон бухимдан уйтгарладаг. Аялгуутай цуг байхдаа л баяр хөөртэй болдог. Жишээлбэл, эрүүл саруул хүний гарыг хэн нэгэн нь цавчихвал тэр баярлах уу? Цавчуулсан гар хэвээрээ байгаа ч биеэсээ салсан тул амьдрах хүчгүй болж, өнчрөн жавхаагүй болж төд удалгүй үхжиж сэргэхээргүй болно. Тасарсан гарыг сэргээе гэвэл буцааж залгах хэрэгтэй.

Германы эмч нар өвчтөний тасарсан гарыг залгаж чадах болжээ. Энэ бол их хүнд нарийн мэс засал юм. Судас, мэдрэл болгоныг нь залгаж оёвол хэсэг хугацааны дараа залгасан гар урьдынхтайгаа адил чөлөөтэй хөдөлж чадна. Тэр үед гар маань

маш баярлана. Амьдрах хүчтэй болж, бие махбодын бусад хэсэг нь ч сэргэж эрүүл болно.

Бидний сүнсэн бие ч мөн адил. Хэрэв орчлон ертөнцийн түмэн бодисын их хүчнээс холбоо тасарвал бид их зовуурилах бөгөөд тэр хүчтэйгээ ахин холбогдвол тун баяртай болдог. Бид энэхүү хүчнээс "холбоо тасрах" үед олон саад бэрхшээлтэй учирна. Жишээлбэл, авто ослын үед гар тасарч мэднэ. Ослын газар тоос шороо, мод чулуу болон бусад заваан бохир зүйлс байдаг. Тэр ч байтугай гар хэлбэр дүрсээ алдаж, харахын аргагүй болбол энэ нь гараас биш ослоос болсон. Тийм үү?

Хүн ч мөн адил. Бид эхээс төрмөгцөө тэрхүү их хүчнээс холбоо тасарснаас олон төвөг бэрхшээлтэй учирна. Бид хүсээгүй ч аяндаа л ийм зовлон бэрхшээлд нэрвэгддэг. Жишээ нь, нэгэн хүн байжээ. Угаасаа хулгайч дээрэмчин биш ч орон гэр нь газар хөдлөлт, хар салхинд сүйрч, ажил олдохгүйгээс хөрөнгөө барж дуусгажээ. Одоо яах вэ? Гуйлга гуйж сураагүй болохоор идэх хоолгүй ихэд өлсөж, эхнэр хүүхэд нь өвдөж бүгд зовсноос идэх юм хулгайлжээ. Түүнд ийм санаа байгаагүй ч гарцаагүй байдлын улмаас хүсээгүй зүйлээ хийсэн.Тэр хүн угаасаа ийм муу хүн биш.

Үүнтэй адил бид угаас үйл түйтгэргүй. Угийн их хүчтэйгээ холбогдвол үйл түйтгэргүй болно. Иймээс л үйл түйтгэрийг угаан арилгаж болно гэж би саяхан хэлсэн. Энэхүү "хүч" (аялгууны урсгал)-тэй холбогдохоос өмнө энэ их хүчтэй хэдийнээ холбогдсон хүнтэй уулзвал адислалын хүчнийх нь нөлөөг аяндаа хүртдэг. Иймээс миний хэлснээр Багшийнхаа ном тайлахыг сонсвол бүдүүн түвшний үйл түйтгэр арилна. Гэхдээ өөрөө голд очиж биеэ угаах нь хамгийн сайн, улам цэвэр болно. Би усны урсгалтай холбогдсон болохоор надад та нарт өгөх ус тун их байна. Та нарын хувьд энэ ус хэмжээ хязгаартай. Хэрэв би өгөхгүй бол та нарынх дуусчихна, тийм үү? Хэрэв та нар өөрөө энэ устай холбогдож ус урсдаг газрыг мэдэж авбал хэчнээн ч хэрэглэсэн болно. Өөрөө хэрэглээд зогсохгүй бусдад өгч болно. Ингэвэл үүрд хэрэглээд ч барахгүй.

Саяхан би тасарсан гарын тухай ярьсан. Хэрэв түүнийг биетэй нь залгахгүй бол улам харлаад, харахын аргагүй болж эд эс нь аажмаар үхжинэ. Жаахан хугацаа алдвал залгах аргагүй болж дахин хэрэглэж болохгүй болно. Бусад оронд ийм нарийн мэс заслыг хийж чадах эсэхийг би мэдэхгүй, харин Германд хийдэг. Авто машины осол болон гай гамшгийн улмаас хэн нэгний гар тасарвал, тэр даруй мөстэй уутанд хийж, өвчтөний хамт тусгай эмнэлэгт хүргэдэг.

Германд ийм эмнэлэг цөөн, ийм мэс заслыг хийдэг эмч ч цөөхөн. Арван хоёр жил мэрийн сурч, судас, мэдрэл нэг бүрийг залгаж сураад ийм мэс заслыг хийх чадвартай болдог. Залгахгүй бол судсаар цус чөлөөтэй урсахгүй болж, эд эс нь үхжин ажиллагаагаа бүрмөсөн алдана. Үүнийг хийхийн тулд хичээнгүй суралцах хэрэгтэй. Германд ийм эмчийг эзэн бурхан шиг хүндэлдэг. Өвчтөнүүд бол мэдээж бүр ч их хүндэтгэдэг.

Ийм эмч маш цөөн. Учир нь тэд олон жил чармайн суралцдагаас гадна ажил нь тун хэцүү. Тэд арван зургаа, арван найм, цаашилбал хорин дөрвөн цаг бүх анхаарлаа төвлөрүүлэн зогсоогоороо ажилладаг. Мэс заслын явцад эмч солихгүй, дуусахаас өмнө амарч, хооллож болохгүй. Мэс засал амжилтгүй болбол гар үхжих тул тун анхаарал болгоомжтой нэг бүрчлэн оёдог. Учир нь дотроо ясан эдтэй тул бүгдийг нь нэгтгэн оёвол ажиллагаа нь сэргэж, урьдын адил чөлөөтэй хөдөлдөг болно. Энэ гайхамшиг биш үү? Залгасны дараа цус судсаар гүйж, арьс нь аажим улайж сэргэнэ.

Бидний байдал ч адилхан. Хамгийн ихдээ зуу насалдаг ч тун их зовлон бухимдалтай. Хэдийгээр мөнгө төгрөгтэй, сайхан эхнэртэй, орон байртай, сайн ажилтай байсан ч сэтгэл дундуур. Учир нь агуу “Жинхэнэ бие”-ээсээ энэ гар шиг тасран салжээ. Хурдхан залгахгүй бол удалгүй үхжиж өмхийрөөд ойртохын аргагүй болох тул хогонд хаяж, газарт булахаас өөр аргагүй.

Бид бас үүнтэй адил. Нэгэн Төгс Гэгээрсэн Их багшаар оёулан залгуулж, ганцаардсан хүнийг их хүчний “Жинхэнэ бие”-тэй нь холбох хэрэгтэй. Энэ их хүчний жинхэнэ биеийг зарим хүмүүс хамгийн дээд “Эзэн Бурхан”, зарим нь “Бурхан сэтгэл”, “Угийн сэтгэл”, “Дао” эсвэл “Их би”, “Их билиг ухаан” гэх зэргээр нэрлэдэг. Бид одоо “Бага би” болох бөгөөд, “Их би”-гийн нэг жижигхэн хэсэг юм. Тэрхүү “Их би”-гээсээ салчихсан учраас ийм зовлонтой, уйтгартай, тасарсан гартай адил харахад таагүй, сэтгэл гуниглам, амьдралын өчүүхэн ч хүчгүй байдаг. Тэр гарыг оёж залгавал судсаар нь цус гүйж маш хурдан сэргэх болно.

“Аялгууны урсгал” мөн адил. Тэрээр бүхий л орчлон ертөнцийг холбоно. Энэ аялгууны урсгалын дотор оршдоггүй нэг ч зүйл байхгүй. Гэтэл бид түүнээс холбоо тасарч, өчүүхэн төдий харилцаатай үлджээ. Нийлүүлж оёхгүй бол удахгүй энэхүү аялгууны урсгалаас бүрмөсөн холбоо тасрах учраас бид сансрын хүрдэнд эргэлдэн “зургаан заяа”-нд (зургаан заяанд тэнгэр, хүн, асури, бирд, там, адгуус багтана) зовлон амсаж, эрхэм дээд ертөнцөд дэвшин хүрэх аргагүй болдог билээ.

Хүний мөчийг залгаж чаддаг эмч болоход амаргүй. Сургуулиа амжилттай төгссөн төдийгүй бусдыг “их хайрын сэтгэл”-ээр хайрлаж чадах эмч л сонгогдох бөгөөд дараа нь удаан хүлээж байж дадлага хийнэ. Гэвч заах багш цөөн, оюутан олон тул хажуугаас нь харахаас биш өөрийн биеэр дадлагажих завшаан олддоггүй.

Германд ийм эмнэлэг ганц байдаг тул дотоод гадаадад их алдартай. Тэнд суралцахын тулд хэдэн жил хүлээдэг. Багшаас гадна оюутан ч дадлага хийж болно. Гэвч нэг удаагийн дадлагыг удаан хүлээж байж хийдэг. Хүн олон тул ээлжлэх бөгөөд бусдын хийхийг харахын зэрэгцээ өөрийн гараар хийнэ. Ингэж байж сая багш болно. Иймээс суралцахад амаргүй, нарийн мэргэшсэн эмч болох бүр ч амаргүй. Нэр алдартай болохын тухайд бүр ч хэцүү. Сурсныхаа дараа хүнийг эмчлэх төдийгүй бусдыг сургах чадвартай болдог. Хүмүүс тэднийг яагаад бурхан шиг хүндлэн хайрладгийг одоо бид ойлголоо. Тэд ч ийм нэр алдрыг хүртэх эрхтэй.

Ганц гарыг оёход ийм амаргүй байтал, нэгэн “Сүнс”-ийг оёж залгахад тун хэцүү нь ярангүй. Мэс заслын үед эмч ярихгүй хөдлөхгүй, бүх анхаарлаа төвлөрүүлэн хязгаартай цагт өчүүхэн ч алдаа гаргалгүй зогсож ажиллах шаардлагатай тул маш их ядардаг. Тасарсан гарыг эмнэлэгт аваачихад тодорхой хугацаа орсон, үргэлжлүүлээд хөргүүрт удаан хадгалбал амьдрах хүчээ алдаж хэрэгцээгүй болно. Хүн хүч хүрэлцээгүй, цаг хугацаатай уралдаж арван хэдэн цаг амралтгүй зогсож, бүх оюун ухаанаа төвлөрүүлэн ажиллах нь мэдээж их зүдэргээтэй. Уг нь эмчид тэгэх шаардлагагүй, тийм үү? Сурахдаа ч, ажиллахдаа ч зүдрээд зогсохгүй цаашдаа улам ядарсаар байгаа нь бүгд л өвчтөний төлөө юм.

Эмчийн мэргэжилд суралцах нь өөрийнхөө төлөө биш. Тэд гэмтсэн ч өөртөө тусалж чаддаггүй. Сурч байхдаа ч “би” гэх бодол оюун ухаанд нь байсангүй. Бүхий л санаа сэтгэл нь бусдын төлөө учраас шантралгүй суралцаж, дараа нь бас л зүдэрч, хагалгааны өрөөнд өвчтөний өмнөөс зовж шаналдаг.

Энэ нь Их Багштай адил. Их Багш бусдыг аврахын тулд тун их зовлон амсаж, хамаг амьтны үйл түйтгэрийг үүрч, түүнийг нь угаан цэвэрлэхдээ тэдгээрийн муу нөлөөнд өртдөг. Өвчтөн мэдээж өдрөөс өдөрт сайжирна, харин эмч улам ядарна. Анхаарлаа үргэлж төвлөрүүлэн ажилладаг тул ихэд ядардаг ч энэ нь түүний ажил болохоор гомдоллохгүй. Ажилдаа дур сонирхолтой тул бэрхшээл зовлон тохиолдсон ч мэс заслаа амжилттай хийчихвэл

тун баяртай байдаг.

Эрт эдүгээгийн Их Багш нар ч адил. Төгс гэгээрээд өөрийн билиг ухаан, хүч чадал, буян хишгээ бүгдийг нь шан харамжгүйгээр бусдад хуваажөгнө. Хурдан хуваах тусмаа сайн тул их зовлон амсдаг. Хэрвээ та нар сүнсний эмч, оюун санааны эмч болъё гэвэл Багшаасаа суралцаарай. Хожим нь та нар Багшаасаа ч сайн болж магадгүй. Яагаад гэвэл зарим хүний гар нь уран тул Багшаасаа илүү болж магадгүй. Би ажлаа тийм ч сайн хийхгүй байгаа учраас олон хүн ирж суралцвал дуртай байх болно. Ингэвэл хожим олон хүнд тустай. Сүнсийг оёж залгах эмч тун цөөн. Хэрэв олон хүн сурч чадвал тун сайн. Олон өвчтөн бидний аврахыг хүлээж байгаа.

Асуулт: Эхний өдөр би ном тайлахыг сонсчихоод, хариад Багшийн айлдварыг уншингаа адистай зүйлийг идэж байтал түүнд ямар нэгэн хүч оршиж байгаа юм шиг санагдсан. Тэдгээр адистай зүйлийн дотор тийм хүч байгаа юу?

Их Багш: Нэгэнт мэдрэгдсэн бол асуух юу байх вэ? Чи өөрөө хариулчихлаа. Тийм үү? (*Хүмүүс инээв.*) Багшийн өгсөн юм мэдээж хүчтэй, тийм биш бол чи яаж мэдрэх вэ? Багшийн айлдварыг унших, бичлэг сонсох бүгд адислалын хүчтэй. Багшийн адисалсан зүйлийг идвэл тун аюултай, дараа нь идэж болохгүй. (*Хүмүүс инээв.*) Идчихвэл энэ ертөнцөд дахин ирэхгүй байж тун болзошгүй. Буцаж ирье гэж бодож байгаа бол битгий идээрэй.

Асуулт: Өмнө нь би бясалгадаг байхдаа нэг зүйлийн аялгуу сонссон. Гэвч муугаар нөлөөлөх болов уу гэж бодоод бясалгалаа даруй зогсоосон.

Их Багш: Аялгуу нь жинхэнэ ба хуурамч гэж байдаг. Хэрэв чи нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшаас суралцаагүй бол үнэн худлыг нь ялгах аргагүй. Иймээс зогсоосон чинь зөв, түүнийг ойшоох хэрэггүй. Хэрэв жинхэнэ эсэхийг мэдье гэвэл надаас суралцаж болно. Гэвч би энд ил ярихгүй, номыг ил уламжилдаггүй. Энд сурах сонирхолгүй хүн олон байгаа тул өөрийн юмаа тэдэнд хүчээр сонсгож болохгүй. Ном уламжлах нь туйлын сүр жавхлантай, ариун дагшин явдал. Хямдхан худалдаж болохгүй. Ялангуяа олон шавьтай болохын төлөө санаан зоргоор уламжилж бүр ч болохгүй. Ном уламжлахад хүний нь харах хэрэгтэй. Зөвхөн энэ төрөлдөө туулан гэтлэх чин эрмэлзэлтэй, билиг ухаантай, Арьяабалын бясалгалын аргын тэнсэлгүй үнэ цэнийг ойлгон, нандигнан хайрлаж, сүнслэг дадал бясалгалыг хичээнгүйлэн дадуулж чадах хүнд уламжилж болно. Багшийнхаа санааг ойлгов уу?

ЧАНАГУУХ ЕРТӨНЦИЙН ГЭРЭЛ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
айлдвар. Формосагийн Пэнхү.
1987 оны 4 дүгээр сарын 25
(Эх нь хятад хэлээр)

Өнөөдөр аялгуу ажих тухай ярина. Гэвч өчигдрийн ярьсан зүйлээс арай өөр. Өнөөдөр аялгуунаас үүсэлтэй гэрлийн тухай ярих болно. Бид нар дөнгөж сая Авид бурханы магтаалыг дууллаа. Авид бурханыг самгарди хэлээр Amitabha гэдэг нь цаглашгүй гэрэл гэсэн утгатай. Цаглашгүй гэрэл хаанаас үүссэн бэ? Бас л энэхүү аялгуунаас үүссэн. Нэлээд нарийн түвшний аялгуу гэрэл болон хувирдаг. Гэрэл бидэнд тун чухал. Аялгуу маш чухал гэж өчигдөр Багш нь ярьсан. Гэрэл ч бас их чухал гэдгийг өнөөдөр ярина. Энэ тухай та нар аль хэдийн мэдсэн.

Гэрэлгүй бол бид амьдарч чадахгүй. Наргүй бол оршин тогтнохгүй. Ногоо тарих аргагүй, Д витамин дутагдана, нялх хүүхдийн өсөлт удааширна гэх мэт. Оройн цагаар сарны гэрэлтэй байсан ч эртний хүмүүс тосон дэн хэрэглэдэг байв. Одоо үед бид цахилгаан гэрэл хэрэглэж байна. Юуны учраас өчигдөр аялгууг, өнөөдөр гэрлийг ярьж байна вэ? Учир нь энэ хоёр холбоотой. Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийхэд гэрлийн бясалгалыг заавал хийнэ. Эртнээс нааш аль ч шашны бүлэглэл, ямар ч Төгс Гэгээрсэн Их Багш дадал бясалгалдаа энэхүү “Гэрэл”, “Аялгуу”-г онцгойлон авч үздэг байжээ. Аялгууны тухай өчигдөр ярьсан. Өнөөдөр гэрлийн тухай заавал ярих шаардлагатай. Ингэвэл та нар сайн ойлгоно.

Их сүнслэг бясалгагчид бүгд гэрлийн тухай ярьдаг. Билиг нээгдэхийн “Билиг” гэдэг нь “Гэгээн” гэсэн утгатай. Гэгээн гэдэг үгийг (хятадын дүрс бичгээр бол) нар, сар гэсэн хоёр дүрсийг хамтатган бичиж бүтээх бөгөөд гэгээн саруул гэсэн утгыг илэрхийлдэг. Гэрэл гэгээгүй бол яаж билиг нээгдэх вэ? Иймээс

билиг нээгдэх гэдэг нь гэрэлтэй байх, гэрэл харах, өөрөө гэрэл цацруулах, эсвэл энэхүү гэрэлтэй холбогдох гэсэн санааг агуулна.

Гэрэл их чухал. Уйлж байгаа нялх хүүхэд хонхны дуу сонсмогц уйлахаа больдог гэж Багш нь өчигдөр ярьсан. Гэрэл чийдэн унтрахаар тэд заримдаа уйлдаг. Хүүхэд харанхуй газар ганцаар унтахаас айж, гэрэл асаавал айхаа болино. Эсвэл гялалзсан тод өнгөтэй хуванцар тоглоом өгвөл хараад уйлахаа больдог.

Юуны учир хүүхэд ахуй цагаас эхлэн "Гэрэл" болон "Аялгуу" нь бидэнд тийм чухал байсан бэ? Эхийн хэвлий дэх хүүхэд гэрэлтэй хэдийнээ харилцаатай байж, энэхүү гэрэл түүнийг өсгөн бойжуулдаг. Гэрэл болон аялгуу нь адилгүй чанартай ч нэг л ижил зүйл.

Ус мөстэй, ус агаартай бараг адил утгатай. Агаарт бас H_20 байх бөгөөд устөрөгч, хүчилтөрөгчийн нэгдэл юм. Ус ч бас ийм. Гэвч ус бол агаар биш, агаар бол ус биш. Энэ хоёр хоёулаа хэрэгтэй. Амьсгалахад агаар, юм уух, хоол хийх, усанд орох гэх мэтэд ус хэрэгтэй. Ийм учир хоёулаа бидэнд тустай. Тэдний бүтэц нь устөрөгч, хүчилтөрөгчийн нэгдэл боловч ус бол агаар биш, агаар бол ус биш. Цангасан үед агаарыг ууж болохгүй, усаар амьсгалж чадахгүй. Бид хэдийгээр усанд сэлэхдээ H_20-той хүрэлцэх боловч хүчилтөрөгчөөр амьсгалах хэрэгтэй. Эс бөгөөс даруй живж үхнэ.

Энэ дэлхийд амьдрахад хэчнээн тав тухтай, сэлүүн сайхан байсан ч ихдээ л зуун жилийн хугацаатай. Тэгээд ч үнэндээ хүний амьдрал "Зовлон ихтэй, жаргал багатай.", ямар ч сайхан юмгүй. Гэвч олон хүн нүсэр том, бат бэх байшин барьж, сайтар тохижуулаад энд үүрд байх юм шиг байдаг ч эцэстээ амьдран суух хугацаагүй болно. Баян байгаад урт насаллаа ч ихдээ зуухан жил амьдардаг нь үнэхээр харамсалтай. Бидний өөрсдийн дотоодын орд харш маш гоёмсог, бат бэх, олон сайхан эд юмтай байтал бид түүнийгээ эдэлж хэрэглэхээ мэдэхгүй, гаднах мөнх бус амьдралын хойноос зав чөлөөгүй хөөцөлдөж байдаг.

Гэрэл ба аялгуу бидэнд туйлын чухал. Гэрэлгүй бол бид оршин тогтнож чадахгүй. Наргүй бол энэ дэлхий оршихын аргагүйг бид мэднэ. Жижигхэн хүүхэд ч нарны гэрэл, гэрэл гэгээтэй зүйлд дуртай байдаг. Төрсөн хүүхдийг эргэхээр ирсэн хүмүүс хурц тод өнгөтэй өнгөлөг хувцас өмссөн байвал хүүхэд дуртай байдаг. Тийм үү? Та нар хүүхэдтэй бол мэдэх л ёстой. Миний ажигласнаар хүүхдийн тоглоом нүд булаам, гэрэлтэй, өнгөлөг байдаг. Томчууд хар бараан өнгөтэй тоглоомыг хүүхдэдээ өгдөггүй. Хүүхдийн тоглоом голдуу час улаан, нов ногоон, цав

цагаан зэрэг хурц тод өнгөтэй байдаг. Тэд өнгөнд нь л дурлаж шохоорхоно.

Яагаад тэр вэ? Яагаад гэвэл хүүхэд эхийн хэвлийд байхдаа хэдийнээ энэхүү гэрэлтэй холбогдоод юм идэхгүй ч маш сайн өсөн торнидог. Учир нь энэхүү "Гэрэл" болон "Аялгуу" түүнийг ивээж өсгөн бойжуулжээ. Гэвч эхээс төрмөгцөө гэрэлтэй холбоо тасарна. Та нар Бурханы шашны "Хэвлийд орохуйн судар"-ыг уншсан бол мэднэ. Сударт дурдсанаар хүүхэд хэвлийд бүрэлдэхээс өмнө түүний сүнс нь орон зай, цаг хугацааг мэдэхгүй тэнүүчилж явсаар гэрэл хармагцаа хүрч очин хэвлийд шурган орж, ураг болон бойжоод эхээс төрдөг.

Эхийн хэвлийд байхад нь энэхүү гэрэл түүнийг асран хамгаална. Эхээс төрөнгүүт гэрэл үгүй болдог. Эхийн хэвлийд байх үеийн гэрэл асар хурц тод байдаг ч хүүхдийн нүдийг цочроодоггүй. Бие махбодыг нь хүчтэй шархируулан өвтгөж, амь насанд аюул болохгүй. Энэ бол "Бурханы гэрэл", "Түүнчлэн ирсэн гэрэл", "Уг чанарын гэрэл" учраас тун эергүү зөөлөн тул нүдийг маань гэмтээхгүй, айлган цочоохгүй. Ураг ч ийм эергүү зөөлөн Бурханы гэрэлтэй хамт байсаар хэдийнээ дассан байдаг.

Энэ дэлхийд мэндлэхэд нарны гэрэл, тэнгэр огторгуйн болон бусад материаллаг юмсын гэрэл нь хүүхдийн биеийг ихэд өвтгөж, нүдэнд нь таагүй байдаг. Хүүхэд төрөхөд нүдийг нь түмэн зүүгээр хатгаж байх шиг санагддагаас болоод нээж чаддаггүй. Бүх биед нь бас ийм мэдрэмж төрнө. Эмзэг мэдрэмтгий биеийг нь эндхийн агаар салхи дэндүү өвтгөн шархируулдгаас хүүхэд уйлдаг. Ингэж уйлах нь нэг талаар бие махбод нь зовсноос, нөгөө талаар гэрэлтэй холбоо тасарснаас болжээ. Гэрлээсээ тасраад эхийн хэвлий дэх шигээ тааламжтай, баяр баясалтай байж чадахгүй болохоор уйлдаг. Хожим аажмаар өсөж бойжоод гадаад орчиндоо дасдаг.

Нялх хүүхдийг уйлахад жижигхэн хонх бариулах юм уу эсвэл өрөөний гэрлийг асаахад гайхсандаа уйлахаа больдог. Хэдийнээ алдчихсан гэрлээ гараад ирлээ гэж бодоод хараад л байдаг. Бяцхан хонхны дууг сонсмогцоо дотоодын аялгуугаа эргээд олчихлоо гэж бодон түр сатаарч, анхааран сонсож байгаад ямар ч нэмэргүй, сүнсийг нь тайвшруулахгүй гэдгийг нь мэдмэгц ахин уйлдаг. Томчууд олон хонхтой шажигнадаг тоглоомоор их дуу чимээ гарган аргадан саатуулахад тэр уйлахаа зогсож, хуурмаг болохыг нь мэдмэгц дахиад уйлна. Тэгээд уйлахаа болино, бас дахиад л уйлна. Хүүхэд өдөржингөө л иймэрхүү янзтай байдаг.

Заримдаа ямар ч шалтгаангүйгээр уйлна. Бухимдвал уйлна. Эхээс дөнгөж төрсний дараа хүүхдийн мэдрэмж маш хурц тод,

билиг ухаан нь хамгийн цэвэр ариун байдаг тул өчүүхэн төдий ч тааламжгүй зүйлийг дорхноо мэдэрдэг. Бид хүүхдийг өөрсөд шигээ амьдрахыг албадвал тэд аажмаар үүнд дасдаг. Өсөж томроод ч мөн л гялалзсан юманд дуртай хэвээр байдаг. Та нар анзаарсан бол эмэгтэйчүүд элдэв энгэсэг түрхэх дуртай, тийм үү? Энэ бол эхийн хэвлийд байх үеийн гэрэл гэгээ далд ухамсарт нь хадгалагдаж байдгаас болжээ.

Иймээс шинэ загварын хувцас голдуу тод гэгээлэг өнгөтэй байдаг. Зун болоход бие сэтгэл тавирч хөнгөрөн, баяр хөөртэй болдог биш үү? Харин өвөл болоход тэнгэр огторгуйн өнгө бүүдийж, гэрэл гэгээ багасаж, бие сэтгэл тавгүйрхдэг нь байгалийн гэрэл багассанаас болжээ.

Бид өсөж томорсон ч гэрэл гэгээтэй зүйлсийг эрж хайсан хэвээр л байдаг. Тухайлбал хурц өнгийн хувцас өмсдөг. Өнөөдөр Багшийн чинь өмсөж байгаа энэ шар өнгийн хувцас бол та нарын дотоодын гэрлийг анхааруулан сануулахын тулд юм. Энэтхэгийн хуврагууд бүгд шар хувцас өмсдөг. Үүний цаад утга нь гэгээлэг хүн, гэрэлтэй хүн, билиг нээгдсэн хүн гэсэн санаа юм. Наад зах нь тэдэнд нарны гэрэл байдаг болохоор шар өнгө нь билиг нээгдэх үеийн гэрлийн өнгийг төлөөлдөг.

Билиг нээгдээгүй хүн ч тод өнгөнд дуртай. Амралт тоглоом, зугаа цэнгээний газрууд бүгд л нүд гялбам элдэв өнгөөр чимсэн байдаг биз дээ? Хурц тод гэрэлтэй байх тусмаа олон хүнийг татдаг. Хүн багатай ч гэрэл гэгээгээ цацруулсаар л байдаг. Ингэж байж л олон хүнийг татна. Тийм үү? Бид хамгийн хөгжөөнтэй газрын элдэв гэрлэн чимэглэлд нүдээ унагаадаг. Яг л эрвээхэй дэнгийн гэрэл хармагцаа нисэж очдогтой адил. Эрвээхэй заримдаа гал харвал нисэж очоод өөрийгөө шатаачихдаг биш үү?

Хамаг амьтад гэрэлд дуртай. Энэ бол гадна талын энгийн гэрэл. Үүнээс гадна өөр нэгэн зүйлийн “Чанагуух ертөнцийн гэрэл” байдаг бөгөөд бид түүнийг сүнслэг бясалгалын гэрэл гэдэг. Бясалгал дадуулдаг хүмүүс зарим нь их, зарим нь бага, бүгд л гэрэлтэй. Шагжамуни Будда, Арьяабал бурхан, Есүс Христийн тэргүүн дээр гэрэл цацарч байгааг бид хардаг. Тэдний дотоодын гэгээрлийн дэс нь хөгжин тодорхой түвшинд хүрэхэд гэрэл цацруулдаг байна. Энэ нь нэгэн мод ургаж бүдүүрээд алс холоос харагддагтай адил юм.

Энгийн хүн гэрэлтэй юу, үгүй юу? Гэрэлтэй. Зарим хүний гэрэл тун бараан байдаг. (*Хүмүүс инээв.*) Заримынх нь кофены өнгөтэй эсвэл хөхөвтөр, хүрэндүү, улаавтар, шаравтар байдаг. Зарим их бясалгагчийнх алтан шаргал, мөнгөлөг цагаан гэх мэт

олон өнгөтэй. Ялгаатай нь гэвэл эдгээр нь энгийн гэрэл биш тул бидний билгийн мэлмий нээгдээгүй бол харахгүй. Билгийн мэлмий бага зэрэг нээгдсэн хүнд их бясалгагчдын гэрэл тод биш бүүдгэр харагддаг.

Их бясалгагчид яагаад ийм гэрэлтэй байдаг вэ? Гэрэлтэй байх нь сайхан харагдах эсвэл өөрийгөө чимэхийн төлөө биш. Гэрэл бол түүний бие цогцос. Учир нь энэхүү гэрлийн дотоод хүч илрэн гарах бөгөөд тэр нь хүмүүсийг аварна, хамгаална. Энэхүү гэрэл дотор орвол их таатай санагдана. Иймээс гэрэлтэй хүн хүмүүсийг маш тааламжтай болгодог. Харин муу санаатай, эсвэл ад түйтгэр ихтэй хүн энэхүү гэрлийг тэсвэрлэдэггүй болохоор тун эвгүйцэж, холхон байх нь дээр санагддаг. Гэрэлд ойртох л юм бол тавгүйрхэнэ.

Уржигдар нэг хүн Багшид нь: “Таны хажууд болон эргэн тойронд цав цагаан гэрэл байхыг харсан. Гэвч ойртож болохгүй зөвхөн холоос л харж чадаж байна.” гэв. Надад ойртоход таагүй байсан тул, тэрээр: “Танд албаар ойртвол гэрэлд тань цохиулж амиа алдаж магадгүй.” гэв.” Үгүй дээ! Чи миний ойролцоо суугаад үхээгүй л байна шүү дээ! Энэ бол мэдрэмж төдий.” гэж би хариулав. Зарим хүн хэдийгээр бясалгал дадуулаад тодорхой түвшинд хүрсэн ч дотроо ад түйтгэртэй, бохирдсон хэсгээ угааж цэвэрлээгүй байдаг. Гэрэлтэй хүнд ад дургүй болохоос гэрэл түүнд дургүй биш. Багшийнхаа хэлж байгаа санааг ойлгож байна уу?

Жишээлбэл, хэрэг төвөг хийсэн юм уу, гэм буруутай хүн цагдааг хармагцаа тавгүйрхэж, айсандаа шалавхан зугтдаг нь цагдаа түүнд ямар нэг таагүй юм хийснээс болоогүй. Тэр ч байтугай цагдаа түүнийг хараа ч үгүй байхад тэр хэдийнээ зугтчихдаг. Энэ нь хоёр өөр үзэл бодол, хоёр өөр түвшин, хоёр өөр нөхцөл байдлын төлөөлөл юм. Нэг нь хамгийн хар, нөгөө нь хамгийн цагаан талыг төлөөлжээ. Цагдаа шударга ёс, хууль цаазыг төлөөлж, гэмтэй хүн харанхуй мунхаг, ялт үйлийг төлөөлж байна. Иймээс цагдааг хармагцаа эвгүйцжээ. Ихэнх гэмгүй хүмүүст энэхүү эргүү зөөлөн гэрэл тун тааламжтай байдаг бол хар санаатай, эсвэл бага зэргийн ад түйтгэртэй хүнд таагүй байдаг ч гэрэлтэй хүнд олонтоо ойртвол аажимдаа таатай санагддаг болно.

Учир нь тэрхүү гэрэл тэдний бохирдсон хэсгийг ариусгадаг. Бид энэхүү бохирдсон хэсгийг “Үйл түйтгэр” юм уу “Ад түйтгэр” гэдэг. Угааж цэвэрлэсний дараа тэр хүн асуудалгүй болж тааламжтай санагдана. Таатай байх эсэх нь энэхүү ад болоод бохирдсон хэсгээс болсноос биш, гэрэл өөрчлөгдсөн,

эсвэл тэр хүн өөрчлөгдсөнөөс болоогүй. Хүний мөн чанар угаас ариун ч, өөрийн биш, танил бус зүйл цэвэр ариун чанартай нь холилдоноос ийм болж хувирчээ.

Жишээлбэл, бид хүйтэн усаар биеэ угаавал таатай, бүлээн усаар угаасан ч бас л таатай байдаг. Гэтэл бид шархадсан, эсвэл түлэгдэж, арьс мах гэмтсэн үед усанд орвол таатай байх уу? Мэдээж таагүй, тийм үү? Та нарыг ингээгүй л байгаасай гэж би найдаж байна. Хэрэв шархтай үед усанд орвол хэцүү байдгийг та нар бүгд мэднэ. Энэ нь уснаас биш шархнаас болсон. Эдгэсэн бол яаж ч угаасан асуудалгүй. Үнэн хэрэгтээ шарх эдгэрсэн болохоос ус хувирч өөрчлөгдөөгүй.

Ад шүглэсэн юм уу, бохирдсон хүн ч ялгаагүй их бясалгагчтай ойртмогцоо бие нь тавгүйтдэг. Үргэлж түүнтэй ойр байвал яваандаа дуртай болж, дахин хэцүү санагдахаа болино. Бясалгал дадуулдаг хүн цагдаагаар хамгаалуулахгүй байсан ч болно. Өөрөө хүсээгүй л бол хэн ч ойртож чадахгүй. Хамгаалалтын хана аяндаа үүсэж, танихгүй этгээдийг нэвтрүүлэхгүй. Түрэмгийлэн орогчдыг гэрэл түлхэж байгаа юм биш, харин тэд өөрсдөө түлхэгдэж байгаа юм. Учир нь харанхуй зүйлс гэрэлд дургүй. Гэрэл байвал харанхуй үгүй, өдөр байвал шөнө үгүй. Багшийнхаа хэлсэн санааг ойлгож байна уу?

Жишээлбэл, өмнөд болон умард туйлд харанхуй хагас жил үргэлжилдэг. Харин нар нэг л мандвал ойр орчим бүгд гэрэлтэй болно. Хэдэн зуу, хэдэн мянган жил үргэлжилсэн ч байж мэдэх харанхуй, нар нэг л удаа мандахад түүний агуу гэрэлд туугдан арилдаг. Учир нь эсрэг тэсрэг чанар зэрэгцэн оршиж чадахгүй.

Дээрхийн адил орчлон ертөнцийн цэвэр ариун гэрэл гэгээтэй талыг сүнслэг бясалгагч төлөөлөх бөгөөд бясалгадаггүй, эсвэл үйл түйтгэр ихтэй хүн харанхуй мунхаг талыг төлөөлдөг. Өнгөрснөөс үлдсэн тааруухан дурсамжийн нөлөөллийг л үйл түйтгэр гээд байгаа юм. Хэрэв тийм их үйл түйтгэртэй бол өдөр, шөнө салангид оршдог шиг гэрэл гэгээтэй хамт байж чадахгүй нь мэдээж. Иймээс бясалгал дадуулдаг хүн цагдаагаар хамгаалуулахгүй байсан ч болно.

Тэгвэл Есүс Христ яагаад алагдсан юм бэ? гэж зарим хүн өөрөөсөө асуух байх. Яагаад гэдгийг та нар мэдэх үү? Учир нь тэр өөрөө хүссэн юм. Хэдийд хорлогдохоо ч мэдэж байжээ. Тэр шавь нарынхаа үйл түйтгэрийг үүрэхийн тулд амиа зольж, тэдний өмнөөс нүгэл хилэнцийг нь төлж барагдуулжээ. Ингэхгүй бол шавь нарт нь төвөг бэрхшээл учирч, бясалгалаа дадуулж чадахгүй, туулан гэтэлж чадахгүйд хүрэх байв. Гэвч энэ нь түүний амьд

байх үеийн хэрэг явдал юм. Бид одоо түүнд итгэж биширсэн ч амьд байх үеийнх шигээ нь тус нэмэртэй байж чадахаа больжээ.

Одоо дэлхийд залран буй Их Багш өнгөрсөн үеийн Их Багштай адилгүй. Энэ нь одоогийн эмч, хорвоогоос хальсан эмчтэй адилгүй байдагтай адил. Хуа Түо, Биан Чүе нар хамгийн алдартай нь байсан тул тэднийг хувилгаан шидтэй эмч гэж хүндлэн нэрлэжээ. Гэвч тэд хэдийнээ энэхүү ертөнцөөс ангижирсан тул тэднийг яаж ч хүндлэн биширсэн босож ирээд биднийг аврахгүй. Бид өвчнөө эмчлүүлье гэвэл одоо байгаа эмчид хандах хэрэгтэй.

Үүнтэй адил өнгөрсөн үеийн Их Багш нарыг бид ихэд шүтэн биширдэг. Гэвч тэдэнтэй үг сольж чадахгүй, тэднээс ямар нэгэн бясалгалын аргыг сурах аргагүй. Иймээс амьд сэрүүн Их Багш хамгийн чухал. Есүс Христ, Шагжамуни Будда, Лууз бол хамгийн алдартай Их Багш нар болно. Маш олон хүн тэдэнтэй адил дэсэд хүрсэн ч нэрд гараагүй болохоор мэдэх хүнгүй болжээ.

Жишээлбэл, зарим эмчийн өвчнийг эмнэн зассан тухай тарсан мэдээлэл түүнд гэнэтийн алдар нэр авчирдаг. Үүнтэй адил эмнэлгийн дээд сургууль төгссөн, эмчлэх чадвар гарамгай олон сайн эмч нар байгаа ч нэрд гараагүй тул хүмүүс мэддэггүй. Дахин жишээ авъя. Дэлхий дээр зөндөө баячууд олон тэрбумын хөрөнгөтэй атал Рокфеллер,Онассес нараас гадна бид хэчнээнийг мэддэг билээ? Тэднээс ч баян хүмүүс олон байдаг нэрд гараагүй. Нэрд гарах онцгой шалтгаангүйгээс, эсвэл дургүйгээс, үгүй бол дэлхийд танигдсан ямар нэгэн бүтээгдэхүүн үйлдвэрлээгүйгээс нэрд гараагүй байж мэднэ.

Шагжамуни Буддаг нирваанд одсоны дараа түүнийг шүтдэг нөлөө ихтэй хүмүүс түүний сургаал номлолыг газар бүхэнд түгээн дэлгэрүүлснээр Түүнийг нэрд гаргаж дэлхийд нэртэй шашин болгожээ.

Есүс Христ ч мөн нэрд гарчээ. Түүний үхэл энэ ертөнцийн хамгийн гашуун зовлонтой нь байсан болохоор тэр юм. Түүний шавь нар олон газраар явж, сургаал номлолыг нь түгээн дэлгэрүүлснээс аажимдаа ихэд нэрд гарчээ. Тэр бол хамаг амьтны үйл түйтгэрийг үүрч зовлонтойгоор тэнгэрт хальсан түүхэн дэх анхны хүн юм. Нас барсныхаа дараа шавь нартаа хувилгаан биеэрээ үзэгдэж, олон хүн түүнийг харсан учраас улам нэрд гарчээ. Бусад багш нарын заримынх нь дэс тун өндөр байсан ч тийм зовлонтойгоор нас нөгчөөгүй болохоор төдийлөн нэрд гарсангүй.

Үе үеийн бусад Их Багш нар Шагжамуни Будда, Есүс

Христтэй адил нэрд гараагүй ч төрлөөс төрөлд ийм багш нар ирж хамаг төрөлтөнд заан сургадаг. Энэ ертөнцийн ёс суртахуун доройтож, муу үйл нь сайн үйлээсээ их, арга билиг тэнцвэргүй болсон тул ийм багш нар байгаагүй бол аль хэдийнээ мөхчих байсан. Арга билиг тэнцвэргүй бол дэлхий оршин тогтнох аргагүй болж тамын орон болон хувирна. Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Там гэж юу вэ? Муу хүмүүс амьдардаг, огтоос ёс суртахуунгүй газар юм. Тамд зөвхөн гэсгээл шийтгэл, зовлонт үйл л байдаг. Диваажин гэж юу вэ? Диваажин бол зовлон бага жаргал ихтэй. Бурханы орон зовлон үгүй, төгс баясгалантай хамгийн сайхан газар.

Энэ дэлхийг ажиглавал зовлонтой жаргалтай тул аргатай билигтэй. Билиг нь харанхуй мунхаг, зовлон зүдүүрийг, арга нь гэрэл гэгээ, ёс суртахууныг төлөөлдөг. Их сүнслэг бясалгагч нь аргын хэсэгт харьяалагдана. Тэрээр ёс суртахуунтай, гэрэл гэгээтэй, хүч чадалтай тул хамаг амьтныг аварч чадна. Эгэл ертөнцийн сайн муу хүчийг илүү тэнцвэртэй болгоно. Тэр шавь нартайгаа хамт хичээнгүйлэн бясалгал дадуулж энэхүү ертөнцийг илүү гэрэл гэгээтэй болгодог. Эс бөгөөс хамаг амьтны муу үйл энэ ертөнцийг улам бохирдуулж, тамын орон болгон хувиргана. Шагжамуни Будда, Есүс Христ, Лууз зэрэг үе үеийн Их Багш нар гэрэл гэгээтэй чанарыг төлөөлж, энэхүү ертөнцийн сайн, муу нөхцөл байдлыг тэнцвэржүүлдэг байна.

Гэрэл бидэнд тун чухал. Бид диваажингийн төрөлтөн, тэнгэрийн элчийг харвал тэд бүгд гэрэлтэй. Ад чөтгөр мэдээж гэрэлгүй. Учир нь тэд харанхуй талыг, харин Бурхан, тэнгэрийн элч нь гэрэл гэгээг төлөөлдөг тул өдөр байвал шөнө байдгийн адилаар энэхүү ертөнц эрээн бараантай, бас гэрэл гэгээтэй. Бурханы орон л зөвхөн гэрэлтэй, тамын орон тас харанхуй. Хэрэв бид тамд очиж болдогсон бол тэнд өчүүхэн ч гэрэлгүй, өдөр бүр хав харанхуй байдгийг үзнэ. Харин бидний ертөнцөд эрээн бараан, гэрэл гэгээ холилдон байдгаас зовлон жаргал, гэрэл харанхуй бүгд байна. Зарим хүн шөнийн харанхуйд дургүй, өдөр бүр гэрэл гэгээтэй байгаасай гэж хүсдэг. Хэрэв өдөр бүр гэрэлтэй байхыг хүсвэл Арьяабалын аргаар заавал бясалгал дадуулах хэрэгтэй.

Арьяабалын аргаар бясалгавал гэрэлтэй болно. Бид зөвхөн аялгуу ажих төдийгүй (аялгуу ч бас нэг зүйлийн гэрэл юм) бас гэрэл аждаг. Гэрэлгүй бол хэн бидэнд замчлах вэ? Зөвхөн аялгуу сонсож, аялгууг дагаад гэрэлгүй бол яаж замчлах вэ? Хав

харанхуйд зам харагдахгүй. Харин манай Арьяабалын бясалгалын арга гэрэлтэй.

Гэгээрсэн хүн билиг нээгдэх тэр агшиндаа энгүй их гэрлийг хардаг гэж ярьдаг. Тийм үү? Тэр үед түүний бүхий л бие нь уусан арилж, зөвхөн гэрэл л оршин байгаа мэт санагдана. Тэрхүү агшин тав, арван минут, тэр ч байтугай бүтэн өдөр үргэлжилж болох бөгөөд гэгээрсэн хүн энэ ертөнцөд оршин буй ч Бурханы оронд байгаа мэт санагдана. Түүний хувьд шөнө гэсэн ч гэрэлтэй бөгөөд гэрэл нь цацарвал эгэл хүн ч олж харна. Харанхуй байшин цэлсхийн гэрэлтэж, гэрэл асаагаагүй ч өрөөн дэх юмс тод харагдана. Зөвхөн сүнслэг бясалгал дадуулдаг хүн л ийм хэмжээст хүрч чадна. Энэхүү гэрэл нь дэнгийн гэрэлтэй адилгүй.

Жишээ нь: Багш нь гэрэлтэй байна гэж, та нарын билгийн мэлмий нээгдсэн гэж "Төсөөлцгөөе". Намайг энд сууж байхад та нар Багшийнхаа гэрлийг харах болно. Ном тайлж байгаа газар хэдийгээр олон гэрэл чийдэнтэй ч, Бурханы гэрлийг гүйцэхгүй. Бүгдийг асаасан ч Бурханы гэрлийг харж чадна. Багшийнхаа хэлсэн үгийн утгыг ойлгож байна уу? Учир нь Бурханы гэрэл материаллаг ертөнцийн гэрэлтэй адилгүй.

Бид яагаад энэхүү Бурханы гэрлийг олох ёстой вэ? Сүнслэг дадал бясалгал хийхгүй, тэр гэрлийг эрэхгүй байж болох уу? Болно. Чи энэ дэлхийд дуртай бол хар цагаан, өдөр шөнөд дуртай бол бясалгах хэрэггүй, эндээ үлдэж болно. Хэрэв төгс төгөлдөр чанагуух ертөнцийн гэрэлд дуртай бол, угаас гайхамшигтай, үнэнхүү ачтай, хүмүүнийг гэтэлгэгч гэрэлд дуртай бол энэхүү гэрэл нь хүмүүнийг орчлонгийн хамгийн агуу, хамгийн билиг ухаантай төрөлтөн болгож чадна. Тийм бол агуу гэрэлт Арьяабалын бясалгалын аргаар дадуулан бясалгаж, тэрхүү гэрэлтэй, гэгээн саруул орныг хайх хэрэгтэй.

Тийм орныг яаж эрж олох вэ? Эхлээд "Минши" (Их Багш) ийг олох хэрэгтэй. "Мин" гэдэг ханз үсэг ямар утгатай вэ? Гэрэл цацруулж аливааг төгс ойлгосон, "Гэрэл"-ээсээ багаханыг ч гэсэн бидэнд уламжилж чадах Төгс Гэгээрсэн Их Багшийг хэлнэ. Тиймгүй бол Төгс Гэгээрсэн Их Багш гэдгийг нь яаж мэдэх билээ? Хэн ч өөрийгөө Төгс Гэгээрсэн Их Багш гэж болох боловч, өөрөө ч мөн эсэхээ ухаарч ойлгоогүй байдаг. Нэгэн багш өөрийгөө Шифу (Их Багш) эсвэл Минши (Төгс Гэгээрсэн Их Багш) гэвэл Шифу гэдэг ханз үсэг нь багш юм уу эцэг гэсэн утгатай. Тийм бол эд хөрөнгөнөөсөө бага ч болов бидэнд өгөх учиртай. Тэр өөрийгөө баян чинээлэг гэсэн ч мөнгийг нь хараагүй бол бид яаж итгэх билээ? Эд хөрөнгө нь түүнийх болохоор бид бүгдийг нь авахгүй.

Харин дэлгүүрээ ажиллуулах жаахан мөнгө л авахыг хүссэн.

Хэрэв бидэнд мөнгө өгнө гээд өгөхгүй бол түүний баян эсэхийг яаж мэдэх вэ? Тэрээр үнэхээр нэг баян эрхэм атлаа биднийг ядуу бэрх, өлсөж үхэхийн ирмэг дээр байхад туслахгүй, харин ч биднээс мөнгө нэхвэл тэр баян байгаад ч нэмэргүй. Үнэхээр л баян юм бол бидэнд жаахан туслахад л болно.

Төгс Гэгээрсэн Их Багш ч мөн адил. Тэр бидний "Билгийг нээж" өгнө гэж хэлсэн ч бид жаахан ч гэрэлгүй, гэрэл огт хараагүй, Бурханы аялгууг сонсоогүй бол бид билиг нээгдсэн эсэхээ яаж мэдэх билээ? Нотолчихмоор юм байна уу? Урьдынхтайгаа адил ямар ч өөрчлөлтгүй болохоор түүнээс "Юуг билиг нээгдэх гэх вэ?" гэж асуувал тэрээр: "Бясалгалаа хийгээд дадуулаад л бай, арван жилийн дараа мэдэх болно." гэж хариулна. Хэрвээ бид таван жилийн дараа эсвэл маргааш нас барвал, билиг нээгдээгүй хэвээр, гэрэл ч харж амжаагүй, билгээ нээх хүсэл маань ч биелэгдээгүй бол яах вэ? Ингэх нь зөвхөн цагаа гарздаж байгаа хэрэг болно. Тэр үед аврах хүнгүй учраас бид аль хэдийнээ тамд уначихсан байж тун магадгүй. Миний санааг ойлгож байна уу?

Тиймээс жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багш нар бүгд ийм гэрэл. Тэд ном уламжлахдаа тэр даруй бидний билгийг нээж, биднийг бага зэргийн нотолгоотой болгодог. Адаглаад л бага ч гэсэн гэрэл харуулж, дотоодын аялгуу сонсгоно. Ном уламжлах үедээ бидний билгийг бага багаар нээнэ. Дараа нь бид өдөр бүр хичээнгүйлэн бясалгал дадуулснаар энэхүү "Билиг"-ээ улам нээнэ. Нэг л өдөр билиг бүрэн нээгдэнэ гэж зорьдог. Авшиг хүртсэний дараа өдөр бүр дадуулан бясалгах ёстой. Тэгвэл энэхүү билиг нээгдсэн ахуй ойлголт чинь өдөр бүр байсаар байх болно. Учир нь тэрээр нэгэнт бидний эд хөрөнгө болжээ. Энэхүү "Гэрэл" болон "Аялгуу" нь Арьяабалын бясалгалын арга бөгөөд зөвхөн жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багш л биднийг ахуй ойлголттой болгож чадна.

Гэрэл, дотоодын аялгуу бидэнд угаас байдаг. Энэ нь бидний "Угийн чанар" бөгөөд "Бурхан чанар" гэсэн ч болно. Есүс Христ: "Диваажин чиний дотоодод буй.", Шагжамуни Будда: "Бурхан сэтгэлд буй." гэжээ. Лууз ч ийм учир ёсыг ярьж, "Дао"-г гаднаас эрж хай гээгүй, уул усанд мөргөж байж л "Дао"-г олно гээгүй. Тийм үү? Өөрийн дотоод дахь "Дао" (Мөр ёс)-г эрэх хэрэгтэй гэдэг нь "Даодэжин"-гийн гол санаа юм.

Өнгөрсөн үеийн Их Багш нар ингэж онцлон тэмдэглэсэн байхад бид яагаад гаднаас эрсээр байна вэ? Яагаад бид сүм хийдээс эрдэг юм бэ? Яагаад "Дотооддоо хандаж уг чанараа ажих"-гүй байгаа юм бэ? Бидний Бурхан чанар хаана байна вэ? Хутгаар

биеэ зүсэж нээгээд дотоодын Бурхан чанараа харах бус, заавал түлхүүрээр нээх хэрэгтэй. Жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багшид түлхүүр бий. Хэрэв онгойлгож чадахгүй бол Төгс Гэгээрсэн Их Багш биш. Бидэнд билиг нээгдэх үеийн өчүүхэн ч атугай ахуй ойлголт өгч чадахгүй бол тэрээр билиг нээгдсэн хүн биш.

Арьяабалын бясалгалын арга гэрэлтэй байх ёстой. Гэрэлтэй байж биднийг замчилна. Ингэвэл бид яаж явахаа мэднэ. Хүрэх түвшин тун олон тул гэрэлгүй бол яаж харах вэ? Дотоодын түвшнээ, доторх эрдэнэсээ харъя гэвч гэрэлгүй бол яаж харах вэ? Гэрэлгүй бол бид энэ ертөнцөд юуг ч харж чадахгүй юм чинь дээд түвшнийг хэлэх хэрэг юун. Гэрлээр замчлуулахгүй бол бид юу ч харахгүй. Иймээс гэрэл тун чухал.

Эртний сүнслэг бясалгагчид өөрийн билиг нээгдэх үеийн ахуй ойлголтыг бичээд хожмын хүмүүст дамжуулан үлдээдэг байжээ. Тэд билиг нээгдэх үедээ их нь их, бага нь бага, ямар ч байсан бүгд гэрэлтэй байсныг бид тэндээс мэдэж болно. Анхандаа бага зэрэг, дараа нь билиг ихээр нээгдэхэд их гэрэл харна. Энэхүү гэрэл нь гадагш цацарвал бусад хүмүүст ч харагддаг. Тиймээс Шагжамуни Будда гэрэлтэй, Есүс Христ гэрэлтэй гэдэг нь ийм учиртай.

Зарим үед бид бясалгаж суугаагүй, сүнслэг дадал бясалгал хийгээгүй байхад, тэр ч байтугай Төгс Гэгээрсэн Их Багш ном уламжлаагүй байхад ч энэхүү гэрлийг харж, аялгууг гэнэт сонсдог. Гэвч ийм гэрэл, дотоодын аялгуу нь түр зуурынх л байдаг. Төгс Гэгээрсэн Их Багшаар ном уламжлуулаагүй бол гэрэл, аялгууг үргэлжлүүлэн харж, сонсож чаддаггүй.

Хоёр зүйлийн аялгуу байдаг гэж Багш нь өчигдөр ярьсан. Нэг нь “Сөрөг аялгуу”. Энэ нь гурван ертөнцийн доторх аялгууг төлөөлнө. Нөгөө нь гурван ертөнцийн гаднах аялгууг төлөөлдөг “Туулан гэтэлгэх аялгуу” юм. Бид гурван ертөнцийн доторх аялгууг сонсвол сансрын хүрдэнд эргэлдэж, гурван ертөнцийн гаднах аялгууг сонсвол тэр биднийг дагуулж гэтэлгэнэ. Харин Төгс Гэгээрсэн Их Багшийн удирдлагагүй бол аялгууны ямар нь жинхэнэ, төгс төгөлдөр, гэтэлгэдэг, ямар нь хуурамч, төгс бус, гэтэлгэж чаддаггүй болохыг ойлгохгүй.

Гэрэл ч мөн хоёр зүйлд хуваагдана. Нэг нь биднийг туулан гэтэлгэж, нөгөө нь сансрын хүрдэнд эргэлдүүлнэ. Иймээс бидний сонссон аялгуу, харсан гэрэл болгон хүмүүсийг гэтэлгэдэггүй. Тиймээс бид Төгс Гэгээрсэн Их Багшаар удирдуулах хэрэгтэй. Учир нь Төгс Гэгээрсэн Их Багш л эерэг, сөрөг гэрэл, аялгууг хэрхэн ялган танихыг бидэнд зааж чадна. Тийм биш бол бид

өөрсдөө бясалгачихна, замчлах Төгс Гэгээрсэн Их Багшийг юунд эрж хайх вэ? Та нар өөрсдөө бясалгаж, маани уншихад л болчихно гэж бүү бод. Энэ нь юу ч хийгээгүйгээс дээр ч, сайн арга биш, билгийг ихээр нээж чадахгүй.

Иймээс эртнээс нааш их бясалгагчид билиг нээгдэхээсээ өмнө уул усыг гатлан олон газраар хэсэж, "Төгс Гэгээрсэн Их Багш"-ийг эрдэг нь чухам ийм учир шалтгаантай. Хэрвээ өөрөө бясалгал дадуулаад болчихдог бол Төгс Гэгээрсэн Их Багшийг эрж хайхын хэрэг юун? Есүс Христ мэндлэхдээ л гэгээнтэн, Эзэн Бурханы хүү байсан атлаа юунд Энэтхэг явж, олон Их Багшийг даган арван хэдэн жил бясалгал дадуулсан юм бэ? Шагжамуни Будда мэндэлмэгцээ долоо алхаж чадсан бөгөөд алхам бүрээс нь нэг багц, нийт долоон багц лянхуа дэлгэрсэн гэдэг. Учир нь Тэрээр Бодьсадвагийн хувилгаан дүрээр мэндэлсэн билээ. Их Бодьсадва болж мэндэлсэн ч мөн л Төгс Гэгээрсэн Их Багшийг хайх хэрэгтэй болж, хожим нь зургаан жил хатуужилтайгаар дадуулан бясалгаад төгс гэгээрэлд хүрчээ.

Зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн бичиг үсэггүй түлээчин байсан. Гэвч "Очироор огтлогч судар"-ыг хүн уншиж байхыг сонссон даруйдаа билиг нь нээгджээ. Тэгсэн ч яагаад заавал тавдугаар үеийн Их Багш Хүн Рэнг эрж ном уламжлуулсан юм бэ? Дараа нь арван зургаан жил нууцаар бясалгал дадуулж төгс гэгээрэлд хүрч, хүмүүст ном уламжлах болжээ. Есүс Христ ч бас Хималайн Их Багш нарыг даган сүнслэг дадал бясалгал хийж, маш олон учир ёсыг ойлгон ухаарч чадсан юм. Шагжамуни Будда зургаан багштай. Түүнийг Бурхан болсны дараа багш нар нь бүгд ертөнцөөс ангижирсан байна. Үнэндээ Шагжамуни Будда эргэж очоод тэдэнд энэхүү Үнэн ёсыг тайлбарлаж, ач тусыг нь хариулъя гэж бодож байсан. Шагжамуни Буддаг багшгүй байсан гэж хэлж болохгүй, Тэр зургаан багштай байсан. Ирж мэндэлсэн ямар ч Будда, Бодьсадва нар бүгд Төгс Гэгээрсэн Их Багштай уулзаж байж л дадал бясалгал нь амжилтад хүрдэг.

Гэрлийг хоёр зүйлд хуваадаг. Нэгдүгээр зэргийн гэрэл нь Бурханы дэс, эсвэл Эзэн Бурханы дэсэд хамаарна. Ийм гэрэл нь биднийг туулан гэтэлгэдэг. Хоёрдугаар зэргийн гэрэл нь хүмүүсийг сансрын хүрдэнд эргэлдүүлэх төдий. Бид жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багшаар хөтлүүлэхгүйгээр өөрсдөө дурааараа бясалгаж, сүнслэг дадал бясалгалыг замбараагүй хийвэл дотоодын гэрэл, аялгууг гэнэт санамсаргүйгээр харж сонсон, жаахан билиг ухаантай болно.

Гэвч Төгс Гэгээрсэн Их Багшийн удирдлагагүй бол харсан

гэрэл, сонссон аялгуу нь лавтай хоёрдугаар зэргийнх болно. Бид өөрсдөө мэдэхгүй болохоор түүнийг маш сайн гэж боддог ч, эцэстээ хоёрдугаар зэргийн гэрэл болон аялгуугаар доод түвшинд хүлэгдээд, хамгийн дээд ахуй ойлголттой болж чадахгүй. Жинхэнэ аялгууг бус, өчүүхэн билиг ухааныг олж чадна. Энэ нь хоёрдугаар зэргийнх бөгөөд гурван ертөнцийн доторх билиг ухаан, зургаан заяаны билиг ухаан болно. Зургаан заяа гэж юу вэ? Тэнгэр, хүн, асури, бирд, там, адгуус болно. Иймээс бид хоёрдугаар зэргийн гэрэл харж, хоёрдугаар зэргийн аялгуу сонсвол Үнэн ёсыг олж чадахгүй.

“Мах идсэн ч гэрэл харах байтал Та яагаад хүмүүсийг заавал цагаан хоол идэхийг шаарддаг юм бэ?” гэж олон хүн Багшаас нь асуудаг. Хариулт нь тун энгийн. Багшийнх нь дөнгөж сая ярьсан учир ёстой холбоотой юм, ойлгов уу? Мах иддэг сүнслэг бясалгагч нь хоёрдугаар зэргийн гэрлийг олж хардаг ч Үнэн ёсыг олж чадахгүй. Тэд яаж ч явсан зургаан заяандаа эргэлдэнэ. Гэвч тэд дадал бясалгал хийдэг учраас эгэл хүнээс илүүг ойлгодог.

Жишээлбэл, угааж цэвэрлээгүй бохир аяганд юу ч хийгээд нэмэргүй. Хүчээр уувал лавтайяа өвчин олох болно. Энэхүү аяга хэдийнээ бохирдсон тул юу ч хийсэн цөм хор болон хувирна. Ойлгож байна уу? Сүү хийвэл гашилж ээднэ. Дарс хийсэн ч, ус хийсэн ч адил муухай амттай болно. Ус, дарс хоёр хольцгүй цэвэр, сүү сайхан амттай ч аяга бохир тул уугаад нэмэргүй, харин ч хортой зүйлийг ходоод руугаа юүлсэн хэрэг болно.

Үүнтэй адил бясалгал дадуулдаг хүн бие, хэл, сэтгэлээ ариусгаагүй бол ямар түвшинд хүрч, ямар үр дүн олсон ч энэхүү түвшин нь эргээд түүнд төвөг бэрхшээл учруулна. Энэ нь усыг бохирдуулагч бохир аягатай адил. Бид өөрийгөө бохирдуулснаас гэрэл маань бараантсан бөгөөд тунгалаг гэрлийг цэвэр ариун бясалгалаар л цогцлоож чадна.

Бие, хэл, сэтгэл тун чухал. Зөвхөн үг хэлээр нүгэл хийхгүй байхыг дадуулснаар болчихгүй. Өдөржингөө бусдыг муулахгүй байх нь хангалтгүй, ёс суртахуунтай зүйлийг ярьж байх ёстой. Хор уухгүй л бол болчих биш, шим тэжээлтэй зүйлсийг идэж байх хэрэгтэй. Зөвхөн сэтгэлээ засах нь хангалтгүй. Өдөржин муу бодолгүй байх нь хангалттай биш, сайн үйлийг ч бас хийх хэрэгтэй. Бохир идээг, жишээ нь мал амьтдын мах идэж болохгүй. Юу ч идсэн бидний “Сэтгэл”-д нөлөөлдөг.

Та нар хар л даа. Торой хоолоо, үхэр өвсөө, адуу тэжээлээ, тахиа тахианыхаа хоолыг иддэг. Хүн ч хүнийхээ хоолыг, өөрөөр хэлбэл ургамлын зүйл идэх ёстой. Библид: “Эзэн Бурхан жимс,

ногоог бидэнд зориулан бүтээсэн. Энэ бол бидний хоол хүнс юм.” гэжээ.

Шагжамуни Будда ном судар болгондоо амьтны амийг хороож болохгүй, хамаг амьтны махыг идэж болохгүйг онцгойлон дурдсан байдаг. Тэрээр: “Сүнслэг дадал бясалгал хийдэг хүн мах иддэг бол Бурхан болж чадахгүй, Бодьсадва ч болж чадахгүй. Учир нь мах иддэг хүн нигүүлсэнгүй сэтгэлгүй. Мах идэх нь нигүүлсэнгүй сэтгэлийн үрийг тасалдаг тул мах иддэг бясалгагч хамгийн дээддээ Маяа, дунд зэрэг нь түүний албат, хамгийн адгийнх нь шулам болно.” гэжээ. Энэ тухай Будда тун тодорхой ярьсан байдаг.

Иймээс би бясалгалын ямар ч аргаар бясалгал хийдэг дадуулдаг хэнийг ч бай тэднийг цагаан хоол идэхийг ятгадаг. Ингэвэл хожим нь дээд түвшинд хүрэх жаахан ч гэсэн боломж олдох юм. Энэ нь заавал Багшаа дагаж, Арьяабалын аргаар бясалгал дадуулах хэрэгтэй гэсэн үг биш, заавал Багшдаа итгэх хэрэгтэй гэсэн үг биш. Ямар ч бясалгалын аргаар сүнслэг дадал бясалгал хийхэд өөрийн бие, хэл, сэтгэлээ заавал ариусгах хэрэгтэй. Тэгж байж л тэрхүү муу нөлөөг арилгана. Жишээлбэл, бид ямар нэгэн эм уухад эмч: “Та энэ эмийг уувал кофе ууж огт болохгүй. Кофетой хамт уувал эмийн гаж нөлөө илэрч, өвчний байдалд муугаар нөлөөлнө.” гэж хэлнэ. Заримдаа толгой өвдөхөд толгойны эм уусны дараагаар гэдэс ч юм уу бусад газраар эвгүйрхдэгтэй адил.

Бид бясалгал хийе гэвэл өөрийн бие, хэл, сэтгэлээ заавал ариусгана. Өдөр бүр усанд орж биеэ цэвэр байлгах төдийгүй дотоодоо ч ариусгах. Хүн төрөлтөн угаасаа цагаан хоол идэх ёстойг жирийн хүмүүс мартсан байна. Өдөр бүр мах идээд заншчихсан тул одоо тэдний цагаан хоол идэхийг нь сэргээе гэвэл тун бэрхшээлтэй болоод байна. Бид гахай, тахиа, нугас, үхэр, хонийг тэврэх дургүй байж, яагаад тэдний зовлогыг амандаа хийнэ вэ? Энэ бол ямар ч ёс зүйгүй хэрэг.

Багш нь сая мах идсэн ч гэрэл харна, аялгуу сонсоно гэж хэлсэн. Энэ буруу биш. Гэвч энэ нь хүмүүсийг туулан гэтэлгэх жинхэнэ аялгуу, жинхэнэ гэрэл биш. Энэ бол дээд түвшний гэрэл, аялгуу биш.

Шагжамуни Буддагийн амьд ахуйд шавь нар нь бүгд гэрээс гарагчид байсан болохоор цагаан хоол иддэг байсан нь ярианүй. Эртнээс нааш Энэтхэгчүүдийн ихэнх нь цагаан хоолтон. Иймээс бүх Их Багш нар Энэтхэгээс төрсөн буюу Энэтхэгтэй холбоотой байдаг. Шагжамуни Буддагийн гэрээс гараагүй шавь нар нь бүгд

Бодьсадва бөгөөд “Баатараа явагч их хөлгөн судар”-т дурдсан хорин таван Бодьсадвагийн олонх нь гэрээс гараагүй Бодьсадва болно.

Яагаад тэднийг Бодьсадва гэж нэрлэсэн бэ? Тэд нэгэнт Бодьсадвагийн сахил хүртсэн. Уг сахилд Бодьсадвагийн сахил хүртэгсэд мах идэж огт болохгүй гэжээ. Гэрээс гараагүй Бодьсадва нэгэнт Бодьсадвагийн сахил хүртсэн учраас Шагжамуни Будда тэдэнд дээдийн номыг уламжилжээ. Тэгээгүй бол тэд гэртээ байх эгэл хүн төдий. Гэрээс гараагүй Бодьсадва сахил хүртсэний дараа мах идэж болохгүй тул тэдний дэс нь тун өндөр. “Баатараа явагч их хөлгөн судар”-т өөрсдийн ахуй ойлголтоо бичсэнээс үзэхэд бясалгал дадуулж эхэлмэгцээ л тэдний дэс нь хэдийнээ өндөр болсон байжээ. Энэ нь тэдний мах иддэггүйтэй холбоотой. Буддагийн гэрээс гарсан шавь нарын тухайд гэвэл мах идэж огт болохгүй нь ойлгомжтой.

Гэрээс гарагч мах идэж болохгүй гэж бүхий л ном сударт дурдсаныг бид мэдэж байгаа. Ер нь бол ийм л байх ёстой. Гэтэл өнөөгийн Бурханы шашинтай улс орнуудын цөөхөнд нь, ердөө л Ау Лак, Формоса, Хятадын эх газрын буддистууд л цагаан хоол идэцгээж байна. Бусад улс оронд, тухайлбал Өмнөд солонгосын лам хуврагуудын тал хувь нь цагаан хоолтнууд юм. Японыг бол дурдахын ч хэрэггүй, ная орчим хувь нь мах иддэг.

Ямар ч бясалгалын аргаар бясалгал дадуулдаг бай зөвхөн зүтгэлтэй эсэхийг нь харах биш, ёс суртахууныг нь илүү анхаарах хэрэгтэй. Учир нь “Сахил”-гүй бол жинхэнэ “Самади”-гүй, жинхэнэ самади үгүй бол жинхэнэ “Билиг ухаан” үгүй. Иймээс сахил санваар тун чухал. Юуг сахил гэх вэ? Хүн шиг хүн байх хэрэгтэй. Үүний зэрэгцээ орчлон ертөнцийн хууль цаазыг хүндлэн сахих ёстой. Өөрөө алуулах дургүй бол бусдын амийг бүү тасал. Бусдад идүүлэх дургүй бол бусдын махыг бүү ид. Хамаг амьтад бүгд амьтай, үхэхээс айдаг. Амьтныг хорооход тун их зовж шаналан, айн цОчироорддог тул хорсон занахдаа хор ялгаруулдаг.

Гэвч өвс ургамал, мод бутны ухамсар үхэхээс айдаг болтлоо хөгжөөгүй тул тэдгээрийг идэхэд тийм их үйлийн үр үүсэхгүй. Гэхдээ бага зэргийн үйлийн үртэй байх нь мэдээж. Ямар ч зүйлийг хороосон бүгд үйлийн үртэй. Гэтэл өвс ургамал өшөө авах сэтгэлгүй тул тэдний багахан хорсох сэтгэл биднийг доош татахгүй. Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр хамгийн багадаа хоёр цаг хагас бясалгал дадуулвал бага зэргийн үйл түйтгэрийг маш хурдан угаан цэвэрлэдэг. Гэтэл амь хороосон үйл түйтгэрийг амархан арилгах аргагүй. Тэд бодол сэтгэлтэй учир

өс хонзонгоо авахаар биднийг олж ирээд цааш явуулахгүй тул хамаг амьтны махыг идсэн бясалгагч дээд түвшинд хүрдэггүй нь ийм шалтгаантай. Учир нь "Туулан гэтлэх" гэдэг нь өнө үүрд буцаж ирэхгүй гэсэн утгатай. Бид амьтны махыг идэхийн хамт бас үүрд буцаж ирэхгүй гэж санавал, хэн ирж энэхүү "Махны тооцоо"-г төлөх вэ? Багшийнхаа санааг ойлгож байна уу? Мах идээд туулан гэтэлж чаддаг юм бол үйлийн үр байхгүй гэсэн үг. Энэ орчлонгийн хууль цаазаар бол "үйл байвал үр байдаг". Мах идвэл махаа буцааж өгөх хэрэгтэй. Иймээс мах иддэг хүн бясалгал дадуулаад дээд түвшинд хүрэх боломжгүй.

Судар номд үндэслэн үүнийг ярьж байгаагаас биш та бүгдийг энд шүүмжлэх гээгүй. Үнэн ёсыг ярихын тулд заавал үнэн үг хэрэгтэй. Юу мэдэж байгаагаа хэлж өгөх хэрэгтэй. Хүмүүсийг баярлуулах зүйл хэлэх ёстой бол би энд яриад байх шаардлагагүй. Лам хувраг болж, ном судар тайлахын ч хэрэггүй. Харин өдөр болгон: "Чи өнөөдөр их сайхан харагдаж байна. Хувцас чинь ганган дэгжин юм. Та юу ч хийж болно, ертөнцийн түмэн жаргалыг эдэлсэн ч болно. Сахил хүртчихвэл л болох нь тэр, мах идэж, архи уусан ч хамаагүй." гэвэл хүмүүс сонсмогцоо баярлана. Ямар ч ном тайлахын шаардлагагүй.

Тэдгээр мах иддэг хүмүүст: "Зүгээр зүгээр, махаа ахиухан ид, эрүүл чийрэг болно." гэвэл хэдэн өдөр бололгүй л тэд эмнэлэг бараадах хэрэг гарна. Учир нь мах иддэг олон хүн хавдраар өвчилдөг. Цагаан хоолтонд ийм асуудал байхгүй. Энэ зууны эдгэшгүй өвчин ДОХ (AIDS)-оор мах иддэг хүн л өвчилдөг, цагаан хоолтонд тийм зүйл огт байхгүй.

Та нарыг баярлуулъя гэсэн бол би эдгээрийг тайлбарлах шаардлагагүй, цагаан хоол ид гэж давтан хэлэх ч хэрэггүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Цагаан хоол идэх нь та нарын одоогийн амьдралын дадал зуршилтай зөрчилдөх тул зарим хүн сонсоод дургүйцдэг. Бясалгал хийдэг хүн үнэн үгийг билиг ухаантай нэгэнд шулуухан хэлэх ёстой. Күнз: "Эрхэмсэг дээд хүмүүн хулстай адил шулуун байх хэрэгтэй." гэжээ. Иймээс би хүмүүст тустай хэрэг явдлыг бодож олмогцоо тэдний сонсох дуртай эсэхийг харгалзалгүйгээр хэлж өгөх ёстой.

Түүнчлэн Күнз: "Өөрийн хүсэхгүй зүйлийг өрөөлд бүү тулга.". Энэ үгийг та нар бүгд мэддэг, байнга эш татах дуртай. Тийм үү? Яагаад та нар энэхүү учир ёсонд дуртай байдаг вэ? Яагаад гэвэл Үнэн ёс бидний уг чанарт оршин байдгаас сайн учир ёсыг бид хүсдэг. Эрхэм дээд үг яриа, эрхэм дээд үзэл санаа угаас бидний дотоодод оршин байдаг. Хүн уулаасаа хамгийн эрхэм дээд

төрөлтөн ч та нар тэр дорхноо цагаан хоолтон болж чадахгүй байж мэднэ. Учир нь хүн хүний нөхцөл байдал адилгүй. Заримынх нь эхнэр, нөхөр нь саад хийнэ, заримд нь ажлын орчин нь нөлөөлнө.

Хэдий ийм ч та нар ёс суртахуунтай зүйл, Үнэн ёсны тухай сонсох дуртай. Учир нь та нарын дотоодод хамгийн эрхэм дээд газар, тухайлбал та нарын "Бурхан чанар" дотоодод чинь байгаад би итгэж байна. Энэхүү "Бурхан чанар" эсхүл "Тэнгэрийн орон" (Диваажин) та нарын дотоодод байгаа юм чинь Үнэн ёсонд яахан дурлахгүй байх билээ? Яалаа гэж эрхэм дээд үзэл санаанд дургүй байх билээ, тийм үү? (*Зарим хүн тийм гэж хариулав.*) Хүмүүс Үнэн ёсыг мөрдөн сахих дургүйдээ биш харин Үнэн ёсны тухай өмнө нь огт сонсоогүй тул мэддэггүй байжээ. Үйл үрийн хууль маш нарийн тодорхой, хатуу чанга, өчүүхэн ч алдаа мадаггүй. Ямар үйл байна, тийм л үр байдаг. Өчүүхэн ч зайлж чадахгүй. "Тэнгэрийн хууль хатуу чанга, мултарч зайлах арга үгүй." гэдэг нь ийм утгатай.

Эрт цагт Энэтхэгт Кабир (Kabir) гэдэг нэгэн их сүнслэг бясалгагч байжээ. Нэг хүн тэднийд очиход, тэр эзгүй байв. Түүний хамтран бясалгагч (эхнэр нь түүний шавь болсон тул хамтран бясалгагч гэх болжээ) түүнд: "Чи оршуулгын газар яваад оч, тэр яг одоо найзыгаа оршуулж байгаа." гэжээ. Тэр хүн: "Би түүнийг яаж олох вэ? Танихгүй шүү дээ." гэжээ. Энэтхэг хүмүүс зүс царайгаараа бараг ижилхэн, мөн адилхан хувцас өмсдөг. Формосагийн гэрээс гарагчид нэг ижил хуврагийн хувцас өмсдөгтэй адил.

Кабирын эхнэр түүнд: "Тэнд очоод сайн ажиглаарай. Толгой дээрээ гэрэлтэй нь Кабир шүү." гэжээ. Тэр хүн оршуулгын газар очиход тэд нүх малтацгааж байв. Зарим нь авс дамнаж, зарим нь нүх ухаж, бусад нь оршуулахад бэлтгэж байв. Хүн бүр толгой дээрээ гэрэлтэй байсан тул тэр хүн Кабирыг олсонгүй. Оршуулгын үед бүгд чимээгүй байдаг тул асууж зүрхэлсэнгүй. Аргагүйн эрхэнд буцаж очоод Кабирын эхнэрт: "Би Кабирыг олсонгүй. Хүн болгоны толгой дээр гэрэл байна, одоо яах вэ?" гэжээ.

Кабирын эхнэр: "Зүгээр, зүгээр. Чи буцаад яв. Оршуулж дуусаад буцах үеэр ганцхан л хүн гэрэлтэй байна. Тэр бол Кабир мөн." гэжээ. Тэр хүн буцаж очин оршуулгын ажлыг хүлээн байж дуусгаад цуг буцахад үнэхээр ганцхан хүн тэргүүн дээрээ гэрэлтэй байхыг харав. Яагаад гэдгийг та нар мэдэх үү? Яагаад оршуулгын үеэр бүгд гэрэлтэй, буцах үеэр Их Багш л ганцаараа гэрэлтэй үлдсэн бэ?

Учир нь талийгаачийг оршуулах үеэр найз нөхөд нь ариун явдлыг бодож, “Үхэх төрөх”-ийг эргэцүүлэн бодол санаагаа төвлөрүүлжээ. Энэ үеэр туулан гэтлэх юмсан гэж бүгдээрээ нэгэн сэтгэлээр бодож байсан тул дотоодын гэрэлт чанар нь гэрэл гэгээ цацруулж, тэр хүнд бүгдээрээ гэрэлтэй харагджээ. Төрж үхэхийн хүрдэнд эргэлдэх нь хамгийн аймшигтай хэрэг гэдгийг тэр үед жинхэнээрээ мэдэрч, энэ амьдрал мөнх бус гэдгийг ойлгожээ. Энэ агшинд тоост хорвоод хоргодох нь багасаж, нэгэн сэтгэлээр дадал бясалгал хийхийг бодож, туулан гэтлэхийг хүссэн учраас тэдний дотоодын гэгээн саруул чанар нь илэрч, гэрэл болон харагджээ.

Ийм гэрэл хүн болгонд байдаг ч оршуулга дуусаад буцахдаа бүгд ариун явдлыг бодохоо мартсан байна. Учир нь эгэл хүн өдөр бүр дасгал сургууль хийхгүй бол бодлоо захирч чадахгүй болж, бодол ч бидний санаа зоригийг дагахаа больдог. Ойлгож байна уу? Заримдаа бидний санаа зоригийг сөрж, есөн шидийн бодолд дарагдуулдаг. Иймээс тэднийг оршуулгаас буцах үед талийгаачийн цогцос болон авс харагдахгүй тул бодол санаа нь төвлөрөх газаргүй болж сарниад, сансрын хүрдний талаар дахин эргэцүүлэхээ больж, зөвхөн эхнэр нөхөр, идэх хоол, унтах нойр, зугаа цэнгэл зэрэг эгэл ертөнцийн явдлыг бодсоноос гэрэл цацраахаа больжээ.

Бид хэрэв үхэж төрөхийн асуудалд бодол санаагаа төвлөрүүлбэл лавтай гэрэлтэй болно. Та нар хариад туршиж үзээрэй. Тэд оршуулгаас буцах замдаа сэтгэлдээ зөвхөн ертөнцийн юмыг бодож байсан тул гэрэлгүй болжээ. Учир нь энэхүү ертөнц эрээнтэй бараантай, доогуур түвшний газар юм. Уурлах үед гэрэл бүдгэрч тамын түвшин хүртэл унана. Ертөнцийн хэргийг бодвол харлан бараантаж, сүнслэг дадал бясалгалыг бодвол сая гэрэлтэй болдог.

Кабир удаан хугацаагаар дадуулан бясалгасан учраас ямар ч үед бодол санаагаа бясалгал дээр, өндөр дээд хүсэл зорилго дээр тавьж чаддаг. Иймээс тэр хэзээ ч гэрэлтэй байдаг. Бид дээд хүсэл зорилгоо бодвол даруй гэрэл гэгээ болж хувирна. Энэ ертөнцийн учир явдлыг бодвол эгэл хүн болно. Хэрэв бид шунал, хилэн, мунхгийг бодвол даруй ад чөтгөр болж хувирна гэх мэт.

Үйл үрийн хууль харьцуулшгүй нарийн оновчтой, өчүүхэн төдий ч алдаа мадаггүй гэж саяхан хэлсэн. Миний өвөг багш амьд ахуйдаа нэгэн шавьтай байжээ. Тэр шавь Арьяабалын аргаар ихэд чармайн бясалгал дадуулдаг байв. Нэгэн өдөр гадаа зугаалж яваад, шоргоолжинд хазуулаад зовон тарчилж, үхэхдээ тулсан ч зугтан зайлж чадахгүй байгаа чийгийн улаан хорхойг

хараад нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс түүнийг аюулгүй газар шилжүүлж, шоргоолжийг хөөн явуулжээ.

Орой бясалгаж суухдаа мянга түмэн шоргоолж ирэхийг харав. Шоргоолжнууд бүдүүн биеэрээ биш, нарийн сүнсэн биеэрээ ирээд түүнийг хазжээ. Тэрээр шоргоолжны сүргийн сүнсэн биеийг хараад ихэд айхад тэд хазахын хажуугаар гомдол тавьж шоргоолжны хэлээр ярьжээ. Бясалгалын түвшин өндөрсвөл амьтны үг хэлийг ч ойлгодог. Шоргоолжнууд: "Чийгийн улаан хорхой өөрийн үйл лайгаа үүрч түүнийгээ цайруулах ёстой. Чи яагаад бидний хэрэгт оролцоно вэ? Энэ бол бидний олбол зохих олз мөн. Чийгийн улаан хорхой урьд нь үйлдсэн нүгэл, үйл түйтгэрээ заавал амь насаараа төлөх ёстой." гэжээ. Бид юу ч хийсэн бүгд үйл үртэй байдаг. Бид хүнийг аварвал түүний үйл түйтгэрийг үүрэх ёстой. Гэвч маш их буян хишигтэй бол бусдын үйл түйтгэрийг үүрэхэд нэг их асуудалгүй. Жаахан өвдөх, бие махбод тааламжгүй болох нь мэдээж. Харин хамгийн муу байдал бол Есүс Христтэй адил загалмайд цовдлуулж, хамаг амьтны үйл түйтгэрийг тун зовлонтойгоор төлж барагдуулах явдал юм. Эсвэл Шагжамуни Буддатай адил чулуугаар цохиулж, гүтгүүлэн доромжлуулна. Зарим хүн түүнийг алахыг санаархсан, зарим нь хилсээр буруутгасан зэрэг төвөг бэрхшээл тохиолджээ.

Бурхан болоод тун их хүч чадалтай болсон ч бусдад хилсээр буруутгагдах, гүтгүүлэх, хорлогдох явдал тохиолдсоор л байх болно. Яагаад тэр вэ? Олон шавьтай болж тэдэнд ном уламжлан нүгэл хилэнцийг нь үүрч, тэднийг эгэл хүнээс богд гэгээнтэн болгодог болохоор Их Багш үйл түйтгэрийг нь заавал төлж дуусгах ёстой.

Иймээс бид өглөг өгөх, сахил сахих, хүлцэн тэвчих, хичээнгүйлэн шамдах, даяан агуулах, билиг ухааныг олохдоо дур зоргоороо хандаж болохгүй. Жинхэнэ нөхцөл байдлыг сайтар ойлгосны дараа л хийх хэрэгтэй. Ингэхгүй бол их төвөг бэрхшээлтэй учирна. "Очироор огтлогч судар"-т маш олон учир явдлыг ярьсан байдаг. Эгэл хүн хүчгүй учраас бид түүнийг хийж чадахгүй байж тун магад. Зөвхөн ганцхан чийгийн улаан хорхойг аврахад тийм аймшигтай байдалтай болсныг бодооч. Хэрэв бид өөрсдөө нүгэл үйлдвэл үр дүн нь ямар байх бол?

Цаг боллоо, асуулт байна уу? Та нар яагаад сүнслэг дадал бясалгал хийхгүй байна вэ? Яагаад тийм олон хүн бясалгал дадуулахыг бодохгүй байна вэ? гэдэг нь миний хувьд хамгийн том асуулт болоод байна. Энэхүү ертөнц мөнх бус, амьдрал тун богинохон, ихдээ л зуун жил болно. Амьдрал их зовлонтой, ямар

ч утга учиргүй. Өдөржингөө хоол иднэ, унтана, ажиллана, ахиад л ажиллана, хоол иднэ, унтана гэж олон хүн гомдоллодог. Гэвч хүмүүс энэ ертөнцөд хоргодсон хэвээр, салж түвдэхгүй, огоорч чадахгүй байна. Хамаг амьтан яагаад үүнийг бодож тунгаахгүй байна вэ? Энэ бол миний хамгийн чухал асуулт юм.



Жинхэнээр билиг нээгдсэнийг хүнд үзүүлэх аргагүй, худалдаж болохгүй, иймээс үгээр илэрхийлэх боломжгүй. Гэсэн ч түүнийг ойлгож болно. Учир нь бид өөрийн дотоодын хувирлаа сэрж мэдэрнэ. Билиг нээгдвэл дотоод сэтгэл маань улам тогтуун тайван, баяр баясгалантай болж юу ч хийсэн хөнгөн хялбар болно.
(“Буян хийж, өглөг өгөөд туулан гэтэлж чадахгүй” айлдвараас)



Бидний соронзон талбай аажмаар сайжирч байгаа нь дээшлэн дэвшиж буйг харуулах бөгөөд хэдий хэрийн хугацаанд бүрэн сайжрах нь сэтгэлийн цэвэр цайлган эсэхтэй холбоотой. Хүүхэд шиг цагаан цайлган сэтгэлтэй болсон цагтаа л бид диваажинд очих болно гэж “Даодэжин” болон бусад судар номд дурдсан байдаг.

(“Үйл түйтгэр хаанаас үүсэлтэй вэ?“ айлдвараас)



Эхний үед заавал Багшийн хүчний туслалцаа хэрэгтэй. Дараа нь байнга Багшийн хүчинд дулдуйдаад байхгүй өөрөө явж эхэлнэ. Өсөж томрохоороо бие даана. Яг л дөнгөж хөлд орж байгаа хүүхэд шиг. Тэр ганцаараа явж чадахгүй шүү дээ. Хойно урдаас нь түшиж алхам алхмаар сургах хэрэгтэй. Удалгүй өсөж бойжоод өөрөө явж чадах болно.

(“Бурханд мөргөөд Бурхан болохгүй” айлдвараас)

ЦЭЦЭГ ДЭЛГЭРВЭЛ БУРХАНЫГ ХАРНА ГЭДГИЙН УЧИР

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
айлдвар. Формосагийн Тайнань хот.
1987 оны 5 дугаар сарын 11
(Эх нь хятад хэлээр)

Танай эндхийн нишингэ болон амтат төмс тун амттай гэж өнөөдөр би сонсоод их баярлаж, буцах дургүй болчихлоо. (*Бүгд инээв*.) Амтат төмс, нишингэ хоёр байгаа юм чинь энд үлдсэн ч болно. (*Бүгд инээв*.) Тайнаньд гэртээ байгаа юм шиг л байна. Миний төрсөн нутаг Ау Лакт бас их амттай нишингэ байдаг. Аав маань Хятадын уламжлалт эмнэлгийн эмч байсан бөгөөд жил бүр олон хүний өвчнийг эдгээн тусалж байсан. Тэр өвчин эмнэх онцгой авьяас билигтэй байсан байх. Бусдын эмчилж чадаагүй өвчтөн ирвэл мөнгө төгрөггүй байсан ч чадлаараа тусалж аврахыг хичээдэг байсан. Өөрөө зохиож найруулсан эмийн энгийн жор хэрэглэдэг байв. Бодвол хятад эм, европ эмийг хольдог байсан байх. Өвчтөн уугаад дороо эдгэчихдэг болохоор талархсан хүмүүс тасралтгүй жимс авчирч өгдөг байв. Жишээ нь, нишингэ, амтат төмс, эсвэл хамгийн амттай чихэр гэх мэт. Бага байхад энэ нь миний хувьд ертөнцийн хамгийн сайхан бэлэг байлаа.

Тиймээс би одоо болтол дуртай хэвээрээ байгаа. Тайнаньд сайн нишингэ, сайхан амтат төмс байдгийг сонсоод гэртээ байгаа юм шиг л санагдаж байна. Иймээс өнөөдөр ном сайн тайлж магадгүй. (*Бүгд инээв*.) Формосагийн хүмүүсийн цэцэн ухааныг би биширдэг. Тэд уран гартай, юу ч хийсэн сайхан хийнэ. Германд байхдаа би Формосагийн гар урлалын зүйлсийг үргэлж худалдаж авдаг байсан. Хямд, гоё, бас хөөрхөн. Хуурамч барааг ч сайн дуурайлгадаг болохоор жинхэнэ юм шиг л байдаг. Хүмүүс жинхэнэ эсэхийг нь ялгадаггүй.

Би Формосад ирээд хүмүүс хоол хийхдээ маш их цаг зав гаргадгийг ажигласан. Миний бодоход Формосачууд идэмхийдээ биш. Идэмхий гэдэг нь юу л байна тэр бүгдийг идэхийг хэлдэг. Гэтэл Формосачууд их цаг зарцуулан байж хоолны өнгө, үнэр, амтыг цогцлоодог. Хоол хийхдээ зөвхөн идэхийн төлөө бус, хоолны урлагийг ч анхаарна. Энэ бол гоо зүйн мэдрэмж юм.

Формоса болон Япон цэцгийн урлагаараа алдартай. Гэвч япон хүний сэтгэл тийм ч өгөөмөр биш санагдсан нь миний тогтсон үзлээс болоогүй. Тэдний саван дахь цэцэг тун цөөн, ганц хоёрхон байхад Формосачуудынх дүүрэн байдаг. Формосад ямар ч зүйлийг баян тансгаар засаж чимэглэдэг нь тэдний сэтгэл халгиж цалгиж байдгийг илтгэнэ.

Яг л устай аягатай адил, хэтэрхий дүүрвэл халина. Яагаад тэр вэ? Энэ нь тэднийг сайн газраас ирж төрснийг илтгэн харуулж байна. Тиймээс Формосагийн сүм хийдүүд олон бөгөөд том байдаг. Хурал хурахад номын багш нь нэрд гарсан эсэх, ном тайлж чадах эсэхийг харгалзахгүйгээр олноороо ирж, Бурханы ном судар, ёс суртахуунтай хэрэг явдлын тухай сонсдог. Яагаад гэвэл та нар хэдийнээ бэлтгэлээ сайтар базаачихсан, дотоодын дэс чинь дээшилсэн учраас энэ бүхэнд дуртай. Энэ нь та нарын түвшинтэй холбоотой.

Диваажин тун гоёмсог, Буддагийн орон, Авид бурханы орон их үзэсгэлэнтэй гэлцдэг. Бид тэндээс ирсэн байж тун магадгүй. Иймээс бид сайхан юманд, үзэсгэлэнт цэцэгст дурладаг байж мэднэ. Идэж уухдаа ч гоё сайхныг эрхэмлэж, хэсэгхэн дүүфүүг хүртэл харахад сайхан, амттай болгодог нь та нарын гоо зүйн мэдрэмж өндөр болохоор тэр юм. Формосачууд бүгд гоё сайхан зүйлст дуртай, үзэмжтэй хувцасладаг. Ядуу хүн ч сүлжмэл даавуугаар оёсон цэвэрхэн хувцас өмсдөг. Энэ нь та нар урьдын төрөлдөө улсын хаан, эрхэмсэг хатан, их түшмэл байгаагүй ч диваажингаас бууж ирснийг чинь харуулж байна. Тиймээс Формосад бясалгал дадуулдаг хүн маш олон. Бурханы шашны уламжлалын талаас нь хэлбэл, Формоса нь эдүгээ энэхүү шашны уламжлалыг харьцангуй сайн хадгалж үлдсэн орон юм. Бусад улсад аажмаар өөрчлөгдөн доройтож, жинхэнэ Бурханы шашин биш болжээ.

Формосад нууц тарни, ариун орон (сугавадийн орон), их хөлгөн, бага хөлгөний алийг нь ч бясалган дадуулсан, гэлэн, гэлэнмаа гэлтгүй бүгд гэрлэдэггүй бөгөөд цагаан хоол иддэг. Бурханы шашин угаасаа ийм байх учиртай. Шагжамуни Буддаг амьд ахуй үед ийм уламжлалтай байсан. Одоо хувирч

өөрчлөгдөөд зөвхөн Формоса л Бурханы шашны уламжлалаа цэвэрээр нь хадгалсаар байна. Хэрэв та нар ном уншдаг бол бусад Бурханы шашинт улс оронд хувраг хүн мах идэж, архи ууж, гэрлэж болдгийг мэднэ. Формосад иймэрхүү явдал байхгүй. Миний бодоход Формосачуудын буян хишиг хангалттай байснаас Бурханы шашны уламжлалыг цэвэрээр нь үргэлжлүүлэн хадгалж чаджээ.

Бусад орноор явж байхад, тухайлбал Мьянмар гэхэд Бурханы шашин ихэд дэлгэрсэн орон шиг байдаг. Гэрээс гарагчид их олон, бүр Формосагаас ч олон. Хаяагүй шар хувцастай гэрээс гарагчид тодруулбал их хувраг, бага хувраг, настай хувраг, гэлэн, гэцэл гэх мэт олон хүнийг хараад сэтгэл баясав. Ийм олон Бурханы шашны гэрээс гарагсдыг үзээд ихэд баярлатал, байдал үнэн хэрэгтээ Шагжамуни Буддагийн үеийнхтэй адилгүй болсон байв. Яагаад гэвэл Мьянмарт ямар ч хугацаагаар гэрээс гарч болно. Гурван сараар ч болно. Зарим үед элдэв бэрхшээл, асуудалтай тулгарвал сүмд очиж үсээ хусуулаад, хүсэлт гарган гурван сарын турш гэрээс гарагчтай адил өдөр бүр бадарчилна. Гурван сарын дараагаар гэртээ хариад мөн урьдынхтайгаа адил эхнэр, нөхөр болцгоодог. Долоон настай бяцхан хүүхэд ч гэрээс гарч болно. Тэгээд ганц хоёр жилийн дараа буцаад эгэл ард болж болно. Иймээс л маш олон гэрээс гарагсадтай мэт харагджээ. Ингэх нь мэдээж тустай, бас сайн нөлөөтэй. Гэтэл тэд бүгд цагаан хоол иддэггүй, Формосагийн хуврагууд шиг тийм цэвэр ариун биш.

Одоогийн Шри Ланка, Тайланд, Мьянмар, Япон, Өмнөд Солонгос бараг бүгд л иймэрхүү байдалтай. Зөвхөн Формосад л угийн Бурханы шашны уламжлал хэвээрээ байна. Би гэрээс гарагсдын тухай ярьж байгаа болохоор гэртээ байгаа хүмүүсийн байдлыг сайн мэдэхгүй. Гэвч олон хүн надад: “Их Багш аа, өглөөний цав идмээр байна.” гэхэд нь би: “Би өглөө иддэггүй, та нар идэж яах нь вэ?” гэсэн. (*Бүгд инээв.*) Өглөө цав идэхгүй байсан ч болно. Дөнгөж боссон тул хоолны дуршил төрдөггүй. Мах идмээргүй байдаг тул цагаан хоол идэх нь хялбар. Тийм үү? Гэхдээ зүгээр, юу идмээр байна түүнийгээ л ид, чөлөөтэй шүү дээ!

Гэхдээ би Формосаг нэлээд цэвэр Бурханы шашинтай гэж боддог. Яагаад гэвэл “Баатараа явагч их хөлгөн судар”-т Шагжамуни Будда: “Гэрээс гарсан, гэрээс гараагүй ямар ч хүн цагаан хоол идэхгүй мах идвэл, даяанчлан сүнслэг дадал бясалгалыг сайтар дадуулсан ч ад түйтгэртэй байж, Бодьсадва болж чадахгүй. Мах идэж даяан бясалгадаг хүн хамгийн дээддээ

Маяа, дунд зэрэг нь Маяагийн албат, хамгийн адаг нь шуламс болно.” гэжээ. Учир нь мах идвэл нигүүлсэнгүйн үр тасарна, Бодьсадвагийн үр тасарна. Тиймээс “Баатараа явагч их хөлгөн судар”-ын үүднээс яривал, Формосагийн гэрээс гарагсад Буддын сургаал номлолыг хамгаас сайн сахиж байна.

Өнөөдөр ном тайлж буй анхны өдөр болохоор эхлээд та нартай найрсаг сэтгэлээр элдвийг хөөрөлдөж байна. Жирийн үед ном тайлахдаа ч ингэж ярьдаг. Ном тайлах нь миний хувьд тун энгийн явдал. Бичиг цаас хардаггүй, эх ноорог ч бэлддэггүй. “Аяндаа урсдаг ном”-ыг хамгийн энгийн үгээр тайлна. Гүн утгатай үг үсэг, эртний хэл хэрэглэхгүй. Хүнд ойлгогдохгүй, бас өөрөө ч ойлгохгүй болчихвол яана! (*Бүгд инээв.*) Нэгэнт ном тайлж байгаа болохоор эрдэмтэй, эрдэмгүй гэлтгүй бүх хүнд ойлгуулбал зохино. Тиймээс миний ном тайлах нь их хялбар тун ойлгомжтой. Хүмүүс юу сонсохыг хүснэ, түүнийг нь тайлна. Хэрвээ намайг бичиг цаас хар гэвэл юу ярихаа мартчихна. Ном судар миний цээжнээс аяндаа урсан гардаг болохоор хэрэгтэй номоо тэр дор нь тайлдаг.

Одоо номоо тайлж эхэлье. Урьдынхтай адил онцгойлон ярих зүйлгүй. Та нар ямар ном сонсмоор байна? (*Бүгд “Авид бурханы судар” гэж хариулав.*) Болно, болно. Багш нь даяан бясалгадаг болохоор “Авид бурханы судар”-т дургүй гэж бүү бодоорой. Үнэндээ би түүнд их дуртай байсан. Энэтхэгт очихоос өмнө “Авид бурханы судар”-ыг уншиж, Авид бурханы зүрхэн тарни уншдаг байсан. Ингэх нь тун амархан, бяцхан хүүхэд ч чадна. Тиймээс Авид бурханы маани, тарни уншихыг заах нь тун хялбар гэж бодож байна.

Ингэх нь ямар ач тустайг ярья. Авид бурханы нэрийг самгардиар Amitabha гэнэ. Уг нь энэ үг “бурхан” гэсэн утгыг агуулаагүй ч хятадаар орчуулахдаа бурхан гэдэг үг нэмж, Авид бурхан болгожээ. Самгарди хэлний Amitabha нь цаглашгүй гэрэл гэсэн утгатай. Amitayus гэдэг нь цаглашгүй насан хутаг гэсэн утгатай үг юм.

“Цаглашгүй гэрэл” гэж юу вэ? Бид үргэлж “Бурханы гэрэл мөнхөд гийгүүлнэ.” гэж ярьдаг. Хэрэв Бурханы гэрэл мөнхөд гийгүүлж Авид бурхан цаглашгүй гэрэлтэй юм бол бид яагаад харахгүй байна вэ? Иймээс “Бурханы гэрэл мөнхөд гийгүүлнэ.” гэдэг ямар утгатай вэ?, хаана, хэзээ гийгүүлдэг вэ?, яавал энэхүү мөнхөд гийгүүлэх Бурханы гэрлийг харах вэ? гэж бид өөрсдөөсөө асуудаг. “Авид бурханы судар”-т Шагжамуни Будда: “Бурхан энэхүү “Цаглашгүй гэрэл”-ийг агуулж байгаа болохоор “Бурханы

гэрэл мөнхөд гийгүүлнэ гэж хэлж буй юм.” гэжээ.

Хэрвээ бясалгалыг сайтар дадуулсан бол нас нөгчих үед Бурхан гэрэл цацруулан ирж тосдог гэцгээдэг. Тийм үү? Гэвч бид одоо болтол гэрэл хараагүй бол жаахан сэжиг төрөх нь яриангүй. Учир нь бид нас барах үед гэрэл харах эсэх, Бурханы гэрэл гийгүүлэх эсэхийг мэдэхгүй. Одоо бид харанхуй мунхаг тул Бурханы гэрлийг харахгүй. Нас барах үед бидний билгийн мэлмий нээгдэж, тэрхүү гэрлийг харах эсэхийг мэдэхгүй. Бидний маани, тарни уншдаг хүмүүс Бурханд их итгэдэг ч заримдаа бас иймэрхүү асуудалтай тулгардаг. Тийм үү?

Орчуулахдаа “Бурхан” гэдэг үг нэмснээс болж энэ үгтэй зууралдах болсон. Тухайн үед зөвхөн Amitabha гэж орчуулсан бол Авид гэдэг бурхан байдаг юм байна гэж хүмүүс бодохгүй. Amitabha нь “Цаглашгүй гэрэл”, Amitayus нь “Цаглашгүй насан хутаг” гэсэн утгатай. Бид угаас энэ бие махбод биш, цаглашгүй гэрэл, цаглашгүй насан хутаг болно. Дээнч одоо энэхүү цаглашгүй гэрэлтэй холбоо тасраад энэ биедээ хоригдсон байна. Энэ байдлыг зүйрлэн хэлбэл нэгэн аягыг их далайд хөмөрч тавьсантай ижил. Хөмөрсөн аяган дахь ус өөрийгөө угаасаа ийм өчүүхэн, их далайн устай адилгүй гэж боддог. Гэвч аягыг нь авчихвал, аяган дахь ус далайн устай ав адилхан тул нийлж нэгэн цогц болно. Учир нь эдгээр ус угаас ижил чанартай.

Цаглашгүй гэрэл яг үүнтэй адил. Бид ч угаасаа цаглашгүй гэрэл юм. Гэвч махан биед хоригдсоноос болж гаднах байдлыг мэдэхээ больжээ. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Үнэндээ бидний дотор ч бас гэрэлтэй. Өөрийн жинхэнэ гэрлээ харъя гэвэл харж болно. Энэхүү гэрэл нь бидний Уг дүр юм.

Уг дүр гэж юу вэ? Бидний жинхэнэ уг чанар бол “Гэрэл” мөн. Хэрэв хэн нэгэн энэхүү бие махбодыг мэс заслын хутгаар бус, ямар нэгэн сэтгэшгүй бясалгалын арга ашиглан нээж чадвал, бие доторх “Хэмжээтэй гэрэл” махан биеийн хүлээснээс салж, “Цаглашгүй гэрэл”-тэй холбогдоно. Энэ нь тэрхүү аягыг авмагц доторх ус нь далайн устай дахин нийлж, анхны нэгдмэл байдлаа сэргээсэнтэй адил. Тэр үед бид “Цаглашгүй гэрэл” болохоо ойлгоно.

Цаглашгүй гэрлээс гадна бас яагаад “Цаглашгүй насан хутаг” гэж хэлж байна вэ? Учир нь бид угаас үл төрж, үл үхэх болохоор) “Зүрхэн судар” (Heart sutra)-т: “Хамаг ном хоосныг өгүүлж, төрөхгүй устахгүй, хиргүй, ариунгүй, нэмэгдэхгүй, хорогдохгүй болой.” гэжээ. Энэ нь цаглашгүй гэрэл, цаглашгүй насан хутаг гэдэгтэй нэг утгатай. Шагжамуни Буддагийн айлдсан

ном судруудад олон зүйрлэл, олон аргыг хэрэглэж, хамаг амьтанд өөрсдийнх нь уг чанарыг ойлгуулдаг. Хамаг амьтны дэсэд тохирсон зүйрлэл ашигладаг байжээ. Тиймээс “Зүрхэн судар” болон “Авид бурханы судар” хоорондоо зөрүүгүй, үнэндээ ижил байдаг.

“Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”-т Шагжамуни Будда айлдахдаа: “Бурхан ертөнцөд заларсан нь өөртөө шүтэн мөргүүлэх, өөрийгөө дэлхийн хамгийн агуу хүн гэж төрлөөс төрөлд магтуулахын төлөө бус. Харин Бурханы мэдэж ухаарсныг, түүний билиг ухааныг хамаг амьтанд ойлгуулж, тэднийг Бурхан болгохын төлөө юм.” гэжээ. Түүнчлэн Тэрээр: “Бурхан заларсан нь хамаг амьтныг Бурхан болгохын төлөө, тэдэнд Бурханы билиг ухааныг ойлгуулахын төлөө юм. Бурханы билиг ухааныг ойлговол Бурхан болсныг илтгэнэ.” гэжээ. Шагжамуни Будда энэ зорилгоор ертөнцөд заларсан билээ. Тиймээс Түүний аль ч ном судар, аливаа дүрслэл зүйрлэл нь бүгд хамаг амьтныг Бурханы хутагт хүргэхийн төлөө юм. “Зүрхэн судар” болон “Авид бурханы судар”-ын эцсийн зорилго нь яг адил. Яагаад адил болохыг Багш нь дараа хэлж өгье.

“Авид бурханы судар”-тай холбоотой өөр бас нэгэн судар бий. Энэ бол “Цаглашгүй насан хутагт Бурханыг ажихуй судар” юм. Уг сударт Авид бурхан, Арьяабал бурхан болон Очироорваань бурханыг хэрхэн дүрслэн бодохыг Шагжамуни Будда бидэнд хэлж өгчээ. Түүнчлэн төгс баясгалант орон (диваажин)-д ямар гайхамшигт үзэгдэл байдгийг тайлбарлажээ. Дээгүүр зэрэг нь дээр мэндлэх, дунд зэрэг нь дунд мэндлэх, доогуур зэрэг нь доор мэндлэхэд ямар нөхцөл бүрэлдсэн байх ёстой вэ? Арван зургаан дүрслэн бодохуйг бясалгаж байж л төгс баясгалант оронд мэндэлж чадна. Энэ бол “Цаглашгүй насан хутагт бурханыг ажихуй судар”-ын гол агуулга юм. Үнэн хэрэгтээ үүнийг “Авид бурханы судар”-т тооцож болно.

“Авид бурханы судар”-т Будда: “Авид бурханыг нэгэн сэтгэлээр долоо хоног дуудан залбираад сэтгэл сарнихгүй бол төгс баясгалант оронд мэндэлнэ.” гэдэг. Гэвч сэтгэл сарних нь уу, үгүй юү? Уншиж үзье. Долоо хоног байтугай нэг бодлын зуур ч сарнихгүй байж чадахгүй. Ийм хялбархан бясалгалын аргаар бид яагаад бясалгаж чадахгүй байна вэ? Тэгэхээр алдаж буруудсан газар лавтай байна. Учир нь бид “Цаглашгүй гэрэл”-ийг хараагүй болохоор зөвхөн амаараа дурсан унших төдий. Ингэх нь хангалтгүй. Хятадын “дурсах” гэдэг үг “бодох ба дурсах” гэсэн утгатай хоёр ханзнаас бүтнэ. Энэ хоёр ханзанд хоёуланд

нь “сэтгэл” гэсэн дүрс агуулагддаг нь “сэтгэл”-ээрээ дурсах гэсэн утгыг илэрхийлнэ. Хэрэв “сэтгэл”-ээрээ гэвэл эхлээд үзэж харж байж л “сэтгэл”-ээрээ дурсаж чадна. Тийм үү? Жишээ нь, эрэгтэй хүн эмэгтэйгээ дурсан саная гэвэл урьд нь уулзсан, үзэж харсан байж л дурсан санаж чадна. Наад зах нь дуу хоолойг нь сонссон ч юм уу, гар хөлийг нь анзаарсан байж таарна. Үгүйдээ л барааг нь, эсвэл царай зүсийг нь харсан учраас хариад дурсан санаж чадна. Тийм үү? Дурсан санах гэдэг нь нэг нь нөгөөгөө санагалзахыг хэлнэ. Үзэж хараагүй хүнийг яаж дурсан санах вэ? Намайг ойлгож байна уу? Бид хүчээр дурсвал толгой өвдөнө. Дээр үед эмэгтэйчүүдийг гэрт нь хориод гадагш гаргадаггүй байсан тул санаашрах өвчин тусах нь бага байв. Хайр дурлалын түүх ч цөөн байжээ. Одоо ийм түүх олширсон. Учир нь хүмүүсийн уулзаж учрах боломж ихсэж, бие биеэ дурсан санагалзах нь улам нэмэгджээ.

Үүнтэй адил бид Бурханыг “дурсан саная” гэсэн ч үзэж хараагүй юм чинь яаж дурсаж чадах вэ? Бид дурсахгүй гээгүй ч Бурханыг хараагүй тул сэтгэл сарниад байгаа хэрэг. Иймээс сэтгэлээ сарниулахгүй байлгая гэвэл эхлээд цаглашгүй гэрлийг харах хэрэгтэй. Amitabha-г хараад, өөрийн “Хэмжээтэй гэрэл”-ээ “Цаглашгүй гэрэл”-тэй нийлүүлэх агшинд л “дурсан саналцаж” чадна. Ингэвэл Бурхан бидэнтэй, бид ч Бурхантай холбогдож чадна.

Бид нэгэнт цаглашгүй гэрэл юм чинь дотор маань бас гэрэл байх ёстой. Энэ гэрэл их бага нь хамаагүй, бидэнд байгаа л бол цаглашгүй гэрлийг харах арга заавал бий. Гэрэл харах үеийг “Цэцэг дэлгэрвэл Бурханыг харна.” гэдэг. Бурхан энгийн хүмүүсийн төсөөлөн боддог шиг дүртэй биш. Мэдээж Тэр өөр хэлбэрт хувирч болох ч энэ нь угийн тийм төрхтэй гэсэн үг биш. Бурхан дүр дүрсгүй боловч ямар ч дүр дүрсэнд хувирна. Тиймээс “Үй түмэн хувилгаан биет Шагжамуни Будда”, “Гучин хоёр тоост ертөнцийн лагшин дүрт Арьяабал бурхан”, “Цаглашгүй гэрэл, гэрлийн дотор Бурханы хувилгаан үй түм, Бодьсадвагийн хувилгаан хэмжээлшгүй их” гэдэг билээ. Учир нь Бурхан угаас цаглашгүй гэрэл болохоор яаж ч хувирч болно.

Одоо “Цэцэг дэлгэрвэл Бурханыг харах” тухай ярья. Чухам ямар Бурханыг харах вэ? гэвэл энэхүү “Цаглашгүй гэрэл”-ийг харна. Энэ гэрэл Арьяабал бурхан болон хувирч чадна. Бас Авид бурхан, Очироорваань бурхан болж ч чадна. Тэр хэн ч болон хувирна. Энэ бүгд бидний өөрийн цаглашгүй гэрлээс хувиран гарсан тул “Аливааг сэтгэлээр зохиосон.” гэдэг билээ. Гэхдээ

энэхүү “Сэтгэл”-ээ олохоос өмнө “Аливааг сэтгэлээр зохиосон.” гэж болохгүй. Яагаад гэвэл бид юуг ч хувиргаж чадахгүй. Өвчнөө эдгээе гээд эдгэхгүй, баяжъя гэсэн ч чадахгүй, баруун тийш явах гээд зүүн тийш явчихдаг. (*Бүгд инээв*.) Диваажинд очих гээд тамд уначихдаг. Энэ нь бидний “Сэтгэл”-ээ хараахан олоогүйгээс болж байгаа тул “Аливааг сэтгэлээр зохиосон.” гэж болохгүй.

Бид Цаглашгүй гэрлийг харахаас өмнө жинхэнэ ёсоор “Бурханд залбирсан” гэж хэлж болохгүй. Багш нь ном судрыг үндэслэн ингэж ярьж байна. Та нарыг буруу залбирлаа гэж шүүмжилж байгаа юм биш. Та нар яаж залбирдгийг би мэдэхгүй. Харилцан мэдэлцэхийн тулд л үүнийг ярьж байгаа юм.

Бидний бие махбодын дотор нэгэн хаалга бий. Хаалга гэхэд хаалга биш, нүд гэхэд бас нүд биш. Тэрхүү хаалгаар бид билиг ухаанаа нээж болно. Иймээс зарим нь түүнийг “Билгийн мэлмий“ гэнэ. Учир нь энэхүү билгийн мэлмий нээгдсэний дараа Бурханыг харна, Бурханы билиг ухаантай болно. Зарим нь бас “Бурханы мэлмий” ч гэдэг. Бид тэр газраа яаж нээхийг мэдвэл өөрийн “Уг чанар”-аа олж харах бөгөөд өөрсдийгөө “Гэрэл” болохыг ойлгоно. Анхандаа “Хэмжээтэй гэрэл” байна. Олонтоо харсаар байгаад энэхүү биеийг баглагч хувцсыг тайлж хаясны дараа “Цаглашгүй гэрэл” болон хувирна. Цаглашгүй гэрэл болсны дараа “Цаглашгүй насан хутаг” болно. Учир нь энэ үед хэдийнээ төрж үхэхээс ангижирч төрөхгүй, устахгүй, ирэхгүй, одохгүй, нэгэнт “Түүнчлэн ирсэн” болно.

Хүмүүс хэдийгээр янз бүрийн бясалгалын аргаар сүнслэг дадал бясалгал хийдэг ч энэхүү хамгийн чухал зүйлийг мартжээ. Энэхүү хаалгыг эхлээд нээх хэрэгтэй. Дотор нь гэрэл бий. Хаалгыг нээвэл замаа харна. Энэхүү билгийн мэлмийг нээсний дараа бид билиг ухаантай болно. “Бурханы мэлмий”-г нээсний дараа “Бурхан чанар” буюу “Бурханы гэрэл”, эсвэл “Өөрийн чанарын гэрэл”-ээ харна. Бурханы гэрэл бол бидний өөрийн гэрэл. Учир нь бид угаас Бурхан. Шагжамуни Будда: “Хамаг амьтан бүгд Бурхан чанартай.” гэсэн. Тэр биднийг хуурахгүй. Гагцхүү өөрсдөө мэдэхгүйгээс “хаалга”-аа нээхгүй байгаа нь бидний буруу. Энэхүү билгийн мэлмийг нээсний дараа Шагжамуни Буддагийн ярьсан Авид бурхан ямар дүр төрхтэйг ойлгоно. Тэр үед л бид Авид бурхантай танилцаж эхлэх бөгөөд Түүнийг дурсаж чадна. Анх эхлээд бага сага танилцана. Гэртээ хариад ихээр дурсан санаж, санах тусмаа улам сайн танилцана. Чухам энэ үед л бид жинхэнэ ёсоор “Бурханыг дурсан санана”. Ийм аргаар “Бурханыг дурсвал” лавтайяа ангижирна. Жар, дал, зуу наслахыг хүлээх биш, одоо ч

ангижирч болно.

Ангижрах гэдэг нь ямар утгатай вэ? “салж одох” гэсэн үг.

Юу салж одох вэ? Бидний жинхэнэ би, жинхэнэ хүн энэхүү махан биеэс салж одно. Багшийнх нь саяхан ярьсан аяга устай адил. Аягыг усанд хөмөрвөл дотор нь ус хоригдоно. Аягыг авмагц ус урдын байдалдаа эргэж орно. Хэрэв авахгүй бол доторх ус нь аажмаар муудан, амт орж өмхийрнө. Урсгал ус ч адил. Зогсолтгүй урсаж байвал зүв зүгээр, цэвэр тунгалаг хэвээр байдаг. Хэрэв түүнийг хашиж нуур цөөрөм үүсгэвэл хэд ч хонолгүй мэлхий, шумуул зэрэг олон амьтан цуглаж үржээд урьдын адил цэвэр тунгалаг биш болно. Ус урсахаа больж, гол урсгалтайгаа нийлэхгүй болсноос “тогтонги ус” болон хувирна.

Үүний адил бид энэхүү махан биед хоригдоод байвал гэрэл маань улам бүдгэрч, улам зовуурьтай болно. Учир нь “Их гэрлийн урсгал”-аасаа тасран, холбоогүй болсноос ганцаардаж, ихэд зовж, юу ч хийсэн урамгүй, юу ч олсон ханамжгүй болж, аажимдаа муудаж ялзарна. Хамгийн ихдээ л зуун жил амьдарна. Бид муудаж ялзарсны дараа гэрэл ч үгүй, бие махбод ч үгүй болдог. Тэр үед бид хаа очихоо мэдэхгүй болно. Бид ангижрахыг хүсдэг. Одоогоос ангижрах дасгалыг хийх хэрэгтэй. Тэгвэл цаг нь ирэхэд бид жинхэнэ ёсоор ангижирч чадна. Одоо л дасгал хийхгүй бол цаг нь болоход яах ч учраа олохгүй будилах болно. Жишээ нь, бид багаасаа сайн сурахгүй бол эрдэмтэй хүн болж чадахгүй. Өөд болсны дараа бол бүр ч чадахгүй. Эрдэмтэй больё гэвэл эхлээд суралцах хэрэгтэй. Эс бөгөөс амжилт олж чадахгүй. Тариачин өөд болоод эмч болохгүй. Үүнтэй адил ангижрах гэж юу болохыг бид одоо л мэдэж авахгүй бол цаг нь ирэхээр яаж ангижрахаа мэдэхгүй. Ингээд бид энэ ертөнцөөс албадлагаар явах болдог. Энэ нь жинхэнээр ангижирч буй хэрэг биш юм.

Тиймээс Бурханыг чухам яаж дурсахаа мэдчихвэл сэтгэл сарнихгүй болж, баталгаатай ангижирна. Яаж дурсахаа нэгэнт мэдсэн бол энэ төрлийн үйл үр барагдмагц яваад өгч болно. Эртнээс нааш маш олон Их Багш нар ангижрахаа урьдаар мэдээд хэзээ явахаа шавь нартаа хэлдэг байжээ. Нэг өдрөөр хойшлуулаач гэж Их Багшаас гуйвал тэр хойшлуулж чадна. Тэрээр урьдаар мэдээд бэлтгэлээ базаана. Эхлээд биеэ угааж, шавь нараа дуудан хамтдаа цайлсны дараа (*Бүгд инээв.*) суугаагаараа амарлингүй ёсонд саатна. Өдөр бүр ангижрах дасгал хийж байсан тул хэдийнээ дадамгай болжээ. Та нар ногоо авахаар өдөр бүр дэлгүүр явдаг болохоор замаа андахгүй. Нүдээ аниад явсан ч хүрч чаддагтай адил. Тэдний хувьд ангижрах нь тун энгийн хэрэг юм.

Хэрвээ бид өдөр бүр хаалгаа хаачихаад гэрээс гарахгүй бол хэсэг хугацааны дараа хаалга нээгдэхээ болино. Тийм үү? Хаалга гажиж зэврээд барьцалдан наалдаж, түлхүүр байсан ч онгойлгож чадахгүй болдог. Бидний бие махбодод бас нэгэн хаалга бий. Түүнийг одоо алгуур аажмаар, өдөр бүр онгойлгохгүй бол буцах үед нээхэд хэцүү болно. Тиймээс насан эцэслэх гэж буй хүнийг харахад урьд нь бясалгалыг жинхэнэ ёсоор нь дадуулж байгаагүй бол үнэхээр их зовлон шаналалтай байдаг. Яагаад тэр вэ? Сүнс гэж яривал ойлгоход дөхөмтэй. Яагаад гэвэл түүний сүнс буюу эзэн, түүний "Жинхэнэ хүн" нь явах гэтэл хаалга нь онгойхгүй, нааш цааш гүйн, энд тэнд мөргөж, ихээр зовж шаналан, хаагуур гарахаа мэдэхгүйгээс яах ч аргагүй болдог. Жишээ нь, галын аюул гарахад үүд хаалгаар гарч чадахгүйд хүрвэл, аргагүйн эрхэнд цонхны хөшгийг урж цонхыг хагалах юм уу, эсвэл ариун цэврийн өрөөний жижиг салхивчаар үсэрнэ. Энэ үед гар хөлөө хугалж, биеэ гэмтээж мэднэ. Яарч бачимдсан үед гол хаалгаар гарах аргагүй бол цонх юм уу бусад аль нэг газраар үсэрнэ. Их сандарснаасаа болж зүг чиггүй харайлгаж биеэ гэмтээх юм уу, элдэв юм мөргөж амь насаа ч алдаж болно.

Үүнтэй адил бид одоо гол хаалга гэж юу болохыг мэдэхгүй, гарах бэлтгэлгүй, хаалгаа гүйцэд нээгээгүй учраас энэ ертөнцөөс ангижрах үед тун их зовох нь мэдээж. Явах гээд явж чадахгүй. Жинхэнэ хаалгаа нээгээгүй тул аргагүй эрхэнд хажуугийн жижиг хаалгаар гарна. Тэгээд там, бирд, адгуус, асурийн оронтой учирч, үхээд там, бирд, адгуус, асурийн төрөлтөн болдог.

Үүнээс гадна "Авид бурханы судар"-т Шагжамуни Будда: "Буян хүрэхгүй бол төгс баясгалант оронд төрж үл чадна." гэжээ. Авид бурхан гэж амандаа залбираад байвал буян хүрэх үү? (*Бүгд хүрэхгүй гэж хариулав*.) Дээр нь "Очироор огтлогч судар"-т дурдсан өглөг, сахил, хүлцэнгүй, хичээнгүй, даяан, билгийг нэмж байж буян хүрч магадгүй. Тийм биш бол Шагжамуни Будда"Авид бурханы судар"-ыг тайлахад л хангалттай, "Очироор огтлогч судар"-ыг нэмж тайлах шаардлагагүй байсан. Тэрээр "Авид бурханы судар"-ыг тайлахад Ананд байлцсан. Шагжамуни Будда өөрийн их шавь Анандад зориулж "Баатараа явагч их хөлгөн судар"-ыг тайлжээ. Шагжамуни Буддаг ном тайлах бүрд Ананд үргэлж хамт байсан. "Цаглашгүй насан хутагт Буддаг ажихуй судар"-ыг тайлахад Ананд бас байлцсан. Учир нь тэр үед Войдэхи хатан гянданд хоригдож байхдаа Молом тойн (Модгальяана), Ананд хоёрыг гянданд ирүүлж, ном тайлж өгнө үү? гэж Буддагаас гуйжээ. Тэр үед Хэнтригүд ууланд байсан Будда, Войдэхи хатны

гуйлтыг сонсоод Ананд, Молом тойн (Модгальяана) хоёрыг тэр дор нь гяндан уруу илгээж, өөрөө ч мөн нисэж очоод гурвуул "Цаглашгүй насан хутагт Бурханыг ажихуй судар"-ыг тайлж хатанд сонсгосон байна.

Энэ нь Бурханыг жинхэнэ дурсах бясалгалын аргыг мэдэх боломж Анандад байсныг илтгэж байна. Яагаад гэвэл Шагжамуни Буддаг ном тайлахад тэр дэргэд нь байсан. Гэтэл яагаад "Баатараа явагч их хөлгөн судар"-т Арьяабалын бясалгалын аргыг сурах хэрэгтэй гэж Будда Түүнд заасан юм бэ? Манзушир бурхан бас Арьяабалын бясалгалын аргыг сурч байж л Бурхан болно гэж хэлсэн. Учир нь "Бурханыг дурсах"-даа зөвхөн амаараа унших нь хангалтгүй. Арьяабалын бясалгалын аргаар билгийн мэлмийгээ нээх хэрэгтэй. Бурханыг харсны дараа "Үл төрөхийг ухаарна.", "Цэцэг дэлгэрвэл Бурханыг харж, үл төрөхийг ухаарна." гэдэг нь Бурханыг хараагүй бол төрөхгүй, устахгүй болж чадахгүй гэсэн санаа. Бурханыг харах гэдэг нь энэхүү цаглашгүй гэрлийг харахыг хэлнэ. Агшнаа гэгээрэх бясалгалын аргаар цаглашгүй гэрлийг тун түргэн харж чаддаг. Арьяабалын бясалгалын арга нь "Агшин зуур гэгээрэх бясалгалын арга" юм. Бурханд мөргөх, маани, тарни унших нь "Аажмаар гэгээрэх бясалгалын арга" бөгөөд алгуур аажмаар суралцдаг. Энэхүү аажмаар гэгээрэх бясалгалын аргыг Шэньшиү заажээ. Зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн "Агшин зуур гэгээрэх бясалгалын арга"-аар хэрхэн тэр даруйдаа "Чанараа харж Бурхан болох"-ыг зааж байв.

Агшин зуур гэгээрэх бясалгалын аргыг одоо ч сурч болно. Эртнээс нааш аль ч үед "Агшин зуур гэгээрэх" хийгээд "Аажмаар гэгээрэх" бясалгалын аргыг уламжлах хүн байдаг болохоор суръя гэснээ сонгоод сурч болно. "Агшнаа гэгээрэх" бясалгалын аргыг заах хүнийг олоход тийм ч амаргүй. Ихэнх нь аажмаар гэгээрэхийг зааж, аажмаар бясалгахыг сургаж, өдөр бүр толь зүлгүүлдэг. (Бие бол бодь мод, сэтгэл бол тунгалаг толь, цаг ямагт алжаалгүй арчин зүлгэж, хог тоос суулгаж болохгүй.) Гэтэл Зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн: "Толь үгүй, угаас баймаар юмгүй байтал бас юуг нь арчиж зүлгэх вэ? " гэжээ. (Бодь мод гэдэг нь угаас мод үгүй, тунгалаг толь гэдэг нь угаас толь үгүй, угаас нэг ч юм үгүй атал тоос тортог хаана нь суух вэ?) Аажмаар гэгээрэх хийгээд агшин зуур гэгээрэх нь гаднаасаа ялгагдах юм үгүй ч дотоодын дэс нь үнэндээ огт өөр.

"Авид бурханы судар"-т ч Арьяабалын бясалгалын аргын талаар, тухайлбал хүчит гэрэл, цаглашгүй гэрлийг ажих, мөн

дотоодын аялгууны талаар дурдсан. Гэвч энэ талаар өнөөдөр бага ярина. “Цэцэг дэлгэрвэл Бурханыг харна.” гэдэг нь энэхүү “Бурхан чанар”-аа харж байж л бид “Үл төрөхийг ухаарна.” гэсэн үг. “Үл төрөхийг ухаарна” гэж юу вэ? Төрөхгүй устахгүй, төрж, үхэхээс нэгэнт ангижирсан гэсэн утгатай. “Авид бурханы судар”-т Шагжамуни Будда төгс баясгалант орны зүйл зүйлийн үзэсгэлэнт, гайхамшигт байдлыг танилцуулсан байдгийг би саяхан дурдсан.

Тэнд бадамлянхуа цэцэг, найман эрдэмт рашаан бий. Бурханы хувилгаан бяцхан шувуухай хорин дөрвөн цаг тасралтгүй ном тайлдаг. Хамаг амьтан тэрхүү шувуухайн ном тайлахыг сонсож, төгс баясгалант оронд өдөржин шөнөжин дуурьсаж байгаа яруу гайхамшигт дуу хөгжмийг сонссоны дараа нэгэн сэтгэлээр Бурхан, ном, хуврагийг дурсан санаж чадна.

Хэрэв бид Бурханыг харж чадахгүй юм бол жинхэнэ ёсоор “Дурсан санаж” чадахгүй гэж би саяхан хэлсэн. Одоо бид нар хараа ч үгүй, сонсоо ч үгүй байгаа нь харамсалтай хэрэг биш үү? Ийм байж яаж Бурханыг “дурсаж” чадах вэ? Шагжамуни Будда энэ тухай тун тодорхой тайлсан билээ. Төгс баясгалант орны гайхамшигт яруу сайхан дуу хөгжмийг сонсоод Бурхан, ном, хуврагийг дурсан унших сэтгэл хамаг амьтанд аяндаа үүсдэг. Тэр үед Бурханыг жинхэнэ ёсоор “дурсаж” чадна гэжээ. Бид одоо хараагүй, сонсоогүй болохоор нэгэн сэтгэлээр Бурханыг дурсан уншиж чадахгүй нь мэдээж. Хэрхэн дурсахыг бидэнд зааж сургасан хүнгүй тул бидний буруу биш. Шагжамуни Будда хэдийнээ энэ ертөнцийг орхин одсон. Түүний их шавь нар ч бас явчихсан. Одоо маш олон номын багш нар байгаа хэдий ч та нар тэднээс асууж лавласангүй юу, эсвэл тэд мэдэхгүй байгаа юм уу гэдгийг би тогтоож чадахгүй. Ямартай ч та нар нэгэн сэтгэлээр бурханыг дурсах аргыг сураагүй байна. Бидний дурсаж буй хэлбэр бүрэн зөв биш учраас тал хувийг нь ч дурсаж чаддаггүй. Цаглашгүй гэрлийг хараагүй тул төгс баясгалант орны гайхамшигт дуу хөгжмийг бас сонсож чадахгүй. Иймээс Бурхан, ном, хуврагийг дурсан залбирах нэгэн сэтгэл аяндаа төрөхгүй. Ингэж хэлэх нь зөв үү? Та нар ойлгов уу? (*Бүгд ойлгосон гэж хариулав*.) Бид Буддагийн айлдсан ёсоор хийх хэрэгтэй. Ингэх нь жинхэнэ ёсоор, нэгэн сэтгэлээр Бурханыг дурсах” болно.

“Ум ма ни бад ми хум” гэдэг тарни байдаг. Энэ ямар утгатайг та нар мэдэх үү? “Ум” гэдэг нь угтаа ямар ч утгагүй, самгарди хэлний нэгэн авиа төдий. Гэвч тэр орчлон ертөнцийн аялгуутай тун төстэй. Хэрэв бид сүнслэг дадал бясалгал хийгээд тодорхой түвшинд хүрвэл “Ум”-тай тун адилавтар аялгууг сонсдог. Үүнээс

болоод “Ум ма ни бад ми хум” гэх сахиулсан тарни болж хувирчээ. “Ма ни” гэдэг нь юуг хэлж байна вэ? Ма ни бол Муни болно. Тэр нь муни сувд буюу хүслийг хангагч чандмань эрдэнэ гэсэн утгатай. Энэхүү хүслийг хангагч чандмань эрдэнэ буюу муни сувдаар бидний Бурхан чанарыг төлөөлүүлж байна. Ойлгож байна уу? Билиг нээгдэхэд энэхүү муни сувдыг олно. Цэцэг дэлгэрвэл Бурханыг харна гэдэг нь энэхүү муни сувдыг олж авахыг хэлж байна.

Бурхан чанар яагаад муни сувд болж хувирсан бэ? Учир нь Бурхан чанараа харсны дараа хүслийг хангагч чандмань эрдэнэ шиг санасан бүхэн сэтгэлчлэн бүтнэ. Ойлгов уу? Бид юу хүснэ тэр биелж, тэр байтугай бодож ч амжаагүй байхад биелчихдэг болохоор муни сувд гэж нэрийджээ. Муни сувд гэдэг нь самгарди үг бөгөөд хятад хэл рүү орчуулбал хүслийг хангагч сувд эрдэнэ гэсэн утгатай. Хэрэв бид муни сувдтай болбол бидэнд бүх юм бүхэн байх болно.

“Ум ма ни бад ми хум”-ын “бад ми” гэдэг нь бадамлянхуаг зааж байна. Бид - гэдэг. Padma Padme нь үнэндээ ялгаагүй. Энд тэндхийн аман аялгаас болж адилгүй болжээ. Энэхүү муни сувд бадамлянхуа дотор бий. Бадамлянхуа дотор аянгын дуут гэгээн гэрэлт эрдэнийн сувд бий гэдэг нь “Гэрэл” болон “Аялгуу” бадамлянхуа цэцгийн дотор байгааг илтгэж байна. Энэ нь “Ум ма ни бад ми хум” гэдэг тарнийн утга юм. Одоо ойлгов уу? “Авид бурханы судар”-т “Цэцэг дэлгэрвэл Бурханыг харна” гэсэн. Үүний утга нь “Ум ма ни бад ми хум”-тай адилхан. Гэвч “Муни сувд”-ыг үзээгүй, “Бурхан чанар”-аа хараагүй бол бид “Ум ма ни бад ми хум” гэж уншаад ч төдийлөн нэмэргүй. Эрт үеийн Их Багш нар энэхүү тарниар биднийг муни сувдаа эрэх хэрэгтэйг, муни сувд бидний бадамлянхуа дотор байгааг анхааруулан сануулсан хэрэг. Юуны учир бадамлянхуа гэдэг вэ? Яагаад “Цэцэг дэлгэрвэл Бурханыг харна.” гэж хэлдэг вэ? Яагаад жимс боловсорвол Бурханыг харна, гарын алга нээгдвэл Бурханыг харна, чих нээгдвэл Бурханыг харна гэлгүй, заавал “Цэцэг дэлгэрвэл Бурханыг харна.” гэсэн бэ? Учир нь бидний биед төрж үхэхтэй холбоотой маш олон чухал “Хүрд”-үүд (самгардиар Chakra буюу биеийн гол төв гэсэн утгатай, өнөөгийн хэлэнд хүрд гэж хэлж хэвшсэн байна.) байдаг. Эдгээр хүрдийг харахад бадамлянхуатай адил. Бидний биед маш олон “Хүрд”-үүд байна. Яагаад хүрд гэдэг вэ? Тэрхүү хүрдүүдийг бясалгаж хаалгыг нь нээвэл бид агуу орчлонтой холбогдон нэгдэнэ. Түрүүний миний ярьсан тэрхүү аягатай устай адил. Аягыг авмагц ус нь гадаад их далайн устай нэгддэг шиг. Иймээс

бид тэрхүү төвийг “Хүрд” гэж нэрлэдэг.

Бидний биед иймхүрд олон бий. Бэлгэ эрхтэнд, наран сүлжээнд, зүрхэнд, хоолойд, хоёр хөмсөгний дунд, толгойн орой зэрэгт байдаг. Бид бясалгал дадуулаад билгийн мэлмий нээгдвэл эдгээрийг мэднэ. Түүнийг харахад яг л бадран дэлгэрч буй бадамлянхуатай адил болохоор “Ум ма ни бад ми хум” гэдэг. Энэ нь эрдэнийн сувд бадамлянхуа дотор байгааг илтгэнэ. Мөн “Цэцэг дэлгэрвэл Бурханыг харна.” гэсэн утгатай. Тиймээс жимс боловсорвол Бурханыг харна гэж хэлсэнгүй. Учир нь түүнийг харахад жимстэй адилгүй, харин бадамлянхуатай адил байдаг. Энэхүү цэцэг дэлгэрвэл бид муни сувдаа олж авна. “Ум ма ни бад ми хум”, “Цэцэг дэлгэрвэл Бурханыг харж, үл төрөхийг ухаарна.” гэдэг нь ийм утгатай.

Маш олон ном сударт нэгэн адил учир ёсыг тайлсан байх бөгөөд шидэт тарни ч бас энгийн тарнитай адилхан. Бид завтай бол лавлан үзэж болно. Бясалгал дадуулсны дараа тэдний утга санаа нь бараг адилхан болохыг ойлгоно. Ийм олон хүрдүүдээс чухам алийг нь нээвэл зохих вэ? гэж өөрөөсөө асууж магадгүй. Энэ асуултыг билиг нь нэгэнт нээгдсэн хүнээс асуугаад мэдэж авч болно. Цаг боллоо. Одоо буяны магтаалаа дуулцгаая.

АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГААР БЯСАЛГАХЫН АЧ ТУС

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
айлдвар. Формосагийн Тайбэй хотын
Цаглашгүй гэрэлт бясалгалын төв.
1987 оны 3 дугаар сарын 7
(Эх нь хятад хэлээр)

Шагжамуни Будда 49 жил ном уламжлахдаа туулан гэтэлгэх бясалгалын аргыг л тайлж, бүх ном сударгаа Арьяабалын бясалгалын аргыг магтан сайшаажээ. Нэгэн гэгээнтэн өчигдөр Багшаас нь: "Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн сударт-т юуг тайлсан юм бэ? гэж асуусан. Намайг энэ номыг тайлахыг манай авшигтнууд хэдэн арван удаа сонссон.

"Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн сударт-т Арьяабалын бясалгалын арга, дотоодын аялгууны тухай л ярьсан. Та нар хариад уншвал мэднэ. Гэвч Арьяабалын бясалгалын аргаар бясалгал дадуулаагүй л бол үүнд итгэхэд бэрх. "Богдсын ном цагаан лянхуа" нэрт их хөлгөн сударт-т Шагжамуни Будда Арьяабалын бясалгалын аргыг "Богдсын ном", "Лянхуа ном" гэж нэрлэсэн. "Очироор огтлогч" сударт "Очироорт ном", "Авид бурханы сударт-т "Ариун орны ном" гэжээ. Нэр нь адилгүй тул хольж хутгаж магадгүй. Хамаг төрөлтний уг гарвал, дэс түвшин адилгүйгээс Шагжамуни Будда нэг бясалгалын аргыг өөр нэрээр тайлжээ. Үнэн хэрэгтээ тийм олон бясалгалын арга байхгүй. Энэ тухай Багш нь Пэнхүд өмнө нь ярьсан тул айлдварын материалыг лавлагаа болгон тарааж өгнө. Та нар цаг зав гаргаж сайтар нягтлан уншвал ойлгоно. Өнөөдөр энэ талаар давтан ярихгүй.

Ном тавиад дөрвөн өдөр боллоо. Багш нь олон зүйлийн талаар ярьсан ч гол нь Арьяабалын бясалгалын арга бол хамгийн сайн бясалгалын арга гэдгийг та нарт ойлгуулахыг зорьсон. Түүнээс биш цаг завтай, ярих дуртайдаа биш. Хүмүүсийн ярьцгаадаг

бясалгалын арга гэгч нь туулан гэтэлгэх дээд бясалгалын арга биш, харин Арьяабалын бясалгалын арга л төгс дээд нь болохыг та нарт жинхэнээр ойлгуулахын тулд өдөр бүр энд ирж ном тайлж байна. Багш нь өнөөдрийг хүртэл Арьяабалын бясалгалын аргыг зөвхөн магтан сайшааж, танилцуулан сурталчилж байгаа тул энэхүү бясалгалын арга гэж чухам юу болохыг та нар хараахан мэдээгүй байгаа. Тийм үү?

Ном уламжлах үед Багш нь үг ярьдаггүй болохоор л шавь нар энэхүү бясалгалын аргыг хүртэж чаддаг. Ярьдаггүй учраас энэхүү бясалгалын аргыг ном судраас хэзээ ч олохгүй. Эрт үеийн Их даяанч багш нар "Онол номлолоос ангид байж, ном судар хэрэглэхгүй." гэдэг. Ном судраар юу ч уламжилж чадахгүй. Харин эртний их бясалгалтнуудын ахуй ойлголт, бодол санаа ямар байсан, билиг нээгдээд ярьсан, харсан зүйлсийг өөрийнхтэйгээ харьцуулан лавлаж, судалж болох нэг төрлийн тэмдэглэл юм. Энэ нь түүний ач тус, гэвч ном судраар ном уламжилж болохгүй.

"Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл"-д Шюаньзан Их Багш хятадын эх газраас энэтхэгт очин ном залж, гэгээрлийн мөрийг эрж явахдаа амссан зовлон зүдүүр, ад чөтгөрт хэрхэн түйвээлгүүлсэн, шавь Сүн Үкүн түүнд туслан ад шуламсыг хэрхэн зайлуулсан, эцэст нь ном судраа яаж залж авчирсныг өгүүлжээ. Гэвч энэхүү судар Шюаньзан Их багш биш тул "Тансан ламын баруунаа зорчсон тэмдэглэл"-ийг бусдын уншихыг сонсох, эсвэл өөрөө унших нь ямар ч ач тусгүй. Бид ном судар залж авчирч чадахгүй. Шюаньзан тухайн үед яаж зовж зүдэрч байсныг ч ойлгохгүй. Тэр ч байтугай Сүн Үкүны ид шидийг ч олж чадахгүй. Бид зөвхөн үлгэрийн агуулгыг нь бодож чадах төдий. Тийм үү?

"Баатараа явагч их хөлгөн судар", "Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар", "Очироор огтлогч" судар"-т Шагжамуни Будда Арьяабалын бясалгалын аргыг олонтоо магтан сайшаасан ч бид ямар бясалгалын арга болохыг нь мэддэггүй. Олон хүн "Баатараа явагч их хөлгөн судар"-ыг уншаад хамгийн төгс бясалгалын арга болохыг ойлгосон ч, бясалгалыг хэрхэн яаж хийхийг мэддэг хүн тун цөөхөн. Иймээс тэд зөвхөн таамаглах төдий байжээ.

Жишээ нь, зарим хүн далайн хөвөөнд очиж, далайн түрлэгийн дууг сонсдог. Тэрхүү тасралтгүй урсгалын чимээг сонсохыг аялгуу ажиж буй хэрэг гэж үздэг. Зарим нь Арьяабалын бясалгалын арга гэж "Арьяабал бурханд мөргөмүй." гэж залбирахыг, зарим нь их нигүүлсэнгүй тарни уншихыг хэлнэ гэдэг. Зарим хүн үнэн худлыг

ажих хэрэгтэй гэнэ. Үнэн худал гэж байхгүйн адил, хүн намайг загнах нь загнаагүйтэй адил гэнэ. Энэ нь аялгуу ажиж байгаа бус, харин дотоод сэтгэлээ ажиж байгаа хэрэг. Нигүүлсэнгүй сэтгэлээ ажих нь Арьяабалын бясалгалын арга гэж зарим нь үзнэ. Жишээ нь, өөрийн эргэн тойрон ах дүү, хамаатан садан, таних танихгүй хүмүүс байна гэж төсөөлөн бодоод тэд бүгдэд эрхэм дээд хүсэл мөрөөдөл, нигүүлсэнгүй бодлыг илгээж, баяр баясгалантай, амар түвшин байхыг ерөөн, тэднийг сэтгэлдээ багтааж уучлан өршөөх нь Арьяабалын бясалгалын арга болно гэж үздэг.

Бид ном судрыг жинхэнэ ёсоор уншиж агуулгыг нь гүн гүнзгий ойлговол дээр дурдсан таамаглалууд зүй ёсонд нийцэхгүйг мэдэж болно. Энэхүү таамаглалууд нь эгэл хүний тархи оюунаараа ургуулан бодсон зүйл юм. Арьяабал бурханы нигүүлсэл хэмжээлшгүй. Учир нь Тэр бол Бодьсадва. Бид түүний дэсэд нь хүрээгүй бол Түүний нигүүлслийг яахан төсөөлж чадах вэ? Бидний эгэл хүний оюун ухаан хэмжээ хязгаартай. Гэвч Арьяабал бурхан хэмжээ хязгааргүй нигүүлсэлтэй. Түүний нигүүлсэнгүй сэтгэл нь үг хэлнээс хэтийдсэн тул хүмүүн төрөлтний оюун санаагаар төсөөлж чадахгүй. Хэрэв төсөөлж чаддаг бол бясалгал дадуулахын ч хэрэггүй, оюун ухаанаа ашиглаад Арьяабал болон хувирч болно.

Их нигүүлсэнгүй тарнийг түм бум давтаад мянган мутарт мянган мэлмийт болчихдог бол Формосад маш олон хүн хэдийнээ Арьяабал бурхан болчихсон байгаа. Тэд тарнийг маш хичээнгүйлэн уншдаг. Зарим нь түм бум ч хүргэнэ. Төвөдүүд ч биеэ зүдэртэл уншдаг. Ау Лак хүн ч адил. Гэвч нэг нь ч Арьяабал болсонгүй. Тэд их нигүүлсэнгүй тарнийг түм бумаар уншдаг ч сэтгэл санаа нь тайван бус, энэрэл нигүүлслээр дутмаг байдаг. Үнэн байдал ийм байгаа болохоор хэлэхээс аргагүй. Намайг өршөөгөөрэй.

Тэдний шунал хүсэл, уур хилэн, харанхуй мунхаг нь их хэвээр. Маани, тарниа унших тусам би үзэл нь ихэснэ. Тэд "Би" бясалгадаг, "Би" цагаан хоол иддэг, "Би" бурханд залбирч мөргөдөг, "Би" нигүүлсэнгүй сэтгэл үүсгэдэг, "Би" тэгдэг ингэдэг, би... гээд бүгд "Би" болж, "Би" нь улам томордог. Иймээс түүнд хэлж ярьж, зааж сургах хүн олдохгүй. Түүнд шинэ бясалгалын арга уламжлах хүн бас олдохгүй. Түүний толгой тархи "Би"-гээр дүүрсэн болохоор шинэ сэргэг юм орох өчүүхэн ч зайгүй болж, өөрийгөө бүгдийг мэдсэн бүгдийг ойлгосон гэж үзэх болжээ.

Жинхэнэ бясалгалын аргыг ойлгоогүй бол бидэнд бясалгал дадуулахад тун хэцүү, "Би үзэл"-д хялбархан баригдах болно.

Хараахан дадал бясалгал хийгээгүй хүн бага зэрэг даруу төлөв байдаг ч бясалгал дадуулаад харин ч нэлээд асуудалтай болдог. “Бурханы ном уншвал буянтай юу, сайн уу?” гэж зарим хүн Багшаас нь асуудаг. Бодьдарма “нэмэргүй” гэсэн. Харин Багш нь “нэмэртэй” гэлээ. (*Бүгд инээв*.) Багш нь та нартай сөргөлдөх санаагүй, найзалж нөхөрлөхийг боддог. Та нар ном сударт үнэхээр дуртай бол уншиж яагаад болохгүй гэж?

Жишээ нь, та нар исгэлэн, чихэрлэг юм идэх дуртай. Мэдээж бүгдийг идэж болно. Багш нь эсэргүүцэхгүй. Гэхдээ яагаад та нараар уншуулахгүй байна вэ? Дуртай бол унш. Унших нь бусдыг харааж, хүний сайн мууг ярьж явснаас л дээр. Бас жаахан буянтай. Гэвч ном сударуншсаны буян Багшид нь хангалтгүй. Тэр нь зөвхөн хүний буян, тэнгэрийн буян төдий. Уншсан судраа ойлгохгүй ч ашиг тустай гэвэл магнитофон ч бас Бурхан болж болно. (*Бүгд инээв*.) Магнитофон ч бас буянтай болж болно. Учир нь түүний унших нь биднийхээс илүү тод. Бид заримдаа уншиж байгаад унтчихдаг (*Бүгд инээв*.) Гэтэл магнитофон буруу зөрүү уншихгүй, бас унтдаггүй.

Олон хүн ном сударунших, Бурханд мөргөхийг л дадал бясалгал гэж боддогоос омог бардам болжээ. Утгыг ухаж ойлгон үнэнийг эрэхийн төлөө ном сударуншдаг хүмүүс жинхэнэ утгыг нь ойлгоогүй байсан ч омгорхуу зан гаргахгүй. Ном уншиж, сударцээжлэх нь буруугүй. Наад зах нь бидэнд лавлагаа болж, урьдын хүмүүсийн хэрхэн бясалгал хийж байсныг сануулан, аажимдаа тэдний нэгэн адил бясалгал дадуулах сэтгэлтэй болгож мэднэ. Гэтэл зарим хүн ном сударунших нь буянтай гэж сонсоод тэрхүү буянд шунан ихээр уншиж, унших тусмаа “миний” буян нэмэгдлээ гэж боддог. Харагдаж үзэгдэхгүй тул буян хишиг гэж юу болохыг ойлголгүй, их буян хураасан гэж бодно. Ингээд “би үзэл” нь улам ихсэж, илүү омог бардам болдог. Энэ нь тун аюултай.

“Баатараа явагч их хөлгөн сударт”-т бусад бясалгалын аргын тухай ярьсан байдаг. Бясалгалын арга бүр өөрийн давуу талтай бөгөөд нэгэн сэтгэлээр бясалгал дадуулахад маань тусалдаг. Өөрийн хийж буй бясалгалын аргадаа итгэвэл ямар нэгэн үр дүнд хүрэх нь гарцаагүй. Үр дүн гарахгүй биш, их бага ч гэсэн гарна. Өөрийн нэрээ уншсан ч үр дүн гарна. Хариад туршаарай. Чин сэтгэлээсээ анхаарлаа төвлөрүүлээд долоо хоног уншвал самадид бас орно. Гэвч “Анхаарлаа төвлөрүүлж” байж л үр дүн гарна. Гэртээ очоод туршаад үз. Авид бурханыг уншихаа түр зогсоон түүнийг долоо хоног амраж, өөрийнхөө нэрийг уншиж

үзээрэй. (*Бүгд инээв.*) Энэ ч бас буянтай.

Авид бурханы зүрхэн тарнийг унших нь өөрийн нэрээ уншихаас мэдээжилүү буянтай. Учир нь Авид бурханыг самгардиар Amitabha гэнэ. Энэхүү авиа нь орчлонгийн хэлбэлзэлтэй тун адил. Самгарди хэлний авиа нь орчлонгийн хэлбэлзэлтэй тун ойролцоо байдаг. Бид өөрийн дотоодын орчлонгийн хэлбэлзлийг сонсоогүй учраас Бурханы алдрыг "Нэгэн сэтгэл"-ээр залбиран уншвал Эсэрвaа тэнгэрийн хэлбэлзлийг сонсоно. Энэ нь бас бага сага тустай.

Эрт дээр үед Хятадад шар буурцаг тоолж, Авид бурханы зүрхэн тарни уншдаг уламжлал байсан гэж би сонссон. Унших бүрдээ нэг буурцаг хажуу тийш нь тавиад, дараа нь түүнийгээ хүнд өгч барилдлага үүсгэдэг. Миний сонссон үлгэрт нэг хөгшин өдөр бүр Авид бурханы тарни уншаад буурцгаа бусдад өгч, дахин худалдан авдаг байжээ. Сүүлдээ хөгшин буурцаг авах мөнгөгүй болсон тул байгаа буурцгаа эргүүлэн хэрэглэжээ. Буурцгаа дуусвал ахин эхэлж нэг уншихдаа нэг буурцаг тавина. Энэ мэтээр нэлээд удсаны дараа буурцгийг гараараа зөөх хэрэггүй болж, өөрсдөө бөмбөрдөг болов. Маани уншмагц буурцаг нөгөө тал руу өөрөө бөмбөрнө.

Та нар итгэж байна уу? Энэ үлгэрийг урьд нь сонссон уу? Яагаад ингэснийг мэдэх хүн байна уу? Та нар Авид бурханы тарнийг ийм удаан тоолсон атлаа яагаад мэдэхгүй байна вэ? Формосачууд ариун орон (диваажин)-ыг бясалгахгүй байна гэвэл гайхмаар хэрэг болно. Авид бурханыг бясалгахгүй бол өөр дадуулчихмаар бясалгалын арга байхгүй гэж тэд хэлдэг. Та нарын дотор өдөр бүр Авид бурханы тарни тоолдог хүн байна уу? (*Хөгшний номын чадлаас болсон гэж нэг нь хариулав.*) Гэвч олон хүн насаараа уншсан ч ийм чадал яагаад байхгүй байна вэ? (*Бурханы хариу гэж нэг хүн хариулав.*) Энэ юун хариу вэ? Яагаад бусад нь хариу өгдөггүй юм бэ? Хятад даяар ганцхан хүн чин сэтгэлээсээ тарни тоолсон гэвэл үнэмшилгүй сонсогдоно. Хятадын эх газар ийм өргөн уудам, тийм олон хүн маани, тарни уншдаг байтал яагаад ганцхан хүн номын чадалтай, бусдад нь байхгүй байна вэ?

Сүнслэг дадал бясалгал хийхгүй болохоор үүнийг мэдэхгүй байна. Харин сайтар бясалган дадуулвал билгийн мэлмий нээгдэн харж чадна Орчлон ертөнцөд бусад олон төрөлтөн байдаг. Том жижиг, дээд, доод түвшний, тэр ч байтугай нүдэнд үл үзэгдэх өчүүхэн жижиг төрөлтнүүд байдаг. Тэд нааш цааш гүйлдэж, зарим үед "Хоол чинь ялз боллоо." гэж чамд хэлдэг ч

чи сонсохгүй, харахгүй болохоор түүний оршин буйг мэддэггүй.

Тэрхүү жижиг төрөлтнүүд биднийг зүдрэн ажиллахыг хараад өөр хийх юмгүй тул өдөр бүр бидэнтэй тоглож, туслах санаатай байдаг. Зарим нь хайр хүрэм, зарим нь догшин хэрцгий. Зориуд хорон сэтгэл гаргаж, хүнийг хорлоод байгаа юм биш. Яг үнэндээ тэд буг чөтгөр биш, харин байгалиас хувирч гарсан "элемент" (Element) юм. Байгалиас хувирч үүссэн төрөлтнүүд гэвэл илүү ойлгомжтой. Ургамал мод, жимс ногоо гэх мэт төрөлтнийг (Element) бид мэднэ. Хаа сайгүй байгалиас хувиран үүссэн төрөлтнүүд дүүрэн байдаг. (хэвлийгээс төрөгсөд, өндөгнөөс төрөгсөд, хувилж төрөгсөд, чийгээс төрөгсөд гэсэн амьдралын хэлбэрүүд байдаг тухай Бурхан багш айлдсан.) Иймээс Бурханы шашин нь тун шинжлэх ухааны бөгөөд 2500 жилийн өмнө Шагжамуни Будда: "Бидний нэг насандаа ч олж үзээгүй өөр олон төрөлтнүүд байна." гэжээ. Бурхан багш билгийн мэлмийгээр их олон зүйлийг нэвт харж чаджээ.

Тэдгээр өчүүхэн жижиг, байгалиас хувилж бий болсон төрөлтнийг бид махан нүдээрээ олж харахгүй. Зарим нь нэлээд сайхан сэтгэлтэй, бидэнд тусалдаг. Зарим нь хэрцгий догшин бөгөөд үймээнч болохоор элдвийн хэрэг өдөөж, биднийг хооронд нь хэрэлдүүлдэг. Зарим амьтан сайхан сэтгэлтэй хүнд нэлээд дуртай. Тэдэнтэй тоглож юм уу тусална. Зарим нь хүмүүсийг хэрэлдүүлнэ. Энэ нь тэдний уг чанар тул гай гамшигт дуртай. Заримдаа бидний ярилцаж байгаа газар маш олон тиймэрхүү жижиг төрөлтөн байдаг учраас ирж, биднийг тойрч бүчдэг болохоор тэр хавь гэрэлтэж байгааг харж болно. Сүнслэг дадал бясалгал хийдэггүй хүмүүс үүнийг Бурхан, Бодьсадва ирж гэрэлтүүлэн тусалж байна гэж боддог. Үнэндээ бидний харсан гэрэл бүхэн сайн биш. Энэ нь эерэг гэрэл биш, хар хүчинд харьяалагдах сөрөг гэрэл болно. Тэрхүү жижиг төрөлтнүүд ч гэрэлтэй бөгөөд бидний билгийн мэлмий нээгдээгүй бол ялгаж салгаж чадахгүй.

Библид: "Эзэн Бурхан хоёр зүйлийн гэрэл бүтээсэн. Нэг нь гэгээн өдрийн гэрэл, нөгөө нь хар бараан гэрэл." гэжээ. Хар бараанд бас гэрэл байх уу? Үүгээр муу хүчийг хэлжээ. Ойлгов уу? Тийм төрөлтнүүд тэр газраар дүүрэн байх тул хүж асааж, хүслээ даатгахад хүрч ирээд бидэнтэй наадаж, хүжийн галыг хөгжөөхөд нь бурхан санаа сэтгэлийг маань мэдчихлээ гэж бид боддог. Үнэндээ энэ нь ямар ч чухал юм биш, тэд л үймүүлэн тоглож байгаа төдий юм. Иймэрхүү явдал олон байдаг.

Жишээ нь, бид ямар ч саадгүй сайхан давхиж яваад гэнэт

осолд ордог. Энэ нь тэдгээр жижиг төрөлтнөөс болдог бөгөөд уг газарт аюул осол нэг л гарсан бол хожим нь байнга ийм явдал тохиолдоод байдаг. Тиймээс тэр газрыг “гүйдэлтэй” гэдэг. Хүн бүхэн түүгээр өнгөрөхдөө заавал мөргөх хэрэгтэй, тэгэхгүй бол автомашины осол гарна гэлцдэг. Учир нь нэг, хоёр удаа осол гарсан болохоор тэдгээр төрөлтнүүд тэнд цугларах дуртай. Ойлгож байна уу? Тэд сэтгэл донсолгосон, эмгэнэн гашуудсан, эмх замбараагүй байдалд дуртай. Тэнд цугларч амьдраад дасчихдаг учраас машинтай хүн ирэхийг хармагцаа эвдэн сүйтгэх ажиллагаа явуулна. Ингэхэд машинд асуудал гарч эвдрэх, эсвэл гэнэтийн осолд орох зэргийг хараад тэд баярлан инээлддэг.

Зарим хүн их бухимдуу тул сэтгэл нь амархан хөдлөх юм уу дорхноо уурладаг. Багш нь өчигдөр соронзон талбайн тухай та нарт ярьсан. Сайн, муу соронзон талбайн аль алиныг бид өөрсдөө бүтээдэг нь сайн болон муу элемент (Element)-ийг татсанаас болно. Эсвэл бусад онцгой нөхцөл байдлаас болсон ч байж мэднэ. Бясалгал дадуулдаг хүнд ийм гай гамшиг цөөн тохиолдох бөгөөд өвчлөх нь бага. Арьяабалын аргаар бясалгал дадуулдаг хүн хамгийн аюулгүй. Багш нь өөр дээрээ мэдэрснээ хэлж байна. Учир нь Арьяабалын бясалгалын аргаар дадуулан бясалгавал хамгийн дээд хүчтэй хамт байдаг. Аялгуу гэж юу болохыг Багш нь өчигдөр ярьсан. Энэ аялгуу нь ертөнцийг бүтээгч хүч юм. “Баатараа явагч их хөлгөн судар”-т “Аялгууны урсгал”-ын талаар ярьсан. Библид энэхүү аялгууг бас дурдаж, “the word” гэж нэрлэжээ. Бурхан Бодьсадва энэхүү аялгууны урсгалыг түшиглэн бууж хамаг амьтдыг гэтэлгэн, энэхүү аялгууны урсгалыг түшиглэн буцдаг. Энэ бол “Аялгууны урсгал”, “Дао”, Луузын хэлсэн “Нэрлэж үл болохуйц нэр.” болно.

Бид энэхүү “Нэрлэж үл болохуйц нэр”-тэй, энэхүү “Аялгууны урсгал”-тай холбогдоогүй үед ихэд өнчирч ганцаардаг. Учир нь бидэнд туслах хүчгүй, зөвхөн ганцаархнаа байгаагаас болсон хэрэг. Энэхүү аялгууны урсгалд орвол нэгэн том бүлгэмд элссэнтэй адил. Том бүлгэм угаасаа их хүчтэй, харин ганц хүний хүч өчүүхэн. Энэхүү том бөгөөд эрх чөлөөт бүлгэмтэй, их хүчтэй хамт байвал муу зүйлс ойртохгүй. Энэ ертөнцөд сайн муу, хар цагаан бүгд байдаг. Бид сайн хүчтэй хамт байвал муу хүчнээс чөлөөлөгдөнө. Учир нь бид тэднээс хэдийнээ салж, бүрмөсөн холдсон. Үүрд орхисныг тэд ч бас мэддэг.

Тиймээс Арьяабалын аргаар бясалгал дадуулагч хүн нас нөгчихөд ад чөтгөр, эрлэг номун хаан ч ойртож зүрхлэхгүй.

Учир нь энэ аргаар бясалгал хийсэн хүний “Соронзон талбай” илт хувиран өөрчлөгдөж, урьдынхтайгаа адилгүй болж, зөвхөн сайныг л татаж саарыг үл шингээнэ. Учир нь энэхүү “Аялгууны урсгал” нь бидний соронзон талбайн муудсан хэсгийг цэвэрлэж сайныг нь үлдээдэг. Урьд нь бидний соронзон талбай цоороод зарим хэсэг нь сайн, зарим хэсэг нь муу болсон байжээ. Тэгээд сайн нь сайныг, муу нь мууг татаж байсан аж. Харин одоо орчлон ертөнцийн “Аялгууны урсгал”, энэхүү Бүтээгчийн хүч, угийн язгуур хүч соронзон талбайг маань сэлбэн засаж, муу бүхнийг цэвэрлэнэ. Яг мэс засал хийж, муу эдийг нь огтлоод дахин оёхтой адил. Ингэвэл удалгүй эдгэж, өвчингүй болоод бие эрүүлжинэ.

Арьяабалын аргаар бясалгал дадуулах нь үүнтэй адил. Бид энэ их хүчээр доройтсон хүчээ сэлбэсэн болохоор бүх юм ариусаж, айх аюулгүй болсон. Бид энэхүү бясалгалын аргаар жинхэнэ ёсоор хичээнгүйлэн дадал бясалгал хийхгүй, анхаарал болгоомжтой байж, Их Багшийн зааврыг сонсохгүй бол цэвэрлэгдэж чадахгүй. Гэвч энэ нь ховор тохиолдоно. Энэ хүчтэй нэг л холбогдвол үүрд холбогдоно. Харин бид энэ хүчийг бага ашиглавал бага хүчтэй байх нь ярангүй.

Жишээ нь, бидний эцэг нас барахдаа бидэнд арвин хөрөнгө зоорь үлдээжээ. Гэвч залхуураад банкнаас мөнгөө авахгүй, эсвэл хадгалсан газраас хөрөнгөө гаргаж ашиглахгүй бол мэдээж мөнгөгүй байна. Гэвч бидний баян чинээлгийг хүн бүр мэддэг тул ядуу гэж хэн ч хэлэхгүй. Эд хөрөнгөтэй л гэж мэднэ. Хэрэглэх эсэх нь биднээс шалтгаална. Бид ахиухныг гаргаж хэрэглэвэл амьдрал маань илүү тавлаг болох нь ярангүй. Мөнгөтэй бол элдэв зүйл худалдан авч, тансаг идээ будаа зооглож болно. Залхуу хойргоосоо болж мөнгөө хэрэглэхгүй, эсвэл хэрэглэж зориглохгүй бол мэдээж эд юмаар хомс, бараг л урьдынх шигээ ядуугаараа байна. Гэвч биднийг мөнгөтэй гэдгийг хүмүүс гадарлана. Садан төрөл, найз нөхөд, хөршүүд биднийг эцгээсээ их хэмжээний хөрөнгө өвлөснийг мэднэ.

Авшиг хүртээд Арьяабалын аргаар бясалгал дадуулж байгаа хүн Их Багшаар ном уламжлуулж, энэхүү их хүчтэй холбогдсоноор орчлонгийн хамгийн том бүлгэмд нэгдэн ордог. Гэвч аажмаар өсөн торних хэрэгтэй. Авшиг хүртсэнээр л “жинхэнэ хүн”-д байх чанараа хөгжүүлж эхэлдэг. Өмнө нь хүний хагас төдий байсан бол одоо жинхэнээсээ бүрэн бүтэн хүн болсон гэж болно. Гэвч дадал бясалгалаа шаргуу хийхгүй бол түүний тогтсон хувь заяа, амьдрал, хувийн чанар төдий л их өөрчлөгдөхгүй нь мэдээж. Бусад хүмүүс ч хараад мэдрэхгүй.

Бясалгалыг хичээнгүйлэн хийдэг хүн богино хугацаанд, ганц хоёр өдөр, эсвэл долоо хоногийн дотор бидний дадал бясалгалын ач тус болоод аялгуу ажихуйн хүчийг даруй мэддэг. Хувь хүний амьдралд болоод хувийн чанарт гарсан хувиралт, билиг ухааны хөгжил нь урьдынхтай огт адилгүй болсныг мэдэрдэг. Үүнийг зарлан сурталчлахгүй ч мэдэж болно. Учир нь тэд амаа барьж дийлэлгүй ярьчихдаг нь аяган дахь ус дүүрээд бялхан асгарах мэт. Арьяабалын бясалгалын арга бол хорвоод хосгүй сүнслэг дадал бясалгалын арга мөн.

Та нар улсынхаа төв аялгыг ойлгодог байх хэрэгтэй. Формоса хэмээх бяцхан амтат төмс шиг оронд л гэхэд хоёр гурван аялгаар ярьдаг. Хэл яриа адилгүй болохоор дэлхий тасралтгүй дайтаж байна. Хэрэв бүгд “Арьяабал”-ын хэлийг ашиглавал хамгийн сайн. Хамаг амьтан бүгд ойлгодог нэг л аялгуу бий. Хамаг амьтан өөр өөрийн дэсээр ойлгодог нэгэн аялгуу буюу хэл яриа байдаг гэж Будда хэлсэн нь ийм учиртай. Энэхүү аялгуу буюу яруу сайхан хөгжим, дотоодын хөгжим нь алсын дуудлагын станцтай нэг л холбогдвол Европ, Африк, Америк тивүүд, Гаошюн, Тайнань хот гээд хаашаа ч ярьж болдог телефон утасны системтэй адил ямар ч асуудал гарахгүй.

Утас залгагдмагц бид яръя, холбогдъё гэсэнтэйгээ холбогдож ганцаардахаа болино. Нөгөө тал ч бидний хаана байгааг тэр дороо мэднэ. Ямар нэгэн хэрэг явдал гарлаа гэхэд ганц л залгахад хоёр минутын дотор бүгдээрээ мэдчихээд цагдаа нар, айл саахалтынхан, найз нөхөд ирж туслах болно. Тийм үү? Утасгүй бол бид хэн нэгэнтэй ярьж туслуулъя ч гэсэн амаргүй. Зарим нь гэртээ нас нөгчөөд нэлээд хэд хоносон ч мэдсэн хүн байдаггүй. Зарим хүн өвчтэй ч мэддэг хүнгүй. Одоо бүгдээрээ телефон утастай болсон болохоор тун амар болжээ. Өвчин хүндрээд явж чадахгүй байсан ч утсаар дуулгачихвал эмч ирээд биднийг үзэж өгнө. Эсвэл түргэн тусламжийн машин ирж биднийг эмнэлэгт хүргэнэ. Тэр ч байтугай такси гэрээс чинь аваад явчихна. Тун амар болжээ.

Арьяабалын систем ч үүнтэй адил. Энэхүү аялгуу буюу дотоодын хөгжим нь бүхэл бүтэн систем, эсвэл цахилгаан дамжуулагч утас шиг хамаг амьтныг холбон нэгтгэдэг. Тиймээс бид энэхүү системд нэгдвэл дахин өнчирч ганцаардахгүй. Учир нь бид хамаг амьтантай холбогдсон учраас бясалгалыг хэдий чинээ их дадуулах тусмаа энэхүү системийг илүү өргөн хэрэглэж, хамаг амьтныг улам ихээр таньж мэднэ. Жишээ нь, бид утсаа их ашиглаж байгаа нь найз нөхөд ихтэй болж, олон хүнтэй

холбогдож буйг илтгэнэ. Олон хүн биднийг ойлгож, хаана байгааг маань мэдэж буйг илтгэнэ. Хамаг амьтан бүгд ийм дотоодын аялгуутай учраас бид энэхүү аялгууны урсгалд ормогц хамаг амьтныг ойлгоно. Бяцхан шувуухай, шоргоолж, тэр ч байтугай маш нарийн түвшний төрөлтнүүдийг ч ойлгож чадна.

Хэрвээ Америкт байгаа хэн нэгэн биднийг яривал бид мэдчихнэ. Бас Францад байгаа хүн биднийг дурсвал даруй мэдээд хувилгаан биеэрээ очиж уулзана. Хэрэв түүний дадал бясалгал сайн бол хувилгаан биеэрээ ирж бидэнтэй уулзаж болно. Энэ нь одоогийн телевизийн ажиллагааны зарчим, эсвэл хамгийн шинэ үеийн дүрст утастай адилхан. Чи утсаар ярихдаа ярилцагч хүнээ харж болно.

Гэвч тэрхүү аялгууны систем эсвэл арьяабалын систем нь телефон утаснаас ч нарийн ажиллагаатай төдийгүй тун их ач тустай. Дамжуулагч утас хэрэглэхгүй, мөнгө төгрөг зарахгүй. Хэнтэй холбогдож буйг хэн ч гадарлахгүй, хэнтэй уулзах гэж байгааг хэн ч харахгүй. Хаашаа ч явсан онгоцны тасалбар хэрэггүй. Өөр юу ч шаардагдахгүй. Нэг ч алхам явахгүй, нэг ч үг дуугарахгүй, юу ч бодохгүй. Энэ систем нь хамгийн их автоматчилагдсан, хамгийн хялбар, хамгийн хурдан болохоор Арьяабалын аргаар бясалгал дадуулснаар дээшээ Бурхан бодьсадватай, доошоо гурван муу заяатай холбогдоно. Иймээс “Дээшээ дөрвөн энэрлийг хариулж, доошоо гурван муу заяаг аварна.” гэдэг. Тэр үед л жинхэнээсээ ингэж хэлж болно. Арьяабалын бясалгалын аргаар бясалгал дадуулаагүй бол ингэж чадахгүй. Учир нь ертөнцийг бүтээгч хүчтэй холбогдоогүй байж хамаг амьтдыг гэтэлгэнэ гэж хэлж болохгүй. Өөрийн биеэ гэтэлгэж чадахгүй, маргааш хаана очихоо, хэдийд ангижрахаа мэдэхгүй байж хамаг амьтдыг гэтэлгэнэ гэж яриад ч хэрэггүй.

Та нарын ихэнх нь, ядахдаа ерэн есөн хувь нь төв аялгаар ярихыг ойлгодог байхаа гэж би боддог. Ойлгохгүй байсан ч хамаагүй та нарын билиг ухаан ойлгоно. Та нарын уг чанар, Бурхан чанар чинь ойлгоно. Үнэндээ та нар нүд рүү харахад л хангалттай. Хосууд бие биеэ хайрлахдаа нүд нүдээ ширтэлцээд л болчихдог. Тэд ингэж холбогдож болж байхад Багш нь яагаад та нартай ингэж холбогдож болохгүй гэж? Маргааш ирж Багшийнхаа нүд рүү хараарай. Хоёр цаг харчихаад буцаарай.

Бясалгалын түвшин өндөр хүн Багштайгаа уулзаад яримаар зүйлгүй ч Багшийгаа харах дуртай. Харахгүй бол ихэд санагалзаж, юмаа гээсэн шиг санагдаад зорин ирж Багштайгаа уулздаг. Хоёр биеэ хэсэг ширтээд шавь маань явж би бясалгана. Энэ бол бидний

багш шавийн харилцаа юм.

Тиймээс бидний бясалгалын аргыг “Чимээгүй” бясалгалын арга гэж болно. Юу ч ярихгүй. Багш нь ном уламжлах үед ч ярихгүй. Долоо хоногийн даяаны үеэр бүр ч ярьж болохгүй. Багштайгаа уулзсан ч ярих юмгүй, тэгэхээр чимээгүй бясалгалын арга мөн биз дээ? мэдээж, “Аялгуу ажих” ёстой гэж та нар сонссон. Гэтэл тун нам жим байдаг болохоор аялгуу ажиж буйг хэн ч анзаардаггүй. Айл саахалтынхан, гэр орныхон ч мэддэггүй. Энэхүү аялгуу, энэхүү дэсийг хэн ч аваад явахгүй, хэн ч мэдэхгүй, хэн ч ойлгохгүй. Хэн ч биднийг сэтгэлийн энэ төлөвөөс хүчээр гаргахгүй.

Жишээлбэл, бид Бурханы шашинтан. Гуан Чин хуврагаас сахил хүртэж, номын нэр аваад өдөр бүр түүний хөрөгт, эсвэл Бурханд мөргөн маани, тарни уншдаг. Үүнийг харсан Католик шашинтан тавгүйцэж, бидний итгэл бишрэлийг шүүмжилж магад. Учир нь мөргөл залбирал бол өнгөн талын зүйл учраас хүмүүс хараад л бясалгал хийж байгааг мэдчихнэ. Харин Арьяабалын аргаар бясалгал хийхэд хэн ч мэдэхгүй. Автобусанд, цэцэрлэгт хүрээлэнд, ариун цэврийн өрөөнд, хаана ч, хэзээ ч бясалгаж болно.

Хэсэг бясалгасны дараа бид зүгээр байсан ч тэрхүү дотоодын аялгуутайгаа үргэлж хамт байж, тэр биднийг хэзээ ч орхихгүй болдог. Тэр аялгуу бол бидний хамгийн үнэнч, хамгийн ачтай, хамгийн өгөөмөр найз бөгөөд хэрэгтэй бүхнийг хүссэн цагт өгнө. Ямар ч бэрхшээл тулгарсан даруй тусалж дэмжинэ. Тэрээр бидний өмнөөс ямар ч ажлыг хийнэ. Бид юуг ч онцгойлох хэрэггүй, юуг ч хүсэх шаардлагагүй, тэгсэн ч аяндаа Бурхан болж чадна. Иймээс явавч даяан, идэвч даяан, унтавч даяан гэдэг. Амьдралд даяангүй юм үгүй гэдэг нь ийм утгатай. Гэхдээ ийм түвшинд хүрээгүй байж “Даяан” ийм тийм байх ёстой гэж хэт их маргалдсаны хэрэггүй. Бясалгасаар “Амьдрал нь даяан” болсон хүнд хүмүүсийн ингэж маргалдах нь тун инээдэмтэй санагддаг ч яриад нэмэргүйг мэдэх тул тэр үед юу ч ярихыг хүсдэггүй. Учир нь даяаны тухай ойлгож мэдэх билиг ухаантай хүн маш цөөн. Уужуу тайвуу, өөдрөг сэтгэлгүй бол хамгийн дээд, тэгсэн атлаа хамгийн хялбар, аяндаа бүтэх бясалгалын аргыг хүлээн авч чадахгүй.

Багш нь Арьяабалын бясалгалын аргыг нэмж танилцуулъя. Мэдээж, энэ нь ном уламжилж буй хэрэг. Ном уламжлахад үг ярихгүй. Арьяабалын номд оръё гэвэл Багшийнхаа үг ярихгүй байх үеийг хүлээж байж л орж чадна. Багшийнхаа их ярихыг сонсоод Арьяабалын бясалгалын аргыг сурчихлаа гэж бүү

бодоорой. Уг бясалгалын арга нь гурван хэсэгтэй бөгөөд нийлээд Арьяабалын бясалгалын арга болдог.

Нэгд, бид билиг ухаанаа ашиглана. Энэ ертөнцөд хүний ууриг тархи, оюун ухаан заавал ямар нэг зүйлийг "бодож" байдаг. Жишээ нь, чи нөхрөө "бодож" байхад, нөгөө хүн эхнэрээ "бодож" байдаг. Энэ хүн хичээл сурлагаа "бодож" байхад, тэр хүн ажлаа "бодож" байдаг. Зарим хүн бусдын сайн мууг, зарим нь уйтгар бухимдлыг, зарим нь хорон санаа, эсвэл нэр ашгийг "бодож" байдаг. Гагцхүү Авид бурханыг "бодвол" уйтгар бухимдал багасна. Авид бурхан цаглашгүй гэрлийг төлөөлдгийг бид мэднэ. Тэр бол хүн бус цаглашгүй гэрэл тул Авид бурханыг дуугаар сонсож дүрсээр үзэж байгаа бол хамгийн дээдэд нь бус харин дуу, өнгөний түвшинд оршсоор байна гэсэн үг.

Цаглашгүй гэрэл ямар утгатай вэ? Тэр нь бидэнд угаас буй дотоодын гэгээн чанарыг төлөөлдөг. Бидэнд маш олон чанар бий. Жишээ нь, шунал тачаал, уур хилэн, тэнэг мунхаг, уйтгар бухимдал, ухаарал гэгээрэл, харанхуй мунхаг, энэрэл нигүүлсэл, хорон санаа гэх мэт. Бид Авид бурханы тарни "уншиж" далд ухамсар дахь гэгээн чанар, чадвараа, Арьяабал бурханы тарни "уншиж" угийн энэрэн нигүүлсэх чанараа, Очироорваань бурханы тарни "уншиж" энэхүү хүч дотоодод маань оршин буйг өөртөө сануулан, энэхүү эрхэм чанаруудаа хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа хэрэг юм. Язгуурын гурван бурханы тарнийг "унших"-ын утга учир үүнд оршино.

Авид бурхан, Арьяабал бурхан, Очироорваань бурхан бол язгуурын гурван бурхан болно. Бид Авид бурхантай адил билиг нээгдсэн, гэрэл гэгээтэй байх ёстой. Очироорваань бурхантай адил билиг ухаантай, хүч чадалтай байх ёстой. Арьяабал бурхантай адил энэрэн нигүүлсэх сэтгэлтэй байх ёстой. Тиймээс язгуурын гурван бурхан нь бидний хамгийн сайн талыг төлөөлж байдаг. Тэдэнд залбирах нь бид өөрийн сайн талдаа залбирч буй хэрэг ч тийм их тустай биш. Учир нь бид жинхэнэ Авид бурхан гэж хэн болохыг мэдэхгүй учраас "залбирч" чадахгүй. Залбирсан ч холбогдож чадахгүй.

Жишээ: их сайхан хүүхэн гэлцдэг ч огт хараагүй, сонссон төдий болохоор түүнийг дурсан санаж чадахгүй. Зөвхөн өөрийн эхнэрээ л дурсаж, санаж чадна. Учир нь Си шинийг танихгүй болохоор царай зүс нь ямар болохыг мэдэхгүй. Мэдээж Си ши танай эхнэрээс царайлаг байж мэдэх ч аль хэдийн хорвоог орхисон учраас та түүнийг танихгүй. Ядаж үс толгойг нь ч төсөөлж чадахгүй болохоор яаж түүнийг дурсан санах вэ? Тийм үү?

Үүнтэй адил Авид бурхан, Арьяабал бурханы маани, тарнийг уншаад тийм ч их нэмэргүй. Учир нь жинхэнэ Авид бурхантай холбогдоогүй. Цаглашгүй гэрлийг хараагүй, энэхүү гэрэлтэй холбогдоогүй. Ертөнцийг бүтээгч их хүч буюу Багшийнх нь саяны хэлсэн тэрхүү "Нэрлэж үл болохуйц нэр"-тэй холбогдоогүй.

Арьяабал бурханыг дуудан залбирсан ч Түүний энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэлтэй холбогдоогүй тул тийм ч тустай биш. Зөвхөн сэтгэл илүү төвлөрч, уйтгар бухимдал арай багасах төдий. Тэгээд ч амаараа "дурсах" болохоос бодлоороо "дурсаагүй".

Та нар эхнэрээ дурсахдаа: "Тэр өчигдөр надтай хэрэлдсэн. Тун ч айхавтар хүн дээ. Салчихдаг ч юм билүү." гэж боддог. (*Бүгд инээв.*) Бид түүний тухай бодвол бухимдах сэтгэл аяндаа үүснэ. Авид бурханы тарнийг сэтгэлээ төвлөрүүлэн уншиж, Түүнийг нэгэн сэтгэлээр дурсвал яршигтай эхнэр, төвөгтэй нөхрөө мартаж, уйтгар бухимдал аяндаа багасна. Сэтгэлээ төвлөрүүлэн Бурханд залбирах нь зөвхөн ийм л тустай. Өөр ямар ч нэмэргүй. Нэгмөсөн туулан гэтлэхгүй, төгс баясгалант оронд очиж чадахгүй. Америкт очиход ч онгоцны тасалбар хэрэгтэй байхад, амаараа уншаад яаж төгс баясгалант оронд очих вэ? Ингэх нь утга учиргүй. Тийшээ очих тийм ч хялбар биш.

Маани, тарни унших нь огт буянгүй биш. Уйтгар бухимдал багасан, сэтгэл санаа сэргэж тайвширдаг нь маани, тарни уншсаны буян. Гэвч яагаад буянтай болдгийг билиг ухаанаараа ажих хэрэгтэй. Сохроор итгэж болохгүй. Авид бурханы тарнийг бусад хүн уншихыг хараад дагаж уншина. Энэ үед хүн чамаас юм асуувал ихэд дургүйцэж: "Чухам юу асуух гэсэн юм бэ?" гэж магадгүй. (*Бүгд инээв.*) Хэрэв хүүхдүүд ирээд үймүүлж шуугивал: "Битгий олон юм асууж шалгаагаад бай!" гээд тэднийг эрихээрээ шавхуурдаж ч магадгүй. Тэд "Бурханыг дурсах" нь иймэрхүү л янзтай.

Авид бурхан бол цаглашгүй гэрэл бөгөөд бидний гэгээн саруул чанарыг төлөөлдөг. Арьяабал бурхан бидний энэрэн нигүүлсэх сэтгэлийг, Очироорваань бурхан бидний хүч чадлыг төлөөлдөг боловч энэ гурваас гадна бидэнд өөр олон чанар бий. Гэвч бид эдгээр чанараа хөгжүүлэх боломжгүй. Тиймээс хүмүүс олон сайн сайхан чанартай болохын төлөө наян найман, Бурхан, түмэн Бурхан, зарим нь гурван түмэн Бурханд залбирдаг. Арван зүг гурван цагийн Бурхад тун олон. Яагаад тийм олон байдаг вэ? Учир нь Будда болгон Бурхан болсныхоо дараа энэхүү чөлөөт хүрээлэлд ороод бүрэн эрх чөлөөтэй болдог. Гэтэл орчлон үүдэн

бүтээгдсэнээс хойш маш олон хүн бясалгаж, Бурханы зэрэгт хүрсэн тул улам олон Бурхантай болжээ. Хожим Багш нь бас Бурхан болж тун магадгүй. Та нар "Намо Чин Хай Бурхан" (*Бүгд инээв*.) гэж залбирах болно. Ингээд бас нэг Бурхан нэмэгдэнэ.

Тийм олон Бурхадад залбирч байхад яагаад ийм их уйтгар бухимдал байна вэ? Яагаад билиг нээгдээгүй вэ? Яагаад Бурхан болж чаддаггүй вэ? Та нар яагаад гэдгийг мэдэх үү? Сүү, сүү гэж уншвал сүүтэй болж чадах уу? Сүү ууя гэвэл сүү зардаг газарт очих хэрэгтэй. Ам нээлгүй гараараа заахад мөнгөтэй л бол тэд чамд сүү өгөх болно. Эс бөгөөс сүү гэж гэртээ түмэнтээ уншаад ямар ч нэмэргүй. (*Бүгд инээв*.) Сүү танайд өөрөө гүйгээд ирэхгүй. Мөнгө хэрэгтэй болсон цагт гэртээ суугаад мөнгө гэж уншсан ч мөнгөтэй болохгүй. Чи банканд очиж тусгайлан ямар нэг юм хэлэлгүй, чекээ үзүүлэхэд л тэд чиний санааг ойлгоно. Мөнгөө хадгалуулаад танил болсон учраас мөнгийг чинь даруй гаргаж өгнө.

Сүнслэг дадал бясалгалын түвшин өндөр хүн "Бурханд залбирах хэрэггүй." гэдэг. Учир нь тэр нэгэнт Бурхан болж, Бурхантай нөхөрлөжээ. Ийм үед юу ч ярих шаардлагагүй, нүд рүү нь харахад хангалттай. Жишээ нь, хэн нэгэнтэй танилцахаас өмнө заавал утсаар ярих, захиа бичих, эсвэл очиж уулзах хэрэгтэй. Гэвч хоёр, гурван удаа уулзаж, танил болсон бол дараа нь түүний нүд рүү харахад л болно. Юу ч ярих хэрэггүй. Үүний адил Бурханд жинхэнээсээ сайн залбиръя гэвэл Түүнтэй танилцах хэрэгтэй. Ингэж байж л дурсан санана. Одоо бид Бурханд ийм ихээр залбирдаг ч Түүнийг танихгүй тул ямар ч нэмэргүй. Энэ нь банк руу явж мөнгөө авахгүй, харин гэртээ суучихаад мөнгө мөнгө гэж буйтай адил. Бид олон Бурханд залбирдаг ч бүгд өнчин Бурхан байжээ. Бид хэсэгхэн жижиг Бурханд залбираад харин томд нь залбирсангүй. Багшийнх нь хэлж байгаа санаа бол энэ Бурхан нь тэр Бурханаас том гэсэн үг биш, харин тэдний ажил төрөл нь адилгүй гэсэн үг юм. Ойлгож байна уу?

Шагжамуни Будда Авид бурханыг магтан сайшааж: "Авид бурханы алдар нэрийг дурсан залбирч бай!" гэжээ. Гэвч Түүний алдар нэр нь нэрлэж болшгүй тул та нар мэдэхгүй. Иймээс зөв "дурсаж" чадахгүй. Та нар Авид бурханыг амаараа дурсдаг гэж боддог. Энэ нь одоо миний жигнэмэг сурталчилж буйтай адил. Багшийнх нь яриа бол яг тэр жигнэмэг биш. Жинхэнэ жигнэмэг нь өөр зүйл байгаа. Авид бурхан бидний гэрэл гэгээтэй талыг төлөөлдөг тул Түүнд залбирдаг. Арьяабал бурхан нь бидний

энэрэн нигүүлсэх сэтгэлийг төлөөлдөг тул Түүнд залбирдаг гэх мэт. Гэвч өөр олон чанар байгаа ч залбиралгүй орхигдуулжээ.

Жишээ нь, эртний цэргүүд жад, бамбайгаар өөрийгөө хамгаалахаас гадна бас хуяг дуулга өмсдөг. Хамаг биеэ хуяг дуулгаар бүрж, хоёр нүдээ ил гаргана. Түүнийг хөнөөе гэвэл урьдаар хуяг дуулгаар хамгаалаагүй газрыг олж, түүгээр нь жадлах хэрэгтэй. Эсвэл арга сийлж, дуулгыг нь унагааж, толгойг нь ил гаргавал хөнөөж дөнгөнө. Үүний адил бид Авид бурхан, Арьяабал бурханыг амаараа дурсах нь учир дутагдалтай. Энэхүү хуяг дуулга найдваргүй. Хэсэгхэн газрыг л хамгаална. Өөр ил гарсан хэсэг олон байна.

Учир нь Авид бурхан бол зөвхөн төгс баясгалант орны сургаалын эзэн төдий. Дорно зүгт бас Оточ Манал бурхан байна. Өмнөд, умардын, дээд, доод ертөнцийн гэх мэт олон Бурхан байдаг. Зөвхөн дорнод, өрнөд, өмнөд, умард төдийгүй бас арван зүг гурван цагийн Бурхад байдаг. Тэр олон Бурханд хэзээ залбирч дуусах вэ? Ертөнц болгонд хамгийн дээд сургаалын эзэн бий. Бид энэхүү сургаалын эзнийг танихгүй бол яаж ч мэрийсэн өчүүхэн жаахан хэсэгт нь л залбирдаг. Бурханд залбирах нь ач тустай, буян хишигтэй ч Тэдний ажил нь өөр.

Жишээ нь, бид хааны ордонд очъё гэвэл хаана байдгийг нь мэдэх хэрэгтэй. Хэрэв хаантай шууд уулзалгүй өөр газраар орж бусад түшмэдтэй уулзвал төөрч будилах бөгөөд энэ нь бидний жинхэнэ чухал зорилго биш. Авид бурханд залбирах нь тустай ч Тэрээр зөвхөн төгс баясгалант орны сургаалын эзэн болохоос бүх ертөнцийн сургаалын эзэн биш. Ертөнц бүхэнд дорнод, өрнөд, өмнөд, умард гэх мэтийн маш олон газар бий. Арван зүг гурван цагийн Бурхад бий. Гэвч ертөнц бүрд нэгэн хамгийн дээд сургаалын эзэн бий. Бид хэрэв энэхүү хамгийн дээд сургаалын эзнийг таньж мэдээд, Түүнийг дуудан залбирвал нэлээд хүчтэй болно. Гэвч ийм сургаалын эзэн байгааг мэдэвч танилцуулах хүнгүй бол бас л нэмэргүй.

Иймээс жинхэнэ Их Багшийг эрж олох нь хамгаас чухал. Учир нь Их Багш хамгийн дээд сургаалын эзний найз тул чамайг дагуулж аваачаад: “Энэ бол миний шавь, энэ бол миний найз.” гэж танилцуулбал тустай болно. Тухайлбал, Америкийн Ерөнхийлөгч Рейганыг бид бүгдээрээ мэднэ. Бид түүний нэрийг мэднэ, бас түүнийг Америкийн хамгийн дээд төлөөлөл гэдгийг мэднэ. Гэвч Багшийнх нь хувьд энэ нь ямар ч тус нэмэргүй. Учир нь Багшийг нь Цагаан ордонд дагуулан аваачаад: “Энэ эрхэм бол Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай. Тун сайн хүн. Түүнийг

номоо дэлгэрүүлэхэд нь тусалж дэмжээрэй.” гэж танилцуулаад: “Энэ бол манай ерөнхийлөгч. Миний хамгийн сайн найз. Хэрвээ ямар нэгэн бэрхшээл гарвал түүнтэй уулзаарай. Тэр чамд тусалж асуудлыг чинь шийдэж өгнө.” гэж Багшид нь хэлж өгсөн хүнгүй.

Иймээс Авид бурханы нэрийг мэдэх нь төдий л нэмэргүй. Харин Авид бурханыг таньдаг байх нь тустай. Учир нь энэхүү нэр Түүнийг төлөөлөхгүй, Түүнд хамаагүй. Ямар ч нэртэй байж, хэн ч нэр өгч болно. Америкт Рейгантай ижил нэртэй хүн байдаг ч бидэнд тус болохгүй. Тиймээс ямар ч Бурханыг дуудан залбирахад, тэрхүү Бурхантай хэдийнээ танилцсан найз чинь чамайг танилцуулах хэрэгтэй. Танилцсаны дараа тэрхүү Бурхан чамайг хамгаална. Үгүй бол ямар ч хэрэггүй. Утгыг нь ойлгож байна уу?

Рейганы нэрийг би бас мэднэ. Гэвч миний визний хугацаа дуусвал би Америкаас заавал гарах хэрэгтэй. Түүний нэр надад туслахгүй. Би гэртээ ерөнхийлөгчийн алдар нэрийг байнга уншсан ч тэр надад туслахгүй. Учир нь би түүнийг танихгүй, тэр намайг танихгүй. Тэр намайг хэн бэ гэдгийг мэдэхгүй, түүнээс тусламж хүсэх эрх надад байхгүй. Хэрэв хэн нэгэн урьдчилан захидал бичиж намайг ерөнхийлөгчид танилцуулаад, захидалдаа: “Хэзээ нэг өдөр миний найз тантай уулзаж магадгүй. Түүний нэрийг хэн хэн гэдэг. Түүнд туслахыг танаас хүсэж байна.” гэж дурдаад, надад хандаж: “Би чамайг ерөнхийлөгчид танилцуулсан. Тэр чамд тусална. Түүн дээр яваад оч. Чамайг ордондоо оруулах болно.” гэж тэр хэлсэн бол өөр хэрэг. Багшийнхаа хэлсэн санааг ойлгож байна уу?

Та нар Бурханыг дуудан залбирахдаа түүнтэй хараахан уулзаагүй байж магадгүй. Бурханыг дуудан залбирахыг заадаг жинхэнэ Их Багштай байх, Их Багшгүй байх хоёр адилгүй. Тэр Их Багш Бурхантай танил байж, тэрхүү Бурханг дуудан залбирахыг чамд зааж өгч чадна. Шагжамуни Будда хэдийнээ Түүнтэй танилцсан болохоор хүмүүст Авид бурханыг “Дуудан залбирах”-ыг заасан. Тэрээр шавь нараа дагуулж очоод: “Миний шавь нар ёс суртахуунтай сайн хүмүүс. Бүгд цагаан хоол идэж, бясалгал дадуулдаг гэж баталгаа гаргахад Авид бурхан тэдэнд тусалжээ. Тиймээс тухайн үед Шагжамуни Буддагийн шавь нарт Түүнийг дуудан залбирах нь тус нэмэртэй байв. Харин одоо жирийн хүмүүс Бурханыг амандаа дуудан залбираад төдийлөн нэмэргүй. Зөвхөн нэгэн сэтгэлээр дуудан залбирвал уйтгар бухимдал багасна. Иймэрхүү маягаар залбирвал бага сага тустай байж магадгүй.

Авид бурхан бол зөвхөн төгс баясгалант орны сургаалын

эзэн болохоос бүх ертөнцийн сургаалын эзэн биш гэж Багш нь саяхан хэлсэн. Бид төгс баясгалант оронд залбирсан ч сэтгэл маань өмнөдөд хүлээстэй байвал төгс баясгалант оронд очиж чадахгүй. Тэгэхээр бид хамгийн дээд Бурханд залбирвал хамгийн сайн, хамгийн аюулгүй. Хаана ч очсон Түүнтэй уулзана. Бурханы орон бол Бурханы орон тул хаана ч очсон Бурхан байвал болох нь тэр. Ганцхан төгс баясгалант оронд очно гэсэн үг биш. Ойлгов уу? Учир нь бид сэтгэлээ төвлөрүүлэн төгс баясгалант оронд очиж чадахгүй учраас жинхэнэ Авид бурханыг танихгүй.

Иймээс хамгийн дээд нэрийг дуудан залбирах нь хамгийн сайн. Гэвч энэхүү хамгийн дээд нэрийг ном сударт дурдаагүй. Учир нь "Нэрийг нэрлэж болбол мөнхийн нэр бус." тул хэлье гэвч хэлэх аргагүй. Танилцъя гэвэл Их Багшийн танилцуулсны дараа л сая мэднэ. Ийм Их Багш нь бурханы найз байж мэднэ. Эсхүл бурханы албат, тэр ч байтугай бурханы зарц ч байж магадгүй.

Гэвч хамаагүй, зарц нь ч Бурхныг танина. Тэр биднийг дагуулж Түүнтэй уулзуулна. Жишээлбэл, бид хааны тогоочтой танил бол сайн хэрэг. Нэг л өдөр хаантай уулзаж мэднэ. Бусад түшмэдтэй танил ч тэд төдийлөн нэмэр болж чадахгүй тул бид хаантай хэзээ ч уулзахгүй байж магадгүй. Учир нь түшмэд өөрсдөө ч хаантайгаа уулзахгүй байж мэднэ. Харин бурхны зарцтай танилцвал энэ нь Түүнтэй уулзах хамгийн сайн дөт зам болно.

Иймээс та нар Багшийгаа ямар дэстэйг таамагласны хэрэггүй. Бурханы зарц, бурханы тогооч гэж бодоход л хангалттай. Тэрээр Бурханыг таних тул түүний танилцуулга хамгаас тустай. Хэрэв бид хааны тогоочийг таньдаг бол ямар нэг асуудал тулгарахад тогооч лавтай хаанд дуулгаж чадна. Гэтэл Засгийн газрын өндөр тушаалын түшмэл хаанд үг ч хэлж чадахгүй байж мэднэ. Яагаад гэвэл хэлж зориглохгүйн зэрэгцээ эзэн хаанаа хараад айн дагжиж магадгүй!

Зөвхөн том баяр ёслолын үед л биш бол тэрхүү түшмэл хаантайгаа уулздаггүй байж мэднэ. Учир нь энэ үед хааны аюулгүй байдлыг хариуцаж, түүнийг муу этгээдэд хорлогдохоос сэргийлэх хэрэг гарна. Хамгаалалтын ажлаас гадна түүнд хаантайгаа ярилцчихмаар зүйл үгүй тул уулзаж чадна гэж батлан хэлж чадахгүй. Хэрвээ бид бурхантай танилцъя гэвэл хэдийнээ танилцсан хүнийг олох хэрэгтэй. Жишээ нь, Бурханы зарц. Тэрээр хэрэг эрхлэх газрын ажилтантай адил. Тэрээр даргаа таньдаг учраас даргатай нь уулзъя гэвэл чамайг дагуулан уулзуулна. Хэрэв бид даргыг нь танихгүй бол иймэрхүү хүмүүстэй танил

байх хэрэгтэй. Тэд даргаа сайн мэддэг, ойр дотно тул биднийг хурдан учруулна.

Иймээс Арьяабалын аргаар бясалгал хийе гэвэл "Тэвчээртэй"-гээр бясалгаж бага сага ахуй ойлголттой болж, бясалгал дадуулснаар л ямар болдгийг нь мэдэж, хамгийн дээд сургаалын эзний нэр хэн болох, энэхүү "Нэрлэж үл болох нэр" нь ямар учиртайг ойлгоно. Хааны зургийг харж, нэрийг нь сонссон ч энэ нь хаан өөрөө биш. Хаан гэдэг нь зураг ч биш, нэр ч биш. Хаантай жинхэнэ ёсоор танилцах нь өөр асуудал. Үүнтэй адил эгэл хүний үг хэлээр нэрлэсэн нэр бол бурхан биш. Бурхантай, энэхүү жинхэнэ нэр буюу "Нэрлэж үл болох нэр"-тэй танилцах нь өөр нэг асуудал. Үнэхээр амаргүй !

Учир нь бид оюун ухаандаа олон зүйлийг бодоод хэдийнээ заншчихжээ. Нөхрөө бодно, эхнэрээ бодно, хорвоог бодно, уйтгар бухимдлын талаар бодно гэх мэт. Хорвоо ертөнцийн зүйлсийг бодсоноос Авид бурханд залбирах нь илүү тустай. Ингэх нь зөвхөн бидний гэрэл гэгээтэй талыг л сануулах төдий. Хэрэв бид Бурханд залбиръя гэвэл бидний бүхий л сайн чанаруудыг сануулж, хөгжүүлдэг илүү хүчтэй бурханы алдар бий. Бид Авид бурханыг дуудан залбирахын учир нь өөрийн гэрэл гэгээтэй талыг хөгжүүлэхийн төлөө юм. Арьяабал бурханыг дуудан залбирах нь энэрэн нигүүлсэх сэтгэлээ хөгжүүлэхийн төлөө юм. Гэтэл зарим бурханы алдар нь бидний бүх сайн чанарыг илрүүлэн хөгжүүлдэг. Ийм алдрыг унших нь хамгийн сайн. Гэтэл тэрхүү хамгийн сайн алдар нэрийг нэрлэхийн аргагүй. Бидний ууриг тархи, оюун ухаан бодомтгой. Бодохгүй юмгүй. Тэгтлээ их дурсан санадаг. Тиймээс Багш нь та нарт бас дурсан бодох юм өгч чадна. Тэгэхдээ бидний бүхий л эрхэм дээд, сэтгэшгүй чанарыг хөгжүүлдэг хамгийн сайн, хамгийн хүчтэй тийм алдар нэрийг өгнө.

Арьяабалын бясалгалын арга ч "Бурханыг дурсан залбирах"-ыг хүмүүст сургадаг. Гэхдээ Авид бурханд биш, харин хамгийн дээд, хамгийн хүчтэй Бурханд залбирдаг. Учир нь энэхүү хамгийн хүчтэй Бурханы алдар нэрийг Багшийнх нь хүч (Бурханы хүч Багшийн дотоодод бий) адислах тул хүмүүс залбирах үедээ тэрхүү адислалыг маш хүчтэй мэдэрдэг. Багшийнх нь хүчээр адислагдсан бол Авид бурханд залбирсан ч адислалын хүчийг ялгаагүй мэдэрнэ. Та нар Авид бурханаа орхиж чадахгүй бол авшгийн дараа нэрийг нь нэмээд хамтад нь уншиж болно. (*Бүгд инээв*.) Ингэвэл бас нөлөөтэй. Авшиг хүртэхээс өмнө амаараа Авид бурханыг унших нь тийм их нэмэргүй, нөхцөл байдал өөр, учир нь урьд нь энэхүү адислах хүч байсангүй. Энэ нь яг

л гүйдэлд холбоогүй цахилгааны утсанд цахилгаан байдаггүйтэй адил ямар ч бодитой ач тусгүй юм.

Та нар мөнгө, мөнгө гэж уншивч халаасанд чинь мөнгө байхгүй бол яаж ч уншаад мөнгөтэй гэдэгт чинь хүмүүс итгэхгүй. Хүмүүс хэлсэн болгонд үнэмшдэггүй. Би мөнгөтэй гээд хэлэх нь хангалтгүй, өөрт чинь байвал тэр үед л итгэнэ. Хэрэв бид баян хүний шинжгүй бол бас үнэмшихгүй. Мөнгөтэй хүн, мөнгөгүй хүний үг яриа адилгүй. Үүнийг сонсоод юм уу хараад л мэдчихнэ. Тийм үү?

Жишээлбэл, хэн нэгэн чамайг хөнөөхөөр ирвэл чи хөдөлшгүй зоригтойгоор: "Би чамаас айхгүй, би хүчтэй бас надад буу бий." гэвэл тэр хүн үгэнд чинь итгээд чамайг хорлож зүрхлэхгүй. Хэрэв чи чичгэнэсэн хоолойгоор: "Би, би, би... чамаас айх... гүй гүй, миний гэрт буу... байна, чи... намайг... хорлож... чадахгүй..." гэвэл тэр сонсмогцоо чиний хулчгар болохыг мэдчихнэ. Тиймээс бурханд залбирахад Багшийнх нь хүчний хамгаалалт байхгүй бол ад чөтгөр ч айхгүй. Багшийнхаа хамгаалах хүчээр бамбай хийвэл чи залбиралгүй Багшаа бодох төдийд л ад чөтгөр хэдийнээ айж, чамд ойртож зүрхлэхгүй.

Багшийнх нь Арьяабалын бясалгалын арга ч Бурханыг дурсан залбирахыг багтаана. Тэгэхдээ та нарт жинхэнэ ёсоор тусалж чадах хамгийн дээд, хамгийн хүчтэй Бурханд залбирдаг. Бурханы алдар нэрийг уншиж ч дуусаагүй байхад ад чөтгөр аль хэдийнээ зугтааж, Бурхан, Бодьсадвагийн дүрд хуурамчаар хувилсан ад чөтгөрүүд нэг хором ч байж зүрхлэхгүй. Муу хүн ч ойртож чадахгүй. Иймээс тэд дургүйцэж, довтлох түмэн арга сүвэгчилнэ. Учир нь тэд Бурханы алдрын хүч чадлыг тэсвэрлэж чаддаггүй. Ингэвэл сая Бурханыг жинхэнэ ёсоор "Дурсан залбирсан" хэрэг болно.

Энэхүү алдар нэрийг уншихад цаглашгүй гэрэл, Авид бурханы гэрэлтэй холбогдож, өдөр бүр гэрэлтэй хамт, гэрэл дотор амьдарна. Энэхүү гэрэлд залбирч, гэрэлтэй хамт унтаж, хамт хооллоно. Хаа ч хамт байж, гэрлээс үл сална. Дараа нь хаана ч гэрэлтэй болох бөгөөд энэ нь "Цаглашгүй гэрэл" болно. Хэмжээлшгүй бөгөөд хаа сайгүй орших тул цаглашгүй гэрэл гэнэ. Энэхүү цаглашгүй гэрэлтэй холбогдвол өдөр бүр түүнийг харж, хамт байна. Тэр биднийг хамгаалах төдийгүй сайн талыг маань хөгжүүлж, билиг ухааныг нээж, биднийг удирдан төгс баясгалант ариун орон, Бурханы орон дээд түвшинд аваачна.

Бурханы алдрыг уншиж гэрэл харахаас гадна гайхамшигт дотоод хэлбэлзлээ "ажна". Орчлонгийн аялгууны урсгал гэдэг

нь гадаад орчны дуу аялгуу биш. “Гэрэл харах”, “Аялгуу ажих” эсвэл “Бурханыг дурсах”-ын аль алиныг Багшийн ном уламжилснаар олж авна. Ном уламжлахад юу ч ярьдаггүй учир “Авшиг уламжлах” гэнэ. Номыг “Сэтгэл”-ээр уламжилна. Сэтгэл гэж юу вэ? Сэтгэл гэдэг нь бодол сэтгэлийн сэтгэл биш, харин бидний угийн сэтгэл, жинхэнэ сэтгэл юм. Иймээс сэтгэлээр авшиг уламжлах үед юм ярих шаардлагагүй.

Даяан үг хэрэглэдэггүй гэж бид ярьдаг нь ийм учиртай. Хэрэв үг хэл хэрэглэх шаардлагатай бол ном уламжилж буй явдал биш.

Учир нь угаасаа уламжилмаар “ном” үгүй. Гэхдээ уламжлахгүй бол “ном” үгүй, уламжилбал “ном”-той болно. Хэдийгээр “ном” гэж яривч үнэндээ “ном” үгүй. Тиймээс “дүрс үгүй ном” гэдэг. Миний уламжилсан нь “Дүрс үгүй ном” гэж зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн хэлжээ. “Зүрхэн судар”-т мөн адил учрыг дурдсан байна. Шагжамуни Будда энэ номыг дүрслэн өгүүлэхдээ “Хамаг ном дүрс хоосон.” гэсэн нь зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөнгийн хэлсэн “Дүрс үгүй ном.” гэдэгтэй яг адил. Үүнээс гадна Шагжамуни Будда бас энэхүү номыг: “Төрөхгүй, устахгүй, бохир үгүй, цэвэр үгүй, нэмэгдэхгүй, хасагдахгүй. Иймд хоосонд өнгө үгүй, сэрэл үгүй, сэтгэхгүй, нүдгүй, чихгүй, хамаргүй, хэлгүй, бие үгүй, дур үгүй, дүр үгүй, дуу үгүй, үнэр үгүй, амт үгүй, хүртэхүй үгүй, ном үгүй болой. Нүд үзэхгүй, дурлахгүй...” гэсэн билээ.

Юу ч үгүйг “Дүрс үгүй ном.” гэнэ. Гэвч бас юу ч үгүй биш. Иймээс “Нэрийг дуудаж болбол мөнхийн нэр бус.” гэдэг. Хэлье гэвч хэлэх аргагүй. Гэвч юм бүхэн бий. Алив бүгд “Дүрс үгүй ном”-ын дотор бий, “Аялгууны урсгал” дотор бий. Энэхүү “Аялгуулж үл болох аялгуу.”, “Нэрлэж үл болох нэр”-ийн дотор бий. Тиймээс “Дүрс үгүй ном” гэж нэрийджээ. Гэвч уламжлахгүй бол ном үгүй. Зөвхөн ном уламжлах үед “ном”-ыг олно. Гарцаагүй олно. Багшийгаа ном уламжлах үед та нарын хэн нь ч гэсэн үүнийг биеэрээ ойлгож, мэдэрнэ. Ном уламжлахын өмнөх болон уламжилсны дараах байдал огт адилгүй. Ном уламжлахад хэдийгээр юу ч ярихгүй, уламжилчихмаар “ном” үгүй боловч, бид “ном”-ыг олж хүртэнэ. Үүнийг бид алган дээрээ байгаа мэт тодорхой мэдэх болно.

Даяан үг ярихгүй, үг хэл хэрэглэхгүй тул даяан үгүй гэж хэлж болохгүй. Ном дүрс үгүй болохоор Багш нь та нарт ном уламжлаагүй гэсэн үг ч биш. Мэдээж уламжилна. Гэвч үг хэлээр ярих боломжгүй учраас “Сэтгэлээр авшиг уламжлах” гэж ярих нь хангалттай. Сэтгэлээр сэтгэлд уламжлах үед та нарын сэтгэл

“Нээгдэнэ”. Яриад байх зүйлгүй.

Багш нь Арьяабалын бясалгалын аргын ач буяныг хэчнээн ч магтаад ч барахгүй. Харин жинхэнэ ёсоор хичээн бясалгасан хүн ойлгож, тэр даруйдаа таньж чадна. Тэгээд бясалгахгүй нэг л хоновол бүхэл бие нь загатнаж, нэг л биш санагдана. Үүнээс бид энэхүү хүч хэчнээн сэтгэшгүй болохыг дорхноо ойлгож мэдэх болно.

Шагжамуни Будда ном судар болгондоо аялгуу ажихуйг магтан сайшаасан байдаг. “Хотол зохилдогч зүйл”-д Тэрээр: “Хэрвээ бид аялгуу ажихуйн алдар нэрийг мэдвэл, энэ нь үй түмэн Бодьсадвагийн алдрыг уншсанаас ч илүү ач буянтай. Үй түмэн Бодьсадвад өргөл өргөснөөс ч илүү ач буянтай.” гэжээ. Учир нь Арьяабал нь Түүний нэр биш. Түүний нэр нь “Нэрлэж үл болох” нэр, энэхүү орчлонгийн аялгууны урсгал, бүхий л орчлонгийн өнөд оршигч хэлбэлзлийн хүч мөн.

Иймээс Арьяабалын аргаар бясалгал дадуулагч нь хамгийн ач буянтай, хамгийн эрхэм дээд хүн юм. Үүнийг авшиг хүртсэн хүн тов тодорхой мэднэ.

ҮЙЛ ТҮЙТГЭР ХААНААС ИРСЭН БЭ?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар. Формосагийн Тайбэй хотын Цаглашгүй гэрэлт бясалгалын төв.
(Эх нь хятад хэлээр)

Өнөөдөр та бүгдтэй Арьяабалын бясалгалын аргын талаар ярилцана. Энэ сэдвийг уг нь хамгийн сүүлийн өдөр тайлах байсан ч бүгд эртхэн сонсъё гэж яараад байхаар нь өнөөдөр тайлахаар боллоо. Та бүхэн Арьяабалын бясалгалын аргыг ойлгоё гэвэл юуг “Аялгуу” гэх, юуг “Аялгуу ажих” гэдгийг эхлээд ойлгох хэрэгтэй. “Ажих” гэдэг нь “дүрслэн бодох”, “Аялгуу” гэдэг нь “дуу аялгуу” болно. Жирийн үед бид хүнийг эгэл хүний оюун ухаанаар ажигладаг. Жишээлбэл, нүдний том жижиг, өндөр нам, тарган туранхай эсэх, тэр ч байтугай түүний хувийн зан чанар гэх мэт. Ингэж ажиглах нь бодит байдалтай тун их зөрүүтэй. Эгэл хүний оюун ухаанаар Бурхан чанарыг төсөөлөн бодвол алдаа гаргах нь ойлгомжтой.

Тиймээс бид “Билиг ухаан”-аар ажиглан шинжих хэрэгтэй. Энэхүү билиг ухаан угаас бүгдэд нь байдаг ч хүн болгон ашиглаж чаддаггүй. Хүн төрөлтөн маш олон зүйлийг нээж, бүтээн туурвиж, ертөнцийн олон юмсыг сурч чадна. Энэ бүхнийг билиг ухаанаар бус цэцэн ухаанаар хийсэн. Хэдий тийм ч билиг ухаан үгүй бол аливааг сурч мэдэж, таньж ухаарахын аргагүй. Цэцэн ухаан нь билиг ухаанаас гаралтай бөгөөд билиг ухааны өчүүхэн хэсэг юм.

Одоо би эхлээд энэ ертөнцийн энгийн дуу аялгууг ярья. Дараа нь чанагуух ертөнцийн аялгуу Бурханы аялгууг ярина. Дуу аялгуу нь эртнээс нааш бидний амьдралын чухал хэсэг байсаар иржээ. Хэрвээ энэ ертөнц дуу хөгжимгүй бол амьдрал хэчнээн уйтгартай болохыг төсөөлөхийн аргагүй. Уянгалаг зөөлөн сонгодог хөгжим хүнийг баяр баясгалантай, амар амгалан, сайхан

сэтгэлтэй болгоно. Тиймээс эрт үед энэрэнгүй уужим сэтгэлтэй, эрхэм дээд чанартай хүмүүс олон байжээ. Орчин үеийн жааз, рок хөгжим сэтгэл хөдөлгөх хэдий ч зарим хүмүүс багаасаа ийм хөгжмийн нөлөөнд автвал хүмүүжүүлэхэд тун амаргүй болдог. Ийм хөгжим нь орчин үеийн хүмүүсийн зан чанар, хэв маягийг төлөөлж байдаг. Сэтгэцийн эмнэлэгт эмч нар өвчтөндөө уянгалаг хөгжим сонсгож сэтгэл санааг нь тогтуун болгодог. Бид ажилдаа ядарсан эсвэл сэтгэл санаа бухимдсан үед хөгжим сонсвол тайвширдаг.

Орчлонгийн аливаа юмс цөм хэлбэлздэг. Энэхүү хэлбэлзэл нь дуу аялгуу болж хувирна. Радио станцаас цацсан долгион хүлээн авагчаар дамжин дуу авиа болдогтой адил. Орчлонгийн түмэн бодис бүгд хэлбэлзэх бөгөөд өөр өөрийн давтамжтай. Жишээ нь хад чулуу, өвс мод, хүн амьтан бүгд өөрийн гэсэн хэлбэлзлийн давтамжтай байдаг. Давтамжийн зөрөөнөөс болоод хүн амьтан, хүмүүс хоорондоо, эхнэр нөхрүүд харилцан ойлголцоход тун хэцүү.

Зарим хүний давтамж нэлээд ширүүн тул уулзмагц л тайван бус байдлыг мэдэрдэг. Заримынх нь хэлбэлзэл буюу ярианы өнгө тун аядуу зөөлөн болохоор харангуут л тун таатай, баяр хөөртэй болно. Зарим газрын хэлбэлзлийн давтамж биднийхтэй ойролцоо тул очиход сайхан байдаг. Сөрөг энергитэй хүн хаана ч явсан хүмүүсийн сэтгэлийг тавгүйтүүлж түгшүүр төрүүлдэг. Учир нь түүний давтамж хэт доогуур, их удаан. Үүнийг үйл түйтгэр ихтэй, хорон муу санаатай, адын хорлол ихтэй гэж бас хэлж болно. Түүний хэтэрхий сөрөг чанар бидний эрэг байдалтай зохицохгүйгээс тайван бус, түгшүүртэй мэдрэмжийг төрүүлдэг.

Манай бөмбөрцгийн газар бүрд хэлбэлзлийн давтамж өөр юм. Учир нь дэлхий дээрх элдэв төрлийн металлын ордуудын байршил, тархалт харилцан адилгүй. Бясалгал хийдэггүй хүмүүст тайван тогтуун амьдрахын аргагүй газар олон байдаг. Харин жинхэнэ бясалгал дадуулдаг хүний хувьд газар бүхэн диваажин, хаа сайгүй ариун орон болно. Гэвч үүнийг хэлэхэд амар, хийхэд хэцүү. Энэ түвшинд жинхэнэ ёсоор хүрч чадсан хүн хэд билээ? Газар оронтойгоо зохицохгүй ийм байдлыг цөөн тооны харанхуй мунхаг, хад чулуу шиг хүмүүсээс бусад бясалгадаггүй энгийн хүн ч мэдэрч чадна. Сүнслэг бясалгагч хүн түвшин нь өндөрсөх тусмаа илүү мэдрэмтгий болдог ч хамгийн дээд түвшинд хүрвэл түүний хувьд газар бүхэн ялгаагүй болдог.

Бид хэнтэй хамт байна, түүний хэлбэлзлийн нөлөөг хүртэх бөгөөд аядуу зөөлөн бол бид нэлээд зөөлөрнө. Сэтгэл хөдлөмтгий

бол бид ч бас тийм болно. Бодьсадваг хүмүүсийн үйл түйтгэрийг үүрдэг гэж ярьдаг. Бодьсадва нар бусдын сөрөг хэлбэлзэл, өөрөөр хэлбэл үйл түйтгэрийг өөртөө аваад сайн хэлбэлзлээ өгч, сүнслэг бясалгалын хүчээ ашиглан тэдгээр үйл түйтгэрийг маш хурдан угаан ариусгадаг. Ингэхэд чухам хэр их хугацаа орох нь тэдний хураасан үйл түйтгэрийн их багаас шалтгаална. Бусдаас авсан үйл түйтгэрээ угааж дуустлаа үйлийн үрийн нөлөөг амссаар байдаг тул өвчин тусч, гүтгүүлэн муушаагдаж, тэр ч байтугай хорлогдож мэднэ.

Жишээ нь, Есүс Христ хамаг амьтны нүгэл хилэнцийг үүрч загалмайд цовдлуулсан билээ. Шагжамуни Будда бусдын үйл түйтгэрийг үүрсэн тухай бид сонсоогүй ч ном сударт ийнхүү тэмдэглэсэн байна. Ерэн есөн хүнийг хороосон нэг хүн Шагжамуни Буддаг хорлох гээд чадсангүй. Харин ч Буддагаар гэтэлгүүлж бясалгал дадуулаад, эцэст нь архадын хутгийг олжээ. Будда түүний үйл түйтгэрийг үүрээгүй юм бол өдий төдий хүнийг хороосны үйл лай нь хаачсан хэрэг вэ? Олон хүний аминд хүрчихээд архад болсон нь үйл үрийн хуулийг зөрчсөн явдал болох биш үү? Тийм биш юм. Учир нь Шагжамуни Буддагийн буян эрдэм тун арвин, буян хишиг нь цаглашгүй, хязгааргүй тул түүний бүхий л үйл түйтгэрийг төлж барагдуулахад хангалттай хүрнэ. Ямар ч асуудалгүй. Тэрээр үйлийн үрээ эдлэхгүй гэсэн үг биш, харин Шагжамуни Будда өмнөөс нь эдэлжээ.

Тиймээс эртнээс нааш туулан гэтлэхийг хүссэн хүн эхлээд заавал тийм нэгэн Их Багшийг хайж олох хэрэгтэй. Учир нь бид дадал бясалгалыг дөнгөж хийж эхэлж байгаа болохоор зөвхөн өөрийн хүчиндээ найдвал тийм их үйл түйтгэрийг төлж барагдуулахад нэн хэцүү. Харин Их Багшийн төрөл төрөлдөө хураасан сүнслэг дадал бясалгалын эрдэм, буян хишиг маш их тул Тэрээр бидний явах замыг зааж, ачааг маань үүрэлцэж тусалдаг. Учир нь Их Багш нар хангалттай хүчтэй. Хүнд хүний хүч бий, бясалгалтанд сүнслэг бясалгалын хүч бий. Тэрхүү хүчийг бид харахгүй байж болох ч, тэр нь үнэхээр цаглашгүй, хязгаарлашгүй. Биеийн хүчтэй огтхон ч харьцуулшгүй. Багшаас авшиг хүртсэн хүний таван үе төрөл дэвшинэ гэдэг нь сүнслэг бясалгалын хүчээр цөмөөрөө дээш татагддаг гэсэн үг. Иймээс бясалгал дадлын хүчийг үнэлж баршгүй. Хэчнээн ч мөнгөтэй байсан худалдаад авч чадахгүй, ямар ч эрх мэдэлтэй байсан булаагаад авч чадахгүй.

Багш нь зарим үед ном тайлахад үг аяндаа урсаж торох юмгүй байдаг. Заримдаа юманд дарагдах мэт болж, ярьж ч болохгүй, их

ядарсан санагддаг. Авшиг хүртээхэд ч мөн адил. Заримдаа тун урагштай, ямар ч асуудалгүй. Заримдаа яг л үхэх гэж байгаа мэт болно. Энэ нь ном сонсохоор, авшиг хүртэхээр ирсэн хүмүүсийн хэлбэлзлээс болдог. Хүн бүрийн хэлбэлзлийн их бага нь тэрхүү үйл түйтгэр гэгч болно. Эдгээр адилгүй хэлбэлзлүүд яаж бий болсон бэ? Энэ нь үйл үрийн хуулиар бий болсон бөгөөд бидний төрөл төрөлдөө үйлдсэн үйл түйтгэртэй холбоотой.

Бид угаасаа Бурхан юм. Есүс Христ: "Бид бол Бурханы хүүхдүүд." гэсэн билээ. Хэрвээ тийм бол, яагаад зарим нь баян чинээлэг, зарим нь ядуу хоосон, зарим нь цэцэн сэргэлэн, зарим нь тэнэг мунхаг байдаг вэ? Яагаад зарим нь сайхан сэтгэлтэй, зарим нь муу санаатай байдаг вэ? Учир нь нэгд, бид угаасаа Бурхан ч энэ ертөнцөд унаж ирэхдээ ихэнх билиг ухаанаа мартдаг. Хоёрт, гадаад орчны нөлөөнөөс болдог байна.

Энэ хорвоо дээд түвшний ертөнцтэй адилгүй. Дээд түвшний ертөнц бидний бясалгал дадлын дэвшилд тусалж, илүү уужуу тайван, улам эрхэм дээд болгодог бол энэ хорвоо биднийг хойш татаж, улам мунхаг, муу хүн болгодог. Төгс баясгалант оронд дутагдах юмгүй тул өчүүхэн ч зовлонгүй. Гэтэл энэ хорвоод байгалийн хүчтэй тэмцэж байж л оршин тогтнож чадна. Шагжамуни Будда ч гэсэн хоол унд идэж, энэ дэлхийн юмыг хэрэглэж байж л оршин амьдарч байсан билээ. Энэ хорвоо нь дүрстэй, өнгөтэй, ялгавартай ертөнц. Хүйтэн, халуун, сайхан, муухай, эрэгтэй, эмэгтэй байх болохоор төгс баясгалант оронтой адилгүй.

Төгс баясгалант орон нь дүрсгүй, өнгөгүй, ялгаваргүй ертөнц. Бид энэ хорвоод ирээд гадагш хандагч төрөлтөн болсон. Идэх юм харвал идэх бодол төрж, эд зүйлийг хараад дурлах буюу голох санаа үүснэ. Бидний сэтгэл дуртай зүйлдээ байнга татагдсанаас билиг ухаанаа мартаж, орчлонгийн их хүчнээс аажмаар холдсоор улам ганцаарджээ.

Бүх зүйл биднийх ч сэтгэлээ ганц хоёрхон дуртай зүйлдээ хандуулснаас өөрөө ч мэдэлгүйгээр өчүүхэн жижиг хүрээнд хашигдаж, угийн ялгаваргүй байснаа (Төгс баясгалант оронд бүгд адилхан алтан шаргал биетэй, эрэгтэй, эмэгтэйн ялгаа үгүй.) ялгаатай нэгэн болон хувирчээ. Бид хэн нэгэн хүн, ганц нэг зүйлд онцгойлон дурласнаас орчлонгийн их хүчнээс тасарч, өөрийгөө улам өнчрүүлснээр өчүүхэн бага хүч болж хувираад түүнийгээ дор нь хэрэглээд баржээ. Энэ нь нэг хүн хэрэглээд дундаршгүй Ганга мөрний устай байсантай адил. Хэрэв тэр Ганга мөрнөө орхин эрэг рүү сэтгэл татагдан түүндээ хэт автвал буцах замаа

мартана. Түүнд ус хэрэгтэй үед ойр хавиасаа багахан ус олдог ч мэдээж хангалтгүй.

Үүний адилаар бид улам сул дорой, билиг ухаангүй болжээ.

Билиг ухаан багасахын хэрээр улам шунахай болно. Амь амьдрал нь баталгаагүй санагдах тул ахиухан юмтай болохыг хичээнэ. Ингээд л шунал хүсэл, уур хилэн, тэнэг мунхгийн сэтгэл үүсэж, тэр нь нэгэн онцгой соронзон талбай болоод биднийг бүчиж авна. Хүн бүр өөр өөр болохоор соронзон талбай нь адилгүй. Ижил зүйлс таталцаж, эсрэг зүйлс түлхэлцэх тул шунал ихтэй, эсвэл сэтгэлийн хөөрөлтэй хүн сэтгэл тогтворгүй байдлыг өөртөө татдаг. Аядуу зөөлөн хүн аядуу зөөлнийг татна. Үйл түйтгэр гэгч ингэж бүрэлддэг.

Зарим хүн юу ч хийсэн үргэлж буруудаж бүтэлгүйтээд байдаг. Энэ нь соронзон талбайдаа их билиг ухааны хүчийг татаж дийлэхгүй, харин сөрөг муу хүч, эсвэл саад тотгорын хүч, тэнэг мунхгийн хүч, ад түйтгэрийн хүчийг байнга татсанаас болдог байна. Зарим хүн их адгууслаг байдаг нь өөрийн соронзон талбай, эсвэл урьд төрлийн дадал зуршлаа засаж чадаагүйтэй холбоотой. Соронзон талбай сайн тал руугаа аажмаар хувирах нь бидний дээшлэн дэвшиж буйг харуулах бөгөөд хэдий хугацаа орох нь бидний сэтгэлийн цэвэр ариунаас шалтгаална. Хүүхэд шиг гэнэн цайлган болбол диваажинд очно гэж “Даодэжин” болон бусад ном сударт дурджээ.

Дадал зуршил, соронзон талбайгаа өөрчлөх нь хялбаргүй. Амьсгалаа тоолох аргаар юм уу, эсвэл иогийн дасгал хөдөлгөөнөөр өөрчилж огт чадахгүй. Учир нь дадал зуршил үүсэх нь оюун ухаанаас хамаарна. Иймээс дадал зуршлаа өөрчилье гэвэл оюун бодлоо өөрчлөх хэрэгтэй. Зөвхөн наран сүлжээг ажих, араг яс ажих, урсгал ус ажих, амьсгал ажих зэрэгт найдалтгүй. Гагцхүү Арьяабалын бясалгалын аргаар бясалгал дадуулах нь хамгийн төгс арга болно.

Энэхүү аялгуу бол “Бурханы аялгуу”, уг чанарын аялгуу бөгөөд орчлонгийн түмэн бодис буй болохоос өмнө энэхүү аялгуу хэдийнээ оршиж байсан. Энэ аялгуу бол “Чанагуух ертөнцийн ялгуулсан дуу” учраас эгэл хүний чихээр сонсож чадахгүй. Гэвч хамаг амьтан цөм сонсдог. Зөвхөн тэдний дэс өөр өөр байдгаас сонсох аялгуу нь адилгүй. Орчлонгийн аливаа юмс бүгд хэлбэлздэг учраас бүгд аялгуутай. Чулуу ч гэсэн аялгуутай. Гэвч тун нарийн учраас чихээр сонсох аргагүй, билиг ухаанаар л сонсож чадна. Иймд аялгуу сонсох гэдэггүй “Аялгуу ажих” гэдэг. Хамаг амьтад хэдийнээ аялгуутай учир бүгд билиг ухаантай. Гэвч яагаад энэхүү

аялгууг ажиж чаддаггүй вэ? Учир нь тэд түлхүүргүй, бас аялгуу хаана байдгийг мэддэггүй. Тиймээс хаалга онгойлгож өгөх нэгэн Их Багшийг эхлээд хайж олох хэрэгтэй.

Энэхүү аялгуу яагаад тийм чухал вэ? Орчлонгийн түмэн бодис цөм энэхүү аялгуугаар холбогдон нэгддэг. Дээд түвшнээс доод түвшин хүртэл энэхүү аялгуугаар л холбогдоно. Зарим хүний хэлбэлзэл бусдынхтай зохицохгүй учраас хамт байхад тун бэрх байдаг гэж саяхан дурдсан. Үүний адил бидний хэлбэлзэл амьтныхтай, эсвэл ямар нэгэн газар орны хэлбэлзэлтэй зохицохгүй бол бид амьтадтай цуг амьдарч чадахгүй, тэнд байж чадахгүй. Хэрэв зарим хүн тэр газарт амьдарч чадвал энэ нь тэр биднээс илүү гэсэн хэрэг биш. Харин түүний хэлбэлзэл хэтэрхий доогуур, амьтны хэлбэлзэлтэй ойролцоо байж тун болзошгүйг илтгэж байгаа юм. Тиймээс л тэр юу ч мэдэрдэггүй байна.

Жишээ нь, гахай, мэлхий хэдийгээр бохир заваан газар амьдардаг ч сэтгэл хангалуун байдаг. Хэн ч тэсэж тогтохооргүй газарт зарим хүн юу ч бодолгүй тааламжтай амьдарч чаддагийг үүгээр тайлбарлаж болно. Учир нь түүний хэлбэлзэл тухайн газрынхтай зохицож буйгаас тэр. Гэвч бид нэлээд өндөр, уян зөөлөн хэлбэлзэлтэй тул иймэрхүү доогуур хэлбэлзэлтэй зохицож тэнд тэсэж байж чадахгүй. Энэ нь тэд биднээс өндөр чадвартайг илтгэж байгаа юм биш. Сайхан сэтгэлтэй хүн хорон муу санаатантай хамт байхад үргэлж хэцүү байдаг.

Хэрэв тогтсон хувь заяагаа өөрчилье гэвэл энэхүү хамгийн дээд аялгууг ашиглах хэрэгтэй. Одоо бидэнд зөвхөн хэсэгхэн аялгуу л байна. Тэгээд ч хэлбэлзэл нь өндөр биш болохоор дэс нь ч өндөр биш. Амьтадтай зэрэгцэн оршдог энэхүү гараг дээр бид амьдарч байна. Ижил нь ижлээ дагадаг гэдэг нь энэ билээ.

Хамаг амьтныг багтаасан нэгэн зүйлийн аялгуу бий. Энэ бол “Бурханы аялгуу”, “Уг чанар”-ын аялгуу юм. Хэрвээ энэхүү аялгууг түшиглэж, бясалгал дадуулвал бидний хэлбэлзэл дээшилж, дэс маань улам өндөрсөнө. Гаднаас нь харахад урьдынхтай ялгаагүй байж болох ч биеэс нь гэрэл цацарч, ном тайлахыг нь хүмүүс дуртайяа сонсоно. Бусдыг хялбархан гэтэлгэнэ. Учир нь бидний хэлбэлзэл нэлээд аядуу зөөлөн болсон тул хүний сэтгэлийг тайвшруулж, тэднийг туулан гэтэлгэдэг. Бидний хэлбэлзэл тэднийхийг бүчин авч, сайнаа өгөөд мууг нь устгана. Хүний цус бохирдоход эмч муу цусыг сайн цусаар сольдогтой яг адил. Хувинтай ус бохирдвол бохир усыг асгаад цэвэр ус хийдэг. Гэвч бидний хэлбэлзэл хангалттай сайн биш бол бусдын муу хэлбэлзлийг өөрчилж чадахгүйгээр барахгүй үр дагавар нь тун

тааруухан байх болно. Тиймээс хамаг амьтныг гэтэлгэе гэвэл урьдаар сайн бясалгах хэрэгтэй.

Энэ дэлхийд амьдрахад энэ ертөнцийн багажийг хэрэглэх хэрэгтэй гэж саяхан дурдсан. Энэхүү багаж (*Багш өөрийн биеэ заав*.) нь Формосагийн төв аялгаар сайн ярьж чадахгүй, энэ багаж (*Англи хэлний хэлмэрчийг заав*.) англиар сайн ярьж чадахгүй, энэ багаж (*Хятад хэлний хэлмэрчийг заав*.) хэлснийг бүрэн тогтоож чадахгүй. Бүгд төгс төгөлдөр биш болохоор их төвөгтэй. Хэрэв бүгдээрээ төгс баясгалант оронд очвол ийм асуудал гарахгүй. Та нар төгс баясгалант орон уруу явмаар байна уу? (*Бүгд явмаар байна гэж хариулав*.) Хэрэв явъя гэвэл Арьяабалын аргаар бясалгал дадуулах хэрэгтэй. Энэ бол төгс баясгалант оронд очих хамгийн сайн зам юм.

Авид бурханыг дуудан залбиръя гэвэл эхлээд Түүнтэй танилцах хэрэгтэй. Ингэж байж жинхэнээр "Залбирсан"-д тооцогдоно. Авид бурханыг амаараа дурсан залбирч байгаа бол анхан шатандаа байна гэсэн үг. Учир нь Бурханыг амаараа бус, сэтгэлээрээ "Дурсан залбирах" ёстой. Бурханыг танихгүй бол яаж Түүнд сэтгэлээрээ "Дурсан залбирах" вэ? Арьяабалын бясалгалын аргыг Бурханыг дурсан залбирдаггүй гэж бүү бодоорой. Харин ч Бурханыг дээд зэргээр дуудан залбирдаг. Өдөр бүр Авид бурханы нэрийг өндөр дуугаар дуудаж залбирах нь Бурханд жинхэнээр залбирч буй хэрэг биш бөгөөд Түүний толгойг өвтгөхөөс цаашгүй.

Орчлонгийн түмэн бодис бүгд аялгуутай гэж саяхан дурдсан. Орчлонгийн түмэн бодис энэхүү аялгуунаас үүссэн. Үүнийг "Даодэжин"-д "Дао" буюу "Нэр" хэмээжээ. Лууз: "Дао" нь дуудаж болбол мөнхийн "Дао" бус, нэр нь нэрлэж болбол мөнхийн нэр бус. Хоосон хэмээгч нь тэнгэр газрын үүсэл, буй хэмээгч нь түмэн бодисын эх" гэжээ. "Нэр" буюу "Дао" нь энэ аялгуу, энэ хэлбэлзлийг хэлж буй бөгөөд эртний болон орчин цагийн хятад хэлэнд өөр утгаар хэрэглэгдэж байж болох ч үнэндээ нэг л зүйлийг заана. Үүнийг та нар ойлгох ёстой.

Орчлонгийн түмэн бодис цөм энэхүү "Нэр" буюу "Аялгуу"-наас үүссэн. Бид ч мөн түүний нэг хэсэг. Гэвч бид "хүн" болохоор энэ аялгууны хамгийн дээд хэсэг нь бидэнд бий. Иймээс бид аялгууг бүхлээр нь оршоох боломж ихтэй. Харин амьтдын дэс нь хүрэлцэхгүй тул ингэх боломжгүй. Бид энэхүү аялгуугаар өөрийгөө тасралтгүй дээшлүүлж илүү их, илүү өндөр түвшний аялгууг хүлээн авсаар түүнийг бүхлээр нь оршоох хүртлээ бясалгал дадуулна. Тэр үед бид орчлонгийн хамаг амьтантай зохицож чадна. Учир нь хамаг амьтад бүгд энэхүү аялгууны нэг

хэсэг юм. Бид энэхүү аялгууг бүхэлд нь оршоосон тул бидний хувьд газар болгон ариун орон, хүн болгон Бурхан болж, хамаг амьтан цөм Бурхан чанартай болно. Тэр үед жинхэнээр сэхээрч ойлгосон гэж үзнэ. Эс бөгөөс бүгд зөвхөн "... гэж ярьдаг", "миний сонссоноор бол...", "тийм тийм... гэнэ ээ" гэж ярих төдий болж, эцсийн эцэст аль нь үнэн, аль нь худал болохыг ялгаж чадахгүй. Иймээс өөрөө ахуй ойлголттой болох нь ном судар унших, бусдын ахуй ойлголтыг уншихтай адилгүй. Ном судар унших нь бусдын ахуй ойлголтыг уншиж буй хэрэг. Бид Арьяабалын аргаар бясалгал дадуулаад өөрөө ахуй ойлголттой болж, ном сударт тэмдэглэсэнтэй харьцуулан түүнийгээ урьдын хүмүүсийнхтэй адил эсэхийг харж болно. Заримдаа бидний ахуй ойлголт тэднийхээс илүү байна. Энэ нь бид илүү болчихсон гэсэн үг биш. Энэхүү ахуй ойлголтоо бичиж үлдээх үедээ тэдний дэс тийм ч өндөр байгаагүй байж болох юм. Тэдний тэр үеийн хэмжээнээс бид бага зэрэг давсан байж магадгүй.

Тэр аялгуу хэчнээн хүчтэй болохыг, хамаг амьтан тэрхүү хэлбэлзэл буюу аялгуутай бөгөөд харилцан бие биедээ нөлөөлдөг гэдгийг бид мэдэх ёстой. Энэхүү ертөнц маань Төгс баясгалант оронтой адилгүй. Энд араатан амьтад, сайн, муу хүн болон бачуу сэтгэлтэй, амар тайван, баяр баясгалантай, зовлон зүдүүртэй хүн гээд элдэв зүйлийн орчин нөхцөл холилдон байдаг. Бид ийм нөхцөл байдалд амьдардаг учраас сэтгэл амар байж бясалгал дадуулахад тун бэрх. Маш их саад бэрхшээл, таагүй орчин биднийг саатуулан зовоож байдаг ч нэгэн сэтгэлээр бясалгал дадуулж чадвал дэвшил тун хурдан байх болно.

Иймээс маш олон тэнгэрийн төрөлтнүүд хүн болж төрөх дуртай. Учир нь энэхүү бие махбод байснаар л сая бясалгал хийж чадна. Энэхүү бие махбод хэрэггүй гэж бид үргэлж боддог ч түүнгүй бол бясалгал дадуулах аргагүй. Тэгэхээр махан бие үнэхээр эрхэм нандин. Түүнийг сайтар халамжлан шим тэжээлтэй хоол хүнсээр тордох нь чухал ч хэтрүүлж болохгүй. Даарч хөрж, зовж зүдрэхгүй байх хэрэгтэй. Бясалгал дадлыг хатуу аргаар хийх нь сайнгүй , өөрийн биеэ залхаан шийтгэж байгаа хэрэг бөгөөд ингэх нь хамгийн том ял нүгэл болно. Бид өнгөрсөн, одоо, ирээдүйн Бурхан тул өөрсдийгөө хүндэтгэвэл зохино. Хатуу бясалгалыг дураараа хийж, өөрийн биеэ шийтгэж яаж болох вэ? Гэвч нөхцөл байдал шаардвал мэдээж өөр хэрэг.

Жишээлбэл, Багш нь Хималайд бясалгал дадуулж байхдаа өдөр бүр жаахан түүхий ногоо иддэг байсан тухай та нар сонссон. Тэндхийн газрын байрлал өндөр, агаар нь сийрэг, агаарын

хэм болон даралт доогуур тул хоол, ногоог чанаж болгоход бэрхшээлтэй. Иймээс түүхий ногоо идэх нь амар. Ганга мөрөнд угаагаад давстай усанд дүрээд идчихнэ. Энэ бол Багш нь зориуд хатуу аргаар бясалгал дадуулж байсан хэрэг биш. Мөн багш нь Формосагийн уулын нэгэн сүмд битүүмжлэн бясалгаж, гурван сар зуны хайлан хийхдээ, өдөр бүр бор будааг жаахан гүнждийн үр, давстай идэж, бага сага усууж байсан. Тухайн үед харж хандах хүнгүй байсан. Өөрөө өдөр болгон дэлгүүр рүү ногоонд яваад байвал битүүмжлэн сууж байна гэж яаж хэлж болох вэ? Харин ч ногоо цагааг битүүмжилсэн явдал болох биш үү? (*Хүмүүс инээв.*) Энэ бол тухайн үеийн нөхцөл байдлаас болсон хэрэг. Юу олдоно түүнийгээ л иднэ. Зориуд хатуу бясалгал хийсэн явдал огт биш юм. Хатуу аргаар бясалгал дадуулаад Бурхан болж чадахгүй. Хатуу бясалгал хийвэл зовлонтой хүн болно. Бидний амьдрал хангалттай зовлонтой байхад дээрээс нь дадал бясалгалыг хатуу аргаар хийж яаж болох вэ?

Бурхан болъё гэвэл Арьяабалын аргаар бясалгал хийж, билиг ухаанаараа энэхүү язгуурын аялгууг ажих хэрэгтэй. Учир нь энэхүү аялгуу орчлонгийн түмэн бодисыг бүтээгч болохоор орчлонгийн хамгийн өндөр дээд, хамгийн агуу хүч, басхүү орчлонгийн хамгийн дээд билиг ухаан болно. Бид энэхүү их хүч, агуу билиг ухааныг түшиглэж бясалгал дадуулахгүй бол өөр юуг түшиглэх билээ? Яагаад тэрхүү өчүүхэн жаахан харанхуй бүүдгэр хэвлий (*Наран сүлжээгээ заав.*), эсвэл мөнх бус амьсгалд тулгуурлан бясалгал дадуулна гэж? Хэрвээ бид бясалгах үеэрээ гэмтэх юм уу үхэж, амьсгалгүй болбол яаж бясалгал дадуулах болж байна вэ?

Бид тэр их хүчийг түшиглэн бясалгал дадуулвал бие гэмтэх, тэр ч байтугай алагдаж шархадсан ч хамаагүй. Учир нь бидний (сүнс) эзэн хэдийнээ энэхүү аялгуутай нэвтрэлцэж, нэгэнт туулан гэтлээд энэхүү бие цогцостой хамааралгүй болсон. Иймээс мэдээж үргэлжлүүлэн бясалгал дадуулж болно. Тэрээр бидний амьдралд байнга санаа тавьж, биднийг тасралтгүй дэвшүүлнэ. Тэгэхээр энэхүү агуу их, хамгийн өндөр дээд, язгуурын аялгууг түшиглэх ёстой бөгөөд өөр юуг ч түшиглэсэн бүгд буруу болно. Бүхний анхдагч энэхүү аялгуу нь биднээс өмнө, орчлонгийн түмэн бодис үүсэхээс өмнө нэгэнт оршиж байсан. Гурван ертөнц эвдрэн сүйрсний дараа ч мөн оршсоор байх болно. Энэхүү мөнхийн хүчийг түшиглэж, бясалгал дадуулвал үүрд оршин байх хэмжээнд хүрч чадна. Харин мөнх бус амьсгалыг түшиглэвэл зөвхөн мөнх бусын хэмжээнд хүртэл бясалгаж чадна.

“Баатараа явагч их хөлгөн судар”-т: “Аливаа бясалгалын аргаар бясалгал дадуулах нь түр зуур хэрэглэх төдий. Өнө мөнхийн бясалгалын арга биш. Гагцхүү Арьяабалын бясалгалын арга л өнө мөнхийн, хамгийн төгс, хамгийн зөв бясалгалын арга болно.” гэж Шагжамуни Будда айлджээ. Бид Арьяабалын аргаар дадуулан бясалгасны эцэст түүний үзэл бодолтой санал нэгдэнэ. Долоо хоногийн даяаны үеэр Багш нь зарим сүнслэг бясалгагчдад өөр нэгэн бясалгалын аргыг зааж өгчээ. Жишээ нь: нэг хүн энэ тэнд эвгүйрхээд байна гэхэд нь би хэвтүүлээд арав тэр ч байтугай зуун удаа гүн амьсгаа авахуулав. Тэрээр жаахан асуудалтай ч юм уу, эсвэл саад тотгортой байсан тул би энэ аргыг зааж өгч зовуурийг нь арилгасан. Энэ бол Багш нь өөр бясалгалын арга зааж буй хэрэг биш. Гэвч мэдэхгүй хүн бол өөр бясалгалын арга зааж байна гэж бодож магадгүй.

Өөр жишээ гэвэл, нэг чалчаа хүн үгээ цөөлөх арга байна уу? гэж Багшаас нь асуув. Би түүнд хэлний үзүүрээ тагнайдаа тулга гэж заасан. Энэ нь яриасаг хүнд зориулсан нэг зүйлийн хэрэглээ багатай дөхөм арга юм. Түүний асуудлыг шийдвэрлэсний дараа Арьяабалын аргаар бясалгал дадуулах болно. Үнэнийг хэлэхэд амьсгал авах гаргах, хэлний үзүүрээ тагнайдаа тулгах зэргийг бясалгалын арга гэж үзэж болохгүй. Эдгээр нь ердөө л энгийн хялбар арга.

Энэ нь хоол идэхдээ ширээн дээрээ шанцай, дүүфүү, гурилын ууураг тавьдагтай л адил. Зарим хүн цагаан хоол идэж эхэлж байгаа болохоор сайн дасаагүй тул чинжүү, жан, перец зэрэг амтлагч нэмбэл амттай болж мэдэх юм. Гэвч амтлагчийг хоол болгон идэж болохгүй. Үүний адил Арьяабалын бясалгалын аргаас бусад бясалгалын арга нь зөвхөн амтлагч төдий тул хоолны оронд идэж болохгүй.

Библид: “Орчлон ертөнц анхандаа аялгуу (word) байжээ. Энэхүү аялгуу нь Эзэн Бурхантай хамт байсан. Энэхүү аялгуу нь Эзэн Бурхан мөн. Түмэн бодис цөм энэхүү аялгуунаас үүссэн. Үүгээр бүтээгдээгүй нэг ч зүйл үгүй.” гэж дурджээ. (In the beginning was the word (sound), and the word was with God, and word was God, everything was made by this, and noth¬ing was not made by this) “Даодэжин”-д үүнтэй адил зүйлийг өгүүлдэг. Лууз хэлэхдээ: “Дао” нь өгүүлж болбол мөнхийн “Дао” бус, нэр нь нэрлэж болбол мөнхийн нэр бус. Хоосон хэмээгч нь тэнгэр газрын үүсэл, буй хэмээгч нь түмэн бодисын эх.” гэжээ. Энэхүү “Нэрлэж үл болох нэр.” буй болох үед орчлонгийн түмэн бодис бүтээгджээ.

“Упанишад” (Upanishad) бол энэтхэгийн шашны хамгийн

алдартай судар бөгөөд мөн л үүнтэй адил ёсыг өгүүлдэг. “In the beginning was the word”. “Аялгуу угаасаа л байсан”. Энэхүү аялгуунаас орчлонгийн түмэн бодис цөм буй болжээ. Энэ аялгуу бол Эзэн Бурхан мөн. Энэ аялгуу бол Бүтээгч мөн. Бүгд л адил зүйлийг өгүүлжээ. Шагжамуни Будда, Лууз, Библи, энэтхэгийн шашин, лалын шашинд нэг л учир ёсыг өгүүлдэг. Арьяабалын аргаар бясалгал дадуулсны дараа бусад ном судруудыг судалж үзвэл үүнийг ойлгоно.

Билиг ихээр нээгдсэний дараа шашин суртахуун нь өөр болохоос биш, ном судруудад нэг л ижил зүйлийг өгүүлдгийг мэдэж болно. Учир нь дараа дараагийн үеийнхэн сургаалын эзний сургаал номлолыг гуйвуулснаас шашны олон урсгалд хуваагджээ. Бурханы шашин, христийн шашин, лалын шашин цөм олон урсгалтай бөгөөд энэ хуваагдал нь бүгд эндүүрлээс үүдэлтэй. Жишээлбэл, Багш нь одоо Арьяабалын бясалгалын аргыг зааж байна. Энэхүү бясалгалын аргыг Формосад өөр хүмүүс, өөр багш зааж байгаагүй болохоор Багшийг нь буруу номтны бясалгалын аргыг зааж байна гэж хүмүүс бодож магадгүй.

“Авид бурханы судар”-т дурдсан “Маш далд, гүн нууцлаг” гэдгийн утга санааг хүмүүс ойлгохгүй байж магадгүй. Иймээс Багшийг нь яагаад Авид бурханыг дуудан залбирахыг заахгүй байгааг ойлгохгүйд хүрдэг ч, Багш нь чухамдаа Авид бурханыг дуудан залбирахыг зааж байдаг. Үүнийг та нар Арьяабалын аргаар бясалгал дадуулсны дараа ойлгоно. Багш нь өөр бясалгалын арга заагаагүй. Бурханыг дурсах бясалгалын арга, Арьяабалын бясалгалын арга, Очироорт бясалгалын арга бүгд адил. Ойлгоогүй үед өөр санагдана. Ойлгочихвол бүгд адил.

Шагжамуни Будда зөвхөн ганц л бясалгалын аргыг заасан. Бусад бясалгалын аргыг бид өөрсдөө гаргаж ирсэн. Иймээс Шагжамуни Буддаг нас нөгчсөний дараа олон урсгалд хуваагджээ. Будда ертөнцөөс ангижирсны дараа эрдэмт шавь нар нь олон газраар явж Арьяабалын бясалгалын аргыг уламжилсан байж мэднэ. Гэвч тэндхийн хүмүүс эгэл хүмүүсийн ярьдаг бурханы шашныг мэдэх төдий тул Буддагийн эрдэмт шавь нар очиж Арьяабалын бясалгалын аргыг заахад өөр өөр урсгалууд бий болжээ. Жишээ нь, Линьжигийн урсгал, Цаодүнгийн урсгал, Ариун орны урсгал, Тиэньтайн урсгал гэх мэт. Үнэндээ тэд бүгд ижил зүйлийг заан сургаж байсан. Би бүгдийг нь бясалгаж үзсэн тул үүнийг тодорхой мэдэж байна. Миний ярьсан бүхэн бүгд өөрийн биеэр туулж мэдэрсэн зүйлс юм. Өөр өөр бясалгалын аргуудад ямар ижил талууд байгааг Багш нь Пэнхүд нэгэнт ярьсан

болохоор энд дахиж нуршихгүй. Та нар сонсъё гэвэл Пэнхүд тайлсан номын бичлэгийг авч сонсоорой.

Асуулт: Маани, тарни унших нь тус нэмэртэй юу?

Их Багш: Тустай, гэвч тийм их биш. Маани, тарни унших нь ертөнцийн юмсыг уншихаас дээр. Учир нь хүний тархи бодолгүй болоход бэрх. Энгийн цагт эр нөхрөө, эхнэр хүүхдээ бодно. Нэр төр, ашиг хонжоо бодно, элдэв зүйлийн уйтгар бухимдал бодно. Анхаарлаа төвлөрүүлэн Бурханыг дурсвал ядаж л эгэл ертөнцийн зүйлсийг түр огоорч, оюун бодол чинь сэлүүхэн болох тул Бурханыг дурсах нь ертөнцийг дурссанаас дээр гэж хэлж буй хэрэг. Гэвч Бурханыг дурсахдаа "Сэтгэл"-ээрээ дурсах хэрэгтэй. Зөвхөн "Ам"-аараа дуудан уншиж болохгүй. Ингэвэл оюун ухаан чинь элдвийг бодсоор байх болно. Ингэж хэчнээн дурсаад нэмэргүй. Дурсах тусам улам төвөгтэй болно. (*Арьяабалын бясалгалын аргыг Багшаас сурахаас өмнө шүтдэг Бурхнаа дуудан залбирч болох уу*?) Мэдээж болно. Яагаад гэвэл түүнд сонголт байхгүй шүү дээ!

Асуулт: Ном судрыг дотроо унших, чангаар уншихын аль нь илүү вэ?

Их Багш: Чи аль дуртайгаараа л бол. Хэрэв ном судрын утгыг ойлгохгүй бол яаж ч уншсан нэмэргүй. (*Миний хэлэх гэж буй санаа бол би аялгуулан уншдаг боловч ойлгодоггүй. Хэрвээ дотроо уншвал санааг нь ойлгоход нэлээд хялбар байдаг*.) хэрэв дотроо унших нь ойлгоход амар байвал дотроо унш. Аялгуулан уншихад маш түргэн уншаад өнгөрдөг тул утгыг нь ухаж ойлгох чөлөө гардаггүй. Ном судрын утгыг ойлгох нь тустай ч, дотроо юм уу аялгуулан унших нь ач буянгүй. Зөвхөн уншдаг ч ойлгохгүй бол бас л ач буянгүй. Уншихад зөвхөн утга санааг нь ойлгох төдий. Бодитой ахуй ойлголт байхгүй.

Асуулт: Ном судар уншвал ач буянтай юу?

Их Багш: Нэг түүх ярьж өгье. Бодьдарма нэгэн номын багштай уулзаж гэнэ. Тэр багш "Нирваан судар"-ыг унших дуртай байжээ. Бодьдарма түүнээс: "Та энэ судрыг уншиж яах нь вэ?" гэсэнд тэрээр: "Үүнийг уншвал туулан гэтэлж Бурхан болно." гэхэд Бодьдарма: "Судраа нааш нь өгчих, шатаачихъя. Бин зураад өлөө дарах уу?" гэжээ. Энэ бол миний хариулт. Сэтгэл чинь ханав уу? Үүнийг би хэлээгүй, Бодьдарма хэлсэн. Би одоо өөрийнхөө ахуй ойлголтыг ярихаас айдаг болсон.

Асуулт: Төгс Гэгээрсэн Их Багшаа, ном судрыг чангаар аялгуулан унших нь ач буянгүй юм бол гадуур олон хүн ингэж

уншиж байгааг юу гэх вэ?

Их Багш: Тэднийг ном судраа битгий унш гээгүй, уншиж л байг. Битгий унш гэж хэлж зүрхлэхгүй. Үнэндээ бол хэлээд ч нэмэргүй! Энд тавь, жархан хүн байна. Гадуур бол тав, зургаан сая хүн өдөр бүр ном судар уншицгааж байна. Нэг бүрчлэн очиж хэлэх бололцоогүй, ингэх сонирхол ч алга. Унших эсэх нь тэдний хэрэг. Дэлхий дахин угаас амгалан гэдэг. Би бясалгалаа дадуулж өөрийнхөө юманд л анхаарна. Харин асуувал хэлж өгнө. Асуухгүй бол хэлэхгүй.

Ном судар унших нь "би чамд хайртай, чи надад хайртай." гэж дуулснаас л дээр. Яагаад уншиж болохгүй гэж? (*Бүгдээрээ инээв*.) Үлгэр тууж уншсанаас дээр! Ном уншихыг би сайшааж байна. Ядаж л тэд Бурханы бодож, номыг бодож, хуврагийг бодож, бүрмөсөн мартаагүй байна. Тэд хэдийгээр сайн бясалгалын аргыг олж чадаагүй ч бүрмөсөн марталгүй, бага ч гэсэн санасан хэвээр байна. Хэрвээ ном судар уншихгүй бол цаг завтай үедээ сайн үйл хийхгүй элдвийг ярьсаар байх болно. Учир нь бидний ам чалчих дуртай! Тиймээс ном судар унших нь тустай. Гэртээ хариад ядарсандаа болоод бусдын энэ тэр явдлыг ярьж чадахгүй. (*Бүгдээрээ инээв*.)

Асуулт: Маани, тарни уншсаар байгаад уншаагүй үед ч бурханы аялгуу сонсогдоод байдаг болсон. Энэ сайн уу, муу юу?

Их Багш: Сайн ч биш, муу ч биш. Чи дууны хуурцаг болчихсон байна Бидний бие эрхтэн сонссоор байгаад чинээндээ тултал дүүрч, бялхан хальсан байна. Энэ нь аягатай адил. Их ус хийвэл бялхан асгарна. Бурханы дурсан уншсаар дэндүү дүүрвэл дууны хуурцаг болж хувирна. Тэгвэл хуурцаг худалдаж авах шаардлагагүй болж, бага сага мөнгө хэмнэж болно. (*Бүгд инээв*.)

Асуулт: "Гурван хор"-ын алийг нь таслахад хамгийн хэцүү вэ?

Их Багш: Хүн болгонд адилгүй байдаг. Зарим хүн нэлээд шуналтай, зарим нь нэлээд хилэнтэй, зарим нь нэлээд мунхаг. (*Багшийн туршлагаар бол аль нь вэ?*) Миний хувьд энэ гурвыг гурвуулыг нь таслахад бэрх. Би хамгаас шуналтай, хамгаас хилэнтэй, хамгаас мунхаг. Хамгийн дээд зүйлд шунана. Бүхий л орчлон хорвоод шунана. Би Бурхан болмоор байна. (*Бүгд алга ташив*.) Би их ууртай. Хамаг амьтны нэн мунхгийг хараад, тэдэнд энэхүү эрдэнэс, хүч чадал байгаа ч хэрэглэж чадахгүй байгааг хараад үнэхээр уурладаг! Тиймээс би уураа хаяж чаддаггүй. Би тун мунхаг. Учир нь энэхүү "Дао"-д шунаад одоо буцалтгүй

болжээ. Улам л дээшлэхээс биш эргэж буцахаасаа өнгөрсөн. Чи нэг эмэгтэйд татагдлаа гэхэд нэг л өдөр сэхээрч магад. Жишээ нь, чи нэг эмэгтэйд дурлалаа гэхэд хөгшрөөд зүс царай нь гундвал дурлахаа болино. Гэтэл би "Бурханы зам мөр"-д шунаж, өнө үүрд сэхээрч чадахгүй болоод ямар ч хүн намайг буцахыг ятган сэнхрүүлж дөнгөхгүй болсон тул Багшийнх нь шунал, хилэн, мунхгийг таслахад тун бэрх. (*Бүгд дахин алга ташив.*)

Асуулт: Ном судар унших нь Бурхан болоход нэмэргүй ч хүн, тэнгэрийн буян хишигтэй болоход тустай юу?

Их Багш: Ном судар унших нь үлгэр тууж уншсанаас дээр гэж би сая хэлсэн. Үүнийг буян хишигтэйд тооцож болно! Хэрвээ чи ахиухан буянтай болохыг хүсэж байгаа бол ном судар уншаад илүү их буянтай болох эсэхийг би мэдэхгүй. Үүнийг Бодьдарма Шагжамуни Буддагаас асуу. Уншиж болно, энэ бол сайн.

Асуулт: Миний уншсан номд, нэг хүн аюул зовлон тохиолдоход "Авид бурханы судар"-ыг уншдаг байжээ. Нэг удаа түүнийг уншсаны ачаар араас нь нэхэн хөөж байсан цэргээс зайлж чадсан гэнэ. Яагаад тэр хүн судар уншаад зовлонгоосоо зайлсан юм бол?

Их Багш: Тэр судар уншсаны ачаар аюулаас зайлж гарсан уу?, буян хишгээсээ болсон уу?, эсвэл тухайн үед цэргүүд түүнийг харалгүй өнгөрсөн үү? гэдгийг би мэдэхгүй. Хэрэв итгэж байгаа бол чи ч бас судар уншиж болно. Судар унших нь их сайн. Гэвч буянтай эсэхийг би хэлж чадахгүй. Чи үүнийг анхаарах хэрэггүй. Буянтай гэж бодвол зөвхөн хүн, тэнгэрийн буян төдий л юм. Тун бага, өчүүхэн буян учраас хангалтгүй. Би хамгаас шунахай тул энэхүү өчүүхэн буян миний хувьд байхгүйтэй адил. Би хэдийгээр байхгүй гэж буй боловч үнэн хэрэгтээ жаахан бий л дээ! Чи судраа үргэлжлүүлэн уншаарай! (*Бүгд инээв.*) Ном унших нь их сайн! Ядаж л Бурханы юу хэлснийг тогтооно. Бурханы хэлсэн нь ертөнцийн хүний хэлж байгаагаас сайн тул бидний оюун ухаанд сайн нөлөө, сайн үзэл бодол, сайн үзэл санааг өгнө.

Асуулт:"Хотол зохилдогч зүйл"-ээр Лууз, Күнзийн үзэл санааг тайлбарлаж болох уу?

Их Багш: Болно. Даогийн сургаалтанд "Хотол зохилдогч зүйл"-ийг Луузын үзэл санаагаар тайлбарлаж, Бурханы шашинтанд бол "Хотол зохилдогч зүйл"-ээр Луузын үзэл санааг тайлбарлаж болно. Ялгаа зөрүү байхгүй. Гэвч заавал бүрэн төгс ойлгож байж эргэлзээгүй болно. Эс бөгөөс эмх цэгцгүй яривал

хүмүүс чамайг асуултаар шахаж, элдвийн асуудал үүсгэнэ. Иймээс бүрэн ойлгосны дараа хүмүүст хэлж өгч болно. Жишээлбэл, өнөөдөр ном судар цөм адил гэж Багшийнхаа ярьсныг сонсоод, харингуутаа гэрийнхэндээ ярьж өгвөл тэд олон асуулт асуух болно. Чи жинхэнэ бодитоор мэдэрсэн юмгүй болохоор саадтай тулж хариулж чадахгүйд хүрнэ.

Асуулт: Даогийн шашинтан эсвэл Христийн шашинтны аль нь ч бясалгал дадал нь өндөр түвшинд хүрвэл Бурханы шашны ном судруудын агуулгыг ойлгож чадах уу?

Их Багш: Хэрэв бясалгал дадал нь өндөр түвшинд хүрсэн бол мэдээж чадна. Үнэндээ Бурханы шашин угаас байгаагүй. Шагжамуни Буддаг залрахаас өмнө Бурханы шашин хаана байсан бэ? Хаа сайгүй байсан. Бурхан гэж хэн бэ? Билиг нь бүрэн нээгдсэн хүнийг Бурхан гэдэг. Иймээс билиг нь бүрэн нээгдсэн Луузын шашинтныг (Бумбын шашинтыг хэлж байна.) Бурхан гэж бас нэрлэж болно. Сайн бөгөөд ёс суртахуунтай бясалгагч байж чадвал бүгд Бурханы шашинтан мөн. Заавал номын нэр авч, номын багшаас сахил хүртэж дагавал Бурханы шашинтан болчих юм биш. Бурханы шашны агуулга ийм явцуу биш, өргөн дэлгэр. Луузын шашин, Христийн шашны агуулга ч мөн өргөн дэлгэр. Бид өөрсдөө шашин суртахууныг явцууруулсан бөгөөд энэ нь бидний алдаа юм. Сургаалын Эзний уг санаа огт тийм биш байсан.

Асуулт: Багшийн хэлсэн "Аялгуу" нь бидний энгийн үед сонсдог дуу аялгуу шиг тийм тодорхой байдаг уу?

Их Багш: Адилгүй. Энэ аялгууг ном уламжлуулснаар сонсож болно. Энгийн хүн сонсохгүй.

Асуулт: Гэрээс гараагүй хүн энэ бясалгалын аргаар бясалгал дадуулж болох уу?

Их Багш: Болно. Шагжамуни Будда гэрээс гараагүй олон шавьтай байсан. "Баатараа явагч их хөлгөн судар"-т хорин таван Бодьсадва дадал бясалгалынхаа ахуй ойлголтоо бичсэн байдаг. Тэдьий ярьсан зүйлийн ихэнх нь гэртээ бясалгал дадуулж байх үеийн ахуй ойлголт юм. Гэрээс гараагүй хүн энэ бясалгалын аргаар бүр ч илүү бясалгал дадуулах хэрэгтэй.

Асуулт: Сүнслэг дадал бясалгал хийх замаар үйл түйтгэрээ арилгаж болох уу? Эсвэл өвчин болж хувирснаар арилах уу?

Их Багш: Бясалгалыг сайн дадуулдаг хүн бол үйл түйтгэрийг арилгаж чадна. Хэрвээ бясалгал хийдэггүй бол өвдсөн ч арилахгүй. Учир нь ганц удаагийн өвчин тийм их үйл түйтгэрийг төлж

дуусгаж чадахгүй. Нүгэл хилэнцийн хагасыг самадийн галаар шатаавал нэлээд хурдан арилдаг. Арьяабалын аргаар бясалгал дадуулвал үйл түйтгэр маш хурдан арилна. Яагаад гэвэл Багш нь үйл түйтгэрийн чинь хагасыг үүрдэг учраас тэр.

Асуулт: Их Багш ном уламжилснаар Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх үү? Хэрэв багштай учрахгүй бол хэзээ ч бясалгал дадуулах боломжгүй юу?

Их Багш: Тийм. Жинхэнэ багштай учирч чадахгүй бол бясалгах аргагүй. Хааяа бага сага аялгуу сонсож магадгүй. Гэвч энэ нь чухам юу болохыг та нар мэдэхгүй. Маргааш нь сонсъё гэвэл огт сонсогдохгүй байж мэднэ. Харин ном уламжилсны дараа үүрд аялгуутай байх болно.

Асуулт: Багш ном уламжлахад ямар нөхцөл, дүрэм журамтай вэ?

Их Багш: Одоогоос эхлээд цагаан хоол идвэл болно. Энэ хүнээс (*Багш өөрийгөө заав.*) сахил хүртэж дагахгүй. Харин тэрхүү аялгуу, тэр их хүч буюу уг дүрээс сахил хүртэж дагана. Багш нь зөвхөн чамд яаж бясалгал хийхийг зааж өгнө. Тиймээс дүрэм журам гэхээр юм байхгүй. Би та нарыг шавиа болгоё гээгүй бас та нараар тахин шүтүүлье ч гээгүй. Багш нь энэ бясалгалын аргыг мэдэх болохоор хэлж өгье гэсэн юм. Бясалгал дадлыг жинхэнэ ёсоор хийе гэвэл зөвхөн өөртөө л түшиглэх хэрэгтэй. Зарим хүн номын багшаас сахил хүртэн дагаад үүрд түүнийх болж холдож чадахаа больдог. Бусад бясалгалын аргыг суръя гэсэн ч болдоггүй. Энэ нь баригдаж хүлүүлсэнтэй адил тул би ингэж сахил хүртэн дагахыг сонсох ч дургүй. Хэрэгтэй гэж үзвэл би чамд ном уламжилж өгнө. Чамайг өөрийн эд хөрөнгөө уудлан гаргаж, өөрөө хэрэглэдэг болгоно. Эдгээр юмс чамд угаасаа байсан. Би чамд юу ч өгч чадахгүй. Багш нь зөвхөн чамд туслан билгийг чинь нээж, уг хүчтэй чинь холбож өгнө. Орчлон ертөнцийн хүчтэй, угийн хэлбэлзлийн хүчтэй холбоно. Барагдашгүй их баялгийг чи өөрөө эзэмших болно. Тиймээс Багшаасаа сахил хүртэж дагах хэрэггүй. Энэхүү эгэл хүнийг дагах огтхон ч хэрэггүй.

Асуулт: Арьяабалын аргаар дадал бясалгал хийх гэж байгаа хүн заавал цагаан хоол идэх хэрэгтэй гэж Багш сая ярьсан. Гэтэл бид эгэл ертөнцөд амьдарч байгаа учраас бодит амьдралтай зохицохын тулд цагаан хоол идэх аргагүй бол яах вэ?

Их Багш: Шалтаг эрж болохгүй. Хамаг амьтны зовлон шаналлыг хайхралгүй махыг нь иддэг хүн яаж Бодьсадва болох вэ? Чи цагаан хоол идэж чадахгүй бол надад ямар ч арга байхгүй.

Би иймэрхүү асуултад хариулах дургүй. Хамаг амьтныг гэтэлгэе гэсэн сэтгэл үүсгэсэн бол зарим идээ ундаанаас татгалзаж, багахан саад бэрхшээлийг давах хэрэгтэй. Одоо энд тэндгүй ногоон хоолны газар байна. Эсвэл жаахан дүүфүү, гурилын ууураг олж аваад чанаж идсэн ч болно. Энэ бүхэн шалихгүй зүйл шүү дээ. Энэтхэгт хүн амын талаас илүү нь цагаан хоол идэж байна. Тэнд дүүфүү, гурилын ууураг байхгүй болохоор буурцгийн зүйлийг чанаад хоолтойгоо иддэг. Ямар ч асуудал гардаггүй.

Асуулт: Багшийн хэлсэн Арьяабалын бясалгалын арга гэдэг нь "Баатараа явагч их хөлгөн судар"-т дурдсан Төгөлдөр нэвтэрхий бясалгалын аргатай адил уу?

Их Багш: Адилхан. Гэвч "Баатараа явагч их хөлгөн судар"-т Арьяабалын аргаар яаж бясалгал дадуулахыг дурдаагүй, зөвхөн түүнийг магтан сайшаасан байдаг. Арьяабалын аргаар дадуулан бясалгахыг хүсвэл чамд заах нэгэн багшийг заавал хайж олоод түүнээс сурах хэрэгтэй.

Асуулт: Багшид уламжлан залгамжлуулсан Их Багш байна уу?

Их Багш: Байдаг. Шагжамуни Буддагаас эхлээд тасралтгүй уламжлан залгамжилсаар ирсэн.

Асуулт: Багшийн багш хаанахын хүн бэ?

Их Багш: Энэтхэгийнх. Ау Лакт ч бас бий. Ау Лакт Арьяабалын аргаар дадал бясалгал хийдэг хүн маш олон байдаг.

Асуулт: Шавийн маань ээж үр хөндүүлсэн гэнэ. Одоо яавал зохих вэ?

Их Багш: Нэгэнт хөндүүлчихсэн юм бол одоо энэ талаар яриад яах вэ? (*Ингэсэн тохиолдолд уул усанд идээ будаа өргөх, хурал ном хурвал тустай юу?*) Чи хүн хөнөөчихөөд цагдаад очиж гэмээ наманчлах нь тус нэмэртэй юү? Цагдаа чамайг аврах уу? Ерөнхийлөгчид эсвэл шүүгчид гэмээ наманчилсан ч нэмэргүй. Тэд чамайг баривчлаад гянданд хорино. Ингэснээр чамайг аварч үйл түйтгэрийг чинь төлүүлж байгаа хэрэг. Уул усанд идээ будаа өргөж, хурал ном хураад ямар хэрэг байх вэ? Эгэл хүний сэтгэлээр гэмшээд үйл түйтгэрийг яаж арилгаж чадах вэ? Эгэл хүний сэтгэл угаас мунхаг харанхуй тул бохир усаар бохир юмыг яаж ч угаасан цэвэр болохгүй.

Асуулт: Шагжамуни Будда ч гэсэн хатуу аргаар бясалгал хийж байсан. Гэтэл Багш яагаад ингэх хэрэггүй гэж байгаа юм бэ?

Их Багш: Шагжамуни Будда хатуу аргаар дадуулан бясалгаад ингэж бясалгах нь хэрэггүй, өчүүхэн ч утга учиргүй болохыг ойлгожээ. Тэрээр үхлийн ирмэгт тулаад сэхмэгцээ гэмшиж юм идсэн. Сүү ууж, жигнэмэг идээд бие нь аажмаар тэнхэрчээ. Багш нь зориуд хатуу аргаар бясалгал дадуулаад иймэ туранхай болсон юм биш. Би идэж уух дургүй байсан. Жирийн үед тун бага иддэг. Заримдаа үдийн хоолоо ч идэх дургүй байсан. Хоол идэх нь буцалгасан ус уухтай адил ямар ч амтгүй санагддаг ч, энэхүү биеэ тэсэхгүй болчих вий гээд хүчээр жаахан иддэг байсан.

Асуулт: Бид бясалгал дадуулах явцдаа энгийн хүн шиг их хооллох сэтгэлийн ханамж авахыг хүсэж болохгүй юу?

Их Багш: Сэтгэлийн ханамж эдэлчихээр юу байх вэ дээ. Өдөрт гурван удаа хооллох нь үнэндээ ихдэж байна. Бидний ходоод хэмжээтэй. Ахиухан идье гэсэн ч багтаахгүй. Хувцас хунарын тухайд гэвэл нэг удаа хамгийн ихдээ хоёр, гурвыг л өмсөж чадна. Аливаа юмс үзэгдэлд төв дундыг баривал сайн. Арьяабалын аргаар дадуулан бясалгаад өндөр түвшинд хүрсэн бол хүн чамд юу ч өгсөн авахгүй. Мөнгө төгрөг өгсөн ч авахгүй. Юу байна, түүнийгээ хэрэглэнэ. Шуналын сэтгэлгүй болно. Хэрэв чамд мах идүүлбэл хамаг бие чинь эвгүйрхэн гэдэс чинь өвдөж, бөөлжих тул дахиж идмээргүй болно.

Асуулт: Багшийн түвшинд очоод ном судар уншихад ямар мэдрэмж төрдөг вэ?

Их Багш: Би багаасаа ном судар уншсаар байгаад бүгдийг цээжилчих шахсан. Миний хувьд ном судар унших нь лавлагаа болдог тул хэрэг болох нь бий. Жишээ нь, бясалгал дадлыг хэрхэн яаж хийвэл сая зөв оновчтой болохыг Багш нь Есүс Христ, Шагжамуни Буддагийн үгээр баримт нотолгоо болгож ярихгүй бол та нар итгэхгүй. Би хэн билээ? Дөнгөж ном дэлгэрүүлж эхэлж байгаа, тэгээд ч ийм залуухан болохоор юу ч ярьсан хүмүүс амархан итгэдэггүй. Тиймээс “Баатараа явагч их хөлгөн судар”, Библи эсвэл Луузын сургаалаас эш баримт болговол та нар итгэнэ. Өмнөх үеийн их бясалгалтнуудад илүү итгэдэг нь бидний зуршил. Яг одоо амьд Бодьсадва өмнө чинь зогсож байвал та хүндэтгэхгүйгээр барахгүй түүнд огтхон ч итгэхгүй.

Асуулт:Багшийн уншдаг ном судрууд ямар хэлээр бичигдсэн бэ?

Их Багш: Би ямар ч хэлээр уншина. Энэ чамд ямар хамаатай юм бэ? (*Бүгд инээв.*) “Баатараа явагч их хөлгөн судар”-ын хятад

орчуулга хүнд болохоор Багшийг бараг ойлгохгүй байх гэж тааварласан юм. Би Ау Лак хэлээр үзэж болохгүй гэж үү? (*Бүгд инээв*.) “Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”, “Баатараа явагч их хөлгөн судар”-т би их дуртай. Их Багш сэнхрүүлж өгнө үү? “Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”-ыг яаж одоо тайлах вэ? Цаг байхгүй болохоор дараа тайлж өгье.

Асуулт: “Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”-ын “Номын багшийн эрдмийн зүйл”-д аялгууны тухай дурдсан байдаг. Их Багшаас сэнхрүүлж өгөхийг хүсье.

Их Багш: “Номын багшийн эрдмийн зүйл”-ээс гадна “Хотол зохилдогч зүйл”-д бас “Эсэрваагийн эгшиг, далайн түрлэгийн чимээ, Чанагуух ертөнцийн ялгуусан дуу”-г дурдаж байсан. “Номын багшийн эрдмийн зүйл”-д номын багшийн бясалгал дадлын хэмжээ нэгэнт “Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”-ыг тайлах түвшинд хүрсэн бол найман зуун хамрын эрдэм, мянга хоёр зуун чихний эрдэм, найман зуун нүдний эрдэм бүрэлдсэн байдаг гэжээ. Энэ эрдмээ ашиглан тэрээр эгэл хүний чихээрээ Эсэрваа тэнгэрийн болон эрлэг тамын дууг сонсоно. Бас хонхны дуу, хэнгэргийн дуу, далайн түрлэгийн чимээ, гадаад орчны дуу чимээ, дотоодын аялгууг сонсоно. Бүхий л дуу аялгууг бүгдийг сонсоно. Дотоодын аялгуу гэдэг нь чухам ямар утгатай вэ? Энэ нь “Хотол зохилдогч зүйл”-д өгүүлсэн чанагуух ертөнцийн ялгуусан дуу болно. “Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар” маш урт болохоор хэрэгтэй бол дараа тайлж өгье.

АЛИВАА СҮНСЛЭГ ДАДАЛ БЯСАЛГАЛЫН АРГА БҮГД АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА МӨН

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
айлдвар. Формосагийн Пэнху.
1987 оны 2 дугаар сарын 12
(Эх нь хятад хэлээр)

Өнөөдөр “Очироор огтлогч судар” (Diamond sutra)-ыг тайлна. Судар бүхэн “Очироор огтлогч” судар. “Очироор огтлогч судар” нь “Очироор огтлогч судар” биш. Гэвч тайлахад үгээр ярих шаардлагатай тул “Очироор огтлогч судар” гэж нэрлэжээ.

Нэг удаа Багш нь хүнд ном уламжлав. Тэрээр ад шүглэсэн байдалтай байв. Ад шүглэхэд ямар байдгийг та нар мэдэх үү? Хэрвээ тухайн хүний бясалгал дадал тааруухан, өөрийн дураар замбараагүй бясалгасан, эсвэл сайн Багш, сайн бясалгалын аргатай учраагүй, сэтгэлээ цэвэр ариун байлгаж чадаагүй зэргээс болж ад шүглэдэг байна. Ад шүглэх гэдэг нь хэдийгээр бие махбод нь өөрийнх боловч түүний сүнсийг нь ад хөөж гаргаад, биеийг нь ашиглан элдэв зүйлийн замбараагүй явдал хийлгэхийг хэлнэ. Энэ үед тухайн хүн ямар нэг гарын чагж, хөлийн чагж болон толгойн чагж хийн, эсвэл элдэв хачин юм ярьж, чихэнд нь хүн шивнэх шиг болж ингэ тэг гэх мэтээр зааварлан, биеэ авч яваа байдал нь ердийн хүнтэй адилгүй болдог. Ад түүнийг албадаж ямар нэг зүйл хийлгэхэд биеэ хянаж чаддаггүй. Тиймээс заримдаа үг яриа нь орон гаран болж, юу ярьж байгаагаа өөрөө ч мэддэггүй. Энэ нь адад эзлэгдсэнийг харуулж байна.

Нэг өдөр Багш нь ийм ад шүглэсэн хүнд ном уламжлав. Багш нь ном уламжилъя ч гэсэн юм биш, намайг мэдээгүй байхад хамтран бясалгагч маань найзыгаа дагуулаад ирсэн юм. Багш нь шавь нараа хамтран бясалгагч гэж дууддаг. Учир нь Багштай нь хамт нэг бясалгалын аргаар дадуулан бясалгадаг тул хамтран

бясалгагч гэдэг.

Түүний найз нь ад шүглээд нэлээд хэдэн жил болсон болохоор дагуулж ирээд Багшид нь танилцуулав. Багшийнх нь шавь учраас түүний төлөө ад шүглэсэн найзад нь ном уламжилж өгсөн. Хэдийгээр ад шүглээд олон жил болсон ч тун сайн хүн байв. Цагаан хоол иднэ, Буддаг шүтнэ, маани мэгзэм уншиж бас бясалгаж, туулан гэтлэхийг хүсэж байв. Гэвч урьд нь тааруухан бясалгалын аргаар бясалгал дадуулж байсан, эсвэл сайн багш олдсонгүй юу ийм хүн болжээ.

Багш нь түүнд ном уламжлах үед олон ад нэгэн зэрэг гүйн гарсан. Энэ эмэгтэйн гадаад төрхийг харахад зүв зүгээр. Анх удаа уулзахад ад шүглэсэн гэж мэдэгдэхгүй. Жирийн үед үг яриа нь хүнээс ялгарах юмгүй. Гэвч авшиг хүртэх үеэр олон ад гүйн гарч ирээд хоорондоо сүрхий тулалдав. Тэр үед цуг байсан хамтран бясалгагчид ихэд айцгаасан. Учир нь ад гарч ирэх үед тэр эмэгтэй энгийн хүнтэй адилгүй болж, нүүр царайных нь хэлбэр өөрчлөгдөөд, үзэшгүй муухай болов. Адуудын нэгнийх нь дуу нохой хуцаж байгаа мэт, заримынх нь арслан архирах шиг, сонсоход тун бэрх. Тэдний зарим нь кэжя (Формоса) аялгаар, зарим нь хятадын эх газрын аялгаар ярина. Гэтэл тэр эмэгтэй угаасаа кэжя аялгаар ярьдаггүй.

Багш нь түүнийг ариун нэрээ унш гэхэд уншиж зүрхлэхгүй атлаа Авид бурханы тарнийг уншдаг. Харин Багшийнх нь уламжилсан бясалгалын аргын тарнийг бол уншихыг хүсэх ч үгүй, чадах ч үгүй. Түүнийг хүчээр уншуулахад дуу хоолой нь бүрмөсөн өөрчлөгдөж хажууд байсан хамтран бясалгагчдыг ихэд эвгүйцүүлэв. Зарим адын уншиж байгаа нь нохой хуцаж буй мэт. Зарим нь нэлээд сайхан сэтгэлтэй. Бусад адаа загнан зандарч: “Бүү ингэ, сайн унш. Энэ бол маш сайн номын багш шүү. Заавал мөргө.” гэнэ. Тэр өдрийн ном уламжилсан явдал хөөр хөгжөөнтэй цайллага дайллага шиг байв. Нэг нь бусад адууддаа: “Энэ Их Багшийг би хүндэтгэн дагахгүй. Гэвч түүнд Очироорт бясалгалын арга байгаа учраас өмнө нь мэхийн хүндэтгэж, зарлигийг нь дагах ёстой.” гэв. Ад чөтгөрүүд тун айхавтар, Багшийнх нь байгаа газарт хүртэл ном хурж байна.

Яагаад энэ түүхийг ярьж байна вэ? гэвэл Багш нь угаас иймэрхүү зүйл ярих дургүй. Эс бөгөөс та нар ад шүглэсэн олон хүнийг Багш дээрээ авчирч төвөг удна. Үүнд би дургүй. Шуудхан хэлэхэд тэднийг аврах их төвөгтэй, амаргүй. Маш их хүч зарцуулах хэрэг гарна. Зарим үед жирийн хүнийг аварч чадахгүй байхад ад шүглэсэн хүнийг бол ярилтгүй. Ойлгож байна уу? Жирийн хүмүүс

Багшийнх нь үгийг сонсохгүй байхад ад шүглэсэн хүн тэднээс ч илүү саад тотгортой. Багшийнх нь үгэнд бүр ч итгэхгүй.

Багш нь ямар учраас энэ түүхийг ярьж байна вэ? гэвэл бясалгалын арга бүхэн "Очироор огтлогч судар" мөн гэж би түрүүн хэлсэн. Аливаа бясалгалын арга бүхэн Очироорт бясалгалын арга мөн гэж Шагжамуни Будда ч бас хэлж байжээ. Энэхүү ад ч бас Очироорт бясалгалын аргыг мэдэж байна. Очироорт бясалгалын арга нь чухамдаа Арьяабалын бясалгалын арга юм. "Очироор огтлогч судар"-т Будда: "Очироорт бясалгалын аргаар заавал сүнслэг дадал бясалгал хийх хэрэгтэй." гэж Субхутид хэлж байсан ч бусдад нь Арьяабалын бясалгалын арга гэж хэлж байжээ. "Хотол зохилдогч зүйл"-д бол Хотол гэтэлгэгч бясалгалын арга болно. Ариун орны урсгалын "Авид бурханы судар"-т бол Авид бурхан эсвэл Ариун орны бясалгалын арга болно. "Зургаадугаар үеийн Их Багшийн мандалт судар"-т бол Их билиг барамид бясалгалын арга болно гэж Багш нь өчигдөр тайлсан. Яагаад ингэж хэлж байгаагаа удахгүй та нарт тайлбарлаж өгье.

Өчигдөр "Авид бурханы судар"-т аялгууг мөн дурдсан бөгөөд дотоодын гайхамшигт аялгуу хөгжим гэж Багшийнхаа тайлсныг санаж байна уу?. "Баатараа явагч их хөлгөн судар"-т энэхүү аялгуу ажих, дуу аялгуу ажихыг ярьж байсан. Хорин таван Бодьсадва өөрсдийн билиг нээгдэх үед сонссон аялгууны талаар ярьсан. "Хотол зохилдогч зүйл"-д "Эсэрваагийн эгшиг, далайн түрлэгийн чимээ, "Чанагуух ертөнцийн ялгуусан дуу"-г дурдаж байсан. Хэрэв Шагжамуни Будда гаднах далайн түрлэгийн чимээг хэлсэн бол Пэнхүгийн хүмүүс бүгд хэдийнээ билиг нь нээгдчихсэн. (*Бүгд инээв.*) Учир нь та нар өдөр болгон далайн түрлэгийн чимээг сонсож байдаг. Тийм үү? Шагжамуни Будда мэдээж ийм утгаар яриагүй.

Далайн түрлэгийн чимээ гэж гадаад ертөнцийн далайн түрлэгийн дууг хэлж байгаа юм бол эсэрваагийн эгшиг гэдэг нь чухам юу вэ? Яавал түүнийг сонсох вэ? Уулнаас эрэх үү? Эсвэл далайн хөвөөнөөс хайх уу? Хаанаас ч эрж олохгүй. Эсэрваа гэдэг нь самгарди хэлний үг. Самгарди хэл нь энэтхэг хэл. Тийм юм бол бид Энэтхэгт очоод самгарди хэл сонсвол билиг нээгдчих биш үү? Мэдээж үгүй. Тэгэхээр эдгээр нь бүгд буруу ташаа тул чухам аль нь Чанагуух ертөнцийн ялгуусан дуу байх вэ? Түүнийг хаанаас хайж олох вэ? Хаанаас олж сонсох вэ?

Шагжамуни Буддагийн ярьсан зүйл бол дотоодын аялгуу, билиг нээх аялгуу, Бурханы аялгуу болно. Энэ бол Арьяабал бодьсадвагийн бясалгал дадуулсан арга учраас гадаад ертөнцийн

энгийн аялгуу биш. Тиймээс “Чанагуух ертөнцийн ялгуусан дуу” гэжээ. Энэ бол эхний баталгаа. “Хотол зохилдогч зүйл”, “Авид бурханы судар”, “Билиг барамид судар”, “Баатараа явагч их хөлгөн судар”-т бүгд нэг утга санааг өгүүлснийг одоо Багш нь та нарт ойлгуулах хэрэгтэй байна.

Яагаад гэвэл “Баатараа явагч их хөлгөн судар” нь “Баатараа явагч их хөлгөн судар” биш, зөвхөн танилцуулга төдий, жинхэнэ “Баатараа явагч их хөлгөн судар” биш. “Очироор огтлогч судар” нь жинхэнэ “Очироор огтлогч судар” биш. Жинхэнэ “Очироор огтлогч судар” нь гагцхүү ном уламжлах үед л байна. Багш нь яагаад ингэж ярьж байна вэ? Учир нь зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн “Очироор огтлогч судар”-ыг анх сонсоод билиг нь нээгдсэн боловч тавдугаар үеийн Их Багш Хүн Рэнг дээр очиж, Түүгээр Очироорт бясалгалын аргыг уламжлуулжээ.

“Очироор огтлогч судар” болоод Очирт бясалгалын арга адилгүй. Жишээлбэл, Багш нь жигнэмэг сурталчлахдаа: “Энэ жигнэмэг хамгийн сайн, эрүүл мэндэд тустай. Бас амттай, дээд зэргийн чанартай ч үнэтэй тул жирийн хүн авч чадахгүй.” гэнэ. Багшийнхаа энэ яриаг магнитофонд бичиж авааД гэртээ сонсвол, зөвхөн жигнэмгийн тухай ярихыг сонсохоос жинхэнэ жигнэмгийг амталж чадахгүй. Та нар жигнэмэг, жигнэмэг гэж хэчнээн давтаад ч жигнэмэг гэж юу болохыг мэдэхгүй. Хэрэв ойлгоогүй бол миний хэлснийг л жигнэмэг гэж бодно. Гэвч жигнэмгийг бүгд мэддэг болохоор ялган таньж чадна.

“Маш далд, гүн нууцлаг ном”-ыг бид ойлгодоггүй. Шагжамуни Будда таалал төгсөөд хоёр мянга таван зуун жил болж байна. Бид Түүнээс асуух аргагүй. “Очироор огтлогч судар” бүхнийг агуулсан тул түүнийг уншихад болно гэж боддог. Тийм биш. “Очироор огтлогч судар” нь “Очироор огтлогч судар” биш. Хүний хэлээр бичигдсэн бол жинхэнэ судар биш. Нүдээр харж болдог бол жинхэнэ судар биш, чихээр сонсож болдог бол жинхэнэ судар биш.

Төгс Гэгээрсэн Их Багш ном уламжилснаар л жинхэнэ “Очироор огтлогч судар”-ыг олж авна. Төгс Гэгээрсэн Их Багш ном уламжилснаар л жинхэнэ “Их билиг барамид судар”-ыг ойлгоно. Төгс Гэгээрсэн Их Багш ном уламжилснаар л жинхэнэ “Хотол зохилдогч зүйл”-ийг сонсож чадна. Их Багш ном уламжилснаар л жинхэнэ “Авид бурханы судар”-ыг биеэрээ мэдэрнэ.

Өнөөдөр ном тайлахгүй байсан нь дээр гэж Багш нь бодож байсан. Учир нь ойлгож мэдсэн бүхнээ та нарт хэлж өгөх аргагүй. Үнэхээр тийм. Багш нь ном тайлах үеэр толгойгоо сэгсэрч байсан нь

мэдсэн зүйлээ яаж яривал та нарт ойлгуулах вэ? гэдгээ эргэцүүлж байсан юм. Үнэхээр хэцүү! Гэвч зүйрлүүлэн хэлж болно. Жишээ нь, ус гэдэг үгийг янз бүрээр нэрлэдэг. Формосагийн нутгийн аялгаар, хятад, франц, герман, англи, испаниар гэх мэт. Хэрэв Багш нь герман хүнтэй уулзвал Wasser, франц хүнд бол L'eаи, Англи хүнд Water гэж хэлэх ёстой. Хятад хүнтэй тааралдвал шуй гэнэ.

Шагжамуни Будда ч мөн адил. Зарим хүн Очироорт бясалгалын арга хэмээх нэрд дуртай тул энэ бол "Очироорт бясалгалын арга" мөн гэнэ. Зарим нь Авид бурханд, өрнө дахины ариун оронд мэндлэх дуртай тул Тэрээр: "Энэ бол "Ариун орны бясалгалын арга". Та энэ аргаар бясалгал дадуулвал өрнө дахинд лавтай очно." гэнэ. Үнэндээ өрнө дахинд лавтай очиж чадна. Учир нь Арьяабалын бясалгалын аргын бидэнд сонсгодог тэрхүү яруу сайхан аялгуу нь "Авид бурханы судар"-т бичсэнтэй адил. Зарим хүн Арьяабал бурханд дуртай тул Шагжамуни Будда: "Энэ бол Арьяабалын бясалгалын арга. Та энэ аргаар бясалгал дадуулвал Арьяабал бурхантай тун ойртож, "Эсэрваагийн эгшиг, далайн түрлэгийн чимээ, Чанагуух ертөнцийн ялгуусан дуу"-г сонсож, Арьяабал бурхантай адил болно." гэнэ.

Сонсож буй хүмүүс мэдээж тун дуртайгаар: "Тун сайн. Та надад Арьяабалын бясалгалын аргыг уламжилж өгөөрэй." гэнэ. Авид бурханд дуртай хүн: "За, Та надад энэхүү цаглашгүй гэрэлт бясалгалын аргыг уламжлаарай. Би цаглашгүй гэрэлтэй холбогдож өрнө дахины гайхамшигт яруу хөгжмийг сонсох дуртай. Надад хурдхан ном уламжилж өгөөч." гэнэ. Зарим хүн даяаны аргаар бясалгал хийгээд хэдийнээ дадсан байдаг. Тиймээс Шагжамуни Будда: "Энэ бол хамгийн хүчтэй, хамгийн билиг ухаантай Их билиг барамид бясалгалын арга мөн. Энэ аргаар дадуулан бясалгавал агшин зуур билиг нээгдэнэ." гэж хэлэх ёстой болдог байна.

Авид бурханыг энгийн хүн бясалгадаг, "би" бол даяан бясалгадаг гэж зарим нь үздэг болохоор Шагжамуни Будда: "Энэ аргаар дадуулан бясалгах нь даяаныг бясалгаж буй хэрэг. Лавтайяа ухаарч, билиг ихээр нээгдэх болно." гэнэ. Энэ нь их билиг ухаан гэсэн утгатай. Зарим хүн их билиг ухаанд дуртай тул Шагжамуни Будда : "Энэ бол их билиг ухааны бясалгалын арга мөн. Энэ аргаар бясалгал дадуулвал лавтайяа их билиг ухаантай болно." гэж хэлнэ.

Ингэвэл хамаг амьтныг гэтэлгэхэд хялбар байсан тул

Шагжамуни Будда ингэж ярих хэрэгтэй байжээ. Ямар ч хэлээр ус гэж хэлэх нь хамаагүй, уух ус байвал болно. Иймээс Будда хүмүүст өөр өөр номын нэр хэлж өгчээ. Гэвч түүний уламжилсан бясалгалын арга нь бүгд "Адилхан ".

Бясалгалын аргыг судар номоос эрээд олохгүй. Ном уламжлах үед үг яриа хэрэглэдэггүй болохоор бичигт буулгаж болохгүй. Багш нь ном уламжлахаас өмнө буюу хойно заавал бага сага тайлбар хийдэг. Учир нь бясалгалын аргыг танилцуулах хэрэгтэй. Гэвч номыг жинхэнээр уламжлах үед Багш нь юу ч ярьдаггүй. Огт хөдөлдөггүй, ганц үг ч хэлдэггүй. Ном уламжлах үед нүд хэрэглэхгүй, чих хэрэглэхгүй, сэтгэл хэрэглэхгүй. Оюун ухаан хэрэглэхгүй, бие махбод хэрэглэхгүй, ер нь юуг ч хэрэглэхгүй. Бие, хэл, сэтгэлийг мартаж орхино. Энэхүү биеийг ашиглан унтаж болно. Чихээрээ элдэв замбараагүй хов жив, жигнэмэг сурталчлахыг сонсож болно. Гэвч жинхэнэ ёсоор жигнэмэг идэх үед зургаан эрхтэн (нүд, хамар, чих, хэл, бие, толгой)-ийг огт хэрэглэхгүй. Өөр юуг ч хэрэглэхгүй.

Багшид даруй итгэдэг нь сайны үр их, урьдын буян ихтэй төдийгүй сэтгэл нь тун цэвэр ариуныг илтгэнэ. Тиймээс Багшийгаа хармагц юу ч яриагүй байхад нь итгэдэг. Энэ нь урьдын буян сайтай ерөөл барилдлагатайгаас болдог. Гэвч бид аливаа юманд хэтэрхий амархан итгэж болохгүй. Заавал баталгаа хэрэгтэй.

Зургаадугаар үеийн Их Багш нэрт даяанч Хүй Нөнг та нар мэднэ. Тэрээр тавдугаар үеийн Их Багш Хүн Рэн дээр очиж ном гуйхад Тэрээр найман сарын дараа Хүй Нөнг шөнө дөлөөр гэртээ авчирч Очироорт бясалгалын аргыг уламжилжээ. Ном уламжлуулсны дараа зургаадугаар үеийн Их Багш тэндээс зугтах хэрэгтэй болсон. Тэрээр арван зургаан жил нууцаар бясалгасны дараа хүмүүст ном уламжилж эхэлсэн.

"Зургаадугаар үеийн Их Багшийн мандалт судар"-ын нэгдүгээр бүлгээс үзвэл Тэрээр энэхүү бясалгалын аргыг мянган хүнд сонсгохдоо: "Миний бясалгалын арга бол "Их билиг барамид" бясалгалын арга мөн." гэжээ. Энэ нь Очироорт бясалгалын арга болон Их билиг барамид бясалгалын арга нь ижил утгатайг илтгэж байна. Арьяабалын бясалгалын арга нь Их билиг барамид бясалгалын аргатай мөн адил. "Зүрхэн судар"-ын эхэнд: "Ажихуйн эрхт Бодьсадва Их билиг барамид бясалгалын аргыг гүн бясалгах үед таван цогц цөм хоосныг тольдож, хамаг гашуун зовлонтныг гэтэлгэх..." гэжээ. Тэр нь даяан гүн агуулах үедээ таван цогц бүгд хоосныг тольдон харж, хамаг гашуун зовлонтныг гэтэлгэх зэргийг илэрхийлж байна. Энэ нь Их билиг

барамид бясалгалын аргаар самади агуулах үед түүний билиг нээгдсэнийг харуулж байна.

Одоо Багш нь та нараас асуулт асууя. Ажихуйн эрхт Бодьсадва гэж хэн бэ? (*Арьяабал бурхан гэж хариулав.*) Арьяабал бурхан ямар бясалгалын аргаар бясалгал дадуулж байсан бэ? (*Арьяабалын бясалгалын арга гэж хариулав.*) Зөв. Энэ нь Их билиг барамид бясалгалын арга нь Арьяабалын бясалгалын арга болохыг харуулж байгаа биш үү? "Ажихуйн эрхт Бодьсадва Их билиг барамид бясалгалын аргаар гүн бясалгах үед..." гэдгийг бид "Арьяабал бурхан Арьяабалын бясалгалын аргаар гүн бясалгаж байх үед таван цогц бүгд хоосныг тольдож, хамаг гашуун зовлонтныг гэтэлгэх..." болно хэлж болно.

Энэ юуг илтгэж байна вэ? Их билиг барамид бясалгалын арга нь Арьяабалын бясалгалын аргатай адил гэдгийг илтгэж байна. Зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн бас адил бясалгалын аргаар бясалгал дадуулж байжээ. Тавдугаар үеийн Их Багш Хүн Рэний бясалгасан Очироорт бясалгалын арга нь зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөнгийн дадуулан бясалгасан Их Билиг барамид бясалгалын аргатай адил байна. Тавдугаар үеийн Их Багш Хүнрэн, зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн болон Арьяабал бурхан цөм нэг бясалгалын аргаар сүнслэг дадал бясалгал хийж байсныг үүнээс мэдэж болно.

Арьяабалын аргаар дадуулан бясалгахад чих, нүд, сэтгэл хэрэглэхгүй. Иймд "Аялгуу сонсох" гэдэггүй "Аялгуу ажих" гэдэг. Ажихад ямар нэгэн зүйлээр бус билиг ухаанаар ажна. Аялгуу ажихад нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэлийг хэрэглэхгүй гэж Багш нь сая ярьсан. Хятадад Цаодун урсгалын нэгэн даяанч багш байжээ. Тэрээр Цаодун урсгалын бясалгалын заавар ном бичсэн. Хятадаар ямар нэртэйг би мэдэхгүй. Уг номд: "Цаодунгийн аргаар дадуулан бясалгахад чих, нүд, хамар хэрэглэхгүй. Бие, хэл, сэтгэл хэрэглэхгүй. Ингэвэл жинхэнэ Цаодун болно." гэжээ. Бид зургаан эрхтнээр бясалгадаггүйг Арьяабалын аргаар бясалгал дадуулж буй хүн бүр мэднэ. Тэгэхээр Цаодун нь Арьяабалын бясалгалын аргатай адил байгаа биз?

Үүнээс гадна "Даодэжин"-д Лууз бас энэхүү "Нэрлэж үл болох нэр" бол түмэн бодисын эх болохыг дурдсан. (Нэгдүгээр бүлэг: "Дао" нь өгүүлж болбол мөнхийн дао бус, нэр нь дуудаж болбол мөнхийн нэр бус. Хоосон хэмээгч нь тэнгэр газрын үүсэл, буй хэмээгч нь түмэн бодисын эх.") Луузын хэлсэн санаа бол дэлхий дахин угаас амгалан. Энэхүү "Нэрлэж үл болох нэр" үүсэхээс эхлээд орчлонгийн түмэн бодис бүтээгджээ.

Христийн шашны Библид мөн адил ёсыг дурджээ. Библид: “Орчлон ертөнц эхэндээ аялгуу (word) байсан. Энэхүү аялгуу нь Эзэн Бурхантай хамт оршдог. Энэхүү аялгуу нь Эзэн Бурхан мөн. Түмэн бодис бүгд энэхүү аялгуунаас үүдэн бүтээгджээ. Үүгээр бүтээгдээгүй нэг ч зүйл үгүй. (In the beginning was the word (sound), and the word was with God, and word was God, everything was made by this and nothing was not made by this). Нэгэн удаа Күнз аялгуу сонсож байгаад өөрийгөө бүрмөсөн мартаж, гурван сар болсон ч яруу сайхан дуу аялгуунд мансуурсаар байсныг Түүний “Шүүмжлэл ном”-ыг уншсан хүн бүр мэднэ. Энэ нь дотоодын аялгууг хэлж буйг бид ойлгох хэрэгтэй. Ертөнцийн дуу хөгжим ийм их татах хүчтэй байж чадахгүй.

Энэтхэгийн Ведийн (Veda) судар болон бусад ном сударт орчлон ертөнцийн анхдагч аялгуу нь ОМ авиатай төстэй гэж дурджээ. Тэд түүнийг Шабд (Shabd-хөг аялгуу) гэж нэрлэдэг. Бид Шюаньзан (Тансан лам) номын багшийн тухай үлгэрийг уншвал мэдэх болно. Энэ багш болон бусад номын багш нар өөр өөр цаг үед Энэтхэгт байсан ч Шабдын бясалгалын аргыг бас сурч байжээ. Лалын шашны “Коран”-сударт Мухаммед орчлонгийн аялгууны тухай өгүүлсэн ч өөр нэр хэрэглэжээ. Өөр өөр шашин суртахууны ном судруудад өөр олон нэр байдаг. Жишээлбэл, Naam, Anhadnaad, Udgit, Kalam-i-qadim, Bang-i-ilahi, Nida-iasmani, Saut-isarmad, Katha, Kirtanrag... гэх зэрэг.

Үнэндээ Их Багш нар бүгд ижил зүйл ярьсныг би Арьяабалын аргаар бясалгал дадуулсны дараа ойлгосон. Бясалгал дадуулахаас өмнө юу нь ижил, юу нь өөр болохыг мэдэхгүй байсан байж магадгүй.

Тяньтай урсгалын номын аргаар бясалгал хийж байсан нэгэн гэлэнд би ном уламжилсан. Тэрээр тодорхой нэг түвшин хүртэл бясалгал хийгээд тэндээ гацсан байв. Чин сэтгэлтэй, тун даруухан гэлэн бөгөөд гурвантаа мөргөн ёсолж ном уламжлахыг гуйв. Багш нь түүнд ном уламжилъя гэж бодоогүй. Гэлэн хүн өөрийгөө гэлэнмаагаас дээгүүрт тавьдаг учир би болгоомжилдог. Багшид нь мөргөж ном уламжлахыг гуйдаг гэлэн яаж байх вэ? Ном уламжилбал ойлгох болов уу? гэж санаа зовсон. Гэвч тэр гэлэн ойлгосон.

Ном уламжилсны дараа гэлэн: “Энэ бясалгалын арга Тяньтайн урсгалынхтай их адилхан юм.” гэхэд нь би: “Тийм ээ” гэж хариулав. Угаасаа л ижил бясалгалын арга. Сайн Төгс Гэгээрсэн Их Багштай бол Тяньтайн урсгал, сайн Төгс Гэгээрсэн Их Багштай бол Цаодунгийн урсгал, сайн Төгс Гэгээрсэн Их Багштай бол

Арьяабалын, даяаны, Авид бурханы, Хотол зохилдогч бясалгалын арга болно. Төгс Гэгээрсэн Их Багш ном уламжлахгүй бол бүгд өнгөн талын юмсыг амаараа унших төдий. Ном уламжлах хүчгүй бол юу ч олж чадахгүй. Бид аливаа бясалгалын аргыг хагас дутуу сураад түүнийгээ хүмүүст уламжилбал бүрэн төгөлдөр жинхэнэ бясалгалын арга биш тул бусдыг татаж дийлэлгүй замын дундаа гацна. Учир нь түүнээс илүү дээгүүр түвшин байдгийг, яаж хүрдгийг мэдэхгүй.

Хүй Нөн бол Линьжийн урсгалынх гэж Багш нь хэлсэн. Тяньтайн урсгал, Цаодунгийн урсгал, Линьжийн урсгал, Ариун орны урсгал, Арьяабалын бясалгалын арга, Их билиг барамид бясалгалын арга бүгд ижил. Харин ном уламжлах хүчгүй бол өөр өөр болж хувирна. Төгс Гэгээрсэн Их Багштай, ном уламжлах хүчтэй бол аль ч бясалгалын арга бүгд ижил. Учир нь ном уламжлах үед үг ярихгүй. Яримаар уламжилмаар ном үгүй. Гэсэн ч уламжлахгүй бол ном үгүй. Үүнийг зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн "Дүрс үгүй бясалгалын арга" гэж нэрлэжээ.

Шашны урсгалууд бүгд ижил гэж өчигдөр Багш нь ярьсан. Их Багш нарыг тэнгэрт хальсны дараа ном уламжлах шилдэг шавь байхгүй бол бясалгалын аргын уламжлал тасарна. Хожим нь өөр нэгэн газраас шилдэг сайн шавь тодроод Энэтхэг, Формоса эсвэл Хятадын эх газарт очиж магадгүй. Тэр шавь өөр газарт бясалгаж төгс гэгээрээд ном уламжилж болно. Тэр заавал Багшийнхаа байгаа газар ном уламжилж, Түүнтэй адил зүйл ярих албагүй. Өөр хэлээр ярьж, өөр нэр ашиглаж магадгүй.

Жишээ нь тавдугаар үеийн Их Багш Хүн Рэнг зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөнд Очироорт бясалгалын аргыг уламжилсан ч үүнийгээ Их билиг барамид бясалгалын арга гэж байв. Арьяабал бурхан угаасаа Арьяабалын бясалгалын аргаар бясалгал дадуулж байсан ч түүнийг Их билиг барамид бясалгалын арга гэж Шарибударид хэлж байв. Гэвч утга агуулга нь бүгд ижил. Энэхүү бясалгалын арга Хятадын эх газарт дэлгэрэхдээ Линьжийн урсгал, Цаодунгийн урсгал болон хувирчээ. Линьжи гэдэг нь Линьжи урсгалыг үндэслэгчийн нэр юм. Шагжамуни Будда таалал болсны дараа бид өөрсдийгөө Бурханы шашинтан, Есүс Христ тэнгэрт хальсны дараа Христийн шашинтан, Лууз өөд болсны дараа Луузын шашинтан (Даогийн шашинтан, бумбын сургаалтан) гэх болсон ч үнэн хэрэгтээ бүгд адилхан.

Төгс Гэгээрсэн Их Багш нар ижил номлол сургаалыг зааж, хүмүүнийг туулан гэтэлгэхдээ адил бясалгалын аргыг уламжилдаг. Зөвхөн нэг л бясалгалын арга туулан гэтэлгэж

чадна. Энэ бол Арьяабалын бясалгалын арга. Түүнийг Ариун орны бясалгалын арга, Хотол зохилдогч бясалгалын арга, Их билиг барамид бясалгалын арга, эсвэл Очироорт бясалгалын арга гэх зэргээр яаж ч нэрлэсэн бүгд ижил юм. Гэтэлгэдэг л бол Арьяабалын бясалгалын арга мөн.

Дотоодын Бурханы аялгуу нь биднийг туулан гэтэлгэх тул Шагжамуни Будда "Баатараа явагч их хөлгөн судар"-т Арьяабалын бясалгалын аргыг сэтгэшгүй хүчтэй гэж магтан сайшаажээ. Тэр хэлэхдээ: "Арван зүг гурван цагийн бурхад цөм Арьяабалын бясалгалын аргаар бясалгал дадуулвал Ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутагт хүрч чадна." гэжээ. Энэ нь хамгийн дээд, Ханьцашгүй үнэхээр туулсан бодь хутаг болох гэсэн санаа юм. Үүнийг Католик шашинд Эзэн Бурхан гэнэ. Тэдний хувьд Эзэн Бурхан бол хамгийн дээд нь. Бурханы шашинд бол ханьцашгүй үнэхээр туулсан нь хамгийн дээд нь юм. Ханьцашгүй гэдэг нь үнэхээр хэтийдсэнийг, оройн дээдэд хүрснийг хэлж байна. Эзэн Бурхан христийн шашинтанд хамгийн дээд нь юм. Бидний ханьцашгүй үнэхээр туулсан гэдэгтэй адил бүгд л төгс туулан гэтлэх хамгийн дээд түвшин, агуу билиг ухааныг хэлнэ.

Гэвч хожмын хүмүүсийн билиг нээгдсэнгүй, ном судраа ойлгосонгүй. Мөн буруу зөрүү орчуулснаас олон эгэл хүний санаа бодол ном сударт оржээ. Иймээс шашин суртахуун нь анхны Төгс Гэгээрсэн Их Багшийн угийн санаанаас улам бүр хөндийрөн холдсон байна. Бурханы шашинд олон том, жижиг янз бүрийн урсгалууд байдгийг бид мэднэ. Бусад шашин суртахуун ч ялгаагүй. Хэрэв шашин суртахууны жинхэнэ учир утгыг ойлгочихвол харилцан маргалдаж тэмцэлдэхгүй.

Ау Лакт нэг номын багш байв. Тэр бас Арьяабалын бясалгалын аргатай төстэй аргыг заадаг байсан. Ханьцашгүй үнэхээр туулсныг тайлахдаа энэ бол хий хоосон их самади гэжээ. Түүний хий хоосон хэмээгчийн утга нь "Тэр цагт, тэр газарт, ямар ч юм үгүй, хүн үгүй, би үгүй, тэр үгүй, чи үгүй, хамаг амьтан үгүй, Бурхан үгүйг, их самадийг гүн агуулсан." гэнэ. Иймээс хий хоосон их самади гэжээ. Гэвч олон хүн Бурханы шашинд итгэдэг болохоор түүний номлолыг ойлгохгүйгээс дургүйцэж, түүнийг буруу номтон гэцгээж байв. Харин Багш нь буруу номтон гэхгүй. Тэрээр хүмүүст өглөг, сахил, хүлцэнгүй, хичээнгүй, даяан, билгийг заан сургадаг.

Тэр хүн "Очироор огтлогч судар"-ын дагуу ном тайлаагүй байж мэднэ. Тэрээр "Очироор огтлогч судар"-ыг гартаа барьж, сударт бичсэн ёсоор нэгдүгээрт өглөг, хоёрдугаарт сахил,

гуравдугаарт... гэхчлэн заагаагүй, өөрийн аргаар тайлсан хэдий ч мөн л ялгаагүй амь хороохгүй, хулгайлахгүй, архи уухгүй, садар самуун явахгүй, худал хэлэхгүй гэх зэрэг сайн явдлыг хүмүүст зааж байжээ. Гэвч тэр тодорхой заадаггүй байсан бөгөөд таван сахилын нэрийг хэрэглэхгүйгээр ёс суртахуунтай хүн байх хэрэгтэй, амь хороож болохгүй, бусад хүний эхнэрийг эргүүлж болохгүй гэхчлэн заадаг байсан нь таван сахилын агуулгатай адил байжээ.

Тэрээр бас Арьяабалын бясалгалын аргыг заадаг. Нэгэн сайн багшаас сурч гэгээрээд бусдад ном уламжилж байсан ч байж магадгүй. Гэвч Арьяабалын бясалгалын аргын нэрийг хэрэглэлгүйгээр түүнийгээ "Бурханы шашны үл мэрийх маш нууц бясалгалын арга." гэж нэрлэжээ. Түүний үл мэрийх гэдэг нь Даогийн шашинтны баримталдаг "үл мэрийх"-тэй адил бөгөөд бүгдийг би хэмээгч сэтгэлээр хийх бус, харин юу ч хийсэн хийгээгүйтэй адил гэсэн утгатай.

Би түүнд шавилаагүй, түүнтэй уулзаагүй. Гэвч би номыг нь уншаад Арьяабалын бясалгалын арга болохыг тэр даруй мэдсэн. Энэ бясалгалын аргыг угаасаа бичиж тэмдэглэж болдоггүй ч тэрээр бага сага задруулжээ. Тиймээс түүний зааж байсан бясалгалын арга нь Арьяабалын бясалгалын арга болохыг би мэдсэн. Хэрэв Багш нь Арьяабалын аргаар бясалгал дадуулаагүй бол түүний юу ярьсныг ойлгохгүй. Түүнийг бас буруу номтон гэж хэлж мэднэ. Арьяабалын аргаар бясалгал дадуулахад л жинхэнэ билиг нээгдэх тул бүх зүйлс тунгалаг толинд тод тусах шиг тун ойлгомжтой, тун тодорхой байдаг. Толь өчүүхэн ч тоосгүй тул тийм тод харагдана.

Эс бөгөөс бол өдөржингөө Бурханы шашин сайн, Католик шашин муу, эсвэл Католик шашин сайн, Бурханы шашин муу гэх зэргээр бусдыг дайрч давшлах болно. Хэрвээ бид өөрсдөө ойлгоогүй бол ямар ч шашин шүтээд нэмэргүй. Хүн, тэнгэрт мэндлэх бага сага буяны хувьтай гэж өөрийгөө жаахан тайтгаруулна. Гэвч хэн болохоо мэдэхгүй, өөрийгөө угаас Бурхан гэдгийг ойлгохгүй бол Бурхан болохын аргагүй. Иймээс шашин бидэнд бараг хэрэггүй.

Тиймээс л ном судрыг хэрэггүй зүйл, түүнийг шатаагаад хоол хийж болно гэж зарим номын багш, даяанч багш нар хэлдэг байжээ. Заримдаа Багш нь ч бас ингэж хэлдэг. Учир нь Багш нь ном судар уншаад цөхөрч, итгэл алдарч байсан. Түүнийг уншаад туулан гэтлэхгүй. Зарим хүн ном сударт дэндүү хүлэгддэг. Тэд Багш дээр нь ном уламжлуулахаар биш, харин маргалдахаар

ирдэг. “Очироор огтлогч судар”-т энэхүү судрыг уншвал билиг нээгдэж, Бурхан болно гэсэн гэж тэд хэлдэг. Тийм биш. “Очироор огтлогч судар”-т “Очироор огтлогч судар”-ыг “унш” гээгүй, харин түүнийг “баримталж мөрд” гэсэн. Сахил сахих нь сахил сахих тухай уншихтай адилгүй. Иймээс ном судрыг дагаж мөрдөх гэдэг нь ном судар уншихтай адилгүй.

Бодьсадвагийн сахил хүртсэн хүн гэртээ хариад хэдэн сахилаа өдөржингөө уншаад байвал болно гэж бодож болохгүй. Яаж болох вэ? Бодьсадвагийн сахилыг сахиж, Бодьсадвагийн замаар замнах хэрэгтэй. Ном судар ч мөн үүнтэй адил. Та “Очироор огтлогч судар”-ыг уншаад хэрэггүй. Буддад уншиж сонсгоё гэж байгаа бол Будда аль хэдийнээ мэднэ. Буддад уншиж өгөөд яах юм бэ? Хүмүүст уншиж сонсгоё гэвэл тэд ойлгохгүй тул хэнд хэрэгтэй юм бэ? Зөвхөн бясалгал дадуулж байж л ном судрыг ойлгож чадна.

Багш нь багаасаа “Очироор огтлогч судар”-ыг уншиж байсан. “Очироор огтлогч судар”-ыг унших нь их тустай гэж хүн болгон хэлдэг болохоор удаан уншсан ч ямар ч билиг нээгдээгүй. Зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн яаж уншсаныг мэдэхгүй. Багшид нь л лав тус болоогүй. “Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”-ыг уншсан ч ямар ч нэмэр болсонгүй. “Нирваан судар”-ыг уншаад ч билиг нээгдсэнгүй. Шагжамуни Будда энэ сударт чухам юу тайлсныг бас ойлгосонгүй.

Харин Арьяабалын аргаар бясалгаж дадуулаад төд удалгүй ном судрыг уншмагц ойлгодог болсон. Судрын утгад нэвтэрсэн тул уншаад шатаачихмаар санагддаг. Нэгэнт ойлгосон бол шатааж болно. Ойлгоогүй байхдаа ном судрыг тэргүүн дээрээ залж, нэг алхаад нэг мөргөж, хоёр алхаад гурав мөргөсөн ч тусыг олоогүй, билиг нээгдээгүй. Өөрийгөө хэн болохыг ч ойлгохгүй, зөвхөн Бурханд мөргөж, Бурханы шавь болж, БУрханы гутлыг арчина. Ингээд яах юм бэ? Будда биднийг Бурхан бол гэснээс бус, Бурханд мөргө гэж хэлээгүй. Бурханд мөргөж болно. Гэхдээ Бурхан гэж хэн болохыг заавал мэдэх хэрэгтэй. Тэгээд мөргөж болно. Та ирээдүйн эхнэрийнхээ царай зүсийг хараагүй бол түүнийг өдөр бүр санан дурсаж чадах уу?.

Тиймээс Шагжамуни Будда: “Бурханд итгэн бишир, гэвч Бурханыг ойлгоогүй бол Түүнийг гүтгэж буй хэрэг.” гэжээ. “Нирваан судар” уншиж буй нэгэн хүнийг Бодьдарма хараад: “Үүнийг уншаад яах нь вэ?” гэхэд тэрээр: “Нирваан судар”-ыг уншвал билиг нээгдэж Бурхан болно.” гэжээ. Тэгэхэд нь Бодьдарма: “Наадхаа наашаа өгчих, хүн мэхэлдэг юмыг шатааж

орхиё.” гэв. “Бин зураад өлөө дарахгүй.” гэдэг нь ийм утгатай. Судар ном бол зөвхөн бясалгалын аргыг танилцуулах төдий болохоос ном уламжлах хүчгүй, бясалгалын арга биш. Учир нь ном уламжлахад үг хэл хэрэглэхгүй. “Даяан үг хэрэглэхгүй.” гэдэг нь ийм учиртай.

Өнөөдөр Багш нь Арьяабалын бясалгалын аргыг цаг гаруй магтлаа. Аялгуу ажихыг мэдсэн хүн цаглашгүй, хязгаарлашгүй буянтайг тайлбарласан. Багшийнх нь санаа бол Арьяабалын аргаар бясалгал дадуулвал цаглашгүй буянтай гэдгийг хэлсэн хэрэг. Багшийнхаа дууны хуурцгийг сонсох нь буян хишигтэй ч төгс туулан гэтлэхгүй. Тиймээс Арьяабалын бясалгалын аргыг, аялгуу ажихыг, “Хотол зохилдогч зүйл”-ийг “баримтлах” хэрэгтэй. “Баримтлах” гэж юу вэ? Энэ нь “Сүнслэг дадал бясалгал хийх” гэсэн үг.

Жишээлбэл “Сахилыг уншаад” нэмэргүй харин “Сахилыг сахих” нь тустай. Амь хороохгүй, хулгай хийхгүй, садар самуун явахгүй, худал хэлэхгүй, архи уухгүй гэдэг нь таван сахил болно. Бид хариад таван сахилыг уншаад байвал хэрэгтэй юу, үгүй юу? Хэрэггүй. Олон хүн өөрийгөө Бурханы шашинтан гэж нэрлээд арав, арван тав, тавин хуврагаас сахил хүртэн дагаж, тавь гаруй номын нэртэй болж, элдэв сахилын нэр цуглуулах боловч амь хороохгүй гэж юу болохыг ойлгоогүйгээс аанай л мах идэж, архи ууж байдаг. Арван таван номын багшаас сахил хүртсэн ч хариад сахилаа сахихгүй бол нэмэргүй. Харин сахил хүртэж дагасан үнэмлэх сэлтээ шатааж орхивол нэлээд үнэнч хүнд тооцогдоно. Ингэхгүй бол хүмүүсийг хууран мэхэлсэн хэрэг болно. Ийм Бурханы шашинтан байгаад яах юм бэ?

Будда маш нигүүлсэнгүй. Бидний байгаа байдлыг хараад инээнэ. (*Бүгд инээв.*) Будда: “Тэд юу хийж байна аа? Таван сахилаа ойлгохгүй байж яана гэнээ? Багшид шавилж, номын нэр цуглуулаад юу хийх вэ? Ямар ч хэрэггүй.” гэж хэлнэ. Ойлгов уу? Маш олон хүн сахил хүртсэн ч мах идэж байна. Өчигдөр Багш нь махны тухай ярьсан. Мах идэх нь дамаар амь хөнөөж буй хэрэг. Амь хороохыг хараад баясах нь бас амь хороож буй явдал. Мах идэх хүнгүй бол амьтан хороож, мах худалдах хүнгүй болно. Будда “Ланкаватара судар”-т энэ тухай маш тодорхой ярьсан байдаг. Будда: “Их билгээр үзвэл яргачдын ихэнх нь хүнд идүүлэхийн тулд амь хороодог. Хүн мах иддэггүй бол амь хөнөөх явдалгүй болно. Тиймээс мах идэх нь амь хороохтой адил гэмт явдал мөн.” гэжээ. (Буддагийн өгүүлсэн нь: “Их билгээр үзвэл аливаа аллагын ихэнх нь хүн мах иддэгээс болжээ. Хүн мах идэхгүй бол аллага

үгүй. Иймд мах идэх хийгээд аллагын ял адил болой.” хэмээжээ).

Асуулт: Энэ бясалгалын аргаар сүнслэг дадал бясалгал хийхэд ямар нөхцөл шаардлагатай вэ?

Их Багш: Ямар ч тусгай нөхцөлгүй гэж би өчигдөр хэлсэн. Сүнслэг дадал бясалгалыг хэн ч хийж болно. Гэвч сахил сахих хэрэгтэй. Сахил сахих нь бас сахил сахиж буй хэрэг биш. Сахил гэхээр юм угаас байхгүй. Эрт дээр үеэс л хулгай хийвэл хуультай байсан. Харин дадал бясалгал хийвэл хулгайлж болохгүй гээгүй.

Амь хөнөөхгүй байхыг угаас хүндэтгэн сахивал зохино. Күнз: “Өөрийн дургүй зүйлийг өрөөлд бүү тулга.“ гэжээ. Тэр бас адил ёсыг ярьсан байна. Хятадад аль эрт ярьж байсан зүйлийг заавал дадал бясалгал хийж байж ойлгох шаардлагагүй.

Бид өөрсдөө алуулах дургүй байтал юунд идэж уухын төлөө бусдыг хөнөөхийг дэмжинэ вэ? Амьтан алагдах үедээ тун их зовдог. Тэд хүний адил үхлээс айж, амьдралд тэмүүлдэг. Үүнийг бид тодорхой мэднэ. Тийм байтлаа амьтны зовж байгааг харж яаж тэвчинэ вэ? Амьтны зовлонт үхлээр жаргал хийж байна уу? Амьтдын үхэл зовлон бидний таашаал авдаг амт болон хувирчээ. Угаас амь хороож болохгүй. Иймээс амьтны амь хороохгүй гэдэг нь сахил биш. Төрөл төрөгсөд маань өөд болсны дараа бид цогцсыг нь идэж зүрхлэхгүй байтал бусад амьтныг яаж идэж чадаж байна вэ?

Амьтад угийн бохир заваан болохоор бид гахай, үхэр, тахиа, хонь ямааг тэврэн үнсэж, хамт унтана гэж төсөөлж ч чадахгүй. Гэтэл тэдний цогцосыг өөрийн эрхэм ариун амандаа яаж хийнэ вэ? Түүгээр ёс суртахуунтай явдлыг хэлэлцэх, яруу тансаг шүлэг найраг, утга зохиолыг уншдаг байтал булшны хаалга болгож яаж болох вэ? Бид энэхүү эрхэм дээд хүний биеийг үхдэл тавьдаг оршуулгын газар болгодог. Зарим хүн хүүрийн газар унтахаас айх мөртөө өөрийн гэдсэн дэх оршуулгын газартай өдөр бүр хамт байхаас айдаггүй. Амьтан ч бас үхлээс айж амьдрахыг хүсдэг. Хэрэв тийм биш бол тэднийг хороож болно. Гэтэл үхэхийг хүсэхгүй байхад нь бид амьтдыг хүчээр хороох нь дэндүү шударга бус хэрэг.

Өвс ургамал, цэцэг ногоо үг хэлэхгүй ч бидэнд идүүлэхийг хүсдэгийг билгийн мэлмий нээгдсэн үед мэдэж болно. Тэд: “Би нэгэнт боловсорчихлоо. Намайг түүж аваад ид.” гэдэг. Харин амьтад үхэх дургүй, алуулах ч дургүй. Гэтэл хүн хүчээр хороодог. Энэ бол туйлын буруу, хүчирхийлж байгаа хэрэг. Хүмүүс бид цэцэн сэргэлэн, хүч чадалтай болохоор дорой буурай, өчүүхэн

жижиг амьтдыг барьж аваад, биеийг нь хэрчиж огтлох нь эрхэмсэг хүний явдал огт биш.

Та нар дайтах урлаг мэдэх үү? Талууд хүч ойролцоо байж л тулалдана. Ялсан нь ялагдсанаа хоморголон устгадаггүй. Байлдаж буй этгээдээс ч сул дорой, өөрийгөө хамгаалж үл чадах өчүүхэн жижиг амьтдыг хэрцгийлэн хорооно. Тэд хүмүүсийг хармагц үхтлээ айж зугтан зайлж, нуугдан хоргоддог. Гэвч бид тэднийг хөөж байгаад хороодог. Загас биднээс хамааралгүй их далайдаа хөвж явахад нь бид тороор шүүнэ. Амьтад ууландаа амар жимэр байхад нь бид авлаж гэртээ авчирч иднэ. Ингэх нь үнэхээр буруу бөгөөд орчлонгийн хуулийн эсрэг явдал юм.

Ногоо үхлээс айхгүй тул тийм мэдрэмжгүй. Түүний ерээс дээш хувийг ус эзэлдэг. Усны эзлэх хувь их бол мэдрэл, ухамсар бага байна. Амьтны ухамсар өндөр, хүнийхтэй ойролцоо. Иймээс морь, нохой маш үнэнч хайр энэрэлтэй бөгөөд өөрийн эзнээ сайн таньдаг. Амьтныг хүнтэй адил мэдрэхүйтэй гэж бодох хэрэгтэй. Зарим морь, нохой үнэхээр үнэнч. Эзнээ нас барвал ихэд шаналан хоолноос гарч хэдэн өдөр ч бололгүй үхэх нь бий. Иймд тэднийг идэж болохгүй. Амьтны ухамсар ухаан нь хүнийхтэй бараг ижил тул бид амьтдыг албадаж, алж хороож болохгүй. Мөн алуулж буйг нь хараад баясаж, тэдний зовлонгоор цэнгэл хийж болохгүй. Бодьсадва болох нь юуны төлөө вэ? Өөрөө зовлонгоос ангижрах төдийгүй өрөөлийг ч ангижруулахын төлөө юм. Нүдний чинь өмнө зовж байгаа хамаг амьтныг одоо гэтэлгэхгүй юм бол хэзээ гэтэлгэх вэ? Бодьсадва болохоо хүлээх зуураа хамаг амьтдыг чи идээд дуусгачихна. (*Бүгд инээв.*) Гэтэлгэх ч хэрэггүй болно.

Тиймээс хамаг амьтныг өөрийн төрөл төрөгсдийн адил үзэх нигүүлсэнгүй сэтгэлийг үүсгэж байж л Бодьсадва болж чадна. Бид одоо л нигүүлсэнгүй Бодьсадва болохгүй бол хожим нь яаж өрнө дахинд очих вэ? Их буян эрдэмтэй, их нигүүлсэнгүй Бодьсадва нар л өрнө дахинд амьдран суудаг. “Авид бурханы судар”-т: “Өчүүхэн бага буян хишгээр төгс баясгалант оронд мэндэлж чадахгүй.” гэжээ. Бясалгал дадуулахад нигүүлсэнгүй сэтгэл нэн чухал. Шашин суртахуун бүхэн үүнийг онцгойлон тэмдэглэдэг. Бид нигүүлсэнгүй сэтгэлийг үүсгэхгүйгээр төгс баясгалант ариун оронд очиж мэндэлнэ гэж яаж бодож болох вэ?

Багш нь багадаа нэг цэцэг тарьсан юм. Түүнийг түмэн өлзийт цэцэг гэдэг. Та нар тэрхүү цэцгийг сахлаг сайхан ургуулъя гэвэл хэсэг хугацааны дараа голыг нь авах хэрэгтэй. Ингэвэл түмэн өлзийт цэцэг томорч, улам их цэцэглэнэ. Тэгэхгүй бол давжаараад

ганц хоёрхон дэлбээ, хоёр гуравхан нахиа гарна. Гэтэл түүний голыг нь авбал улам өндөр сахлаг болж, улам дэлгэрнэ. Тийм үү?

Кориандр болон бусад ногооны нэг хэсгийг нь тасалбал хоёр, гурав, дөрөв болж нэмэгддэг. Тийм үү? Ихэнх ногоо ийм байдаг. Та нар үүнийг нүдээрээ үзэж болно. Тэднийг идвэл баярлаж, улам өсөж томроод арвин үр жимс өгдөг. Хэрэв идэхгүй бол гомдсондоо олширч чадалгүй ганц хоёрхон ургах бөгөөд идэнгүүт үхчихдэг. Багшдаа итгэхгүй бол түмэн өлзийт цэцэг тариад голыг нь авбал улам сайн ургана. Та нар хоёрыг тариад нэгнийх нь голыг аваад, нөгөөг нь зүгээр орхичих. Тэгээд ялгааг хараарай.

Иймд өвс мод, аливаа ургамал тасчуулж зулгаалгах, хүнд идүүлэх дуртай байдаг. Модны мөчир салааг цавчиж хаявал удалгүй шинэ навч нахиа урган гарна. Харин тахиа, үхрийг цавчвал үхэхээс биш үржиж олшрохгүй. Тиймээс билгийн мэлмий нээгдээгүй ч өвс мод, жимс ногоо хүнд идүүлэх, хэрэглүүлэх дуртай эсэх, амьтад алуулах, цавчуулах дуртай эсэхийг энгийн нүдээр ажиглан мэдэж болно.

Арьяабалын аргаар дадуулан бясалгая гэвэл өдөр бүр хоёр цаг хагас “Бясалгах” хэрэгтэй. Ингэвэл үйл түйтгэрээ угаан цэвэрлэх хүрэлцэхүйц хүч чадалтай болоод төгс баясгалант оронд очиж чадна. Бидний үйл түйтгэр дэндүү ихээс очъё ч гэсэн очиж чадахгүй болохоор Бурханыг сэтгэл сарнихгүй болтлоо “Дурсан залбирах” хэрэгтэй. Гэвч аргыг нь мэдэхгүйгээс яаж ч дурсан залбирсан сэтгэл их сарнидаг. Тиймээс заавал хоёр цаг хагас бясалгах хэрэгтэй. Ингэвэл сэтгэл тогтож жинхэнэ ёсоор “Бурханыг дурсаж” чадна.

Дурсах гэдэг нь санан дурсахын “Дурсах” юм. Хоёр цаг хагас Бурханыг жинхэнэ ёсоор дурсвал нэгэн сэтгэлээр “Дурссан” гэж болно. Учир нь бясалгах үед энэ ертөнцийн бүхий л зүйлсийг огоорч жинхэнэ ёсоор бие, хэл, сэтгэлээ Бурханд өргөл болгодог. Бидэнд өдөр бүр 24 цаг бий. Бурханд зориулж хоёр цаг хагасыг өргөж байгаа нь хоногийн аравны нэг төдий юм. Гэтэл ихэнх хүн түмэн шалтгаан тоочдог. Би тун завгүй, гэртээ суудаг, нөхөртэй, эхнэртэй, хүүхэдтэй, ажилтай гэх мэт.

Арьяабалын аргаар дадуулан бясалгахад бие, хэл, сэтгэлээ Бурханд хоёр цаг хагас заавал өргөх хэрэгтэй. Жинхэнэ “Би”-гээрээ сууж Бурханыг санан “Дурсах” хэрэгтэй. Ингэвэл нэгэн сэтгэлээр Бурханыг “Дурссан” болно. Бид зөвхөн самади агуулах үед л сэтгэл сарнихгүй болно гэсэн үг биш. Одоогоос эхлэн жинхэнэ чин сэтгэлээр өдөр бүр бясалгаж, Бурханд хамгийн

багадаа хоёр цаг хагас “Сэтгэл”-ээ өргөвөл энэ нь жинхэнэ сэтгэл сарнихгүй гэгч болно.

Самадид орох нь амаргүй. Заавал урьдаар дадуулж байж самадийн түвшинд хүрч чадна гэдгийг Багш нь хэлье. Өдөр бүр амаараа “Авид бурханд мөргөмүй.” гэж уншсаар гэнэт нэг өдөр сэтгэл сарнихгүй болно гэж хүлээх нь огт боломжгүй зүйл. Бурханд өргөл өргөх, Бурханд “Сэтгэл”-ээрээ залбирах, Түүнийг санан “Дурсах”-ыг заавал дадуулах хэрэгтэй. Хамгийн багадаа өөрийн цагийн аравны нэгийг Бурханы өргөлд өдөр бүр зориулна. Ийм маягаар Бурханыг “Дурсвал” нэгэн сэтгэлээр сарнихгүй болж чадна.

Энэ бол манай бясалгалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх ном журам юм. Цагаан хоол идэж, хоёр цаг хагас бясалгах хэрэгтэй, өөр зүйлгүй. Бясалгахдаа Бурханыг санан “Дурсана”. Гэвч санан “Дурсах” нь бас бясалгалын аргатай. Чухам яаж “Дурсвал” тустай болохыг заавал мэдэх хэрэгтэй. Багшийнх нь та нарт яриад байгаа нь нөгөө л жигнэмэг, устай аяга мэт гадна талын зүйлс болно. Та нар усыг нь ууж, жигнэмэгийг амсаж амжаагүй л байна.

.



Бясалгал хийснээр бухимдлаа даван туулж чаддаг болсон тул юу ч тохиолдсон хөөрч догдлохоо больж, үйл хөдлөл, ааш авир маань уужуу тайвуу, амарлингуй дөлгөөн болдог. Иймээс бясалгал хийх нь тун зугаатай хэрэг юм.



Багшийг харах эсвэл хамт байхад бүдүүн түвшний үйл түйтгэр цэвэрлэгдэх нь мэдээж. Харин харагдаж мэдрэгдэхгүй, баригдаж тэмтрэгдэхгүй, гүн үндэстэй, нарийн түвшний таагүй дурсамж, сэтгэгдлийг зөвхөн харагдахгүй, мэдрэгдэхгүй, нарийн түвшний аялгууны урсгалаар л угаан цэвэрлэнэ.

(“Чанагуух ертөнцийн аялгуу” айлдварааc)



Дэлхийн энх тайван ба олон улсын хүний эрхийн төлөө даатгах Олон улсын долоо хоногийн даяан бясалгал. 1995 оны 5 сар. Формосагийн Тайпэй хотын Хуанья зочид буудал.

Өндөр түвшний бясалгагч хүнд Багштайгаа уулзсан ч яримаар зүйл байдаггүй. Харин Багшийгаа харах үнэхээр дуртай. Уулзахгүй удвал сэтгэлийн гүнд тун их санагалзан, ямар нэг юмаа гээсэн мэт болдог болохоор Багшийгаа зорин ирдэг. Тэгээд бид хоёр хэсэг зуур ширтэлцэнэ. Дараа нь тэр явж, би бясалгана. Энэ бол бидний багш шавийн харилцаа болно.

(“Арьяабалын аргаар бясалгахын ач тус” айлдварааc)

БИЛГИЙН МЭЛМИЙН НУУЦ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
айлдвар. Формосагийн Пэнхү.
1987 оны 2 дугаар сарын 16
(*Эх нь хятад хэлээр*)

Шагжамуни Буддагийн хэлснээр бид бүгд Бурхан чанартай мөртлөө яагаад түүнийгээ олдоггүй вэ? Багш нь өнөөдөр энэ талаар ярья. Бид бас "Бурхан сэтгэлд буй." гэж ярьдаг ч яагаад олохгүй байна вэ? Буддагийн хэлснээр хамаг амьтан бүгд Бурхан. Тэгвэл яагаад сайн хүн, муу хүн гэж байдаг юм бэ? Өнөөдөр энэ тухай ярья.

Хоёр гурван хоногийн өмнө Багш нь ариун орон, бохир орны талаар ярьсныг та нар санаж байна уу? Ариун орон, бохир орны дунд тэдгээрийг тусгаарласан нэгэн ертөнц байдаг. Тэрхүү ертөнц тас хар, түнэр харанхуй, замгүй, гэрэлгүй. Бидний сонссоноор ариун орон, Авид бурханы оронд хорт үйл, эрэгтэй, эмэгтэй, эрлэг там, муу муухай гэж байхгүй. Католик шашны хувьд энэ нь диваажин болно. Энэхүү диваажинг Шагжамуни Будда: "Бурхан чанар юм уу эсвэл Уг дүр." гэжээ. Есүс Христ түүнийг диваажин гээд: "Диваажин бидний дотоодод бий." гэжээ. Тийм бол бид яагаад олохгүй байгаа юм бэ? Хэрэв бидний дотоодод диваажин оршдог бол бид их сайхан сэтгэлтэй байж таарна. Тийм үү? Гэтэл хүн бүр сайхан сэтгэлгүй байдаг. Яагаад тэр вэ? гэж бид өөрсдөөсөө асуудаг. Үүний шалтгаан нь бохир орон, ариун орон хоорондоо холбогдохгүй байгаад оршино.

Орчлон ертөнцийн тухайд гэвэл, гурван ертөнцийн дотор хүн, тэнгэр, асури, бирд, там, адгуус оршино. Гурван ертөнцийн гадна ариун орон, Бурханы орон байдаг. "Бурханы гэрэл мөнхөд гийгүүлнэ." гэж бид үргэлж ярьдаг бөгөөд энэ нь "Цаглашгүй гэрэл" гэсэн утгатай. Хаа сайгүй гэрэлтэй байхад яагаад манай гурван ертөнцийн дотор энэхүү бурханы гэрэл байдаггүй юм бэ? Яагаад ийм эмх замбараагүй ертөнц болж хувирсан бэ? Учир

нь хоорондоо тас хар, түнэр харанхуй ертөнцөөр зааглагдсанаас болжээ. (*159-р хуудасны 1-р зургийг лавлаж үзнэ үү)*. Багш нь орчлон ертөнцийн талаар ярихад та нар түүнийг зөвхөн гадаад тал төдийгөөр бүү бод. Тэр бидний дотоодод бас оршин байдаг. Бид бол бичил орчлон юм. Орчлон ертөнцийн гадаад байдал ямар байна, бидний дотоодод бас тийм байна. Тиймээс бидний дотоодод бас тэрхүү харанхуй газар бий.

Бидний толгойноос дөрвөн мөч хүртэл билиг ухааныг саатуулж нэвтрүүлдэггүй, нэвтрүүлсэн ч гажуудуулдаг нэгэн харанхуй газар байдаг. Бидний оюун ухаан, билиг ухаан сайн сайхан зүйл бодож төлөвлөсөн ч хэрэгжихээрээ тааруухан үр дүнтэй болдог. Тэрхүү хаалттай хаалга шиг газрыг нээж байж билиг ухаан ундран гарна. Сайн нээвэл “Бурханы гэрэл”-ийг харна. Бурханы гэрэл бол бидний билиг ухаан мөн.

Иймээс түүнийг “Билгийн мэлмий “, “Гуравдагч нүд”, эсвэл “Бурханы мэлмий “ (*Их Багш магнай руугаа заав*.) гэдэг. Гэвч энд хоёр хаалга байдгийг анхаарах хэрэгтэй. Нэг нь зөвхөн гурван ертөнц доторх хамгийн дээд хэсэг рүү нэвтэрдэг. Бурханы шашинд түүнийг “Эсэрваа тэнгэр” гэнэ. Хэрэв энэхүү хаалга нээгдвэл бага зэргийн билиг ухаан, буян хишигтэй болно. Нөгөө хаалгаар нь гурван ертөнцийн гаднах хязгааргүй түвшин лүү нэвтэрч болдог. Миний ярьж буй “Билгийн мэлмий” нь энэхүү гурван ертөнцөөс хэтийдсэн хаалгыг зааж байна.

Ихэнх хүний хоёр хаалга бүгд хаалттай, заримынх нь гурван ертөнцийн доторх хаалга жаахан нээгдсэн төдий байдаг. Их нээгдвэл тодорхой түвшин юм уу гэрэл харна. Гэвч эдгээр нь (хоёрдугаар зэрэгт харьяалагдах) гурван ертөнцийн доторх гэрэл, гурван ертөнцийн доторх түвшин юм. Зөвхөн Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийвэл билгийн мэлмий нээгдэж, Бурханы гэрэл сая мөнхөд гийгүүлэх болно. Хэрэв бүгд хаалттай бол Бурханы гэрэл ариун орноос ирж гийгүүлэхгүй. Ирсэн ч энэхүү харанхуй газраас болж харлаж бохирдоно. Иймээс магнайнаас доошихыг бохир орон, магнайнаас дээшихийг ариун орон, диваажин гэж болно. (*159-р хуудасны 2-р зургийг үзнэ үү*.) Нэр чухал биш, зөвхөн хэлний ялгаа төдий. Арьяабалын бясалгалын аргаар дадуулан бясалгадаг хүний билгийн мэлмий нээгдэж, Бурханы гэрэл мөнхөд гийгүүлнэ. Тэгээд бясалгал дадуулах тусам өөрийнхөө эзэн болж, билиг ухаан маань энэхүү харанхуйгаар бохирдож, буруу ташаа мэдээлэл болж хувирахгүй.

Ариун орон бол ариун орон, бохир орон бол бохир орон тул харилцан холбогдохгүй. Учир нь энэхүү харанхуй хана зааглаад

гурван ертөнцөөс дээш гаргахгүй тул бидэнд ариун орон, жинхэнэ диваажинг мэдүүлдэггүй. Гурван ертөнцийн дотор яг л шорон шиг байдаг. Энэ харанхуй ертөнц нь гадна талын эрх чөлөөт ертөнц болон шорон гянданг хооронд нь тусгаарладаг давшгүй өндөр хана хэрэм юм.

Ариун орон нь бидний билиг ухаан, бие махбодтой холбоотой. Жишээ нь, ариун орон бидний дээд хэсэгт, тархинд оршино. Эндээс (*Их Багш магнай дахь билгийн мэлмийгээ заав*.) дооших нь бохир орон. Иймээс билиг ухаантай хүнийг "толгой сайтай" гэдэг. Тийм үү? Оюун ухаан бол биднийг удирдах төв юм. Хэрэв түүний тушаалыг дамжуулж чадахгүй бол маш их алдаа гаргана. Иймээс ухаан муутай, эсвэл ухаан санаа нь самуурсан гэхчлэн ярьдаг. Билгийн мэлмийгээс дээших нь ариун орон, Бурхан чанар, диваажин бөгөөд гурван ертөнцийн гаднах газар болно. Билгийн мэлмийгээс дооших нь бохир орон, гурван ертөнцийн доторх, сансрын хүрдэнд эргэлдэх газар болно. Бид нэлээд цэцэн ухаантай хүнийг ажвал түүний энэ хэсэг (*Магнайн хэсгийг заав*.) нэлээд өргөн байдаг. Магнайнаас дооших нь бүгд ялгаруулах систем болно.

Төгс Гэгээрсэн Их Багшаар заалган удирдуулбал сүнслэг бясалгагчийн билиг ухаан улам илүү нээгдэнэ. Харин Төгс Гэгээрсэн Их Багшаар заалгахгүй бол буруу хаалгаа нээж дадал бясалгал нь буруудаж тун магадгүй. Хэрэв хэн нэг хүн өөрөө бясалгал дадуулвал ид шидтэй болж болзошгүй. Бидний биед олон "хүрд" байдаг. Энэ бол (*Билгийн мэлмийг заав*.) төв удирдлага нь юм. Доошилбол хоолой, зүрх, наран сүлжээ зэрэгт бүгдэд нь бий. Зарим бясалгагч хэлээ матийлгаж тагнайдаа хүргээд рашаан ус хүртэж байна гэдэг ч энэ нь жинхэнэ рашаан биш. Харин Арьяабалын аргаар бясалгал дадуулдаг хүн "хэлээ хөдөлгөхгүйгээр" жинхэнэ рашааныг хүртэнэ. Хэрвээ билгийн мэлмийгээс дооших хүрдүүдийг бясалгавал ид шидийг олж болох ч гурван ертөнц дотроо л байдаг. Бүтэх, орших, эвдрэх, устах түвшинд л байх тул билгийн мэлмийнээс дооших хүрдүүдийг бясалгавал гурван ертөнцийг давахгүй. Үүрд туулан гэтэлж чадахгүй!

Хэрвээ бясалгал дадуулж гурван ертөнцөөс хэтийдье гэвэл заавал билгийн мэлмийгээс эхлэх хэрэгтэй. Гэвч зарим хүн хамгийн доод төвөөс эхлэн шат шатаар өгсүүлэн бясалгадаг. Ингэх нь үнэндээ хэтэрхий удаан, хүнд хүчир. Тэд нэг насаараа бясалгаж байж л дээшээ мацаж гарна. Харин манай тогтолцоо билгийн мэлмийгээс эхэлдэг. Урьд цагт энэтхэгт иогийг бясалгаж

байгаа хүн нэлээд цаг завтай байсан тул юуг ч бясалгаж болдог байсан.

Эдүгээ гэртээ суудаг хүнд тийм ч их цаг байхгүй. Бясалгахын зэрэгцээ мөнгө олох, гэр орондоо санаа тавих хэрэгтэй. Дооросс алгуур мацах маягаар бясалгавал дээд дэсэд хүрэлгүй ангижирч магадгүй. Иймээс дадал бясалгал хийе гэвэл сайн тогтолцоог хайж олох хэрэгтэй.

Багшгүй ганцаар бясалгаад аль нэгэн хүрдээ нээж магадгүй. Жишээ нь, наран сүлжээгээ нээвэл гал чанар ихсэж, зан ааш муудан бэлгийн дур хүсэл ихсэж мэднэ. Зарим хүрдээ нээгээд өөрөө хааж дийлэхгүй, хамгаалж чадахгүй болохоор ад чөтгөрүүд тэрхүү хүрдээр дамжин ороод бие махбодыг нь эзэмддэг. Иймээс бид Төгс Гэгээрсэн Их Багшийг дагаж, хамгаалалттай бясалгалын аргаар бясалгал дадуулвал төвөг учрахгүй.

Бясалгал хийдэггүй байхад ямар ч ад түйтгэргүй юм шиг байсан. Харин бясалгал дадуулснаас хойш адын саад тотгор ихсэж, элдэв янзын сүнс үймүүлэн түйвээх болсон гэж олон хүн Багшид нь хэлдэг. Энэ нь хүрдүүдээ замбараагүй нээснээс, эсвэл Багшийнх нь хүч нь хүрэлцэхгүйгээс болдог. Бясалгал дадуулсны дараа зарим нэгэн хүрдүүд аяндаа нээгдэнэ. Жишээ нь, та иймэрхүү маягаар бясалгавал зарим хүрдээ нээж чадна. Хэрэв амьсгалаа удирдахдаа хянуур болгоомжтой байхгүй бол наран сүлжээг хөндөх аюултай. Энэ нь гал чанар ихтэй болохоор догшин зантай, уурлаж уцаарламтгай, эсвэл эр эмийн харилцаанд орох дуртай болох зэргээр өөрийн биеэ хянаж чадахгүйд хүрдэг.

Төгс баясгалант ариун орон нь бидэнтэй харилцан холбоотой байдаг. Бидний бие махбод бол нэгэн бичил орчлон ертөнц юм. Гадна тал бол их орчлон ертөнц мөн. Бидний билгийн мэлмийгээс дээших нь ариун орон, дооших нь гурван ертөнцийн доторх бохир орон болно. Учир нь билиг ухаан энд бий. (*Их Багш магнайгаа заав*.) Иймд аливааг бодох, хийхдээ уураг тархи, оюун ухаанаа ашиглах хэрэгтэй. Заримдаа ямар нэгэн зүйлийн учрыг ойлгохгүй үед хөмсгөө зангиддаг. Жишээ нь, хэн нэгэнтэй хаана уулзсанаа эргэн санахыг хичээх үед хөмсгөө зангиддаг биз дээ? Энэ үед бид оюун бодлоо гуравдагч нүд, билгийн мэлмийдээ төвлөрүүлдэг. Ингэвэл асуудлыг нэлээд шуурхай шийдвэрлэнэ. Энд бидний билиг ухаан оршдог болохоор билгийн мэлмий, гуравдагч нүд, номын нүд, Бурханы мэлмий, Бодьсадвагийн мэлмий гэж нэрлэдэг.

Шагжамуни Буддагийн билиг нээгдсэн учраас магнайдаа ийм мэлмийтэйг бид мэднэ. Бидний эгэл хүмүүс хэрвээ дадал

бясалгал хийдэггүй, туслах Төгс Гэгээрсэн Их Багшгүй бол билгийн мэлмий хаалттай хэвээр байдаг. Энэхүү хаалттай газар нь Багшийнх нь саяын хэлсэнчлэн орчлон ертөнцийн тэрхүү харанхуй түвшинтэй холбоотой. Энэ хана хэрэм нь ариун орон, бохир орныг тусгаарлаж, ариун орны цаглашгүй гэрлийг доош нэвтрүүлэхгүйн тулд байдаг. Гэвч бидний билгийн мэлмий нээгдвэл цаглашгүй гэрэл (Бурханы гэрэл) саадгүй гэрэлтүүлнэ. Яг л замтай боловч түгжрээд нэвтэрч чадахгүй байснаа нээгдсэн мэт.

Хэрэв билгийн мэлмий нээгдвэл билиг ухаан дээрээс дөрвөн мөч, бүхий л бие махбодод хүрэх тул юу ч хийсэн тов тодорхой, тун ойлгомжтой, шулуун шударга байдаг. Учир нь энэ үед билиг ухаан бүхий л бие махбодод нэвтрээд ямар ч саад тотгоргүй болсон байдаг.

Иймээс билиг ухааны хүрдэн дээр бясалгал дадуулах нь хамгийн дээд нь бөгөөд бусад хүрдүүд нь бүгд ялгаруулах систем юм. Та нар хар л даа. Нүднээс нуух нулимс, хамраас нус гоожно. Чихнээс хулхи, амнаас шүлс, цэр, шулуун гэдсээр бохир ялгадас гарч, доошлох тусам муухай болно. Бидний биеийн есөн сүв бүхнээр бохир зүйлс гадагшилна. Ялгаруулах систем учраас бүтэх, орших, эвдрэх, устахтай адилхан болохоор эдгээр хүрдэн дээр бясалгал дадуулах нь аюултай, тэгээд ч мөнх бус.

Багш нь зөвхөн ерөнхий байдлыг л ярьж байна. Ном уламжлах үед ямар ертөнц ямар байдалтайг тодорхой тайлбарлаж өгнө. Гэхдээ одоо бясалгалын аргыг ил тодоор ярьж болохгүй. Яриад ч нэмэргүй. Та нар хариад эмх замбараагүй туршвал ад шүглэнэ. Номыг жинхэнээр уламжлах үед бүх зүйл тодорхой. Эхлээд бие, хэл, сэтгэлээ ариусгах бөгөөд дараа нь Багш ном уламжилна. Үүнийг бүгд мэдэх тул одоо ярихгүй. Бага зэрэг ярьж та нарт сонирхуулсан төдий.

Зарим хүн урьд насны бясалгал дадлын буян нэлээд ихтэйгээс билиг ухааны хүрд нь бүрэн хаагдаагүй байдаг тул цэцэн ухаантай, өндөр ёс суртахуунтай байдаг. Урьд төрлүүддээ бясалгалыг сайн дадуулж, өндөр түвшинд хүрсэн бол билгийн мэлмий төдий хэмжээгээр их нээгдсэн байдаг. Мөн бусдын аль хүрд нь нээгдсэн, аль нь нээгдээгүйг билгийн мэлмийгээрээ харж чаддаг. Төгс Гэгээрсэн Их Багштай учирч чадвал билгийн мэлмий бүрэн хаалттай байсан ч хамаагүй, Тэр бидэнд туслан билгийн мэлмийг маань дор нь нээж өгдөг. Яг л цоожинд түлхүүр хийж эргүүлмэгц онгойдогтой адил. Түлхүүртэй бол ямар ч асуудалгүй.

Иймд эртнээс нааш өрнө, дорнын сүнслэг бясалгагчид бүгд

л амьд сэрүүн Төгс Гэгээрсэн Их Багшийг чухалчилдаг. Бид одоо өнгөрсөн үеийн Төгс Гэгээрсэн Их Багшид мөргөж байна. Учир нь бид Түүнийг хүндэтгэн биширч, өөрсдөө нэг л өдөр Шагжамуни Будда шиг болно гэж мөрөөддөг. Гэвч Шагжамуни Будда энэхүү ертөнцөөс хэдийнээ ангижирсан тул бидний үүд хаалгыг нээн өгч чадахгүй. Тэрээр амьд сэрүүн өөр нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшид түлхүүрээ дамжуулжээ. Үүдээ нээе гэвэл ангижраагүй, амьд сэрүүн Их Багшийг хайж олбол Тэр бидэнд тусална.

Ариун орноос бохир орон хүртэл ямар ч холбоо барих газаргүй. Хэрэв холбогдъё гэвэл энэ түлхүүрийг ариун орноос бохир оронд авчрах хүн хэрэгтэй. Учир нь түлхүүр ариун орноос шууд унаад ирэхгүй. Унаж ирсэн ч гэсэн түрүүчийн ярьсан орчлон ертөнцийн дээр орших тэрхүү харанхуй газарт Бурханы гэрэл замхран арилахтай адил гээгдэн алга болж мэднэ. Билгийн мэлмий нээгдэхгүй бол бидний билиг ухаан дөрвөн мөчиндөө хүрэх аргагүй болж сэтгэл зүрхээ хянаж чадахгүй. Иймээс бид заримдаа уурлая гэж бодоогүй ч уурладаг. Ажлаа сайн хийе гэсэн ч чаддаггүй. Учир нь жинхэнэ билиг ухаан энэхүү харанхуй ертөнцөд халхлагдан саатуулагдсанаас болжээ.

Үүнтэй адил цэвэр ариун Бурханы гэрлийг энэхүү ертөнцөд авчрахад цахилгааны утас шиг хамгаалах багаж хэрэгтэй. Хэрэв дамжуулагч утасгүй бол цахилгааныг энд авчирч чадахгүй. Цахилгаан гүйдэл байгаа ч багаж хэрэгсэл ашиглаж байж л түүнийг хамгаалж, хадгалж чадна. Дахиад жишээ авъя. Уулнаас ус татахад усны хоолойгоор татахгүй бол ус бохирдож, хэрэглэж болохгүй болно. Иймээс амьд сэрүүн Төгс Гэгээрсэн Их Багш усны хоолойн адилаар усыг эх ундаргаас нь аюулгүй, цэврээр нь бидний гэрт хүргэж ирдэг.

Гагцхүү билгийн мэлмий (Бурханы мэлмий, Номын нүд гэх мэт)-гээ нээж байж л бид Бурхан болж чадна. Иймээс “Цэцэг дэлгэрвэл Бурханыг харна.”, эсвэл “Чанараа харвал Бурхан болно.” гэдэг. Үнэндээ ийм хялбархан, огтхон ч ярвигтай биш. Гэвч олонх хүний хувьд яаж тийм хялбархан Бурхан болох вэ дээ? гээд итгэлгүй байдаг. Яагаад хялбар бус гэж? Шагжамуни Будда “Бурхан сэтгэлд буй.” гэж хэлсэн. Тийм үү? Хэрэв Бурхан сэтгэлд байдаг бол яагаад хурдан олж чаддаггүй вэ? “Бурхан сэтгэлд буй.” гэсэн нь мөнгөө уутанд хийсэнтэй адил. Уут хаана байгааг мэдэж байвал мөнгөө авч чадна. Бурхан сэтгэлд буй гэдэг нь мөн адил. Сэтгэл хаана байгааг мэдвэл Бурханыг тун хурдан олно.

Есүс Христ ч бас: “Диваажин бидний дотоодод буй.” гэжээ.

Хэрэв энэ үг буруу бол хүмүүсийг хуурч буй хэрэг. Гэвч

ингэх боломжгүй. Тэд бол эртнээс нааших хамгийн агуу хоёр Төгс Гэгээрсэн Их Багш юм. Хэрэв Тэд хүмүүсийг мэхэлсэн бол бид одоо болтол тэгж ихээр шүтэхгүй байх байсан. Энэ хоёр Их Багш болон Лууз нь хамгийн их алдаршиж, хоёр, гурван мянган жил өнгөрсөн ч нэр хүндтэй хэвээр, улам олон хүн итгэж шүтсээр байна. Энэ нь тэдний номлол сургаал гарцаагүй үнэн зөвийг илтгэнэ. Учир нь хүн бүхэн мунхаг биш тул зарим нь бясалгаж, билиг нь нээгджээ. Тэд Шагжамуни Будда, Есүс Христийн сургаалын зөв эсэхийг ойлгож чадна. Хэрэв буруу байсан бол тэд бас хариу хэлнэ шүү дээ! Гэвч хоёр мянга гаруй жилийн хугацаанд хамаг амьтад, аливаа бясалгагчид, их бага гэлтгүй бүгд бишрэн шүтсээр байгаа нь Тэдний хэлсэн бүхэн үнэн зөв гэдгийг илтгэж байна.

Яагаад зарим нь цэцэн сэргэлэн, зарим нь мунхаг тэнэг, зарим нь сайн санаатай, зарим нь хэрцгий догшин байдаг вэ? гэж Багш нь ном тайлж эхлэхдээ асуусан. Учир нь энэ бүхэн билгийн мэлмий нээгдсэн эсэхтэй холбоотой. Ариун орон, бохир орон хоорондоо нэвтрэлцсэн эсэхтэй холбоотой. Бид яагаад сүнслэг дадал бясалгал хийх ёстой вэ? гэж зарим хүн асууж магадгүй. Учир нь бид бичил ертөнц бөгөөд их орчлонтой холбоотой. Хэрэв манай бичил ертөнц амар амгалан бус, эмх замбараагүй бол гадна талд ч бас адил. Хэрэв бичил орчлон маань их орчлонтой холбогдоод “нэг цогц” болбол бид зохиролтой болдог. Үүнийг Бурханы шашинд “Аливаа нь сэтгэлээр зохиогдсон.” гэдэг. Есүс Христ: “Би Эцэгтэйгээ нэгдмэл нэг.” гэжээ. Лууз бас: “нэг” (нэгдмэл нэг)-ийн дэсийг олох байдлыг хэлжээ. “Даодэжин”-ийн 39-дүгээр бүлэгт: “Эртнээс нааш нэгийг ологсод, тэнгэр нэгийг олбоос тунгалаг болмуй, газар нэгийг олбоос тогтуун болмуй, сахиус нэгийг олбоос шидэт болмуй, горхи нэгийг олбоос бялхам болмуй, хамаг бодис нэгийг олбоос өсөн төлжмүй, ноёд хэргэмтэд нэгийг олбоос хаан эзэн болмуй.” гэжээ.

Тиймээс бясалгал дадуулах нь бичил ертөнцөө эмхлэн цэгцэлж, “Жинхэнэ би”-гээ өөрийн эзэн болгохын төлөө юм. Ийм явдал бидэнд үргэлж тохиолддог. Уурлая гэж бодоогүй ч уурладаг. Аядуу зөөлөн үг хэлье гэж бодсон ч амаа захирч дийлэлгүй бусдын сэтгэлийг сэвтээх явдал байнга тохиолддог. Хүн зодох санаагүй ч гар маань заримдаа ухаан бодлоос өрсөнө. Үнэндээ хүн зодож болохгүйг билиг ухаан сануулсан ч харанхуй ханыг нэвтрэхдээ утга санаа нь өөрчлөгдөж зодож болох болж хувираад бид биеэ ч захирч дийлэхгүй эзний эрхээ алддаг.

Бид өөрийн биеэ хянаж захирч чадахгүй бол гадаад ертөнц

ч мөн эмх замбараагаа алдана. Өөрийгөө захирч чадвал ертөнц энх амгалан болно. Аливаа нь сэтгэлээр зохиогдсон гэдэг нь ийм утгатай. Иймээс бид “Сэтгэл ариун бол улс орон ариун.” гэдэг. Энэ нь эр нөхрөө захирвал гэр бүл эв найртай гэсэн үг биш. Эхнэрээ байнга зодож дарамталбал гэр бүл эв найртай гэсэн үг бүр ч биш. Эв найртай байя гэвэл эхлээд өөрийгөө өөрчлөх хэрэгтэй. Ингэвэл эхнэр чинь бас өөрчлөгдөнө. Өөрчлөгдөхгүй байлаа ч бидний сэтгэл тогтуун байдаг. Есүс Христ: “Хэрэв хүн баруун хацрыг чинь алгадвал зүүн хацраа тавьж өг.” гэсэн. Учир нь сэтгэлд хорсолгүй, хүн зодох сэтгэлгүй, жаахан загнуулж зодуулсан ч сэтгэл юман чинээ тоохгүй болдог.

Бясалгал хийдэггүй байхад хүн намайг нэг цохивол би тэр дор нь хэдэнтээ хариу цохино. Дадуулан бясалгадаг болсны дараа хүн энд цохивол “тэнд бас цохичих, хоёуланд нь цохичихвол шударга.” гэж хэлнэ. Цохиулах нөхцөл нь адил боловч хүлээж авах сэтгэлийн түвшин эрс өөрчлөгджээ. Бид энэхүү ертөнцийг өөрчилсөн юм биш, харин сэтгэл амарлингуй болсноос ертөнц бидэнтэй хамааралгүй болж, нөлөөлөхөө больжээ. Бид бүрэн өөрийнхөө эзэн нь болж, уурлая гэвэл уурлана, уурлахгүй гэвэл уурлахгүй. Зургаан эрхтэн зургаан мэдрэхүйдээ захирагдахгүй, мөн энэхүү харанхуй газарт захирагдахгүй. Махан биеэ бүрэн эрхшээж, түүгээр юу хийлгэхийг хүснэ, түүнийгээ хийлгэнэ.

Иймээс зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн: “Ариун орон тийм хол биш, Төгс баясгалант орон ч холгүй.” гэжээ. Төгс баясгалант орон энд бий. (*Их Багш билгийн мэлмийгээ заав.*) Хэрэв бид сайн аргаар дадуулвал бүх түвшин энд байдгийг (*Их Багш билгийн мэлмийгээ заав.*) биеэрээ мэдэрч болно. Бид их өндөрт авираад нисээд төгс баясгалант оронд оччихгүй. Үнэндээ очихоор газар ч байхгүй. Иймээс “Сэтгэл санаа ариун бол улс орон ариун.” гэжээ. Учир нь энэхүү бичил орчлон их орчлонтой харилцан шүтэлцээтэй. Иймээс Лууз: “Сүнслэг бясалгагч гэрээсээ гарахгүй ч, хаа ч очилгүйгээр ертөнцийн явдлыг мэднэ.” гэжээ. “Даодэжин”-ийн 47-дугаар бүлэг: “Гэрээс гарахгүй ч дэлхий дахиныг мэдэх болно.” гэжээ. Учир нь тэд бясалгал дадуулсны дараа бичил орчлон нь их орчлонтой холбогдсон болохоор хаа сайгүй оршиж, хамаг бүхнийг мэднэ.

Иймээс нэгэн хүн Бурхан болбол бид түүнийг “Түүнчлэн ирсэн” гэнэ. Түүнчлэн ирсэн бол ирэхгүй очихгүй, Тэр хэдийгээр энд байх ч хаана ч оршино, тэр үед бид Түүнийг нэгэнт “Бурхан” болжээ эсвэл “Түүнчлэн ирсэн” болжээ гэнэ. Гагцхан Шагжамуни Будда л түүнчлэн ирсэн болдог юм биш. Өнөө

цагийн хүн ч бас болж болно, бид бүгдээрээ болж болно. Багш нь бусдаас сонсчихоод түүнчлэн ирсэн болж болно гэж та нарт ярьж байгаа юм биш, харин өөрийн биеэр мэдэрснээ ярьж байгаа тул баталгаатай.

Жинхэнэ түүнчлэн ирсэн байдал гэдэг нь жишээлбэл, нэгэнт "Дао"-гоо олсон хүн бие нь энд байвч өөр газар ном уламжилж, багшилж байгааг, эсвэл диваажинд хүн сургаж буйг нь бусад хүн олж үзнэ. Иймээс бид Буддаг "Тэнгэрийн орон, хүний ертөнцийн жолоодогч багш", "Дөрвөн төрөхүйн энэрэлт эцэг" гэдэг нь ийм утгатай. Ариун оронд очсон ч Түүнийг харна. Тэр ч байтугай нэгэн өдөр баярлаж хөөрсөндөө эрлэг тамд очиж үзье гэвэл тэнд ч Түүнтэй учирна. Учир нь "Түүнчлэн ирсэн" болохоор хаана ч Түүнийг харж болно. Тэрээр ирэхгүй, очихгүй. Энэ үед Тэрээр энэхүү бие махбод биш, харин номын ертөнцтэй нэгдмэл болдог. Будда бол номын ертөнцийн биелэл, Тэр бол номын ертөнцөөс ялгаагүй. Түүнийг хамаг амьтнаас тусгаарлах цаг хугацаа, орон зай үгүй. Учир нь энэ үед Тэр хамаг амьтантай нэгдсэн болохоор хаана ч гэсэн хамаг амьтан Түүнтэй уулздаг. Гэвч Тэр хамаг амьтан биш.

Төгс баясгалант орны түвшин нь гурван ертөнцийн доторхтой нэвтрэлцэн холбогдож чадахгүй бол гурван ертөнцийн дотор ихэд самуурах болно. Үүнтэй адил бидний дээд билиг ухаан магнайнаас дооших хэсэгтэй нэвтрэлцэж чадахгүйд хүрвэл мөн л самуун байдал үүснэ. Энэ нь зарц боолууд нь гэртээ байгаа ч гэр нь эзэнгүй юм шиг, утас нь холбогдохгүй байгаатай адил. Тэд ухаан муутай хэрхэхийг эзнээрээ заалгуулж нэгэнт дадсан болохоор эзэн нь гэнэт явж, утас нь ажиллахгүй бол захиа ч бичиж чадахгүй тул эмх замбараагаа алдаж, юуг ч ёс журмаар нь хийж чадахгүй болно.

Хүмүүс бясалгаж заримдаа самадид орохоороо ертөнцөөр тойрон аялж, Америкт ямар байдгийг, дэлхийн үймээн самуун хэр байгааг очиж үздэг гэж бид сонссон. Энэ нь жирийн сүнсний аялал болохоос "Түүнчлэн ирсэн" биш. Үүнийг англиар Astral Projection (Сүнс гарах буюу сүнсэн биеэр аялах.) гэдэг. Энэ нь түүнчлэн ирсэнтэй хамаагүй, огт адилгүй.

Одоо Багш нь зураг дээр үзүүлье (*159 дүгээр хуудасны 3-р зургийг үзнэ үү*), тухайлбал энд нэг хүн байна гэж бодъё. Гадуур нь давхар давхар биеэс бүрхжээ. Бидний "Уг дүр", бидний "Эзэн", эсвэл бидний "Жинхэнэ бие", "Бурхан чанар", "Диваажин", "Сүнс" гэх зэрэг нь хамгийн дотор талд байна. Тэднийг юу ч гэж дуудсан болно. Бидний Бурхан чанар хамгийн дотор талд

хүлэгдчихээд, тэндээс гарч чадахгүй байна. Гэвч зарим хүн Astral Projection-ыг хэрэглэвэл гарч болох боловч энэ нь түүнийг Бурхан чанараа олсныг илтгэж буй хэрэг биш. Харин тэрээр Astral body (давхар давхар биес болон жинхэнэ биеийг дотроо багтаасан) астрал биеийг хэрэглэн гарч яваад, зөвхөн махан биеэ үлдээсэн байна. Энэхүү давхарласан биес нь нийтдээ долоон давхаргаас бүрдэнэ. Католик шашныхан долоон давхар тэнгэр гэнэ. Лалын шашныхан ч үүнтэй ижил зүйл ярьдаг бөгөөд энэ нь бидний бие махбодтой холбоо хамааралтай юм. Ойлгов уу?

Иймээс энэ нь бас л түүнчлэн ирсэн биш, Бурхан чанар ч биш. Учир нь Бурхан чанарыг хэрэглэн хаашаа ч очих шаардлагагүй. Ертөнцөд болж буй хэрэг явдлыг эндээсээ мэднэ. Адилхан л иднэ, унтана, явна, ярина, гэвч бүгдийг мэднэ, хаана ч оршино. Жишээлбэл, Багш нь одоо энд ном тайлж байна. Тайбэйд байгаа зарим хүн бясалгаад ч, бясалгахгүйгээр ч (энэ нь тэдний бясалгалын түвшнээс хамаарна) Багшийг нь тэнд байгааг хардаг. Түүнд хэрэгтэй зүйл байвал Багшийнх нь хувилгаан бие очиж тусална. Энэ нь Astral Projection (сүнс гарах)-ын төлөв байдалтай адилгүй. Учир нь "сүнс гарах"-даа давхар давхар биесээ авч яваад зөвхөн махан биеэ үлдээдэг. Бусад бүх биесээ аваад олон газраар аялсны дараа угийн биедээ эргэж орно. Энэ нь хананд өлгөөтэй хувцсыг өмсөх, эсвэл гараад буцаж ирэхтэй адил. Гэр орон, байшин сав нь байсан янзаараа, харин аялж дуусаад авч явсан ачаа бараа, мөнгө зоос, алив бүхнээ буцааж авчирна.

Гэвч энэ байдал нь түүнчлэн ирсэн биш. Түүнчлэн ирсэн гэдэг нь бясалгах үед л ирдэг юм биш. Учир нь Тэр түүнчлэн ирсэн болохоор оршихгүй газаргүй. Иймээс Тэр хэдийгээр явах, идэх, унтах, ярих, ном тайлах мэт энгийн үйл хийж байгаа ч оршихгүй газаргүй тул алив бүхнийг шийдвэрлэж чадна. Тэрээр бусад төрөлтнүүд болон авшигтнуудад тусалж чадна.

Үүнийг "Хотол зохилдогч зүйл"-д бас дурдаж байсан. "Хотол" гэж юу гэсэн үг вэ? Хотол гэдэг нь оршихгүй газаргүй, нийт хотлоор нь туулан гэтэлгэнэ, "зохилдогч" гэдэг нь бясалгалын арга гэсэн үг. Шагжамуни Буддагийн хэлсэн санаа бол Арьяабалын аргаар бясалгал дадуулаад бид аль ч газрыг мэдэж, хаана ч орших учраас "Түүнчлэн ирсэн" болно. Өөрөө ч энэхүү Хотол зохилдогч, Арьяабал бурхан болж хувирна. Хамаг амьтан ямар ч газраас, юу ч хүссэн бүгдийг мэдэж даруй аварна. Ямар ч хэрэг учир гарсан бүхнийг сонсож харж чадна. Үүнийг Тэр билгийн мэлмийгээрээ харж байдаг бөгөөд үүнийг тэнгэрийн нүд, тэнгэрийн чихтэй хольж хутгаж болохгүй. Тэнгэрийн чих,

тэнгэрийн нүд нь хотол зохилдогч биш, түүнчлэн ирсний дэс ч биш, үүнтэй огт адилгүй. “Түүнчлэн ирсэн” гэдэг нь Тэрээр түүнчлэн ирсэн сэтгэлээр, Бурханы сэтгэлээр сэрж мэдсэн учраас аливаа бүхнийг мэдэх тул “Хотол” гэдэг билээ. Хэрэв бид Арьяабалын аргаар бясалгал дадуулвал Арьяабал бурхан болж чадна. Иймээс энэхүү бясалгалын аргыг “Хотол зохилдогч” гэжээ. ”Хотол зохилдогч” нь хотлоор гэтэлгэх бясалгалын аргыг тайлах бөгөөд хэрхэн Арьяабал бурхан болохыг хэлж өгдөг ч зөвхөн танилцуулах төдий. Түүнд бясалгалын аргыг дурдаагүй. Хэрэв бид Арьяабал бурханы алдар нэрийн жинхэнэ агуулгыг нь мэдвэл, бид ч Арьяабал бурхан болж болно. Бид байнга Арьяабал бурханы алдрыг уншдаг ч үнэндээ энэ нь Түүний алдар биш. Түүний алдрыг сонсголын онцгой чадвар хэрэглэж байж л сонсоно. Учир нь “Нэрийг нэрлэж болбол мөнхийн нэр бус.” тул эгэл хүний үг хэлээр энэхүү нэрийг дуудаж болохгүй. Түүний жинхэнэ алдар нь Арьяабал бурхан биш гэдгийг Арьяабалын аргаар бясалгал дадуулснаар ойлгож мэднэ. Аливаа үг яриа хэрэглэн хэлж, бичиж байгаа нь бүгд жинхэнэ “Нэр” биш.

Эртнээс нааш Төгс Гэгээрсэн Их Багш нар бүгд л нэгэн адил учир явдлыг тайлдаг. Иймээс бид үг үсгэн дээр маргалдсаны хэрэггүй. Бид өөртөө санаа тавьж, сайн хүн болж, Тэдний номлолыг дагаж суралцвал сайн. Аль “Дао” нь сайн болох талаар маргаан үүсгэх шаардлагагүй. Угаас бид “Дао” гэж юу болохыг ойлгоогүй байж, ямар шашны урсгал сайн болох талаар маргалдсаны хэрэггүй. Бид бусад шашны урсгал ямархуу болохыг мэдэхгүй. “Дао” өгүүлж болбол мөнхийн “Дао” бус. Энэхүү “Дао”-г олсон үедээ л бид энэ талаар ярьж болно. Түүнийг олохоос өмнө бид мунхаг харанхуй хэвээр, дур зоргоороо таацгааж, амаараа нүгэл хураана. “Дао”-г олсны дараа ямар “Дао” нь сайн биш болохыг ухаарна. Олоогүй бол энэ талаар ярихгүй байсан нь дээр. Лууз: “Мэдэж буй хүн хэлэхгүй, хэлж буй хүн мэдэхгүй.” (“Даодэжин”ийн 56 дугаар бүлэг: “Мэдэгч үл өгүүлэх, өгүүлэгч үл мэдэх.”) гэжээ.

Иймээс маргалдах дуртай нэгэн: “Дао” ийм байх ёстой, тийм байх ёсгүй гэхчилэн яривал тэр хүнийг “Дао” гэж юу болохыг ойлгоогүй явааг мэдэж болно. “Дао”-г яаж ярьж тайлбарлаж чадах вэ? Ном уламжлах үед Багш нь юу ч ярьдаггүй. Одоо та нарт ярьж байгаа нь ном уламжилж байгаа хэрэг бус. Зөвхөн бясалгалын арга болон дотоод мөн чанарыг бага сага танилцуулж буй хэрэг. Энэ бол ахуй ойлголт биш. Миний ахуй ойлголт минийх л болохоор та нар ойлгохгүй.

“Дао” өгүүлж болбол мөнхийн “Дао” бус, нэр нэрлэж болбол мөнхийн нэр бус учраас Арьяабал бурхан гэдэг нь түүний жинхэнэ нэр биш болохыг мэдэж болно. Түүний жинхэнэ нэр нь гайхалтай сайхан. “Чанагуух ертөнцийн ялгуусан дуу” гэдэг нэгэн яруу сайхан аялгуу болно. Тэрхүү “Чанагуух ертөнцийн ялгуусан дуу”-г жирийн эгэл хүний чихээр сонсох аргагүй. Иймээс “Хотол зохилдогч зүйл” нь хотол “ном” биш. Хотол “ном”-ыг уламжлах хүнтэй байж олж мэднэ. “Хотол зохилдогч зүйл” нь зөвхөн хотол зохилдогч бясалгалын аргын зарим ахуй ойлголтыг танилцуулсан төдий юм.

Өнөөдөр нэг хүн: “Авид бурханы судар”-ыг уншсан чинь төгс баясгалант ариун орны түвшнийг дүрслэн бичсэн байна. “Газар нь шижир алт, модны навч нь сувд эрдэнэ, бас бяцхан шувуухай дуу дуулна, найман эрдэмт рашаан, лянхуа цэцэг зэрэг байна.” гэж Багшид нь хэлсэн. Тэр түвшин түүнд ямар ч учир утгагүй байсан учраас тийшээ очих дургүй гэж хэлэв. Би ч бас санал нэг байна. Хэрэв Авид бурханы орон иймэрхүү янзтай юм бол би ч бас түүнд шунахгүй. Газар нь шижир алт уу, шороо юу надад хамаагүй, би шижир алтанд, сувд эрдэнэст шунахгүй. Энэ ертөнцөд хэдийнээ шунахаа больсон байтал ариун оронд очоод сувд эрдэнэст нь шунаад юу хийх вэ? Бид эдгээр сувд эрдэнэст, энэхүү үзэсгэлэнт газар шунасандаа ариун оронд очих гэж байгаа юм биш гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ бол хамаг амьтан тэнд очоод танихад хялбарыг бодож Шагжамуни Будда ариун орныг танилцуулсан төдий. Харин бид энэхүү ертөнцөд шунасандаа бясалгал дадуулах гэж байгаа хэрэг огтхон ч биш.

Сүнслэг дадал бясалгал хийгээд төгс баясгалант оронд очвол бид их баяр хөөртэй болох бөгөөд их ач тустай төрөлтөн болж хувирна. Өөртөө тустай, дэлхий ертөнцөд тустай, хамаг амьтныг зовлонгоос аврах их хүчтэй болж, Арьяабал бурхан, Очироорваань бурхан, цаглашгүй гэрэлт Авид бурхан болно. Иймээс бид дадуулан бясалгаад тэрхүү дэсэд хүрэх хэрэгтэй болохоос бус, харин төгс баясгалант ариун орны байдалд шунасандаа бясалгаж байгаа хэрэг огт биш. Мэдээж Бурханы орон бүр ч сүр жавхлантай. Төгс баясгалант оронд очоод шавар шороо, өвс модоор барьсан орд харшийг харах боломжгүй. (*Бүгд инээв*.) Эсвэл манай эндхийн бохир заваан ногооны захтай адил зүйлийг ч харах боломжгүй. Тэрхүү газар их сүр жавхлантай, үзэсгэлэнтэй сайхан, цэвэр цэмцгэр, үнэнхүү гайхамшигтай, гэгээн саруул, бас бус олон гайхшируулсан зүйлс байдаг.

Шагжамуни Будда энэ талаар ярьсан хэдий ч бүрэн гүйцэд дүрслээгүй. Эгэл хүний хэл яриагаар ариун орны тухай яаж ярьж илэрхийлж болох вэ? Гэвч бага сага хэлж ярьж, хүмүүст жаахан ойлгуулж болох юм. Үнэн хэрэгтээ үүнийг бас ярьсан ч юм биш. Түүний шавь бясалгах үеэрээ харсан ахуй ойлголт юм. Учир нь Шагжамуни Будда шавиа дагуулан ариун орныг үзүүлсэнд шавь нь буцаж ирээд үүнийг бичиж үлдээжээ. Будда "Авид бурханы судар"- ыг энэхүү ертөнцөд тайлаагүй.

Хэрэв бид "Цаглашгүй насан хутагт Бурханыг ажихуй судар" -ыг уншвал Войдэхи хатан төгс баясгалант орныг харсан, тэгэхэд Шагжамуни Будда түүнийг хувилгаан биеэрээ дагуулж явсныг мэдэж болно.

Хэрвээ бясалгаж байхад сүнс дээд түвшинд очоогүй бол ахуй ойлголттой болохгүй гэдгийг бясалгагчид бүгд мэднэ. Энэ нь эгэл хүний дэс биш. Учир нь Войдэхи хатан бясалгал дадуулаад хэдийнээ дээд түвшинд хүрсэн тул Буддагийн хувилгаан биетэй хамт өндөр түвшинд очсон ахуй ойлголтоо тэмдэглэн үлдээжээ. Үүнийг зарим хүн Будда махан биеэрээ гянданд нисэж очоод түүнд ном айлдсан гэж тайлбарладаг. Энэ яриа нь зүй ёстой нийцэхгүй байх. Учир нь нэгд, Будда үй түмэн хувилгаан биетэй тул махан биеэрээ тийшээ очих шаардлагагүй. Хоёрт, Буддагийн шавь нар тун олон учраас тэр ганцхан хүний төлөө өөрийн биеэр тэнд очих зав чөлөөгүй.

Саяхан Багшийнх нь хэлсэнчлэн, "Түүнчлэн ирсэн"-ий дэс нь оршихгүй газаргүй гэсэн утгатай. Бид чин сэтгэлтэй байвал Төгс Гэгээрсэн Их Багшийн хувилгаан бие (Түүнчлэн ирсэн)-ийг харах бөгөөд энэ үед Түүний хувилгаан бие бясалгалын дэсэд маань тохирсон түвшинд биднийг дагуулж аваачна. "Авид бурханы судар" ч бас адил. Уг сударт Буддагийн шавь ариун оронд очоод ирсний дараах ахуй ойлголтоо бичиж үлдээсэн ба энэ нь сүнслэг дадал бясалгалын өдрийн тэмдэглэл юм.

Жишээ нь, Багшийгаа ном уламжлах үед та нар ямар ахуй ойлголттой болсон, ямар түвшинд очсоноо бүгдийг бичиж болно. Ном уламжлах тэрхүү мөч нь хувь хүний ахуй ойлголтод хамаарах болохоор та нар ингэж бичиж магадгүй. Тухайлбал: "тэдэн сарын тэдний өдөр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын арга, ариун орны бясалгалын аргыг тайлав. Авид бурхан болон ариун орны байдал, долоон эрдэнийн нуур, найман эрдэмт рашааныг харав." гэх мэтээр бүгдийг бичсэнийг хожим нь Арьяабалын аргаар дадал бясалгал хийдэггүй хүн олж уншвал түүний хувьд эдгээр ахуй ойлголт ямар ч утга учиргүй. Учир

нь найман эрдэмт рашааныг зөвхөн ингэж бичсэнээр ойлгож чадахгүй. Найман эрдэмт рашаан гэдэг нь тун сайхан зүйл, ариун оронд очиж үзэх нь бидний хамгийн баяр баясгалант мөч юм. Жирийн эгэл хүн ариун оронд очиж чадахгүй. Түүнийг харах нь бидний дэс их өндөрт хүрч, нэгэнт буцашгүй Бодьсадва болсныг илтгэнэ. Энэ нь бидэнд болон хамаг амьтдад их ач тустай бөгөөд их хүчтэй болж, хүмүүнийг аврахад тун хялбар болно.

Иймээс ариун оронд шунасандаа дээшээ гарч байгаа юм биш. Ариун орныг олох нь Бодьсадвагийн хутгийг олохын тулд юм. Энэхүү Бодьсадвагийн хутаг л бидэнд хэрэгтэй. Бодьсадвагийн мөрийн хутгийг олбол нэгэн сүр жавхлантай газар сууж таарна. Жишээ нь, чи их сургуулиа төгсөөд эмч болжээ гэе. Энэ үед түрүүчийнхтэй адил гэрэлгүй, умгар байшинд суух уу? Одоо нэгэнт эмч болсон тул мэдээж нэлээд гоёмсог, цэвэр тохилог байранд суувал эмчийн байр суурьтай чинь тохирно. Гэвч чи хамаг амьтны төлөө, өвчтөний төлөө эмч болсноос биш энэхүү гоёмсог байрны төлөө сураагүй. Сурсны дараа сайхан сууцтай болох нь мөн л аяндаа бүтэх явдал.

Жишээ нь, Багшийнхаа ном уламжлах үед зарим хүний харсан төгс баясгалант ариун орны гайхамшигт байдлын талаарх ахуй ойлголтоо бичсэнийг өөр хүн харвал хоосон зүйл шиг санагдана. Гэвч бичсэн хүний хувьд байдал огт өөр. Түүний байр байдал нь өөр, дэс нь адилгүй болж, тун тааламжтай, баяр баясгалантай, уужуу тайвуу болоод билиг ихээр нээгдсэнээ мэдэрнэ. Энэ л хамгийн чухал болохоос түүний харсан зүйл нь чухал биш. Гэтэл түүний тэрхүү байдлыг бид биеэрээ мэдэрч чадахгүй бас ойлгохгүй. Юуны учир түүний харсан ахуй ойлголт нь түүнд тийм чухал вэ? Учир нь түүнд өөрт нь хувиралт гарчээ. Төгс баясгалант ариун орныг харах үед их баяр хөөртэй, нэг л өөр, их хүч чадалтай, ид шидтэй, их билиг ухаантай болдог. Бид өөр хүний ахуй ойлголтын өдрийн тэмдэглэлийг үзвэл мэдээж ямар ч утга учиргүй санагдана. Төгс баясгалант орны тэмдэглэлийг үзэх юм бол мөн л онцын зүйлгүй бодогдоно. Учир нь бид өөрсдөө тэрхүү дэсийн, ахуй ойлголттой болоогүй байдаг.

Жишээ нь, Авшиг хүртэх үеэр Арьяабал бурханыг харлаа гэж нэг нь хэлэхэд нөгөө нь: “Түүнийг хараад ямар хэрэгтэй юм бэ?” гэж тун магадгүй. Түүний хувьд Арьяабал бурханыг харах нь ямар ч утга учиргүй. Гэвч нөгөө хүн: “Зөвхөн энэ төдий биш. Арьяабал бурханаас гадна бас тун гоёмсог орд харш байх бөгөөд Тэр тун үзэсгэлэнтэй газарт амьдардаг. Би Түүнийг харах үед бүхий л бие махбод, ухамсар маань өөрчлөгдсөн.” гэж хариулах

болно. Үүнийг үгээр илэрхийлэхийн аргагүй. Арьяабал бурханыг хараад л ханачих юм биш. Түүнийг харах тэр агшнаа бүхий л бие махбод, ухамсар хувирч, билиг ухаан ч өөрчлөгдөнө. Дотоодын ийм хувиралт хүнийг бүхнээс илүү баярлуулдаг.

Билиг ухаан нээгдсэн тул баярлана, "Цэцэг дэлгэрч Бурханыг хараад, үл төрөхийг ухаарсан." тул баярлана. Бурханыг харах үед "Үл төрнө". "Үл төрөх" гэдэг нь төрөхгүй, үхэхгүй буюу төрж үхэхийн хүрдэнд орчихгүй гэсэн санаатай. "Чанараа үзэж Бурхан болох" нь бас адилхан. Чанараа үзэх нь Бурхан болохын төлөө болохоос бусад юмны төлөө биш. Бид яагаад Бурхан болох ёстой вэ? Яагаад гэвэл билиг ухаан, хүч чадалтай болсноор зовж зүдэрсэн хамаг амьтанд тусалж чадна. Бид угаасаа тэдний нэг тул тэрхүү зовлонт байдлыг сайн ойлгоно. Хэрэв бид хүч чадалтай болж бусад зовсон төрөлтөнд тус болбол ихэд баярлах бус уу? Энэ бол бидний хариуцлага гэдгийг сэхээрэх ийм зөв үзэл бодолтой байвал Бурхан болж чадна. Ийм байж л Бурханыг, Бодьсадваг харна, ийм байж л Бурханаас байнга суралцана.

Ариун орны үзэсгэлэнт байдалд шунаснаар, эсвэл Бурханы хутгийг олоход шунаснаар, ид шидтэй, хүч чадалтай, билиг ухаантай болоход шунаснаар Бурхан болдоггүй. Бид орчлон ертөнцийн сайн иргэн, сайн багаж байж, энэхүү их орчлонг бичил орчлонтой энх тайвнаар зэрэгцэн оршиход туслах учиртай. Яагаад гэвэл дэлхий ертөнц эдүгээ тун самуурч, бие биесээ хөнөөж буйг бид харж байна. Хүн төрөлтөн угаас энэ дэлхийн хамгийн эрхэм дээд нь байх ёстой атал ихэнх хүмүүс идэж уух, тоглож цэнгэх зэрэгт цагаа үрэн өдөр бүр ажиллаж, идэж, унтаж нэг насаа бардаг. Үүнд ямар утга учир байна вэ?

Үнэндээ амьдрал тийм ч хялбар бус. Олон хүний амьдрал зовлон зүдүүр, хэрүүл тэмцэл, зодоон нүдээнээр дүүрэн байдаг. Эхнэр, нөхрүүд таарамжгүй, зарим нь дампуурч, зарим нь алуулж, зарим нь хэрэг төвөгт холбогдоно. Хүн бүр төрөх, өтлөх, өвдөх, үхэхээс ангижирч чаддаггүй. Нэг насаараа идэж ууж, наадаж цэнгэчихээд эцэст нь алгаа ташаад л явчихдаг бол сайн хэрэг. Туулан гэтлэхийг хүсээд ч хэрэггүй. Гэтэл үнэн хэрэгтээ төрөх, өтлөх, өвдөх, үхэхэд захирагдаж байна. Хүний амьдарч байгаа байдал адгуус амьтантай тун ойролцоо. Адгуус амьтан ч гэсэн хоол идэж, унтаж хэвтэж, үр зулзагаа өсгөдөг. Бид тэднээс ухаантай сэргэлэн ч өөрсдийнхөө билиг ухааныг бүрэн ашиглаагүйгээс тэднээс ялгагдах юмгүй байгаа нь үнэхээр харамсалтай! Зуун жилийн цаг хугацааг зүгээр л талаар өнгөрөөнө.

Хэрэв бид нэг насаараа хичээн бясалгал дадуулвал их

Бодьсадва болж, бүхий л орчлон ертөнц бүгд биднийх болоод юу дуртайгаа хийнэ. Хүн аваръя гэвэл аварна. Хаа хүрсэн ч өөрийн дур, онгоцны тасалбар ч хэрэггүй. Харин энэ махан биед бол онгоцны тасалбар хэрэгтэй. Багш нь тэнгэрт нисдэг шидтэй болчихоод та нар дээр ирээд, дараа нь өөр тийш нисэж, бусад авшигтнуудтай (*Багш шавиа заав*.) уулзана гэж төсөөлье. Ингэвэл би тийм удаан амьдарч чадахгүй байх. Учир нь зарим хүн намайг шувуу гэж бодоод буудаж алаад идчих байх. (*Бүгд инээв*.)

Иймээс ид шидтэй байх нь бараг хэрэггүй, түүнгүйгээр ч хүрээд очиж болно. Бие махбод энд байвч хувилгаан бие оршихгүй газаргүй. Иймээс Шагжамуни Будда түүнчлэн ирсэнтэй адил үй түмэн хувилгаан биетэй. Тэрээр ширхэг үсээ тасчин авч үлээгээд маш олон болж хувилдаг Сүн Үкүнтэй адилгүй. Энэ нь үй түмэн хувилгаан бие биш, зөвхөн хүн мэхлэх ид шид юм. Учир нь тэр бол толгойныхоо эсвэл биеийнхээ ширхэг үснээс хувилсан Сүн Үкүн бөгөөд хоёр гуравхан минутын дараа л арилан замхарч эргээд үс болж хувирна. Иймээс энэ нь үй түмэн хувилгаан бие биш. Үүнийг яасан ч хольж хутгаж болохгүй.

Үй түмэн хувилгаан бие нь түүнчлэн ирээд түүнчлэн явна. Бие нь хэдийгээр энд байвч оршихгүй газаргүй, алив хэрэг учрыг бүгдийг мэднэ. Тэр онцгойлон ямар нэгэн зүйл хийх шаардлагагүй. Адилхан л өдөр бүр идэж, унтаж, ярина, эгэл жирийн хүнээс ялгаагүй. Та нар Сүн Үкүн болох уу? Үгүй бол Шагжамуни Будда болох уу? Будда болбол мэдээж хамгийн төгс сайн, өнө мөнхөд оршино. Сүн Үкүн гурван ертөнцийн дотор хэвээр байгаа болохоор түүнчлэн ирсэн Бурханы гараас мултарч чадахгүй.

Гэвч Бурхан болсны дараа идэх, унтах шаардлагагүй гэсэн үг биш. Бурханы гадна төрхийг харахад эгэл хүнтэй адил, бас л иднэ, унтана, ажиллана. Гэвч тэр идэх, унтах үедээ ч хамаг амьтанд тусалсаар байдаг. Тэрээр бясалгаж, ном тайлж байхдаа ч хамаг амьтанд ач тус хүргэж байдаг. Бид хоол унд идэж байхдаа хэнд ч нэмэр болж чаддаггүй. Өөртөө ашиг тус хийж чадахгүй байж бусдад туслах талаар дурдаад ч хэрэггүй.

Иймээс Бурхан болсны дараа түүнийг харахад хамаг амьтантай адилхан боловч үнэн хэрэгтээ адилгүй байдаг. Бурхан хэдийгээр идэж, унтаж, ажиллаж байсан ч энэ зуур Түүний хэлбэр дүрсгүй ажил маш их байдгийг бид харж чадахгүй. Бидний идэх, унтах, ярих нь зөвхөн идэх, унтах, ярих л болохоос өөр бусад юмгүй. Бидний бие энд байсан ч үй түмээр хувилахгүй, түүнчлэн ирж түүнчлэн одохгүй. Арьяабал бурхан болж чадахгүй, хамаг

амьтдыг хотлоор нь гэтэлгэж чадахгүй. Иймд хамаг амьтад нь Бодьсадватай зарим талаар огт адилгүй. Эс бөгөөс ямар ялгаа байх вэ? Хамаг амьтан бүгд түүнчлэн ирсэн болж болно. Гагцхүү түлхүүр хаана байгааг мэдээд үүдээ нээсний дараа хичээнгүйлэн бясалгал дадуулвал л адилхан амжилтад хүрнэ. Шагжамуни Будда зургаан жил, Хүй Нөн арван зургаан жил бясалгал дадуулаад Бурхан болсон юм чинь бид ч бас болж болно.

“Аливаа амьтад бүгд Бурхан чанартай.” гэж Шагжамуни Будда хэлжээ. Түүний санаа нь адгуусан амьтад ч бас Бурхан чанартай. Гэтэл тэд яагаад Бурхан болж чаддаггүй вэ? Зөвхөн хүн л Бурхан болдог уу? Учир нь хүн “ухамсар”, “далд ухамсар”-тай болохоор дээд зэргийн шинжлэн дүгнэх чадвартай, дээд зэргийн билиг ухаантай. Адгуусан амьтад бас шинжлэн дүгнэж чадах боловч зөвхөн хаана аюултай, хаана идэш хоол арвинтай, хаана уух устай зэргийг л шинжиж чаддаг. Түүний үнэрлэх чадвар хүнийхээс илүү ч ёс суртахуун, муу үйлийг дүгнэн шинжиж чадахгүй. Сайн мууг ялгаж мэдэхгүй. Хүн харин магадалж чадна. Бид диваажинд очих уу, тамд очих уу, эсвэл энэ ертөнцөд үлдэх үү гэдгээ сонгож болно. Гэвч хүний билиг ухаан адилгүйгээс диваажинд очъё гэж бодсон ч эцэстээ тамд унаж, туулан гэтлэх замыг сонгосон ч алдаанаасаа болоод үхэж төрөхийн орчилд эргэлдэж байдаг.

Иймд бид өөрсдөө ойлгож мэдэхгүй бол Гэгээнтнийг олж удирдан зааварчлуулах хэрэгтэй. Гэвч эхэн үедээ л зааварчлуулах бөгөөд дараа нь өөрсдөө биеэ дааж, өөрсдөө гэгээнтэн болж, өөрсдөө Төгс Гэгээрсэн Их Багш болох хэрэгтэй. Яагаад гэвэл бид өөрсдийнхөө Их Багш юм. Энэ нь аливаа хүн сурч боловсроод эмч болдогтой адил. Сайн эмчээс суралцвал сайн эмч болно.

Бурхан болох нь үүнтэй агаар нэг. Иймээс Шагжамуни Будда: “Аливаа амьтад бүгд Бурхан чанартай.” гэжээ. Хүмүүс бид нэг төрөлдөө Бурхан болж чадна. Тэр худал яриагүй, энэ бол үнэн. Надад Бурханы хэлж ярьсан үнэн гэдгийг нотлох хангалттай ахуй ойлголт бий. Хэрэв нэг төрөлдөө Бурхан болж чадахгүй бол хамгийн багадаа л Бодьсадва болно. Их Бодьсадва болж чадна гэдгийг лавтайяа баталж чадна.

Асуулт: Хэрэв бясалгаад Бурхан болчихвол тэрхүү Бурхан, Шагжамуни Будда хоёр адилхан Бурхан уу, эсвэл ондоо юу?

Их Багш: Тэдний дэс нь адилхан. Гэвч нэг ч биш, бөгөөд бас хоёр ч биш.

Асуулт: Хэрвээ авшиг хүртээгүй, сүнслэг дадал бясалгал

хийдэггүй бол тэрхүү гайхамшигт аялгууг сонсох боломжтой юу? Боломжтой бол жинхэнэ ба хуурамч түвшнийг яаж ялгах вэ?


Их Багш: Сонсож магадгүй, гэвч жинхэнэ аялгуу биш.

Тэгээд ч хүссэн үедээ сонсож болохгүй. Тэр аялгуу ямар түвшнийг төлөөлж байгааг та мэдэхгүй. Гэтэл манай бясалгалын арга бүрэн төгс тул жинхэнэ эсэхийг ялгаж чадна. Хамгаалалтын их хүчтэй болохоор ад чөтгөр ирж үймүүлэхгүй. Бясалгал дадуулаад л байвал түвшин нь улам л дээшилнэ.


Арьяабалын аргаар бясалгал хийдэг хүн хэзээ ч энэхүү дотоодын аялгуутай байдаг, үзэх түвшин ч бас адилхан. Өнөөдөр хараад маргааш хардаггүй гэсэн үг биш. Хэрвээ үзэгдэхээ боливол жинхэнэ түвшин биш. Жинхэнэ нь өнөөдөр ч байна, маргааш ч байна. Жишээ нь, энэ сүм хийд зэрэглээ биш бодитой оршин байгаа. Бид хэзээ ч ирээд түүнийг харахад янзаараа л байна. Харин зүүдэлсэн ой тойндоо ургуулан бодсон бол өнөөдөр харагдавч маргааш байхгүй.

Төгс Гэгээрсэн Их Багшийг дагавал ямар түвшин нь ямар аялгуутайг Тэр мэднэ. Багш ном уламжилсны дараа та өдөр болгон хүссэн үедээ энэхүү аялгууг сонсож болно. Ном уламжилснаар дотоодын аялгууг сонсох боломжтой болж, цаашид хичээн бясалгавал бидний түвшин улам дээшилнэ. Өөрийн сонсож буй аялгуунаас түвшингээ, дэсээ мэдэж болно. Энэ нь газрын зурагтай адил. Газар бүхэн тэмдэг, тэмдэглэгээтэй учраас хаа хүрснээ даруй мэднэ гэж Багш нь ном уламжлахын өмнө тодорхой хэлж өгдөг.


Хүний бие маш үнэ цэнтэй. Учир нь Багш нь нохойд ном уламжлахгүй. Нохой бас Бурхан чанартай ч бараг үгүйтэй адил. Түүнд ном уламжилсан ч хэрэглэж чадахгүй. Гэвч бид хэрэглэж чадна. Учир нь хэл яриа ойлгоно, ойлгохгүй байсан ч хамаагүй, далд ухамсар нь ойлгоно. Багш нь ярихгүйгээр ном уламжилдаг. Ном уламжлах үед юу ч ярихгүй, одоо ярьж буй нь ном уламжлахын өмнөх танилцуулга төдий. Үнэн хэрэгтээ танилцуулахгүй байсан ч болно. Би юу хийнэ, түүнийг дагахад л болно. Ингэснээр та бас энэхүү бясалгалын аргыг олж авна. Юу ч ярих хэрэггүй, юу ч хийх хэрэггүй. Учир нь “Аливаа ном дүр хоосон”. Зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөнгийн уламжилсан “Дүрс үгүй ном” Багшийнх нь уламжилдаг номтой яг ижил.



(зураг нэг)



зураг хоёр



(зураг гурав)

1) Ариун орон (гурван ертөнцийн гаднах)
2) Бохир орон (гурван ертөнцийн доторх)
3) Дэлхийн бөмбөрцөг
4) Ариун орон (магнайгаас дээших)
5) Бохир орон (магнайгаас доошох)
6) Жинхэнэ бие (Уг дүр, Бурхан чанар)
7) Бусад давхаргуудаар хучигдсан бие
8) Махан бие- нийт 7 давхар

Тайлбар: **Их Багш**. Жинхэнэ биеийг тайлбарлах аргагүй. Ойлгоход дөхмийг бодож түр зууртаа энэхүү зураг ба үгээр тайлбарлав.

АСУРИ ТӨРӨЛТӨН

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
айлдвар. Формосагийн Тайпэй хот.
1987 оны 3 дугаар сарын 13
(Эх нь хятад хэлээр)

Та нартай уулзсангүй уджээ. Өнөөдөр асурийн талаар ярья. Сонсмоор байна уу? Формосад олон хүн бясалгал болоод өөр элдэв зүйлийг зааж байдаг. Эхэндээ бага сага зүйл мэдэрдэг ч хэсэг хугацааны дараа бүгдэд нь асуудал үүсэж, олон хүнд ад шүглэн солио тусдаг гэнэ. Олон хүн ирж Багшаас нь энэ талаар асуудаг. Зарим хүн элдэв янзын сонин жигтэй хөдөлгөөн зааж, бусад ойлгомжгүй зүйлсийг хийлгэх шидтэй гэнэ. Хүмүүс сониуч тул ихэд шохоорхон дурладаг. Өмнө нь гарын чагж хийж байгаагүй ч тэнд очоод дорхноо сурна. Гарын чагж хийхгүй юмаа гэхэд дор хаяж нөгөө элдэв янзаар хөдлөх, биеэ займчуулан чичиргэх мэтийг сурдаг. Удалгүй бүгд л төвөг бэрхшээлтэй учирч, олноороо ирж Багшид нь гомдлоо тоочдог. Гэвч цөөнгүй хүн иймэрхүү зүйлд итгэсээр байгаа учраас өнөөдөр Багш нь энэ сэдвийг тусгайлан ярья. Сонирхолтой байх болно.

Иймэрхүү хэрэг зөвхөн Формосад л гараад байгаа юм биш. Багш нь Германд байхдаа тийм хүмүүстэй зөндөө таарч байсан. Тэд жинхэнэ багшаас сураагүй тул гэртээ хариад өдөржин шөнөжин дуу чимээ сонсдог. Энэ нь сонсголонтой сайхан дуу ч биш, хүмүүс ярилцах чимээ байдаг. Маш их чимээ шуугиантай тул сонссон хүн идэж, унтаж чадахаа болино. Энэ чимээ нь унтаж амраахгүй, их сонсвол ядран сульдаж, мэдрэл муудна. Үнэндээ энэ нь ямар ч нууцлаг явдал биш, хэргийн ихэнхийг доод түвшний асурийн төрөлтнүүд хийж байдаг.

Бидний буян бага бол нас барсныхаа дараа тэнгэрт төрж чадахгүй. Илүү буянтай бол тэнгэрийн төрөлтөн, бүр их буянтай бол Бодьсадва болно. Бурхан болох нь тун цөөхөн. Одоо бид Бурхан болох талаар ярихгүй. Амьд байхдаа их буянгүй ч их нүгэл

хийгээгүй бол нас нөгчөөд тамд унахгүй. Хэсүүчлэн тэнэгч хий сүнс, хээрийн чөтгөр болохгүй ч, тэд доод дэсийн асури болж, асурийн оронд амьдарна. Асурийн орон нь манай бөмбөрцөгт хамгийн ойр байдаг бөгөөд жаахан дээшилбэл тэнгэр бий.

Асурийн орныг хоёр дэсэд хуваана. Нэгдүгээр дэс нь диваажин, хоёрдугаар дэс нь там. Гэвч энэхүү там нь диваажинтай бараг адил, бүгд л асурийн оронд оршино. Тамд буй асури нь гяндан дахь ялтан эрх чөлөөгүй байдагтай адил гарч чаддаггүй. Харин диваажинд буй асури бол эрх чөлөөтэй, нааш цааш чөлөөтэй явж болно. Тэд бас зарим нэг шидийн хүчтэй, дайтах дуртай, шогломтгой, бусдад яршиг төвөг тарьдаг. Тэд хүмүүст яаж хийхийг заадаг ч үнэн хэрэгтээ тэднээр тохуурхаж, тоглоом наадам хийж буй төдий. Зарим үед огтхон ч муу санаа өвөрлөдөггүй.

Зарим хүний сүнс нэлээд мэдрэмтгий. Сүнс, эсвэл эзэн гэж ярих нь бараг ялгаагүй. Заримдаа сүнс биеэс гарах үед бусад төрөлтөн ирж, бидний биеийг хэсэг хугацаагаар зээлж болзошгүй. Тэрээр энэхүү бие махбодыг зээлээд ямар нэгэн зүйл хийе гэж бодсон байж болох ч, тэр нь базаахгүй зүйл байж ч магадгүй. Эсвэл ертөнцийн элдэв зүйлээс таашаал авахыг бодсон ч байж болно. Заримдаа хүний бие маш олон төрөлтөнд эзлэгддэг бөгөөд үүнийг “ад шүглэх” гэдэг. Түүнийг элдэв янзын дуу авиа гаргаж байгааг бид сонсдог. Тэр хүн өөрөө ярьж байгаа биш, заримдаа тэр ярихыг ч хүсдэггүй. Гэвч өөрөө ч мэдэлгүй элдэв дуу авиа гаргадаг. Учир нь маш олон асури төрөлтөн түүний биеийг нь эзлээд, элдвийг чалчиж, дур зоргоороо авирладаг тул хүн өөрийгөө эзэмдэж чаддаггүй.

Гэвч зарим асури сайн санаатай, тэр ирээд чамтай тоглож наадаж байснаа яваад өгдөг. Иймэрхүү байвал ч бас яах вэ. Зарим асури шунахай сэтгэлтэй, хүний биеийг ашиглаад зогсохгүй өөрийн болгохыг санаархана. Биед нь орчихвол салах дургүй, үүрд суухыг хүсдэг. Энэ нь зарим хүн эзэнгүй байшинд орж суучихаад, хожим хүн нь ирээд хөөсөн ч явахгүй, орон гэрийг нь эзэгнэсээр байхтай адил.

Хэрэв зөв аргаар бясалгал дадуулдаггүй, мэдрэмтгий сүнстэй хүн сайн багшгүй, сайн хүчний хамгаалалтгүй бол иймэрхүү доод дэсийн асури төрөлтөнд эзлэгдэнэ. Тэдний орж ирэхийг нь бид мэддэггүй. Зарим үед хэн нэгэн чихэнд шивнэх шиг санагдавч хэн ч үзэгдэхгүй. Заримдаа харагдаж магадгүй ч энэ нь бидний мэдрэмтгий байдлаас болно. Зарим хүн ад чөтгөр, асури төрөлтний ирэхийг харж чаддаг.

Гэвч асури ирэхдээ өөрийгөө асури гэдгээ бидэнд мэдэгдэхгүй. Тэд бас ид шидтэй. Тун сүр жавхаатай болон хувирч чадна. Шагжамуни Будда болон Авид бурханы дүрд ч хувилж мэднэ. Тэр ч бүү хэл Багшийнх нь дүрд ч хувилж болно. Гэвч сайн багштай бясалгагч жинхэнэ эсэхийг нь дорхноо ялгаж салгана.

Жишээлбэл, асури Багшийнх нь дүрд хувилж ирээд та нартай ярилцана. Хэрэв чи Багшийнхаа шавь бол асури хувирч ирсэн үү, эсвэл жинхэнэ багшийн хувилгаан дүр үү? гэдгийг тэр дороо ялгаж мэднэ. Хэрэв Багшийгаа дагаагүй юм уу, эсвэл сайн багшгүй бол асурийн хувирсан Авид бурхан, Есүс Христ, Арьяабал бурхан, эсвэл өөр ямар нэгэн Бурхан бодьсадвагийн дүрд мэхлэгдэнэ. Тэрхүү асуриуд юу хийхийг зааж өгөхөд, жинхэнэ Бурхан бодьсадваг үзлээ гэж бодоод ихэд хүндэтгэж наманчлан мөргөнө. Асури тэднийг юу хий гэнэ, түүнийг нь хийнэ. Гэвч үргэлж эмх замбараагүй юм үйлдүүлдэг. Дараа нь хүмүүст зааж сурга, ном уламжил гэж зааварладаг. Янз бүрийн гарын чагж үйлдүүлж, сэтгэл санааг тайван биш болгож, элдэв янзын сонин жигтэй хөдөлгөөн хийлгэдэг. Эсвэл ямар нэг зүйлийг хий гэж дотроос нь хэлдэг ч бүгд л хэрэгцээгүй зүйлс байдаг. Тэрхүү хуурамч Бурханы хэлсэн зүйлийн ихэнх нь буруу. Зарим үед тэрээр бага сага зүйлийг зөгнөн хэлдэг ч ихэнх нь андуу ташаа байдаг. Жишээ нь, маргааш нэг юм болно гэж хэлэхэд тэр нь болдоггүй ч, зууны нэг хувийг нь таах магадлалтай.

Ад чөтгөр ирэхийг жинхэнээр бясалгал дадуулдаг хүн бол мэднэ. Иймэрхүү асурийн төрөлтөн биеийг эзлэх буюу биед түр орогнохдоо биднээр олон юм хийлгэж, бусадтай хэрэлдүүлж муудалцуулдаг.

Найман сарын өмнө Багш нь Германд очиж нэгэн сүмд суусан юм. Нэгэн Ау Лак хөгшин өдөржингөө асурийн дуу чимээнд үймрэн, хүүгээ ямар муу болохыг, бэрээ ямар таарууxан бэр болохыг, өөртөө яаж муу ханддагийг ярьж суудаг. Үнэндээ ийм зүйл байхгүй бөгөөд асури тэдэнд төвөг удаж, зориуд хэрэлдүүлж байгаа хэрэг юм. Дараа нь түүгээр ажил хийлгүүлэхэд гартаа юм барьж хүнтэй зодолджээ. Хүч хэрэглэн хутгаар хүн хөнөөхөөр завдсан. Хэдийгээр хүний аминд хүрээгүй ч ийм үйлдэл байнга гаргадаг тул мэдээж ажилгүй болно. Хүү, бэр хоёртоо дургүй, тэдэнтэйгээ өдөр болгон муудалцдаг тул гэртээ сэтгэл амар сууж чаддаггүй. Хүн бүрийг хардаж сэжиглэнэ. Учир нь асури өдөр бүр түүнд: “Хүн болгон чамд муу, чамайг сэжиглэдэг. Тэр хүн одоо юу бодож байна гээч, чамайг тун муу хүн гэж бодож байгаа. Таван минутын дараа тэр чамайг зодох юм уу, эсвэл хоёр

цагийн дараа чамд ямар нэгэн муу юм хийнэ.” гэх мэтээр хэлнэ. Ад шүглэсэн хүн ингэж хэлэх болгонд нь итгэж тэр хүнтэй хэрүүл зодоон хийнэ. Гэвч ийм явдал үнэндээ огт байхгүй.

Гэвч тэдгээр ад чөтгөрүүд хүнийг хэрэлдүүлж муудалцуулах дуртай. Учир нь тэр бол асури, тэдний уг чанар нь байлдаанч. Амьд ахуйдаа дайтах дуртай байлдаанч хүн, үхсэнийхээ дараа асури болдог. Учир нь байлдаанч зангаа гээж чаддаггүй. Тэд эмзэг мэдрэмтгий, билиг ухаанаар тааруухан, итгэмтгий хүнийг ашиглан хооронд нь тэмцэлдүүлээд хажуугаас нь шоолон инээлдэж байдаг.

Зарим үед тэд Шагжамуни Будда, Арьяабал бурхан Хятадын Жигүн зэрэг олон жижиг бурхан болон хувирч, өөрсдийгөө ийм тийм бурхан, сахиус гэж нэрлэнэ. Тэгээд сургаал айлдаж, мөргөн шүтүүлж, эсвэл ямар нэгэн ном тайлна. Зарим үед тайлсан учир ёс нь нэлээд гайгүй, учир нь тэд өөрсдөө ч бас урьд нь сурч байжээ. Хүмүүс бид сурч болж байгаа юм чинь ад яагаад сурч болохгүй гэж? Тэд ном судар сонсчихоод дараа нь бусдад тайлж, өөртөө мөргүүлэн, элдвээр өргүүлж тахиулна. Зарим үед хүмүүсийг олон эхнэр аваарай гэнэ. Учир нь тэд эмэгтэй хүнд тун дуртай, шалиг завхай. Өөрөө биегүй болохоор иймэрхүү ертөнцийн таашаал эдлэх аргагүй байдаг. Тиймээс хүмүүсийг дахин дахин гэрлүүлэх юм уу, эсвэл элдвийн махан хүнс болон ямар нэг онцгой зүйл идүүлдэг. Энэ бүгдэд тэр дурладаг ч бие махбодгүй тул таашаал авч чадахгүй. Тэр хэн нэгний бие махбодыг ашиглаж байж таашаал эдэлдэг.

Тамхи татаж, архи уух нь бид өөрсдөө хүсээгүй харин асурийн нөлөөнд орсноос болдог. Бясалгал дадуулдаг хүн билгийн мэлмий нээгдсэнийхээ дараа тамхи татдаг, мансууруулах бодис хэрэглэдэг, мөрийтэй тоглодог, архи уудаг хүмүүс бүгд тэрхүү хэлбэр дүрсгүй, элдэв төрлийн асуриудаар хүрээлэгдсэнийг хардаг. Тэд тамхины үнэрт дуртай, үнэрлэнгүүтээ баярлаж хөөрнө. Учир нь тэд биегүй тул өөрсдөө тамхи татаж, мансуурч, мөрийтэй тоглож, архидаж чадахгүй учир сул дорой, эмзэг мэдрэмтгий хүнийг ашиглан тамхи татуулж, архи уулгаж, мансууруулах бодис хэрэглүүлнэ.

Иймээс архичин хүн уух тусмаа улам их уудаг. Учир нь асури ганцаараа биш, бас гурав, дөрвөн найзаа дагуулан ирээд түүний биеийг ашиглан ууцгаана. Хэдий олон асури ирнэ, төдий чинээ их ууна. Иймээс архи уудаг хүн архинаас гарахад амаргүй, гаръя гэсэн ч чадахгүй. Тамхи татдаг хүн ч бас тамхиа хаяхад хэцүү. Мансууруулах бодис хэрэглэх, мөрийтэй тоглох нь бүгд адил. Хятад хэлэнд тэднийг тоглоомын чөтгөр, архины чөтгөр

гэж нэрлэдэг нь миний бодоход тоглоом наадам хийж буй хэрэг биш, хэн нэгний хэвшмэл үзэл ч биш, харин жинхэнэ бодитой зүйрлэл юм.

Гэтэл Арьяабалын аргаар бясалгал дадуулдаг хүн маш түргэн засарна. Бясалгадаггүй бол засрахад тун хэцүү. Энд нэлээд хэдэн авшигтан (*Багш шавиа заав.*) бий. Үнэн хэрэгтээ тийм олон биш, хэдхэн л бий. Учир нь тийм олон тамхичин ирж бясалгая гээгүй. Өдөрт гурав, дөрвөн хайрцаг тамхи татдаг хэдэн авшигтан байсны нэг нь энд байна. Тэр өөрийгөө бусдад мэдэгдэх дургүй байж мэдэх тул хэн болохыг хэлээд яах вэ. Уг нь өдөр бүр гурав, дөрвөн хайрцаг татаж байсан ч авшиг хүртсэн даруйдаа хаясан. Одоо огт татдаггүй. Өөрөө татахгүйгээр барахгүй өөрийнхөө найз нарт нөлөөлж, бүгдийг тамхинаас гаргасан.

Архийг ч гэсэн адилхан, тавь хүртлээ насаараа архи уугаад авшиг хүртсэний дараа гэнэт гарчээ. Багшийнхаа аргаар дадал бясалгал хийгээд тэр дороо засарна. Одоо тамхи татахгүй, архи уухгүй, мах идэхгүй, аяндаа маш хурдан бүрэн засарчээ. Багш нь тэдэнд ном уламжилсны дараа тэд тамхи огт татахгүй, архи ч уухаа больсон. Найзууд нь тэднийг бараг танихаа байгаад, яагаад гэнэт ийм их хувирав гэж их л гайхаж байгаа. Энэ бол эртний үлгэр биш одоогийн үнэн бодит жишээ юм.

Архи уух нь асурийн нөлөөнд орсноос болдог гэвэл та нар итгэх үү? Иймэрхүү зүйлийг үзсэн хүн байна уу? Зарим асури нэлээд хэрцгий, зарим нь сахилгагүй, зарим нь тамхи татаж, архи уух дуртай. Иймээс бид тэдний нөлөөнд ордог. Ямар асурийн нөлөөнд автаж буйгаа бид өөрсдөө мэднэ.

Зарим хүн дадал бясалгалаа муу хийдэг эсвэл тааруухан бясалгалын аргаар бясалгадаг, эсвэл бясалгах зорилго нь зөв бус, бясалгадаг хэдий ч өөрөө цэвэр ариун бус байдаг. Жишээлбэл, бясалгалаа нэр алдар, ашиг хонжоо, ид шид олохын төлөө, эсвэл бясалгадаг ч өөрийн дур хүслээ хорьж дийлэхгүй, хуучин янзаараа хамаг амьтны мах идэж, архи ууж, садар самуун явдалд дурласаар байдаг. Хэрэв энэ нь ихсэж хэрээс хэтэрвэл асури биеийг нь ашиглан муу юм үйлдүүлнэ. Үүнийг нэлээд өөдгүй муу асури хийдэг. Арай бага нь хүмүүсийг хооронд нь хэрэлдүүлдэг. Бүр бага нь архи уулгаж, тамхи татуулна.

Асури зөвхөн сүнслэг бясалгагчийг төдийгүй ямар ч хүнийг ашиглаж чадна. Бясалгал нь цэвэр бус, эсвэл зорилго нь ариун бус хүнийг өөдгүй асуриуд ашиглах тун дуртай. Жижиг асуриуд нь эмзэг мэдрэмтгий, сэтгэлийн тэнхээгүй хүнийг ашиглан тэднээр ахиухан шиг тамхи татуулж, архи уулгаж, мансууруулах бодис

хэрэглүүлээд, бие махбод сэтгэл мэдрэлийг нь хөнөөдөг. Ийм хүн үнэхээр хөөрхийлөлтэй. Уг нь өөрөө ийм зүйл үйлдэх дургүй, өөрт нь хэрэггүй ч сул дорой байдлаасаа болж асурийнханд ашиглуулдаг.

Иймэрхүү байдал нэлээд тохиолддог. Хэрэв хүн сонор сэрэмжгүй бол өөртөө олон төвөг учруулна. Асури өөрийгөө бурхан бодьсадва гэж чамд итгүүлнэ. Үүнийг ялган таних ухаан жирийн хүнд ч бий. Бурхан, бодьсадва яаж ийм мэтийн зүйлсээс таашаал авах вэ? гэсэн эргэлзээ сэжиг бидэнд төрнө. Бурхан, бодьсадва хамгийн эрхэм дээд, хамгийн эрхэм ариун, агуу билиг ухаантай, агуу нигүүлсэлтэй атлаа яахаараа олон эхнэр авъя гэх вэ? Бас яахан мах идэж, архи ууя гэх вэ? Гэвч тэр үед асури өөрсдийн ёс жаягийг бидэнд тайлбарлах бөгөөд бие маань тэдэнд эзлэгдсэн учраас хэлсэн бүхэнд нь итгэнэ. Нэгэнт тэдний хяналтад орсон тул зайлах аргагүй болж, хий гэснийг нь хийх болдог. Хожим бид эзэн байх эрхээ алдаад улам, сул дорой, хүч чадалгүй болдог. Юм бүхэнд тэднийг түшиглэсээр байгаад оршин буй нь үгүйтэй адил болж, өөрөө ч бас асури болж хувирна.

Эзэн нь амьдран суухгүй бол энэхүү биеийн хэрэг үгүй. Энэхүү эзнийг бид сүнс буюу “Уг дүр” эсвэл “Билиг ухаан” гэж нэрлэж болно. Хэрвээ энэхүү эзэн эсвэл сүнс маань амьдран суухгүй юм бол энэ бие огт хэрэггүй. Асури биеийг минь ашиглавал бие маань асурийнх болж хувирна.

Энэ ертөнцөд маш олон асури болон бусад төрөлтөн байдаг. Зөвхөн та нар л энд сууж, ном тайлахыг сонсож байгаа юм биш. Ном тайлах үед Багшийнх нь махан бие бус, харин Бурхан Бодьсадва болон Багшийнх нь уг дүр ирж ном тайлж байгаа юм. Үүнээс гадна тэнгэрийн төрөлтөн, асури гэхчлэн бусад төрөлтөн бүгд ирж ном сонсдог. Бидний билгийн мэлмий нээгдсэн бол олж харна, нээгдээгүй бол харахгүй. Энд зөвхөн өөрсдийгөө л байна гэж бодоцгоодог.

Энэ ертөнцөд маш олон асури бий. Бас ад ч бий, чөтгөр ч бий. Иймээс нүдэнд үзэгдсэн хүн болгон хүн биш. Гэвч бидний билгийн мэлмий нээгдээгүй тул аль нь хүн, аль нь ад, аль нь чөтгөр, аль нь асури гэдгийг ялгаж салгахын аргагүй. Хэрэв олоод харчихвал түүнийг хэдийнээ хүн биш болсон гэдгийг нь мэдээд айж эмээнэ.

Асурийн төрөлтөн өөрсдийн биеэр бидэнд төвөг саад болох төдийгүй зарим үед садан төрлийг маань ашиглаж, саад бэрхшээл учруулна. Жишээ нь, биднийг бясалгал хийх үед ирж үймүүлнэ. Хэрэв зорилгодоо хүрч чадахгүй бол бидний садан төрөл дээр

очиж, яршиг удна. Аав, ээж, үр хүүхэд, эхнэр, нөхрөөр дамжуулан биднийг зовоож, сүнслэг бясалгалд саад хийдэг. Энэ бүгд асурийн нөлөөнөөс болно. Нэлээд дээд зэргийн асури нь гурван ертөнцийн дотор харьяалагдана. Багш нь "Хүсэлт тэнгэр, дүрст тэнгэр, дүрс үгүй тэнгэр" гэх мэт бурханы шашны нэр томьёогоор ярихгүй. Ингэх нь дэндүү төвөгтэй. Нэг, хоёр, гурав, дөрөв, тав, зургаадугаар ертөнц... гэх мэт энгийнээр яривал ойлгоход хялбар юм.

Нэгдүгээр ертөнц асурийн төрөлтнөөр дүүрэн. Хоёрдугаар ертөнцөд сайн санаатай, эрдэм мэдлэгтэй хүн хүрч чадна. Хоёрдугаар ертөнц тун олон дэсэд хуваагдана. Бурханы шашны судар номд ч энэ тухай дурдсан байдаг. Би та нарын цагийг үрэхгүй. Хэрэв тэрхүү түвшний нэрийг мэдмээр байгаа бол хариад Бурханы шашны толь бичиг, ном судруудыг үзээд ойлгож болно.

Хоёрдугаар ертөнц нь тун олон дэсэд хуваагддаг. Тэндхийн төрөлтнүүдийн зарим нь тийм ч сайн санаатай биш. Бид бясалгал дадуулаад арай дээгүүр дэсэд тухайлбал хоёрдугаар ертөнцийн дэсэд хүрэхэд тэд бидэнд бас л төвөг саад учруулна. Тэд асуриас хүчтэй учраас бидэнд учруулах төвөг бэрхшээл нь нэн хэцүү. Бясалгаад хоёрдугаар ертөнцөд хүрэхэд ийм бэрхшээлтэй байгаа юм чинь, бурхан бодьсадватай уулзахыг хүсвэл гэвэл үнэхээр хялбар бус. Учир нь зам дагуух үүд хаалга болгонд саад төвөг учруулагч төрөлтнүүд биднийг саатуулан хорьж, цааш нэвтрүүлдэггүй.

Асури төрөлтөн мэдээжийн хэрэг жаахан шидтэй. Тэд тэнгэрийн нүдээр нэвт харах чадвараа бидэнд зээлдүүлж чадна. Учир нь тэд биегүй. Биегүй тул биднээс эрх чөлөөтэй, өөд уруугүй нисээд хаа ч түргэн хүрнэ. Тэд өөрсдөө биегүй хоосон тул дүрсгүй амьтдыг ч мөн харж чадна. Иймээс тэдний нүд биднийхээс тодорхой хардаг. Зарим үед хүний бодлыг уншина, бас нэг, хоёр явдлыг оновчтой хэлдэг. Гэвч энэ бол ялихгүй зүйл юм. Хэрэв нэгэн өдөр асури яваад өгвөл бид юуг ч ойлгодоггүй, юуг ч мэддэггүй байсан өмнөхтэйгөө адил болно. Гэхдээ урьдынхаасаа ч илүү мунхаг, сул дорой болдог. Учир нь одоо энэ байдалдаа дасаж өгөхгүй, бие махбодоо яаж хэрэглэхээ мэдэхээ больдог. Тэд бидний бие махбодыг хэрэглэх бүртээ сүнсийг маань шахан гаргадаг тул биднийг үхсэн юм шиг байлгадаг. Өөрийнх нь сүнс хажууд нь зогсоод юу болж байгааг бүгдийг мэддэг ч тэдэнд захирагдаж байгаа тул биеэ хянах аргагүй болно.

Маш олон эмзэг мэдрэмтгий хүн ад чөтгөрт ашиглагддаг

гэж Багш нь сая хэлсэн. Учир нь тэд гэнэн цайлган, бусдад хэтэрхий амархан итгэдэг тул мэдээж асурид ашиглуулна. Энэ бол нэг байдал нь. Нөгөө нэг байдал нь бясалгал дадуулахдаа замчлах сайн багшгүй, сайн бясалгалын аргын хамгаалалтгүй, эсвэл бясалгалын зорилго нь цэвэр ариун бус, бясалгаад зөн билигтэй болж, хожим нэр алдар, ашиг хонжоог нэгэн зэрэг олж олон түмний бишрэл хүндэтгэлийг хүлээх гэх мэт болно. Хэрэв ийм бодолтой, хурдхан ид шидтэй болохыг хүсвэл асури хамгаас их баярладаг. Тэд иймэрхүү хүний шунаг сэтгэлийг ашиглаж, тэднээр ид шидтэй зүйл хийлгэж улам итгүүлнэ. Жинхэнэ бурхан, бодьсадва ирж сургаалаа айлдаж байна гэж бодогдуулна. Тэд: "Та бясалгал хийх дуртай учраас зааж өгөхөөр ирлээ." гээд хуурамч дүр эсгэнэ. Тэд ном тайлж чадна, нэлээд зүйлийг хэлж ярина. Бас чамайг бусад хуурамч түвшинд дагуулан аваачиж зугаалуулна.

Иймээс бясалгал хийх сайн зорилготой байх ёстой. Энэ бол хамгийн чухал. Эрхэм дээд зорилго гэдэг нь өөрийгөө төдийгүй хамаг амьтныг сансрын хүрднээс гэтэлгэхийг хүсэхийг хэлнэ. Энэхүү эрхэм дээд цэвэр ариун зорилгоос гадна бас дээдийн бясалгалын арга, дээд дэсийн Төгс Гэгээрсэн Их Багштай байж гэмээ нь дадал бясалгал нь сая аюулгүй болдог. Өдөр бүр нэг, хоёр, гурав, дөрөв гэж амьсгалаа тоолоод үүнийгээ бясалгал дадуулж байна гэж бодож болохгүй. Энэ нь зөвхөн анхан шатны арга төдий.

Хэрэв бясалгал дадуулж буй хүн ид шидэд шунавал, асурийн бурхан бодьсадвагийн хуурамч дүрд хууртагдах бөгөөд тэд түүнийг бусад хуурамч түвшинд аваачна. Жишээ нь, төгс баясгалант ариун оронд аваачлаа гэхэд энэ нь мэдээж жинхэнэ биш, хуурмаг. Асурийнханд бас төсөөлөн бодох чадвар бий. Нэлээд их буянтай асури хуурамч түвшнийг зохиож чадна. Тэд хэсэгхэн диваажинг бүтээчихээд, хүмүүсийг аваачиж үзүүлдэг. Учир нь эгэл хүн жинхэнэ төгс баясгалант ариун оронд очиж үзээгүй тул өөрийн харсан диваажингийн жинхэнэ эсэхийг ялгаж мэдэхгүй.

Энэ нь ховсдуулсан, согтуу байхтай адил. Хүн юу ч гэж хэлсэн хүлээн зөвшөөрөх бөгөөд өөрийн жинхэнэ билиг ухаангүй, сэрүүн сэргэг оюун ухаангүй болдог. Ухаан санаа нь балартсан тул хэн юу ч гэж ярьсан тэрээр харснаа Бурхан гэж бодоод жинхэнэ эсэхийг нь ялгалгүй даруй залбиран мөргөдөг. Тэр ч байтугай Бурханд хүндэтгэлгүй хандахаас айгаад ойртож ч зүрхлэхгүй. Ийм байж яаж жинхэнэ эсэхийг нь ялгаж салгах вэ?

Тэрхүү хуурамч Бурхан: "Чи одоо Бурхан болсон, эсвэл архад,

хэн нэгэн Бодьсадва болсон. Чиний одоогийн үүрэг даалгавар бол бусдад багшлах.” гэж чамд хэлнэ. Тэр бидэнд нэг арга зааж, яахыг хэлж өгдөг. Иймээс бид одоо цагийн нэлээд олон “багш” гэгчтэй таарна. Тэд хүмүүст ямар нэгэн зүйлийг мэдрүүлж дөнгөдөг учраас элдэв янзын сонин жигтэй хөдөлгөөн хийлгэдэггүй юмаа гэхэд биеийг нь займчуулж эсвэл гарын чагж хийлгэдэг. Тэд чихэнд нь ямар нэгэн юм хэлэхийг сонсдог. Эсвэл маргааш ийм юм болно, нөгөөдөр тийм юм болно гэхчлэн зөгнөнө. Асури бас эмчилдэг ч хүч нь хязгаартай тул бага сага өвчнийг л эмнэж засна. Гэвч бид улам итгэсээр хэлсэн болгоныг нь хийдэг.

Асурийн хүн заримдаа нисдэг таваг хийгээд дотор нь ганц хоёр хүнийг суулгаж зугаацуулдаг. Харин бид тэнгэрийн хүн ирлээ гэж боддог ч тэр нь үнэндээ бол нисдэг таваг юм. Биднийг дагуулан аваачсан газар нь асурийн ертөнц төдий. Асурийн орон маш үзэсгэлэнтэй учир бид очсоныхоо дараа жинхэнэ диваажинд, төгс нирвааны нутагт хүрчихлээ гэж эндүүрэн боддог. Бид жинхэнэ эсэхийг нь ялгаж чадахгүй. Тэдний ертөнц бидний ертөнцөөс хэдэн зуу дахин гоёмсог. Эмэгтэйчүүд нь тун гоо үзэсгэлэнтэй. Иймээс жинхэнэ сайн Их Багшгүй, сайн замчлагчгүй бол бид өөрсдөө бясалгаад, эсвэл асури биднийг дагуулан очсон ч бид төөрөлдөж, тэндхийн үзэмжит байдлыг хараад үнэхээр үзэсгэлэнтэй сайхан гэж боддог. Тэдэнд одоо итгэх юм бол нас нөгчсөний дараа тэд биднийг тийш нь авч явна.

Амьд ахуйдаа буян хишиггүй бол нас нөгчсөн даруйдаа мэдээж тамд унана. Жаахан буянтай хүн тэрхүү “нэгдүгээр зэргийн там” буюу асурийн диваажинд очно. Үүнээс гадна “хоёрдугаар зэргийн там” байдаг бөгөөд энэ бол жинхэнэ эрлэг там юм. Гэвч асурийн оронд оршиж байгаа учраас хоёулаа тамд тооцогдоно. Хэдийгээр асурийн ертөнцөд байгаа боловч урт насалж болно. Зарим нь мянган жил, эсвэл хоёр, гурван мянган жил амьдрах нь асуудалгүй. Тэр ч байтугай заримдаа хэдэн сая жил амьдарна. Хэрэв иймэрхүү байдалтай учирвал бид нэгэнтээ төгс төгөлдөрт хүрээд үхэшгүй мөнхөд хувирч, мөнхөд орших төгс баясгалант оронд байгаа гэж бодоод үүнээс өндөр түвшин оршин байгааг мэдэхээ болино.

Олон хүн хэсэг хугацаагаар бясалган дадуулсны дараа өөрийгөө Бурхан болчихлоо гэдэг. Тэд: “Бүх Бурхан ирж намайг сургадаг.” гэж хэлнэ. Бурханыг олж үзэх нь тийм ч хялбар бус. Эрхбиш хатуужилтай, хичээнгүйлэн бясалгал хийж, маш үнэнч, цэвэр ариун сэтгэлтэй байх хэрэгтэй. Тэрхүү цэвэр ариун сэтгэл нь ширхэг ч толбогүй, тув тунгалаг биндэрьяа мэт байх ёстой.

Хэдийгээр чин үнэнч сэтгэлээр туулан гэтлэхийг хүсэж, билиг ухаан олохын төлөө, хамаг амьтныг гэтэлгэхийн төлөө бясалгал дадуулж байгаа хэдий ч нэгэн жинхэнэ "Төгс Гэгээрсэн Их Багш"-ийг хайж олох хэрэгтэй. Түүнийг даган олон жил бясалган дадуулж байж л ганц хоёр Бурхантай учирч чадна. Бясалгахад ядах юмгүй, Бурхантай уулзъя гэвэл уулзана гэж олон хүн боддог. Тэд өөрсдийгөө бусдаас онцгой болохоор л тэр гэж үздэг ч ийм байх боломжгүй.

Энэ ертөнц дээр эмч болъё гэсэн ч нэлээд хугацаагаар суралцаж байж амжилт олно. Багш болъё гэвэл олон жил сайн багшаас суралцаж, баялаг туршлага хуримтлуулж байж болно. Юу ч сурсан гэсэн урт хугацааны чармайлт хэрэгтэй. Ертөнцийн юмсыг сурахад ийм хялбар бус байхад Бурхан болохын тухайд ярихын ч хэрэггүй. Тийм хурдан амжилтад хүрэх ямар боломж байх вэ? Энэхүү орчлонгийн хууль цааз өөрсдөд нь хамаагүй гэж тэд үздэг. Хамаагүй байж яаж болох вэ? Шагжамуни Будда ч ялгаагүй хэн байхаас үл хамааран энэхүү ертөнцөд амьдарч байгаа бүхий л төрөлтнүүд эндхийн хууль цаазыг дагах ёстой.

Иймээс Шагжамуни Будда амьд ахуйдаа: "Бурханаас хамаг амьтан хүртэл бүгд дөрвөн ачлал энэрлийг хүртэнэ." гэжээ. Энэ нь төр улсын ачлал энэрэл, эцэг эхийн ачлал энэрэл, багш дээдсийн ачлал энэрэл, найз нөхдийн ачлал энэрэл юм. Бурхан ч, Бодьсадва ч, хамаг амьтан ч энэ ертөнцөд амьдарч байгаа л бол энэхүү дөрвөн ачлал энэрлийг заавал хариулах үүрэгтэй. Бясалгагчид ч мөн адил ачлах сэтгэлтэй байж, энэхүү дөрвөн ачлалыг хариулан, хорвоогийн хууль цаазыг хүндэтгэн дагах хэрэгтэй. Үгүй бол саад бэрхшээлтэй учирна.

Шагжамуни Будда, Есүс Христ нар нэг л зүйлийг номлодог. Тэд эхлээд ёс суртахууныг чухалчлах хэрэгтэй гэж заана. Ёс суртахуунгүй, нигүүлсэх сэтгэлгүй хүн бясалгал дадуулж болохгүй. Сүнслэг бясалгал хийсэн ч ёс суртахуунгүй Бурхан болно. Энэ дэлхий дээр ёс суртахуунгүй хүмүүс хэдийнээ бусдад таалагдахаа больсон юм чинь яаж түүнийг төгс баясгалант орон руу явуулж, тэндхийн ёс суртахуунгүй Бодьсадва болгох вэ? "Баатараа явагч их хөлгөн сударт "Мах идэж, архи уудаг хүн бясалгал хийгээд ад чөтгөр болохоос Бодьсадва болохгүй." гэж тодорхой дурдсан байдаг.

Би зөвхөн бага сага жишээ дурдлаа. Нэлээд хүн замбараагүй бясалгал хийгээд өөрийгөө орчлонгийн хуулиас дээгүүр гарчихлаа гэж үздэг. Тэгээд хамаг амьтны махыг зооглосон ч хамаагүй, эр нөхөр, эхнэр хүүхэд илүү авсан ч хамаагүй, худал ярьж, хүн

мэхэлж, их мөнгө авсан ч хамаагүй гэж боддог. Тэд өөрийгөө хэдийнээ Бурхан болчихсон, өөрийн амжилт нь орчлонгийн хуулиас дээгүүр гарчихсан гэж үздэг.

Гэтэлсэн ч сахилаа сахих төдийгүй тодорхой чанд сахих хэрэгтэй. Гагцхүү энэ хуулийг хүндэтгэн сахиснаар гэтэлж чадна. Тэгэхгүй бол Бурхан, Бодьсадва ч адилхан унаж уруудна. Хэрэв номоосоо буцах, эсвэл ёс суртахуунаар дутмаг бол тэр дороо дэс нь доошилно. Жишээлбэл, нэг улсын ерөнхийлөгч энэ улсынхаа хувьд хамгийн дээд төлөөлөл нь болдог. Гэвч хууль зөрчвөл мөн л адилхан цагдаад баригддаг биш үү? Адилхан л төрийн хуулийн цээрлэлийг хүлээдэг. Тийм үү? Шүүхээр шийтгүүлж, шорон гянданд хоригддог бус уу? Тэр ерөнхийлөгч учраас санасан бүхнээ хийж болохгүй. Бурхан, Бодьсадва ч үүнтэй адилхан.

Зарим үед хувийн шалтгаанаар цагаан хоол идэж чаддаггүй. Эсвэл өөрийгөө эгэл хүн гэж боддогоос жинхэнэ ёсоор бясалгаж чаддаггүй. Үүнийг санаатай хийгээгүй тул энэ байдлыг Багш нь ойлгоно. Гэвч үйл түйтгэрээс зайлж чадахгүй. Зориуд болон зориуд бус байсан ч бүгд үйл түйтгэртэй. Үйл байвал үр байдаг. Жишээлбэл, эр нөхөр юм уу, эхнэр хүүхэд чинь чамайг бясалгал хийхэд дургүй, хоол хийж өгөх хүсэлгүй, эсвэл цагаан хоол идэх газар олдохгүй гэх мэт. Энэ нь хуурч буй хэрэг биш, бодит байдал тул бас ойлгож болно.

Бас нэг өөр төрлийн хүн байна. Тэд мах идэж, архи ууж, садарлаж самуурах мөртлөө өөрийгөө Бурхан гэнэ. Ийм явдал байхгүй. Түрүүн хэлсэн шиг цагаан хоол идэж чадахгүй, бясалгалыг хичээнгүйлэн хийж, ажил төрөлтэй холбоотой юм уу эсвэл эр нөхөр, эхнэр хүүхдийн эсэргүүцэл зэргээс болоод өөрийгөө болохгүй байна гэдгээ мэдэж байдаг. Гэтэл зарим хүн юу ч идсэн, юу ч хийсэн болно гэж боддог. Явдал суудал нь замбараагүй, садарлаж самуурах, амь таслах, мах идэх, архи уух, мөнгө төгрөг хулгайлах, хүн амьтан хуурах гэх мэтийг хийдэг ч өөрийгөө Бурхан гэнэ. Яаж ийм Бурхан байж болох вэ? Ийм хүмүүсийг бид ч хүлээж авдаггүй байхад яаж ийм Бурханыг мөргөн шүтэх вэ? Бас өөрийнхөө багшийг болгох уу? Ингэвэл ёс зүйгүй хэрэг болно.

Олон хүн өөрийгөө бясалган дадуулж байна гэдэг ч Бурхан болсон нь тун цөөхөн. Учир нь энэхүү орчлонгийн хууль цаазыг ойлгохгүйгээс асурийн төрөлтөнд мэхлэгдэнэ. Тэд: “Би бол чамайг сургахаар ирсэн тийм тийм Бурхан, одоо чи Бурхан болсон, иймэрхүү жижиг сажиг явдлыг бүү хайхар. Сүнслэг дадал бясалгалдаа хүлэгдээд хэрэггүй.” гэх зэргээр ярина. Тэднийг

ингэж ярихад бид өөрсдийгөө тун сүрхий, дэс маань аль хэдийн дээшилсэн учраас орчлонгийн хуулийг дахин анзаарч тоосны хэрэггүй гэж бодоход хүргэнэ. Хэрэв үнэхээр ингэж бодож байгаа бол баларлаа гэсэн үг. Иймээс бясалгал дадуулж байгаа хүн билиг ухаангүй бол хялбархан хууртагдаж, цаашаа явж чадахгүй. Учир нь тэрхүү ад түйтгэр тун хэцүү. Бид салъя гэсэн ч салж болдоггүй. Тэд биднийг буцааж авчраад явуулахгүй төдийгүй нэг том чулуугаар замыг маань таглачихдаг.

Иймээс бясалгагч заавал сайн Их Багштай байх хэрэгтэй. Амьд сэрүүн Их Багштай байх нь маш чухал. Энэ нь хоёр шалтгаантай. Нэгд, Тэр бидэнд сүнслэг дадал бясалгалын үндсэн дүрэм журам юу болохыг, дадал бясалгалын ёс суртахуун ямар байхыг, сэтгэл цэвэр ариун, эрхэм дээд хүслэн, зорилго тун өндөр байх хэрэгтэй гэдгийг зааж сургана. Ийм байвал ад шүглэхгүй, адад мэхлэгдэхгүй.

Хоёрт, бид бясалгал хийхдээ одоогийн Их Багшаа харвал танина. Учир нь бид Түүний гадна төрхийг мэднэ. Хэрэв бясалгаж байх үед Тэр харагдвал дүр төрх нь адилхан байна. Гэвч одоогийн Их Багшгүй бол бясалгах үеэр өнгөрсөн үеийн Их Багш ирж, биднийг дагуулж явах юм уу эсвэл ном тайлбал энэ нь өнгөрсөн үеийн жинхэнэ Их Багш мөн эсэхийг бид мэдэх аргагүй. Яагаад гэвэл бид түүнийг ерөөсөө харж байгаагүй. Шагжамуни Будда нас нөгчөөд хэдийнээ хоёр мянга таван зуу гаруй жил болж буй. Есүс Христ яваад бараг хоёр мянган жил болж байна. Жирийн үед бидний харж заншсан тэдний дүр төрх бүгд л хүмүүсийн ургуулан бодож зурсан зураг болон гэрэл зураг байдаг. Иймээс бясалгаж байх үед Тэд бидэнд үзэгдвэл жинхэнэ эсэхийг нь мэдэхгүй. Гагцхүү одоогийн Их Багшийг харвал жинхэнэ эсэхийг нь ялгаж чадна.

Бид бясалгаад дээд түвшинд хүрэх үедээ жинхэнэ Багшийгаа олж уулзана. Бид төвөг бэрхшээлтэй бол Тэр шийдвэрлэж өгнө. Бидэнд саад тохиолдвол Тэр тусалж, дээд түвшинд хүргэнэ.

Энэ үед л сая өнгөрсөн үеийн бусад Төгс Гэгээрсэн Их Багш нарыг жинхэнээр харж чадна. Ингэхгүйгээр өөрөө муйхарлан бясалгал хийгээд харсан өнгөрсөн үеийн Их Багш нарын дүр бүгд найдваргүй. Учир нь бид Есүс Христ, Шагжамуни Будда нар ямар царай зүстэй байсныг мэдэхгүй. Асурийн оронд тиймэрхүү хуурамч дүр зөндөө бий.

Иймд бясалгал дадуулахад бидэнд зааж зааварлах багшийн удирдлага заавал хэрэгтэй. Учир нь асурийн орноор дайран өнгөрөхөд Багш нь: “Үүнийг харах хэрэггүй, нүдээ аниад хурдан

өнгөр.” гэж бидэнд хэлнэ. Эсвэл тэрээр сайн биш түвшнийг халхлаад харуулдаггүй. Бясалгалын үеэр хав харанхуйг юм уу, эсвэл хаалттай хөшигний цаанаас гэрэл гялбах мэт байдлыг харуулна. Ингэж Тэр гараас минь татаж дээшээ гаргадаг. Асурийн орныг өнгөрвөл халхалж байсан хөшгөө аваад бидэнд харуулна. Учир нь бясалгалын тогтсон хүч хүрэлцэхгүй бол хүний ертөнцөөс үзэсгэлэнтэй асурийн орныг хараад энэ бол хамгийн төгс газар юм байна гэж бодох болно. Тэгээд үлдэх юмсан гэж дурлавал тэдэнд татагдана. Татагдаад явах үед нь Багш нь үнэн байдлыг хэлсэн ч чи сонсохгүй. Асурийн хүн: “Чиний багш юу ч биш. Нааш ир, би чамд Авид бурханыг үзүүлье.” гэхчлэн хэлдэг. Тэрээр иймэрхүү аргаар чамайг урхидан мэхэлнэ. Чи мэхлэгдсэнээ мэдэх үед нэгэнт оройтсон байх болно.

Иймээс жинхэнэ бясалгалын аргаар бясалгал дадуулахад тийм ч хурдан ямар нэгэн түвшнийг тэр даруй харахгүй байж магадгүй. Их доогуур түвшнийг Багш нь та нарт үзүүлэхгүй ч, бага сага нотолгоо өгнө. Тухайлбал, гэрэл харах, зам харах гэх мэтээр түвшнээ хараагүй ч хаа очсоноо мэднэ. Түвшнээ харах нь ямар нэгэн ашиг тустай гэсэн үг биш бөгөөд тэрхүү доогуур түвшнийг харчихвал тэдэнд урхидуулан мэхлэгдэж, төөрөлдөөд занганд унаад цаашлах аргагүй болно.Учир нь асурийнханд татагдвал тэд биднийг дагуулан аваачаад зүйл бүрийн заль мэх хэрэглэн итгүүлж, албатаа болгодог.

Бурханыг олж үзсэн ч бид тэгтлээ баярласны хэрэггүй. Энэ бол бидний эцсийн зогсоол биш. Энэхүү дуу, дүрст түвшнийг давж байж өөрсдийн жинхэнэ бүрэн эрхээ олно. Учир нь дуу байгаа, дүрс байгаа, Бурхан байгаа, би байгаа бол “Хоёр”-ын ялгаа оршсоор буй. “Би”,”Бурхан”-ыг олж харсан гэдэг нь “би бол Бурхан” гэсэн үг биш. Иймээс бясалгалын үед Бурханыг эсвэл Багшийгаа харвал энэ нь Тэд та нарыг илүү дээгүүр түвшин рүү аваачиж байгаа хэрэг. Учир нь хэсэг хугацаагаар бясалгаад нэг түвшинд хүрэхэд байшингийн таазанд тулчихсан мэт болдог. Тэр үед бид яаж ч хүчлээд давж гарч чадахгүй. Юу ч биднийг дагуулан гаргаж чадахгүй. Зөвхөн Их Багш л ирж татан гаргаж, энэхүү түр зуурын бэрхшээл саадыг гэтлүүлдэг. Үүний дараа бид цааш явах боломжтой болно.

Иймээс чамайг замчлах Их Багш байх хэрэгтэй. Бясалгалын үед Багш нь ирж та нарыг өндөр түвшинд дагуулан аваачихыг хараад өөрийгөө хэдийнээ сүрхий болжээ гэж боддог. Гэтэл энэ нь мөн л “би Их Багштай”, “би Их Багшаа шүтдэг” гэсэн түвшин болохоос “би бол Их Багш” гэсэн түвшин биш. Өөрөө Их Багш

болох нь хамгийн зөв. Бид өөрсдөө Төгс Гэгээрсэн Их Багш юм.

Иймэ түвшинд хүрэх нь хамгийн дээд нь болно. Бид өөрийгөө Төгс Гэгээрсэн Их Багш гэдгээ танихаас өмнө, биднийг дагуулан явах өөр Төгс Гэгээрсэн Их Багштай байх хэрэгтэй. Иймээс даяаны урсгалынхан: "Бурхан ирвэл Бурханыг цавч, ад ирвэл адыг цавч." гэдэг. Гэвч тэдний ихэнх нь үүнийг зөвхөн хэлж ярих төдий болохоос өөрийн ахуй ойлголтгүй байдаг. Тэд Бурхан болох хэрэггүй, юу ч гуйж залбираад хэрэггүй, тэгвэл л болж байгаа хэрэг гэж боддог ч үнэндээ тийм биш юм. Өөрөө ахуй ойлголттой болж байж л "Бурхан ирвэл Бурханыг цавч." гэж хэлж болно. Хэрэв Бурханыг ерөөсөө үзээгүй бол юуг нь цавчих гээд байгаа юм бэ? Бурханыг цавчих нь илүү өндөр түвшинд хүрэхийн төлөө юм.

Энэтхэгт нэг алдартай бясалгагч бий. Тэр хэдэн арван жил бясалгаж байж Их Багш болжээ Бурхан болоогүй, Очироор самадид хүрээгүй, өөрөөр хэлбэл хамгийн төгс тэнсэлгүй, үнэхээр туулан ангижирсан болохоосоо өмнө бидний Арьяабал бурханыг шүтдэгтэй адил нэгэн дарь эхийг ихэд шүтэж, уулзахыг тун их хүсдэг байжээ. Хэсэг хугацааны дараа тэрхүү дарь эхийн дүр амилж, өдөр болгон түүнтэй ярилцдаг болжээ. Түүнийг сүмд очиход дарь эхийн дүр бууж ирэн түүнтэй ярилцаж, юм зааж өгдөг байв. Дарь эх түүнд их таалагдсан тул түүнтэй дотно нөхөрлөжээ. Гэвч хожим нь тэрээр Их Багштай учраад ном тайлахыг нь сонссоны дараа энэхүү ахуй ойлголт нь шалихгүй зүйл болохыг мэджээ.

Жишээлбэл, бид Арьяабал бурханд, Есүс Христэд эсвэл Гэгээн Марияд их хайртай. Бид хэтэрхий хайртай тул нэгэн өдөр тэдэнтэй холбогдон ярилцаж, эсвэл тэднийг харж магадгүй. Тухайн үед бидэнд их сайхан санагдаж болох ч, тэдэнтэй яаж дотносож, бишрэн шүтсэн ч бүгд өнгөн талын зүйлс байдаг. Тэднийг харснаар бид өөрсдийгөө хэн болохыг мэдэж чадахгүй. Бид угаасаа ямар чадвартай, ямар эрхтэй болохоо ойлгодоггүй. Энэхүү орчлон ертөнцийн бодит байдал ямар болохыг ч мөн ойлгодоггүй.

Тэрхүү Энэтхэг бясалгалтан Их Багштайгаа уулзаад өөрийн харсан үзсэн бүхэн нь хамгийн төгс ертөнц биш гэдгийг дорхноо ойлгожээ. Багш нь түүнд бясалгал дадуулах аргыг зааж өгсөнд тэр их л чармайн бясалгаж дэвшил нь ч бас хурдан байв. Гэвч тодорхой нэг түвшинд хүрээд давж гарахын аргагүй болжээ. Учир нь тэрхүү хүслэнт ахуйг давж гарахыг завдах болгонд түүний бишрэн шүтдэг нөгөө дарь эх ирж өмнө нь зогсчихоод

өнгөрөөдөггүй байж. Нэлээд урт хугацаанд тэр энэхүү дуутай, дүрстэй саад тотгорыг гэтэлж дийлэхгүй байв.

Нэгэн өдөр Их Багшдаа гомдлоо тоочсонд: “Яагаад давж гарч болохгүй гэж?” гэж Тэрээр ихэд санаа тавин өгүүлжээ. Тэр нэгэн хурц ирмэгтэй чулуу эрж олоод иртэй хэсгээр нь шавийнхаа магнайн голд цус гартал нь хүчлэн дарав. Хэрэв энгийн хүн харах юм бол энэ Их Багшийг хүн алж мэдэх хэрцгий хүн байна гэж лавтай бодно. Заавал давах ёстой болохыг мэдвэл зохино гэж Багш нь хэлжээ. Энэ үед шавь нь үнэн сэтгэлээсээ бясалгаж, дарь эхийг ирэхэд билиг ухаанаараа түүнийг хоёр хэсэг болгон цавчиж хаяад даван туулж чаджээ. Ярихад амархан ч та нар иймэрхүү хүслэнт ахуйтай учраагүй бол төсөөлж бодохын аргагүй. Үнэндээ тийм ч хялбар биш.

Жинхэнэ сайн багш доод хүрдүүд дээр бясалгахыг заадаггүй. Учир нь бидний биед төвлөрөн бясалгаж болдог нэлээд олон хүрдүүд байдаг. Тэднийг Chakra гэнэ. Бид наран сүлжээг бясалгавал их хүчтэй болно, зүрхний хүрдийг бясалгасан ч мөн адил. Юуг ч бясалгасан хүчтэй болно, хамартаа төвлөрсөн ч ялгаагүй. Гэвч энэ бүхэн бясалгалын хамгийн сайн хүрд биш. Хэрэв билгийн мэлмийнээс дооших хэсгүүдийг бясалгавал, хожим нь дээд түвшнийг бясалгахад амаргүй болдог. Учир нь бид “сэтгэл”-ээ доогуур газар хандуулсаар байгаад хэт дадсан тул дээшээ явахад хялбар бус. Иймээс Их Багш нар сэтгэлээ доогуур түвшинд хандуулахыг заадаггүй. Билгийн мэлмийнээс дооших нь бүгд ялгаруулах систем бөгөөд тун бохир заваан. Ялгаруулах эрхтнээр бясалгал дадуулсан түвшин нь мөн л бүтэх, орших, эвдрэх, хоосрохын дотор байх учраас мөнх бус.

Маш олон бясалгалын арга байдаг ч чухам аль нь хамгийн сайн болохыг мэддэггүйгээс олон хүн өөрсдийгөө хамгийн дээд номын багш хэмээн нэрийддэг. Зарим нь амьсгал дээрээ, наран сүлжээндээ төвлөрч бясалгаад ололттой байдаг ч энэ нь хамгийн төгс сайн нь биш. Энэ талаар бид ном судраас лавлаад ойлгож болно. Эсвэл өөрөө бясалгаж дадуулсны дараа эдгээр арга бүгд төгс сайн биш гэдгийг мэднэ.

Дадал бясалгал сайтай хүн телевиз кино үздэггүй, дуу хөгжим сонсдоггүй. Яагаад тэр вэ? Учир нь бид сэтгэлээ угаас гадагшаа олон газар луу хандуулж байдаг. Нүдээ нээмэгц гадаад ертөнцийг харна, чих ч бас гаднын элдэв зүйлийг сонсоно. Иймээс “Дотооддоо хандаж, уг чанараа ажих.” нь тун амаргүй, дотооддоо төвлөрөхөд хялбар бус. Хэрэв дуу хөгжим сонсвол бидний сэтгэл гадагш сарнина. Бид бясалгал дадуудахдаа сэтгэлээ татан,

дотогш хандуулж “дотоодоороо бясалгах” хэрэгтэй. Иймээс их бясалгагчид дуу хөгжим сонсдоггүй, ертөнцийн зугаа цэнгэлийг боддоггүй. Учир нь сэтгэлээ арай ядан дотогш хандуулчихаад, яах гэж дуу хөгжим сонсож гадагш сарниулах вэ?

Бясалгалын олон янзын арга бий гэж Багш нь саяхан ярьсан. Тэр аргууд нь бүгд л сэтгэлийг “Билгийн мэлмий“-ээс дооших хүрдүүдэд хандуулдаг. Энэ хүрдүүд нь бүгд л бүтэх, орших, эвдрэх, хоосрох тул мөнхөд орших түвшин биш. Билиг ухаан бидний биеийн аль хэсэгт байдгийг та нар мэдэх үү? Бид билиг ухаан, ид шидийн талаар одоохондоо ярихгүй. Толгой тархи бол бидний хамгийн чухал эрхтэн мөн үү? Бид юу ч бодсон тархи оюундаа бодож, түүнд төвлөрч байж тулгарсан асуудал, саад тотгорыг шийдвэрлэж чадна. Хэрэв бид хамгийн чухал оюун ухаанаа, ухамсраа доогуур хүрдүүдэд хандуулбал ёс зүйгүй явдал болох биш үү?

Жишээ нь, ямар нэгэн асуудлыг шийдэж чадахгүй үедээ бид хөмсгөө зангиддаг. Тийм үү? Дараа нь ухамсраа энд төвлөрүүлдэг биз дээ? (*Багш магнайныхаа голд заав.*) Зарим үед тархиа хэтэрхий ажиллуулбал, жаахан хэвтэж амран түүнийг цусаар хангавал үргэлжлүүлэн сэтгэж чадна. Яагаад гэвэл бидний тархи толгой тун чухал, түүнд билиг ухаан оршино. Тархины тусламжтайгаар бид сэтгэн боддог бөгөөд энэхүү чадвар нь төрөлхөөс заяагдмал. Гэтэл бид өөрсдийн ухамсрыг хамар, хоолой, зүрх, наран сүлжээнд, цаашилбал зарим хүн бэлгэ эрхтэндээ төвлөрүүлдэг. Ингэх нь харин ч хөлөөрөө толгой хийсэн явдал болох бус уу?

Хүн нас нөгчсөний дараа хэвлий нь халуун байвал бирд болно, зүрхний нь хавьд халуун бол хүн болно, өвдөг орчим халуун бол адгуус болж төрнө. Магнай нь зөөлөн бол тэнгэрт төрнө, зулай нь зөөлөн бол Бурхан болно гэж Бурханы шашны ном сударт дурдсан байдаг. Хэрэв тийм бол бид яагаад магнайнаас эхэлж бясалгал хийхгүй байгаа юм бэ? Сэтгэлээ доош хандуулж болохгүй. Угаас энд (*Багш билгийн мэлмийгээ заав.*) бодож сэтгэдэг байтал яагаад дадал бясалгал дадуулах үед эсрэгээрээ доошоо явна гэж? Гэдэс юмыг шингээж, зүрх цусыг бүх биед хүргэнэ. Зарим хүн бэлгэ эрхтнээ бясалгадаг, ингээд яах гээ вэ? Бэлгэ эрхтэн юу ч бодож чадахгүй. Зөвхөн хүүхэд гаргах, өтгөн шингэн гадагшлуулах л төдий. Гэтэл Энэтхэг, Формоса, Америк зэрэг оронд бэлгийн хүрдийг бясалгадаг хүмүүс байдаг. Учир нь “Дао” гэж юу болохыг ойлгодоггүй, хэрхэн яаж бясалгахыг мэддэггүй. Иймээс бодож бодож аль газар нь таашаалтай санагдана, түүнийгээ бясалгадаг.

Зарим хүн “Бурхан сэтгэлд оршино.” гэж сонсоод зүрхний

хүрдэн дээр бясалгана. Энэ нь уулаасаа цус түгээх эрхтэн төдий, сэтгэн бодох чадвар огт байхгүй. Хэрэв наран сүлжээн дээрээ бясалгавал тэр биднийг шингээж орхих бөгөөд (*Бүгд инээв*.) дараа нь бид гэдсээр туугдаж гарна. Хамраа ажих нь бас адил. Хамраар юу хийдгийг та нар тодорхой мэдэж байгаа. Хэлээрээ ногоо иднэ, цагаан хоол иднэ. Зарим хүн хэлээрээ бохир заваан мах идэж, зарим нь архи ууж, есөн жорын үг ярин, чимээ шуугиан үүсгэж байдаг. Хэл бодож сэтгэж чадахгүй. Энэхүү толгой тархи байхгүй бол хэл хөдөлж ч чадахгүй, гэдэс шингээж ч чадахгүй. Толгой тархи байхгүй бол зүрх цохилохоо болино. Хүн өөд болсны дараа бие эрхтэн нь бүрэн байвч ажиллагаа нь бүгд зогсож, дахиж сэргэхгүй болсон байдаг. Яагаад вэ? Яагаад гэвэл эзэн нь нэгэнт явчихжээ.

Иймээс бясалгал хийе гэвэл толгой тархи буюу оюун ухаанаасаа эхлэх хэрэгтэй. Толгой тархи нь угаас эрхэм дээд газар юм. Хэрэв түүнийг албадан буулгаж доод байрлалд аваачвал, толгой тархи маань ногоо цагаа, архи махтай хамт ялгаран гадагшилчихвал улам л ухаангүй болно. Ийм байхад яаж билиг ухаантай болох юм бэ?

Зарим хүн амьсгалын аргаар бясалгал дадуулдаг. Гэвч толгой тархи байхгүй бол амьсгалж чадахгүй. Үхсэний дараа амьсгалгүй болно. Төрөхөөс өмнө мөн л амьсгалгүй байдаг. Амьсгал нь угаасаа мөнх бус. Зарим хүн амьсгалаа удирддаг. Хэрэв оюун ухаан байхгүй бол бид амьсгалаа хянаж чадахгүй. Бүх юм оюун ухаанаас хамаарч байхад яагаад шуудхан түүгээр бясалгахгүй байна вэ? Яагаад гэдэс, хамар, зүрх, бэлгэ эрхтэн, амьсгалыг хүртэл түүгээр хянуулж, тэгтэл их ядраана вэ? Яагаад түүнийг шууд даруй ашиглахгүй байгаа юм бэ? Юунд түүнийг тэгтэл нь чармайн ажиллуулдаг юм бэ? Хэчнээн зүтгээд ч хэрэггүй, учир нь бид түүнийг зөвхөн ажиллуулж байгаа болохоос биш ашиглахгүй байна. Үүнд л учир нь байгаа юм.

Бид хэрэв дадал бясалгалыг жинхэнэ ёсоор хийе гэвэл оюун ухаанаа түшиглэх хэрэгтэй. Эгэл хүн тархиныхаа өчүүхэн хэсгийг ашигладаг. Их бясалгагч их билиг ухаантай байдаг гэж бид байнга ярьдаг. Учир нь тэд оюун ухаанаа сайн ашигладаг. Тэр ч байтугай зарим хүн тархиныхаа чадамжийг бүрэн ашигладаг учраас алив зүйлийг бүгдийг мэддэг. Бүхий л орчлон хорвоог бүгдийг мэднэ. Тийм хүнийг бид “Бурхан болжээ.” гэдэг. Бурхан болоход үнэндээ ямар нэг нарийн нууц байхгүй, оюун ухаанаа илүү их ашигласанд л учир нь байгаа юм. Оюун ухаанаа хэтэрхий бага хэрэглэж байгаа учир бид мунхаг харанхуй, харин Бурхан

ухаантай сэргэлэн байдаг.

Энэхүү оюун ухааныг зарим хүн “Билиг ухаан”, зарим нь “Сүнс” гэж нэрлэх бөгөөд энэ нь магнайн төвд оршдог. Иймээс сүнслэг дадал бясалгал хийхдээ дадуулахдаа магнайнаас дооших хэсгийг мартаж орхи. Амьсгал ч гэсэн мөнх бус тул мартах хэрэгтэй. Өөрийн билиг ухаанаараа бясалга. Билиг ухаантай газраасаа эхлэн бясалгал дадуулах нь зөв боловч чухам юуг бясалгах вэ? Энэ нь заавал ном уламжилсны дараа бясалгаж чадна. Өнөөдөр Багш нь ном тайлсан болохоос ном уламжлаагүй тул та нар ойлгохгүй. Ном тайлсан нь зөвхөн та нарт лавлагаа болгох төдий. Ном уламжлах үед тэр даруй ойлгох бөгөөд одоогийнх шиг их ярихгүй. Энэ үед юм ярьдаггүй ч хамгийн хэрэгтэй, хамгийн хүчтэй, хамгийн их зүйлийг олж авдаг. Одоо Багш нь тийм их ярьсан ч та нар юу ч олж авч чадаагүй, зөвхөн бага сага ойлгосон төдий л юм. Багш нь юм ярихгүй байх үед, та нар жинхэнэ ёсоор “ном” олж хүртэнэ. Одоо миний ярьж байгаа нь танилцуулах, тоглож наадах, ярилцаж мэтгэлцэн найз нөхөд болцгоож буй төдий.

Бидний биед хамгаас чухал нэг газар байдаг бөгөөд тэнд билиг ухаан бий. Магнайн төв хэсэгт гуравдагч нүд, билгийн мэлмий эсвэл Бурханы мэлмий, номын нүд, Бодьсадвагийн мэлмий буй гэж бид байнга ярьдаг. Түүнийг мэлмий гэдэг ч үнэндээ тэнд мэлмий байхгүй. Гэвч тэр бүхнийг хардаг болохоор бид “мэлмий” гэж нэрлэсэн. Энэхүү мэлмий бүхнийг хардаг, ойлгодог, сонсдог, мэдэрдэг, мэддэг болохоор “Билгийн мэлмий” гэжээ. Билгийн мэлмийгээ хэрэглэе гэвэл түүнийг нээх түлхүүр хэрэгтэй. Нээсний дараа л хэрэглэж болно. Нээхгүй бол байгаад ч хэрэггүй.

Бид “Сэтгэл”-ээрээ боддог юм биш. Илүү өндөр түвшнийг оюун ухаанаараа боддоггүй, бидний өөрийн “Билиг ухаан” аяндаа мэддэг. Бурханыг бодож, номыг бодож, хуврагийг бодож, өөртөө төвөг удсаны хэрэггүй. Бурхан, ном, хувраг гэдгийн жинхэнэ утгыг аяндаа биеэрээ мэдэрнэ. Ингэвэл сая билиг нээгдсэн хэрэг болно. Гэвч одоохондоо билиг нээгдэхийг мэдэхгүй байгаа болохоор Бурхан болохыг бодох хэрэгтэй Бурхан харья гэвэл Бурханы оронд очих хэрэгтэй. Бурханы орон ямар байдаг бол? Бурхан ямар дүр төрхтэй вэ? Хэрэв бид эдгээр зүйлийг олж үзэхийг хүсэж буй бол эхний түвшиндээ л байна гэсэн үг. Билиг жинхэнэ ёсоор нээгдэх үед бид өөрсдөө харна. Бодохгүй ч харна, хүсээгүй ч мэднэ, лавлаагүй ч ойлгоно. Үүнийг билиг нээгдэх гэнэ. Тэрхүү билиг ухаан нь хүн бүрд бий ч нээхгүй бол хэрэглэж

болохгүй, байсан ч хаана байгааг нь мэдэхгүй.

Гэвч жинхэнэ Их Багш үүнийг мэднэ. Бидний билиг ухаан хаана байгаа, түүнийг хэрхэн хэрэглэхийг Тэрээр бидэнд хэлж өгдөг. Өдөр бүр түүнийг ашиглаж, төгс төгөлдөр болтол нь ашигласны дараа бүхий л оюун ухаан, эсвэл билиг ухаан бүгд биднийх болно. Тэр үед бид "Бурхан болжээ" гэдэг. Багш нь энд билиг ухаан буй гэж та нарт хэлсэн. Гэвч яаж хэрэглэхийг та нар хараахан мэдэхгүй байгаа. Үүнийг гагцхүү ном уламжлах үеэр л мэдэж болно. Энд хэчнээн ярьсан ч нэмэргүй, учир нь номыг жинхэнэ ёсоор уламжлахад юм ярьдаггүй.

Магнайнаас дооших ямар ч хүрдэд билиг ухаан байхгүй гэж Багш нь хэлж чадна. Билиг ухаан нь магнайн төв хэсэгт "Гуравдагч нүд" (билгийн мэлмий буюу номын нүд)-нд бий. Гэвч та нар нээж чадахгүй болохоор мэдэхгүй. Гагцхүү жинхэнэ Их Багшийг хайж олоод Түүгээр нээлгүүлбэл даруй ашиглаж болно. Ийм Их Багш нь хүмүүст билгийн мэлмийг нь тусгайлан нээж өгдөг мэргэжилтэнтэй адил. Билгүүн ухаан нээгдэх үеийг бид "Билиг нээгдэх" (гэгээрэх) гэдэг.

Түрүүчийн 7 хоногт нэг багш дөч, тавиад сурагчаа дагуулан манай бясалгалын төвд ирсэн. Хэдийгээр тэд хүүхэд боловч мөн л билиг нь нээгддэг. Багш нь тэдэнд бага сага гэгээрлийн ахуй ойлголт өгсний дараа тэд бүгд ахуй ойлголттой болсон. Ахуй ойлголтгүй хүн нэг ч байгаагүй. Хүүхэд ч бас сүнслэг дадал бясалгал хийж болж байгаад Багш нь баяртай байна. Хэрэв аль хаалгыг нь нээхийг мэдвэл хүүхэд ч бас өөрийн гэсэн ахуй ойлголттой болдог. Хамаг амьтан бүхэнд энэхүү билиг ухаан бий. Гэвч нээгээгүй учраас хэрэглэж чадахгүй байгаа нь үнэхээр харамсалтай.

Асуулт: Багшаа, энэ амь насны Keypoint (гол зорилго) нь юу вэ?

Их Багш: Keypoint-ийг ном уламжлах үед чамд өгөх болно. Одоо би яриад ч нэмэргүй. Ном уламжлах үед Багш нь юм ярихгүй ч чи Keypoint-ийг олж авах болно. (*Багш хэзээ надад ном уламжилж өгөх вэ?*) (*Бүгд инээв.*) Одоогоор завгүй, гэвч чи надаар уламжлуулна гэвэл тийм ч хэцүү биш. (*Уучлаарай, багш та хэзээ надад хаалгыг минь нээж өгөх вэ л гэж асуусан юм?*) (*Бүгд инээв.*) Байдлаас л болно. Хэрэв хүн олон бол нэг өдөр цаг зав гаргаж та нарт ном уламжилж өгнө. Гэвч та нар эхлээд өөрсдийгөө бэлтгэж, биеэ ариусгах хэрэгтэй. Энгийн хүн хэвээрээ байя гэвэл хамаагүй. Харин Бодьсадва, Бурхан болъё гэвэл нигүүлсэнгүй сэтгэл үүсгэх хэрэгтэй. Хамаг амьтны махыг иддэг зуршлаа бүрэн

орхих хэрэгтэй. Ингэж байж Бодьсадва болж чадна.

Ердийн бясалгалын аргаар бясалгал хийхэд юу ч идсэн хамаагүй. Амьсгалаараа болон наран сүлжээгээрээ бясалгахад заавал цагаан хоол идэх албагүй. Гэвч Бодьсадва болъё гэвэл даруй цагаан хоол идэх хэрэгтэй. Хамаг амьтны махыг огт идэж болохгүй. Энэ бол хамгийн үндсэн бөгөөд хамгийн чухал ёс суртахуун болно. Хамаг амьтныг гэтэлгэж ч эхлээгүй байж, тэднийг цөмийг нь гэдэс рүүгээ "гэтэлгэчихээд" Бодьсадва болъё гэж яаж бодож болох вэ? (*Бүгд инээв.*) Ингэвэл хожим гэтэлгэх амьтангүй болно. Бид уг нь Бурхан, Бодьсадва болчихоод хамаг амьтныг гэтэлгэх байтал, тэднийг гэдсээрээ гэтэлгэж байгаа нь ичмээр явдал биш үү!

Асуулт: Сүнслэг бясалгагч хүн гэр бүл зуучлагч болж болох уу?

Их Багш: Хэрэггүй. Өөр хийчихмээр юм олдохгүй байна уу? (*Бүгд инээв.*) Энэ түүний ажил нь уу? (*Үгүй.*) Хэрэв ажил нь биш бол хийх хэрэггүй. Тэд өөрсдөө хань ижлээ олог. Олон хүн зуучлагчгүйгээр гэрлэцгээж байна. (*Бүгд инээв.*) (*Хүү нь их ноомой, эмэгтэй найзтай болж чаддаггүй, гучин нэгтэй болчихоод гэрлээгүй л байна гэж хөрш маань хэлсэн.*) (*Бүгд инээв.*) Эхнэр олдохгүй бол сайн. Түүнийг гэрээс гар гэж хэл. (*Бүгд инээв.*) Формоса ийм их хүнтэй байхад бас гэрлэнэ гэнэ ээ? Хүүхдэд ч идэх хоол олдохгүй болно. Гэрээс гарсан хүн өдөрт нэг удаа хооллоно, улсын мөнгөнд арвитай. (*Бүгд инээв.*) Хүүхэд цөөн бол улс гүрэн дампуурахгүй. Түүнд гэрээс гар гэж хэлбэл сайн, зуучлаад хэрэггүй.

Эхнэр олдохгүй байгаа нь түүний өөрийнх нь үйлийн үр. Эхнэргүй бол бүр сайн, эхнэрээр яах юм бэ? Цагаан хоол идье гэвэл тэр чамд хийж өгөхгүй. Тэр чамайг дадал бясалгал хийлгэхгүй, билиг ухаанаа хөгжүүлэхэд чинь саад болно. Эр нөхөртэйгөө хамт бясалгадаг эхнэр олно гэдэг тун хэцүү. Ихэнх тохиолдолд эхнэр нь бясалгавал нөхөр нь саад болдог, нөхөр нь бясалгавал эхнэр нь саад хийдэг. Иймээс хүнд зууч болох хэрэггүй. Түүнийг зөнгөөр нь орхивол сайн. Эр нөхөргүй, эхнэр хүүхэдгүй байхад ямар ч асуудал гарахгүй. Гэрлэнэ гэдэг нь чухал зүйл биш, ая зөнгөөрөө байвал сайн. Бид бусдын үйлийн үрд хөндлөнгөөс оролцох хэрэггүй. Ингэх нь өөрийн биедээ үйл түйтгэр авчирдаг.

Асуулт: Багш аа, та саяхан бясалгалын үндсэн нөхцөл нь ёс суртахуунтай байх, сэтгэл санаа ариун байх, тэгээд хамгийн эрхэм дээд хүслэнтэй байх явдал гэж ярьсан. Багшаа, эрхэм дээд

хүслэн гэж чухам юу болохыг хэлж өгнө үү?

Их Багш: Эрхэм дээд хүслэнг чи өөрөө мэдэх ёстой, Багшаасаа асуух хэрэггүй. (*Яг ч сайн мэдэхгүй, Их Багш та бодит жишээн дээр тайлбарлаж өгнө үү?*) За тэгвэл чиний бясалгалын зорилго чинь юу вэ? Чи Бурхан болмоор байна уу? эсвэл өөр юу болмоор байна? (*Ер нь бол Бурхан болмоор байна, гэвч Бурхан болох нь ямаршуухан байдгийг би ойлгохгүй байгаа юм. Бурхан гэж чухамдаа хэн бэ?*)

За, одоо би хэлж өгье. Бидний бясалгал дадуулж буй нь энэхүү ертөнцийн шаналал зовлонг хараад хамаг амьтанд туслах хүч чадалтай болохын төлөө юм. Жишээлбэл, Бурхан болсны чинь дараа чамаас нэг хүн төгс баясгалант оронд очъё гэвэл түүнийг даруй дагуулж аваачиж болно. Хэн ч очъё гэсэн чи хүргэж өгч чадна. Чи Бурхан эсвэл их билиг ухаантай болсны дараа хэн нэгэн чамаас билиг ухаанаа нээхэд минь туслаач гэж гуйвал чи даруй нээж өгч чадна. Үүнийг л эрхэм дээд хүслэн гэнэ. Бурхан болох, эсвэл ямар нэг юм болохыг чухалчлан анхаарах хэрэггүй. Нэр чухал биш. Жишээ нь, өвчин зовлонд шаналж байгаа хүмүүсийг хараад зовлонгоос нь аврах сэтгэл төрж, эмч болдог. Иймээс бид түүнийг эмч гэх юм уу өөр ямар нэг нэрээр дууддаг. Хэн ч гэж дуудсан хамаагүй, өвчин зовлонгоос аврах эрхэм дээд хүслэнтэй байгаа нь л хамгаас чухал юм.

Яагаад сүнслэг дадал бясалгал хийх хэрэгтэй юм бэ? гэж өөрөөсөө асуугаарай. Зовлонгоосоо салахын төлөө юу, гурван ертөнцөөс гэтлэхийн төлөө юу? Эсвэл хамаг амьтан зовж буйг хараад аврахын тулд, тэднийг дагуулан гурван ертөнцийг даван гарч, сансрын хүрдэнд дахин эргэлдэхгүйн төлөө юу? Хэрэв чи ийм хүсэлтэй бол энэ нь эрхэм дээд хүслэн мөн. Бид энэхүү шударга бус ертөнцөөс залхсан учраас өөрийгөө аварч, гурван ертөнцөөс хэтийдэх хэрэгтэй. Төрөхгүй, өтлөхгүй, өвдөхгүй, үхэхгүй, үүрд баяр хөөртэй байдаг нэн өндөр түвшинд бид очихыг хүсдэг. Очсоны дараа төрөл садан, ахан дүүсээ дагуулан аваачна. Ингэвэл эрхэм дээд хүслэн болно. Чиний юу болох нь хамаагүй, гагцхүү ийм хүслэнтэй л бол хамгийн сайн.

Асуулт: Гурван ертөнц хамгийн өндөр нь үү? Гурван ертөнцөөс цааш илүү өндөр түвшин оршин байдаг уу?

Их Багш: Гурван ертөнцөөс гадна илүү өндөр түвшин мэдээж бий. Тийм биш бол бид гурван ертөнцийг давах хэрэг юун? Гурван ертөнцийн доторх бүх зүйл бүтэж, оршиж, эвдэрч, хоосордог тул эрт орой хэзээ нэгэн цагт сүйрч алга болох учраас бид гурван ертөнцийг давах хэрэгтэй. Гурван ертөнцөөс гадна

өнө мөнхийн үүрдийн баяр жаргалтай газар байдаг.

Асуулт: Орчлонгийн аливаа юмс үзэгдэл нь бүгд хүний сэтгэлээс үүдэлтэй гэж найз маань ярьдаг. Энэ үнэн үү?

Их Багш: Тиймээс л бид бие, хэл, сэтгэлээ дадуудах хэрэгтэй. Учир нь бие, хэл, сэтгэл л үйл түйтгэр үүсгэдэг. Бидний бодсон, ярьсан, үйлдсэн бүгд л үйл үртэй. Сүнслэг дадал бясалгал хийгээд архад юм уу Бодьсадва болбол үйл түйтгэргүй болно. Учир нь үйл түйтгэр хэдийнээ ариусаж, түүнийг давсан тул ямар ч нөлөөнд автахгүй. Хамаг амьтныг гэтэлгэнэ гэж тангараглаад буцаж ирсэн бол энэ нь өөрийн хүслээрээ энэ ертөнцөд бууж буй тул үйл түйтгэртэй холбоо хамааралгүй.

Асуулт: Багш аа, сэтгэлийн хүч хэр их байдаг вэ? Гурван ертөнц бүгд түүний нөлөөнд байдаг уу? Эсвэл хүний ертөнц л энэ нөлөөнд байдаг уу?

Их Багш: Гурван ертөнцийн дотор сэтгэлийн нөлөө байсаар байдаг. Гуравдугаар ертөнцөд хүрвэл үйл түйтгэр үгүй болно. Гэвч мөн л бүтэх, орших, эвдрэх, хоосрохын дотор оршин байгаа учраас гурван ертөнц нэг л өдөр эвдрэн сүйрнэ. Зөвхөн манай ертөнц ч биш, гурван ертөнц бүхлээрээ эвдрэн сүйрнэ. Иймээс түүн дотор байгаа л бол үүрд туулан гэтэлсэн бус. (*Тэгвэл яавал гэтэлсэнд тооцогдох вэ?*) Гэтлэх гэдэг бол гурван ертөнцөөс цааш, тухайлбал дөрөв, тавдугаар ертөнцөд хүрч, гурван ертөнцөөс хэтийдэхийг хэлнэ. Гэвч дөрөвдүгээр ертөнцөд хүрсэн ч үүрд туулан гэтлэхгүй. Энэхүү дүрс үгүй ертөнц нь угаас гурван ертөнцийн дотор ч байдаггүй, гадна нь ч оршдоггүй, харин түүний хил дээр байдаг. Жишээ нь, гуравдугаар ертөнц энд байна. Түүнтэй хиллэсэн нэг ертөнц бий. Түүнийг дөрөвдүгээр ертөнц гэх бөгөөд энэ нь дүрс үгүй ертөнцөд багтана. Дүрс үгүй ертөнц бас нэлээд олон түвшинтэй. Саяын хэлсэнчлэн гурав, дөрөвдүгээр ертөнцийн хил нь дүрс үгүй ертөнцийн хамгийн доод түвшинд хамаарагдана. Тэр уг нь гуравдугаар ертөнцийн гадна байгаа ч бидэнд ач холбогдол багатай тул гурван ертөнцийн дотор багтаасан.

Хожим чи тэнд очсон ч нэмэргүй, мөн л гэтлэгдэхгүй. Бас юу ч хийж чадахгүй. Доошоо бууж болно, дээшээ гарч чадахгүй. Түүний нөхцөл байдал нэлээд онцлог учраас гурван ертөнцийн дотор хамааруулсан ч, түүний дотор оршдоггүй. Шагжамуни Будда үүнийг гурван ертөнцийн доторх буюу гурван ертөнцийн гаднах гэж энгийнээр ангилжээ. Гэвч энэ нь гол биш. Би маргах гээгүй. Хэрэв та нар сүнслэг дадал бясалгал хийх юм бол, дөрөвдүгээр ертөнц тийм ч чухал бус гэдгийг мэдэж авна гэж

л хэлэх гэсэн юм. Зарим хүн түүнийг гурван ертөнцийн дотор, зарим нь гурван ертөнцийн гадна хамааруулдаг ч, энэ нь ямар ч ялгаагүй. Ном уламжлах үед би нэлээд тодорхой ярина. Тэнгэрийн нууцыг олны газар задруулж болохгүй.

Асуулт: Жирийн үед бясалгал хийх, маани тарни унших үеэр юм харах юм уу аялгуу сонсвол яах вэ?

Их Багш: Чи ямар маани уншдаг юм вэ? (Арьяабал бурханы) Тийм бол үргэлжлүүлэн уншаарай. (*Унтаж чадахгүй бол яавал дээр вэ?*) Тийм бол унтахгүй л байхаас. Чиний ингэж уншихыг бясалгалд тооцохгүй. Энэ бол зөвхөн маани тоолж байгаа хэрэг. Шагжамуни Бурхан ингэхийг заагаагүй. Бид Түүний бясалгалын аргыг буруу ойлгоод байгаа юм. Арьяабалын аргаар дадуулан бясалгахдаа "Арьяабал бурханд мөргөмүй." гээд уншихад болно гэж бид боддог. Тийм биш. "Аялгуу ажихуй"-г бясалгах нь их өндөр түвшин, дээдийн дээд бясалгалын арга юм. Арьяабал бурханыг амаар дурсдаггүй. Яг одоо чамд зааж өгөх аргагүй болохоор Арьяабал бурханаа дурсан уншиж л бай. Үнэн сэтгэлээсээ гэтэлье, авшиг хүртье гэж санаж байгаа бол Багшаасаа ном уламжлахыг хүсэж болно. Гэвч манай бясалгалын аргыг олны газар заадаггүй.

Манай бясалгалын арга үг яриа хэрэглэхгүй. Хэдийгээр би юм ярихгүй боловч та "ном"-ыг олж хүртэнэ. Тэгсэн ч та Арьяабал бурханы мааний унших дуртай бол уншиж, ямар нэг түвшнийг харахыг хүсвэл түүнийгээ харж болно. Надад ямар ч арга байхгүй. Яагаад гэвэл та харж буй түвшнийхээ жинхэнэ эсэхийг ялгаж чадахгүй. Учир нь та, бидний замаар яваагүй болохоор би одоо танд хэлэх аргагүй. Хэрэв хэрэгтэй гэвэл энэ зам руу ороорой. Ингэвэл би танд тусалж чадна. Үгүй бол зогсоогоорой. Бясалгал дадуулсны хэрэггүй.

ГЭГЭЭРЭХ ГЭЖ ЮУ ВЭ?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар. Формосагийн Тайбэй хотын Цаглашгүй гэрэлт бясалгалын төв.
1987 оны 3 дугаар сарын 5
(Эх нь хятад хэлээр)

Бид олон хүн Бурханыг харсан, Бодьсадваг харсан гэж ярихыг сонссон. Тийм амархан гэж үү? Миний бодлоор тийм биш. Гуан Чин хуврагийг амьд ахуй үед нэгэн номын багш: "Арьяабал бурханыг олж харлаа. Дүр төрх нь тун ч жавхлантай юм." гэжээ. Гуан Чин хувраг инээгээд: "Нээрээ юу? тийм хялбархан гэж үү?" хэмээв. Учир нь түүний бясалгалын түвшин маш өндөр болохоор Бурханыг харах, Бодьсадваг харах нь тийм хялбаргүйг мэднэ. Цэцэг дэлгэрвэл Бурханыг харна. Цэцэг дэлгэрэх нь билиг нээгдэхтэй адил. Өнөөдөр яаж билиг нээхийг ярина.

"Цэцэг дэлгэрвэл Бурханыг харж, үл төрөхийг ухаарна." гэж бид байнга ярьдаг. Цэцэг дэлгэрнэ гэж яахыг хэлж байгаа юм бэ? Цэцэг гэж юу вэ? Та нарт цэцэг байна уу? Цэцэг хаана байдгийг мэдэх үү? Чухам ямар цэцэг вэ? (*Цэцэг бол бидний сэтгэл гэж нэг хүн хариулав.*) Сэтгэл яаж дэлгэрэх вэ? Үнэн хэрэгтээ чиний зөв. Багш нь тоглосон юм. Чиний сэтгэл хаана байна? (*Орчлонгоор дүүрэн гэж нэг хүн хариулав.*) Чиний сэтгэл тийм том гэж үү? Би итгэхгүй байна. Бүх орчлонг дүүргэсэн тийм том цэцэг байх боломжгүй (*Бурхан багшийн сэтгэл бидний сэтгэлтэй адил гэж нэг нь хариулав.*). Адил байх боломжтой юу? (*Буддагийн сэтгэл хамаг амьтны сэтгэлтэй ижилхэн гэж хариулав.*) Буддагийн сэтгэл ижил ч чиний сэтгэл тиймгүй байна. Хэрэв ижил бол чи эмэгтэй хүнийг эрэгтэй хүнтэй адилаар харах болно. Одоо чамд адилхан санагдаж байна уу? (*Түүний мөн чанар, уг дүр нь адилхан гэж хариулав.*) Зүйтэй, гэвч чи олоогүй л явна. Тийм үү? (*Тийм гэж хариулав.*) Тэгвэл энэхүү цэцгийг хамтдаа хайж олъё.

Бидний бие олон цэцэгтэй. Доогуур байрлалтай цэцгийн талаар өчигдөр ярьсан болохоор одоо ярихгүй. Хүрд (чакра) болгон лянхуа цэцэгтэй адил. Тиймээс Шагжамуни Будда "Баатараа явагч их хөлгөн судар"-ыг тайлахдаа мянган дэлбээт лянхуа цэцэг дээр заларсан. Энэхүү мянган дэлбээт лянхуа цэцэг нэгдүгээр ертөнцөд байдаг. Бид бясалгал дадуулаад нэгдүгээр ертөнцийн хамгийн дээд дэсэд, өөрөөр хэлбэл нэгдүгээр ертөнцийн оргилд хүрвэл энэхүү мянган дэлбээт лянхуа цэцгийг харна. Гэвч би тэрхүү дотоодын ахуй ойлголтыг ярихгүй. Та нар өөрсдөө бясалгал хийж ойлгоорой. Гол нь бидний дотор олон лянхуа цэцэг байдгийг Багш нь та нарт хэлэх гэсэн юм. Энд (*Багш билгийн мэлмийгээ заав*.) ч бас лянхуа цэцэг бий. Энэхүү цэцгийг энгийн нүдээр бус билгийн мэлмийгээр л олж харна. Доогуурх хүрдний төвүүдэд бас лянхуа цэцэг бий. Гэвч өнөөдөр ярихгүй, дараа цаг завтай үедээ ярья.

Энэхүү (*Билгийн мэлмийгээ заав*.) лянхуа дотор муни сувд бий. Хэрэв цэцэг дэлгэрвэл дотор нь муни сувд, эсвэл Бурханы мэлмий, билгийн мэлмий буй. Энэ нь цэцэг дэлгэрэхтэй адил. Цэцэг дэлгэрнэ гэдэг нь билгийн мэлмий нээгдэх, эсвэл билиг нээгдэх гэсэн утгатай. Үүнийг эртний Их Багш нар үнэн бодитой үгээр дүрслэн үзүүлжээ. Одоо Багш нь цэцэг энд (*Билгийн мэлмий заав*.) дэлгэрнэ гэвэл та нар тэрхүү цэцгийг мэдэхгүй, бас хаана байгааг нь харахгүй. Гэвч би өөрийнхөө шавьд яривал тэд мэднэ. Учир нь тэдний зарим нь цэцгээ нэгэнт үзсэн, энд цэцэг яаж дэлгэрдгийг харсан.

Та нарыг Багшийнхаа үгэнд итгэсэн гэж бодъё. Энд байх лянхуа дэлгэрэхэд бид Бурханыг харна. Бурханыг харах нь Авид бурханы дүрийг харсан гэсэн үг биш. Мэдээж Түүний дүрийг, эсвэл Арьяабал бурханы дүрийг харсан байж магадгүй. Гэвч энэ нь мөн л хуурамч. Цэцэг дэлгэрвэл Бурханыг харна гэж ямар Бурханыг харахыг хэлж байна вэ? Өөрийн Бурхан чанараа, өөрийн мөн чанараа, өөрийн уг дүрээ олж харна. Иймээс цэцэг дэлгэрвэл Бурханыг харна гэжээ. Энэхүү Бурхан чанар ямархуу янзтай вэ? Та нарын хэн нь мэдэх вэ?

Бурханы шашинд "Ум ма ни бад ми хум" гэдэг шидэт тарни байдгийг та нар мэднэ. Тэр ямар утгатай вэ? Муни сувд лянхуа дотор буй гэдэг нь энэхүү тарнийн гол утга юм. Мани гэдэг нь муни сувд, бад ми гэдэг нь лянхуа цэцэг гэсэн үг. Иймээс Төвөдөд лянхуа цэцгээс мэндэлсэн Бадма Самбава Их Багш гэж байсан. Түүний нэр нь Padma Sambawa. Padma нь лянхуа цэцэг гэсэн үг. "Ум ма ни бад ми хум" гэдэг нь энэхүү муни сувд лянхуа цэцэгт

бий гэсэн утгатай.

“Ум ма ни бад ми хум” –ийг уншаад бидний онгод орохгүй. Харин энэхүү тарнийн гүн утгыг мэдэж авах хэрэгтэй. Эртний даяанч багш нар болон Их Багш нар энэ тарнийг уншиж байдаг нь эрдэнийн сувд лянхуа цэцэгт байдгийг мартаж болохгүйг, энэхүү бясалгалын аргаар өдөр бүр бясалгал, дадуулахыг эрдэнэсийн сувд байгаа энэхүү лянхуа цэцгийг бясалгах хэрэгтэйг шавь нартаа сануулахын төлөө юм. Тухайлбал, Багшийнх нь ярьсан зарим зүйлийг зөвхөн миний шавь нар л ойлгоно. Энд яривал та нар ойлгохгүй. Зарим үед би юу ч ярьдаггүй болохоор гарын дохиогоор тэд миний санааг даруй ойлгоно. Учир нь багш шавийн хооронд үггүй ойлголцох явдал их байдаг.

Ном уламжилсны дараа Багш нь тэдэнд тусгайлан заах зүйлгүй. Хэрэв тэдэнд ямар нэгэн асуудал гарвал гараараа дохиход даруй ойлгоод түүнийгээ шийдчихдэг. Юу ч ярих шаардлагагүй. Эсвэл зарим шавь асуудалтай бол Багш нь “Бурханд залбир” гэдэг. Та нар авшиг хараахан хүртээгүй болохоор Авид бурханыг уншуулах гэж байна гэж бодно. Тэгээд та нар Авид бурханыг уншаад байдаг. Үнэндээ миний санаа ийм биш, Бурханд залбирахыг шавь нартаа сануулсан. Тэд ямар Бурханд “яаж залбирах”-аа мэднэ. Амандаа уншдаггүй. Ингэх нь Бурханд жинхэнэ ёсоор залбирч буй биш. Иймээс заалгаагүй хүн ойлгохгүй байх нь аргагүй.

Үүний адилаар энэ тарнийг тун шидтэй гэж боддогоос “Ум ма ни бад ми хум” гэж амандаа уншдаг. Гэвч хэчнээн удаан уншсан ч ямар ч хариу мэдэрдэггүй. Сэтгэлээ төвлөрүүлэн уншвал хэзээ нэг өдөр бага сага хариу мэдрэгдэх ч энэ нь тарнийн ид шидээс бус, сэтгэлээ төвлөрүүлснээс болжээ. Их Багш нар эрт дээр үеэс энэхүү тарнийг уламжилж ирсэн нь шавь нартаа бясалгал дадуулахыг сануулахын төлөө юм. Яагаад нууц тарни гэсэн бэ? Учир нь шавь нар нь л ойлгохоос гаднын хүн ойлгохгүй тул нууц тарни болжээ.

Жишээлбэл, Багш нь “Бурханд залбир” гэвэл энэ нь миний шавь нарын хувьд нууц тарни юм. Жишээ нь, Багшийнх нь шавь асуудалтай тулгараад өөрийн биеэр ирж уулзаж чадахгүй бол бусад авшигтнууд ирж, Багшид нь энэ тухай хэлнэ. Тэгэхэд нь би: “Хариад Бурханд залбир гэж түүнд дамжуулаарай. Энэ бол тун сайн нууц арга.” гэнэ. Тэр хариад найздаа Бурханд залбирахыг, манай бясалгалын аргаар бясалгал хийхийг сануулна. Эсвэл сэтгэлээ төвд тавь гэвэл тэд даруй ойлгоно.

Харин гаднын хүнд “Сэтгэлээ төвд тавь.” гэвэл утгыг нь

ойлгохгүй. Төв нь хаана байна? Сэтгэл хаана байна? Яагаад сэтгэлээ төвд тавих хэрэгтэй зэргийг ойлгохгүй. Энэ нь бидэнд тустай байдаг болохоор нууц тарни юм. Энэ тарнийг цаг үргэлж санаж явбал бясалгал дадалдаа хурдан дэвшинэ. Түүнээс биш "Сэтгэлээ төвд тавь." гэж байнга давтаад бай гэсэн үг биш. Ингэлээ гээд нууц тарни болохгүй. Харин түүний утгыг ойлгож, марталгүй санаж байгаа нь уг тарнийг уншиж буй хэрэг юм.

Эртний даяанч багш нар ийм зорилгоор шавь нартаа "Ум ма ни бад ми хум" тарнийг заасан байх. Энэ нь багшаас шавьд өгч буй хялбар заавар, хоорондоо ойлголцох нууц үг юм. Шавьд ямар нэгэн асуудал гарч, бясалгалаа сайн хийж чадахгүй, яаж бясалгахаа мартах, бясалгах үед сэтгэл нь ихэд сарнивал түүгээр "Ум ма ни бад ми хум"-г уншуулж сэтгэлээ эрдэнийн сувд байгаа лянхуа цэцэгт тавивал сувдыг олно гэж заадаг. Энэ нь багшийнхаа аргаар бясалгал хийгээрэй, энэхүү лянхуа цэцэгтээ эрдэнийн сувдтай бясалгалын аргаар дадуулаарай гэж шавьдаа сануулж буй хэрэг юм.

Гэвч цаад утгыг нь ойлгохгүйгээр өдөржингөө ум ма ни бад ми хум гэж уншвал ямар ч ашиггүй, тус нэмэргүйг би батална. Хэчнээн ч тамга дарсан болно. Учир нь энэхүү маш далд, гүн нууцлаг номыг ойлгоогүй, эртний Их Багш нарын номлол сургаалын гүн утгыг ухаараагүйгээс бясалгал дадуулж чадахгүй байна. Жишээ нь, долоо хоногийн даяаны үеэр олон хүн хамтдаа бясалгахад хэн нь ямар асуудалтайг Багш нь мэддэг. Би очоод: "Бурханд залбир, ойлгов уу?" гэвэл тэрээр даруй Бурханыг дурсан залбирна. Учир нь түүний сэтгэл сарниад байгааг мэдсэн учраас Бурханд залбируулсан. Нөгөө хүнд: "Сэтгэлээ төвд тавь." гэнэ. Өөр нэгэнд нь юу ч хэлэлгүй ингэж (*Багш таван хуруугаа дэлгэ*в.) харуулна. Ингэснээр Багш нь өөр бясалгалын арга зааж буй хэрэг бус. Энэ хүнд Бурханд залбир, тэр хүнд сэтгэлээ төвд байлга, энэ хүнд ингэхийг, тэр хүнд тэгэхийг зааж байгаа ч үнэндээ бүгд нэг л бясалгалын арга.

Тэр үед тэд өөр өөр асуудалтай байсан учраас иймэрхүү маягаар хэлж өгөхөд даруй ач тусаа өгч, бясалгахыг, сэтгэлээ төвлөрүүлэхийг тэдэнд сануулжээ. Багш нь өөр бясалгалын аргыг заасан юм биш, харин тухайн үед тэдэнд тохирсон өөр өөр заавар хэрэгтэй байсан. Хэрэв тэр үед Багшийг нь дагадаггүй гаднын хүмүүс хамт бясалгал хийж байсан бол тэд хамраа ажиж, наран сүлжээгээ ажих, амьсгалаа ажих зэргээр өөрсдийн бясалгалын аргаараа бясалгаж, Багшийнх нь юу гэж байгааг ойлгохгүй. Энэ хүний толгойг тогшиж, энэ хүнийг ингэж суу гэж,

тэр хүнийг сэтгэлээ төвдөө тавь гэхийг хараад Багш яагаад ийм эмх замбараагүй юм заагаад байна вэ? гэж бодох болно. Тийм биш. Тэд ойлгоогүй тул Багшийнх нь юу хийж байгааг мэдээж мэдэхгүй.

Үүнтэй адил билгээ нээе гэвэл бясалгалын арга байх хэрэгтэй. Хар таамгаар бясалгал дадуулж болохгүй. Юу бясалгамаар санагдана түүнийгээ бясалгавал билиг нээгдэнэ гэж боддог. Хэрэв гэгээрэх гэж юу болохыг мэдэхгүй бол бясалгаад ч ойлгохгүй, билиг нээгдсэн эсэхээ ч мэдэхгүй. Иймээс одоо Багш нь билиг нээгдэх гэж юу болох талаар яръя.

Гэгээрэх гэдэг нь ямар утгатай вэ? Гэгээрэх гэдэг нь "Ухаарч ойлгох" гэсэн үг бөгөөд хятад ханз үсгээр бол нар (rì) болон сар (yuè) гэсэн хоёр дүрсээс бүрдэнэ. Хятад ханз үсэг их ойлгомжтой. Миний бодлоор эртний хятад хүмүүс сүнслэг дадал бясалгалын түвшин өндөр байсан учраас тэдний бичсэн ямар ч ханз үсэг тун ойлгомжтой байдаг. Жишээ нь, "Ухаарч ойлгох" гэдэг ханзанд нар сарны дүрс бий. Энэ нь юуг харуулж байна вэ? Гэрэл гэгээтэй гэсэн санаа юм. Билиг нээгдэх үед дотоодод нэг зүйлийг ухаарч ойлгодог. Гэгээрэх нь "Ухаарч ойлгох"-ыг илэрхийлэх тул нар, сар байх ёстой. Иймээс гэгээрсэн хүн нар, сарыг хардаг. Та нарын дунд даяан бясалгадаг хүн байвал энэ талаар мэднэ. Зарим үед номын багш даяаны танхимд бэрээгээ бариад нааш цааш алхахдаа: "нар хаана байна?" гэж асууна. Нарыг яаж олохыг чамд хэлэхгүй харин өөрөө эрж ол гэдэг. Энэ нь үнэхээр төвөгтэй.

"Одоо өвлийн цаг тул өнөөдөр наргүй байна." гэвэл тэр чамайг бэрээгээрээ цохино. "Нар баруунтаа бий." гэвэл буруу гэнэ. Хэрэв цаг эрт, нар дөнгөж гарч байна гэж бодоод: "Нар дорно зүгт бий." гэвэл тэр бас цохино. Юу ч гэж хариулсан буруутна. Нар хаана байна? Хэн мэдэх вэ? Энд даяан бясалгадаг хүн байна уу? Нарыг ингэж хайх нь бага даяан болно. Жинхэнэ ёсоор бясалгал дадуулаад билиг нээгдэхэд нар, сарыг хардаг. Би зах зухаас нь дурдаж буй төдий. Та нарт хэт ихийг хэлж өгч болохгүй.

Гадаа байгаа нарыг харчихаад билиг нээгдлээ гэж болохгүй. Нээгдээгүй. Ингэх нь ертөнцийг ухаарснаас билиг нээгдсэн хэрэг биш. Билиг нээгдэх нь ойлгох, ухаарах гэсэн утгатай. "Ухаарч ойлгох" гэдэг ханз үсэгт нар, сарны гэрэл байдаг. Миний бодоход эртний хятад хүмүүсийн бясалгал дадал тун сайн тул наад зах нь нар, сарыг хардаг. Тэгээд билгээ нээсэн гэж үзээд үүнийгээ "Ухаарч ойлгох" гэсэн ханзаар илэрхийлжээ. Нар, сарны гэрлийг харсан ч тэд гурван ертөнцийн дотор оршсон хэвээр. Энэ бол

гурван ертөнцийн доторх дэс юм. Гурван ертөнцийн гаднах байдлын талаар зөвхөн ном уламжлах үед л ярина.

Иймээс "Гэгээрэх" гэдэг нь гэрэл харж, гэрэлтэй харилцан холбогдсоныг илтгэнэ. Тэгвэл эртний хүмүүс билиг нээгдэхэд гэрэл хардаг байсан уу? Хардаг байсан. Иймээс Багш нь билиг нээгдэх нь ухаарч ойлгох гэсэн утгатай гэж сая ярьсан. Учир нь тэд билиг нээгдэх үед гэрэл хардаг. Бурханы гэрлийг харна, өөрийн гэрлийг харна. Энэ нь бидний Бурхан чанар юм. Бурханд чанар нь эгэл хүний чанартай адилгүй бөгөөд хэлбэр дүрс үгүй, барьж, хүрч, үнэртэж мэдрэгдэхгүй. Энэ гэрэл нь тун ариун, маш тунгалаг. Энэхүү гэрэлд бүх юм, бүх билиг ухаан байдаг. Орчлонгийн түмэн бодис энэхүү гэрлээс үүсэлтэй.

Нэлээд нам давтамжтай гэрэл нь аялгуу болно. Аялгуу гэдэг нь ярилцах дуу чимээ биш, харин хөгжимтэй төстэй хөг аялгуу юм. Гэвч тун аядуу зөөлөн. Энэ аялгууг сонсвол бидний сэтгэл амарлиж, билиг ухаан нээгдэн хувийн чанар өөрчлөгдөнө. Дэлхий ертөнц бидний хувьд зовлон багатай, бид баяр баясгалантай болж, орчлонгийн түмэн бодисыг илүү их ойлгоно. Ном судрыг ч ойлгож өөрийгөө илүү их таних тусам бусад төрөлтнийг сайн ойлгодог болно.

Иймээс бид гэрэлтэй нэвтрэлцэн, гэрлийг харах үедээ Бурханыг Бурхан чанараа харна. Учир нь Бурхан дүрс үгүй. Бурхан энэ ертөнцөд хүний биеэр заларсан нь дүр төрхөө харуулахын төлөө бус, харин хамаг амьтдыг гэтэлгэхийн төлөө юм. Хэрэв бид аль нэг түвшинд очоод тэндхийн нөхцөл байдлыг харахад энэ нь Бурханы жинхэнэ орон байсан ч мөн л жинхэнэ биш байдаг. Энэ бол хоёрдох хувилсан дүр. Анхных нь хамгийн дээд дүр. Туйлын үнэн бол дүрс үгүй. Бодол үүсмэгц дуутай, дүрстэй болж хувирдаг. Эгэл хүн хамгийн дээд түвшинд хүртлээ энэхүү дуу, дүрснээс хэтийдэх аргагүй тул ийм дэс байх ёстой. Гэвч энэ нь материаллаг дуу, дүрс биш, харин дотоодын, маш нарийн, дээд түвшний энгийн хүний чихэнд сонсогдож, нүдэнд үзэгддэггүй жинхэнэ дуу, дүрс юм. Хэдийгээр тийм нарийн түвшнийх ч хамгийн төгс нь биш. Гэвч байшингийн шатыг нэг нэгээр өгсдөг шиг, алгуур аажим дээшлэхгүй бол эгэл хүнээс нэг л үсрээд ханьцашгүй үнэхээр туулсан болж чадахгүй. Иймээс энэхүү дотоодын гэрэл, дотоодын аядуу зөөлөн аялгуу нь бидний дээшээ мацах шат мөн.

"Баатараа явагч их хөлгөн сударт" ч "Аялгууны урсгал"-ын тухай дурдсан байдаг. Шагжамуни Будда: "Бурхад энэхүү аялгууны урсгалаар буун ирж, хамаг амьтдыг гэтэлгэдэг. Бодьсадва болон

хамаг амьтан энэхүү аялгууны урсгалыг түшиглэн дээшилж Бурхан болно.” гэжээ. Та нар уншсан уу? Богинохон өгүүлбэр болохоор уншсан ч анхаараагүй байж магадгүй. “Аялгууны урсгал” бол энэхүү аялгууны зам юм. Будда тун тодорхой хэлсэн ч, эгэл хүн ахуй ойлголтгүй тул уншаад ойлгохгүй. Жишээ нь, нисэх онгоц хараагүй хүнд онгоцны нэрийг хэлсэн ч түүнийг төсөөлж чадахгүй.

“Баатараа явагч их хөлгөн сударˮ-т хорин таван Бодьсадвагийн дадал бясалгалын ахуй ойлголтыг дурдсан байдаг. Гэгээрэх үедээ бүгд гэрэл харжээ. Хэдийгээр харсан гэрэл нь адилгүй ч, бүгд гэрэл харсан тул билиг нь нээгдсэн гэж хэлж болно. Тэдний зарим нь бас аялгуу сонсжээ. Тухайлбал, аянгын дуу, хэнгэргийн дуу, хонхны дуу, далайн түрлэгийн чимээ, эсэрваагийн эгшиг гэх мэт. Эдгээр нь бүгд тэдний билиг нээгдэх үеийн ахуй ойлголт болно. Гэрэл харж, аялгуу сонсохоос бусад байдлыг гэгээрсэн гэхгүй. Хэн нэгний элдэв янзаар сонин жигтэй хөдлөх, янз бүрийн гарын чагж хийх зэрэг нь гэгээрсэн хэрэг биш. Иймэрхүү байдлаар гэгээрдэг гэж аль ч ном сударт бичсэнийг би олж уншаагүй.

Католик шашны Библид мөн гэрлийн талаар дурджээ. “Эзэн Бурханыг харах үед Тэр гэрэлтэй адил, асар том гал мэт байсан. Түүний дуу нь аянгын дуу мэт, их далайн чимээ шиг байсан.” гэжээ. Энэ нь манай Бурханы шашны ном судруудад бичсэнтэй ойролцоо, билиг нээгдэх үеийн ахуй ойлголт нь бүгд адил байна. Энэтхэгийн шашны ном сударт ч мөн ахуй ойлголтын талаар бичжээ. Гэгээрэх үед гэрэл харж, аялгууг сонссоноо дурдсанаас бус, элдэв хөдөлгөөн, янз бүрийн гарын чагж байсныг дурдаагүй. Ингэх нь гэгээрсэн хэрэг огт биш.

Багшийнх нь үзсэн бүхий л ном сударт ингэж өгүүлсэн учраас үнэн бодитойгоор та нарт ярьж өгч байна. Түүнээс биш ахуй ойлголтоо яриагүй. Гэвч миний ахуй ойлголт ном сударт бичсэнтэй мөн л адил байдаг. Иймд өөрийн ахуй ойлголтыг ном судрынхтай нэгтгээд: “Гэрэл харна гэдэг нь Бурхан чанараа харна гэсэн үг. Гэхдээ бага зэрэг харна.” гэж дүгнэсэн. Гэрлийн дотор зөвхөн гэрэл биш, олон түвшин, олон билиг ухаан, өөр бусад зүйлс байдаг. Гэвч гэгээрэх үед эхлээд энэхүү гэрэлтэй нэвтрэлцдэг. Иймээс гэрэл харвал сая гэгээрдэг.

Гэгээрэх нь ухаарч ойлгох гэсэн үг. Гэрэл байвал ухаарч ойлгоно. Харанхуй бол яаж ухаарах вэ? Харанхуй бол орчлонгийн түмэн бодисыг яаж харах вэ? Бид хэдийнээ хангалттай мунхаг харанхуй. Эгэл хүн сайндаа л ойр орчмоо харж, сонсож чадна.

Орчлонгийн түмэн бодисыг харах, өндөр дэсийн чанагуух ертөнцийн аялгууг сонсох цаглашгүй, хэмжээлшгүй чадваргүй.

Билиг нээгдээгүй үед сонссон дуу чимээний хэлбэлзлийн давтамж өндөр бол эгэл хүний сонсголын эрхтнийг гэмтээнэ.

Дууны хэлбэлзлийн давтамж хэт өндөр бол бидний чих тэсвэрлэхгүй гэж эрдэмтэд үздэг. Үүнтэй адил гэрэл хэт хурц бол эгэл хүний нүдийг гэмтээнэ. Гэвч билиг нээгдэх үед тэр их гэрлийг бид хүлээн авч чадна. Тэрхүү өндөр давтамжтай аялгууг бас сонсож чадна. Чих гэмтэхгүй. “Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”-т үүнийг жинхэнэ ёсоор билиг нээгдсэн гэнэ хэмээн тодорхой өгүүлжээ.

Гэвч гэрэл нэлээд олон төрөл, олон дэстэй. Гэрэл харвал хангалттай гэсэн үг биш. Асурийн орон ч гэрэлтэй болохоор зарим нь тэндхийн гэрэл байдаг. Тиймээс асурийн гэрэл харахыг гэгээрлээ гэхгүй. Зарим хүн гэгээрэх үедээ асурийн гэрэл хардаг ч асурийн түвшнийг хардаггүй. Ийм гэрэл харсан нь түүний дэс асурийн түвшинд хүрснийг илтгэнэ. Хэрэв тэр хэсэг хугацаанд бясалгал дадлыг үргэлжлүүлбэл энэхүү дэсийг давж болно. Асури нь зөвхөн нэгдүгээр ертөнц бөгөөд үүнийг давбал хоёрдугаар ертөнцөд, түүнчлэн гурав, дөрөв, тавдугаар ертөнцөд хүрч болно.

Бурханы гэрэл угаас сүүдэргүй. Жишээ нь чийдэнгийн гэрэл дор зогсвол сүүдэртэй. Нар, сарны гэрэлд зогсвол бас л сүүдэртэй. Гэвч бид Бурханы гэрлийг харахад сүүдэр байдаггүй. Иймээс “Бурханы гэрэл сүүдэргүй.” гэдэг. Бясалгал хийдэг олон хүн энэ талаар маргалдаж, энэхүү өгүүлбэрийг хэлэлцэх дуртай. Учир нь өөрсдөө ахуй ойлголтгүй болохоор Бурханы гэрэл сүүдэргүй гэдэг нь ямар утгатайг мэддэггүй. Билиг нээгдвэл тэр даруйдаа мэдэх болохоор тэгтэл их ярьсны хэрэггүй. Ном судруудыг ч бүгдийг нь шатааж болно. Ямар ч ашиггүй.

Тэд гэгээрээгүй байж өдөр бүр “Бурханы гэрэл сүүдэргүй.”, “аяга нь аяга биш” гэдэг ямар утгатай талаар маргалдана. Ам нээх бүртээ “Дүрстэй нь хоосонтой адил, хоосон нь дүрстэй адил.” гэнэ. Дүрстэй нь хоосонтой адил, хоосон нь дүрстэй адил гэх атлаа хүн цохивол уурлаад сүйд болно. Дүрстэй нь хоосонтой адил юм чинь яаж өвдөх билээ? Ном судраа ч ойлгоогүй байж, бас хүнтэй маргалдах дуртай. Бид сонсоод л гэгээрээгүйг нь даруй мэднэ. Гэгээрсэн хүн маргалдах дургүй байдаг. Маргалдах нь хамгийн залхмаар хамгийн ядаргаатай явдал.

Өнөөдөр Багш нь ном тайлж байгаа нь гэрээс гарсан миний үүрэг. Шавь нар маань ууланд очиж, ирж ном тайлахыг Багшаасаа

уйлан гуйсан болохоор аргагүйн эрхэнд ирсэн. Угаасаа ном тайлъя гэж огт бодоогүй. Юу ярих билээ? Юу яривал өөрийн дотоодын түвшнийг ойлгуулж чадах вэ? Заан хараагүй бол заан гэж юу байдгийг ойлгохгүй. Нисэх онгоц үзээгүй хүнд яаж тайлбарлавал ойлгуулах вэ?

Иймээс тун хязгаарлагдмал хүний хэлээр та нарт хэр ихийг хүргэж чадах билээ? Ярья гэсэн ч яримааргүй санагддаг байтал цаг заваа үрж, хүмүүстэй маргалдаж яаж болох вэ? Иймээс маргалдах дуртай хүмүүсийн дэсийг та нар даруй мэднэ. Доогуур түвшний хүн хамгийн их маргалддаг. “Дүрстэй нь хоосонтой адил, хоосон нь дүрстэй адил.” гэдэг нь ямар утгатай талаар хоорондоо баахан маргалдаад өөр өөрсдийгөө зөв гэж царайгаа минчийлгэн зүтгэнэ. Эцэстээ дайснууд болдог нь билиг нээгдээгүйгээс болсон хэрэг.

Гэгээрмэгц “Бурханы гэрэл сүүдэргүй.”, “Дүрстэй нь хоосонтой адил.” гэдгийн утгыг даруй мэднэ. Маргалдаад хэрэггүй, тэгээд ч яримаар санагдахгүй. Учир нь ярьсан ч хүмүүс ойлгохгүй тул яримаар юм тун бага. Гэгээрэх тусам улам ярих дургүй болно. Өнөөдөр их ядарсан учраас ууланд гарч унтвал ямар сайхан бэ? гэж бодлоо. Яагаад надаар ном тайлуулж байгаа юм бэ? гэж би тэдэнд (*Шавь нараа заав*.) гомдоллоо. Яг юу ярих вэ? Хэлсэн амандаа хүрэх хэрэгтэй. Тэр өдөр шавь нарынхаа их чин сэтгэлтэйг хараад Багш нь долоо хоног ном тайлъя хэмээн нэгэнт зөвшөөрсөн тул хэлсэн үгнээсээ буцах аргагүй.

Зарим үед Багш нь баярласандаа даруй зөвшөөрдөг. Дараа нь харамсана. Пэнхүд очсондоо харамсана. Хаа ч очсон их ядардаг. Юм ярих дургүй, юу ярих вэ? Гэвч нэгэнт зөвшөөрсөн болохоор очихгүй бол болохгүй. Зөвшөөрчихөөд харамсаж эхэлнэ. Гэвч мартаад эргээд л зөвшөөрнө. Ном тайлах бүртээ дахиж тайлахгүй гэдэг ч тэд “Багш аа, багш аа.” гээд гуйхад нь бас л мартаад, тэр даруйдаа: “За! Би очъё, очъё.” гэдэг. Очоод хэсэг хугацаа өнгөрөхөд ууланд очиж унтвал хамгийн сайхан даа гэж бодно.

Гэрэл их олон төрөл гэж би саяхан ярьсан. Ертөнц бүрд өөрийн гэсэн онцгой гэрэл, онцгой өнгө, онцгой шинж бий. Хэрэв Их Багш ном уламжлахгүй, замчлахгүй бол бид гэрэл харах үед дэсээ мэдэж чадахгүй. Энэ нь өндөр дээд түвшин үү, эсвэл доогуур түвшин үү гэдгийг ялгахгүй. Жишээ нь, бид нэг, хоёрдугаар ертөнцийн гэрлийг харах нь тийм ч сүрхий зүйл биш. Эсвэл бид санаандгүй ямар нэгэн аялгуу, жишээ нь: аянгын дуу, хэнгэргийн дуу, хонхны дуу, далайн түрлэгийн чимээ, арслангийн архираа гэх мэтийг сонсдог. Эдгээрийг Бурханы шашны ном судруудад дурдсан байдаг бөгөөд онцын ашиг тусгүй.

Библийн сударт: “Эзэн Бурханыг харах үед дуу нь аянгын дуу мэт, нүд нь их галтай адил.” гэжээ. Энэ нь үлэмж их гэрэлтэй гэсэн утгатай. Гэвч хэлний ялгаанаас болж илэрхийлэх арга нь заримдаа адилгүй байдаг. Иймээс гэрэл харах, эсвэл аялгуу сонсох нь билиг нээгдсэн гэсэн үг. Католик шашинд хэлдгээр Эзэн Бурханыг харна. Харин манай Бурханы шашинд бол цэцэг дэлгэрвэл Буддаг харна гэх бөгөөд Будда гэдэг нь Бурхан чанарыг заана. Хэрэв чи Төгс Гэгээрсэн Их Багшаар ном уламжлуулалгүйгээр Багшийнх нь саяын ярьсан тэдгээр дууг, тухайлбал аянгын дуу, хэнгэргийн дуу, далайн түрлэгийн чимээ, арслангийн архираг сонсоод: “Тун сайн. Би гэгээрчихлээ!” гэж бодож магадгүй. Гэтэл маргааш нь нөгөө аялгуу алга болсон байна. Учир нь санамсаргүй гэгээрсэн аж.

Манай Ау Лакт “Нохой эвшээнгүүт ялаа орох.” гэдэг хэлц үг бий. Үүгээр санамсаргүй тохиолдлыг илэрхийлнэ. Гэнэт аялгуу сонсох буюу эсвэл бага сага гэрэл хараад гэгээрчихлээ гэж үздэг. Үгүй, үгүй! За яах вэ, билиг нээгдсэн гэе. Энэхүү хормын төдий ухаарал нь ямар ч хэрэггүй. Хангалтгүй. Жишээ нь, үнээний сүүг ганц халбагадаад л юу болохыг нь, ямархуу амттайг нь мэдэж болно. Энэ нь сүү огт ууж үзээгүй хүмүүсийг бодвол хамаагүй дээр, ядаж л сүү гэж юу болохыг мэднэ. Ганц халбага сүүнээс хангалттай шим тэжээл авах уу? Хүүхдэд өдөрт ганц халбага сүү өгөөд хоёр гурван өдөр өгөхгүй өнжвөл тэр амьдарч чадах уу? Мэдээж чадахгүй.

Үүний нэгэн адил бид билгээ тасралтгүй нээх хэрэгтэй. Нээн нээсээр хэзээ ч хаагдахгүй болохыг билиг нээгдлээ гэж хэлж болно. Аялгууг нэг л сонсчихвол үүрд сонсдог болно. Ийм болбол билиг нээгдлээ гэж болно. Манай авшигтнуудаас гадна та нарын дунд тэр байдлыг биеэрээ мэдэрсэн хүн байна уу? Байхгүй ээ? Тэгвэл хараахан гэгээрээгүй байна гэсэн үг. Гэнэт санаандгүй гэрэл харах, бодьсадваг харах, аялгуу сонсох нь юу ч биш, бүгд хий хоосон зүйл. Энэ нь сохор муурт үхсэн хулгана тааралдсан явдал болохоос хичээн зүтгэж олж авсан юм биш. Хулгана хаана байгааг мэдэхгүй мөртөө санамсаргүй тохиолдлоор барьжээ.

Билиг нь үнэхээр гэгээрсэн хүн өдөр бүр хулгана барьж болно. Хэдийг ч барьсан болно. Үүнийг л гэгээрэх гэнэ. Энэ нь ч гэсэн тийм том юм биш. Жишээ нь, өдөр бүр аянгын дуу, далайн түрлэгийн чимээг сонсох нь сүртэй зүйл биш. Эдгээр нь гурван ертөнцийн доторх тун доогуур дэсийн аялгуу бөгөөд гурван ертөнцийн гадна бүү хэл гуравдугаар ертөнцөд ч хүрээгүй байдаг. Гурван ертөнцийн гадна өөр аялгуу, өөр гэрэл, өөр түвшин бий.

Хэрэв бясалгалын аргагүй, багшгүй бол бид мэдэхгүй. Зөвхөн ном судар үзэх нь хангалтгүй. Яагаад хангалтгүй гэж? Учир нь ном сударт дурдсан нь эртний хүмүүсийн дөнгөж бясалгал хийж эхлэх үеийн ахуй ойлголтууд. Жишээ нь, Шагжамуни Буддагийн ном уламжилсан тав, зургаа, эсвэл зуун хүн тухайн үед өөрсдийн ахуй ойлголтоо бичиж үлдээжээ. Ном уламжлах үед тэд юу харсан, юу сонссоноо бичсэн нь ном судар болсон. Тэр нь дээр үеийн хүмүүсийн ахуй ойлголт болохоор уншаад нэмэргүй. Бүгд л доогуур түвшний ахуй ойлголт төдий. Тэд Шагжамуни Буддаг дөнгөж дагаж эхэлж байсан тул тэрхүү ахуй ойлголтыг ном уламжлах үед тэмдэглэжээ. Учир нь ном уламжлах үед билиг нээгддэг болохоор "Агшин зуур гэгээрэх" гэдэг. Энэ үед билиг тэр даруй нээгдэнэ. Билиг нээгдэх даруйдаа харсан, үзсэн бүхнээ бичсэн тул дээд зэргийн ахуй ойлголт биш.

Дээд түвшинд очиход замчлагч хэрэгтэй. Багш биднийг дагуулж аваачих, эсвэл дээд түвшинд ямар зүйлс байдгийг бидэнд хэлж өгвөл, хожим нь бид бясалгал дадуулах үедээ харьцуулан үзэж болно. Үнэндээ харьцуулан үзэхгүй байсан ч мэдэж болно. Гуравдугаар ертөнц, эсвэл гурван ертөнцийн гадна хүрвэл бид дороо мэднэ. Билиг нээгдэх бол билиг нээгдэх, жигнэмэг идэх бол жигнэмэг идэх, өчүүхэн ч эргэлзээ байхгүй. Гурван ертөнцийн гадна хүрэхэд бүхий л оюун санаа хувирч, билиг ухаан ч өөрчлөгдөн бүгдийг ойлгоно. Их билиг жинхэнэ ёсоор нээгдсэн нь огтхон ч эргэлзээгүй. Энэ үед даруй Буцашгүй Бодьсадва буюу Найман газрын Бодьсадва болно. Түүний сэтгэл үүрд буцашгүй, үүрд эргэлзээгүй машид тодорхой болдог.

Өнөөгийн Хятадад нэгэн Их Багш бий гэж сонссон. Зөвхөн сонссон л төдий. Гэгээрэх үедээ тэрээр хананы цаана хүн морь харахыг олж харжээ. Энэ юу гэсэн үг болохыг та нар мэдэх үү? Үнэндээ бас билиг нь нээгдсэн хэрэг. Тэр яагаад үүнийг харсныг та нар мэдэх үү? Яагаад хана халхалж байхад бусад хуврагийн хананы цаана юу хийж байгааг олж харсан бэ? Энэ нь ямар учиртай вэ? (*Нүд нь нээгдсэн гэж нэг хүн хариулав*). Ямар нүд нь нээгдсэн бэ? (*Тэнгэрийн нүд нь нээгдсэн гэж нэг нь хариулав*.) Тэнгэрийн нүд нээгдэх нь билиг нээгдэх биш, харин ид шид юм.

Энд сууж буй махан биеэс гадна бидэнд өөр нэгэн бие бий. Тэрхүү бие нүд, чих, хамар, ам, бие махбодыг хэрэглэхгүй ч бүгдийг мэднэ. Энэ бол бидний сүнсэн бие юм. Сүнсэн бие энэхүү махан биеийг орхиод олон газраар зугаалж болно. Гадагшаа гарч бусад хүмүүсийн юу хийж буйг харна. Бас өөрийн биеэ харна. Энэ нь бидний үхэх үеийн төлөв байдалтай төстэй.

Энэ нь билиг багаар нээгдэж, хоёрдугаар бие гарч явсныг харуулж байгаа болохоос ихээр гэгээрсэн гэсэн хэрэг биш. Жинхэнэ гэгээрэх үед энэ ертөнцийн байдлыг харах төдийгүй дээд түвшний гэрэл, аялгуу болон үзэмж байдлыг хардаг. Ингэвэл жинхэнэ билиг нээгдсэн гэсэн үг. Сүнсэн биеэр аялахад сүнс гардаг тул үүнийг Astral Projection гэх бөгөөд билиг нээгдэхээс огт өөр.

Билиг нээгдэх үед гэрэл хардаг, харин энэ нөхцөлд зөвхөн сүнс гарч явна. Үнэндээ сүнс гарсан биш, тэр бол өөр зүйл. Бидэнд олон бие бий. Энэ нэг нь (*Биеэ заав.*) байна. Дотор нь нэлээд нарийн бие, түүний дотор дахиад нэг нарийн бие бий. Дотор нь бас түүнээс нарийн бие, дахиад дотор нь түүнээс нарийн бие гэхчлэн хамгийн сүүлд, бүр дотор нь хамгийн нарийн бие бий. Тэр нь бие махбод биш бидний Угийн дүр, сүнс болно. Тэрээр маш олон биес дотор хоригдон хашигджээ.

Хэрвээ хамгийн гадна талын биеэ (*Биеэ заав.*) энд орхиод бусад биеэ авч гадуур зугаалбал, энэ үед бидний сүнс буюу хамгийн дотор талын бие нь бусад биес дотор хоригдсон хэвээр байх болно. Иймээс энэ нь билиг нээгдсэн бус. Зөвхөн бага сага эрх чөлөөтэй болж махан биеийг орхин явж буй хэрэг. Гэтэл их бясалгалтан бүх биесээ орхин чөлөөтэй явж чаддаг. Бидний жинхэнэ эзэн бусад биесээ үлдээгээд эрх дурааараа салан явбал тэр л жинхэнэ гэгээрсэн хэрэг болно.

Энэхүү хамгийн дотор талын биеийг бидний эзэн буюу Уг дүр гэж болно. Хэрэв сүнс маань бидний биеэс бүрмөсөн салалгүй, жаахан тасарч бага зэрэг өндөрт гарсан бол жишээ нь, эндээс тэнд хүрсэн бол бидний сүнсэн бие бусад биес дотроо хоригдсон хэвээр байдаг. Хэрэв сүнс маань жаахан дээшлээд тал нь дотроо, тал нь гаднаа байх үед бусад түвшнийг харна. Жишээ нь, бид нэгдүгээр дэсэд хүрвэл нэгдүгээр түвшний гэрлийг харна, хэрэв дахиад дээшилбэл хоёрдугаар дэсийн гэрлийг харна.

Гэвч ертөнцийг орхин үүрд туулан гэтэлсний дараа буцаад ирж болно. Урьдынхтайгаа адил дахиад явчихаж болно. Явбал явна, ирвэл ирнэ. Тэр үед даруй “Түүнчлэн ирсэн” болно, учир нь ирэх ч үгүй бас очих ч үгүй. Нэн өндөр түвшнээс энэхүү бие махбод болон зургаан мэдрэхүйг удирдан аливаа юмсыг үйлдэнэ. Тэр түүнчлэн ирээд түүнчлэн одно. Тэр орчлон ертөнцийг бүгдийг харж чадна. Бүх ертөнцийн ямар ч газрыг мэднэ.

Иймээс бид тийм хүнд залбирвал тэрээр даруй мэддэг. Учир нь тэр энэхүү жижигхэн байшин дотор бус, орой дээр нь байдаг. Хэрэв бид уулын оройд гарвал Тайбэйг бүхлээр нь харна. Бид

нисэж буй онгоцноос ямар ч байшинг харж чадна. Зарим хүн дуран ашигладаг тул далайн шуурга тохиолдлоо гэхэд тугаараа даллавал онгоцтой хүмүүс олж хараад, даруй ирж олсоо буулган биднийг татаж авна.

Түүнчлэн ирэгчийн түвшин ч бас адил. Тэр энд ирэхгүй ч бүхнийг мэднэ. Тэрээр очихгүй ч ямар нэгэн юмаар биднийг татан гаргана. Учир нь Тэр түүнчлэн ирээд түүнчлэн одно. Тэр хамгийн дээд түвшинд байгаа учраас хаанаас ч бүхнийг харна, бүхнийг сонсоно. Энэ бол Арьяабал бурханы түвшин мөн. Та хаанаас ч залбирсан Арьяабал бурхан бүгдийг мэднэ. Хэрэв Арьяабал бурхан ганц байдаг бол бүх ертөнцөөрөө түүнд залбирвал ядарч үхнэ. Тэр яаж тийм хурдан гүйж чадах вэ? Чадахгүй. Гэвч Тэр түүнчлэн ирсэн болохоор очихгүй ч сонсоно, очихгүй ч харна. Энэ бол түүнчлэн ирэгчийн түвшин юм.

Түүнчлэн ирэгчийн түвшин бол сүнс хэдийнээ гэтэлчихсэн, эзэн нь хэдийнээ хамгийн дээд түвшинд очсоныг хэлнэ. Энэ нь яг л үйлдвэрийн эзэн нь ажил дээрээ байхгүйтэй адил. Тэр хэдийгээр байхгүй ч ажлын байр, ажилчид, нарийн бичгийн дарга нь бүгд байгаа. Ганцхан эзэн л байхгүй. Эзэн нь өөр газарт байгаа ч ялгаагүй утасдаад л ажилтнууддаа хэрхэн ажиллахыг зааварлана. Энэ байдал нь автомат машинтай адил. Эзэн нь хэдийгээр байхгүй ч машин ажилладгаараа ажиллана. Энэ бол түүнчлэн ирсэн мөн.

Харин эндээс гараад орчин тойрноо харахыг түүнчлэн ирсэн гэхгүй. Энэ бол аялал хийж буй хэрэг. Харин махан биеэ орхиод аялбал нэлээд хурдан. Ийм байдал нь чөтгөртэй адил. Хэрэв та нар гадаадын ном уншвал мэднэ. Дөнгөж үхсэн хүнийг тусгайлан судалдаг нэгэн америк эмчийн судалгаанаас үзвэл зарим хүн үхээд дахин буцаж ирдэг. Үхээд нэг хоёр, гурван цаг болсны дараа дахиж амилна. Зарим хүн гурав, дөрвөн өдрийн дараа амилдаг. Та нар ийм явдлыг сонссон уу? (*Тийм гэж нэг хүн хариулав.*) Формосад, Ау Лакт тохиолдож байсан. Тэд эргэж амьдарсныхаа дараа олон түүх ярьсан байдаг. Зарим хүн ярьдаг ч, зарим нь айгаад ярьдаггүй.

Америкт ийм зүйлийг мэдээлж байсан. Зарим хүн машинд дайруулахдаа өөрөөс нь өөр нэгэн бие гарч явахыг мэдэрчээ. Өөрийнхөө тэнд хэвтэж буйг, олон хүн нааш цааш гүйлдэн, цагдаа ирээд ямар нэгэн зүйл тэмдэглэж, эмч ч бас ирсэн байсан зэрэг болж буй бүх үйл явдлыг тэр харжээ. Тэгээд амь орсныхоо дараа энэ талаар эмч, цагдаа нарт ярьж өгчээ. Энэ нь үнэн бодит хэрэг болно. Үхсэн мөртөө бүгдийг мэдэж байсан нь тухайн үед тэнд байсан хүмүүст хачирхалтай санагджээ.

Учир нь махан бие үлдэж хоцроод бусад биес нь гарч оджээ. Гараад зугаалж болно. Бусад хүмүүсийг нэвтлэн гарч чадна, тэднийг нэвтлэн гарах үед тэд мэдэрдэггүй. Энэхүү ертөнцөд бид заримдаа ад чөтгөрийг нэвтэлж гардаг ч, үүнийгээ өчүүхэн төдий ч мэддэггүй. Дөнгөж үхсэн олон хүний байдал бүгд ижил байдаг. Тэд үхэх үедээ өөрсдийгөө дээшээ гарахыг мэдэрдэг бөгөөд дараа нь бие нь тэнд хэвтэж буйг, эсвэл сууж байгааг, эсвэл автомашины аймшигт осолд орсноо олж хардаг.

Зарим хүнд мэс засал хийхэд сүнс нь гараад явчихдаг. Үнэндээ энэ нь сүнс хараахан бус. Хэрэв заавал сүнс болгож ярих хэрэгтэй бол энэхүү сүнс гэгч нь бидний билиг ухаантай адилгүй. Билиг ухаан эсвэл бидний эзэн гэдэг нь өөр зүйлийг хэлж буй бөгөөд тэр хамгийн дотор талд цөмд нь байдаг. Дотор талд гэхэд хэрэг дээрээ дотор талд биш, Та нар харин мэс засал хийхийн адил давхарга давхаргаар нь дотогш хайвал өөрсдийн уг дүрээ эрж олно гэж бодож болохгүй. Ийм утгатай биш. Дотор тал гэдэг нь дотор тал биш. Гэвч тохирох үг олдохгүйгээс дотор тал гэсэн. Учир нь гадна гэвэл та нар гадна талынх гэж бодох учраас арга ядахдаа дотор тал гэсэн юм. Гэвч бас дотор тал биш. Та нар гэртээ хариад уг дүрээ олж чадах нь уу, үгүй юу гэж хагалж үзэж болохгүй. Ингэвэл төвөг болно. (*Бүгд инээв.*) Олдохгүй шүү!

Мэс засал хийлгэж байгаа хүн зарим үед өөрийгөө дээш хөөрч, өөр өрөөнүүдээр аялж байгаагаа хардаг. Бусад өвчтөнүүдийн байр байдлыг харсны дараа биедээ буцаж ороод энэ тухайгаа хүмүүст ярьдаг. Тэд бүгдийг мэддэг бөгөөд яг л өрөөл бусдыг ажигласан мэт бүх зүйл тов тодорхой байдаг. Энэ нь бидний үхлийн төлөв байдал болно. Гэвч энэ нь их доогуур түвшний, энгийн хүний үхлийн төлөв юм. Их бясалгагчийн үхэл огт тийм биш. Тэр үхвэл дороо төгс баясгалант оронд очно. Эсвэл түүнчлэн ирж, түүнчлэн одно. Энэ бол бидний хүсэж буй яг тэр зүйл.

Тэрхүү ад чөтгөрийн сүнсний төлөвийг бид хүсэхгүй. Энэ төлөвийг энгийн хүмүүс мэдэж болох ч хорон санаат, муу хүн үхвэл дороо тамд унадаг учраас мэддэггүй. Учир нь тэд энэ ертөнцөд үлдэж чадахгүй, чөлөөтэй явж, өөрийн биеэ, эсвэл садан төрлөө харж чадахгүй. Зарим хүн өөд болсныхоо дараа ч гэртээ нааш цааш холхиж, төрөл садантайгаа юм ярьж, тэднийг илж таалж байсан ч цаадуул нь мэддэггүй тул ихэд зовдог.

Тэр өөрийгөө нэгэнт үхсэн гэдгээ мэдэрдэггүй. Бие цогцос нь урьдынхтайгаа адил байгааг тэр хараад би үнэхээр үхчихсэн юм уу? гэдэг. Ярихыг нь бусад хүн сонсохгүй, юм идье гэвэл

ойлгох хүнгүй, юу ч хийсэн түүнийг мэдэх хүн байхгүй. Гэвч зарим үед тэд хамаг хүчээ гаргавал бид жаахан юм сонсдог ч сүнс надаар оролдож байна гэж бодоод: "чөтгөрийн сүнс байна" гэнэ. Сүнс үүд тогшиж чимээ гаргана, эсвэл аяга шаазан хангир жингэр дуугаргана, эсвэл ор дэрэн дээр дэвхэцнэ. Энэ бол үнэн бодитой.

Учир нь сүнс бүх л өдөржингөө ярьсан ч хэн ч сонсохгүй тул их уурладаг. (*Бүгд инээв.*)

Тэр эхнэрээ тэврэхэд эхнэр нь юу ч мэддэггүй. Өөр нэг эрэгтэйг дагуулж ирээд түүний нүдэн дээр ямар нэгэн явдал үйлдэж мэднэ. (*Бүгд инээв.*) Иймээс сүнс их уурлаж, бүх хүчээ шавхан бага зэрэг дуу чимээ гаргана. Ингэхэд нь түүнийг гэртээ байгааг мэдэвч олж харахгүй. Зарим нь нэлээд буян хишигтэй, хүчтэй бол махан биетэйгээ адил болон хувилж, хоромхон зуур хэсэг хугацаанд үзэгддэг. Тэгэхэд нь бид: "Хүүе ээ! чөтгөр байна!" гэдэг. (*Бүгд инээв.*) Ийм л юм болдог.

Бид өөрсдийгөө ийм ганцаардмал чөтгөр болгох хэрэггүй. Өдөржингөө ярьсан ч хэн ч сонсохгүй, хэлье гэхээр тэд анзаарахгүй. Дөнгөж өөд болоод байхад эхнэр нь өөр эрэгтэйг дагуулж ирвэл тэр мэдээж их шанална. Эсвэл эр нөхөр нь өөр эмэгтэйг дагуулж ирвэл мөн адил. Иймээс чөтгөр болох нь тун ч зовлонтой! Ам байвч ярьж чадахгүй, бие байвч ашиглаж болохгүй, юу ч хийе гэсэн хийж чадахгүй, их зовлонтой. Бид тийм байдалд орох хэрэггүй. Бидэнд хэрэгтэй зүйл бол үхэх үед өөрөө өөрийгөө хянаж, очих газраа сонгох эрхтэй байх ёстойгоос биш, ад чөтгөрийн төлөвт захирагдах учиргүй. Ийм ганцаардмал, тодорхойгүй, мэдэх хүнгүй болохоор сүнс аргаа барахдаа оршуулгын газар очин бусад чөтгөртэй хүүрнэлдэж, хамт амьдрахад хүрнэ. Үнэхээрийн гунигтай.

Гэвч бясалгал сайтай хүн нас нөгчих үедээ өөрийн дураар явж болно. Хэзээ явахаа урьдаар мэднэ. Хаа очихоо ч мэднэ. Энэ нь нэгэн эрх чөлөөт эрхэм хүн мэт. Явъя гэвэл явж, ирье гэвэл ирнэ. Яагаад заавал чөтгөр ирж барьж аваачихыг хүлээх ёстой гэж? Яагаад ад ирж дагуулж явахыг хүлээх ёстой гэж? Энэ нь эрхэм хүний шинж байдал, эрхэм дээд хэв маяг биш. Бид хүн болоод ямар ч муу хэрэг хийгээгүй атал ад чөтгөр юунд биднийг барьж явах ёстой гэж? Ялтан баривчилж байгаа юм шиг, үүнд бид дургүй. Бид бясалган дадуулах хэрэгтэй. Явъя гэвэл явдаг бүрэн эрх бидэнд байх хэрэгтэй. Ангижрахаа урьдаар мэдээд эр нөхөр, эхнэр хүүхэд, шавь нартаа: "Би гурав, тав хоногийн дараа явна, та нар жаахан бэлтгээдэх." гэж хэлнэ. Энэ бол жинхэнэ хүний шинж мөн. Ирье гэвэл ирнэ, явъя гэвэл явна, эрх дураараа. Чөтгөрт

баригдахгүй, хэн ч чамайг сонсоно. Үхэж төрөхдөө эзэн нь болж чадахгүй бол хүн болсны хэрэг юун.

Ад чөтгөрийн дэс угаас биднээс доогуур, тэд бол бидний зарц. Гэвч бид тааруухан байвал тэд барьж аваад яллан шийтгэдэг. Энэ нь цагдаа ерөнхийлөгчид захирагддаг хэдий ч улсын ерөнхийлөгч хуулиа зөрчсөн бол мөн баривчлагдаж, шоронд суун шийтгүүлэхэд хүрдэгтэй адил. Энэ үед ерөнхийлөгч өчүүхэн ч эрх мэдэлгүй болдог. Бидний ярьдаг гурван муу заяа гэдэг нь ямар утгатай вэ? Бирд, там, адгуусыг хэлнэ. Ад чөтгөр биднээс доогуур атлаа, нас нөгчих үед биднийг барин аваачиж, хэрцгийлэн хараах зоддог. Ингэхэд хүрвэл дэндүү нүүрээ барсан хэрэг болох биш үү? Эрхэм дээдийн шинжээ алдсан хэрэг биш үү? Бид ийм байдлыг хэрхэвч үүсгэж болохгүй.

Жинхэнэ ёсоор бясалгал дадуулдаг их бясалгагч хүн бол хамгийн эрхэм дээд. Түүний буцах нь яг л Бурхан буцахтай адил. Аялгуу хөгжим ирж, түүнийг тосно, тэнгэрийн элч болон Бурхан, Бодьсадва нар угтаж авна. Буцашгүй бодьсадватай хамт явахад, ад чөтгөр халдаж чадахгүй. Хэрэв сайтар хичээн бясалгал дадуулахгүй бол тэдэнд баригдаж хүлэгдэн, хараалгуулж зодуулна. Энэ нь эрхэм хүний амьдрал биш, эгэл хүний ч амьдрал биш.

Бид энэхүү ертөнцөд амьдрахдаа биедээ анхаарч, чармайж ажиллан жаахан мөнгө хураавал, өтлөхийн цагт амиа тэжээх бага сага мөнгөтэй болно. Тэгвэл бид яагаад бага сага ач буян хурааж, үхэх үедээ хэрэглэдэггүй юм бэ? Энэ нь өтлөх үед хэрэглэх мөнгөнөөс ч чухал бөгөөд мөнгийг бид хэрэглэж амжихгүй байж тун магадгүй. Учир нь бид өтлөх албагүй, маргааш ч яваад өгч мэднэ. Үхэл зайлшгүй, цагаа болохоор бид гарцаагүй буцна. Заавал урт наслах албагүй. Иймээс бид бясалгалыг хичээнгүйлэн дадуулж буян хураагаад нас нөгчих үедээ хэрэглэж болно. Энэ нь хүний амьдралын хамгийн чухал хэрэг бөгөөд өндөр насны тэтгэврээ хурааж хуримтлуулснаас ч илүү чухал.

Асуулт: Багшаа, таныг бясалгал хийж байхад томоохон адын саад байсан уу?

Их Багш: Миний дадал бясалгалд адын саад тотгор байсан, яагаад байхгүй билээ? (*Та ярьж өгч болох уу?*). Би танд ад түйтгэрээ ярих ямар хэрэгтэй юм бэ? (*Бүгд инээв*). (*Таны бясалгал хийх ерөөл барилдлага юу вэ?*) Шавь нар маань миний гаднах төлөөлөл, ерөөл барилдлага болно. Учир нь тэд намайг явуулдаггүй. Адын саад тотгор бол тийм ч сүртэй зүйл биш, зугаа төдий. Үгүйдээ гэхэд л надад зугаатай. Тиймээс яриад байх

юмгүй, зүв зүгээр. Адын саад тотгор, түйтгэр бидний бясалгал дадлын тогтсон хүчийг нэмэгдүүлэхэд тусалдаг. Хэрвээ бид ад түйтгэрийг даван туулж чадвал бидэнд тустай, чадахгүй бол төвөг саад болно. Үнэн хэрэгтээ адын саад тотгор байхгүй, миний хувьд бол сүртэй юм биш, зөвхөн ертөнцийн нэгэн үзэгдэл төдий.

Зүв зүгээр, би хаана ч бясалгал хийж чадна.

Асуулт: Бясалгах үед тун нарийн аялгуу сонсдог. Номоос уншиж үзэхэд аялгуутай хэтэрхий зууралдах хэрэггүй гэсэн байна. Энэ зөв үү?

Их Багш: Зарим аялгуу сайн, зарим нь муу. Хэрэв чиний дуртай аялгуу чинь нэлээд доогуур түвшний аялгуу бол мэдээж чамд муу. Иймээс зууралдах хэрэггүй. Жишээлбэл, миний шавь надад: "Багш аа, би олон янзын аялгуу сонсдог, их сайхан." гэвэл би түүнд: "Зарим аялгууны дэс өндөр биш тул битгий сонс, чи өөр аялгуу сонсох хэрэгтэй." гэнэ. Гэвч тэр дургүйцэж: "Энэ аялгуу тэр аялгуунаас чинь гоё." гэвэл би: "Түүнд хүлэгдэх хэрэггүй, тэр аялгуу хэдийгээр таатай биш боловч түвшин нь нэлээд өндөр." гэж хэлж өгөх хэрэгтэй болдог.

Иймээс ном судар уншаад хэрэггүй. Учир нь ном судрыг бясалгал хийсэн хүн бичсэн тул тэдэнд өөрсдөд нь тустай. Багш нь тэдэнд яаж хийхийг зааварлахад тэд дараа дахиж үзэхийн тулд бичсэн байж болох юм. Эсвэл багш нь тэдэнд захиа бичиж хэрхэхийг заасан байж мэднэ. Чиний сонссон аялгуу ямар нь болохыг чи мэдэхгүй. Учир нь чамд зааварлах Төгс Гэгээрсэн Их Багш байхгүй. Та Арьяабалын аргаар бясалгал хийж байгаа юу? (*Үгүй*). Аяндаа сонссон уу? (*Би их нигүүлсэнгүй тарнийг унших үед сонссон*.) Заримдаа бид санаандгүйгээр аялгуу сонсдог. Гэвч багшийн удирдлагагүй бол энэхүү аялгуу нь сайн, муу эсэхийг бид мэдэхгүй. Хүлэгдэхгүй байвал сайн. Олон аялгуу байдаг учраас түүний түвшин нь ямар болохыг та мэдэхгүй.

Асуулт: Юуг гэрлийн өнгө гэх вэ? Гэрлийн дэсийг хэрхэн ялгах вэ?

Их Багш: Энэ асуудлыг энд ярьж болохгүй. Байдал өөр өөр болохоор богино хугацаанд нэг бүрчлэн тайлбарлах аргагүй. Ном уламжилсны дараа Багш нь тухайн хүний байдлыг харж байгаад заавар өгнө. Энэ нь тусдаа асуудал тул энд ярьж болохгүй.

Асуулт: Манай нагац эгч хар, цагаан хувцастай дадал бясалгал хийдэг хүнийг хардаг гэсэн. Гэтэл бидний энгийн нүдэнд харагддаггүй.

Их Багш: Ийм явдал зөндөө. Бидний эргэн тойрон маш олон

дүрсгүй төрөлтнөөр дүүрэн. Зарим хүн харж чадна. Нохой ч гэсэн ад чөтгөрийг хардаг биз дээ! Ойр хавьд нь юу ч байхгүй байхад нохой амаа ангайн шүдээ ярзайлгаад зогсолтгүй хөв хөв гэж хуцсаар байдаг. Учир нь тэр дүрсгүй төрөлтөн ад чөтгөрийг, эсвэл таны ярьсан "хар", "цагаан" юмыг хардаг. Хэрэв хар өнгөтэй бол бясалгагч хүн лав биш, бясалгал дадуулдаг хүн их гэрэл гэгээтэй байдаг.

Асуулт: Гэрээс гараагүй хүн ямар аргаар бясалгал хийхээ мэдэхгүй байна. Дадал бясалгалыг яаж хийвэл сайн бэ? Арьяабалын бясалгалын аргаар хэрхэн бясалгах вэ?

Их Багш: Бясалгал дадуулахад хамгийн гол нь ёс суртахуун. Таван сахил сахих хэрэгтэй. Амьтны амь хороохгүй, хулгай хийхгүй, садар самуун явахгүй, худлаа хэлэхгүй, архи уухгүй. Энэхүү архи уухгүй гэдэг сахилд мансууруулах бодис хэрэглэхгүй, тамхи татахгүй, хүний сэтгэл, дур хүслийг өдөөх садар самуун буюу хүчирхийллийн агуулгатай кино үзэх, садар самууныг сурталчилсан ном хэвлэлийг уншиж болохгүй зэрэг багтана. Амьтны амийг хороохгүй гэдэгт шууд бусаар амьтны амь хороохгүй байх мөн багтана. Энэ нь ногоон хоол иднэ гэсэн утгатай. Түүнээс гадна Авид бурханд залбирна. Гэрээс гараагүй хүн бусад бясалгалын аргаар бас бясалгал дадуулж болно. Энэ бол өөрийн чинь дурын хэрэг. Багшийнх нь гэрээс гараагүй шавь нар бүгд Арьяабалын аргаар бясалгал хийдэг. Хэрэв та үнэн сэтгэлээсээ гэтлэхийг хүсвэл ирж болно. Би зааж өгье.

БУРХАН ГЭЖ ХЭН БЭ?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар. Формосагийн Тайбэй хотын Цаглашгүй гэрэлт бясалгалын төв.
1987 оны 3 дугаар сарын 10
(Эх нь хятад хэлээр)

Үнэн ёс гэж юу вэ? гэж өчигдөр нэг хүн надаас асуухад яримааргүй санагдсан. Яагаад гэдгийг та нар мэдэх үү? Учир нь Үнэн ёс гэдэг угаас ярьж болшгүй, яривал дуусахгүй. Үнэндээ яримаар юм байхгүй. Үнэн ёсыг биеэрээ мэдэрч байж л ойлгоно. Үнэн ёсны тухай маргах юм уу, ярих дуртай хүн хэрэг дээрээ түүнийг ойлгоогүйгээ харуулж буй хэрэг. Иймээс Лууз: “Мэдэх хүн ярихгүй, ярих хүн мэдэхгүй.” (“Даодэжин”-ын 56-р бүлэг: “Мэдэгч үл өгүүлмүй, өгүүлэгч үл мэдмүй”) гэжээ. Үнэн ёс гэж юу болохыг та нар заавал ойлгоё гэвэл энэ нь амьдрах өөр маяг гэж арай дөхүүлэн хэлж болно. Тиймээс Шагжамуни Будда, Лууз болон Есүс Христ ч бас Үнэн ёсыг төлөөлж байдаг. Яагаад тэр вэ? Учир нь Тэдний амьдрал нь даруй Үнэн ёс юм.

Угаас бид ч гэсэн Үнэн ёсыг төлөөлдөг гэж болно. Гэвч бид үйл түйтгэртээ ороогдоод, өөрийгөө Үнэн ёс гэдгийг мэдэхээ байж, өөрийн уг дүр, өөрийн эзэн, өөрийн цэвэр ариун сэтгэл, өөрсдийн диваажин зэргийг харж чадахаа больжээ. Бурхан, Бодьсадва Үнэн ёсыг төлөөлдөг учраас Үнэн ёсыг асууя гэвэл Бурхан, Бодьсадваг хайн олж, асуух хэрэгтэй. Шагжамуни Будда: “Бурхан сэтгэлд буй.” гэсэн. Хамаг амьтан бүгд Бурхан чанартай. Гэвч бид яагаад таарсан болгоноосоо Үнэн ёсыг асуулгүй заавал Төгс Гэгээрсэн Их Багш юм уу, Бурхан, Бодьсадвагаас асуудаг вэ? Учир нь Бурхан бодьсадва Үнэн ёсыг хэдийнээ таньж мэдээд өөрөө Үнэн ёс болсон байдаг. Иймээс бид Төгс Гэгээрсэн Их Багш юм уу, эсвэл амьд сэрүүн Бурхан, Бодьсадва дээр очвол Үнэн ёс гэж юу болохын хариултыг аяндаа олно.

Үнэн ёсыг ярих аргагүй. Яривал хэзээ дуусах бол? Шагжамуни Будда дөчин есөн жил ярьсан мөртөө: “Миний мэдэх зүйл ой тайгын модны навчис мэт арвин боловч, та нарт ярьсан нь зөвхөн атганд байгаа навч төдий юм.” гэж шавь нартаа хэлжээ. Шагжамуни Будда ч бүх Үнэн ёсыг ярьж бараагүй атал, би яаж ярьж дуусах вэ?

Зарим хүний асуулт тавих нь Үнэн ёсыг мэдье гэж хүсэж эрмэлзсэндээ биш, билиг ухааныг олъё гэсэндээ ч биш. Зөвхөн маргаан үүсгэж, өөрийгөө хэчнээн агуу, Их Багшаас өндөр зэрэгтэй болохоо хүмүүст гайхуулахын төлөө байдаг. Ийм хүнд тууштай баримталдаг зүйл гэж үгүй. Түүний хувьд мах идэх, цагаан хоол идэх нь адил, амьтан идэх, хүн идэх нь мөн л адил. Учир нь одоо түүний цагаан хоол идэх нь мах идэхтэй адил учраас ирээдүйдээ идэх амьтангүй болоход, хүн идэх, мах идэх нь адил болж хувирна. Тийм хүн бол ийм л байдаг. Үнэн сэтгэл нь сурахын төлөө биш зөвхөн марган мэтгэлцэхийн төлөө. Хаа нэгтээ хүн ном айлдаж буйг сонсоод даруй ирж маргаан хийхээс бус, хичээнгүй сэтгэлээр гэгээрлийг хайдаггүй. Учир нь би үзэл нь хэт их тул түүнээсээ даруй салахад маш хүнд.

Иймээс бид бусад хүний тавьсан асуултыг сонсмогцоо л тэдний дэс хаана байгааг даруй мэдэж болно. Иймд эрт үеийн Их Багш нар шавь нартаа ном уламжлахын өмнө олон удаа сорьж шалгаж, олон асуулт тавьсаар “би” үзэлгүй, омог бардам зангүй болсны дараа л ном уламжилдаг байжээ.

Дөрөв таван зуугаад жилийн өмнө Энэтхэгт олон шавьтай алдарт Их Багш байжээ. Түүнийг Кабир (Kabir) гэдэг. Тэр бол Энэтхэгийн нийгмийн дөрвөн давхаргын хамгийн доод ажилчны давхаргад харьяалагддаг тун ядуу хүн байсан. Энэтхэгт ийм хүнийг хэн ч тоохгүй. Гэвч тэрээр их билиг ухаантай, билиг нь ихээр нээгдэж Бурхан болсон тул олон хүн ирж шавь ордог. Түүний шавь нарын дотор тансаг амьдралаа орхиж, сурахаар ирээд түүнтэй хэдэн жил хамт байсан нэгэн хан хүү байжээ. Гэвч Кабир түүнд ном уламжлахгүй байв. Харин бусад хүнд бол тэр даруйдаа, эсвэл хэсэг хугацааны дараа ном уламжилдаг байлаа.

Ханхүүд ном уламжлалгүй хэдэн жил болов. Түүгээр өдөр бүр юм угаалгах, хог шүүрдэх, жорлон цэвэрлэх, хог хаях, хоол хийх гэх мэт ажлыг хийлгэсээр байж. Нэг өдөр Кабирын эхнэр (өмнө нь түүний эхнэр байсан ч Кабир түүнийг хамтран бясалгагчаа болгосноос эхнэр, нөхрийн харилцаагүй болжээ): “Энэ хан хүү танд ийм удаан үйлчилсэн байтал яагаад түүнд ном уламжилдаггүй юм бэ?” гэж асуужээ.

“Түүний цэвэр байдал, ариун сэтгэл хангалтгүй байна.” гэж Кабирыг хэлэхэд, эхнэр нь итгэж ядан: “Яаж тийм байж болох вэ? Тэр бидэнтэй хамт хэдэн жил болохдоо ихэд даруухан байсан.” гэж хэлжээ. Тэгэхэд Кабир: “Туршаад үзье, маргааш өглөө түүнийг үүгээр өнгөрөхөөр нь толгой руу нь хог асгаад нуугдчих. Түүнд хэн болохоо бүү таниул, тэгээд яахыг нь хараад чи мэдэх болно.” гэв. Эхнэр нь түүний хэлсэн ёсоор хийсэнд, хан хүү маш их уурлаж: “Чи намайг хэн болохыг мэдчихээд ингэж зүрхэлсэн бол ямар шан хүртэхээ мэдэж байна уу?” гэжээ. Тэгэхэд цаана нь нуугдаж байсан Кабир, түүний эхнэр хоёул инээлдээд, Кабир: “Хар даа, би андуураагүй байгаа биз.” гэж хэлэв. Үүнээс хойш түүний эхнэр юм хэлэхээ байжээ.

Хэдэн жил өнгөрсний дараа Кабирын эхнэрт хан хүү их өрөвдөлтэй санагдав. Ямар ч ажил хийсэн их хүлцэнгүй агаад Багшаа удаан асарсан боловч, зөвхөн амьсгалах, Бурханд залбирах, мөргөх мэтийн аар шаархан зүйлийг заагаад, Арьяабалын бясалгалын аргыг жинхэнээр уламжлахгүй байв. Түүний эхнэр нь: “Одоо цаг нь болсон шиг байна.” гэхэд Кабир: “Маргааш дахин туршаад үз. Өглөө үүдээр чинь өнгөрөх үед савтай шээсээ дээрээс нь асгаад, яахыг нь хар.” гэв. Эхнэр нь маргааш хэлснээр нь хийв. Тэр савтай шээсээ бие дээр нь асгаад нуугдан харж байтал хан хүү толгойгоо сэгсэрч: “Миний дотор үүнээс ч бузар байжээ. Оройн дээд Бурхандаа баярлалаа, өнөөдөр би өөрийгөө мэдэж авлаа. Энэ шээсний савнаас ч бузар байсан юм байна.” гээд даруй сөгдөж тэнгэр өөд гуравтаа мөргөөд биеэ угаахаар явав.

Тэгэхэд Кабир: “Өнөөдөр ном уламжилж болно.” гэв. Учир нь хүнд ном уламжлахад “би” үзэл нь хэт их бол ямар ч нэмэргүй. Хүчээр уламжилсан ч шингээж чадахгүй. Шингээлээ ч өндөр дэсэд хүрч чадахгүй зөвхөн Маяагийн албат юм уу, Маяа эзэн болно.

Эртнээс нааш Их Багш нар ном уламжлахаасаа урьдаар ёс суртахууныг зааж, шавь нарынхаа омог бардам занг цэвэрлэдэг. Учир нь бид энэхүү дэлхий дээр эмч, сайд, сургуулийн захирал гэх мэт янз бүрийн байр суурьтай байдаг. Гэтэл бидний нийгэм дэх байр суурь өндөр, өргөн олны хүндэтгэлийг хүлээж байгаад нэгэн номын багшид шавилснаар, юу ч мэдэхгүй бядуу молхи хүн болж хувирна гэдэг тун хэцүү. Тун амаргүй. Тиймээс зарим Их Багш нар өдөр бүр чихэр, жигнэмэг тараагаад байдаггүй, тун тааламжгүй аргаар шавиа сургадаг. Энд ном тайлсны дараа Багш нь та нарт чихэр жигнэмэг өгнө. Гэвч Багшийн жинхэнэ шавь болох тийм амаргүй. Чихэр жигнэмэг өгч болох ч бусад олон зүйл

бий. Гашуун эм, таагүй бэлэг ч бий.

Бид өвдвөл өөр өөр эм ууж байж илаарьшдаг. Өвчин хүнд бол хагалгаа хийлгэнэ. Хагалгаанд орохгүй бол үхэх тул эртхэн хийлгүүлээд амьдрах эсэхээ үзсэн нь дээр. Хугацаа алгуурлаж болохгүй. Үүнтэй адил шалгалт сорилт даахгүй хүнийг эртхэн явуулах хэрэгтэй. Ингэвэл түүнд илүү тустай.

Шагжамуни Будда "Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар"-ыг тайлж байхад таван мянган хүн орхиж явсан гэдэг. Учир нь Түүний тайлсан нь дээдийн бясалгалын арга байсан бөгөөд урьд нь тэдний ерөөс сонсож байгаагүй, сурч байгаагүй зүйл байжээ. Иймээс омог бардам хүмүүс: "Би судар бүхнийг цээжилсэн, олон багштай уулзаж бүх номыг сурсан байтал яагаад миний дуулаагүй бясалгалын арга гэнэт гараад ирдэг билээ? Би лав итгэхгүй нь." гэдэг. Иймээс таван мянган хүн хаяж явжээ. Тэгэхэд Шагжамуни Будда урам нь огт хугаралгүйгээр: "Тун сайн хэрэг. Манай номын цуглаанд жинхэнэ сайн үр нь үлдэж, муу үр бүгд салхинд хийсэн одов." гэжээ.

Багш нь өмнө нь хүнд итгэсэндээ тэр дор нь ном уламжилдаг байсан. Одоо харахад олон хүний номч сэтгэл нь гүн биш, дэс нь өндөргүй болохоор энэхүү дээдийн бясалгалын аргыг андуу ойлгодог. Иймээс би дахиж хамаагүй ном уламжлахаа больсон. Ном тайлаад бараг долоо хонож байхад ямар ч ном уламжлаагүй л байна. Өмнө нь ганц хоёр хоног ном тайлаад, тэр ч байтугай найзынхаа танилцуулсан хүнд ч уламжилдаг байсан. Одоо тийм хялбар биш, уламжлахгүй гэвэл уламжлахгүй. Тэрхүү муу үр бүгд салж одсоны дараа уламжилдаг болсон.

"Ном"-ыг хямдхан зарж болохгүй. Манай бясалгалын аргыг заавал олон хүнд мэдүүлэх албагүй. Олон шавьтай болж, олонд танигдахын төлөө зүтгэж болохгүй. Тийм биш. Арьяабалын бясалгалын арга тийм хямдхан зүйл биш. Хямд зүйлийг олон хүн худалдан авч болно. Үнэт зүйлийг санаан дураар авахгүй, тэгээд ч олон хүнд худалдаж чадахгүй. Иймээс алгуур аажимдаа болох хэрэг. Та нар тэвчээртэй бол хүлээ, үгүй бол яах вэ дээ. Тийм ухаантай юм бол тэр л биз. Багш нь зөвхөн бядуу молхи, жинхэнэ төлөв даруу, гэгээрлийг хайж, үнэнийг олохыг хүссэн хүнд л зааж өгнө. Хэрэв та хэтэрхий ихийг мэддэг бол биднийг орхивол талархана. Та хэт ихийг мэдэж тархиндаа олон чулуу цуглуулсан болохоор манай эрдэнийн сувдыг багтаах зайгүй болсон байна.

Өчигдөр Багш нь чулууны тухай үлгэр ярьсан. Чулуу нь ихэдсэн болохоор түүнийг гэрт нь буцааж чулууг нь хөнгөлөх хэрэгтэй болсон. Чулуугаа гаргаж хаяж чадвал өөрийн үнэт

зүйлээ олж харах болно.

Тэд яагаад ийм бардам байдаг вэ? Учир нь тэд ном судар, тогтсон үзэлдээ хүлэгдэж, ээдрээт амьдралд бохирдсон болохоор Үнэн ёсыг сонсовч шингээж чаддаггүй. Зарим хүн хэд хэдэн удаа сонссон ч өнөөх тэнэг асуултууд нь байсаар байдаг. Сонсоод ойлгохгүй тул бие нь энд байвч билиг ухаан нь нээгдэхгүй болохоор нэмэргүй. Жишээ нь, бороо орох үед цув нөмөрчих юм бол яаж ихээр орсон ч бидэнд нөлөөлөхгүй. Учир нь цувтай болохоор тэр.

Үүнтэй адил бид олон ном судар уншаад ойлгосон гэж боддог ч үнэндээ огт ойлгоогүй байдаг. "Бид Бурхантай учирч байж Бурхан болно. Бурханаас сурч байж Бурхан болно." гэж Шагжамуни Будда хэлсэн. Гэвч Бурхантай уулзах нь тийм амар явдал биш. Хамгийн их буян хишигтэй хүн Бурхантай уулздаг. Бурханы алдрыг сонсох, эсвэл Түүнтэй уулзах нь тун амаргүй. Ялангуяа Бурханы шавь болно гэдэг бүр ч хэцүү.

Будда гэж хэн бэ? Будда гэдэг нь самгарди хэлний Buddha гэсэн үгийг галиглан буулгасан нэр. Самгардиар Buddha гэдэг. Buddha гэж билиг нь ихээр нээгдсэн хүнийг хэлнэ. Хэн ч, хэзээ ч, хаана ч билиг нь ихээр нээгдсэн л бол бид түүнийг Будда (Бурхан) гэнэ. Өөрийгөө Бурхан гэхгүй байж магадгүй ч Тэр бол гарцаагүй Бурхан мөн.

Есүс Христийг Бурхан гэдэггүй ч Тэр бол Бурхан. Луузыг Бурхан гэдэггүй ч Тэр бас л Бурхан. Бурханы шашинтан ингэж ярьж зүрхлэхгүй байж магад. Харин Багш нь та нарт хэлж Үнэн ёсыг ойлгуулах хэрэгтэй. Хэрэв би иймэрхүү зүйлийг бурханы шашны номын багш нарт яривал Багшийг нь буруу номтон гэхийг мэдэж байгаа ч үүнийг хайхрахгүй. Учир нь Луузыг магтвал зохилтой гэсэндээ магтаж байна. Есүс Христийг ч мөн ингэж үзсэндээ магтаж байна. Та нарын хэн нэг нь Есүс Христ, Шагжамуни Будда юм уу Лууз шиг билиг нь ихээр нээгдсэн бол би мөн л сайшааж, түүнд мөргөн ёсолж, түүнийг Бурхан гэж нэрлэнэ.

Учир нь Бурхан гэдэг бол эмч, хуульч, цагдаа гэдэгтэй адил зөвхөн нэр юм. Хэн ч бай хамаагүй эмчийн үүргийг хүлээж, өвчин эмгэгийг эмчилдэг л бол түүнийг эмч гэнэ. Цагдаагийн хувцас өмсөж, үүрэг хүлээсэн хэн ч бай тэр хүн цагдаа мөн. Бүх дэлхийд ганцхан цагдаа байж болохгүй. Зөвхөн Хуа Туо л эмч гэж болохгүй. Хуа Туо нэр алдартай, тун чадварлаг боловч өнгөрсөн цагийн хүн. Одоо үед өвчтөн олон байна, үеийн үед байсаар байх болно. Гэвч бид Хуа Туог ирж аврахыг хүлээж чадахгүй. Өвдсөн

л бол одоогийн эмчийг бараадах хэрэгтэй. Хэрэв бид зөвхөн Хуа Туог хүндэлж итгээд бусад эмчид итгэхгүй бол биднийг өвдөхөд тэр ирж аварч чадах уу? Үгүй. Учир нь тэр хэдийнээ явчихсан. Түүний ажил дууссан.

Үүнтэй адил, "Бурхан" гэж сүнслэг дадал бясалгал хийж гэгээрсэн хүнийг хэлнэ. Тэр хүн "Дао" гэж юу болохыг ойлгосон, энэхүү "Дао"-г бидэнд уламжилна. Үүнийг яаж эрэхийг бидэнд зааварлаж чадах тийм хүн бол "Бурхан" мөн. Шагжамуни Будда үй түмэн хувилгаан биетэй, Тэр ч бас үй түмээр хувилж чадна. Шагжамуни Будда хүн зоныг диваажин, Бурханы орон руу хөтөлж чадна. Тэр ч бас хүмүүсийг дагуулан диваажин юм уу, Бурханы оронд хүрч чадна. Шагжамуни Буддагийн шавь нар "Хотол зохилдогч зүйл", "Богдсын ном цагаан лянхуа нэрт их хөлгөн судар"-т тэмдэглэсэн ахуй ойлголтуудыг биеэрээ мэдэрч чадна. Түүний шавь нар ч мөн иймэрхүү зүйлүүдийг хийж чадна. Шагжамуни Буддагийн шавь нар ид шидтэй, түүний шавь нар ч ид шидтэй. Шагжамуни Будда диваажин, тамын оронд очдог. Тэр ч мөн адил хийж чадна. Шагжамуни Буддагийн шавь нарын очсон газар болгон буян хишигтэй. Ямар ч хүн Шагжамуни Буддагийн шавь нартай холбоотой байвал маш их буян хишигтэй болно. Түүний шавь нар хаа ч очсон тэр газар нь буян хишгээс нь хүртэнэ. Шагжамуни Будда гэрэл гэгээтэй, эсвэл ямар нэгэн билиг ухаантай, хүч чадалтай юм бол амьд сэрүүн Бурхан ч бас адилхан.

Шавь болгон адилгүй хүчтэй болохоор Шагжамуни Буддагийн шавь нар ч бүгд адилхан хүч чадалтай байгаагүй нь мэдээж. Хэрэв одоо ийм хүн байгаа бол бид түүнийг Бурхан гэж нэрлэх нь яриангүй. Бурхан диваажин юм уу төгс баясгалант оронд байдаг тул бид харах аргагүй гэж боддог. Хэрэв тийм бол бид Бурханыг яаж мэдэж, хэрхэн таних вэ? Таних аргагүй мэт боловч Тэрээр хүний дүрд хувилаад бууж ирж чадна. Бурхан үй түмэн хувилгаан биетэй юм чинь хүний дүрд хувилаад бидэнд харагдаж яагаад чадахгүй гэж? Бурхан хүн болж хувилахгүй бол бид хэнийг дагах вэ? Иймд хүний төрлийг авч байж л хүмүүсийг сургана. Түүний гадна төрх нь хүн шиг харагдавч дотроо бол Будда юм.

"Аливаа хүн бүгд Бурхан чанартай.", "Бурхан сэтгэлд бий." гэж бид үргэлж ярьдаг. Энэ нь буруугүй. Гэвч эгэл хүмүүс бид энэхүү Бурханыг таниагүй, энэхүү Бурханыг олж мэдээгүй байна. Гэтэл нэгэн амьд сэрүүн Бурхан өөрийнхөө Бурханыг хаана байгааг мэдээд, өөрөө Будда болчихсон байдаг. Тэр Бурхантай

нэгдэж, нэг цогц болсон учраас Бурханыг олъё гэвэл ийм Бурханыг хайх хэрэгтэй. Ийм хүний дотоод нь Бурхан юм. Хэрэв бид ийм хүнд мөргөвөл хүнд нь мөргөж байгаа биш, Түүний дотоодод хөгжиж төгөлдөржсөн Бурхан чанарт нь мөргөж буй хэрэг. Жишээ нь, аливаа хүн анагаах ухааныг сурвал эмч болно. Чадвараа хөгжүүлж, мэдлэг эзэмшээд сургуулиа төгссөн эмч бусдын өвчнийг эмнэж болно. Бид өвдсөн үедээ суралцаж төгсөөгүй ирээдүйн эмч, эсвэл хожим эмч болж магадгүй хэн нэгнээр өвчнөө эмчлүүлж болохгүй. Харин сургуулиа төгссөн, баялаг туршлагатай болсон эмч дээр очих хэрэгтэй. Үүнтэй адил Бурхан сэтгэлд байдаг боловч зарим хүн сэтгэл доторх Бурханаа олоогүй, зарим нь хэдийнээ олчихсон байдаг. Иймээс бид Буддаг эрж олъё гэвэл Буддагаа нэгэнт олоод харсан тийм хүнийг хайх хэрэгтэй. Яагаад гэвэл түүний дотоодод Бурхан буй.

Иймд эртнээс нааш сүнслэг дадал бясалгал хийх гэж буй хүн урьдаар ийм багшид шавилдаг. Ном сударт ч гэсэн ийм Бурханыг олбол, тэр үед л Бурхан болж чадна гэсэн байдаг. Гэвч ихэнх хүмүүс ном судрын утга санааг андуу ойлгосноос, модон бурхан, чулуун бурханд мөргөцгөөж дотоодын Бурханаа хайж олохоо мартдаг. Дотоодын Бурханаа ганцаардуулж, муутган ялзруулдаг. Дотоодын Бурханаа олж хараагүй, асарч хамгаалаагүй, угааж ариусгаагүй, Түүнд мөргөөгүй, Түүнтэйгээ холбогдоогүй мөртлөө модон бурханд мөргөж залбирдаг. Иймээс дотоодын Бурхан уйлж, ганцаардаж, муудаж ялзарч байхад бид бурхан гэж хэн болохыг олж мэдээгүй л явдаг. Ийм хүн "Дао"-г олоход бэрх. Учир нь бүгд модон бурханд татагдсан, хүлэгдсэн, ном сударт баглуулж, номын хорхой, модны хорхой болсон. Яагаад гэвэл түүний сэтгэлд зөвхөн модон бурхан, ном судар л байдаг болохоор тэд ном судраасаа төдий л ялгаагүй, сэтгэл зүрх нь нээгдээгүй, давчуу уйтан байдаг. Ийм байдалтайгаар хэзээ туулан гэтлэх вэ?

Бороо ороход цув өмсөхгүй бол бүх бие норно. Амьд сэрүүн Бурхан, их бясалгалтны өмнө суучихаад, өөрийгөө үл үзэгдэх цуваар бүтээгээгүй л бол буян хишиг ихээр хүртэнэ. Зарим хүн зөвхөн ном сонсохоор ирдэг ч, сайн ахуй ойлголттой болдог. Зарим нь зөвхөн Их Багшийг харахаар ирдэг ч хариад сайхан ахуй ойлголттой болно. Учир нь тэдний сэтгэл уужим, нэгэнт өндөр дэсэд хүрсэн болохоор тийм буян хишгийг хүртэж чаддаг. Эс бөгөөс Бурханы өмнө сууж байсан ч тамд унана. Шагжамуни Буддаг амьд сэрүүн байхад түүний нүдэн дээр хэдэн хүн тамд унажээ. Учир нь тэд "би үзэл"-ээ хаяагүй, омог бардам, хорон сэтгэлээ гээгээгүйгээс Буддаг хүндэтгэх сэтгэл үүсгээгүй.

Өөрсдийгөө маш агуу, их зүйл мэддэг, Буддагаас ч илүү хэмээн бардамнаснаас болжээ.

Өчигдөр бас нэг хүн цагаан хоол идэх талаар асууж байсан. Тэр хүн маханд их дуртай гэнэ. Мах идэх муу гэж намайг хэлэхэд тэр их дургүй байлаа. Зарим хүн нөхцөл байдлаасаа болж цагаан хоол идэж чаддаггүй, энэ нь бардам зантай холбоогүй. Энэ бол омог бардам зан биш. Гэтэл зарим хүн маханд хорхойсдог зуршлаа хаяж чадахгүй учраас шалтаг эрэх юм уу бардам зан гаргадаг. Тэд өөрсдийгөө махны тухайд сэтгэлдээ болон бясалгал дадалдаа "Тууштай баримтлал"-тай байх албагүй гэж үзэн, Шагжамуни Будда, Есүс Христ, Луузаас ч өндөр дэсэд хүрсэн мэт аашилдаг.

Үе үеийн Их Багш нар мах идэж зүрхэлдэггүй байхад тэд өөрсдийгөө зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөнгээс ч дээгүүр тавьж байна. Их Багш Хүй Нөн анчдын дунд нуугдан бясалгал хийж байхдаа зөвхөн ногоо идэж байв. Яагаад мах иддэггүй юм бэ? гэж түүнээс асуухад: "Гэдэс өвдөнө, шингээж чадахгүй." гэдэг байсан бөгөөд бясалгал дадуулдгаа хэлдэггүй байв. Тухайн үед хавчлагаас зугтаж явсан болохоор чимээгүй байх хэрэгтэй байжээ. Их Багш Хүй Нөн номт дээл, бадар аяга уламжилж аваад, Хятадын даяаны урсгалын зургаадугаар үеийн Их Багш болсон ч тийм даруухан, тийм "Тууштай баримтлал"-тай байсан учраас мах иддэггүй байжээ.

Өчигдрийн тэр хүн Их Багш Хүй Нөнгээс лав дээгүүр байх аа. Тиймээс Багш нь түүнд зааж зүрхлэхгүй. Учир нь миний уламжилдаг бясалгалын арга бол зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөнгээс үе дамжин уламжлагдаж ирсэн юм. Би Их Багш Хүй Нөнг хүндэтгэнэ. Тэр мах идэж зүрхлэхгүй, би ч бас зүрхлэхгүй. Шагжамуни Будда "Бодьсадвагийн сахилын үндэс судар"-т: "Бодьсадвагийн сахил авсан хүмүүс бүгд мах идэж болохгүй." гэсэн байна. Гэтэл Бурханы шашинтан хэмээгч нэлээд олон хүн үүнийг чухал биш гэж үзээд, Шагжамуни Будда ч цагаан хоол идээгүй байтал бид яагаад цагаан хоол идэх ёстой юм бэ? гэж Багшаас нь асуудаг. Шагжамуни Буддаг цагаан хоол иддэггүй байсан гэж хэн хэлсэн юм бэ? Ийм асуулт тавьсан хүн Энэтхэгт очиж үзээгүй байж таарна. Хараагүй байж яаж мэдсэн юм бэ? Тааж л байгаа хэрэг. Шагжамуни Будда цагаан хоол иддэггүй байсан бол шавь нартаа цагаан хоол идэхийг яаж заах вэ? "Бодьсадвагийн сахилын үндэс судар"-т Шагжамуни Будда: "Мах огт идэж болохгүй." гэсэн, "Баатараа явагч их хөлгөн судар"-т: "Мах идвэл ад чөтгөр болно." гэж хэлсэн. Мөн "Баатараа явагч их хөлгөн судар"-т: "Мах идвэл ад болно, мах идвэл чөтгөр болно."

гэсэн байдаг. Тэрээр бүгдийг тов тодорхой ярьсан бөгөөд хэрэв өөрөө мах иддэг байсан бол шавь нартаа цагаан хоол идэхийг яаж зааж зүрхлэх вэ?

Өөрөө юу хийнэ, түүнийгээ шавь нартаа заана, хүнд ингэж заачихаад өөрөө эсрэгээр нь хийж болохгүй. Ном судруудыг сайн мэднэ гэчихээд ийм өчүүхэн зүйлийг ч яагаад ойлгодоггүй юм бол? Өөрийгөө юм мэддэг гэж яаж хэлж чадна вэ? Тэгээд бас бясалгал дадуулахад тууштай баримтлал хэрэггүй гэнэ. Тэр хүн үе үеийн Их Багш нараас дээгүүр болчихсон юм байлгүй. Өнгөрсөн үеийн Их Багш нар бүгд "тууштай баримтлал"-тай, зөвхөн тэр л ганцаараа "тууштай баримтлал"-гүй. Тэр ном судрыг хэр ойлгосон юм бол? Олны өмнө ийм үг хэлж яаж зүрхэлнэ вэ? Дэс нь дэндүү доогуур болохоор билиг ухаан нь нээгдэхийн аргагүй. Дэндүү доогуур болохоор дээш нь татахын аргагүй, хэт хүнд, хэтэрхий их чулуутай, бүхий л толгой тархи, оюун ухаан нь чулуугаар дүүрэн. Тийм хүн манай бясалгалын аргыг хүлээж авч чадахгүй. Учир нь түүний цаг нь болоогүй.

Аливаа төрөлтөн бүгд Бурхан чанартай гэдгийг бид мэднэ. Гэвч бүгд энэхүү Бурхан чанараа олж чаддаггүй. Учир нь билиг ухаан нь хүрдэггүй. Энэ нь гадаа бороо орж буйтай адил. Хэрэв бид борооны цуваар өөрсдийгөө сайн халхалбал бороо их орсон ч бидэнд нөлөөлөхгүй. Зандан мод чанар сайтай гэдгийг та нар мэднэ. Жишээлбэл, ойд ганц хоёр зандан мод байхад уул аажмаар бүхэлдээ зандангийн үнэртэй болдог. Энэ мод нь бусад өвс ургамалд нөлөөлөн анхилам үнэртэй болгоод эцэстээ аль нь зандан, аль нь биш гэдэг нь ялгагдахгүй болно.

Энэхүү байдал нь үнэртэй устай адил. Бид үнэртэй усны дэлгүүрт ороод түүнийг худалдаж аваагүй ч, анхилуун үнэрийг нь үнэртэж чадна. Дэлгүүрийн эзэн бидэнд бага зэргийг цацаж өгвөл харьсны дараа дургүй байсан ч үнэртсээр л байдаг. Харин бид цув нөмөрчихвөл, эсвэл бидний хамар асуудалтай бол анхилам үнэр үнэртэхгүй.

Үүнтэй адил бүхий л төрөлтөн бүгд Бурхан чанартай ч зарим хүн олдог, зарим нь олдоггүй. Бүхий л Бурхан чанараа нэгэнт олсон хүнийг "Бурхан" гэнэ. Бурханыг олъё гэвэл ийм хүнийг эрэх хэрэгтэй. Учир нь тэр бол Бурхан юм. Бурханыг дагаж бид Бурхан чанараа олж болох бөгөөд мөн адил Бурхан болж болно. Бид Бурхан болж чадахгүй бол түүнээс сурах хэрэг юун? Хэрэв өдөр бүр Бурханд мөргөж, Бурханы гутлыг угааж цэвэрлээд байвал мэдээж Бурхан болж чадахгүй. Ямар ч сайн зандан мод байлаа гээд чулууг зандан мод болгож чадахгүй. Иймээс хэрвээ

чулуу байх юм бол бид түүнийг хурдхан зайлуулах хэрэгтэй. Харин хэрэглэхээр аваачиж болохгүй. Мод бэлтгэдэг хүн ийм чулууг гэртээ аваачиж болохгүй. Ийм чулуу зандан модонд хэчнээн ойрхон байлаа ч гэртээ авчирч хэрэггүй. Авчирсан ч ашиглах аргагүй.

Занданд ойрхон мөртлөө ямар ч нөлөө хүртдэггүй ийм чулуу аль ч цаг үед байдаг. Үнэн хэрэгтээ энэ нь урам хугармаар юм биш. Учир нь хамаг амьтан угаасаа ийм, дэс нь адилгүй. Иймээс ном уламжлахдаа хүнийг нь харах хэрэгтэй. Зарим үед Их Багш нар тун энэрэнгүй байдаг. Учир нь олон хүн номд орохоор ирдэг тул аль нэгийг нь хөөгөөд явуулчихаж болдоггүй. Ялгаварлах сэтгэлтэй байж болохгүй болохоор аргагүйн эрхэнд ийм хүнд ч ном уламжилдаг. Гэвч хэрэггүй гэдгийг Их Багш нар хэдийнээ мэдэж байдаг. Иймээс Шагжамуни Будда Девадатад ном уламжилсан боловч тэрээр хожим нь түүнээс урвасан. Зөвхөн хэлээгүй л болохоос үүнийг Шагжамуни Будда мэдээгүй биш, мэдэж байсан.

Багшийнх нь шавь нар дотор ч Девадаттай адилхан хүн байдаг. Гэвч би түүнийг хайхардаггүй. Тийм хүмүүст маш их чулуу булаастай байгаа болохоор аажмаар зайлуулах хэрэгтэй. Гэвч тэд өөрсдийн гэсэн ажилтай. Учир нь Их Багш бусдын өмнөөс их үйл түйтгэрийг үүрч байдаг. Хэрэв түүнийг гүтгэх хүнгүй бол Их Багшийн үйл түйтгэр нь хурдан арилдаггүй. Тиймээс хүмүүс гүтгэх тусам тэр төдий их талархаж, сэтгэл нь нэлээд уужирдаг. Та нар хэрэв Багшийгаа гүтгэвэл Багш нь их талархана. Гэхдээ нүүрэн дээр гүтгэвэл арай зугаатай. Далдуур гүтгээд хэрэггүй, би мэдэх ч үгүй. Тиймэрхүү гүтгэгчид тун тэнэг байдаг. Эрхэм хүн бол хүний нүүрэн дээр хэлнэ. Гэтэл далдуур жиг жуг хийх нь ямар хэрэгтэй юм бэ? Нялх хүүхэд шиг, хов зөөдөг хүн шиг. Багшийгаа харахаар "Багш аа, та үнэхээр нигүүлсэнгүй." гэж уран зөөлөн яриад, далдуур болохоор гүтгэхийн ихээр гүтгэж байдаг.

Энэтхэг юм уу бусад оронд амьд сэрүүн Бурхан, амьд сэрүүн Бодьсадва тодорвол шавь нар нь ихэд хүндэлдэг. Учир нь түүнийг дагаж бясалгалыг хичээнгүйлэн дадуулвал маш өндөр ахуй ойлголттой болно. Тэд багшийгаа хэн болохыг мэдэж байдаг. Иймээс тэд багшийгаа бишрэн шүтдэг бөгөөд харагдахгүй Бурхан харагдахгүй Эзэн Бурханыг бишрэн шүтдэггүй. Учир нь Тэрхүү их бясалгалтан нь Бурхан буюу Эзэн Бурхантай хамт байдаг. Хэдийгээр тэдэнд энэхүү бие махбод байх боловч түүний жинхэнэ эзэн нь Тэр болохоос, харин энэхүү махан бие биш. Жинхэнэ эзэн

нь маш өндөр түвшинд байж, тэндээс энэхүү махан биеийн бүх үйл ажиллагааг удирддаг. Заримдаа Тэрээр махан биедээ буцаж ирнэ, заримдаа ирэхгүй. Энэхүү махан бие нь машинтай адил, эзнийхээ зааварласнаар хийнэ.

UFO (үл мэдэгдэх нисдэг биет) эсвэл нисдэг таваг манай дэлхийд ирдэг тухай бид сонсож байсан. Зарим хүн түүнийг харсан байдаг. Сансрын уудмаас ирсэн хүн өчүүхэн жижиг биетэй, толгойноосоо хөлөө хүртэл битүү хувцасладаг. Тэд эргэн тойрныг ажиж юм бичиж тэмдэглэн, манай дэлхийн байдлыг лавлан танддаг. Бид тэднийг тэнгэрийн төрөлтөн, асури, эсвэл ямар нэг дээд түвшний хүн гэж боддог. Тийм биш ээ! Өндөр түвшнээс ирсэн хүн бол тун үзэсгэлэнтэй. Тийм намхан жижиг байдаггүй. Алхаж гишгэх нь ч тийм байдаггүй, ганцхан нүдээ гаргачихаад битүү хувцаслахгүй. Эд бол тэнгэрийн төрөлтөн биш.

Тэнгэрийн төрөлтөн маш гоо үзэсгэлэнтэй. Багшийг нь ном тайлж байх үеэр, эсвэл долоо хоногийн даяаны үеэр тэд ирж намайг хардаг. Миний шавь нарын зарим нь тэднийг олж харсан. Тэд их үзэсгэлэнтэй, гоё сайхан хувцастай байдаг. Тэд бол жинхэнэ тэнгэрийн хүн юм. Нисдэг тавгаас бууж ирсэн хүний тухайд бол үнэндээ хүн биш робот. Тэрхүү нисдэг тавгийг заавал хүн жолоодох албагүй, робот ч жолоодож болно. Нисдэг таваг хаа нэгтээ буусны дараа робот гарч ирээд, орчин тойрныг ажиж, мэдээлэл цуглуулдаг болохоос тэнгэрийн хүн өөрөө нисдэг тавагт суугаад ирдэг юм биш. Мэдээж, заримдаа өөрсдөө хүрээд ирдэг. Сүүлийн үед тэрхүү дээд түвшний хүмүүс хүрч ирсэн нь бий. Гэвч тэднийг эгэл хүний нүд харах боломжгүй.

Бурхан болсон хүн ч бас адил. Тэр өдөр бүр энэ биедээ оршдоггүй. Тэр эрх чөлөөтэй, эрх тааваараа орчлон ертөнцөөр зугаалж, аль ч газар, ямар ч түвшинд оршин байдаг. Иймд түүнийг “Түүнчлэн ирсэн” гэнэ. Түүнчлэн ирж, түүнчлэн одно гэдэг нь ирэхгүй, очихгүй, оршихгүй газаргүй бөгөөд ирэх шаардлагагүй. Гэвч хаана ч, ямар ч түвшинд Түүнийг харж болно. Тийм хүнийг эрж олох тун амаргүй. Хэрэв бид түүнийг ертөнцөд саатаж байхад нь таарвал Бурхан, Бодьсадва гэж дээдлэн хүндэлдэг. Гэвч тэр өөрийгөө Бурхан, Бодьсадва гэхгүй. Жинхэнэ Бурхан, Бодьсадва өөрийгөө Бурхан, Бодьсадва гэж боддоггүй. Гэвч энэ ертөнцийн хэлээр өгсөн нэрээр нь, эсвэл ном сударт бичсэнтэй харьцуулж байж л бид түүнийг Бурхан, Бодьсадва мөн болохыг нь таньдаг. Иймээс шавь нар нь түүнийг Бурхан, Бодьсадва гэж магтдаг болохоос, өөрөө тэгж ярихгүй. Хожим амнаас ам дамжсаар олон хүн мэддэг болно.

Бид ертөнцөд саатаж буй Бурхан, Бодьсадватай учирч Түүнийг үнэхээр хайрлан хүндэлбэл жинхэнээсээ их буян хишигтэй болно. Жишээ нь, Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийдэг хүн Багшаа хүндэтгэн хайрлахгүй бол түүний дэс нь дээшлэхгүй. Хамгийн ихдээ зөвхөн гурван ертөнцийн доторх гуравдугаар ертөнцөд л хүрнэ. Энэ ертөнцөд хэдийгээр үйл түйтгэр байхгүй ч хэзээ нэгэн өдөр сөнөж мөхнө. Учир нь гурван ертөнцийн доторх нь бүтэх, орших, эвдрэх, хоосрохын түвшинд байдаг. Гурван ертөнцийг давсан цагт үүрд туулан гэтэлнэ.

Иймээс бид өнгөрсөн цагийн Бурхан, ирээдүйн Бурхан, эсвэл төгс баясгалант орны Бурханыг хайрлаж, өдөр бүр Түүний нэрийг дурсаад харин ертөнцөд морилж буй Бурханыг хүндлэн хайрлахгүй бол ямар ч нэмэргүй. Учир нь ертөнцөд саатаж буй Бурхан бол хамгийн сайн замч бөгөөд Тэр биднийг гурван ертөнцөөс дээш гаргаж чадна. Гэтэл бид түүнийг дагалгүй, өнгөрсөн цагийн замчийг дуудан залбираад байвал ямар тус байх вэ? Бид идэж уухгүй, тоглож наадахгүй, унтаж хэвтэхгүйгээр газар сөгдөн Авид бурханыг түмэнтээ дуудан залбиравч, Тэр биднийг дагуулж явахгүй. Гэтэл амьд сэрүүн Бурханд хоромхон зуур ч гэсэн үнэнхүү итгэвэл Тэр бидэнд тусалж, хүлээсийг маань таслан дор нь гэтэлгэнэ. Бидний дэс тэр даруй туулан гэтлэх түвшинд очих бөгөөд үүнийг бид мэдэж ч магадгүй, мэдэхгүй ч байж магадгүй. Мэдэх эсэх нь бидний түвшингээс шалтгаална.

Жишээлбэл, Багш нь одоо байшингийн хамгийн дээд давхарт ном тайлж байна. Та нар хаалганы цаана зогсож байгаад Багштайгаа уулзъя гэж бодвол хэн нэгэн таныг жаахан угзрахад л Багшийгаа тэр даруйдаа харна. Хэрэв та нар дөнгөж нэг, хоёрдугаар давхарт байгаад хэн нэгэн таныг дээш татвал зөвхөн гуравдугаар давхарт л хүрэх тул Багшийгаа харж чадахгүй. Дөрөвдүгээр давхарт очсон ч ахиад нэг давхар өгсөж байж энд ирнэ. Иймээс заримдаа жинхэнэ Их Багшийг харангуут бидний билиг даруй нээгддэг. Уг нь ийм байвал зөв. Авшиг уламжлаагүй байхад билиг нь хэдийнээ нээгдчихдэг. Гэвч зарим хүний дэс нэлээд доогуур. Ялангуяа ном балрах цагт хамаг амьтны үйл түйтгэр маш их тул Бурхан, Бодьсадва ихээр адисалж, илүү дээш татвал билиг нь нээгдэнэ. Авшгийг заавал уламжлах хэрэгтэй. Зарим хүн Багшийг харангуутаа билиг нь нээгдэж, тэр даруйдаа билиг нээгдэх үеийн ахуй ойлголттой болдог. Гэвч мөн л ном уламжлах хэрэгтэй. Учир нь зөвхөн ном уламжилж байж л цаашид сүнслэг дадал бясалгал хийх боломжтой болно. Энэхүү зам их урт бөгөөд билиг нээгдмэгц Бурхан болчихдог юм биш. Билиг

дөнгөж нээгдэхэд зөвхөн бяцхан Бурхан болох бөгөөд энэ нь нялх хүүхдийг сүү, будааны зутан өгч байж өсгөдөгтэй адил.

Шагжамуни Буддаг ертөнцөд заларч байх үед түүний нүдэн дээр хэдэн хүн тамд унасан гэдэг. Учир нь тэдний дэс хэт доогуур, Буддаг хүндэлдэггүй, амьд Буддагийн чухлыг ойлгоогүй. Тэд зөвхөн Эсэрваа тэнгэр юм уу, өөрсдөө олж үзээгүй сахиус эсвэл ном сударт бичсэн сахиуснуудыг хүндэлдэгтээ сэтгэл нь ханаад, өөрсдийгөө сүрхий гэж боджээ. Иймээс Шагжамуни Будда ч тэднийг аварч чадаагүй.

Энэтхэгт шавь нар нь багшийгаа, Эзэн Бурханаас ч илүү магтан сайшаадаг. Учир нь Эзэн Бурхан тэднийг энэхүү ертөнцөд илгээж, зовлон амсуулж байхад, харин амьд сэрүүн Багш дагуулж, туулан гэтэлгэж, энэхүү сансрын хүрднээс ангижруулдаг. Иймээс тэд Эзэн бурханыг бус, Багшийгаа хамгаас дээдлэн хүндэтгэдэг. Тэд Эзэн Бурханыг зориуд гүтгэсэндээ ийн хэлж байгаа биш, харин Багшийгаа үнэхээр хүндэтгэн хайрладгаас тэр юм.

Тэдний ингэж ярьдаг нь буруугүй. Учир нь Эзэн Бурхан байдаг юм бол яагаад ирж биднийг авардаггүй юм бэ? Яагаад бидэнд ийм их зовлон амсуулдаг юм бэ? Зөвхөн багш л бидний зовж буйг, биднийг үхэж төрөхийн орчилд эргэлдэж байхыг хараад дээш дагуулан явахыг даруй зөвшөөрч, төгс баясгалант орон, хамгаас баяр баясгалантай, хамгаас туулан ангижирсан ертөнцөд аваачдаг. Зөвхөн амьд сэрүүн Багш л зөвшөөрдөг болохоос Эзэн Бурхан юу ч зөвшөөрдөггүй, юу ч ярьдаггүй. Эзэн Бурхан оршдог эсэхийг, Эзэн Бурхан байдаг эсэхийг бид мэддэггүй. Гэтэл бид нэгэн амьд сэрүүн Багш байдгийг, Түүнтэй холбогдвол биднийг дагуулан туулан гэтэлгэнэ гэдгийг мэддэг. Энэ маш чухал, үүнийг мартвал бясалгал дадуулахад нэлээд бэрх болно.

Хэн нь Бурхан, хэн нь Бодьсадва болохыг танихад хэцүү. Бид өөрсдийгөө ухаантай, ихийг мэддэг гээд өөрийн хүчинд найдах нь хангалттай гэж боддог. Энэ нь буруугүй! Бидэнд хүч байдаг, бидэнд юм юм байдаг нь үнэн. Гэвч энэхүү хүч чадлаа хөгжүүлэхээс өмнө, хэдийнээ хөгжүүлчихсэн нэгний тусламжид түшиглэх хэрэгтэй.

Хүүхдийг хөлд ороход нь аав, ээж нь хөтлөх хэрэгтэй байдаг. Хоёул дундаа хөтлөх юм уу, эсвэл аль нэг нь хоёр гараас нь түшиж, аажимхан нэг нэгээр алхуулна. Ийнхүү тэнтэр тунтар хийсээр байж хүүхэд аажмаар хөлд ордог. Гэвч энэ үед ч гэсэн хүүхдийг аав ээж нь дагуулж явах хэрэгтэй. Учир нь, ойрхон зайд хүүхэд өөрөө дажгүй алхах боловч, хол бол аав, ээжээрээ тэврүүлэх хэрэгтэй. Юм үзэхээр юм уу зугаалахаар явахад хүүхэд

замын хагаст ядарчихаад, тэврүүлнэ гэж уйлагнана. Тэврэхгүй бол явж өгдөггүй болохоор, тэвэрч л явна. Эсвэл машин, унадаг дугуй, мотоцикл, таксины аль нэгээр авч явах хэрэгтэй болно.

Дөнгөж сүнслэг дадал бясалгал хийж эхэлж байгаа хүн үүнтэй адил. Хэрэв хүндэтгэх сэтгэлгүй, даруу зангүй бол дадал бясалгалдаа дэвших нь тун удаан, зовлонтой, саадтай байх болно. Энэ бол өөрөө өөртөө саад болж буй хэрэг. Зарим үед Багш нар ийм байдлыг хараад тусалъя гэж их боддог ч бид хаалгаа түгжчихээд Багшийгаа сонсдоггүй, татаж авъя гэсэн ч гараа өгдөггүй. Энэ үед Багш нь ярилцаж чаддаггүй болохоор аргагүйдэж, өөрийнх нь хичээлийг өөрөөр нь хийлгэх хэрэгтэй болдог. Бид Англи хэл сурахдаа эхэндээ ярьж чаддаггүй болохоор, өдөр бүр багштайгаа, эсвэл ангийнхантайгаа дасгал хийх, эсвэл англи ном унших хэрэгтэй. Багштайгаа хэдий чинээ хамт байна, төдий чинээ англиар сайн ярьдаг болно. Зөвхөн англи хэл сурахад ийм хэцүү байхад, Бурхан болохын тулд Бурханы хүчинд түшиглэхгүйгээр биедээ найдаж, өөрийн Бурханаа харж чадах уу?

Одоо Бурханы тухай ярьж байгаа нь Бурханыг магтан сайшааж байгаа явдал бөгөөд өөрийгөө Бурхан гэж хэлж буй хэрэг биш. Би ингэж яриагүй. Гэтэл тийм Бурхан байвал бид түүнийг заавал хүндэтгэн хайрлах хэрэгтэй. Ингэвэл бидэнд тустай. Ном тайлсан эхний өдрөөс өдийг хүртэл Багш нь Бурханыг, Арьяабалын бясалгалын аргыг, энэхүү Бүтээгчийн их хүчийг, угийн хүчийг танилцуулж ирлээ. Эдгээрийн заримыг ном судраас, заримыг нь багшаасаа сурч мэдсэн бөгөөд зарим нь миний ахуй ойлголт юм. Та нарт ингэж ярьж байгаа нь биеэ хүндлүүлэх гэсэндээ биш. Та нар өөрсдийнхөө Бурханыг эрж олбол хамгийн сайн.

Гэвч та нар өөрсдийнхөө Бурханыг эрж олъё гэвэл аль замаар явахаа мэдэх хэрэгтэй. Замаа мэдье гэвэл, би та нарт хэлж өгч болно. Зарим хүмүүс мэдэх гэж яараад хэд хэдэн удаа асуучихлаа. Хэрэв та нар долоо хоног ном сонсоод замаа мэдэхийг хүсэж байвал өнөөдөр нэрээ бүртгүүлж болно. Гэвч та нар чин сэтгэлтэй, үнэхээр гэгээрлийг олохын төлөө, үнэхээр туулан гэтлэхийн төлөө байх хэрэгтэй. Сонирхох төдий байж болохгүй. Учир нь Бурхан, Бодьсадва бидний сэтгэлийг мэддэг юм. Хэрэв бид чин сэтгэлгүй бол Бурхан, Бодьсадваг гүтгэсэн, өөрийгөө ч гүтгэсэн хэрэг болно. Хэрэв та нар олон удаа ном сонсож, энэхүү бясалгалын аргыг ойлгон, Багшийнхаа юу заасныг мэдсэн бол одоо нэрээ бүртгүүлж болно.

Асуулт: Багш аа, тахианы өндөг махан хоол уу, цагаан хоол хоол уу?

Их Багш: Өндөг бол цагаан хоол биш. Бясалгал хийж эхэлж байгаа хүн тэсэхгүй бол ганц хоёр өндөг идэж болно. Цаашдаа бүрэн хорих хэрэгтэй. Учир нь өндөг идвэл бясалгал дадалд муугаар нөлөөлдөг. Өндөг амьтны хэвлийгээс төрсөн. Өндөг байхгүй бол тахиа байхгүй. Иймээс өндгийг амьтанд тооцдог. Өндөгний дотор амь агуулагдаж байдаг. Зарим өндөг эр эсийг аваагүй ч хагас амьтай байдаг. Эр, эм эс нийлэхгүйгээр тахиа төрөхгүй, дан эсээр ангаахай бүрэлдэхгүй. Иймд эр эс аваагүй өндөг нь шалтгаан, барилдлага бүрэлдээгүй төдий болохоос түүнийг амьгүй гэж хэлж болохгүй.

Асуулт: Багш аа, тарни уншихдаа тарнийн дууг нь сонсох хэрэгтэй юу, утгыг бодох хэрэгтэй юу?

Их Багш: Буруу байна. Энэ бол Арьяабалын бясалгалын арга биш байна. Чи ямар аргаар бясалгал дадуулдгийг би мэдэхгүй. Манай бясалгалын арга тарни уншдаггүй. Сонсдог аялгуу нь гадаад ертөнцийн дуу аялгуу биш. Зөвхөн гаднах зүйлийг хөөцөлдөөд нэмэргүй. Тарнийн утгыг бодох хэрэггүй, дууг нь чагнаад ч нэмэргүй. Гэвч та өөрийн дурааараа бол. Бидний заадаг нь өөр бясалгалын арга.

Асуулт: Багш аа, миний дадал бясалгал гуравдугаар ертөнц дээр тогтсон байгаад би Багшаас өмнө ангижирвал, та намайг дээш татах уу?

Их Багш: Татна аа! Багш нь зөвхөн энэ бие махбод биш, одоо гуравдугаар ертөнцөд ч бас байгаа. Яалаа гэж зөвхөн ангижирсныхаа дараа тийш очих вэ? Чамайг дээш таталгүй яах вэ. Багш нь чамайг тэнд хэдийнээ хүлээж байгаа. (*Хүмүүс инээв.*) Багш нь ангижирсныхаа дараа л шавь нараа дээш татдаг юм биш. Тэгдэг бол та нар үхэж зориглохгүй. Би маргааш амиа хорлочихвол (*Хүмүүс инээв.*) та нарт аюулгүй санагдах нь ээ дээ. Багшийнх нь зарим шавь ная хүрсэн. Тэгэхээр аюултай гэж үү? Настай хүн намайг дагах зориггүй болох нь. Багшаасаа түрүүлээд ангижирчихвал та нарыг дагуулах хүнгүй яах вэ гэж үү?

Багш нь энэ бие махбодоороо та нарыг дээш дагуулахгүй. Энэ ертөнцөд энэ бие махбодыг хэрэглэнэ. Нэгдүгээр ертөнцөд нэгдүгээр биеэ хэрэглэнэ, хоёрдугаар ертөнцөд бусад биесээ хэрэглэнэ. Аль ч ертөнцөд Багш нь байж байдаг. Дотоодын багш гаднах биеэсээ үзэсгэлэнтэй. (*Багш хэрэв урьдаар ангижирвал биднийг дээр хүлээж байх уу?*) (*Хүмүүс инээв.*) Одоо хэдийнээ хүлээж байгаа. Яалаа гэж ангижирчихаад хүлээж байх вэ? Чи аль ч ертөнцөд ялгаагүй Багшийгаа олж харна. Тийм үү? (*Тийм.*) Тэгээд яагаад ийм тэнэг асуулт асууж байгаа юм бэ? (*Хүмүүс*

инээв.) (*Би бүгдийг төлөөлж асуусан юм.*) Би мэдэж байна, гэвч битгий ингээрэй. Энэ бол дотоодод хамаарах зүйл болохоор чамайг ингэж асуувал Багшийг нь хэн болохыг бүгд мэдчихнэ. Энэ чинь л таагүй байна.

Асуулт: Жирийн үед төдийлөн анхаардаггүй байсан зүйлс арав хорин минут бясалгасны дараа санаанд ороод ирдэг. Яагаад тэр вэ?

Их Багш: Урд нь та тэдгээр зүйлтэй холбоотой байсан учраас одоо чамтай мэндлэхээр ирж байгаа нь тэр. Сэтгэлээ төвлөрүүлбэл байхгүй болчихно. Сэтгэл их үймэрвэл тэгдэг юм. Жишээлбэл, энэ өрөөнд хүн амьдардаггүй бол хэн нэг нь ирж таарна. Хүнтэй байвал ирж, юм хулгайлахыг зүрхлэх хүн байхгүй. Бясалгал хийх үед сэтгэлээ төвлөрүүлэхгүй бол оюун ухаанд олон юм орж ирнэ. Дадал бясалгал илүүхэн хийвэл асуудалгүй болно. Долоо хоногийн даяанд олон удаа суу.

Асуулт: Олон ном сударт тэмдэглэснээс үзэхэд, зарим хүн Чин улсын Иньгуан Их Багш мэт номын багш нарын аргаар Бурханыг дурсан залбирвал ариун оронд хүрч чадна гэнэ. Энэ үнэн үү?

Их Багш: Та нотолсон юм уу? (*Би мэдэхгүй*.) Тийм амар биш. Нэгдүгээр ертөнц бол асурийн орон бөгөөд, тэнд төгс баясгалант орон "гэгч" хаа сайгүй байдаг. Хэрвээ бид жинхэнэ төгс баясгалант орныг мэдэхгүй бол Маяад амархан хууртагдана. Үнэндээ бид дөнгөж нэгдүгээр ертөнцөд хүрсэн төдий болохоор хоёр, гуравдугаар ертөнцийн тухайд дурдсаны ч хэрэггүй. Нэгдүгээр ертөнцөд хүрсэн ч, түүний үзэсгэлэнт сайхан байдал нь тэрхүү төгс баясгалант орон байна гэж андуурахад хүргэнэ.

Гэвч Авид бурханд залбирах нь буруугүй. Юм асуухаар ирсэн хүмүүсийн түвшин хамгийн дээд бясалгалын аргаар бясалгал дадуулах хэмжээнд хүрээгүй нь харагдвал Авид бурханд залбираарай гэж тэдэнд хэлдэг. Ганцхан Иньгуан Их Багш л Бурханд залбирахыг заасан юм биш. Иньгуан Их Багш өөр аргаар бас бясалгал дадуулж байжээ. Гэвч өргөнөөр ном уламжлаагүй болохоор та мэдэхгүй байна. Хэрэв Тэр зөвхөн "Авид бурханд мөргөмүй." гэж уншдаг байсан бол яалаа гэж Пүтүөшань ууланд нуугдаж арван жил бясалгал дадуулах хэрэгтэй болсон байх вэ? Юунд гэртээ "Авид бурханд мөргөмүй." гэж уншиж суулгүй заавал Пүтүөшань ууланд очиж унших билээ? Түүний бясалгах нь тун хичээнгүй.

Өвгөн хувраг Гуан Чин удаан хугацаагаар зүдрэн бясалгал

дадуулж байж өндөр дэсийг олсон. Түүний дэс ямар байсныг би мэдэхгүй. Гэвч дор хаяж архадын хутгийг олсон байх. Учир нь тэр, барсыг сайн санаатай болтол нь номхотгодог байсан. Энэ бол архадын онцгой чадвар юм. Түүний бусад хүч чадлын тухай би яриад яах вэ. Архадаас ч дээгүүр байсан байж магадгүй. Ийм хүн хүртэл тийм хатуужилтайгаар сүнслэг дадал бясалгал хийж байж ариун оронд хүрсэн байхад, нэгэн гэрээс гараагүй хүн хэдхэн өдөр Бурханы алдрыг дурсан уншаад яаж Бурхан болж чадах вэ?

Бид Арьяабалын аргаар бясалгал дадуулдаг. Миний шавь нарын дотор гэрээс гараагүй нь гэрээс гарагсдаас олон байдаг. Шагжамуни Будда амьд сэрүүн байхдаа гэрээс гараагүй олон шавьтай байсан. “Баатараа явагч их хөлгөн судар”-т хорин таван Бодьсадва өөрсдийн дадал бясалгалын ахуй ойлголтоо ярьсан байдаг. Тэдний ихэнх нь гэрээс гараагүй хүмүүс байсан. Арьяабалын аргаар бясалгал дадуулахыг хүсдэггүй хүмүүст би Бурханд залбирахыг заадаг. Залбирах нь залбираагүйгээс дээр. Дор хаяж сэтгэлээ тогтуун байлгана. Гэвч хамгийн төгс нь биш. Бурхан болж, төгс баясгалант оронд очиж чадахгүй.

Асуулт: Хүн төрөхдөө анхны ялтайгаа төрдөг гэж Библид дурдсан. Энэ нь бидний урьд төрлийн үйлийн үрийг хэлж байна уу?

Их Багш: Зөв! Бидний урьд төрлийн үйл үрээс гадна хамтын үйлийн үр гэж бас бий. Өвөг дээдсийн гэм нүгэл бол хамтын үйл үр мөн. Бид аав, ээжтэйгээ хамт амьдарч, тэд биднийг тэжээж байгаа нь бидний хамтын үйлийн үр болно. Хэрэв манай өвөг дээдэс ёс суртахуунгүй хэрэг үйлдсэн байгаад тэдний өмчийг өвлөн хэрэглэвэл бид өвөг дээдсийнхээ гэм нүглийн нэгэн хэсгийг нь амсах болно. Анхны ял, хамтын үйл үр, эсвэл анхны үйл үр гэдэг нь адил утгатай.

Асуулт: Багш аа “Найман сахил”-ын учрыг ярьж өгч болох уу?

Их Багш: Түүний утга нь та нарыг ганцхан өдөр ч атугай амсхийлгэхэд оршино. Учир нь та нар өдөр бүр сахил сахидаггүй. Найман сахилыг Арьяабалын бясалгалын аргатай хамтад нь бясалган дадуулвал ач тустай. Жишээ нь, бид долоо хоногийн юм уу гурав хоногийн даяанд суухын учир бол Багшийн шавь нар энэхүү гурав юм уу долоо хоногийн дотор ертөнцийн алив зүйл, эр нөхөр, эхнэр хүүхэд, утас шөрмөс, садан төрөл, найз нөхөд, арилжаа наймаа бүгдийг огоорч, ууланд гаран Багштайгаа хамт нэгэн сэтгэлээр бясалгал хийхэд оршино. Үүнд Багшийн шавь нар л оролцдог. Энэ үед л жинхэнэ ёсоор сахил сахисанд

тооцогдоно.

Амаараа юу ч ярихгүй, чихээрээ хов жив сонсохгүй, нүдээрээ элдэв бусыг үзэхгүй болохоор тэр хэд хоногт сахилаа жинхэнээр маш тодорхой сахидаг. Тэр үед сахилыг аяндаа сахина. Яагаад гэвэл хамтдаа нийтийн бясалгал хийх учир хов живгүй, ярих юм, хэрүүл маргаан үгүй болохоор аяндаа сахилаа сахиж, аяндаа Бурханыг "дурсан", ном судар уншина. Оройдоо Багш нь ном тайлах тул энэ нь та нарын "амьд" ном судар унших цаг болно. Багш нь бясалгал хэрхэн яаж дадуулахыг өглөө та нарт сануулна. Та нарын бясалгал хийхийг харж байгаад, хаана нь, ямар заавар зөвлөгөө хэрэгтэй байгааг би даруй хэлж өгнө. Эсвэл хүмүүсээр өөрсдөөр нь яриулна. Ингэвэл найман сахилыг жинхэнээр бясалгаж буй явдал болно.

Гэвч Төгс Гэгээрсэн Их Багшийг ангижирсны дараа ном уламжлах хүнгүй болбол бүгд ном судар үзэх төдий л болно. Хүмүүс гурав хоногийн даяанд суухдаа юм ярихгүй, ном сонсож, ном судар уншиж байхыг хараад, гурав хоногийн даяан чинь ийм л юм байна гэж бодоход хүрнэ. Учир нь Төгс Гэгээрсэн Их Багшийн зааваргүй болохоор даяаны утга учрыг ойлгохгүй. Найман сахилыг сахиж чадсан бол нэг өдөр амарсан хэрэг, дажгүй дажгүй. Ингэвэл буян хишиг багатай, хүн, тэнгэрийн өчүүхэн буянтай ч үүнээс дээших ач буянгүй. Зөвхөн сэтгэлийг чинь тайтгаруулж, уйтгар бухимдлыг багасгана. Учир нь өдөржин Бурханыг бодоод ертөнцийг бодохгүй, хүнтэй ч ярихгүй болохоор хэл ам, хэрүүл тэмцэл багасна. Гэвч гэгээрч, билиг нээгдэх аргагүй. Иймд найман сахил сайн хэдий ч онцын их ач буянгүй.

Асуулт: Багш аа, миний уншсан номд Английн нэг доктор Энэтхэгт ирээд нэгэн багштай таарсанд, тэр түүнийг дагуулан агуйд хамт бясалгажээ. Агуйд биеэсээ гэрэл цацруулсан хүнийг доктор харсанд тэрээр өөрийгөө Махакашья гэсэн гэнэ. Энэ үнэн үү?

Их Багш: Би мэдэхгүй. Нүдээрээ үзэж байж мэднэ. Иймэрхүү зүйлийг би сонирхдоггүй. Зарим хүн бясалгал дадуулсны дараа гэрэл цацруулдаг. Миний шавь нарын дотор ч гэрэл цацруулдаг хүн байна. Заавал Хималайн уулны харанхуй агуйд очиж, бусдын гэрэл цацруулахыг харах хэрэг юу байна? Та нар харахгүй л байгаа болохоос энд ч гэсэн гэрэл цацруулдаг хүн байгаа. Агуйд очсоны хэрэггүй. Тайбэй хотын хамгийн хөл хөгжөөнтэй газар ч чамд гэрэл цацруулан үзүүлэх хүн байна. Тэд Багшийг нь дагаад жил гаруй болж байгаа. Хэд хэдэн хүн ганц хоёр сар сурч байгаа боловч бас л гэрэл цацруулж чадна. Ганцхан Махакашъя л гэрэл

цацруулдаг юм биш. Гэрэл цацруулахад тийм удаан бясалгал хийх шаардлагагүй. Шагжамуни Буддагийн үеэс өнөөдрийг хүртэл хоёр мянга таван зуу гаруй жил бясалгал дадуулчихаад гэрэл цацруулах төдийд л хүрдэг юм бол бясалгаад яах вэ.

Уулын агуйд тэр юу хийж байгааг нь би мэдэхгүй. Яагаад гарч ирж, хамаг амьтныг гэтэлгэдэггүй юм бэ? Хамаг амьтан тийм зовлонтой байхад харин тэр өчүүхэн гэрэл цацруулаад тэнд сууж байдаг. (*Хүмүүс инээв.*) Тийм Бурханд мөргөх хэрэггүй. Энд байгаа амьд Бурхдад мөргөх нь илүү нэмэртэй. Ном тавьж байгаа энэ газарт миний шавь нараас гэрэл цацруулдаг хүн бас хэд хэд байна. Тэгэхлээр иймэрхүү зүйлийн үнэн эсэхийг хайхраад хэрэггүй, бидэнд тус нэмэргүй. Тэр хүн хэнтэй таарсныг би мэдэхгүй. Зарим хүн өөрийгөө урьд цагийн хэн нэгэн их бясалгалтан гэж тоглоом наадам хийсэн ч байж мэднэ. Гэвч миний бодоход тэр Махакашъя юм бол харанхуй агуйд өчүүхэн гэрэл цацруулан суух биш, агуу хүн байх ёстой.

Асуулт: Хэрэв бид оройн дээд Эзэн Бурханд эрхшээгдсэн бол энэ байдлаа өөрчлөх аргагүй. Тийм үү?

Их Багш: Үгүй. Бид өөрчилж болно. Учир нь бидэнд "Чөлөөт зориг санаа" (Free Will) бий. Бид сайн мууг мэднэ. Бид сайжирч муудаж болно. Тийм биш бол бясалгал дадуулах хэрэггүй. Өчигдөр Багш нь хулсан баганын тухай ярьсан. Энэхүү баганаар дээшээ авирч, бас доошоо гулсаж болно. Эзэн Бурхан, эсвэл хамгийн дээд Бурхан гэж байдаг нь мэдээж. Гэвч бид өөрчлөгдөж болно. Хэрэв энэхүү хамгийн дээд, хамгийн язгуурын зүйл байхгүй бол бид хаанаас ирэх вэ? Ийм анхдагч зүйл байхгүй байсан ч үнэн хэрэгтээ хамаагүй. Бид агуу хүн болчихвол болно шүү дээ. Эзэн Бурхан байдаг эсэх талаар дараа ярья.

Одоо хамгийн чухал нь бид өөрсдийгөө өөрчилж, энэхүү ертөнц дээрх төгс төгөлдөр, бүхий л орчлонг ухаарч ойлгодог, түүнчлэн ирж, түүнчлэн оддог нэгэн болгох хэрэгтэй. Хэн нэг нь бидэнтэй адил болохыг хүсвэл түүнийг дагуулж чаддаг болох нь бидний гол зорилго. Эзэн Бурхан байдаг эсэхэд бүү анхаар. Энэ бидэнд хамаагүй. Эзэн Бурхан байлаа ч гэсэн одоо бидэнд тусгүй. Учир нь бид мөргөж гуйсан ч Тэр сонсохгүй. Сонсдог бол дэлхий тийм их зовлонтой байх ёсгүй. Зовлонд дуртай хүн байдаггүй болохоор тэд өдөр бүр Эзэн Бурханаас тусламж гуйдаг. Гэвч Эзэн Бурхан туслахгүй, зөвхөн Багш л тусалдаг. Юу ч байсан Багшид залбирвал хурдан. Харин Эзэн Бурхан удаан, чих нь хатуу, Арьяабалын аргаар бясалгал дадуулаагүй. (*Хүмүүс инээв.*)

Иймд Эзэн Бурхан байдаг эсэхийг хайхраад хэрэггүй.

Оройн дээд Бурхан байдаг эсэх нь чухал биш. Бид өөрсдийнхөө хэрэг явдлыг л анхаарах хэрэгтэй. Бид өөрчлөгдөж, сайн хүн, агуу төрөлтөн, ид шидтэй, эрх дурааараа, маш хүчтэй, хүрье гэсэн газартаа хүрч, аваръя гэсэн хүнээ авардаг болох хэрэгтэй. Ингэж чадвал утга учиртай болно. Олон хүн зовж байхыг хараад туслах арга байдаггүй. Иймээс бид хүчтэй том төрөлтөн болж өөрчлөгдөөд тэрхүү зовж зүдэрсэн хүмүүст туслах нь бидний гол зорилго. Энэ Бурхан энэ тэрийн тухайд хайхраад хэрэггүй.



Бясалгах сайн зорилготой байх хэрэгтэй. Энэ бол хамгийн чухал зүйл. Дээд хүслэн гэдэг нь өөрөө туулан ангижрахаар гуйн хүсэхийн хамт бас хамаг амьтныг гэтэлгэн, үхэж төрөхөөс ангижруулна.

(“Асури төрөлтөн” айлдвараас)



Тайландын ахан дүүс Их Багшийг Ялгуусан эрхт хэмээн угтан авсан нь. Тайланд улс. Чиенмайд ном тайлахын өмнө. 1999.9-р сар.

Эрт дээр үеэс өнөөг хүртэл туулан гэтлэхийг хүссэн хүн хамгийн түрүүнд заавал тийм Их Багшийг хайж олох хэрэгтэй. Учир нь бидний сүнслэг дадал бясалгал дөнгөж эхэлж байгаа болохоор дан ганц өөрийн хүчиндээ найдаж тэр их үйл түйтгэрийг төлж барахгүй. Харин тийм Их Багшийн төрөл төрөлдөө бясалгаж хураасан буян хишиг маш их тул биднийг удирдан замчлахын хамт бидний ачааг үүрч тусална. Учир нь Түүнд хангалттай хүчин чадал байна.

(“Үйл түйтгэр хаанаас үүсэлтэй вэ?” айлдвараас)

ГУРВАН ЕРТӨНЦИЙН ДОТОРХ ТОЙМ БАЙДАЛ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар.
Формосагийн Тайбэй хотын
Цаглашгүй гэрэлт бясалгалын төв.
1987 оны 3 дугаар сарын 11
(Эх нь хятад хэлээр)

Өнөөдөр өөр түвшний тухай ярина. Арьяабалын бясалгалын аргаар бясалгал дадуулдаг хүмүүс ном уламжлах үед маш олон түвшин байгааг мэднэ. Гэхдээ нарийн зүйлсийг энд ярьж болохгүй. Ерөнхийд нь бага сага ярья. Бид эгэл хүний оюун ухаан, үг хэлээр дадуулан бясалгаад хамгийн дээд түвшинд хүрнэ гэж боддог. Хэрвээ хэн нэгэн бясалгал дадуулаад гурван ертөнцөөс хэтийдэх, тэр ч байтугай гурван ертөнцөөс илүү өндөр түвшинд хүрэхэд зам зуур маш олон аюултай урхи занга байгааг харна. Хэрвээ замчлагчгүй, эсвэл Их Багш нар хүчээрээ биднийг хамгаалахгүй бол замдаа ад чөтгөр т хялбархан татагдана. Нэгдүгээр ертөнцөд хүрсэн ч хоёрдугаар ертөнцөд очиж амжилгүй мэхлэгддэг. Нэгдүгээр ертөнц бол асурийн орон. Энэ талаар эхний өдөр Багш нь ярьсан. Өнөөдөр асуриас дээших түвшнийг ярьж өгье.

Асури бол нэгдүгээр ертөнц. Хоёрдугаар ертөнцөд хүрэх үед юутай учрах вэ? Мэдээж хамаг амьтантай таарна. Энэ ертөнцийн амьтад асури төрөлтөнтэй адилгүй сайхан сэтгэлтэй, хэрүүл зодоонд дургүй. Гэвч бас хүн хуурдаг. Яагаад тэр вэ? Их бясалгагчид, их билиг нээгдсэн хүмүүсээс бусад ямар ч шашин, шашны урсгалыг дагагсдын талаас хол илүү хувь нь тэрхүү гурван ертөнцийн доторх “жижиг бурхад”-ыг бишрэн шүтдэг. (Жижиг бурхад нь Эзэн Бурхантай адилгүй. Эзэн Бурхан хамгийн дээд хүчийг төлөөлнө. Бурханы шашны ханьцашгүй үнэхээр туулсан гэдэгтэй адил).

Гурван ертөнцийн доторх эдгээр бурхан нь хамгийн дээд түвшнийх биш бөгөөд олон дэстэй. Бүх шашны наяас дээш хувь нь эдгээр доод дэсийн бурханыг шүтдэг. Иймээс ямар ч шашин

шүтсэн ном уламжлах Төгс Гэгээрсэн Их Багшгүй бол хамгийн сайндаа хоёрдугаар ертөнцөд хүрэх төдий. Асурийн орныг давж чадвал тун сүрхийд тооцогдох ч, хоёрдугаар ертөнцөд хүрээд заавал зогсдог. Яагаад тэр вэ? Учир нь цаашлах зам урт, замчлагчгүй бол бид гурван ертөнцөөс гарах замыг олох боломжгүй.

Энэ ертөнц харанхуй бүүдгэр. Бидний эгэл хүмүүс энд амьдрахад зовлон зүдүүртэй. Бид нэгдүгээр ертөнцөд хүрвэл сэтгэшгүй баяр хөөртэй болдог. Ертөнц бүр өөрийн хамгийн дээд сургаалын эзэн, Дээд бурхантай. Хэрэв бид түүний албатуудтай биш харин хамгийн Дээд сургаалын эзэн, Дээд бурхантай нь уулзвал хязгааргүй баяраар бялхаж, бүхий л хувийн чанар, үзэл бодол, амьдралын хэв маяг маань тэр даруйдаа бүрэн өөрчлөгддөг. Ийм хувирлыг төсөөлөхийн аргагүй. Бид маш их хүч чадалтай болж, билиг ухаан дорхноо нээгдэх тул хамгийн дээд түвшинд хүрлээ гэж боддог. Энэ үед үүнээс илүү дээд түвшин байдаг хэмээн төсөөлж ч чадахгүй болно.

Жишээ нь, энэ дэлхий дээр шүтлэггүй хүн маш олон. Тэд Бурханы болон бусад шашинд, бурхан оршдогт, диваажин байдагт итгэдэггүй. Энэ дэлхий л оршин байдаг, үхсэний дараа юу ч байхгүй гэж тэд үзнэ.

Үүнтэй адил зарим хүн нэгдүгээр ертөнцийн сургаалын эзэнтэй уулзмагц энэхүү орчлонгийн хамгийн эрхэм дээд зорилгоо нэгэнт биелүүлсэн хэмээн боддог. Заримдаа энэ бурхан түүнд: “Эргэж очоод ном уламжилж, сургаалын эзэн бол.”, эсвэл “Шинэ урсгал үүсгэ.” гэнэ. Энэ үед өөрийгөө тэнгэрийн элч юм уу Эзэн Бурханы элч гэж бодоод ийнхүү үйлдэх нь огт буруугүй гэж үздэг. Учир нь тэрээр бусад түвшнийг таньж мэдээгүй. Мартсанаас нэгдүгээр ертөнцийн төрөлтнүүд урт настай, удаан амьдардаг болохоор өөрсдийгөө үхэшгүй мөнхийн оронд байгаа гэж зарим нь боддог.

Хэрвээ нэгэн хүний бясалгал дадал нь үнэхээр сайн маш сайн аргаар бясалгадаг хэдий ч хоёрдугаар түвшинд хүрсэн багштай бол багш нь түүнийг хоёрдугаар түвшинд л хүргэж чадна. Хоёрдугаар ертөнцөд хүрсэн хэн ч өөрийн болоод өрөөлийн хувь заяа, өнгөрсөн, одоо, ирээдүйг мэдэх шидтэй болдог.

Учир нь хоёрдугаар ертөнцөд номын сантай төстэй нэгэн газар бий. Энэхүү номын санд аливаа хүний амьдралын тухай мэдээлэл, амьдралын түүх, насны хэмжээ, үхэж төрөхийн орчилд хэдэн удаа эргэлдсэн, анхны төрөлдөө хэн байсан, ямар ажилтай байсан, ямар сайн болон муу үйлүүдийг хийж байсан, хаана

амьдарч, хэр урт насалсан; хоёрдох төрөлдөө ямар амьтан байсан, ямар улсад байсан, хэдэн жил амьдарсан; түүнчлэн гурав, дөрөв, тав дахь төрөлдөө ингэсэн тэгсэн гэхчлэн бүгдийг тов тодорхой тэмдэглэсэн байдаг. Энэ мэтчилэн өнгөрсөн, одоогийн амьдрал тэмдэглэгдсэн байдаг бөгөөд ирээдүй ч бас тэмдэглэгддэг. Өнгөрсөн, одоог өөрчилж болохгүй, харин ирээдүйг бол болно. Иймээс зарим хүн хоёрдугаар ертөнцөд хүрээд амьдралд нь ямар буруу зүйл байгааг мэдмэгцээ засаж өөрчилдөг.

Жишээ нь, олон багш нар өөр аргаар бясалгаж, мацаг хоол ч идДэггүй байжээ. Учир нь шавь нараа мацаг хоолтон байхыг шаарддаг багш тун цөөн байдаг. Мах иддэг хүн сайндаа хоёрдугаар ертөнцөд хүрдэг тул тэр хүн өөрийн амьдрал, үйлийн үрийн холбоог харж ойлгоод даруй цагаан хоолтон болно. Учир нь энэ үед сайн, муу бүх үйлээ ойлгон, өчүүхэн мах идсэн ч аймшигтай үр дүн, шийтгэл хүлээж байдгийг ухаардаг. Ингээд хэн ч түүнд анхааруулаагүй хэдий ч аяндаа өөрчлөгддөг.

Хоёрдугаар ертөнц нь үйл үрийн ертөнц тул ямар ч үйл үрийн холбоо болон өнгөрсөн, одоо, ирээдүйгээ бүгдийг мэднэ. Миний шавь нараас ганц хоёр нь эргээд маханд орсон. Цагаан хоол иднэ гэж Багшдаа амласан ч тэсэлгүй мах иджээ. Мах идсэнийхээ дараа бясалгамагц өөрийгөө хаана очсоноо харсан байна. Ганц өндөг идсэн ч байдал тун бэрх болдог. Хэрэв эндүүрч мах идсэн бол үйл үртэй ч тийм хүнд биш. Харин зориуд идвэл шийтгэл нь тун хүнд.

Нэг шавь маань ганц л өндөг идсэн төдий. Тэр өнөөдөр энд байхгүй. Байсан ч нэрийг нь хэлэхгүй, өөрийгөө мэдэж байгаа. Тэр үед Багш нь Иланьд байсан. Түүний бие нь өвдөж, эмчид очиход өндөг идэхийг зөвлөжээ. Уг нь их дуулгавартай хэдий ч намайг эзгүй болохоор эмчийн үгэнд оржээ. (*Хүмүүс инээв.*) Тэр эмч: “Та өндөг идэх хэрэгтэй.” гэжээ. Нэг өндөг аваад “идэх үү, байх уу” гэж удаан бодсоны эцэст идчихжээ. Тэр оройдоо адад чирэгдэж, сүрхий тамлагдсан байна. Тэр салж өгөхгүй байсан тул Багшдаа залбирч, аврахыг гуйв. Багшаас нь өөр түүнийг аварч чөлөөлөх хүн байхгүй.

Иймээс аврахаас өөр аргагүй. Үүнээс болж Багш нь Иланьд ном тайлж байхдаа золтой л үхээгүй. Ном тайлаад нэг өдөр ч бололгүй үргэлжлүүлэх аргагүй болсон. Дэндүү ядарч, их өвдсөнөөс олон цагийг орондоо өнгөрөөж, яг л үхэх гэж буй мэт арайхийн ярьж, хоол ч орохгүй, юу ч хийж чадахгүй болсон.

Тэрээр ийм их төвөг тарьсан мөртлөө Тайбэйд амарч байхад маань ирж дахин үймүүлэв. Гэмээ наманчилж байгаа нь энэ гэнэ.

Багшийгаа ном тайлж байхад төвөг удна, амарч байхад гэмээ наманчилна гэж бас зовооно. Ер нь яах гэж өндөг идсэн юм бэ? Сахилаа зөрчиж, Багшдаа төвөг тариад дараа нь буруугаа гэмшиж байна гэж бас төвөг удна. Иймээс та нар сахилаа зөрчихгүй байвал сайн. Жаахан өндөг идэхэд хамаагүй гэж бүү бод, тун их хамаатай.

Хэрэв энэ ертөнцөөс түргэн хэтийдэж, хурдан Бурхан болж өөрийгөө, төрөл саднаа, хамаг амьтдыг гэтэлгэе гэвэл сахилаа маш чанд тодорхой сахих хэрэгтэй. Бясалгагч хүн юунд ч баригдах хэрэггүй гэж бүү бодоорой, чанд баримтлах зүйл бас байх ёстой. Улс орон бүхэнд хууль дүрэм байдаг. Багш нь Английн харьяат ч, Формосад ирсэн бол хууль дүрмийг нь хүндэтгэх хэрэгтэй. Мэдэхгүй ойлгохгүй гээд сахихгүй байж болохгүй.

Жишээ нь, Англид машин жолоодоход зүүн гарын дүрэмтэй. Формосад ирээд зүүн гарын дүрмээр явбал хэн хохирох вэ? Дүрэм мэдэхгүй гээд дураараа явж болохгүй. Зөрчвөл төвөг учирна. Учир нь энд баруун гарын дүрэмтэй. Би Английн харьяат ч энд заавал баруун гарын дүрмийг дагах ёстой. Бид угаасаа Бурхан тул яасан ч хамаагүй гэх нь буруу. Бид Бурханы ертөнцөд байгаа бол асуудалгүй байх нь мэдээж. Харин энэ ертөнцөд амьдарч байгаа бол эндхийн хууль дүрмийг хүндэтгэн сахих ёстой. Эс бөгөөс бид эндээс хэтийдэхийн аргагүй.

Жишээ нь, Багш нь угаас Англид ажиллаж амьдарч, тэндхийн хууль дүрмийг сахиж байсан болохоор ямар ч асуудалгүй байсан. Харин Формосагийн хууль дүрмийг баримтлахгүй хэрэг хийвэл Англи руу буцаж чадахгүй төдийгүй Формосагийн цагдаад баригдаж, буудан хороолгуулж ч магадгүй. Тэр үед Английн харьяат байгаад ч нэмэргүй.

Иймээс бид гурван ертөнцийг гэтэлье гэвэл заавал сахил, самади, билиг ухааныг бясалгах хэрэгтэй. Өчигдөр Их Багш Хүй Нөнгийн тухай ярьсан. Тэр бол Хятадын даяаны урсгалын зургаадугаар үеийн Их Багш. Тухайн үед хараахан үсээ хусуулж хувраг болоогүй байсан ч номт дээл, бадар аягаа уламжлан авсан байв. Тэрээр мах иддэг хүмүүстэй хамт байсан ч мах идэж зүрхлэхгүй, зөвхөн ногоо иддэг байсан. “Яагаад мах иддэггүй юм бэ?” гэхэд нь: “Гэдэс өвдөнө, ходоод муу, дотор эвгүйрхэнэ, шингээж чадахгүй.” гэдэг байв. Тийм бэрх үед ч Тэр мах идээгүй. Учир нь тэр үед аюулаас дайжин нуугдаж байсан тул “Би бясалгал хийдэг учраас мах идэхгүй.” гэж хэлж чадалгүй, зөвхөн “Гэдэс өвддөг болохоор мах иддэггүй.” гэж байв. Зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн ч сахилыг “чанд баримтлах” шаардлагатай гэсэн

байхад, шаардлагагүй гэж хэлж зүрхэлдэг бид хэн юм бэ?

Магадгүй түвшин нь хэтэрхий өндөрдөөд энэ дэлхийд "унаж ирээд" амарч байгаа юм байлгүй.

Сахилыг чанд баримтлах хэрэггүй гэсэн үзэл даяаныг бясалгадаг хүмүүст байсаар ирсэн. Ингэж болохгүй. Заавал "тууштай сахиж" байж л эрх чөлөөг олно. Үнэндээ тууштай сахиж буй явдал огт биш. Хүн угаас амьтны мах идэж болохгүй, энэ бол байгалийн хууль. Бид үүнийг мэдэхгүй болохоороо л хамаагүй гэж боддог. Мэдсэнийхээ дараа ихэд айж, сахилаа өчүүхэн ч зөрчихгүй, том үг хэлж, онгирч зүрхлэхгүй болно. Иймээс сахил, самади, билиг ухаан их чухал. Сүнслэг дадал бясалгал хийе гэвэл цэвэр ариун байх ёстой. Одоо ойлгов уу? Мөхөөлдөс идмээр байна уу? Мөхөөлдөс бол зүгээр, өндөг ороогүй, харин өндөгтэй бялуу бүү ид.

Хоёрдугаар ертөнцийн төрөлтөн нэгдүгээр ертөнцийнхөөс илүү хүчтэй. Тэднийг давж илүү өндөр түвшинд хүрье гэвэл тэд чамайг саатуулан зовооно. Асурийнхнаас ч хэцүү. Багш нь Хималайд бясалган дадуулж байхдаа ад шүглэсэн нэгэн хүнтэй хамт амьдарч байсан. Тэр өдөр бүр үүрийн дөрөв, таван цагт босно. Би ч тэр үед босож, түүнтэй хамт залбирал хийдэг байв. Тэр Do Re Mi Fa So гээд элдэв өнгөөр унших нь айдас хүрмээр. Заримдаа өндөр дуугаар уншина, заримдаа нохой хуцах шиг болно. Тэр дуу нь "тун сонсголонтой!" (*Хүмүүс инээв.*) Гадуур дуу хуур дүүрэн болохоор Арьяабалын аргаар бясалгал хийх шаардлагагүй. (*Хүмүүс инээв.*) Түүний ад нь шалихгүй жижиг биш харин хоёрдугаар ертөнцийн ад байсан бөгөөд тэднийг тэнгэрийн хүн, тэнгэрийн сахиус гэдэг ч бас л ад юм. Гурван ертөнцийн доторх нь бүгд ад болно.

Хэрвээ бид орчлонг хулсан баганатай зүйрлэвэл дээд хагас нь аргад, доод хагас нь билигт харьяалагдана. Гурван ертөнцийн доторх нь билгийн хэсэгт харьяалагддаг. Даогийн шашинтнууд үүнийг арга, билиг гэдэг. Арга нь дээд тал, билиг нь доод тал болно. Хоёрдугаар ертөнц бас л билгийн хэсэгт харьяалагддаг тул тэднийг ад чөтгөрт тооцдог. Үнэндээ ад гэхэд ад биш, харин хийдэг ажил нь доогуур түвшнийх. Жишээ нь, манай гадаад явдлын яам олон улсын харилцааг тусгайлан хариуцах бөгөөд ажил нь харьцангуй хөнгөн. Харин цагдаа гэмт этгээдийг баривчлах үүрэгтэй. Хүн баривчлах, загнаж зандрах, гянданд хорих, засан хүмүүжүүлэх нь тэдний ажил. Ийм ажлыг хийх хүн байх хэрэгтэй. Эс бөгөөс нийгэм амгалан тайван байж чадахгүй.

Үүний адил ад чөтгөр оршин байж л доогуур түвшний

төрөлтнүүдийг хянаж чаддаг. Эдгээр төрөлтнүүдийн дэс нь тухайн газартаа тохирсон байдаг тул тэднийг хариуцсан хэн нэгэн тэнд байх хэрэгтэй. Ад шүглэсэн найзын маань бясалгал дадал нь тун гайгүй хоёрдугаар ертөнцөд хүрээд тэдэнд баригдаж, цааш дэвших аргагүй болжээ. Үнэндээ манай Арьяабалын аргаар бясалгал дадуулдаг хүмүүс ямар ч асуудалгүй байдаг. Гэтэл тэр өмнө нь элдэв янзаар бясалгал хийсээр байгаад Багштай минь учрах үедээ байдал нь нэлээд хүндэрсэн байв. Тэр өөрөө бясалгал дадуулаад хүчрэхгүй байсан тул Багш намайг туслуулахаар явуулав.

Тэр байнга үс босож, бие арзайтал хашхиран “дуулна” .(*Хүмүүс инээв.*) Заримдаа тэр шалтгаангүй уурладаг. Би яагаа ч үгүй байхад тэр: “Чи намайг хорлох гээд байна, алах гээд байна. Юу гэж толгойг минь өвдтөл дарна вэ?” гэхэд нь “Яагаа ч үгүй байна шүү дээ. Би энд, чи тэнд байхад яаж толгойг чинь дарах юм бэ? гэхэд тэр: “Чи лав шидийн хүчээр дарсан байх.” гэв. Тэгэхэд нь би: “Үгүй ээ, хамт маани уншаад сууж байна шүү дээ. Тэгээд ч надад ид шид байхгүй, цаг зав ч алга.” гэв. Гэсэн ч тэр итгэдэггүй. Яагаад гэвэл шүглэсэн ад нь түүнд ингэж санагдуулж, ингэж уурлуулж, муу юм бодуулж байдаг.

Түүнд бусдын бодлыг мэдэх жаахан шид бий. Заримдаа тэнгэрийн нүд нь нээгддэг ч эдгээр нь бүгд хоёрдугаар ертөнцийнх. Түүний өмнөх бясалгалын зорилго нь зөв бус, буруу аргаар бясалгаж, ид шидтэй болохын төлөө байжээ. Учир нь хийсэн үйлийнхээ хариуг амсдаг болохоор бясалгал дадуулж тэр ертөнцөд хүрэхэд, ад чөтгөр тооцоо хийхээр ирээд: “Чи миний мөнгө төгрөг, хүч чадлыг хэрэглэсэн. Одоо өрөө төл. Тэгэхгүй бол дээшээ явуулахгүй.” гэж хэлнэ. Түүнд тавьсан зуун төгрөгийн өр одоо мянга түмэн төгрөг болсон байна. Тэндхийн үйл үрийн хууль энэ ертөнцийнхтэй адил. Бид бусдаас зуун төгрөг зээлсэн бол түүнийг нь буцааж өгөөд л болчихдоггүй. Зууг зээлсэн бол мянгыг төлнө.

Үйл үрийн хууль тун хэцүү. Зорилго зөв эсэхээс үл хамааран бидний үйлдэл бүхний үр дагавар уулын уруу өнхрөх тусмаа томордог цасан бөмбөлөг адил арвижин үрждэг. Жишээ нь бид банкнаас арван сая төгрөг зээлээд төлөхгүй бол хүү нь өссөөр богинохон хугацаанд өр улам ихсэж, төлөхийн аргагүй болдог.

Гурван ертөнцийн доторх үйл үр ч мөн адил. Жүржийн үр таривал ирэх жил олон жүрж ургана. Үүнтэй адил хорт ургамлын багахан үр тарихад хожим нь олон болж өснө. Иймээс бид энэ дэлхийд сайн үйл хийвэл сайн үр, муу үйл хийвэл муу үр олно.

Гэтэл сайн, муу ялгаагүй бүгд маш ихээр үржин нэмэгддэг. Сайн нь мэдээж асуудалгүй. Харин муу шалтгааны улмаас тодорхой хугацаанд бүрэлдсэн муу үр дагавар биднийг бүрэн хүлдэг. Энэ бол үнэхээр хатуу хууль.

Гурван ертөнцийн доторх үйл үрийн хууль маш нарийн, тун оновчтой. Хэтэрхий оновчтой тул хийсэн бүхэн тэр даруйдаа тэмдэглэгдэж хуримтлагдсаар маш их болж үрждэг. Иймээс энэ нь дэндүү болхи бядуу хууль болж таардаг. Жишээ нь хүнд нэг төгрөгийн өглөг өгчихөөд баярласандаа: "Өчигдөр би түүнд нэг төгрөг өгсөн." гэж өөр нэгэнд ярьдаг. Би энэ тухай бусдад ярьсан учраас өглөгийн нэг төгрөг даруй үгүй болно. Үйл үрийн хуулиар өглөг нь нэгэнт үгүй болсон. Маргааш нь баярласандаа уржигдар би түүнд нэг төгрөг өгсөн гэж бусдад яривал одоо өгсөн хүндээ нэг төгрөгийн өртэй болно. Хэрэв нөгөөдөр нь би түүнд нэг төгрөг өгсөн гэж дахиад яривал түүнд хоёр төгрөгийн өртэй болно. Уг нь би түүнд нэг төгрөг өгсөн ч, үүнийгээ хоёр гурван удаа ярьснаас түүнд хоёр төгрөгийн өртэй болжээ. Ярих тусам улам төвөгтэй болж улам их өртэй болно.

Иймээс бид энэ ертөнц дээр өглөг өгөхдөө болгоомжтой байхгүй бол тун аюултай. Хэрэв өглөг өгсний дараа өглөг өгсөн гэж бодвол өөртөө төвөг тарьж байгаа хэрэг. Учир нь ийм бодол байснаас өглөг өгсөн буян хишгээ эдлэх хэрэгтэй болно. Эдлэхгүй байж болохгүй тул заавал буцаж ирдэг. Хэрэв чи сайн дадуулан бясалгаад, гурван ертөнцөөс хэтийдэх ёстой байтал нэг хүнд хоёр гурван төгрөгийн өглөг өгснөөс, мөн "би" өглөг өгсөн гэсэн бодол байснаас, заавал буцан ирж, энэ хоёр гурван төгрөгийн буянаа эдэлсний дараа явах болно. Үйл үрийн хууль ийм тодорхой.

Иймээс "Очироор огтлогч судар"-т Шагжамуни Будда: "Өглөг өгснөө бүү дурс, "би" өглөг өгч байна гэж бүү бод. Ингэвэл жинхэнэ өглөг болно." гэжээ. Өглөг өгөхөд бидэнд тийм бодол өчүүхэн төдий байвал цаашид сансрын хүрдэнд эргэлдсээр байна гэдгийг Будда мэдэж байсан. Иймээс гурван ертөнцөөс хэтийдэхэд хялбаргүй. Хэрэв замчгүй, Төгс Гэгээрсэн Их Багшгүй бол явах аргагүй. Учир нь бид юу ч хийсэн алдаж, юу ч хийсэн бүгд бурууддаг.

"Газрын зүрхэн бодьсадвагийн судар"-т газрын зүрхэн бодьсадва диваажинд очиж Шагжамуни Буддатай ном хурж байхдаа: "Миний бодоход хамаг амьтан бодох бүрдээ үйл түйтгэр үйлдэж байна. Үйл түйтгэр үйлдэхгүй агшин гэж үгүй. ("Газрын зүрхэн бодьсадвагийн судар"-ын үхэх оршихын долоодугаар бүлэг: Газрын зүрхэн Бодьсадва Махасадва Будда дор өгүүлрүүн:

“Будда багш аа, би үзвээс замбуулингийн хамаг амьтан сэтгэл хөдлөн, бодол төрвөөс нүгэл үйлдэхгүй нь үгүй.”) гэжээ. Багшийнх нь санаа түүнийхтэй адил. Бид юу хийсэн ч алдаа гаргадаг. Алдаа хийхгүй байна гэж байхгүй учраас Их багшийн хүч, Бурханы хүч биднийг ивээн дээш дагуулахгүй бол бүх төрөлтөн биднийг доош чангааж махан бие, гар хөлийг маань тасчин авч, хувцас хунарыг маань хамж одно. Учир нь бид төрөл төрөлдөө бусдад маш их өртэй байжээ. Бид алдаа хийвэл өрөнд унах нь дамжиггүй. Санамсаргүй хийсэн алдаа ч бас өр болдог. Үйл үрийн хууль бүгдийг тэмдэглэн авснаар гэм нүгэл болж хувирна.

Их Багшгүй, эсвэл багшийнх нь дэс өндөр биш бясалгагч хамгийн сайндаа л хоёрдугаар ертөнцөд хүрнэ. Хамгийн сайндаа хоёрдугаар ертөнцийн сургаалын эзэн буюу хоёрдугаар ертөнцийн бурхантай уулздаг. Энэхүү бурхантай уулзмагц түүний бүх амьдрал, үзэл санаа, хүсэл мөрөөдөл, бодол санаа нь бүрмөсөн өөрчлөгдөж, цэцэн ухаан, билиг ухаанд нь ч хувиралт гардаг. Бодож, санаж байгаа нь урьдынхтай адилгүй болж, өөрийгөө хүчтэй, билиг ухаантай болсныг мэдэрнэ. Тэр үед хоёрдугаар ертөнцийн сургаалын эзэн түүнд: “Одоо буцаж очоод хамаг амьтныг гэтэлгэж болно.” гэж хэлдэг. Тэгэхэд нь өөрийгөө төгс гэгээрч агуу Бурхан боллоо гэж итгэдэг.

Учир нь илүү өндөр түвшин байдгийг, энэ бурханаас ч хүчтэй өөр нэг төрөлтөн байдгийг тэр төсөөлж чадахгүй. Төсөөлөх боломжгүй, бодоод олохгүй, өчүүхэн ч эргэлзэхгүй. Иймээс тэрээр хариад “Тийм бурхан бол Эзэн Бурхан, нэрийг нь хэн гэдэг. Тэр бол орчлонгийн хамгийн дээд нь.” гэж бусдадаа хэлнэ. Түүний ингэж ярих нь худлаа биш, эсвэл зориуд хуурч буй биш. Учир нь тэр үнэхээр мэдэхгүй. Гагцхүү жинхэнэ Их бодьсадва, жинхэнэ Будда эсвэл Хятадын Лууз шиг богд хүн л илүү өндөр түвшин байдгийг мэддэг.

Шагжамуни Буддаг маш агуу гэж бид магтан сайшаадаг. Учир нь Тэр бол их богд, их билиг нээгдсэн Бурхан мөн. Бурхан бол хамгийн өндөр дэстэй, бүхий л орчлон ертөнцийг мэдэж байдаг. Гурван ертөнцийг давсан бол Бурхан гэнэ. Гурван ертөнцийн дотор байгаа л бол дөрөвдүгээр ертөнцөд хүрсэн ч Бурхан биш зөвхөн Бодьсадва болох төдий. Гагцхүү өндөр түвшинд очиж үзсэн Бурхан л нэг, хоёр, гурав, дөрөв, тав, зургаадугаар гэхчлэн бүхий л ертөнцийг жинхэнэ ёсоор тодорхой мэддэг. Аль ертөнцөд ямар сургаалын эзэн байдгийг тэр мэднэ. Тийм хүн л биднийг дээд түвшинд аваачиж чадна. Эс бөгөөс бид гурван ертөнцийн доторх үхэж төрөхийн орчилд эргэлдэж, төрөл авах бүртээ хамгийн дээд

түвшинд хүрлээ хэмээн боддог.

Шагжамуни Будда “Агама судар”-т олон өөр өөр түвшнийг дурдаж, тодорхой ярьсан. Өнөөдөр Багшийнх нь ярьсантай бараг адил. Учир нь Шагжамуни Будда “Агама” сударт: “Сүнслэг дадал бясалгал сайтай нэгэн иогч байжээ. Тэр Эсэрваа тэнгэрийн оронд агшин зуурт л очдог байв. Эсэрваа тэнгэр бол гурван ертөнцийн хамгийн дээд түвшин бөгөөд гуравдугаар ертөнцийн бурхан. Иогч агшин зуур Эсэрваа тэнгэрт очоод, түүнээс: “Энэ орчлонд хамгийн дээд нь хэн бэ?” гэж асуухад тэр дуугарсангүй, дахин асуухад бас хариулсангүй гэнэ. Дахиад л асуусанд, Эсэрваа тэнгэр: “Энэ ертөнцийг би бүтээсэн. Энэ ертөнцөөс өмнө би байсан.” гэжээ. Иогч улам шахамдуулан асуусан нь: “Миний асуусан зүйл энэ биш, энэ орчлон дээр хэн хамгийн дээд нь вэ? гэдгийг л асууж байна.” гэхэд Эсэрваа тэнгэр хариулахаасаа нэрэлхэж гэнэ.

Учир нь тэнд түүний албатууд, шавь нар, ордны охид байсан болохоор тэдний нүүрэн дээр хариулахаас нэрэлхжээ. Иогчийг дагуулж гараад буланд өгиж: “Та үүнийг асуух хэрэггүй.” гэв. Бурхан Иогч: “Яагаад? Би мэдмээр байна. Шагжамуни Буддагаас асуухад тэр хэлэхээс цааргалж, Эсэрваа тэнгэрээс очиж асуу гэсэн.” гэжээ. Тэгэхэд Эсэрваа тэнгэр: “Хөөх! Шагжамуни Буддатай уулзсан бол өөр хэнээс асуух билээ. Тэр хамаг Бурхадын дээд нь.” гэжээ.

Өчигдөр багш нь Төгс Гэгээрсэн Их Багш л хамгийн дээд нь болохоос Эзэн Бурхан бол юу ч биш гэж хэлсэн. Биднийг зовж байхад Эзэн Бурхан хайхардаггүй, баян тарган байхад бас хайхардаггүй, сансрын хүрдэнд эргэлдэж байхад бүр ч тоодоггүй. Түүний үүрэг нь үүсгэн бүтээх бөгөөд түмэн бодисыг ивээн бойжуулдаг. Бидний зовох эсэхийг тэр тоохгүй, харин Их Багш л хайхарна. Хамгийн дээд багшийг Бурхан гэдэг. Бурхан бүгдийг хайхарч, хүмүүсийг эрх чөлөөт газарт аваачдаг. Учир нь Бурхан ертөнцийн хуулийн гадна оршдог тул Эзэн Бурхан Бурхантай юм ярих аргагүй. Энэ нь Бурхан Эзэн Бурханаас дээгүүр, эсвэл Эзэн Бурхан Бурханаас дээгүүр гэсэн үг биш. Тэрхүү түвшинд хэн нь хэнээсээ дээгүүр эсэх талаар боддоггүй, энэ талаар маргалдан харьцуулдаггүй.

Бурхан бол Будда бөгөөд энэ нь өөр түвшин. Эзэн Бурханы тухайд жишээ нь, Эзэн Бурхан, эсвэл ямар нэгэн Бүтээгч байдаг гэх нь бас өөр нэг түвшин. Эзэн Бурхан эсвэл Бүтээгч гэдэгт сансрын хүрд, төрөх, устах, бохир, ариун, арга, билиг зэрэг эсрэг тэсрэг зүйлс оршиж байдаг. Харин Бурхан бол өөр нэгэн түвшин бөгөөд эсрэг тэсрэг байдалгүй. Төрөхгүй, өтлөхгүй, өвдөхгүй, үхэхгүй; ариунгүй, бохиргүй, үүсэхгүй, устахгүй, нэмэгдэхгүй,

хасагдахгүй. Бурханы түвшин нь төрөхгүй, устахгүй, бохиргүй, ариунгүй, нэмэгдэхгүй, хасагдахгүй. Иймээс бид Бурханыг Төгс Гэгээрсэн Их Багш хэмээн хүндэтгэн дууддаг. Төгс Гэгээрсэн Их Багшийг Эзэн Бурханаас дээгүүр гэвэл худал ярьж буй хэрэг биш. Учир нь Эзэн Бурхан хүнийг туулан гэтэлгэж чадахгүй. Эзэн Бурхан хүмүүсийг бүтэх, орших, эвдрэх, хоосрохын түвшинд сансрын хүрдэнд эргэлдүүлэх төдий. Харин Бурхан бол хүмүүсийг энэ хүрээнээс гаргаж, бүрмөсөн туулан гэтэлгэдэг. Иймээс Эсэрваа тэнгэр иогчид: “Таны уулзсан тэр хүн бол хамгийн дээд нь. Түүнээс асуухгүй, юунд надаас асууна нь вэ? Тэр надаас дээгүүр.” гэжээ.

Тэрхүү энэтхэг иогч бясалгал дадуулаад Эсэрваа тэнгэрийн оронд хүрч чадсан нь ховор завшаан юм. Ихэнх иогчид нэгдүгээр ертөнцөд хүрэхээс хэтэрдэггүй, тэнд очихыг дээд зорилгоо хэмээн үздэг. Бясалгагчдаас цөөхөн нь л хоёрдугаар ертөнцөд хүрдэг бөгөөд хаа нэг гуравдугаар ертөнц хүрэх нь бий. Гэвч Их Багш дагуулахгүй бол гурван ертөнцийг давж чадахгүй. Хэрэв тийм Төгс Гэгээрсэн Их Багш байвал Арьяабалын бясалгалын аргыг заадаг. Иймээс “Баатараа явагч их хөлгөн судар”-т Арьяабалын бясалгалын аргыг хамгийн төгс бясалгалын арга бөгөөд ”Арван зүг гурван цагийн Бурхад энэхүү Арьяабалын аргаар л бясалгал дадуулах хэрэгтэй. Тэгвэл бурханы хутгийг бүтээж чадна.“ гэж Шагжамуни Будда магтсан байдаг. Католик шашны Библид Арьяабалын бясалгалын аргыг дээдийн бясалгалын арга болохыг дурджээ. Эдгээрийг Багш нь хэдийнээ ярьсан тул сэдвээсээ хазайхгүйн тулд дахиж ярихгүй. Хэрэв та нар ойлгоё гэвэл миний айлдварыг авч хариад үзээрэй.

Багш нь өчигдөр Энэтхэгчүүдийн хувьд Их Багш бол Эзэн Бурханаас ч өндөр байр суурьтай гэж ярьсан. Тэд гэртээ мод, чулуун бурханыг шүтдэггүй, зөвхөн Их Багшийнхаа, эсвэл Өвөг Багшийнхаа гэрэл зургийг тавьж өдөр бүр цэцэг өргөдөг. Харин манай бясалгалын арга цэцэг, хүж эсвэл ямар нэг юм өргүүлдэггүй. Гэвч Багш нь та нарыг битгий өргө гээд ч нэмэргүй, тахисаар л байдаг. Өнөөдөр энэ хүнээр өргүүлэхгүй бол маргааш өөр нэг нь өргөхөөр ирдэг. Нэгийг нь юм бүү авчир гэхэд нөгөөдөх нь бас аваад ирдэг. Иймээс би юу ч хэлэхээ больсон. Та нарыг битгий мөргө гэдэг ч, мөргөж хэрэггүй гэж өнөөдөр нэгэнд нь хэлэхэд маргааш өөр нэг нь ирээд мөргөж байдаг.

Өдөр бүр нэг юм заагаад байж болохгүй учраас би одоо ажил хаясан. Дахиж ярихгүй. Мөргөвөл мөргө, тахивал тахь. Гэвч Багшдаа тийм их юм бүү өргө, надад хангалттай байгаа. Өргөл

хэтэрвэл машин маань даахгүй. Уул өндөр тул их мөнгө ачвал тэрэг маань хөдлөхгүй. (*Хүмүүс инээв.*) Бид сүм хийд барихгүй болохоор их мөнгө хэрэглэхгүй. Багшийгаа өлбөрч үхэх вий гэж битгий зов, хангалттай хүрнэ! Өлбөрч үхэхдээ хүрвэл сониноор зарлая. (*Хүмүүс инээв.*) Тийм тийм нэртэй бясалгалын төвд нэгэн номын багш өлбөрч үхэх гэж байна гэж сонинд нийтлүүлбэл Формосагийн хүмүүс даруйхан ирж хооллоно. Шавь нар маань намайг өлбөрүүлэхгүй харж хандаж чадна. Хэтэрхий их бол идэж барахгүй, тэгвэл үрэлгэн явдал болно. Та нар гэрээс гаръя гэж байгаа бол хурдхан гарч, үүнээс идэлцэж өгөөрэй. Одоо хэт ихдээд идэж барахгүй байна. Багш нь тун бага иддэг, гэрээс гарагчид ч ялгаагүй.

Энэ ертөнцөд хүмүүсийн ажил их зүдэргээтэй ч тэд ихэд чармайцгааж байна. Орж ирэхдээ нэгдүгээр давхрын нарийн боовны дэлгүүрийнхэн цайны боов хийж байхыг харлаа. Мах, өндөг орсон байж болох тул бид идэж болохгүй. Харахад тэд их ажилтай, тун завгүй ядарсан янзтай. Миний бодоход энэ боов нь төдий л үнэ хүрэхгүй, ашиг ч бага байгаа. Тэгж их зовж олсон мөнгө нь идэж уух, өмсөж зүүхэд хүрэхгүй байх вий гэж заримдаа тэд санаа зовдог. Тэр байтугай зарим нь дампуурч их өрөнд унадаг. Үнэхээр өрөвдмөөр. Жаахан хоолны төлөө, бага сага эд юмны төлөө, ганц хоёр хувцас хунарын төлөө тэгж их зовж зүдэрдэг. Манай бясалгагч нар мөнгөгүй ч идээд барахгүй юмтай. Та нар яагаад бүгдээрээ гэрээс гарахгүй байгааг би ойлгохгүй байна. (*Хүмүүс инээв.*)

Яагаад зовж зүдэрч байж хэдэн төгрөг олоод бас хүрэхгүй нь гэж санаа зовдог юм бэ? Үүний учрыг би ойлгохгүй байна. Бид тэгж зовдоггүй. Хэдийгээр өдөр бүр ажиллах, бясалгах хэрэгтэй ч гэрээс гараагүй хүн шиг зүдрэхгүй. Бид ажиллаж, бясалгаж байгаа нь хамаг амьтанд туслахын төлөө юм. Бид гуйлга гуйгаагүй, сонинд зар тавиагүй, бусдаас өргөл барьц хүсээгүй, бадар бариагүй ч эдээ эдэлж, хувцсаа өмсөж барахгүй байна. Угаасаа гурав дөрвөн хувцас байхад л хангалттай, бидний хувьд харин ч олон байна. Хоол ч гэсэн идээд барахгүй тул их зүйл хэрэггүй. Учир нь манай бясалгагчид амархан сэтгэл ханадаг. Мөнгөгүй хэдий ч сэтгэл ханамжтай байдаг. Өөрсдийн сүм хийдгүй, түрээсийн байранд суудаг ч сэтгэл хангалуун. Юу байна, түүнийгээ л хэрэглэж, сэтгэл нь амархан ханадаг хүн бол хамгийн баян хүн.

Би гэрээс гарахаасаа өмнө санаа зовниж байсан. Учир нь бадарлаж, бусдыг царайчилж сураагүй, гэрээс гарсны дараа

мөнгөтэй байх эсэхээ мэдэхгүй байсан. Айдас л бол айдас. Тиймээс бясалгал дадуулж байгаа хүн зоригтой байх хэрэгтэй. Мөнгөгүй бол тэр л биз, өлбөрч үхвэл эртхэн диваажинд очно. Одоо харин хэрэглээд барахгүй юмтай болсон. Гэтэл жирийн хүмүүсийн хоёр нарны хооронд чөлөө завгүй, нойр хоолгүй ажиллаж олсон хэдэн төгрөг нь амьдралд нь хүрэлцдэггүй. Тэд үнэхээр өрөвдмөөр ч үзэл бодлыг нь өөрчлөх аргагүй. Ямар нэг юмыг барихыг хүсэх тусам баригддаггүй, яг л сүүдрээ барьж чаддаггүйтэй адил.

Жишээ нь, хүнд дурлаад хойноос нь хөөцөлдөх тусам нөгөөх нь улам дөлж зугтаадаг. Хэрэв тоохгүй бол харин өөрөө гүйгээд ирнэ. Та нар маргааш туршаад үз. Идэж уух, наадаж наргихыг хайхрахгүй бол өөрөө хүрээд ирнэ. Юманд хэт санаа зовсны хэрэггүй. Бүтээгч маш олон зүйлийг бүтээсэн. Тэр бүгдийг харж ханддаг. Өвс ургамал мөнгө олж чадахгүй ч өсөж томрон цэцэглэж үр жимсээ өгдөг. Адгуус амьтад санаа тавих хүнгүй ч өсөж үрждэг. Загас жараахай далай тэнгистээ байж харгалзах эзэнгүй, ажил хийдэггүй ч (*Хумүүс инээв*.) маш олон болж үрждэг. Бүх дэлхийн дөрвөн тэрбум хүн өдөр бүр тун их загас барьж байна. Хэн тэдэнд санаа тавьж байна вэ? Эцсийн дүндээ ямар ч асуудалгүй, болж л байна. Хүн бол энэ орчлонгийн хамгийн дээд нь. Хэрэв Эзэн Бурхан байдаг бол бидэнд санаа тавихгүй байж яаж чадах вэ?

Бид гэрээс гарч байгаа нь бие, хэл, сэтгэлээ ариусгаж, Эзэн Бурхан, Бурхан, лам гурван эрдэнэд түүгээрээ өргөл өргөхийн төлөө юм. Эзэн Бурханд итгэвэл Тэр биднийг лавтайяа харж хандана. Бурханд итгэвэл Бурхан ч бас бидэнд санаа тавина. Та нар санал нэгтэй байна уу? (*Тийм гэж хумүүс хариулав*.) Тийм бол та нар бүгд гэрээс гарвал таарна. (*Хумүүс инээв*.) Гэрээс гарвал бүгдийг огоорч, юуг ч хайхрахгүй болдог. Ингэвэл тэр даруйдаа олон юмтай болно. Гэхдээ та нар эдгээр эд юмсын төлөө гэрээс гарч болохгүй.

Би гэрээс гарахаас өмнө банканд хадгаламжтай, тэтгэврийн даатгалтай байсан. Учир нь Германд төрийн албанд ажиллаж байсан болохоор тэтгэврийн, эрсдэлийн, нийгмийн, эрүүл мэндийн зэрэг даатгалуудтай байсан. Төрийн албанд ажиллах тун боломжийн, олон төрлийн даатгалтай. Хэрэв би дахиад ганц хоёр жил ажилласан бол өтлөх үедээ хүрэлцэхээр мөнгө хуримтлуулж болох байв. Би гэрээс гарахаа урьдаас төлөвлөсөн бол арай илүү мөнгөтэй явж болох байсан.

Гэвч тухайн үед би юуг ч тоолгүй тэр даруй явсан. Мөнгөнд шунаад яах вэ? Гэрээс гарахад мөнгөний хэрэггүй болохоор тэгээд л явсан. Хэрэв ганц хоёр жил, ганц хоёр сар хүлээсэн бол

юу болохыг мэдэхгүй. Ямар нэг учир явдал гараад би яваагүй ч байж магадгүй. Өдөр бүр л олон хэрэг явдал өрнөж байдаг. Өнөөдрийн явдлыг таашгүй байхад, маргаашийг яаж мэдэх вэ? Ирэх жилийнхийг яаж мэдэх вэ? Иймээс би: "За за, явна л гэвэл явна." гэв. Гэрээс гарах гэж байж мөнгө бодоод яах вэ? гэж өөрийгөө зэмлэв.

Тэр үед надад их мөнгө байгаагүй, хоёр гурван мянган америк доллар байсан байх. Онгоцны билет авч Энэтхэгт очсоны дараа төдий л их мөнгө үлдээгүй ч, хоёр гурван хувцас, уутан хөнжил аваад өөр юу ч үгүй явдгаараа л явсан. Үлдсэн жаахан мөнгөөрөө дараа нь дахиад л онгоцны билет авч Формосад ирээд огт мөнгөгүй болов. Очоод мөнгөгүй яана даа гэж тухайн үед бодож байсан. Энд ирэхэд хэдэн зуун юань үлдсэн бөгөөд үүгээр зочид буудалд нэг л хонож хүрнэ. Буудлын мөнгөө төлөөд ямар ч мөнгөгүй болов. Яг тэр үед Буддын шашны нийгэмлэгтэй холбоо барьж, лавласанд намайг нэгэн хийдэд суулгасан. Тэгээгүй бол нэг ч хүн танихгүй тул Формосад амьдаараа өлбөрөх байсан. (*Хүмүүс инээв*.)

Үнэндээ Формосад ирсэн эхний өдрөө л Буддын шашны нийгэмлэгийнхэнд энэ талаар тодорхой ярьсан. Гэвч тэд ойлгоогүй бололтой, намайг том зочид буудал (Hotel)-д буулгав. Зочид буудлыг хараад мөнгө хүрэхгүй бол яана гэж санаа зовниж байсан ч тэдэнд хэлж чадаагүй. "Энэ буудал үнэтэй юу?" гэж асуухад "Зүгээр зүгээр, үнэтэй биш, гадаадаас ирсэн багш нар бүгд энд буудаг." гэж хариулав. Гэтэл энэхүү гадаадын багш ямар байдалтайг тэр мэдэхгүй байв. (*Хүмүүс инээв*.) Бусад гадаадын номын багш Формасад ирэхэд олон хүн дагалдаж, шавь нар нь цуглан тосож, хичээнгүйлэн хүлээдэг. Гэтэл намайг хэн ч тосоогүй, хаа ч очсон дагуулах хүнгүй. Тэр үед намайг мэдэх хүнгүй болохоор сэтгэл зовниж, буудлын мөнгийг төлж чадахгүй байх гэж айж байсан.

Би түүнд: "Би зочид буудалд буухгүй. Гэрээс гарагч болохоор зочид буудалд байж чадахгүй. Намайг нэг сүмд аваачиж өгч болох уу?" гэхэд: "Та урьдаар энд хэдэн өдөр байрлаж бай, тэгж байж болъё. (*Хүмүүс инээв*.) Та дөнгөж ирсэн болохоор тэр даруй сүм хийд олж чадахгүй. Одоо бид сахил хүртээх гээд завгүй байна. Хэд хоног байж бай, долоо хоногийн дараа дахиж ярилцъя" гэв. Би сонсоод, зүрх амаар гарах шахав. (*Хүмүүс инээв*.) Учир нь намайг цэвэрхэн хувцасласан байхыг тэр харсан болохоор мөнгөгүй гэдгээ хэлэх аргагүй байв. Гэрээс дөнгөж гарсан тул хувцас цэвэрхэн, шинэхэн бас үзэмжтэй.

Формосагийн хүмүүс Багшид нь их дуртай байсан. Зочид буудлынхан намайг Их Багш гэж бодож байв. Намайг Буддын шашны нийгэмлэгээс ирүүлсэн болохоор ихэд хүндэлж, Их Багш хэмээн дуудна. Гэвч Их Багш нь мөнгө багатайг тэд мэдэхгүй. (*Хүмүүс инээв.*) Би буудалд ормогцоо: "Нэг хоноход ямар үнэтэй вэ?" гэж асуусанд: "Хямдхан, хямдхан бүү санаа зов." гэв. Миний хувьд хямдхан гэдэг нь хэд болохыг тэр мэдэхгүй. (*Хүмүүс инээв.*) Асуугаад ч тэд хэлэхгүй. Өөр үйлчлэгчээс: "Миний өрөөний үнийг мэдэх үү?" гэж асуухад: "Та өрөөндөө ороод үзээрэй, бичээстэй байгаа" гэв. Намайг ороод харахад үнэхээр нэг самбар дээр 750 юань гэж бичсэн байв. Ашгүй! Дөнгөж л хүрэх нь. (*Хүмүүс инээв.*) Маргааш сэмхэн нүүчихвэл болно. Миний мөнгөгүйг Формасад мэдэх хүн байхгүй.

Дараа өдөр нь тэр ирж тавлаг эсэхийг асуухад нь: "Би энд баймааргүй байна. Та надад бушуухан өөр газар олж өгч болох уу? Ямар ч сүм байж болно. Би уутан хөнжилтэй болохоор хаана ч амьдарна, гадаа ч унтаж болно." гэв. Тэр: "За, энэ хавьд нэг номын хийд байдгийг сая саналаа, та тэнд байвал болох уу?" гэхэд нь "Мэдээж болно" гэж би хэллээ. (*Хүмүүс инээв.*)

Иймд миний гэрээс гарсан нь их эрсдэлтэй байжээ. Тэр даруй гарчихсан болохоор ямар ч бэлтгэлгүй, мөнгө төгрөг ч байхгүй. Формасад нэг ч хүн танихгүй байж яаж ирж зүрхэлснээ би одоо ч ойлгодоггүй. Та нар Багшийнхаа ингэж ярихыг сонсоод айж байна уу? Тэр үед би өчүүхэн ч айгаагүй. Хэрэв зоригтой байж идэх, өмсөх, явах, суух зүйлийг жинхэнээр огоорвол Бурхан, Бодьсадва биднийг лавтай харж хандана гэдгийг би мэднэ. Биднийг сүүлчийн хором хүртэл сорьж, тэр ч байтугай амьсгалах өчүүхэн агаар үлдээгүй үед л хүчилтөрөгч өгч мэднэ. Гэвч Бурхан, Бодьсадва бидэнд заавал тусална. Би гэрээс гарахаас өмнө гурав хоног өлсөж үзсэн. Иймээс гэрээс гарсны дараа өлсөхөөс айхгүй байв. Нэг хоёр долоо хоног өлслөө ч би өлбөрч үхэхгүй.

Энэтхэгт номын багш олон байдаг. Тэд заримдаа нэг, хоёр долоо хоногийн турш замд явна. Хэн ч идэх юм өгөхгүй байхад тэд яадаг ч үгүй. Энэ бол бодит явдал. "Та нар ийм янзтай яаж амьдрах юм бэ?" гэж түүнээс асуухад: "Өлсвөл өвс иднэ, цангавал Ганга мөрний усыг ууна." гэв. Зарим хүн өвс ч хайлгүйгээр өлсөх болгондоо Ганга мөрний уснаас уудаг. Бясалгаж дуусаад уйдах юм уу өлсөх эсвэл идэх юм өгөх хүнгүй бол бас л Ганга мөрний усыг ууна. Гэдсээ дүүртэл уучихаад дахин очиж бясалгана. (*Хүмүүс инээв.*) Түүний байгаа газрыг хараад мөнгөгүйг нь мэдэж болох бөгөөд тэр нь өөрөө малтсан бяцхан агуй төдий. Агуйд бясалгаж,

өлссөн ч өглөг өгч хооллох хүн ирэхгүй бол Ганга мөрний усыг уухаас өөр аргагүй.

Миний бодоход түүний амьдрал тун дажгүй. Иймд би Формасад ирэхдээ өчүүхэн ч айгаагүй. Идэх юм өгөх хүнгүй байсан ч хамаагүй, нэг гол олоход л болно. Мэдээж Ганга мөрөн биш ч ямар ч гол байж болно. Тэрхүү голыг бараадан сүнслэг дадал бясалгал хийнэ. (*Хүмүүс инээв*.) Гэвч одоо болтол өлбөрч үхээгүй л байна.

Францад оюутан байхдаа гурван өдөр олон газраар яваад өлсөж үхэх шахав. Ажил эрээд олддоггүй. Англиас явуулсан мөнгө ирдэггүй, байсан мөнгөө ч зараад дууссан байв. Парист амьдралын өртөг тийм өндрийг мэдсэнгүй. Англид бол нэлээд доогуур байдаг. Парис бол дэлхийн амьдралын өртөг ихтэй хотуудын нэг. Тэр үед би дөнгөж очоод зам мэдэхгүй болохоор хаа ч хүрсэн таксигаар явдаг учраас их мөнгө зарсан. Таксины зарим жолооч хүн хуурдаг. Очих газрыг тодорхой мэдэвч энэ тэрүүгээр тойруулдаг болохоор мөнгө их үрэгдэнэ. Тэгэхэд би юу ч хэлж чаддаггүй. Гадаадын хүн болохоор яасан ч тэднийг дийлэхгүй тул хамаагүй уурлаж болохгүй.

Зургаадугаар үеийн Их Багш Хүй Нөн түлээчин хүн байсан. Нэг өдөр "Очироор огтлогч судар"-ыг хүн уншиж байхыг санамсаргүй сонсоод агшин зуур гэгээрчээ. Дараа нь бясалгал дадуулж гэтлэхээр шийдэж, тавдугаар үеийн Их Багшийг эрэхээр бэлтгэж байв. Тэр үед гэр нь их ядуу, бас хүний ганц хүү болохоор настай эхээ асран тэжээх хэрэгтэй байжээ. Тэр гэрээс гаръя гэж үнэхээр бодож байв. Яах вэ? Яг энэ үед нэг хүн ирж түүнд мөнгө өгөв. Ингээд настай ээжийнх нь амьжиргааны асуудал шийдэгдэж, тэр ч сэтгэл амар явжээ.

Иймээс бид чин сэтгэлээр Бурхан болохын төлөө, хамаг амьтанд ач тус болохын төлөө гэрээс гарвал Бурхан, Бодьсадвагийн тусламжийг олох болно. Гэвч заавал үнэнч шударга байх хэрэгтэй. Учир нь Бурхан бодьсадва сэтгэлийг маань биднээс илүү мэддэг. Бид өөрийгөө, Багшаа хуурч болох ч Бурхан, Бодьсадваг хуурч чадахгүй. Иймээс бид заавал үнэнч сэтгэлтэй байх хэрэгтэй. Хэрэв ингэж чадвал юу ч хийсэн бүтэмжтэй байх болно. Цэвэр ариун сэтгэл, цэвэр ариун зорилготой бол юу ч хийсэн туслах хүн заавал байдаг. Юунд ч санаа зовох хэрэггүй.

Багш нь гэрээс гарсны дараа хэрэглээд барахгүй мөнгөтэй болсон. Зарим үед олон хүн өглөг өгдөг ч би авдаггүйг та нар мэднэ. Миний шавь биш бол авахгүй, хэтэрхий их мөнгө бол бас авахгүй. Мөнгө төгрөг хүрэлцэж байвал ер нь авдаггүй.

Ихийг авбал хүрэлцэнэ гэсэн үг биш. Багахан байсан ч хэрэглэж хүрдэг. Багшид нь юу ч хэрэггүй. Өдөр бүр ном тайлж, гэртээ ирээд хичээнгүйлэн бясалгалаа дадуулдаг. Заримдаа та нар Багштайгаа уулзахаар ирэхэд ийм л байдалтай байдаг. Энгийн амьдардаг болохоор дуу дуулан бүжиг бүжиглэж, архи ууж чадахгүй. (*Хүмүүс инээв.*) Эсвэл өдөрт гурван хайрцаг тамхи татаж чадахгүй. Бидэнд онцгой юм хэрэггүй. Бидний амьдардаг газар телевизор, сонин сэтгүүл байхгүй. Гэрээс гарагсад номхон даруу, хичээнгүйлэн бясалгадаг.

Иймээс бид их мөнгө хэрэглэх шаардлагагүй. Сар бүр цахилгааны зардал 300-400 юань болдог. Утсаар бараг ярьдаггүй тул зардал хэмнэнэ. Бүгдээрээ хамт амьдардаг болохоор сайн зохион байгуулах юм бол их мөнгөний шаардлагагүй. Манай ууланд шатахууны мөнгийг оруулж тооцвол сар бүр 2000-3000 юань байвал хангалттай хүрнэ. Гэвч тэр нэг "хэт хуучин машин" заримдаа их мөнгө иддэг. (*Хүмүүс инээв.*) Байнга засаж сэлбэх хэрэгтэй болно. Хэрэв ном тайлахаар явахгүй бол илүү ихийг хэмнэдэг. Тэгээд ч Формасад будаа, ногоо хямд тул хүссэнээ хийгээд идчихнэ. Гэрээс гарсан хүн бага иддэг. Залуу хүмүүс сайн идэх хэрэгтэй байтал бага идэж байгаад нь би гайхдаг. Тийм болохоор нэлээд мөнгө хэмнэнэ. Үгүй бол Багш нь дампуурч алдагдалд орно. (*Хүмүүс инээв.*)

Иймээс гэрээс гарах нь ямар ч асуудалгүй. Үйл үрийн хуулийг давж, гурван ертөнцөөс хэтийдэхээр гэрээс гарч буй тул сайн бясалгалын аргатай байж л туулан гэтэлж чадна. Өвгөн хувраг Гуан Чин: "Сайн бясалгалын аргагүй, сайн багшгүй, хичээнгүйлэн бясалгал дадуулахгүй бол гэрээс гараад ямар ч хэрэггүй. Тун харамсалтай." гэжээ. Түүний үзэл бодлыг Багш нь зөвшөөрч байна. Учир нь олон хүний гэрээс гарсан хүсэл эрмэлзэл нь өндөр, зорилго нь цэвэр ариун байдаг ч буян хишиг дутсанаас сайн багш, сайн бясалгалын аргатай учирдаггүй. Түүний энэ насны амьдрал нь цэвэр ариун, элдэв нүгэлгүй ч урьд төрлийн үйл түйтгэрээ арилгаж чадахгүй тул дэс нь дээшлэхгүй, билиг ухаан нь нээгдэхгүй. Нэг насны амьдрал нь ямар ч үнэ цэнгүй өнгөрдөг. Бясалгал дадуулаад нэг, хоёрдугаар ертөнцөд хүрч болох ч нас нөгчөөд тэнд үлдэж, нэг хэсэг жаргал эдэлсний дараа дахин унаж ирнэ. Төгс туулан гэтэлж чадахгүй, үнэхээр харамсмаар.

Би гэрээс гарахаас өмнө олон сүм хийдэд очиж, олон багшаас суралцсан ч сэтгэл дундуур байв. Гэрээс гарах нь ийм байдаг бол хэрэггүй юм байна гэж бодсон. Тэд өглөө, оройны уншлага залбирлаас бусад цагт элдэв зүйлийг өдөржингөө ярьж,

амт шимтэй хоол унд хийж суудаг. Цагаан хоол шим тэжээлээр дутмаг тул ахиухан идэх хэрэгтэй гэж боддог. Үнэр амт нь цогцолсон хоол хийвэл иднэ. Ахиухан идвэл биед сайн гэнэ. Гэрээс гарчихаад идэх уухад анхаардаг нь шим тэжээл дутагдах вий гэж болгоомжилсноос болжээ. Бясалгагч хүн ийм юманд санаа зовох юм бол хэзээ эрх чөлөөг олох вэ?

Юу ч идэж болно, үүнийг хайхрах хэрэггүй. Бие махбод өөрийгөө аяндаа торддог. Хангалттай шим тэжээлтэй л бол болно. Дадал бясалгал чинь сайн бол их идэх шаардлагагүй. Өвгөн хувраг Гуан Чин төдий л их юм иддэггүй. Тэрээр угийн юм иддэггүй, сайндаа л бага сага жимс иддэг. Түүнийг ууланд бясалгал дадуулж байхад хоол хүнсээр хангах хүн байгаагүй. Заримдаа сармагчин жимс авчирч өгдөг ч ууланд жимс бага тул тэр нь шалихгүй жаахан. Хамаг учир нь түүний бараг юм иддэггүйд байгаа юм.

Бясалгал сайн хийдэггүй хүн их иддэг. Учир нь завтай тул юм идмээр санагдана. Сэтгэлээ дээгүүр түвшинд тавихгүй бол доогуур тавих нь мэдээж. Яг л хулсан баганад авирах мэт дээш авирахгүй бол аяндаа доош гулсана. Дээшлэх, доошлох хоёрхон зам байна. Сэтгэлээ ийш хандуулбал (*Багш гэдэс рүүгээ заав.*) идье гэж бодох нь яриангүй. Уйдахдаа тэр шүү дээ! Жирийн хүн хийх юмгүй бол муу зүйл бодож, муу үйл хийдэг.

Иймээс бясалгал дадуулж буй хүн бараг өлсдөггүй. Тэд (гэрээс гарагчид) өдөр бүр долоо, найман цаг ууланд бясалгадаг тул тэгтлээ өлсдөггүй. Бид жинхэнэ ёсоор бясалгахыг хүсвэл идэж уухад тэгтлээ санаа зовохгүй. Идэх юмгүй байсан ч ямар ч асуудалгүй. Арьяабалын аргаар бясалгал дадуулдаг хүн нэг л өдөр юм идмээргүй санагдаад идэхээ больсон ч яах ч үгүй. Өлсөж үхэхгүй гэдгийг Багш нь баталъя. Гэвч гэнэт гарч болохгүй, аажмаар дасгах хэрэгтэй. Жишээ нь, хоол ундаа өдөр бүр аажмаар багасгавал аюул багатай.

Үнэндээ ямар ч аюулгүй, бие л жаахан эвгүйрхэх шиг санагдах төдий. Идмээргүй бол битгий ид, ямар ч асуудалгүй. Хэрэв нэг өдөр энэ дэлхий дээр дайн дэгдвэл юм олж идэхэд хэцүү болно. Арьяабалын аргаар бясалгал дадуулагч та нар айх хэрэггүй, ус уувал болчихно, тэр байтугай усгүй байсан ч үхэхгүй. Энэ бол ид шид биш аясаараа л болох зүйл. Албаар тэгж байгаа ч юм биш, онцгойлон ямар нэг юм хийсний хэрэггүй. Идмээргүй бол идээд хэрэггүй. Энэ бол ид шид биш, бясалгалын арга ч биш.

Арьяабалын аргаар бясалгал дадуулдаг хүн гүйцэд сайн бясалгавал түүнд бүх юм байх болно. Ахиж юу ч эрсний хэрэггүй.

Бие махбод өөрийгөө тордож чадна. Эхлээд жаахан өлсдөг ч хэсэг хугацааны дараа зүгээр болно. Арьяабалын аргаар бясалгал дадуулвал идэх хоолгүй ч өлбөрч үхэхгүй, өмсөх хувцасгүй ч хөлдөж үхэхгүй. Иймээс Арьяабалын аргаар бясалгал хийвэл энэ ертөнцийн болон туулан гэтлэх аль ч талдаа ямар ч аюулгүй. Санаатай бус жинхэнээр үүссэн ноцтой байдлын үед Багшийнх нь хүч ирж тусална. Чиний явах цаг чинь болоогүй л бол тээглэж унаад үхэх байсан ч Багш нь чамайг ирж аварна. Тэр үед Багшийгаа чухам хэн болохыг, яаж тусалсныг мэдэх болно.

Гэвч "хичээнгүйлэн бясалгал дадуулж" байж л хамгаалалтын хүчтэй болдог. Иймээс Арьяабалын аргаар дадуулан бясалгах нь тун аюулгүй. Хэрэв жинхэнэ дайн гарвал сандрах хэрэггүй, Багшийнхаа өнөөдрийн ярьсныг санаарай. Багшийнхаа зааврыг дагаж, дадал бясалгалаа хичээнгүйлэн сайн хийсэн хүн Багшийн хамгаалалтын хүчтэй байх нь лавтай. Өнөөдрийн ярьсан бүхэн гурван ертөнцийн доторх учир явдал юм. Гурван ертөнцийн гаднах зүйлийг ярьж болохгүй. Энд ярих шаардлагагүй, хожим та нарт завшаан олдвол сонсож магадгүй. Идэх уух талаар угаасаа ярья гээгүй. Хоол идэх эсэх талаар шавь нартаа хэлж өгье гэж байсан ч өнөөдөр баярласандаа ярьчихлаа. Та нар үүнийг одоохон мартаарай. Та нар үүнийг огт сонсоогүй. Тийм үү? Саяын тархиндаа бичсэн зүйлийг арилгаарай.

Дээр үед нэг хүн байжээ. Улсын хаан түүнийг төрийн багш болгоё гэхэд тэрээр даруйхан гол дээр очиж чихээ угааж гэнэ. Хэн болохыг нь та нар мэдэх үү? Түүний нэрийг би мартчихжээ.

Энэ бол эртний хятадын үлгэр юм. (*тайлбар: түүний нэр нь Шюй Ёоу*) Улсын хаан түүнийг ордондоо аваачиж их түшмэл болгоно гэснийг сонсоод даруй гол дээр очиж чихээ угаав. Учир нь хааны ингэж хэлэхийг нэгэнт сонссон болохоор чихээ угааж арилгахаас өөр аргагүй болжээ.

Түүний үхэрчин найз нь тэр үед яг голын хөвөөнд үхрээ хариулж байв. Найзыгаа чихээ угааж байхыг хараад: "Та юунд ийм удаан чихээ угаана вэ?" гэхэд: "Хаан намайг их түшмэл болгоно гэхийг сонсоод оюун ухаанаа бохирдуулахгүйн тулд чихээ цэвэрлэж байна." гэжээ. Тэгэхэд үхэрчин үхрээ тэр даруй дээд талд нь гаргаж услав. Тэгэхэд нөгөө хүн: "Чи яагаад үхрээ миний дээд талд усалж байгаа юм бэ?" гэж асуухад тэрээр: "Таны чихээ угаасан бузар усыг үхэртээ уулгахгүй." гэжээ. "Та билиг ухаантай гэдгээ бусдад харуулахын тулд юунд энд тэндгүй шуугиан тарьж явдаг юм бэ? Үүнээс харахад таны сэтгэлд нэр төр, ашиг хонжооны асуудал байна." гэж үхэрчин зэмлэж гэнэ.

Багш нь өнөөдөр их ярилаа. Олон хүн Багшийг нь Арьяабалын бясалгалын аргыг зааж өгч чадна гэдгийг мэдсэн бөгөөд энэхүү аргаар бясалгал дадуулвал идэх юмгүй байсан ч ажрахгүй гэдгийг бас мэдэж авсан. Та нар гадуур битгий яриарай. Эс бөгөөс зарим хүн идэх юмны төлөө ирж магадгүй. Ингэх нь сайн биш. (*Хүмүүс инээв.*)

Асуулт: Гурван ертөнцийн доторх ертөнц тус бүрийн эзэд бол Бурхан, Бодьсадвагийн хувилгаан, хэрвээ бид бясалгал хийвэл тэд ирж тусална гэж Буддын ном сударт дурдсан. Гэтэл Багш яагаад тэднийг ад чөтгөр гэж байгаа юм бэ?

Их Багш: Тэд ад чөтгөр ч биш, энэ нь тэдний ажил гэж би сая хэлсэн. Иймээс ад гэхэд ад биш. Тэр өдөр би өөр газар ном тайлахдаа хамаг амьтан бүгд Бурхан, ад чөтгөр ч бас Бурхан гэж ярьсан. Ертөнц болгон сургаалын эзэнтэй, хэрэв бид тэднийг таньдаг бол тэд туслан хаалгаа нээн өгч, биднийг дээш гаргадаг гэж Багш нь өмнөх хэдэн өдөр ярьсан. Жишээлбэл, Авид бурхан хамгийн дээр оршдог. Хэрэв та зөвхөн Авид бурханд залбираад, доогуур түвшний сургаалын эзнийг танихгүй бол тэд мэдээж таныг хамгийн дээд түвшин рүү явахад дамжин өнгөрүүлэхгүй. Иймээс Багш нь Бурханд залбирахыг бусдаас өөрөөр заадаг. Ганцхан Авид бурханд залбирахыг заадаггүй. Харин доогуур түвшний сургаалын эздээс эхлэн шат дараалан залбирахыг заадаг. Заавал дооронос нь өгсүүлэн уншвал ач тустай гэж тэр өдөр Багш нь тодорхой ярьсан. Тэр үед та байгаагүй байж магадгүй. Ном сударт байхгүй тул та нар мэдэхгүй. Үүнийг заавал Багшаас уламжлан дамжуулж байж л мэддэг. Ном судраас тийм нэрсийг эрээд олохгүй.

БУЯН ХИЙЖ, ӨГЛӨГ ӨГӨХ НЬ ТУУЛАН АНГИЖРУУЛЖ ЧАДАХГҮЙ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар. Формосагийн Тайбэй хотын Цаглашгүй гэрэлт бясалгалын төв.
1986 оны 10 дугаар сарын 26
(Эх нь хятад хэлээр)

"Дао"(Гэгээрэл)-г эрэх нь төгс сайн хүн болох эсвэл нийгмийн ажилд идэвхийлэн оролцох, эд зүйлийн өглөг ихээр өгөх, олон газраар явж эргэл мөргөл хийх, сүм хийд, хүн зонд өргөл өргөх гэх мэтийн явдал огтхон ч биш. Ингэвэл "Дао"-г олно гэдэг ч үнэндээ боломжгүй. Учир нь "Дао" бол "Дао" юм. "Дао" гэж юу вэ? "Дао" бол "Мөр ёс". "Дао"-г үгээр илэрхийлшгүй, юугаар ч сольшгүй, засаж өөрчлөх аргагүй. Ингэснээр "Дао" болчихгүй. Энэхүү "Дао" буюу "Мөр ёс" нь угаасаа байсан. Гэртээ суугаад энэ "Мөр ёс"-ыг олохгүй, заавал гарч явах хэрэгтэй. Тэгвэл олно.

Жишээ нь, эсрэг талын сүмд очиход заавал их хаалгаар (*Бясалгалын төвийн их хаалгыг заав.*) гарах хэрэгтэй. Тийм үү? Сүм рүү очих зам угаасаа л байсан. Одоо очъё гэвэл эхлээд энэ замыг олох хэрэгтэй. Хэрэв замаа мэдэхгүй бол хүнээс асууна, эсвэл сүмээс ирсэн хүнтэй уулзвал биднийг хүргээд өгнө. Тийм үү? Явах замаа мэдэхгүй, хайж олъё гэхгүй, харин өдөр бүр сайн үйл бүтээж, сүмд мөргөн ядуучуудад мөнгө тарааж, сүм хийд барьж байгуулахад их хөрөнгө хандивлана. Иймэрхүү байдлаар зорьсон газраа олж очих уу? Олохгүй. Энэ бүхэн бидний очих сүмийн замтай ямар ч хамаагүй.

Үүнтэй адил бид "Дао"-г эрж" "Бурхан болъё" гэвэл эхлээд заавал "Дао"-г олох хэрэгтэй. Иймд Лууз: "Дао нь өгүүлж болбол, мөнхийн Дао бус." гэжээ. Энэхүү "Дао" хэдийнээ байж байсан, хэдийнээ төгөлдөржсөн. Энэ бол жам ёсны зам мөр тул засаж өөрчлөх шаардлагагүй. Энэ замд ороход тусгайлан хийгээд байх

зүйлгүй. “Дао”-г эрэхийн тулд л ёс суртахуунтай байх ёстой юм биш, бид угаасаа л тийм байх учиртай. Ёс суртахуунтай байх нь хүний үндсэн хариуцлага бөгөөд бидэнд заавал байх ёстой чанар. Бид бага сургуулиас эхлээд ёс суртахууны олон хэм хэмжээг заалгасан. Жишээ нь, ядуу хүнд туслах, хөршдөө найрсаг хандах, эцэг, эхдээ ачлалтай байх гэх мэт.

Миний санаж байгаагаар өндөр настан юм уу хараагүй хүнтэй зам дээр таарвал дагуулж гарах хэрэгтэй гэж бага сургуульд заадаг. Энэ нь бусдыг хайрлах сэтгэлтэй байхыг бидэнд сургасан хэрэг. Манай Ау Лакт “Холын төрлөөс ойрын хөрш дээр.” гэсэн цэцэн үг бий. Хөрштэйгөө найрсаг дотно байж, бие биедээ туслах хэрэгтэй. Тэдэнд хэрэгтэй зүйлээр нь тусалбал хожим нь тэд ч бидэнд тусална. Энэ бол маш энгийн зүйл бөгөөд “Даог олох”-той хамаагүй. Ядуу, өлсгөлөн хүнийг харвал аяндаа л түүнийг хооллоно. Энгийн хүн ч ингэнэ.

Энэ бол хүмүүсийн хооронд угаас байдаг үндсэн харилцаа. Бусад хүн хэцүү зовлонд учирч, биднээс илүү зовж байгааг хараад энэрэх сэтгэл аяндаа төрж тусалдаг. Бясалгал хийдэггүй хүмүүс ч гэсэн тусалдаг, харин ч илүү сайн хийж мэднэ. “Би үзэл”-гүйгээр, өөрийгөө ёс суртахуунтай, сайн үйл хийж байна гэж бодолгүй аяндаа л хийнэ. Энэ нь түлсэн, эсгэсэн гартаа даруйхан эм түрхэж, боолт хийхтэй адил. Учир нь бид гараа сайн хамгаалбал маргааш нь ажиллаж чадна. Иймд гараа өвдвөл даруйхан арчилж торддог.

Үүний нэгэн адил хөршүүд болон ах дүүсээ зовлон бэрхшээлтэй байхыг хараад тэдэнд даруй тусалдаг. Энэ бол тун энгийн хэрэг. Ийм байвал Эзэн Бурхан намайг ямар сайн хүн бэ? гээд сүнсний гэрт маань хүргэнэ гэж бодож болохгүй. Тэгэхгүй, тийм юм байхгүй. Эзэн Бурхан эсвэл “Дао”, “Бурхан чанар” нь төвийг сахидаг тул сайныг хийсэн үү, саарыг хийсэн үү гэдгийг чинь хайхрахгүй. Тэр бол Тэр. Хэрэв олъё гэвэл “Зөв зам”-аар орж байж л Түүн рүү очно. Энэ замаар сайн, муу ялгаагүй явъя гэсэн нь явж болно.

Жишээ нь, гаднах замаар ямар ч хүн явж болдог. Тийм үү? Согтуу, хулгайч, сайн, муу хүн, тэр ч байтугай ерөнхийлөгч ч явж болно. Энэ зам хэн нь сайн, хэн нь мууг хайхрахгүй. Гэвч ууланд очиход энэ л замаар явна. Бид өчүүхэн ач буян юм уу, сайн үйл хийж хураасан жаахан буянаараа гэгээрлийг олохгүй. Тийм юм байхгүй. Гэвч үнэн сэтгэлээр “Даог эрж” байгаа хүн мэдэж сайн хүн байж таарна. Жишээ нь, бясалгалтнуудын намтрыг уншвал хамгийн ёс суртахуунтай хүмүүс байсныг нь мэдэж болно.

Хэдэн зуун жилийн өмнө Ау Лакт нэгэн мэргэн хаан байжээ. Хүмүүнлэгээр засаглаж, иргэдээ хайрладаг болохоор ард түмэн нь түүнийг хайрладаг байв. Хүн бүрийг хайрлах сэтгэлтэй ийм л нэгэн байжээ. Тэр улс орноо шалган байцаахаар байнга тойрон аялдаг байсан аж.

Нэг өдөр хотоос гарч явахдаа, замын хажууд нэгэн ядуу хүн үхсэн байхыг харжээ. Хувцасгүй нүцгэн хэвтэж байхыг хараад, нулимс унагааж, өмссөн хувцсаа тайлан ядуу хүнийг хучжээ. Хааны хувцас үнэтэй тансаг хэдий ч тэр үед өөрийгөө хаан гэж бодсонгүй, тэр хүнийг үхсэн гэж бас бодсонгүй. Ийм үнэтэй тансаг хувцсаар түүнийг хучсан нь хэтэрхий үрэлгэн явдал болох бус уу? Тэр олон юм бодолгүй аяндаа үүссэн өрөвч сэтгэлээр бусдын зовлонг хараад өөрт байгаагаа өгчээ. Үүнийг л жинхэнэ их билиг барамид өглөг гэнэ.

Их билиг барамид өглөг гэж юу болохыг та нар мэдэх үү? Яавал жинхэнэ өглөг болох вэ? “Би” өгч байна гэж санахгүй, өглөгийн хэрэгтэй эсэх, өөрт ашигтай эсэхийг бодолгүй, дотоод сэтгэлээс аяндаа үүсэж гарсныг их билиг барамид өглөг буюу жинхэнэ төгс өглөг гэнэ. Өглөг өгөхдөө буян горилдог бол ямар ч хэрэггүй. Өчүүхэн бага буянтай.

Би багадаа олон хэрэг хийж байсан. Аав ээжийнхээ мөнгө, гэрийнхээ хоолыг хулгайлж ядууст өгдөг байв. Тэр үед балчир байсан болохоор ингэх нь буруу эсэхийг мэдэхгүй. Мөнгөтэй бол өглөг өгч болно. Харин бусдын мөнгө эд зүйлийг хулгайлан хүнд өгч болохгүй. Гэвч хүүхэд болохоор юмны учрыг ойлгохгүй, ирсэн гуйлгачныг хараад их өрөвддөг байсан. Заримдаа дэндүү олон хүн ирдэг тул аав, ээж тэднийг хайхрахгүй. Эсвэл ажлаасаа болоод анхаарах завгүй байдаг. Энэ үед би жаахан мөнгө, идэх юм сэмхэн хулгайлж тэдэнд өгдөг байв.

Балчир хүүхэд ядуу зовлонтой хүн хараад тусалъя гэж бодохдоо эцэг, эхийн зөвшөөрөлгүйгээр өгч болохгүйг мэддэггүй. Тэр үед манай хөршийнхөнд ч мөнгөгүй ядуу хүмүүс олон байсан. Би тэдэнд ээжийнхээ хоол болон бусад хүнсийг байнга хулгайлж өгдөг байв. Тухайн үед юу ч боддоггүй байсан. Одоо бодоход ингэх нь дэмий байж. Гэвч тэд маань одоо мэдвэл намайг муу хүүхэд гэхгүй.

Сая багын явдлаа дашрамд дурдлаа. Одоо Ау Лакын мэргэн хааны тухай эргээд ярья. Тэр их энэрэнгүй сэтгэлтэй хүн байв. Хожим нь гэрээс гарсан. Хориод наснаасаа гэрээс гарч, Бурханы ёсонд суралцан, бясалгаж Будда болох бодолтой байжээ. Хаан болсон хэдий ч нэг өдөр сэмхэн оргов. Зарим хүн гэрлэхийг

албадахад тэр дургүйцдэг байв. Тухайн үед төрийн ордонд нэгэн их түшмэл байжээ. Тэрээр өмнөх хааны ахмад түшмэл бөгөөд төр улс байгуулалцсан гавьяатай хүн байж. Тэр өмнөх хааны зарлигаар залуу хааныг халамжлан хүмүүжүүлж байсан тул үүндээ бардамнаж дургүй зүйлийг нь албадан хийлгэдэг байв.

Нэг өдөр тэрээр сайн санаат залуу хааныг садныхаа охинтой гэрлүүлнэ гэж хүчлэхэд хаан дургүйлхэв. Тухайн үед хаан гэрээс гарахаар шийдсэн байжээ. Тэрээр хааны өндөр сэнтийг хайхралгүй, ордноос сэмхэн явж ууланд ирээд алдартай даяанчид шавилав. Гэтэл хэдхэн сарын дараа төрийн ордны их бага түшмэд бүгд ууланд ирж түүний байгаа газрыг эрж олоод ордондоо буцахыг гуйсанд хаан дургүйцжээ. Тэгэхэд нь нөгөө ахмад түшмэл: "За за, та ордондоо буцахгүй бол хаана байгаа газар чинь манай ордон нүүж очно." гэв.

Түүний багш нь ч бас аргагүйдэж, залуу хаан ч яах учраа олохоо болив. Багш нь түүнд: "За, та буц даа. Гэртээ ч гэсэн бясалгалыг дадуулж болно. Мартахгүй л байх хэрэгтэй. Асуулт байвал багшаасаа ирээд асууж болно. Бясалгалаа дадуулаад л бай, завтай үедээ багш дээрээ ирээрэй. Цаг гарвал төрийн хэргээ түр орхиод ирж, хэсэг зуур битүүмжлэн бясалгаарай. Ингэж ч бас болно шүү. Хааны хэргэмээ хүүдээ залгамжлаад ирж надтай байнга амьдраарай." гэжээ. Хожим нь тэр хөгширч хаан суудлаа хүүдээ өгөөд гэрээс гарч дэс өндөр, билиг ухаантай их бясалгагч болоод төгс гэгээрэлд хүрчээ.

Тэр бол Ау Лакын ард түмний хамгийн хайртай хаан юм. Түүнийг төр барих үед хийсэн бүхэн нь ил тод байсан болохоор төр тогтвортой, цэвэр ариун байсан. Учир нь тэр улс орноо удирдахын зэрэгцээ бясалган дадуулж, билиг ухаанаараа улсаа удирдаж байсан тул алдаа гаргадаггүй байсан. Түүнийг төр барьж байх үед Ау Лакын утга зохиол, улс төр, хөдөө аж ахуй цэцэглэн хөгжсөн алтан үе байв. Бурханы шашин ч бадрангуй хөгжиж, бусад шашин ч элдэв дарамтгүй чөлөөтэй байв.

Түүнийг эрх барьж байхад баян, ядуугийн ялгаа бага, хууль зөрчигчид цөөн байв. Тэрээр улс орноороо тойрон явахдаа ард олныхоо амин чухал хэрэгцээг мэдэж чаддаг байсан. Тэр бол үнэхээр энэрэлтэй хаан юм. Түүний эцэг нь Бурхан шүтдэггүй, хүү шигээ энэрэнгүй, түгээмэл хайрын сэтгэлтэй байгаагүй. Эцэг нь Бурханы шашинтан байх эсэх нь чухал биш, харин хүү өөрөө үнэн сэтгэлээсээ бясалгал дадуулвал ялгаагүй их бясалгагч болж чадна.

Миний аав, ээж маань католик шашинтан, бурханы

шашинтай төдий л холбоогүй. Гэсэн ч тэдний хувьд Есүс Христ нь зөвхөн нэгэн нэр төдий. Тэд шашны талаар нэг их анхаардаггүй. Миний аав сайхан сэтгэлтэй, сайн хүн хэдий ч ямар нэг юманд жинхэнээсээ итгэж, үнэнийг олохын төлөө явдаггүй байсан. Миний ээж тийм ч өглөгч биш. Тэгсэн ч би Бурханы шашны гэлэнмаа болж, гэгээрлийн зам мөрийг эрэх дуртай байсан.

Иймээс хувь хүний ар гэрийн нөхцөл байдал гэгээрэлд тэмүүлэх сэтгэлтэй хамааралгүй, дэстэй ч холбоогүй. Ихэвчлэн урьд төрөлдөө бясалгал дадуулж байснаас энэ төрөлдөө "Дао"-г эрж, сайн багш, сайн бясалгалын аргатай учрах бөгөөд энэ нь эцэг, эхийн буянтай ямар ч хамаагүй. Хэрвээ бид энэрэн нигүүлсэх, хамаг амьтныг хайрлах сэтгэлтэй бол энэ нь биднийх болохоос эцэг, эхтэй огт хамаагүй. Эдгээрийг та бүхнийг зоригжуулахын тулд ярьж байгаа юм. Өөрийгөө ядуу, буянгүй, Бурханы шашин шүтдэггүй, эсвэл шашин шүтлэггүй гэр бүлд төрж өссөн гэж бодоод итгэл алдарч болохгүй.

Урьд нь Бурханы шашныг шүтэж байгаагүй, энэ талаар мэдлэггүй, бясалгалын тухай ойлголтгүй бол сүнслэг дадал бясалгал хийж болох уу? амжилт олох уу? гэж зарим хүн Багшаас нь асуудаг. Би болно гэдэг. Учир нь энэ нь өнгөрсөн, одоо, ирээдүйтэй огт хамаагүй. Номонд орж, бясалгал дадуулж, гэгээрэхийг яг одоо "хүсэж" байвал даруй биелүүлж болно. Энэ нь бидний одоогийн орчин нөхцөлтэй хамааралгүй.

Бидний хайж буй "Дао" нь өглөг өргөл, ёс суртахуунтай холбоогүй гэж би сая хэлсэн. Гэвч огт холбоогүй гэж болохгүй. Учир нь гэгээрэлд тэмүүлсэн хүн гарцаагүй сайхан сэтгэлтэй байх ёстой. Саяхан ярьсан тэр хаан тийм энэрэл хайрын сэтгэлтэй байсан тул хожим нь бясалгалыг хичээнгүйлэн дадуулж гэгээрэлд хүрсэн бөгөөд энэ нь түүний урьд төрөлдөө бясалгаж байсантай холбоотой. Бид урьд нь ёс суртахуунтай зүйл хийж байгаагүй бол өнөөдрөөс эхлээд буяны үйл үйлдэж болох ч энэ нь дадал бясалгалтай тийм ч их холбоогүй.

Бид сайн хүн байх хэрэгтэй. Тэгвэл аав ээж, анд найз, айл хөршийнхөн бүгд баярлана. Тэд баярлавал бид ч мөн баярлана. Тийм үү? Хорсол занал, олны эсэргүүцэл дүүрэн газарт бид амьдрах аргагүй. Тийм газарт бясалгахад маш их хэцүү. Иймээс бид буян үйлдэж, чадахаараа өглөг өгч, сахил сахиж, хүлцэнгүй байвал бидний бясалгал дадалд тустай. Гэвч зөвхөн өглөг өгч, сахил сахиж, хүлцэнгүй байх нь хангалттай биш. "Очироор огтлогч судар"-т өглөг, сахил, хүлцэнгүй, хичээнгүй, даяан, билиг зургаан барамидыг хамтад нь бясалгахын чухлыг тодорхой

заасан. Тэгэхээр даяаныг бясалгахгүй бусад тавыг бясалгах нь хангалтгүй.

Даяан гэж юу вэ? Бясалгах үед бодол цэгцэрч, сэтгэл тогтоно. Сэтгэлээ нэгэн газарт тогтоон баривал гаднын нөлөөнд автахгүй болдог. Үүнийг "Даяан" гэнэ. Даяаны үед бид өөрийн Уг дүр, Бурхан сэтгэлтэйгээ холбогдоно. Үүнийг Уг дүр, Бурхан чанар эсвэл Дивааажин, Эзэн Бурханы хүч, "Дао" гэх мэтээр юу гэж нэрлэж болно. Тэр тун хүчирхэг болохоор юуг ч шийднэ. Түүнд аливаа буян хишиг бүгд бий.

Бид ийм хүчтэй холбогдчихвол буян үйлдэлгүй буянтай болж, сайн үйл хүчилж хийлгүй аяндаа ёс суртахуунтай болно. Учир нь энэхүү жам ёсны хүч биднийг өөрчлөн, дотоодыг ариусгаж, жинхэнэ сайн хүн болгоно. Дотоодыг хувирган өөрчлөх төдийгүй гаднах нөхцөл байдалд маань ч санаа тавина. Жишээ нь, бид ямар нэгэн бэрхшээлтэй тулгарвал Тэр тусалдаг. Яагаад гэвэл энэхүү билиг ухаан бол "Билиг барамид", энэхүү Бурхан сэтгэл бол их билиг ухаан, их хүч чадал. Бид ийм их хүчинд түшиглэвэл бэрхшээл зовлонгүй болно.

Бид нэр төр, ашиг хонжоо, шунал тачаал зэрэг гаднын зүйлээр хөөцөлдвөл эдгээр нь мөнх бус. Өнөөдөр мөнгөтэй ч маргааш хоосон, өнөөдөр нэр төртэй ч маргааш хүнд гүтгүүлнэ, хорлогдоно, байр сууриа алдана. Эртний хаад ноёд нэг л өдрийн дотор улс гүрнээ эзлүүлж, баячууд бие биеэ хуурч мэхэлсээр юу ч үгүй хоосорсныг бид мэднэ. Өнөөдрийн байр суурь, эд хөрөнгө чинь маргааш байсаар байх уу?

Бид билиг барамидтай нэвтрэлцэж энэхүү их билиг ухаан, их хүчтэй холбогдвол алдахын айдасгүй болно. Учир нь энэ хүч хувиршгүй мөнх бөгөөд энэрэнгүй, аядуу зөөлөн хайраар үргэлж бидэнд тусалдаг. Энэ хүч нь ертөнцийн хамгийн сайн найзаас ч итгэлтэй. Найз бол нэг л өдөр биднээс нүүр буруулна. Гэвч энэ хүч, Бурханы хүч, билиг барамид бол биднээс хэзээ ч нүүр буруулахгүй, үргэлж хамгийн сайн анд нөхөр минь байсаар байх болно.

Иймээс Есүс Христ: "Өөрийн дотоодын диваажинг олбол бүх зүйл биднийх болно." гэжээ. Шагжамуни Будда: "Бурхан сэтгэлд бий." гэсэн. Бурхан сүмд байдаг бол Тэрээр Бурханыг сүмд байдаг гэж хэлэх байсан. Хэрэв бид сүмд мөргөх юм уу, бусад ямар нэг өнгөцхөн зүйл үйлдэх ёстой байсан бол Тэрээр: "Их өглөг өгвөл Бурхан чанараа олно." гэх буюу "Сүмд мөргөвөл Бурхан чанараа олно." гэх байсан. Тийм үү? Гэтэл ингэж хэлээгүй, харин "Бурхан сэтгэлд бий." гэж хэлсэн.

“Бурхан сэтгэлд бий.” гэдэг нь ямар утгатай вэ? Сэтгэл доторх Бурханаа эрж олох хэрэгтэй гэсэн үг. Сэтгэл гэж юу вэ? Энэ бол хувь хүний орон зай. Бусад хүн мэддэггүй, ойлгодоггүй маш олон зүйлс бидний сэтгэлд бий. Энэ бол тун нууцлаг газар бөгөөд энд л Бурхан оршдог. Иймээс Есүс Христ: “Диваажин ёс суртахуунаас үүсээгүй тул тэндээс эрээд олдохгүй. Диваажин бидний дотор оршдог.” гэж ижил зүйлийг ярьжээ.

Хоёр Их Багшийн ярьсан зүйл адил. Шагжамуни Будда “Будда чанар”, Есүс Христ “Диваажин” гэсэн нь юугаараа өөр юм бэ? Нэр нь өөр болохоос утга санаа нь яг ижил. Их Багш нарын санааг ойлгоогүйгээс Тэдний өршөөнгүй, хязгаргүй сургаал номлолыг явцуурууллж, хязгаарлагдмал хувийн үзэл болгосноос шашин хоорондын маргаан үүсдэг. Бурханы болон католик шашин бүгд хязгаарлагдмал шашин болж хувираад хоорондоо маргалдаж байгаа нь Тэдний номлолыг үл ойлгосноос үүдэлтэй.

Иймээс Шагжамуни Будда: “Бурханд итгэсэн ч Түүнийг ойлгохгүй бол Бурханыг гүтгэсэн явдал болно.” гэж хэдийнээ бидэнд сэрэмжлүүлсэн. Түүнийг анхааруулсаар байтал бид ойлгохгүй л байна. Есүс Христ ч бидэнд сэрэмжлүүлж байсан. Тэр: “Танд наманчлан мөргөдөг. Таныг ч, Бурханыг хүндэтгэдэг гэж өдөр бүр яриад гэгээрлийг олохгүй, диваажинг олохгүй.” гэжээ. Түүний санаа нь Буддагийн хэлсэнтэй яг адил.

“Буддаг ойлгох” гэж юуг хэлж байна вэ? Бурхан чанараа олсныг л Буддаг ойлгох гэнэ. Будда (Бурхан)гэдэг нь Buddha буюу самгарди хэлээр гэгээрсэн, цацарсан гэрэлтэй гэсэн утгатай. Иймээс Шагжамуни Будда цацарсан гэрэлтэй, түүний хөрөг дээр ч байдаг. Есүс Христ болон бусад их бясалгалтнуудын биеэс тод гэрэл цацарч байдаг. Үүнийг хүн бүр биш, зөвхөн өндөр түвшинд хүрсэн сүнслэг бясалгагч л харж чаддаг. Бурханsu олъё, Түүнийг ойлгоё гэвэл эхлээд өөрөө Бурхан болох хэрэгтэй. Бурханыг эрж олоод Түүнээс суралцаж, өөрөө Бурхан болох хэрэгтэй. Бурхан болохгүй бол Бурханыг яаж ойлгох вэ?

Өөрөө үр хүүхэдтэй болохоос нааш эцэг, эхийн сэтгэлийг ойлгохгүй гэж бид ярьдаг. Бурханsu ойлгоно гэдэг нь үүнтэй ойролцоо. Бурхан болохоос нааш Бурханыг ойлгох боломжгүй. Иймээс Шагжамуни Буддагийн хэлсэн санаа бол өөрөө Бурхан болох хэрэгтэй, харин Бурханд итгэж, мөргөх төдий байж болохгүй гэсэн үг. Учир нь Бурханд итгэсэн ч, Бурханыг ойлгохгүй юм бол яаж жинхэнээр итгэх юм бэ? Бурханыг ойлгохгүй бол юунд ч итгэсэн мухар сүсэг болно. Учир нь ойлгоогүйгээс мухар сүсэг болж хувирдаг. “Мухар сүсэг” нь ойлгож мэдээгүйгээс үүдэлтэй

тул Бурханыг ойлгоё гэвэл Бурхан болох хэрэгтэй. Гэгээрье гэвэл “Дао”-г олох хэрэгтэй. Үүнээс өөр аргагүй.

Лууз: “Дао байвал бүгд байдаг.” гэжээ. Энэхүү Дао” нь алгуур алдагдсаар яваандаа ёс суртахуун болон хувирч, хожим өршөөл, журам, ёслол, ухаан, итгэл зэрэг нийгмийн янз бүрийн ёс суртахуун үүссэн байна. “Дао” бол хамгийн дээд нь бөгөөд аливаа ёс суртахууны хэм хэмжээнээс дээгүүр. Иймээс “Дао “-г олох хэрэгтэй. Олбол бид бүрэн ёс суртахуунтай болно. “Дао”-г алдсанаар нийгмийн маш олон ёс суртахууныг “зохиомлоор” тогтоох хэрэгтэй болжээ. “Дао”-г жинхэнээр ойлгож, жинхэнээр олбол өчүүхэн зохиомол ёс суртахуун хэрэггүй болно. (18-р бүлэг: “Их мөрийг алдсанаар өршөөл журам үүсжээ, арга ухаан хэрэглэснээр худал хуурмаг үүсжээ.”)

Бид Бурхан чанараа олж Бурхан болсны дараа зургаан барамид (Үүнд: өглөг, сахил, хүлцэнгүй, хичээнгүй, даяан, билиг багтана)ыг хичээхгүйгээр аяндаа үйлдэнэ. Тэр үед бид өөрөө их хүч болон хувираад өглөг өгье гэвэл даруй өгнө. Ганц хоёр аяга хоол, хувцас хунар төдий биш, маш их буян өгнө. Хүн буян хишигтэй бол идэх хоол, өмсөх хувцастай байх нь мэдээж. Иймээс баян хүнийг их буянтай гэж бид ярьдаг. Бурхан болсны дараа хязгааргүй буянаар өглөг өгнө. Хоол, хувцас зэрэг материаллаг зүйлийг өгснөөс илүү хүчтэй, илүү тустай. Иймээс заавал Бурхан болох хэрэгтэй.

Зарим шашин, шашны урсгалууд өглөг өгөхийг хөхиүлэн дэмждэг. Өглөг өгөөд харьж, бурхандаа мөргөвөл болно гэж боддог. Яаж болох вэ? Бурханд мөргөөд Бурхан болохгүй. Бурханд мөргөж болох ч яагаад мөргөж байгаагаа мэдэх хэрэгтэй. Бурханд мөргөх нь сургаалын эзнээ хүндэтгэж байгаагийн илрэл. Шагжамуни Будда байгаагүй бол Бурханы шашин байхгүй, “Маш далд, гүн нууцлаг тэнсэлгүй ном”-ыг бага ч гэсэн ойлгох завшаан олдохгүй, бясалгах сэтгэл үүсэхгүй байсан. Иймээс бид Түүнд мөргөж талархах ёстой.

Бурханд мөргөнө гэж түмэн хүслээ биелүүлэхийг Түүнээс гуйхыг хэлэхгүй. Олон хүн: “Авид бурханд мөргөмүй, Арьяабал бурханд мөргөмүй, Шагжамуни Буддад мөргөмүй, надад ийм юм хайрлана уу, миний тийм юмыг бүтээж өгнө үү.” гэж залбирдаг. Ийм байдлаар Бурханд мөргөж болохгүй. Бурхан тийм юм өгдөггүй. Учир нь Тэр бидэнд юу ч өгсөн хэрэг болохгүй. Тэр мөнгө өгвөл маргааш нь дуусчихдаг. Баян болговол чинээлэг амьдралдаа бардамнаад элдэв муу хэрэг хийж, улам их үйл лай хураана. Чинээлэг хүмүүсийн ихэнх нь утга учиргүй амьдардаг.

Мөнгөтэй байсан ч яршиг төвөг ихтэй.

Энэтхэг орон хэдий ядуу ч ариун дагшин бясалгалын газар юм. Бүхий л Их Багш нар Энэтхэгээс гаралтай эсвэл тэнд суралцсан, тэндхийн бясалгалын аргатай холбоотой байдаг. Учир нь Энэтхэг бол үеийн үед ариун орон байсаар ирсэн. Есүс Христ арван гурваас гучин нас хүртлээ Хималайн ууланд олон Их Багштай хамт бясалгал дадуулж байжээ. Шагжамуни Будда, миний багш нарын нэг нь бас Энэтхэг хүн байсан. Маш олон алдартай номын багш нар Энэтхэг юм уу дорно дахины хүмүүс байдаг.

Үеийн үед Энэтхэгт маш олон алдартай бясалгалын ариун газар байсаар ирсэн. Гэвч бусад улс орноос баян биш, харин хамгийн ядуу газар билээ. Америк, Герман, Франц зэрэг мөнгөтэй баян орнуудаас агуу "Төгс Гэгээрсэн" Их Багш гарсан уу? Гарсан ч тэд Шагжамуни Будда, Есүс Христ шиг нөлөөтэй биш. Шагжамуни Будда, Есүс Христ бүгд дорно дахины хүмүүс. Дорно нь өрнөөс ядуу ч тэндээс олон сэтгэгч, агуу билиг ухаантнууд, тухайлбал Шагжамуни Будда, Есүс Христ, Бодьдарма, Хүй Нөн, Бай Жан, Хуанпи, Лууз, Күнз нар төрөн гарчээ.

Өглөг өгөх нь хамгийн төгс туулан гэтлэх арга юм бол Шагжамуни Будда хүү Рахулагаа гэрээс гарахыг ятгахгүй. Рахула тухайн үед есхөн настай байсан бөгөөд хаан суудал залгамжлахаар бэлтгэж байжээ. Шагжамуныг явсны дараа Рахула хаан болов. Тэгээд өвлөх хөрөнгөө Шагжамуни Буддагаас лавлахаар очоод : "Та бол миний эцэг, залгамжлах хөрөнгө маань хаана байна вэ? Би одоо авъя." гэжээ. Эцэг хүн хүүдээ эд хөрөнгөө үлдээдэг. Тийм үү? Энэ үед Шагжамуни Будда: "За, чи надтай цуг явбал эд хөрөнгөө олж авна." гэжээ. Есүс Христ ч бас адил зүйл хэлсэн байна. Түүнээс: "Их Багш аа, таныг хаан гэж ярилцаж байна. Таны улс орон, нутаг дэвсгэр хаана байна вэ?" гэхэд Есүс Христ: "Миний улс диваажинд бий, энд байхгүй." гэж хариулжээ.

Энэ ертөнцийн юмс мөнх бус, ямар ч хэрэггүй болохоор Шагжамуни Будда, Есүс Христ энэ ертөнц дээр эд хөрөнгөтэй байхыг сайшаадаггүй. Харин өөрийн диваажин болон нирваан дахь үнэт эрдэнэсээ олоход зоригжуулдаг. Энэ бол өнө мөнхийн эд баялаг. Иймээс Шагжамуни Будда хүүгээ гэрээс гарч хувраг болохыг ятгажээ. Хүү нь гэрээс гарвал хамгийн дээд эд баялгаа хайж олоод туйлын баяр жаргалтай амьдрахыг Тэр мэдэж байсан. Тийм биш бол Шагжамуни Будда шиг гэгээрсэн хүн хүүгээ гэрээс гарахыг юунд ятгах вэ? Түүнийг хорлох гэсэн хэрэг үү?

Рахула ханхүү тул ордонд амьдарч, ертөнцийн жаргалд умбаж, хүссэнээ авч болох байсан. Будда яах гэж түүнийг гэрээс гарч, хатуу бясалгал дадуул гэж ятгах вэ? Тэр үед гэрээс гарагчийн амьдрал одоогийнх шиг таатай биш. Өдөр бүр явган явна. Шагжамуни Будда болон түүний шавь нар олон газар очиж ном тавихдаа байнга явган явдаг байв. Солих хоёр гурван хувцастай, замын хажууд юм уу эсвэл хаа тааралдсан газраа унтдаг. Өөрөөр хэлбэл тэдэнд тогтсон тохилог газар байгаагүй. Гэрээс гарах нь ийм хэцүү байхад яагаад түүнийг гэрээс гарахыг ятгасан юм бэ? Хүүгээ хайрлахгүй, зориуд зовлонтой амьдрал үзүүлэх гэсэн хэрэг үү? Үгүй. Түүгээр хамгийн дээд эд баялаг, хамгаас баяр жаргалтай газрыг нь олуулахын төлөө юм. Иймээс л Шагжамуни Будда түүнийг гэрээс гарахыг ятгажээ.

Өглөг өгөх нь Бурхан чанараа олж, Бурхан болгодог хамгийн дээд бясалгалын арга, хамгийн дээд арга байсан бол Шагжамуни Будда: “Чи буцаж очоод сайн хаан болж, улс орныхоо эд баялаг, эрх мэдлээ ашиглан хамаг амьтанд тус хийгээрэй. Ядуучуудад мөнгө өгч, ард иргэдээ харж хандаарай.” гэх байсан. Гэтэл Тэр ганц хүүгээ хувраг болгож, бадар бариулан гуйлгачинтай адил хаа сайгүй бадарчлуулах гэсэн. Зөвхөн өглөг өгөх нь хангалтгүй, нирвааныг олж чадахгүй гэдгийг ном судраас мэдэж болно.

Буддад мөргөвөл ямар буянтай вэ? Шагжамуни Буддаг амьд сэрүүн байхад Буддад мөргөвөл буян хишигтэй. Учир нь “Ертөнцөд саатаж буй Будда”-д мөргөж байгаа болохоор тэр. Тэр бол ихэд билиг нээгдсэн, тэнгэрийн болон хүмүүн төрөлтний жолоодогч Багш болохоор Түүнд мөргөвөл буян хишгээсээ жаахныг бидэнтэй хуваалцана. Иймээс тэр үед Буддад мөргөх нь буянтай байжээ. Гэвч би та нарт үнэнийг хэлэх ёстой. Модон бурханд мөргөвөл буянгүй. Модон Будда бурхан яаж буян өгөх вэ? “Өглөг өгөх хэрэггүй, Бурханд мөргөх хэрэггүй.” гэж Багшийнх нь хэлэхийг сонсоод зарим хүн намайг буруу номтон гэдэг. Яагаад буруу номтон гэж? “Дао” гэж юу болохыг огт мэдэхгүй байж, юунд буруу, зөв номтон гэнэ вэ?

Өөрөө ном сударт нэвтрээгүй тул утгыг нь ойлгохгүй, Шагжамуни Буддагийн “Маш далд, гүн нууцлаг ном”-ыг мэдэхгүйгээс хэн ч, юу ч ярьсан ойлгож чадахгүй тул юунд буруу, зөв номтон гэж ярина вэ? Үнэндээ буруу ч үгүй, зөв ч үгүй, Бүгд л “Дао” юм. “Дао”-г олоогүй бол буруу номтон хэвээр л байна. “Дао”-г олбол католик болон бурханы шашинтан, күнзийн болон даогийн шашинтан хэн нь ч ялгаагүй бүгд зөв номтон болно. Учир нь “Дао” ганцхан байдаг. Иймээс ямар ч шашин шүтсэн

“Дао”-г олбол бүгд зөв номтон болно. Олохгүй бол бүгд буруу номтон болно.

Энэхүү “Дао”-г олох нь бидний буян үйлдэж, өглөг өгөхтэй холбоогүй, Бурхан мөргөхтэй ч хамаагүй гэж би сая хэлсэн. Энэ “Дао”-г олохоос өмнө юунд ч мөргөж, юу ч хийсэн төдийлөн хэрэг болохгүй. “Дао”-г олсны дараа бид Бурханд мөргөвөл их буянтай болно. Учир нь тэр үед хаанахын ямар Бурханд яаж мөргөвөл буян хишигтэй болохоо мэддэг болно.

Шагжамуни Буддаг амьд сэрүүн байхад нь мөргөсөн бол тун их буянтай болох байсан. Будда энэхүү ертөнцөөс ангижирсны дараа бид өөр Буддаг олж мөргөх хэрэгтэй. Ганцхан Шагжамуни Буддад мөргөх биш, харин билиг нь жинхэнээр нээгдсэн Буддаг хайж олоод Түүнд мөргөж болно. Эсвэл өөрийн Бурхан чанартаа мөргөж болно. Гэхдээ энэхүү Бурхан чанараа эрж олж байж л мөргөж болно. Харин олоогүй байж: “Өөрийн Бурхан чанартаа мөргөлөө.” гэвэл худлаа ярьсан болно. Бурхан чанараа хаана байгааг ойлгоогүй байж юунд нь мөргөх вэ?

Энэтхэгт хэн нэгнийг хүндэтгэвэл түүнд мөргөдөг заншилтай. Энэ заншил Хятадад нэвтрэхдээ Бурханд мөргөх болж хувирчээ. Угаасаа “амьд сэрүүн хүн”-д мөргөдөг болохоос, түүний хөшөө баримал, гэрэл зураг, дүр дүрсэнд нь мөргөдөггүй байсан. Иймээс “Очироор огтлогч судар”-т: “Дүрсээр надтай уулзаж, дуугаар надад даатгах нь буруу мөрийн явдал, түүнчлэн ирсэнтэй уулзаж чадахгүй.” хэмээн тодорхой бичсэн байдаг.

Бид өнгөн талын явдалд бус өөрсдөдөө найдах хэрэгтэй. Гэхдээ юуны өмнө өөрийн уг дүрээ эрж олоод, энэхүү хүчтэй Бурхан чанар, хүчтэй Уг дүрээ түшиглэн, эсвэл энэхүү орчлонгийн ханьцашгүй үнэхээр туулсанд түшиглэн, ханьцашгүй үнэхээр туулсныг эрж олсны дараа Түүнд мөргөж болно. Энэ үед бид юу ч хийсэн зөв номтон болно. “Дао”-г олохоос өмнө бид бүгд буруу номтон байдаг. Ямар ч Бурхан эсвэл Есүс Христэд мөргөж, хэчнээн ч ач буян хийсэн, ямар ч номын багш болсон буруу номтон хэвээр байх болно.

Энэхүү Үнэн ёс, энэхүү ханьцашгүй үнэхээр туулсныг яривал маргааш ч дуусахгүй. Хэрэв Багш чинь та нарт тусалж, ханьцашгүй үнэхээр туулсныг эрж ололгүйгээр зөвхөн үг яриагаар тайлбарлах юм бол ярьж дуусахгүй. Тэгэхээр энэ хүртэл яриад дуусгая. Хэрэв та нар энэ уг дүрийг олъё гэвэл яаж олохыг үдээс хойш та нарт хэлж өгье. Би ханьцашгүй үнэхээр туулсан биш ч, түүний хаана байдгийг та нарт зааж өгч болно. Та нар өөрсдөө олоорой. Олоход хялбар бөгөөд хурдан учраас түүнийг агшин

зуур ухаарах бясалгалын арга гэдэг.

Гэвч олсны дараа болгоомжтой байх хэрэгтэй. Учир нь бид төрлөөс төрөлд тогтсон үзэлд баригдсаар ирсэн тул билиг нээгдсэний дараа түүнийгээ мэдэхгүй байж магадгүй. Зарим хүн нас нөгчөөд үүнийгээ мэдэхгүй гэртээ нааш цааш холхин, гэрийнхэндээ төвөг удаж, тэдэнтэй ярилцах гэж оролддог гэж би хэд хэдэн удаа ярьсан. Гэвч түүнийг сонсох, харах хүнгүй болохоор урам нь хугаран бухимдаж маш зовдог. Учир нь өөрийгөө сүнс болсныг тэр мэдэхгүй бөгөөд жирийн хүмүүс түүнийг харахгүй. Зарим хүн ертөнцөөс ангижрахдаа нэг их айхавтар хүчтэй юм мэдэрдэггүй. Нойрсоод сэрсэн мэт, эсвэл байшингийн дооройос дээд давхарт гарсан мэт тун энгийн байдаг. Тэд үхсэнээ мэдэхгүй болохоор бусдад саад болдог.

Ад чөтгөрүүд хүнээр тоглоом наадам хийх юм уу, хүнд төвөг зовлон уддаг тухай бид их сонсож байсан. "Эхнэр маань яагаад намайг сонсохгүй байна? Толгойг нь илсэн ч хариу байхгүй. Бас өөр эрэгтэйг дагуулж ирээд гэрлэнэ гэнэ. Намайг байсаар байтал гэрлэх тухай бодож зүрхэлнэ гэнэ ээ?" гээд хилэгнэн уурладаг. Бидний мэдэхээр зарим айлд үргэлж ад чөтгөр харагдаж, шөнө дөлөөр элдэв чимээ эсвэл хэрүүлийн дуу сонсогддог. Ийм газрыг ад чөтгөртэй гэж хүмүүсийн ярьдаг нь үнэн. Учир нь олон сүнс үхсэнээ огт мэддэггүй.

Билиг нээгдэх нь үүнтэй адил. Хамаг бие цахилгаан гүйдэлд цохиулсан шиг болохгүй. Харин ч аядуу тайван байдаг. Иймээс билиг нээгдсэн ч өөрөө мэдэхгүй байж болно. Миний сонссоноор дээр үеийн хүмүүс билиг нээгдсэний дараа Их Багшаар нотлуулдаг байсан нь ийм учиртай. Гэвч билиг нээгдэхэд их бага ямар нэгэн шинж мэдэгдэнэ. Үл мэдэг юм харж, бага сага нотолгоотой болдог ч аядуу тайван байдаг. Хэрэв та нар цахилгаан гүйдэлд цохиулсан мэт билиг ихээр нээгдэхийг хүсдэг бол тийм юм болдоггүй. Билиг нээгдсэний дараа хянамгай байж, тогтмол бясалгах хэрэгтэй. Бясалгал дадуулах тусам бид өөрсдийгөө хэдийнээ билиг нээгдсэнээ улам ухаарах болно.

Энэ нь өмнө дурдсан үхсэн хүний байдалтай адилхан. Тэрээр энэ ертөнцийг нэгэнт орхиж сүнс болсноо, эхнэртэйгээ ямар нэг харилцаагүй болсноо аажмаар ойлгоно. Сүнс хэдийгээр бухимдаж, дургүйцэвч аажмаар салан одоод цаг нь болохоор дахин төрөл авч өөр биеийг олж төрнө. Эсвэл сансрын хүрдэнд эргэлдэж явах замаараа явна.

Билиг нээгдсэн хүн ч адил, билиг нээгдсэн л бол нээгдсэн, нээгдээгүй байдалдаа эргэж орохгүй. Иймээс "билиг"-ээ

өөртөө шингээж чаддаг болтлоо бясалгалаа дадлаа аажуухан үргэлжлүүлэн хийсээр, улмаар билиг ухаанаа хөгжүүлэх хэрэгтэй. Тэр үед Багшийнх нь хэлсэн үнэн байж, "Билиг үнэхээр нээгдсэн"-ийг аяндаа ойлгоно.

Жинхэнэ ёсоор билиг нээгдсэнийг бусдад харуулж, бас өгч болохгүй болохоор ярьж болшгүй. Гэвч ойлгож болно. Учир нь өөрийн дотоод дахь өөрчлөлт хувирлыг мэдэрдэг. Билиг нээгдвэл бидний сэтгэл тогтуун болж, улам амгалан тайван, баяр баясгалантай болох бөгөөд юу ч хийсэн баригдмал бус, амар хялбар болдог. Ингэвэл бид билиг нээгдсэн гэдгээ мэдэж болно.

Билиг нээгдсэний дараа бидний сүнсэн бие Бурханы оронд очиж, Бурхантай уулзана. Тэр үед л Бурханд мөргөн залбирч болно. Бурханы оронд очиж мөргөх нь жинхэнэ ёсоор Бурханд мөргөж буй хэрэг. Тэр үед чи хэчнээн ч мөргөсөн Багш нь хориглохгүй. Энд мөргөөд хэрэггүй. Энд жинхэнэ Бурхантай уулзах боломжгүй тул хэнд мөргөх вэ? Билиг нээгдсэний дараа бүхий л орчлон ертөнцийг ойлгодог болсон, эсвэл билиг ухаан бүгд тодрон гарсан гэсэн үг биш. Билиг ухаан угаас байсан бөгөөд билиг нээгдмэгц гарч ирсэн юм биш. Бид түүнийг аажмаар нээж хөгжүүлэх хэрэгтэй.

Жишээ нь, Багш нь халуун усны газар олон давхар хувцастай очвол нэг нэгээр тайлж байж усанд орно. Үүнтэй адил билиг нээгдсэн ч Үнэн ёсыг тэр даруй бүрнээр нь ойлгохгүй. Иймээс Шагжамуни Будда нэлээд хэдэн жил бясалган дадуулах хэрэгтэй болсон. Есүс Христ ч мөн адил.

"Билиг нээгдэх" нь "Даог олох (Гэгээрэх)"-той адилгүй. "Билиг нээгдэх", "билиг нээгдсэнийг нотлох" хоёр хоорондоо асар зөрүүтэй. Багш нь зөвхөн билгийг чинь нээж өгнө. Хэрэв та нар "билиг нээгдсэнийг нотолж, даог олох" гэвэл урт хугацаа шаардагдана. Тасралтгүй бясалгал дадуулж Багшийнхаа ном тайлахыг байнга ирж сонсож, ойлгохгүй зүйлээ Багшаасаа асууна. Тэгээд бясалгал дадлаа бие даан хийж, асуудлаа өөрөө шийдвэрлэсээр байвал гурваас зургаан сарын хугацаанд том өөрчлөлт гарч, сайн үр дүнд хүрснийг биеэрээ мэдэрнэ. Дотоодын хувирал гарахад урт хугацаа шаардахгүй.

Өнөөдөр авшиг хүртэх үед та нар тэр даруй ахуй ойлголттой болж, билиг нээгдэж эхэлснийг гэрчлэх бага зэргийн нотолгоотой болсон. Эс бөгөөс бид мэдэхгүй. Хэрэв нотолгоогүй бол энэ бясалгалын арга үнэн эсэх, үр нөлөөтэй эсэхэд яаж итгэх вэ? Тэгэхээр авшиг хүртэхэд заавал нотолгоо хэрэгтэй. Бага ч гэсэн нотолгоотой болсны дараа түүнийгээ улам хөгжүүлэн тэлдэг.

Үүнийг “Авшиг” гэнэ. Авшиг хүртээхэд үг хэл хэрэглэхгүй, сэтгэлээс сэтгэлд (авшиг хүртээхэд юм ярьдаггүй) нэгэн их хүчээр уламжилна.

Тиймээс та нар мэдэрнэ, мэднэ, харна, сонсоно, үнэрлэж ч магадгүй. Хэрэв номыг үг хэлээр дамжуулах юм бол “ам”-аараа жигнэмэг гэж хэлсэнтэй адил. Амаар хэлсэн жигнэмэг нь идэж болдог жинхэнэ жигнэмэг байж чадахгүй.

Агшнаа гэгээрэх гэдэг нь таслах гэсэн утгатай. Юуг таслах вэ? Бидний бие махбодыг таслах бус, харин үхэх төрөхийн орчилд эргэлдэх шижмийг тасална. Иймээс авшиг хүртмэгц сансрын хүрдэнд эргэлдэхээ больж, эргэж төрөхгүй, энэ төрөл эцсийнх нь болно. Иймээс “Агшнаа гэгээрэх” гэдэг. Агшнаа ухаарвал даруй гэгээрч, үхэх төрөхийн орчилд эргэлдүүлэгч гав гинжийг шууд тасална. Гэвч Багшийнхаа агшнаа ухаарах гэж хэлэхийг сонсоод гэгээрэх үед ямар нэг хүчтэй мэдрэмжийг хүсэж хүлээсний хэрэггүй. Билиг угаасаа байсан. Гэвч Багш нь сансрын хүрдэнд эргэлдэхийг чинь таслан зогсоож байгаа учраас л “Билиг нээгдэх” гэж нэрлэсэн юм.

БУРХАНД МӨРГӨӨД БУРХАН БОЛЖ ЧАДАХГҮЙ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар. Формосагийн Тайпэй хотын Цаглашгүй гэрэлт бясалгалын төв.
1987 оны 9 дүгээр сарын 14
(Эх нь хятад хэлээр)

Ном уламжилж байж бясалгах боломжтой болно. Гэвч уламжилсны дараа та нар хүлээн авч чадах уу? тэтгэн тордож чадах уу? энэ үнэт эрдэнийг хэрэглэж чадах уу? гэдэг нь асуудлын гол юм. Эрт үед Их Багш нар хүмүүст ном уламжлахдаа тун болгоомжтой хандаж, урьдаар тэнцэх эсэхийг нь сайтар ажиглаад, чадах нэгэнд нь уламжилж, чадахгүйг нь явуулдаг байв.

Гэвч одоо ном доройтох цаг үе болохоор Багш нар нэлээд өгөөмөр хандаж, хүссэн бүхэнд ном уламжилж байна. Тэдэнд ном уламжлах нь буруугүй, буянтай болох хэдий ч чин сэтгэл дутмаг зарим нь тэсэж чадалгүй замбараагүй ярина. Бясалгалын аргаа ч олигтой ойлгоогүй байж, Багшийнх нь бясалгалын аргын зөв бурууг, ахуй ойлголтын жинхэнэ эсэхийг бусадтай ярьж хэлэлцэж явдаг.

Жинхэнэ эсэхийг тэд мэдэхгүй, бусад номын багш нар ч хэлж чадахгүй. Учир нь бясалгалын арга бүрийн ахуй ойлголт, дэс нь адилгүй, хувь хүний ахуй ойлголт ч өөр өөр байдаг. Билиг нээгдээгүй номын багшид хэлсэн ч тэр ойлгохгүй. Билиг нь “нээгдсэн гэх” номын багш манайхаас өөр бясалгалын аргаар бясалгал хийсэн болохоор түүний асуудлыг мөн шийдвэрлэж чадахгүй. Иймээс хамаг амьтныг гэтэлгэхэд үнэхээр хүнд. Их Багш нар хүмүүст ном уламжлах дургүй биш, харин тэдэнд ном уламжлаад төдий л нэмэргүй байдаг. Энэ нь сувд эрдэнэсийг хүүхдэд өгвөл түүнийг шоколадаар солиод иддэгтэй адил.

Бага байхад ээж маань үнэт эрдэнэс олныг өгсөн ч би бүгдийг нь зарчихсан. Хүүхэд болохоор хямдхан зараад хүмүүст идэх юм авч өгсөн. Миний хувьд хүмүүст идэх юм авч өгөх нь үнэт

эрдэнэс зүүхээс хол дээр ч ээжид бол тун чухал зүйл. Тухайн үед Ау Лакт дайнтай байсан болохоор биедээ ямар нэг гоёлын зүйлтэй явах хэрэгтэй байв. Санамсаргүй явдал тохиолдож аав ээжээсээ төөрвөл түүнийг зараад амиа хамгаалж болно. Гэвч тухайн үед би үүнийг хайхарсангүй. Хүүхдүүд бүгд л адилхан, сувд эрдэнэсээ шоколадаар сольчихдог.

Хамаг амьтад угаасаа Бурхан. Гэвч ингэж хэлбэл тэд ойлгохгүй. Ихэнх хүмүүс модон Бурхан, ирэх цагийн Майдар бурхан юм уу өнгөрсөн цагийн Бурханд мөргөж залбирах дуртай. Шагжамуни Будда хоёр мянга гаруй жилийн өмнө нирваан болсон байтал хамаг амьтан түүнд мөргөдөг. Хараахан залраагүй Бурханыг ч хүлээх дуртай. Харин одоо заларч буй Бурханыг тоохгүй, өөрийн Бурхан чанартаа ч итгэдэггүй тул тун төвөгтэй.

Хамаг амьтны мугуйдлах нь их. Юу сурсан ч оюун ухаандаа бичиж авчихаад өөрийнхөө үзэл бодлыг хамгийн сайн нь гэж үзэх тул өөр учир ёс ярихад итгэдэггүй. Ихэнх нь Бурханд залбирах нь хамгийн зөв гэдэг тул үүнийг тусгүй гэвэл тэд яаж итгэх юм бэ? Та яагаад олноос онцгой ном сургаал яриад байна гэж тэд сэжиглэх болно.

Гэтэл Багш нь та нарыг Бурхан болгох гэж байж яаж олон түмнийхтэй адил учир ёсыг яриад байж болох вэ? Ихэнх нь та нарыг гадагшаа хандаж, гаднах Бурханд мөргө гэдэг бол харин Багш нь өөрийнхөө Бурханыг ол, Бурханд мөргөлгүйгээр "Бурхан бол" гэдэг. Тэгэхээр тэдний ярьдагтай яаж адил байх вэ? Хэрэв тэдэнтэй адил зүйл ярих юм бол ам нээгээд ч хэрэггүй. Тэгснээс ууланд даяанчилж, дотоод тамираа тэтгэх, эсвэл дэлхийгээр аялбал хүчээ бага гарзадна.

Маани, тарни уншихыг өөгшүүлбэл өөрийн болоод хамаг амьтны хайран цагийг үрнэ. Хүний биеийг олсон нь их нандин, туйлын сайн хэрэг. Би хүмүүсийн цагийг үрэх дургүй. Гаднах Бурхан ирээдүйн болоод өнгөрсний Бурханд мөргөх нь бидэнд ямар ч ач тусгүй. Тэд хэдийнээ Бурхан болчихсон, бид ч бас Бурхан болмоор байхад тэдэнд мөргөөд ямар хэрэгтэй юм бэ? Хэрэв нэг насны өвчтэй бол эмчийн хажуугаас салахгүй. Эмчид мөргөж залбираад эсвэл өдөр бүр түүнд үзүүлээд эмч болохгүй харин анагаахын сургуульд сурах хэрэгтэй.

Бид өвдвөл эмчид очдог. Өвдөхийг хүсэхгүй бол эмч болох хэрэгтэй. Хүмүүсийг эмч болгох нь миний ажил байтал юунд эмчид очихыг заах вэ? Өөртөө болон гэр бүлдээ санаа тавьж өрөөл бусдыг асрах эмч болохыг заана.

Бурхан болохгүйн тулд бурханд залбирч, өөрийгөө Бурхан гэдэгт итгэдэггүйгээс бурханд мөргөж байдаг. Би нүгэл хилэнц ихтэй, би сул дорой эгэл хүн. Би Шагжамуни Будда шиг олон төрөлдөө сайн үйл хийгээгүй, би Майдар бурхан шиг их буян хураагаагүй тул бясалгал дадуулж чадахгүй гэдэг. Бүгд л "би", "би". "Би" гэж хэн юм бэ?

Шагжамуни Будда ч гэсэн жирийн нэгэн байсан. Тэр гуч хүртлээ онцын зүйл бүтээгээгүй, ууж идэж наргин цэнгэж ертөнцийн жаргалыг эдэлж явжээ. Хожим нь хамаг амьтны зовж буйг хараад сэхээрч, бясалгал дадуулж, сансрын хүрднээс гэтлэхээр зорьжээ. Гуч хүртлээ хэнд ч хэрэггүй хүн шиг л байв. Харин бид түүнээс илүү хичээнгүй. Өдөр нь ажил сургуульдаа явж, орой нь аав ээждээ тусалдаг. Шагжамуни Будда юу ч бүтээгээгүй байж Бурхан болж чадсан байхад бид ийм сайн байж яагаад Бурхан болж чадахгүй гэж? Тэр бол өнгөрсөн цагийн Бурхан. Түүнд онц гойд зүйл байхгүй.

Одоо ирээдүйн Бурханыг яръя. Майдар бурханыг самгардиар Maitreiya гэдэг. "Хайрын сэтгэлт" (Loving Buddha) гэсэн утгатай. Майдар бурхантай хамт сүнслэг дадал бясалгал удаан хийсэн тухай Шагжамуни Будда өөрөө ярьсныг ном сударт дурджээ. Гэвч Майдар бурхан амтат зоог, тансаг орчинд дуртай, баячуудтай нөхөрлөн байнга зочилж, хоолны сайныг идэж, хувцасны сайхныг өмсөн хичээнгүйлэн бясалгаагүй тул Шагжамуни түүнээс түрүүлж Будда болсон гэдэг.

Энэ хоёр Бурханд онцлоод байх юмгүй. Шагжамуни Будда гуч хүртлээ төр улс, ард иргэддээ ашигтай зүйл хийлгүй, ертөнцийн жаргалыг эдэлж байв. Учир нь хаан эцэг нь түүнийг жаргаах дуртай байсан. Олон сайхан бүсгүйчүүдийг эхнэр, татвар эм болгон өгч, олон хүнээр асруулж, сайн үйл хийсэнгүй. Өглөг өгсөнгүй, сахил сахисангүй, сууж бясалгасангүй. Сахил, самади, билиг ч бас байгаагүй. Гэвч Тэр Бурхан болж чадсан.

Майдар бурхан ч хийсэн юмгүй шахам. Гэрээс гарч бясалгал дадуулах хүртлээ баян тансаг газраар явж ертөнцийн жаргалыг эдэлж байжээ. Гэтэл бас Бурхан болчихоод байнга биднээр хүндлүүлж байна. Тэд ийм байсан атлаа Бурхан болсон байхад бид яагаад өөрсдийгөө эгэл хүн гэх вэ? Яагаад эгэл гэж? Яагаад Бурхан болж чадахгүй гэж?

Тиймээс л Бурхан болъё гэвэл ямар ч Бурханд бүү мөргө гээд байгаа юм. Тэд тийм сүрхий биш, сүрхий байсан ч бидэнд хамаагүй. Мөнгөтэй бол тэд өөрсдөө л хэрэглэнэ. Бид ч мөнгө олж, өөрсдөө хэрэглэх хэрэгтэй. Тэдэнд мөргөөд ямар тус байх

вэ? Тэд өөрсдийн Бурхантай, бид ч өөрсдийн Бурхантай, тэдэнд мөргөлөө гээд Бурханаа бидэнд өгөхгүй.

Багш нь ингэж ярьж буй нь Бурханыг гүтгэж буй хэрэг биш. Тэд ч тийм тааруухан биш. Тэд энэ ертөнцөд хувилгаан дүрээр ирж, хамаг амьтдыг бясалгал хийхийг урамшуулдаг. Тэд бидэнтэй адил угаасаа л Бурхан. Гэвч тэд ингэж хувилах шаардлагатай байсан. Хэрэв тэд төрөхөөсөө л төгс төгөлдөр, тэр даруй Бурхан болж, ид шид, эрх чөлөөг олсон юм бол бясалгал дадуулаад Бурхан болно гэсэн итгэл мөрөөдөл бидэнд байхгүй болно.

Тэднийг ер бусын, төрөлхийн агуу, олноос онцгой түмнээс төгөлдөр хэмээн сүрдэж, Тэдэнтэй харьцуулахын аргагүй, яагаад ч Бурхан болж чадахгүй. Тэдэн шиг мундаг биш, бидний саад бэрхшээл тун их гэж боддог. Шагжамуни Будда биднээс мундаг байгаагүй, Майдар бурхан ч онцгой байгаагүй гэж Багш нь саяхан тодорхой ярьсныг та нар ойлгох хэрэгтэй. Тэд Бурхан болж чадсан юм чинь бид ч бас чадах нь мэдээж.

Иймд би олны ярьдагтай ижил зүйл ярихгүй. “Буян хишгээ хайрла, диваажинд очсоны дараа бясалгал дадуулахад минь туслан соёрх.” гэх мэтийн өчүүхэн жижиг хүслээр залбиралгүйгээр, энэхүү хамгийн дээд зорилго өөд тэмүүлж, заавал Бурхан болоорой гэдгийг л хэлэх гэсэн юм. Энэ ертөнцөд байхдаа хийгээгүй бясалгалыг диваажинд очоод яаж хийх вэ? Тэнд баяр жаргалтай болохоор бясалгал дадуулах ямар ч шаардлагагүй. Энэ ертөнц зовлон ихтэй, хамаг амьтан ч зовлонтой. Хамаг амьтан уйтгар бухимдал ихтэй, бид ч адил. Өөрсдөө зовсон ч бясалгал хийх сэтгэл үүсгэхгүй, хамаг амьтны зовж буйг хараад нигүүлсэхгүй, бясалгаж тэднийг гэтэлгэхгүй байж төгс баясгалант оронд очоод юуны төлөө бясалгах вэ?

Хамаг амьтныг сул дорой болгодог бясалгалын аргад би дургүй. Хүн бол тэнгэрийн элч, Эсэрваа тэнгэрээс ч дээгүүр хамгийн эрхэм дээд нь байтал яагаад түүнийг сахиус шүтээн, ад чөтгөрт мөргүүлэх ёстой юм бэ? Та өөрөө Бурхан бодьсадва гэдгээ мэдэхгүй бол өөр нэгэн багш гэгээнтэнтэй уулзаад: “Миний Бурхан хаа байгааг хэлж өгнө үү?” гэж асуу. Мэдэхгүй бол өөр багш дээр оч. Тэр бас мэдэхгүй бол гурав, дөрөв,... арав дахь, зуу дахь багшаас асуусаар нэг өдөр “Таны Бурхан чанар хаана байгааг би мэднэ. Олоход чинь тусалъя.” гэх хүн тааралдтал хайгаарай. Харин ямар ч Бурханд бүү мөргө. Тэд бидэнд хамаагүй.

Хэрвээ хүн чармайн ажиллавал их мөнгөтэй болж банканд хадгалаад том байшин бариулж болно. Иймээс бид өөрсдөө мөнгөө олох хэрэгтэй. Бурханд мөргөөд яах юм бэ? Зөвхөн

өөрсдийн итгэл бишрэлийг мохоох төдий. Бид түүнтэй адил нүд чих, ам хамар, гар хөлтэй. Бид ч бас мөнгө олж болно. Байнга түүнд мөргөж шүтээд хэрэггүй, тэгвэл өөрөө мөнгө олохоо мартчихна. Баячуудад мөргөсний хэрэггүй, харин өдөр бүр өөрөө чармайн зүтгэж мөнгөө ол. Бурхан чанараа өөрөө эрж хай. Бурхан болсон өнгөрсөн цагийн хүмүүст бүү мөргө.

Одоо цагийн Бурханд ч мөргөөд хэрэггүй. Тэр бол замч төдий. Бид зөвхөн ном гуйж байгаа болохоос бусдаар Түүнтэй яг адил. Түүнд мөргөх, түүнийг бишрэн шүтэх шаардлагагүй. Түүний Бурхан чанар нь биднийхтэй яг ижилхэн. Цорын ганц ялгаатай тал нь Тэр хайсан зүйлээ олчихсон. Харин бид хайсаар байгаа болохоор Түүнээс лавлаж, Бурхан чанараа хэрхэн яаж олохыг зааж өгөөч гэж гуйсан төдий. Түүнд мөргөөд ямар ч хэрэггүй. Хэнд ч мөргөх хэрэггүй. Одоо цагийн Бурханд ч мөргөх шаардлагагүй байтал өнгөрөөд хоёр мянга гаруй жил болсон Буддад мөргөж, эсвэл Майдар бурханы залрахыг хүлээгээд яах юм бэ? Түүнийг заларч амжаагүй байхад нь мөргөж байдаг ямар дорой, яасан өөртөө итгэлгүй юм бэ?

Иймээс би хамаг амьтныг сул дорой болгодог бясалгалын аргад дургүй гэж хэлсэн бөгөөд хамаг амьтан болон Бурхан гэж хоёр ялгадаг “хоёр эшт” бясалгалын аргад ч бас дургүй. Би бол Бурхан, Бурхан бол би, угаасаа ялгаагүй. Үүнийг хараахан мэдээгүй бол хайж, сурч, бодож, бясалгах хэрэгтэй. Юу ч хийсэн “би бол Бурхан” гэдгээ санаж байх хэрэгтэй. Бусад бясалгалын арга бүгд хаалганы гадна байна. Өдөр бүр гадаа ирээд хаалгаа нээгээч гэж хашхирч зогсвол орж чадахгүй нь мэдээж. Би олныг хуурч худал хэлж болохгүй. Та нар Бурханд залбирч, маани, тарни уншаад хайран цагаа дэмий үрж байна. Та нар өөрсдөө Бурхан. Энэ бол үнэн.

Би та нарыг аль нэгэн Бурханд мөргө гээгүй. Гаднах Бурхан бидэнд хамаагүй. Бурханд мөргөх нь хэрэгтэй юм бол хүмүүс өдөр бүр маш олон Бурханд мөргөдөг ч хамаг амьтан яагаад зовсоор байна вэ? Яагаад бид үхэж төрөхийн хүрдэнд эргэлдсээр байна вэ? Шагжамуни Буддаг амьд сэрүүн үед түүнд олон хүн мөргөж байсан. Гэвч зарим нь яагаад Түүний нүдэн дээр амьдын тамд унасан бэ? Та нар энэ түүхийг сонссон уу? Ном сударт бичээстэй байгаа. Ертөнцөд саатаж буй Буддад мөргөсөн ч тамд унасан нь өөрсдөө бясалгал дадуулаагүйгээс болсон юм.

Бид зөвхөн Бурханы хүчинд найдаж болохгүй. Тамд ч Газрын зүрхэн бодьсадва байдаг бөгөөд тамын амьтдыг өдөр бүр сургадаг. Тэд өдөр бүр газрын зүрхэн бодьсадватай “уулздаг” ч тамын

зовлонгоо амссаар л байдаг. Тэгвэл модон Бурханд мөргөдөг бид яаж туулан ангижрах вэ? Хэрэв Жанрайсэг бурханд мөргөж түүний зүрхэн тарнийг уншаад ямар ч зовлонг арилгадаг юм бол одоо яагаад ийм их зовлонтой, дэлхий ертөнц эмх замбараагүй байна вэ? Учир нь энэ бол төгс бясалгалын арга биш. Зөвхөн хүн болоод тэнгэрийн төрөлтний хоромхон зуурын буян бөгөөд хожим нь бүгд үгүй болно. Бид өөрөө сүнслэг дадал бясалгал хийж, өөрөө Бурхан болох хэрэгтэй. Эс бөгөөс бид сансрын хүрдэнд үүрд эргэлдэж, төгс туулан гэтлэхгүй, төрж үхэхээс мултрахгүй.

Зөвхөн Бурханд залбирах, эсвэл арван зүг гурван цагийн Бурханд мөргөх нь төдий л тус нэмэргүй, төгс туулан ангижруулж чадахгүй. Тэр ч байтугай Буддатай хамт амьдраад ч нэмэргүй. Ананд Шагжамуни Буддатай байнга хамт байж, Түүний ном тайлахыг хамгийн их сонссон ч билиг нь нээгдээгүй байжээ. Шагжамуни Буддаг нас нөгчсөний дараа түүнийг харж хамгаалах хүнгүй болж, Махакашъяад хөөгдсөн бөгөөд тэр үед л бясалгал дадуулахын чухлыг ухаараад нэг оройн бясалгалаар билиг нь нээгджээ.

Тэрээр Шагжамуни Буддад шадарлаж, түүнтэй байнга хамт байсан ч бясалгал дадуулдаггүй байв. Тэр Буддагийн хамгийн дотно, хамгийн цэцэн сэргэлэн, хамгийн их мэдлэгтэй шавь нь байсан ч Шагжамуни Будда түүнийг залгамжлагчаа болгосонгүй. Тэр үед түүний хүч хүрэхгүй, билиг нь бүрэн нээгдээгүй байсан тул Махакашъяа Буддаг залгамжилжээ. Иймээс Бурханд мөргөөд төдий л хэрэггүй болохыг заавал мэдэх хэрэгтэй. Амьд Бурханы дэргэд байгаад ч Бурхан болох аргагүй юм чинь модон бурханд мөргөөд ямар тустай байх вэ? Сүм хийдэд очиж ингэж яривал тэд Багшийг нь буруу номтон гэх тул үүнийг газар сайгүй ярьж болохгүй. Уг нь ярья гэж бодоогүй. Яривал төвөг болно. Гэвч Үнэн ёс, бодит байдлыг ярих л хэрэгтэй. Яриагүй бол яах вэ. Яривал заавал үнэнийг хэлэх хэрэгтэй. Хүн хуурч хамаг амьтны цагийг үрж болохгүй. Тэд энэ сургаалыг хүлээж авч чадах эсэх нь өөр асуудал. Ихэнх хүн хүлээн авч чаддаггүй.

Иймээс Шагжамуни Будда гарч ирээд цөөхөн хүн гэтэлгэсэн. Энэтхэг тийм олон хүнтэй ч хэдхэн түмэн хүнийг гэтэлгэсэн төдий. Есүс Христ гурван жил гаруйхан ном дэлгэрүүлээд хорлогдсон. Лууз ч мөн төдийлөн олон хүн гэтэлгээгүй. Түүний үгийг сонсох хүн олдохгүй байв. Тэр даяанд суухынхаа өмнөхөн “Даодэжин” (”Мөр ёсны судар”)-г бичжээ.

Хамаг амьтад гадаад төрхөөрөө адилгүй ч дотоод хүч нь ижил. Энэхүү хүч бол орчлон ертөнцийн хүч, мөнхөд орших

хүч мөн. Энэ бол бидний Бурхан чанар, Уг дүр, Бүтээгчийн хүч буюу "Дао" мөн. Энэ "Дао" мөнхөд орших бөгөөд түүнтэй нэвтрэлцсэний дараа үйл түйтгэр арилж, бид уг язгууртаа буцна. Авшиг хүртсэний дараа үйл түйтгэргүй болдгийн учир үүнд оршино. Авшиг авсан хүн төрөл төрлийн үйл түйтгэрээ арилгаж чадна. Жишээлбэл, аягатай усанд хор хийвэл ууж болохгүй. Гэвч энэ хортой усыг их голд, тухайлбал, Ганга мөрөнд хийвэл энэ багахан хор үйлчилж чадахгүй тул голын усыг уудгаараа ууж болно. Аягатай ус голын ус болон хувирч хоргүй болдог. Учир нь мөрөн голын ус их болохоор юуг ч цэвэрлэж чадна.

Та нар итгэхгүй байж магадгүй. Ганга мөрөн тун зөн мэдрэмжтэй. Энэтхэгчүүдийн хувьд ариун мөрөн юм. Яагаад гэвэл усанд нь юу ч хийсэн нөлөөлдөггүй. Гангын ус нөгөө л янзаараа, үеийн үед цэвэр ариун байдаг. Дотор нь хог новш, өтгөн шингэн байвч усны чанар мөн л цэвэр тунгалаг байдаг. Яагаад тийм байдгийг эрдэмтэд ч тайлбарлаж чаддаггүй. Ус нь их хүйтэн болохоор бактери үрждэггүй байх гэж тэд хэлдэг. Би Германд долоон жил амьдарсан. Тэндхийн гол мөрөн байнга хөлддөг бөгөөд ус нь Гангын уснаас хүйтэн ч бохирдол ихтэй тул их хэмжээний химийн ариутгах бодис хийж цэвэршүүлдэг.

Америкт байхад ч мөн адил. Тэндхийн ус их хүйтэн ч бас л ариутгах бодис хийж цэвэршүүлдэг. Эс бөгөөс уух аргагүй. Англи, Францад ч бас ийм байдалтай. Австрали, Итали, Испанид очиход тэндхийн гол мөрний заримынх нь ус хүйтэн байсан ч Ганга мөрнийх шиг тийм цэвэр байгаагүй. Гангын ус бол Гангын ус. Дэлхийн бусад гол мөрнийхтэй адилгүй. Яагаад ийм байдгийн учрыг би та нарт ярьж өгье.

Энэтхэг бол ариун газар. Үе үеийн бясалгалтнууд Ганга мөрөнд биеэ угаадаг. Тэдний бие хиртэй боловч хүч нь ариун бөгөөд агуу. Биеэ угаах нь мөрний усыг адисалж байгаатай адил болохоор ямар ч бактери үржих аргагүй. Иймээс ус нь үргэлж цэвэр байдаг. Үүнийг би өөрийн биеэр мэдэрсэн. Хэрэв бясалгалтнууд юм уу жирийн хүмүүс урсгалын дээд талд биеэ угааж байхыг хараад доод талаас нь уувал усыг бохир байна гэж бодно. Гэвч тэр уснаас бага зэргийг шинжилбэл өчүүхэн ч бохирдолгүй болохыг нь мэдэж болно.

Би Энэтхэгт очоод үе үеийн хүмүүс бясалгал хийж ирсэн алдартай газарт буусан. Ганга мөрний хоёр эргийн элсэн дээр өдөр бүр бясалгаж буй хүн сууж харагддаг. Шагжамуни Будда ч очиж байсан нэртэй газар болохоор бясалгал дадуулдаг хүн бүр заавал очдог. Би доод урсгалынх нь ойролцоо амьдарч хоёр сар

бясалгал дадуулсан. Урсгалын арай дээд талд нэг тосгон бий. Тэр тосгонд нойтон хамуутай олон хүн суудаг байсан болохоор тэдний ялгадас мөрний усанд орох нь лавтай. Гэвч мөрний ус мөн л цэвэрхэн хэвээрээ байсан. Хамгийн доод урсгалын усны чанар баталгаагүй гэлцдэг.

Энэтхэг хүн ариун цэвэрч биш. Америкийнх шиг орчин үеийн ариун цэврийн өрөө тэнд байдаггүй. Гаднаа бие засдаг. Гэвч Ганга мөрний ус өчүүхэн ч бактеригүй цэвэрхнээрээ байдаг. Хэрэв лонхонд ус хийж ганц хоёр сар байлгавал муудаж, өмхийрөөд өт хорхой ч үүсэж магадгүй. Ганга мөрний усыг лонхонд хийж арван жил болгосон ч ямар ч өөрчлөлт гарахгүй, эхний өдрийнх шиг шинэхэн, цэвэрхнээрээ байна. Энэ бол орчин үеийн шинжлэх ухаанаар ч тайлбарлаж болдоггүй учир битүүлэг зүйл. Багш нь өдөр бүр тэр уснаас ууж, биеэ угаадаг байсан ч одоо болтол элдэв өвчингүй, амьд мэнд байсаар байна.

Саяхан нэг шавь маань намайг авч явж шинжилгээ хийлгэсэн ч угаасаа эрүүл болохоор ямар ч өвчин илрээгүй. Бясалгал хийдэг хүн өвдөх нь ховор бөгөөд Багшийнх нь бясалгалын арга маш олон өвчнийг эмчилдэг ч, үүнд итгэдэг хүн цөөн. Учир нь бясалгал дадуулдаггүй болохоор ийм ахуй ойлголтгүй байдаг.

Ганга мөрний устай адил нэг хүч байдаг бөгөөд түүнийг бид Буддагийн хүч, Бурханы хүч, Бүтээгч, Дао гэхчлэн яаж ч нэрлэсэн болно. Бид тэр хүчтэй нэвтрэлцвэл өөрөө тэрхүү хүч болон хувирч, агуу их болох бөгөөд гаднын хүчинд автагдахгүй болно. Төрөл төрлийн үйл түйтгэрээ бүгдийг нь шатаан арилгана. Тэр хүчийг олоогүй ч оршин буйг нь үгүйсгэж болохгүй.

Газар болгонд Ганга мөрний ус байхгүй тул бид эндхийн бохир усаа уух хэрэгтэй болно. Эндхийн гол мөрний ус маш бохир болохоор ариутгаж цэвэрлэх олон дамжлагаар цэвэрлэж байж уудаг. Тиймээс Ганга мөрний ус тийм цэвэр тунгалаг, ямар ч зүйл орсон цэвэршдэгт итгэхэд үнэхээр бэрх.

Ганга мөрөн үнэхээр оршин байдаг. Сэтгэшгүй ариусгах хүч ч үнэхээр байдаг. Би очсон болохоор мэдэж байна. Ийм зүйл байхгүй гэж зуун хүн хэлсэн ч би итгэхгүй. Учир нь би үүнийг өөрийн биеэрээ мэдэрсэн юм. Би Ганга мөрнийг үзсэн, усыг нь уусан, хүчинд нь итгэдэг болсон. Учир нь би тэр хүчтэй нэвтрэлцсэн юм.

Бид өмнөх олон төрлийнхөө үйл түйтгэрийг арилгах хүчийг олохоос өмнө түүнд итгэх аргагүй байдаг. Бидний өмнөх төрлүүдийн нүгэл хилэнцийг шатаахад туслах нэгэн Төгс

Гэгээрсэн Их Багшийг олохгүй бол ертөнц дээр тийм багш байдаг гэдэгт итгэх аргагүй. Хэрэв бид агшин зуур гэгээрэх бясалгалын аргыг олоогүй бол дэлхий дээр тийм бясалгалын арга байна гэдэгт итгэх аргагүй.

Гэвч олоогүй нь тийм бясалгалын арга, тийм багш байхгүй гэсэн үг биш. Учир нь зарим бясалгалын арга "зөв" болохоор минийх "буруу" мэт харагддаг байх. Тэдний чанх эсрэг явбал энэхүү "Дао"-г олж болно. Харин тэднийг дагавал хаа хүрэхийг би мэдэхгүй. Би тэдний "Зөв дао"-д дургүй. (*Хүмүүс инээв.*) Багшийг нь буруу номтон гэх нь буруугүй. Би буруу номоор явж байгаагаа тодорхой мэдэж байна.

Асуулт: Маани, тарни уншвал сэтгэл Бурхан дээр төвлөрөөд өөр дээрээ төвлөрөхгүй гэж сая Багш ярьсан. Гэвч миний ойлгож байгаагаар ингэх нь замбараагүй "сэтгэл"-ээ нэгтгэн хурааж, цаашлаад бодолгүй түвшинд хүргэх гэж буй хэрэг. Өөр нэг зүйл гэвэл хамаг амьтан өөрийн чанарыг агшнаа ухаарна, хоромхон зуурт өөрийн чанарыг харж чадна гэж Та хэлсэн. Гэвч энгийн төрөлтний оюун ухаан элдвийг бодомтгой тул самади, билиг ухааныг зэрэг агуулж чадахгүй. Багшийн бясалгалын арга сайн хэдий ч зарим зүйлийг тэр дор нь ойлгох аргагүй. Багшаа үүнийг тайлбарлаж өгнө үү?

Их Багш: Эхнийх буруу биш зөв асуулт байна. Хамгийн гол нь сэтгэлээ эрхшээсний дараа яах вэ? Сэтгэл тогтсоны дараа Бурхан чанараа эрнэ. Сэтгэлээ эрхшээж ямар ч бодолгүй болох нь Бурхан болчихлоо гэсэн хэрэг биш. Ямар ч бодолгүй яг л чулуу шиг болно. Энэ нь дөнгөж эхлэл төдий. Сэтгэлээ тогтоосны дараа үргэлжлүүлэн бясалгал дадуулна. Иймээс Шагжамуни Будда "Авид бурханы судар"-т: "Төгс баясгалант оронд очоод л Бурхан болчихгүй, харин аажим бясалгасаар Бурхан болно." гэжээ.

Хоёр дахь асуултын тухайд, тэдэнд туслах арга надад бий. Тэд бие дааж явахгүй харин Багш нь дагуулна. Багш нь машинаа жолоодно. Зам хол тул тэд өөрсдийн хүчээр үнэхээр явах аргагүй. Иймээс заавал Багштай байх хэрэгтэй. Багшийн хүчээр тэдэнд ном уламжилж сэтгэлээ тогтооход нь тусална. Өдөр бүр улам улмаар тогтоохын зэрэгцээ бясалгал дадуулна. Тэгэхгүй бол Багш байгаад ч хэрэггүй.

Багш яагаад хэрэгтэй вэ? Миний бясалгалын арга бол чанараа үзмэгц Бурхан болохыг номлосон төдий биш. Чанараа тийм амархан үзэх үү? Ямар нэг хүч тэдэнд туслан эмх замбараагүй оюун санааг нь тогтуун болгож, дараа нь өмнөх төрлүүдийн үйл түйтгэрийг нь арилган цэвэрлэнэ. Тэгж байж чанараа үзэж,

Бурхан болно. Үүнийг удаан хүлээх хэрэггүй, агшин зуур бүгдийг хамтад нь хийнэ. Аажим гэгээрэх арга нь дэндүү удаан. Жижиг алчуураар удаан арчина. Би шууд голд хийгээд угаачихдаг болохоор тун түргэн.

Иймээс эхлээд Багшийн хүч байж байж л тусална. Дараа нь тэд өсөж чийрэгжээд өдөр бүр Багшийн хүчинд түшиглэх шаардлагагүй болж өөрсдөө явна. Хөлд орж байгаа хүүхэд шиг бол яаж явах вэ? Урдаас нь түшиж ганц хоёр алхуулсаар байтал том болоод өөрөө явчихна. Багшийнх нь бясалгалын арга олон талыг хамардаг. Үйл түйтгэрийг арилгаж, сэтгэлийг тогтооно. Билиг ухааныг нээж, дэвшихэд тусална. Тэднийг махан биеэрээ бус хувилгаан биеэрээ өдөр бүр харж ханддаг.

Авшиг хүртсэний дараа хүн болгоныг Багшийнх нь нэг нэг хувилгаан дүр хариуцаж, хэр зэрэг бойжиж буй болон ямар асуудал, ямар саад бэрхшээлтэй байгааг харж байнга замчлах болно. Хамаг амьтан ганцаараа явж чадахгүй болохоор жинхэнэ Багштай байх хэрэгтэй. Билиг ихээр нээгдээгүй багш жинхэнэ ёсоор тусалж чадахгүй. Үсээ авахуулсан болгон багш биш. Жинхэнэ багш заавал хувилгаан биетэй байх бөгөөд түүнийгээ газар бүхэнд илгээж шавь нараа харж ханддаг. Хэрэв хувилгаан биегүй бол ганцаараа олон хүнд анхаарал тавих аргагүй.

Асуулт: Номын бие гэдгийн талаар Буддагийн ном сударт тэмдэглэхдээ: “Хамаг амьтан номын бие, төгс жаргалангийн бие, хувилгаан биетэй. Жинхэнэ их бясалгагч өөрийн уг чанарын номын биеэ үзнэ. Хамаг амьтан номын биетэй ч үйл үрийн эрхээр эрх чөлөөтэй байх аргагүй.” гэжээ. Тийм үү?

Их Багш: Номын бие үй түмэн хувилгаан биетэй байж болно. Номын биеэ хэрэглэж чаддаг бол Бурхан. Иймээс үй түмэн хувилгаан биетэй Шагжамуни Будда гэдэг. Номын бие хүн бүхэнд байж болох ч тэд түүнийгээ хэрэглэн олон хувилж чадахгүй болохоор хэрэггүй. Хүн болгон Бурхан ч үүнийгээ ашиглаж чаддаггүй гэж бидний ярьдагтай адил. Хэрвээ бид номын биеэ ашиглавал олон зүйлийг өөрчилж, олон дүрд үй түмээр хувилж болно. Гэвч жирийн хүмүүс номын биетэй ч яаж хэрэглэхээ мэдэхгүй тул юунд ч хувилж чадахгүй.

Асуулт: Бурханд мөргөх, маани, тарни унших нь мөн л хамаг амьтныг гэтэлгэх хялбар дөхөм бясалгалын арга юм бол ямар тустай вэ? Сэтгэл тогтоохоос биш Бурхан болгохгүй юу?

Их Багш: Бурханд мөргөж, маани, тарни унших нь тустай.

АБВ гэж уншсан ч тустай. Сэтгэл санаагаа төвлөрүүлэхэд

тустай. Гэвч “сэтгэл”-ийг чинь тогтоох л төдий. Нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэлгүй нэгэн түвшин бий. Та тэнд хараахан хүрээгүй байна. Маани, тарни уншаад сэтгэл санаа сарнихгүй болсон бол “сэтгэл”-ээ тогтоосон хэрэг. Сэтгэл бол бодол. Сэтгэл гэдэг чинь л санаа бодол шүү дээ.

Сэтгэл үймэрч, элдэв бодол ихсэхийг сэтгэл сарних гэнэ. Маани, тарни уншсанаар сэтгэлээ л тогтоож чадах төдий. Нүд, чих, хамар, хэл, бие болоод “сэтгэл” ч байхгүй өөр нэгэн түвшин бий. Маани, тарни уншаад сэтгэлээ тогтоосноор тэнд хүрч чадахгүй. Заавал дээд бясалгалын арга байх хэрэгтэй. Буддад залбираад тэнд очъё гэвэл хүч чинь хүрэхгүй. Багшийгаа дагаж байж л хүрнэ. Учир нь нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэл байхгүй болохоор “Сэтгэл”-ээр бясалгал хийж болохгүй бөгөөд тэрхүү газар бясалгал дадуулчихаар “Сэтгэл” ч байхгүй.

Асуулт: Хүний амьдралын зорилго юу вэ?

Их Багш: Эрх тааваараа, амар жаргалтай байхыг хүсэх нь туулан гэтэлж, дахин ирж сансрын хүрдэнд эргэлдэхгүй байхыг хүсэж байгаа хэрэг. Сүнсээ ариусган, бүхий л зүйлд эрх чөлөөтэй, баяр баясгалантай байя гэвэл бясалгал хийх хэрэгтэй. Гагцхүү Төгс Гэгээрсэн Их Багштай бясалгал дадуулж байж л туулан гэтэлнэ. Өөрөө бясалгал дадуулвал чадал хүрэхгүй тул цаг их гарздах төдийгүй ямар ч амжилтад хүрэхгүй. Хүрсэн ч шалихгүй. Харин Төгс Гэгээрсэн Их Багшаар замчлуулбал бид түргэн урагшилна.

Асуулт: Бид энд эгэл хорвоогийн амьдралаар амьдрах уу, эсвэл түүнийг огоорох уу? Хэрэв хорвоогийн амьдралаар амьдарна гэвэл энэ нүгэлт ертөнцөд цэвэр ариун байдлаа яаж хадгалах вэ? Миний санаа бол яавал бохир ертөнцөд хутгалдсан ч цэврээрээ байж чадах вэ?

Их Багш: Жишээ нь, бороо орвол цув өмсдөг. Гэвч хулгана мэрээд энэ тэнд нь цоолчихвол ус орж, хамаг бие норох тул цувтай байсны хэрэг гарахгүй. Бид энэ ертөнцөд хамгаалах хувцастай ирдэг. Энэ хувцас чинь муудвал Багш нь нөхөөд өгвөл даруй өмсөж болох төдийгүй хаана ч очсон бохирдохгүй.

Заавал ууланд гарах юм уу эсвэл ганцаараа битүүмжлэн сүнслэг дадал бясалгал хийх хэрэгтэй гээд байгаа юм биш. Ингэх нь бага зэрэг тустай. Элдэв бодол багасна. Учир нь бясалгаж эхэлмэгц л телевизор хангинаж, хүүхэд шуугилдаж, самадид оронгуут хүн ирж төвөг удна. Иймэрхүү саад нэлээд их. Гэвч гагцхүү ууланд л бясалгаж болдог юм биш. Гэртээ эсвэл сэлүүхэн

газар бясалгаж ариусаж болно. Авшиг хүртэх үед Багш нь цувыг чинь нөхөж өгнө. Иймээс авшиг хүртсэн хүн Багшийн заслын болон авралын хүчийг нэгэн зэрэг олж авдаг.

Асуулт: Хэрэв ертөнцийг огоорч Бурхан болбол хамаг амьтныг гэм нүглээс яаж аврах вэ?

Их Багш: Бясалгал дадуулж Бурхан болсны дараа хэрхэхийг аяндаа мэднэ. Гэрлээгүй, хүүхэдгүй хүн: "Хүүхэд яаж төрүүлэх вэ? яаж асрах вэ?" гэж санаа зовнин ээжээсээ байнга асуухтай адил. Гэрлээд аяндаа хүүхэд төрүүлж, аяндаа асарч сурна. Хэнээр ч заалгуулалгүй аяндаа мэдчихнэ.

Асуулт: Ном дэлгэрүүлж, хамаг амьтанд туслах болон бясалгал хийх, үгүй хоёрын дунд оршивч яавал тэдгээрт хүлэгдэхгүй байх вэ? Жирийн үед ажиллах, бясалгах, эсвэл хамаг амьтанд тустай үйл хийхэд бясалгал болон ажилдаа яавал хүлэгдэхгүй байх вэ?

Их Багш: Хамаг амьтанд тусалж байна гэж бүү бод. Чи хэн юм бэ? Юугаараа хамаг амьтанд туслах юм бэ? Та өдөр болгон өглөө, өдөр, оройн хоол идэхдээ "би" тийм сайн хүн, тийм агуу хүн. Өнөөдөр өөртөө хоол идэж тусаллаа гэж боддог уу? Биеэ угаачихаад би их мундаг, өөртөө тусалчихлаа гэж бодох уу? Үгүй. Аяндаа л хийдэг.

Үүнтэй адил бусдад туслахдаа "би" тусалж байна гэж бүү бод. Хэрэгтэй бол тусал, хэрэггүй бол шаардлагагүй. Тусалсан туслаагүй адил. Хамаг амьтанд туслах нь гараа угаахтай адил. Та гараа угаахдаа өөрийгөө мундаг гэж боддоггүй, угаах ёстой. Гар угаах нь тун сайн, агуу хэрэг гэж бодолгүйгээр аяндаа л угаадаг шүү дээ.

Хамаг амьтанд туслах нь яг үүнтэй адил. Сайрхах юм байхгүй, юу ч бодох хэрэггүй. Өлссөн хүн ирвэл "одоохон хоол өгье.", өмсөх хувцасгүй хүн ирвэл "би хувцсаа өгье." гэнэ. Тэгээд л мартчих. Өчигдөр түүнд хоол өгсөн, уржигдар хувцас өгсөн гэж бодох хэрэггүй. Бодоод байх ч юмгүй. Үсээ самнахдаа яагаад өөртөө тусалж байгаа юм бэ гэж боддоггүй. Угаасаа энгийн явдал. Хамаг амьтанд туслах нь шүдээ угаахтай адил хийх ёстой ажил. Үүнд сайрхах, сэтгэл ханах хэрэггүй.

Асуулт: Авид бурхан дөчин найман тангаргаар хамаг амьтныг гэтэлгэнэ, Газрын зүрхэн бодьсадва там хоосрохоос нааш Бурхан болохгүй гэсэн. Энэ амлалтыг тайлбарлаж өгнө үү?

Их Багш: Энэ бол Тэдний билиг бүрэн нээгдэхээс өмнөх амлалт юм. Тэд билиг нээгдэж, Бурхан болсныхоо дараа тангараг

тавьснаа бодолгүйгээр аяндаа хамаг амьтныг гэтэлгэсэн. Ээж нь хүүгээ хоол ид гэвэл тэр: “За тэгье, тэгье. Хоол идэхгүй бол том болохгүй гэж ээж хэлсэн.” гэнэ. Том болоод өөрөө идчихнэ. Өлсвөл юу ч бодолгүйгээр иднэ.

Газрын зүрхэн бодьсадва, Бодьсадва болохоосоо өмнө тодорхой мэдэхгүй тул ам тангараг тавьсан. Түүний энэхүү “би” нь хамаг амьтныг гэтэлгэнэ гэж амласан. Гэвч тэд Бурхан, Бодьсадва болоод аяндаа гэтэлгэсэн бөгөөд өөрийгөө бодьсадва гэж, тангараг тавьсан гэж бодоогүй. “Очироор огтлогч судар”-т: “Бурхан юм уу Бодьсадва өөрийгөө Бурхан, Бодьсадва гэж бодвол Тэр жинхэнэ Бурхан биш, жинхэнэ бодьсадва биш.” гэсэн байдаг. Юу ч бодолгүй ядарвал унтаж, өлсвөл идэж, шаардлагатай зүйлээ хий. Энэ бол аяндаа болох хэрэг.

Асуулт: Билиг ухаан бодит болон хоосон чанартай. Өвөг Бурхан болон Их Бодьсадва нарын билиг ухаан хоосон чанартай салшгүй холбоотой ч хамаг амьтныг барилдлагаар гэтэлгэж чадна. Өөрөөр хэлбэл, уг чанарын билиг ухаан нь уг чанарын хоосныг нэвт ухаараад олон зүйлийн хуурмаг төсөөлөл, түмэн үзэгдлийн хувирлыг ойлгож чадна. Миний санаа бол Буддагийн билиг ухаан нь хоосноос хэлбийхгүй, бодитойгоос ч хэлбийхгүй.

Их Багш: Санааг чинь ойлгож байна. Бурхан тийм олон ээдрээтэй явдлыг боддоггүй. Тэр ядарвал унтана, өлсвөл иднэ. Бурхан тольтой адил, хамаг амьтан ямар байна, түүнийг л тусгана. Тэр үнэндээ юу ч боддоггүй. Бурханд хамаг амьтнаас ялгагдах юмгүй. Тэрээр эгэлгүй хүчтэй ч өөрийгөө их хүч гэж боддоггүй. Хамаг амьтанд хэрэгтэй үед их хүчээ хэрэглэнэ. Та нарт илэн далангүй хэлэхэд Бурхан яг л нартай адил юу ч боддоггүй. Нар өөрийгөө агуу гэж бодолгүйгээр хамаг амьтныг гийгүүлж, түмэн бодисыг тэтгэдэг. Нарны ачаар цэцэгс дэлгэрч, бид өсөн торниж, хүүхэд эрүүл чийрэг бойждог. Учир нь Д витамин нарны гэрлээс үүсдэг. Түүнгүй бол бид өсөн бойжиж чадахгүй, арьс маань өвчлөх болно. Нар түмэн бодисыг амилуулдаг ч юу ч ярьдаггүй.

Агуу их хүн өөрийгөө агуу гэж боддоггүй. Бурханы билиг ухаан агуу ч Тэр өөрөө тэгж боддоггүй. Өөрийгөө агуу билиг ухаантай гэж нэг л агшинд бодвол Бурхан даруй эгэл хүн болж хувирна. Тэр үед, яг тэр агшинд Бурхан эгэл хүн болсон байх болно. Гэвч Бурхан ерөөсөө тэгж боддоггүй. Жишээ нь, хэл яриагаар илэрхийлэх шаардлагаас болж би шавь нараа шавь гэж хэлж байгаа юм. Гэвч энэ нэрэнд баригдаж, чи яагаад шавьтай гэж байгаа юм бэ? гэж бүү асуугаарай. Багш нь угаасаа шавьгүй. Үнэн шүү. Гэвч заримдаа үг хэлээр ярих хэрэгтэй.

Жишээ нь, шавь нар маань өөрт нь зааварлаж тусалсан Багшийнхаа хувилгаан биеийг олж үзээд над дээр ирж: “Багш аа, таныг Бурхан гэдгийг одоо л мэдлээ.” гэдэг. Эсвэл зарим хүн Багшийг нь Арьяабал бурханы хувилгаан болохыг хараад: “Багш аа, Таныг Арьяабал бурханы хувилгаан гэдгийг би мэднэ.” гэдэг. Нэг хүүхэд өчигдөр надаас: “Багш аа, Та Очироорваань бурханы хувилгаан, тийм ээ?” гэж асуусан.

Дэс нь адилгүй болохоор тэд өөр өөрөөр хардаг. Тэдний харсан Багшийн хүч нь ч адилгүй, тэрхүү хүчийг хэрэглэх нь ч адилгүй байж болно. Тэдний хувьд энэ бүхэн ялгаатай. Гэтэл Багш нь Очироорваань бурхан, Арьяабал бурхан, Шагжамуни Будда ч биш. Би өөрийгөө Очироорваань бурханы хувилгаан, Арьяабал бурханы хувилгаан ч гэж боддоггүй. Би ер тэгж бодож байгаагүй. Хамаг амьтанд ямар хэрэгцээ байна, түүнийх нь дагуу л үйлддэг.

Нар ганцхан мөртлөө их хүчтэй. Бид хэрэглээд ч барахгүй. Ургаа мод нарны хүчээр өсөж төлжинө. Зарим хүн нарнаас эрчим хүч авна, зарим нь нарны энергиэр хоол хийнэ. Би Энэтхэгт байхдаа нарны энергиэр хоол, ногоо, амтат төмс болгодог байсан. Харин нар амтат төмс, хоолыг маань болгоход надад тусалсан гэж боддоггүй. Би нарыг яаж ч ашиглаж болно. Учир нь наранд цаглашгүй, хязгаарлашгүй хүч байдаг бөгөөд бид юунд ч хэрэглэж болно. Хоол хийхэд, амтат төмс чанахад, арьсны өвчин эдгээхэд, ногоо тарихад ашиглаж болно. Наргүйгээр ногоо ургахгүй.

Бурханы хүч, эсвэл Багшийн хүч адилхан. Тэд тийм хүчтэй гэж угаасаа бодож байгаагүй. Гэвч та нар түүнийг яаж ч хэрэглэж болно. Энэ бол Бурханы хүч. Бурхан дүрсгүй, дүргүй, хэмжээлшгүй, цаглашгүй.

Жишээ нь, цахилгаан станц нь цахилгаан биш ч цахилгаан гаргадаг. Тэнд цахилгааны их хүч бий. Бид тэрхүү цахилгааны хүчтэй холбогдвол юу ч хийж болно. Чийдэн асаана, сүм дуганд хэрэглэнэ, хоол чанана. Гэвч хоол чанахад, сэнс ажиллуулахад, утсаар ярихад тусалж байна гэж цахилгаан боддоггүй.

Бурхан ч бас адил. Бурхан бол Шагжамуни биш, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай биш, Авид бурхан ч бас биш. Бурхан бол дүрсгүй, дүргүй, хэмжээлшгүй, цаглашгүй бөгөөд бидэнд юу хэрэгтэй байна түүнийг өгдөг. Гэхдээ цахилгаан гүйдэлтэй адил ямар нэг зүйлээр дамжин цахилгааны эх үүсвэртэй холбогдоно. Тэрхүү цахилгаан гүйдлийг бид харж, барьж болохгүй ч хэрэглэж болно.

Бурханы хүчийг шууд хэрэглэх аргагүй, заавал нэгэн бие

махбодыг ашиглана. Бие махбодоор дамжуулан энэхүү хүчийг та нарт өгдөг. Ийм учраас л Шагжамуни Будда, Майдар бурхан заларч, Арьяабал бурханы хувилгаан, Хүй Нөн, Бодьдарма, Бай Жан зэрэг Их Багш нар энэ ертөнцөд ирж, хамаг амьтанд тусалж, заан сургах хэрэгтэй болдог.

БАГШ АСУУЛТАД ХАРИУЛЖ БАЙНА

Асуулт: Амьтны мах идэх нь мэдээж амь хороож буй хэрэг. Ургамал ногоо идэх нь амь хөнөөж байгаа явдал биш үү?

Их Багш: Ургамал идэх нь мэдээж амь хороож буй бөгөөд үйлийн үртэй. Гэвч харьцангуй бага. Өдөр бүр Арьяабалын бясалгалыг хоёр цаг хагас хийвэл энэ үйл түйтгэрийг арилгаж чадна. Бид хооллох шаардлагатай тул ухамсрын түвшин доогуур, хамгийн бага зовуурьтай хүнсийг сонгохоос өөр аргагүй болдог. Ургамлын 90% нь уснаас бүтэх бөгөөд зовлон шаналлыг бараг мэдрэхээргүй ухамсрын түвшинтэй. Тэгээд ч бид ургамал ногооны үндсийг тасалдаггүй. Харин навч мөчрийг тасалснаар бэлгийн бус үржилд нь тусалдаг болохоор ургамалд ашигтай. Цэцэрлэгчид ургамлыг өтгөн, сайхан ургуулъя гэвэл хайчилж засаж байх хэрэгтэй гэдэг. Жимсний хувьд гэвэл боловсорсон жимс анхилам үнэр, сайхан өнгө, гайхалтай амтаараа хүмүүсийн идэх дур хүслийг төрүүлж өөртөө татдаг. Үүнийхээ ачаар жимсний мод өргөн уудам газарт үрээ тарааж чаддаг. Хэрэв бид жимсийг нь авч идэхгүй бол тэр нь хэт боловсроод газар унаад ялзарна. Үр нь модны титмийн сүүдэрт халхлагдаад ургаж чадахгүй болно. Тийм болохоор ургамал жимсийг идэх нь зүй ёсны хэрэг бөгөөд энэ нь тэдэнд огтхон ч зовлон шаналал авчрахгүй.

Асуулт: Цагаан хоол иддэг хүн намхан, туранхай, харин мах иддэг хүн өндөр, тэнхлүүн гэж ихэнх хүн боддог. Энэ үнэн үү?

Их Багш: Цагаан хоолтон хүн намхан туранхай байх албагүй. Шим тэжээлээ тохируулж чадвал тэд ч бас нэгэн адил өндөр чийрэг болж чадна. Та заан, бух, анааш, усны үхэр, адуу гэх мэт том амьтад зөвхөн жимс ногоогоор хооллодгийг бодоод үз. Тэд махчин амьтдаас хүчтэй, номхон дөлгөөн, хүнд тустай. Харин махчин амьтад хэрцгий догшин, ямар ч тусгүй. Хэрэв хүмүүс амьтны мах их идвэл тэдний адгууслаг чанарт автана. Мах иддэг хүмүүс заавал өндөр, хүчтэй байдаггүй бөгөөд дундаж наслалт нь тун богино байдаг. Эскимосчууд бараг дан мах хэрэглэдэг.

Тэд өндөр, хүчтэй, урт насалж байна уу? Үүнийг та бүхэн маш тодорхой ойлгох хэрэгтэй.

Асуулт: Цагаан хоолтон өндөг идэж болох уу?

Их Багш: Болохгүй! Өндөг идэх нь бас л амьтан хороож байгаа хэрэг. Дэлгүүрт худалдаж байгаа өндөг үр тогтоогүй тул түүнийг идэх нь амьтныг хороосонд тооцогдохгүй гэж зарим хүн хэлдэг. Энэ яриа зөв юм шиг сонсогдовч тийм биш. Ерөөл барилдлага бүрдээгүйгээс үр тогтож дэгдээхэй болоогүй ч өндөг амьтай хэвээр байдаг. Тийм биш бол яагаад зөвхөн өндгөн эс гэдэг эсийн энэ хэлбэрт л зөвхөн үр тогтоож болдог юм бэ? Өндгөнд хүний биед зайлшгүй хэрэгтэй ууран, фосфор, тэжээллэг бодис байдаг гэж баталдаг ч бид буурцгаас уургаа, төмс болон бусад ногооноос фосфорыг авч болдог.

Эрт, эдүгээгийн дээд хуврагууд мах, өндөг иддэггүй ч урт насалдаг байсан. Жишээлбэл, Их Багш Иньгуан зоог барихдаа аяга ногоо, жаахан будаа иддэг байсан ч ная гаруй насалжээ. Өндөг нь зүрх судасны өвчин үүсгэдэг холестериныг ихээр агуулдаг. Америк, Формосад зүрх судасны өвчин нь нэг номерын үхлийн шалтгаан болоод байна. Өвчтэй хүмүүсийн ихэнх нь өндөг иддэг хүмүүс байдагт гайхах зүйлгүй.

Асуулт: Бид яагаад тэжээж өсгөсөн үхэр, гахай, тахиа, нугасаа идэж болохгүй гэж?

Их Багш: Эцэг, эхчүүд ч бас хүүхдүүдээ өсгөдөг. Эцэг, эхэд үр хүүхдээ идэх эрх бий юу? Амьд амьтад бүгд амьдрах эрхтэй. Хэн ч тэдний эрхийг булааж болохгүй. Хонконгийн хуулиар амиа хорловол гэмт хэрэгт тооцогддог тул бусдыг хөнөөх талаар дурдсаны ч хэрэггүй.

Асуулт: Амьтан угаасаа хүмүүст идүүлэх гэж төрдөг. Хэрэв хүмүүс амьтныг идэхгүй юм бол бүх дэлхий мал адгуусаар дүүрчихнэ. Тийм биш гэж үү?

Их Багш: Энэ чинь ямар ч утга учиргүй санаа байна. Амьтныг алахаас өмнө идүүлэхийг хүсэж байна уу гэж тэднээс асуудаг билүү? Амьтан бүхэн амьдрахыг хүсэж, үхэхээс айдаг. Бид бард идүүлэхийг хүсдэггүй байтал амьтад яагаад бидэнд идүүлэх ёстой гэж? Хүн төрөлтөн дэлхийн бөмбөрцөг дээр хэдэн аравхан мянган жил л амьдарч байна. Гэтэл тэднийг үүсэхээс өмнө маш олон төрлийн амьтан аль хэзээний оршиж байжээ. Тэд дэлхийн бөмбөрцгийг дүүртэл хэт олширсон гэж үү? Амьд амьтад байгаль экологийн тэнцвэрт оршиж байдаг. Хүнс тэжээл, амьдрах орон зай хүрэлцэхээ болиход тоо толгой нь эрс буурч тохирох түвшинд

нь очдог.

Асуулт: Би яагаад веган хоолтон байх ёстой вэ?

Их Багш: Миний дотоодын Эзэн Бурхан үүнийг хүссэн учраас би веган хоолтон болсон. Ойлгож байна уу? Мах идэх нь хөнөөгдөхийг үл хүсэх орчлонгийн хууль ёсыг зөрчинө. Бид өөрсдөө үхлийг хүсдэггүй, мөн өөрсдийнхөө юмыг алдахыг хүсдэггүй. Хэрэв бид бусдад ингэж хандвал энэ нь өөрийнхөө эсрэг үйлдэж байгаа хэрэг болох бөгөөд энэ нь биднийг зовоож шаналгана. Таны бусдад хийсэн хор хөнөөлтэй үйлдэл бүхэн өөрийг тань зовоодог. Та лав өөрийгөө хазаж хутгалж чадахгүй, болох ч үгүй. Үүнтэй адилаар та амь хороож болохгүй, хороовол амьдралын хуулийг зөрчсөн явдал болно. Ойлгож байна уу? Өөрсдийгөө зовоон шаналгах үйлдлийг хийх хэрэггүй. Ингэх нь өөрсдийгөө ямар нэг байдлаар хязгаарлаж байгаа хэрэг биш. Амь нас маань амьдралын бусад бүх хэлбэр лүү өргөжин тэлж байгаа хэрэг. Бидний амь нас зөвхөн энэ биеэр хязгаарлагдахгүй, харин ч амьтан хийгээд бүхий л төрөлтний амь амьдралд хүрч тэлэх болно. Энэ нь биднийг улам эрхэмсэг, улам агуу, улам баяр хөөртэй, хязгаарлашгүй болгодог. Тийм үү?

Асуулт: Та веган хоолны тухай ярьж болох уу? Веган хоол яагаад дэлхийд энх тайвныг авчирна гэж?

Их Багш: Болно. Дэлхий ертөнцөд болж буй дайн дажны ихэнх нь эдийн засгийн шалтгаанаас үүсдэгийг харж байгаа биз дээ. Бид энэ бодит байдлыг илэн далангүй ярих хэрэгтэй. Ямар нэгэн улсад өлсгөлөн гарах, хүнс хоол дутагдах, эсвэл улс орнуудын хооронд хүнсийг тэгш бус хуваарилах зэрэг нь тухайн улсын эдийн засгийн хүндрэлийг улам хурцатгадаг. Хэрэв та цаг гарган сэтгүүл уншиж, веган хоолны талаар үнэн зөв мэдээлэл хайвал үүнийг тун сайн мэдэх болно. Махны төлөө мал амьтдыг тэжээх нь эдийн засгийн олон салбарыг дампуурлын ирмэгт аваачиж, дэлхийн олон улсууд ялангуяа гуравдагч ертөнцийн орнуудыг өлсгөлөнд ихээр нэрвэгдүүлж байна. Энэ нь миний ч бодол биш, харин нэгэн америк хүн энэ талаар судалгаа хийж ном хэвлүүлсэн. Та нар аль ч номын дэлгүүрээс веган хоолны судалгааны болон технологийн ном материалыг уншиж болно. Жон Роббинсын “Шинэ Америкийн хоол хүнс” гэдэг номыг уншаарай. Тэр бол мөхөөлдөсний үйлдвэрийн саятан, тун нэртэй хүн. Тэрээр веган хоолны төлөө бүхнээ орхин, гэр бүлийнхээ уламжлал болон бизнесийнхээ эсрэг веган хоолны тухай ном бичсэн. Тэрбээр их хэмжээний мөнгө, нэр хүнд, бизнесээ алдсан ч Үнэний төлөө энэ бүхнийг хийсэн юм. Тэр тун дажгүй ном.

Веган хоолны тухай, веган хоол нь хэрхэн дэлхийд энх тайвныг авчирч буй талаар өгүүлсэн олон бодит мэдээлэл, баримт бүхий бусад ном, сэтгүүл олон байдаг. Үхэр бордохын тулд хоол хүнсээ үрэн таран хийж буйг та нар харж буй биз ээ. Нэг үхэр хоолны ширээн дээр зоог болохын тулд хэчнээн их ууураг, эм, ус, хүн хүч, унаа хөсөг, зам тээвэр, ямар их газар гарздаж буйг та бүхэн мэдэж байгаа. Ойлгож байна уу? Эдгээр нөөцийг буурай хөгжилтэй орнуудад тэгш хуваарилсан бол өлсгөлөнгийн асуудлыг шийдэж чадах байсан. Хоол хүнсний хомсдолд орсон улс ард түмнээ аврахын тулд бусад улс орон руу түрэмгийлэл үйлдэж болзошгүй. Иймэрхүү байдал удаан үргэлжилбэл муу үр дагавартай. Ойлгож байна уу? "Үйл байвал үр байна.". Бид идэхийн төлөө бусдыг одоо хөнөөвөл хожим нь, эсвэл дараа төрөлдөө алуулж, тэдний хоол болно. Үнэхээр өрөвдөлтэй! Бид ийм ухаантай, соёл иргэншилтэй ч ихэнх маань хөрш орныхоо зовж зүдэрч буйг ойлгох чадваргүй байгаа нь ердөө л ходоодоо баярлуулах хэдхэн зүсэм махнаас болж байна. Ганц биеэ тэжээхийн тулд өчнөөн амь бүрэлгэж, олон хүнийг өлсгөдөг. Би энд амьтдын амь насны талаар дурдаагүй. Ойлгов уу? Санасан ч, санаагүй ч энэхүү гэм буруутай мэдрэмж нь бидний ухамсрын түвшнийг доош татаж, хорт хавдар, уушгины сүрьеэ, ДОХ зэрэг эдгэшгүй өвчтэй болгож байна. Яагаад танай Америкт хорт хавдрын өвчлөл хамгийн өндөр хувьтай байдаг вэ? гэж өөрсдөөсөө асуу. Учир нь америкчууд үхрийн махыг аль ч орноос илүү их иддэг. Яагаад Хятад болон бусад коммунист оронд хорт хавдраар өвчлөх нь бага байдаг вэ?. Энэ орнуудад мах олдох нь ховор. Ойлгож байна уу? Үүнийг би хэлээгүй судалгаа харуулж байгаа юм. Намайг бүү зэмлээрэй.

Асуулт: Веган хоолтон байснаар ямар ямар сүнслэг ашиг тусыг хүртэх вэ?

Их Багш: Сүнслэг ашиг тусыг сонирхож байгаад чинь баярлаж байна. Ихэнх хүн веган хоолны тухай асуухдаа хооллолт, эрүүл мэнд, галбир төрхөө л боддог. Цэвэр ариун бөгөөд хүч үл хэрэглэдэг нь веган хоолны сүнслэг ашиг тус юм. Эзэн Бурхан: "Амь бүү тасал." гэж бидэнд анхааруулахдаа зөвхөн хүний амийг хөнөөж болохгүй гээгүй. Аливаа төрөлтнийг бүү хөнөө гэсэн. Адгуус амьтдыг бидний анд нөхөр болгон туслуулахаар бүтээсэн гэдгээ хэлсэн шүү дээ. Тэрээр биднийг амьтдыг харж ханд гэсэн үг биш үү? "Тэдэнд анхаарал тавьж, харгалзан хамгаал." гэж хэлсэн. Та өөрийн ард иргэдээ захирч жолоодохдоо тэднийг алж иддэг үү? Тэгвэл хүрээлэх ардгүй хаан болно. Эзэн Бурхан яагаад

ингэж хэлснийг одоо та ойлгосон байх. Бид үүнийг эргэлзээгүй дагах ёстой. Эзэн Бурхан маш тодорхой хэлсэн ч Өөрөөс нь өөр хэн Түүнийг ойлгосон юм бэ?

Иймээс Эзэн Бурханыг ойлгоё гэвэл та өөрөө заавал Эзэн Бурхан болох ёстой. Та бүгдийг Эзэн Бурхантай эргэн нэгдэж, өөрийнхөө хосгүй эзэн болохыг хүсэж байна. "Эзэн Бурханд сүсэглэн залбирах" нь Түүнийг тахин шүтэх биш харин өөрөө Эзэн Бурхан болж Түүнтэй нэгдмэл гэдгээ ухаарах явдал юм. Есүс Христ: "Би бол Эцэгтэйгээ нэгдмэл нэг." гэж хэлээгүй гэж үү? Хэрвээ Есүс тэгж хэлсэн юм бол бид ч Эзэн Бурханы хүүхэд учраас Түүний Эцэгтэй мөн л нэгдмэл нэг. Тэгээд ч биднийг Түүний хийж байгаагаас илүү хийж чадна гэж Тэр хэлсэн. Бид Эзэн Бурханаас ч илүү сайн байх боломжтой.

Бид Эзэн Бурханы талаар юу ч мэдэхгүй юм бол яагаад Түүнийг тахин шүтэх ёстой гэж? Яагаад сохроор итгэх ёстой гэж? Бид юу шүтэж байгаагаа эхлээд мэдэх ёстой. Яг л гэрлэхээсээ өмнө сүйт бүсгүй маань ямар хүн болохыг заавал мэдэх хэрэгтэй байдагтай адил. Орчин үед болзохгүй бол гэрлэдэггүй болсон. Тэгвэл бид яагаад Эзэн Бурханыг сохроор шүтэх гэж? Өөрийгөө харуулж, таниулахыг Эзэн Бурханаас шаардах эрх бидэнд бий. Бид шүтэх Бурханаа сонгох эрхтэй. Веган хоол идэх ёстойг Библид тодорхой өгүүлсэн. Эрүүл мэндийн талаас үзвэл бид веган хоол идэх ёстой. Шинжлэх ухааны олон нотолгоогоор бид веган хоолтон байх ёстой. Эдийн засгийн талаасаа ч бид веган хоолтон байх ёстой. Энэрэл нигүүлслийн үүднээс ч бид веган хоолтон байх ёстой. Мөн гараг дэлхийгээ аврахын тулд бид веган хоолтон байх ёстой. Барууны орнууд болон АНУ-д хүмүүс долоо хоногт ганц удаа веган хоол идвэл жил тутам арван зургаан сая өлсөж буй хүнийг аврах боломжтойг нэгэн судалгаанд дурджээ. Иймээс Баатар болъё гэвэл веган хоол ид! Намайг дагаж энэ аргаар бясалгахгүй ч дээрх шалтгааны улмаас өөрийнхөө төлөө, дэлхий ертөнцийн төлөө веган хоол идэхийг та нараас хүсэж байна.

Асуулт: Бүх хүн ургамлаар хоолловол үр тарианы дутагдал үүсэх үү?

Их Багш: Үүсэхгүй. Хүнсний зориулалттай тариалангийн талбайгаас хооллож буй хүний тоог ийм хэмжээний талбайд тарьсан тэжээлээр тэжээгдсэн мал амьтны махаар хооллож болох хүний тоотой харьцуулахад өмнөх нь 14 дахин их. Нэг акр газарт тарьсан хүнсний ургамал 800 ккал илчлэг өгөх бөгөөд үүгээр мал амьтан тэжээж мах үйлдвэрлэвэл ердөө 200 ккал болдог учраас алдагдал нь 600 ккал болно. Үүнээс харахад ургамлын гаралтай

хоол хүнс нь махан хүнснээс эдийн засгийн илүү их үр ашигтай байна.

Асуулт: Веган хоолтон загас идэж болох уу?

Их Багш: Та идмээр байгаа бол ид. Харин та веган хоол идэх хүсэлтэй байвал загас бол ногоо биш.

Асуулт: Хүн сайхан сэтгэлтэй л байхад болно. Заавал веган хоолтон байх албагүй гэж хүмүүс байнга ярьдаг. Энэ үнэний хувьтай юу?

Их Багш: Хэрэв сайхан сэтгэлтэй бол юунд хамаг амьтны махыг идэх вэ? Амьтны зовлонг хараад идэж зүрхлэхгүй бол сайн. Мах идэх нь энэрэл нигүүлсэлгүй хэрэг байтал юунд сайхан сэтгэл ярина вэ? Их Багш Лиэньчи: "Амийг хороож, махыг идэгчийг ертөнцийн хэлээр догшин хэрцгий сэтгэл, хорон муу санааны туйл гэх бус уу? Сайхан сэтгэл хаана байна?" гэжээ.

Мэнзы: "Амьдыг нь мэдэх бол үхэхийг нь үзэж үл түвдэх, дууг нь сонссон бол махыг нь идэж үл түвдэх. Эрхэм хүмүүн хэмээгч нь гал тогооноос хол байгтун." гэжээ.

Хүн төрөлхтний билиг ухаан амьтдынхаас илүү. Хүмүүс элдэв янзын багаж хэрэгслээр амьтдыг арга мухардуулдгаас хорсож үхдэг. Дорой буурай амьтдыг дарлан доромжлогч нь эрхэм хүн гэгдэх эрхгүй. Амьтад алагдахдаа тун их айн цочирдож, уурлан хорсдогоос хорт бодис ялгаруулж махандаа шингээх бөгөөд идсэн хүнд муугаар нөлөөлнө. Үүний зэрэгцээ амьтны доогуур хэлбэлзэл биднийг доош татаж, оюуны хөгжилд муу нөлөө үзүүлдэг.

Асуулт: Махтай хольж чанасан ногоог идэж болох уу?

Их Багш: Болохгүй. Хэрэв хоолоо хоронд дүрээд идвэл хордох үү, үгүй юү? "Нирваан судар"-т Махакашьяпа Шагжамуни Буддагаас: "Бадар бариад махтай хольсон хүнс олбол идэж болох уу? Үүнийг яаж цэвэрлэх вэ?" гэхэд Будда: "Эхлээд ногоог нь махнаас ялгаж усаар угаагаад идэж болно." гэжээ. Үүнээс мах идэх нь бүү хэл, махтай хольсон ногоог ч угааж цэвэрлэхгүйгээр идэж болохгүй гэдэг нь тодорхой байна. Эндээс мөн Шагжамуни Будда болон түүний шавь нар бүгд цагаан хоолтон байсныг мэдэж болно. Гэтэл өглөгийн эзэд махаар өргөл өргөвөл идчихдэг байсан гэж Шагжамуни Буддаг гүтгэж байсан. Энэ бол үнэмшилгүй яриа бөгөөд ном судар бага уншсан, эсвэл агуулгыг нь буруу ойлгосонтой холбоотой. Энэтхэгчүүдийн ер гаруй хувь нь цагаан хоолтон болохоор шар хувцастай хүн бадар баривал тэдэнд зөвхөн цагаан хоол өгөх ёстойг бүгд мэддэг.

Тэгээд ч гэрт нь өргөл болгох мах байхгүй.

Асуулт: Шагжамуни Будда гахайн шийр идсэнээс гэдэс нь гүйлгэж өвдсөн гэж нэг багш ярихыг урьд нь сонссон. Энэ үнэн үү?

Их Багш: Огт үгүй. Шагжамуни Будда нэг зүйлийн мөөг идсэнээс болж нас нөгчжээ. Мөөгний нэрийг самгарди хэлнээс үгчлэн орчуулбал гахайн шийр гэсэн утгатай ч жинхэнэ гахайн шийр биш. Энэ нь нэгэн төрлийн жимсийг "Лунянь" (хятадаар луугийн нүд гэсэн үг) гэдэгтэй адил. Луугийн нүд гэх мэт махны нэртэй олон зүйл байдаг ч үнэндээ веган хүнс байдаг. Учир нь тэр мөөг гахайтай холбоотой болохоор самгардиар "Гахайн шийр" буюу "Гахайн баясал" гэдэг. Эртний энэтхэгт энэ мөөг ховор нандин, идээний дээд байсан тул чин сэтгэлтэй хүмүүс Шагжамуни Буддад өргөл болгодог байжээ. Энэ мөөг ил ургадаггүй тул олъё гэвэл түүнд дуртай хөгшин гахайг ашигладаг байв. Гахай мөөгийг үнэрээр нь олоод туурайгаараа ухаж гаргана. Иймээс л энэтхэгт түүнийг "Гахайн шийр" буюу "Гахайн баясал" гэж нэрлэдэг. Үнэндээ энэ хоёр нь нэг л мөөгний нэр. Харин хайнга орчуулснаас, бас уг домгийн агуулгыг гүнзгий сайн ойлгоогүйгээс хойч үеийнхэн Түүнийг мах иддэг байсан мэтээр ташаа ойлгоход хүрчээ. Энэ бол үнэхээр харамсмаар зүйл.

Асуулт: Зарим махсаг хүн бусдын бэлдсэн махыг авч иддэгээ зөвтгөж, өөрийгөө амьтны амь хөнөөгөөгүй гэдэг. Энэ зөв үү?

Их Багш: Энэ бол маш том алдаа. Мах иддэг хүмүүс байгаа учраас яргачид амьтан алдаг. "Ланкаватара" сударт Шагжамуни Будда: "Их билгээр үзвэл яргачдын ихэнх нь хүнд идүүлэхийн тулд амь хороодог. Хүн мах идэхгүй бол амь хороох явдалгүй болно. Тиймээс мах идэх нь амь хороохтой адил гэмт явдал мөн." гэжээ. Амьтны амийг ихээр хороосноос байгалийн гамшиг, хүний зовлон ихсэж байна. Дайн дажин дэгдэж байгаа нь ч асар их аллагын үйл лайнаас үүдэлтэй. (Эх сударт өгүүлсэн нь : "Их билгээр үзвэл аливаа аллагын ихэнх нь хүн мах иддэгээс болсон. Хүн мах идэхгүй бол аллага үгүй. Иймийн учир мах идэх хийгээд аллага үйлдэхийн ял адил болой.").

Асуулт: Ургамал нь шээсний хүчил, урокинез зэрэг хорт бодис үүсгэн хүний биеийг хордуулдаггүй ч пестицид (шавжийн хор) ихтэй тул биед сайнгүй гэж зарим хүн ярьдаг. Энэ үнэн үү?

Их Багш: Хэрэв тариалангийн талбайд пестицид болон ДДТ (dichlorodiphenyltrichloroethane) зэргийг хэрэглэсэн бол эдгээр нь асар хүчтэй хорт бодис бөгөөд хорт хавдар,

үргүйдэл, элэгний өвчин үүсгэдэг. ДДТ зэрэг нь өөх тосонд уусдаг тул амьтны өөхөнд хадгалагддаг. Та мах идэх үедээ дор хаяж 15 сар өөхөнд нь хуримтлагдсан өндөр концентрацитай пестицид болон бусад химийн хорт бодисуудыг хамт иддэг. Энэ ДДТ(dichlorodiphenyltrichloroethane) нь жимс ногоо, үр тарианд байх хэмжээнээс арван гурав дахин их байдаг. Ургамалд цацсан хорыг угаан цэвэрлэж болно. Харин амьтны өөхөнд хуримтлагдсан хорыг яаж ч угаасан арилахгүй. Пестицид болон бусад хорт бодисууд нь тасралтгүй хуримтлагдан ихэсдэг тул хүнсний үйлдвэрлэлийн эцсийн шатны хаан-хэрэглэгч хамгаас илүү хохирогч болдог. Айова муж улсын Их сургуульд хийсэн туршилтаар хүний бие дэх пестицидийн ихэнх нь мах идсэнээс болдгийг нотолжээ. Цагаан хоолтнуудын биед буй пестицидийн хэмжээ нь махан хоолтнуудын бие дэх пестицидийн хэмжээний талд нь ч хүрэхгүй байгааг илрүүлжээ. Үнэн хэрэгтээ маханд байгаа хорт бодис зөвхөн үүгээр тогтохгүй. Малыг тэжээх явцад маш олон химийн бордоо өгч өсөлтийг нь хурдасгах юм уу махны өнгө, амт, ширхэглэгийг сайжруулан, муудаж ялзрахаас хамгаалдаг.

Жишээ нь, нитратаас гаргаж авсан нөөшлөгч бодис нь асар хортой. 1971 оны 7-р сарны 18-ны өдрийн “Нью Йорк Таймс” сонинд “Хүнс хэрэглэгчдийн эрүүл мэндэд учирч буй асар том нуугдмал аюул бол сальмон загасны нян, пестицид, нөөшлөгч бодис, элдэв даавар, антибиотик болон бусад химийн бодисын үлдэгдэл зэрэг үл үзэгдэгч бохирдол юм.” гэж мэдээлжээ. Үүнээс гадна малд тарьсан өвчнөөс сэргийлэх вакцин маханд ч бас хадгалагддаг. Харин 56% хүртэлх усанд уусдаггүй бохирдолтой махан бүтээгдэхүүнийг бодвол ястай самар, буурцагт ургамал, үр тарианаас авч буй уураг нь илүү цэвэр юм. Дээрх хиймлээр гаргасан нэмэлт бодисууд нь хорт хавдар болон бусад өвчин, ургийн гаж хөгжлийн шалтгаан болдгийг судалгааны итгэлд дурджээ. Иймээс жирэмсэн эмэгтэйчүүд шинээр төрсөн хүүхдийн биеийн болон оюуны эрүүл мэндийг хамгаалъя гэвэл цэвэр веган хоол хүнс идэх хэрэгтэй. Та уургаа буурцагт ургамлаас, амин дэм болон эрдэс бодисоо ногоон өнгийн навчит ургамал болон жимс жимсгэнэ ахиу идсэнээр авна.

Авшиг хүртэхүй- Арьяабалын бясалгалын арга

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Үнэнийг таньж мэдэхийг чин сэтгэлээсээ эрмэлзэн тэмүүлж буй хүмүүст Арьяабалын бясалгалын аргыг авшгаар дамжуулан уламжилна. “Аялгуу ажих” гэдэг нь Хятадаар амарлин сууж аялгууны хэлбэлзлийг ажиглах гэсэн утгатай. Энэхүү бясалгалын аргад дотоодын “Гэрэл” болон “Аялгуу”-г ажих багтана. Эртнээс нааш дэлхийн шашнуудын болон бясалгалын ном сударт дотоодын ийм ахуй ойлголтыг олонтоо дурдсан байдаг. Тухайлбал, Христийн шашны “Библи”-д: “Түмэн бодис аялгуунаас үүссэн. Энэ аялгуу Эзэн Бурхантай хамт байсан. Аялгуу өөрөө Эзэн Бурхан байсан” гэжээ. (Иохан 1-р бүлгийн 1-р хэсэг) Энэхүү аялгуугаар дотоодын аялгууг заажээ. Мөн “Бурханы хэл”, “Шабд”, “Дао”, “Аялгууны урсгал”, “Ум”, “Тэнгэрийн хөгжим” гэж бас нэрлэдэг. Их Багш Чин Хай: “Тэрээр түмэн бодисын дотор хэлбэлзэн, бүхий л орчлон ертөнцийг тэжээн тэтгэдэг. Энэхүү дотоодын хэмнэл нь аливаа шархыг эмнэн, бүхий л хүсэл эрмэлзлэлийг хангаж, эгэл ертөнцийн элдэв дур хүслийг намжаана. Тэрээр бүхнийг чадагч бөгөөд хайраар бялхаж байдаг. Бид энэхүү аялгуунаас үүссэн болохоор түүнтэй холбогдвол сэтгэл ханаж амарлина. Энэхүү аялгууг сонссоноор бид бүхэлдээ хувирч, амь амьдралын тухай үзэл бодол маань үндсээрээ өөрчлөгддөг.” гэжээ.

“Билиг нээгдэх” гэдгээр дотоодын гэрэл- “Эзэн Бурханы гэрэл”-ийг хэлж байна. Гэрлийн хүч нь өчүүхэн багаас авахуулаад тоо томшгүй олон нарны гэрэл мэт хурц тод. Бид Бурханыг дотоодын гэрэл, аялгуугаар л таньж мэддэг.

Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх, авшиг хүртэх нь ямар нэг нууц ёслол үйлдэж буй, эсвэл шинэ шашинд орж буй хэрэг биш. Авшиг хүртэх үеэр гэрэл болон аялгуу ажихад онцгойлон анхаарах зүйлсийг зааж өгдөг. Хамгийн анхны ариун ахуй ойлголт чимээ аниргүйд бууж ирнэ.

Арьяабалын бясалгалын аргын хамгийн чухал хэсэг нь авшиг

уламжлах юм. Таны билгийн үүдийг нээхэд Их Багш Чин Хай өөрийн биеэр морилох шаардлагагүй. Гэхдээ Их Багшийн адислалгүй бол бясалгалын арга ач тусаа өгөхгүй. Авшиг хүртэх үед та тэр даруйдаа дотоодын аялгууг сонсож, дотоодын гэрлийг харна. Үүнийг "Агшнаа гэгээрэх" юм уу "Агшин зуур билиг нээгдэх" гэдэг.

Их Багш Чин Хай шашин шүтлэг, соёл уламжлалын ялгааг үл харгалзан авшиг хүртээдэг. Та шүтэж буй шашин, сүсэг бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таныг ямар нэгэн байгууллагад элсэхийг, эсвэл таны амьдралын одоогийн хэв маягт тохирохгүй аливаа үйл ажиллагаанд оролцохыг шаардахгүй.

Авшиг хүртэх нь ямар ч үнэ төлбөргүй.

Насаараа веган хоолтон байх нь авшиг хүртэх зайлшгүй нөхцөл болно.

Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр бясалгах, таван сахил сахих нь авшиг хүртсэний дараах цорын ганц шаардлага юм.

Сахил нь өөртөө болон өрөөлд хор хүргэхгүй байхад туслах хэм хэмжээ бөгөөд үүнийг сахиж бясалгавал авшгаар нээгдсэн билиг ухаанаа улам тэлсээр эцэст нь хамгийн дээд ухамсрыг олж Бурхан болно. Хэрэв өдөр бүр бясалгахгүй бол билиг нээгдсэнээ мартаж, ердийн ухамсрын түвшинд эргэж очдог.

Өөрөө бясалгал хийж төгс гэгээрэлд хүрэхийг бидэнд зааж сургах нь Их Багш Чин Хайн зорилго билээ. Иймээс Түүний зааж буй бясалгалын аргаар хэн ч бясалгаж болдог. Нэмэлт тусламжид түшиглэхгүйгээр өөрөө бясалган дадуулж болно. Тэрээр сүсэгтэн, бишрэн шүтэгч, шавь эрдэггүй, гишүүнчлэлтэй байгууллага байгуулж хугацаат татвар хураадаггүй. Их Багш Чин Хай сөгдөж мөргөхийг зөвшөөрөхгүй, мөнгө төгрөг, бэлэг сэлт хүлээж авахгүй учир өргөл барьц хэрэггүй. Тэр зөвхөн таны өдөр тутмын амьдрал болоод бясалгал дадалдаа өөрийгөө дэвшүүлэн богд гэгээнтэн болохыг хүсэх тэрхүү чин сэтгэлийг чинь л хүлээж авна.

ТАВАН САХИЛ

Аливаа амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ;*

Үнэн бус зүйл ярихыг цээрлэнэ;

Өөрийн бус юмыг авахыг цээрлэнэ;

Бэлгийн зүй бус харилцааг цээрлэнэ;

Согтууруулах, мансууруулах бодис, хорт зүйл хэрэглэхийг цээрлэнэ;**

* Энэ сахил нь веган хоолны дэглэмийг хатуу мөрдөхийг шаардана. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, шувууны мах, өндөг (өндөгтэй болон сүүтэй боов, чихэр, бялуу, жигнэмэг, зайрмаг гэх мэт) амьтны гаралтай аливаа хүнсийг хэрэглэж болохгүй.

** Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал: архи уух, тамхи, хар тамхи татах, мөрийтэй тоглоом тоглох, садар самуун, хүчирхийлэлтэй кино, зураг үзэх, ном, сэтгүүл унших, цахим тоглоом тоглох зэрэг аливаа хортой зүйлээс зайлсхийх багтана.

ВЕГАН ХООЛНЫ АЧ ТУС

Насан турш веган (ногоон) хоолтон байх буюу ургамал хоол хэрэглэх нь Арьяабалын Бясалгалын (Quan Yin Method) авшиг хүртэх тэргүүн нөхцөл юм. Ургамлын гаралтай зүйлсийг хүнсэнд хэрэглэж болох ч өндөг болон амьтны гаралтай аливаа хоол хүнсийг идэж болохгүй. Үүнд олон шалтгаан байдаг ч хамгийн чухал нь амьтны амь хороож болохгүй гэсэн нэгдүгээр сахил буюу амьтан бүү хөнөө гэдгээс үүдэлтэй.

Амь хороохгүй байх, бусад амьд биест хор хүргэхгүй байх нь тэдгээр амьтанд ач тустай нь яриангүй. Бусдад хор хөнөөл учруулахгүй байх нь бидэнд ач тустай болох нь тэр бүр илт харагддаггүй. Энэ нь "ямар үйл хийнэ, тийм үр байна." гэсэн үйл үрийн хуулиар зохицуулагддагаас тэр юм. Мах идэх шунал хүслээ хангахын тулд амьтны амь хөнөөх, эсвэл бусдаар амьтны амь хороолговол та амь насны төлөөсөнд унаж, хэзээ нэгэн цагт заавал төлөх ёстой болно.

Веган хоол идэх нь үнэндээ бидний өөртөө барьж буй бэлэг юм. Ингэснээр бид хураасан асар их үйлийн үрээ нимгэлж, амьдралын чанараа сайжруулан, өөрийгөө улам чөлөөтэй сайхнаар мэдрэх төдийгүй, дотооддоо нэвтэрч диваажингийн нууцлаг, шинэ содон зүйлсийг ч мэдрэх болно. Энэ бүхнийг та веган хоол идсэнээрээ хүртэж буй хэрэг. Зарим хүн сүнслэг үзэл бодлоор махнаас татгалзуулдаг нотолгоонд нь итгэдэг ч веган хоолтон байхыг хөхиүлэн дэмждэг өөр олон зайлшгүй учир шалтгаан бий. Эдгээр нь хүний эрүүл мэнд, хоол хүнсний шим тэжээл, байгаль экологи, ёс суртахуун, амьтдын зовлон, дэлхийн өлсгөлөн зэрэг асуудалтай холбоотой юм.

ЭРҮҮЛ МЭНД БА ХООЛ ХҮНС

Хүн төрөлхтний хувьслын түүхээс үзвэл манай өвөг дээдэс төрөлхийн цагаан хоолтон байжээ. Хүний бие махбодын бүтэц нь мах идэхэд зохицоогүй. Колумбын их сургуулийн доктор Г.С.Хантинген хүний биеийн бүтэц зүйн харьцуулсан судалгааны өгүүллээрээ үүнийг нотолсон байна. Тэрээр махчин амьтны нарийн, бүдүүн гэдэс нь богино байдгийг анзаарчээ. Махчин амьтны бүдүүн гэдэс шулуун бөгөөд гөлгөр байдаг. Харин мах иддэггүй амьтны нарийн, бүдүүн гэдэсний аль аль нь урт байдаг. Махан дахь эслэгийн агууламж бага, уургийн нягтрал ихээс шим тэжээлийг шингээхэд урт хугацаа шаардагддаггүй тул махчин амьтны гэдэс богино байдаг аж.

Төрөлхийн ургамлаар хооллогч бусад амьтны нэгэн адил хүн төрөлтний бүдүүн, нарийн гэдэс нь урт байдаг. Бидний гэдэсний нийт урт барагцаалбал 8.5 метр (28 фут), олон нугалаатай, хана нь хуниастай, гулгамтгай биш, махчин амьтны нарийн гэдэснээс урт тул идсэн мах гэдсэнд удаж ялзран хорт бодис ялгаруулдаг. Энэ нь шулуун гэдэсний хорт хавдар үүсэхтэй холбоотой төдийгүй элэгний ачааллыг ихэсгэж, элэгний хатуурал, элэгний хорт хавдар үүсэхэд хүргэнэ. Маханд ихээр агуулагддаг урокинез ууураг, шээсний хүчил нь бөөрний ачааллыг ихэсгэж, үйл ажиллагааг нь алдагдуулдаг. Хагас килограмм шарсан үхрийн маханд 14 грамм урокинез ууураг агуулагддаг. Амьд эсийг шингэн урокинез дотор хийхэд бодисын солилцоо нь алдагддаг байна. Маханд эслэг эд, ширхэглэг бодис бага байдаг бөгөөд эслэг бодис дутагдвал өтгөн амархан хатдаг. Өтгөн хатах нь шамбарам болон бүдүүн гэдэсний хорт хавдрыг үүсгэдэг.

Махан дахь холестерин, ханасан өөх нь зүрх судасны өвчин үүсгэдэг. Зүрх судасны өвчин нь америкчуудын нас баралтын шалтгааныг тэргүүлдэг бөгөөд өнөө үед Тайваньд ч мөн адил болжээ.

Хорт хавдар нь үхэлд хүргэж буй хоёр дахь том шалтгаан юм. Махыг шарж хайрахад метилхолантрен хэмээх химийн бодис үүсдэг. Энэ нь маш хүчтэй хорт хавдар үүсгэгч болохыг туршилтаар

нотолжээ. Нядалгааны газрууд мэргэжлийн байгууллагын хяналтад байдаг тул махны эрүүл ахуй асуудалгүй гэж ихэнх хүн үздэг. Үнэн хэрэгтээ нядалгааны газарт өдөр бүр маш олон үхэр, гахай, тахиа, нугас зэргийг алж худалддаг. Тэр бүхний хорт хавдартай эсэхийг нь нэг бүрчлэн шалгах бололцоогүй. Амьтан нэг бүрийг бүү хэл зүсэм махан дахь хавдрын эсийг нягтлах нь туйлын бэрхшээлтэй. Орчин үеийн махны үйлдвэрүүдэд амьтны толгой нь сэжигтэй бол толгойг нь, хөл нь өвчтэй бол хөлийг нь хаях маягаар өвчтэй хэсгийг салгаж бусдыг нь худалдаж байна. Ногоон хоолтон эмч, нэрт доктор Ж.Х.Келлог: "Бид веган хоол идвэл хоол хүнс маань ямар өвчнөөр үхсэн бол гэж санаа зовохгүй, айдасгүй амар тайван хооллоно!" гэжээ.

Өөр нэгэн санаа зовоож буй зүйл бол бордоо тэжээл, антибиотик болон өсөлт хурдасгах даавар, стеройд зэргийг агуулсан эм бэлдмэлийг амьтны тэжээлд холих буюу биед нь шууд тарьдаг явдал. Ийм мах идвэл эдгээр бодисууд хүний биед шингэдэг болохыг нийтэд мэдээлсэн байна. Махан дахь антибиотик нь хүмүүсийн эмчилгээнд хэрэглэж буй антибиотикийн үйлчилгээг бууруулах магадлалтай.

Зарим хүн веган хоол идэхэд шим тэжээл дутагдана гэж үздэг. Америкийн гэмтэл согогийн эмнэлгийн мэргэжилтэн, доктор Миллер Тайваньд дөч гаруй жил ажилласан бөгөөд эмнэлгийн ажилтан, өвчтөн цөмөөрөө веган хоол иддэг эмнэлэг байгуулсан байна. Тэрээр: "Орчин үеийн шинжлэх ухааны ачаар эм, эмнэлгийн шинжлэх ухаанд их дэвшил гарсан ч эм нь зөвхөн өвчнийг л анагаана. Харин хоол хүнс бол эрүүл мэндийг тэтгэнэ." гэжээ. Мөн тэрээр: "Ургамлаас авч буй шим тэжээл нь махныхыг бодвол бидэнд шууд хүрнэ. Учир нь амьтад ургамлаас шим тэжээлээ авдаг. Ихэнх амьтан нас богинотой, хүнд байдаг ихэнх өвчнийг тээдэг. Иймээс хүн төрөлтний өвчин эмгэгийн ихэнх нь өвчтэй малын мах идсэнээс үүсэлтэй байх магадлал тун өндөр. Хүн яагаад шим тэжээлээ ургамлаас шууд авдаггүй юм бэ?" гэжээ. "Үр тариа, буурцагт ургамал, хүнсний ногооноос хангалттай шим тэжээлээ авч эрүүл саруул байх бүрэн боломжтой." гэж Доктор Миллер үзсэн байна.

Амьтны уураг төгс, ургамлынх төгс бус учраас амьтны уураг ургамлынхаас илүү гэж олон хүн үздэг. Үнэндээ зарим ургамал төгс уурагтай. Хүнсний бүтээгдэхүүнүүдийг хооронд нь зөв харьцаагаар хольж төгс уураг үүсгэж болно.

Америкийн Хоол Судлалын холбооноос 1988 оны гуравдугаар сард "Шим тэжээлт чанарыг нь зохистой тохируулж чадвал веган хоол нь эрүүл мэндэд ашигтай, хангалттай шим тэжээлтэй." гэж

зарлажээ.

Мах иддэг хүмүүс веган хоолтнуудаас хүч чадалтай байдаг гэсэн төөрөгдөл түгээмэл байдаг. Йелийн их сургуулийн профессор Ирвинг Фишер 32 веган хоолтон, 15 махан хоолтон оролцсон туршилт хийхэд веган хоолтнууд нь илүү тэсвэр хатуужилтай байжээ. Туршилтад оролцогсдыг удаан хугацаагаар гарыг нь өргүүлэхэд үр дүн нь тун тодорхой байв. Мах иддэг 15 хүний 2 нь л арван таваас гучин минут өргөсөн бол веган хоолтон 32 хүний 22 нь арван таваас гучин минут, 15 нь хагас цаг, 9 нь нэг цагаас дээш, 4 нь хоёр цагаас дээш, нэг нь гурван цагаас дээш хугацаагаар өргөсөн байна.

Марафон гүйлтийн тамирчид тэмцээний өмнө веган болон цагаан хоол иддэг байна. Цагаан хоолоор эмчлэх мэргэжилтэн, эмч Барбара Море 200-гаад км зайг 27 цаг 30 минутад туулжээ. Тавин зургаан настай энэ эмэгтэй залуучуудын тогтоосон дээд амжилтыг эвдсэн байна. Тэрээр: “Веган хоолтон хүн эрүүл чийрэг, ухаан саруул, цэвэр ариун амьдралтай байдгийг харуулах жишээ байхыг би хүссэн юм.” гэжээ.

Веган хоолтон хоол хүнснээсээ хангалттай хэмжээний уураг авч чаддаг уу? Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөснөөр бид өдөр тутам авах илчлэгийнхээ 4,5 хувийг нь уургаас авч болно. Буудайн 17%, ногоон цэцэгт байцайны 45%, цагаан будааны 8%-ийн илчлэгийн эх үүсвэр нь уураг юм. Иймээс мах хэрэглэхгүй веган хоол идвэл хоол хүнснээсээ хангалттай уургийг амархан авч болно. Хүртэж болох өөр ач тус гэвэл өөх тос хэтрүүлснээс үүсдэг зүрх судасны өвчин, хорт хавдар зэргээс зайлсхийж чадна. Иймээс веган хоол идэх нь хамгийн зөв сонголт гэдэг нь илэрхий байна.

Зүрх судасны өвчин, хөхний болон шулуун гэдэсний хавдар, тархины саа өвчнөөр өвчлөх нь ханасан өөх тос ихээр агуулдаг мал амьтны гаралтай хүнсний хэт их хэрэглээтэй холбоотой нь батлагдаад байна. Тос багатай веган хоол идсэнээр бөөрний чулуу, булчирхайн хавдар, чихрийн шижин, арван хоёр нугалаа гэдэсний шархлаа, цөсний чулуу, ходоодны архаг үрэвсэл, үе мөчний үрэвсэл, буйлны өвчин, батга, нойр булчирхайн хавдар, ходоодны хавдар, цусан дахь чихрийн хэмжээ багасах, өтгөн хатах, дивертикулит, цусны даралт ихсэх, яс сийрэгжих, өндгөвчний хавдар, шамбарам, хэт таргалалт, багтраа зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлж, явцыг нь сааруулж тэр ч байтугай эмчилж болно.

Тамхийг эс тооцвол хүний эрүүл мэндийг мах шиг хохироож байгаа зүйл байхгүй байна.

ЭКОЛОГИ БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

Мах идэхийн тулд мал амьтан тэжээх нь дараах хор уршигтай. Үүнд: ширэнгэн ойг сүйтгэх, дэлхийн дулаарал, усны бохирдол, усны нөөц хомсдол, цөлжилт, эрчим хүчний гарздал болон дэлхийг хамарсан өлсгөлөн зэрэг болно. Газар, ус, эрчим хүч, хүний нөөцийг мах боловсруулахад ашиглаж байгаа нь дэлхийн нөөц баялгийг үр ашиггүй зарцуулж байгаа хэрэг юм.

1960-аад оноос Төв Америкт үхрийн бэлчээрт зориулан халуун бүсийн ойн 25 орчим хувийг шатааж устгасан байна. Тооцоолсноос үзэхэд шатааж устгасан 5 метр квадрат ой тутмаас 115 грамм бургерын мах үйлдвэрлэжээ. Үүнээс гадна үхэр тэжээхэд ихээр ялгардаг гурван төрлийн хорт хий нь дэлхийн дулаарлыг ихэсгэдэг. Мөн 450 грамм үхрийн мах үйлдвэрлэхэд 9117 литр ус зарцуулдаг нь үнэхээр цОчироордмоор. Гэтэл 450 грамм улаан лооль ургуулахад ердөө 107 литр ус, тийм хэмжээний цагаан талх үйлдвэрлэхэд 514 литр ус хэрэглэдэг. АНУ хэрэглээний усныхаа тэн хагасыг тэжээл бордоо тарих, үхэр тэжээх болон бусад мал амьтны хэрэгцээнд зарцуулж байна.

Үхэр бордоход хэрэглэж байгаа нөөц баялгаар үр тариа үйлдвэрлэж, дэлхийн хүн амыг хангавал маш олон хүн идэх хоолтой болох сон. Хэрэв нэг акр газарт овъёос тарьж малд биш хүмүүсийн хүнсэнд хэрэглэвэл махныхаас 8 дахин их ууураг, 25 дахин их илчлэг өгнө. Нэг акр газарт тарьсан ногоон цэцэгт байцаа (брокколи) нь ийм хэмжээний газраас гаргаж авсан үхрийн махнаас 10 дахин их ууураг, илчлэг, ниацин өгдөг. Иймэрхүү тоо баримт маш их. Мал амьтан тэжээж буй газарт хүнсний таримал таривал дэлхийн нөөц баялаг илүү үр ашигтайгаар зарцуулагдана.

Веган хоол танд энэ гараг дээр “өр төлөөсгүй амгалан амьдрах” боломж олгоно. Зайлшгүй чухал зүйлээ хэрэглээд, амь хороохоо багасгаж, хоолноос минь болж амьтны амь сүйдээгүй гэж бодохоор таны сэтгэл амар байх болно.

ДЭЛХИЙН ӨЛСГӨЛӨН

Дэлхийн бөмбөрцөг дээр нэг тэрбум орчим хүн өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдлаас шаналан зовж байна. Жилд 40 сая хүн өлсөж үхэж байгаагийн ихэнх нь хүүхэд юм. Гэтэл үүнийг үл харгалзан дэлхийн үр тарианы гуравны нэгийг хүмүүсийн хоол хүнсэнд бус, мал аж ахуйн хэрэгцээнд зориулж байна. АНУ-д үйлдвэрлэсэн үр тарианыхаа 70%-ийг малын тэжээлд хэрэглэж байна. Хэрвээ бид энэ үр тариагаар хүмүүсийг хоолловол хэн ч өлсөхгүй.

АМЬТНЫ ЗОВЛОН ЗҮДҮҮР

Америкийн Нэгдсэн Улсад өдөр бүр 100 гаруй мянган үхэр нядалдгийг та бүхэн харсан уу?

Өрнөдийн орнуудад ихэнх мал амьтныг “үйлдвэржсэн аж ахуй”-д тэжээж байна. Эдгээр фермүүд бага зардлаар олон мал амьтдыг нядлахаар тооцоолж баригдсан байдаг. Мал амьтныг зайгүй чихэлдсэн тун хэцүү орчинд байлгаж, тэдэнд, тэжээлийн мах бэлтгэдэг машин мэтээр хандаж байна. Бидний ихэнх нь бодит байдлын үнэн төрхийг өөрийн нүдээр хэзээ ч олж хараагүй. “Чи нядалгааны газар нэг л очвол насаараа веган хоолтон болно.” гэсэн үг байдаг.

Лев Толстой: “Нядалгааны газар байгаа цагт дайны талбар байсаар байх болно. Цагаан хоол бол хүнлэг энэрэнгүй чанарын өндөр шалгуур юм.” гэжээ. Бидний ихэнх нь амьтны амийг санаатайгаар хөнөөдөггүй ч нийгмийн зуршлаа дагаад байнга мах иддэг дадалтай болсон бөгөөд идсэн амьтанд ямар хор хөнөөл учруулснаа үнэндээ ойлгодоггүй.

ГЭГЭЭНТНҮҮД БА ҮЙЛС НЭГТНҮҮД

Хүн төрөлхтний тэмдэглэж үлдээсэн эртний түүхээс үзэхэд ургамал нь хүн төрөлхтний байгалиас заяасан хоол хүнс байжээ. Эрт үеийн Грек болон Еврейн домог үлгэрт хүмүүс анхнаасаа жимс жимсгэнэ иддэг байсныг өгүүлдэг. Эртний Египетийн билиг ухаант хуврагууд хэзээ ч мах иддэггүй байв. Грекийн агуу их философичид жишээ нь, Платон, Диоген, Сократ нар цагаан хоол идэхийг шийдвэртэй дэмждэг байв.

Энэтхэгт Шагжамуни Будда “Ахимса” буюу аливаа амьтанд хор хөнөөл учруулахгүй байхыг чухалчлан тэмдэглэж, амьтдыг айдаст автуулахгүйн тулд мах идэхгүй байхыг шавь нартаа дахин дахин анхааруулж байв. Будда: “Мах идэх нь ердөө л олдмол зуршил төдий. Бид мах идэх хүсэлтэй төрөөгүй. Мах идвэл их нигүүлслийн үр тасарна. Мах идэгчид бие биеэ алж иддэг. Энэ төрөлд би чамайг, дараа төрөлд чи намайг иднэ гэхчлэн хэзээ ч таслах аргагүй. Ийм хүн яаж гурван ертөнцийг гэтлэх вэ?” гэж өгүүлжээ.

Эрт үеийн Дао, Христ, Еврейн шашны олон лам хуврагууд цагаан хоолтон байжээ. Энэ талаар Библид тун тодорхой тэмдэглэсэн байна. Эзэн Бурхан: “Би та нарыг идэг гэж элдэв зүйлийн жимс, төрөл төрлийн үр тариа өгөв. Харин хээрийн амьтад болон бүх шувуудын хоол тэжээл болгож, өвс ногоо, навчит ургамлыг өглөө.” гэж (Genesis, 1:29) Ариун Библид өгүүлжээ. Библид мах идэхийг цээрлэсэн өөр нэг жишээ нь гэвэл: “Амьтны мах, цусыг идэх ёсгүй. Цус амьтай.” гэсэн үг юм. (Genesis, 9:4) Эзэн Бурхан: Хэн та нарыг энэ эр үхэр, эм ямааг алж, надад тахил өргө гэсэн юм бэ? Намайг мөргөл залбирлаа сонсоосой гэж байгаа бол гэмгүй амьтны цуснаас өөрийгөө цэвэрлэгтүн. Тэгэхгүй бол би та нараас нүүр буруулна. Яагаад гэвэл та нарын гар нэлдээ цустай байна. Надаар өршөөж уучлуулахын тулд гэм нүглээ наманчил.” (Isaiahl: 11-16) гэж хэлжээ. Есүсийн шавь нарын нэг Гэгээн Павел Ромчуудад илгээсэн захидалдаа: “Мах идэхгүй, дарс уухгүй байх нь аль аль нь сайн хэрэг.” гэсэн байдаг. (Ромчуудад

илгээсэн захидал, 14:21).

Саяхан түүхчид Есүсийн амьдрал болон сургаалыг шинээр тодруулсан олон эртний судар ном олж илрүүлсэн байна. Есүс: "Амьтны мах иддэг хүмүүс өөрсдийнхөө булш нь болдог. Та нарт үнэнээр нь хэлэх юм бол алж хөнөөж байгаа хүн өөрөө алагдах болно. Амьд амьтныг хөнөөж, махыг нь идэж буй хүн бол үхдэл хүүрийн мах идэж байгаа хэрэг юм." гэжээ.

Энэтхэгийн шашнууд ч бас мах идэхийг цээрлэдэг. Энэ нь "Хүн амьд амьтныг хөнөөхгүйгээр махыг нь идэж чадахгүй. Амьд амьтныг зовоож тарчлааж буй хүнийг Эзэн Бурхан хэзээ ч адислахгүй. Тийм учраас мах идэхийг цээрлэ!" (Энэтхэг шашны сахил).

Исламын Ариун судар Коранд: Үхсэн амьтны мах, цусыг идэхийг хориглосон байдаг.

Хятадын агуу их Зэн Багш Хань Шань-Зу мах идэхийг эрс эсэргүүцсэн найраглал туурвиж: "Эхнэр хүүхдээ тэжээхээр зах зээлээс мах, загасхан худалдан авах гэж яарах хэрэг юун. Таны амьдралыг тэжээж тэтгэхийн төлөөнөө эдний амь тасрах заавал албатай юу? Ингэхийн утга учир алга. Энэ нь таныг диваажинд хүргэхгүй, харин тамын хог новш болгоно!" хэмээжээ.

Маш олон алдарт зохиолч, урлаачид, эрдэмтэн, гүн ухаантан, гарамгай хүмүүс цагаан хоолтон байжээ. Үүнээс жишээ болгон цөөхнийг дурдвал: Шагжамуни Будда, Есүс Христ, Вергилий, Гораций, Платон, Овидий, Петрарка, Пифагор, Сократ, У.Шекспир, Вольтер, И.Ньютон, Леонардо Да Винчи, Чарльз Дарвин, Бенжамин Франклин, Ральф Уолд Эмерсон, Хенри Дэйвид Торо, Эмиль Золя, Бертран Рассель, Ричард Вагнер, П.Б.Шелли, Х.Ж.Уэллс, Алберт Эйнштейн, Рабиндранат Тагүүр, Лев Толстой, Жорж Бернард Шоу, Махатма Ганди, Алберт Швейцер болон орчин үеийнхнээс цөөхнийг дурдах юм бол Пол Ньюмен, Мадонна, Диана гүнж, Линдсей Вагнер, Пол Маккартни, Кандис Берген нар цагаан хоол идэх ёсыг зориг төгс сайшаан дагаж байв.

Алберт Эйнштейн хэлэхдээ: "Миний бодлоор бол цагаан хоолны улмаас хүний зан чанарт гардаг өөрчлөлт, ариусгах нөлөө нь хүн төрөлхтөнд ихээхэн ашигтай юм. Иймээс хүмүүс цагаан хоол идэхийг сонгох нь буян хишигтэй болоод амар амгалан хоёр талтай юм." гэжээ. Энэ бол хүн төрөлхтний түүхэн дэх сод гарамгай, сэцэн мэргэн олон хүний номлосоор ирсэн сургаал билээ.

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр

Англи (1-5), Ау Лак (1-15), Герман (1-2), Индонез (1-5), Испани (1-3), Монгол (1-10), Польш (1-2), Солонгос (1-11), Португал (1-2), Тай (1-6), Төвөд (1), Унгар (1), Фин(1), Франц (12), Хятад (1-10), Швед (1), Япон (1-4)

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Асуулт Хариулт

Англи (1-2), Ау Лак (1-4), Болгар (1), Герман (1), Индонез (1-3), Монгол (1-2), Орос (1), Польш (1), Португал (1), Солонгос (1-4), Унгар (1), Франц (1), Хятад (1-3), Чех (1), Япон (1)

Багш болон сүнслэг бясалгагчдын захидлууд

Англи (1), Ау Лак (1-2), Испани (1), Хятад (1-3)

Багштайгаа өнгөрүүлсэн гайхамшигт мөчүүд

Ау Лак (1-2), Хятад (1-2)

1992 онд Сан Ди Мун-д болсон 7 хоногийн даяан бясалгал / тусгай хэвлэл

Англи (1), Ау Лак (1)

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 1993 онд Дэлхий даяар ном дэлгэрүүлсэн аялал

Англи (1-6), Хятад (1-6)

Их Багшийн ярьсан үлгэр түүх

Англи (1), Ау Лак (1), Испани (1), Монгол (1), Солонгос (1), Тай (1), Хятад (1), Япон (1)

Эзэн Бурхан ба хүн төрөлхтний үлгэр - Библийн үлгэрүүдээс

Англи, Ау Лак, Хятад

Эзэн Бурхантай шууд холбогдох - Энх тайванд хүрэх зам

Англи, Ау Лак, Хятад

Амьдралаа солонгоруулъя

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Эрүүл мэндээ ухаарахуй Жам ёсны зөв амьдралын хэв маягт эргэн орохуй

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Гэрт чинь хүргэж өгөхөөр би ирлээ
Англи, Араб, Ау Лак, Болгар, Герман, Грек, Индонез, Итали, Испани, Монгол, Орос, Польш, Румын, Солонгос, Турк, Унгар, Франц, Хятад, Чех

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд- Бурхан бүхнийг зохицуулдаг

Англи, Ау Лак, Монгол, Солонгос, Хятад, Франц, Япон

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч хошигнол - Таны гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна!

Англи/Хятад (ном + CD)

Онч мэргэн үгс (1)

Англи (1), Хятад (1), Испани/Португал, Франц/Герман, Англи/Солонгос, Англи/Япон

Онч мэргэн үгс (2)

Англи (1), Хятад (1)

Тэнгэрлэг зоог - Олон улсын цагаан хоолны гал тогоо

Англи/Хятад, Ау Лак, Япон

Тэнгэрлэг зоог – Гэрийн хоолны амтат сонголт

Англи/Хятад

Диваажингийн урлаг

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Жинхэнэ хайр

Англи, Хятад, DVD, MP4

Ая эгшгээр амгалан дэлхийг бүтээхүй (тусгай хэвлэл)

Англи/Ау Лак/ Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог

Англи/Ау Лак/Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог -Уран зургийн цувралууд

Англи (1), Хятад (1)

Тэнгэрийн хувцас

Англи/Хятад

Шувууд миний амьдрал

Англи, Ау Лак, Араб, Герман, Индонез, Монгол, Солонгос, Орос, Франц, Хятад

Миний амьдрал дахь нөхөд

Ау Лак, Хятад, Англи, Япон, Солонгос, Испани, Польш, Герман, Монгол

Эрхэм ариун амьтад

Англи, Ау Лак, Герман, Монгол, Солонгос, Франц, Хятад

ШҮЛГИЙН ЦОМИРЛОГ

Аниргүй нулимс

Англи, Ау Лак, Хятад, Герман, Франц, Испани, Португал, Солонгос, Монгол, Филиппин

Вуузуу шүлгүүд

Англи, Ау Лак, Хятад

Мартагдсан дурсамж

Англи, Ау Лак, Хятад

Хайрга ба Алт

Англи, Ау Лак, Хятад

Эрвээхэйн мөрөөдөл

Англи, Ау Лак, Хятад

Өмнөх амьдралын зам мөр

Англи, Ау Лак, Хятад

Эрт дээр үе

Англи, Ау Лак, Хятад

Эрин зууны хайр

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Аниргүй нулимсыг хайрлахуй

Англи, Монгол, Хятад, CD, DVD, MP4

Амьдрал болоод ухамсрын тухай бодрол:

Доктор Янезын бичсэн ном, Хятад хэл дээр

Хямралаас энх тайванд: Шийдэл нь Органик веган зам мөр

http://crisis2peace.org хаягаар олон хэл дээр үнэ төлбөргүй унших болон татаж авна уу.

Дээрх номууд үргэлжлэн хэвлэгдсээр байна.

Бусад айлдварууд болон дууны DVD, MP3, MP4, CD-ны цувралууд Араб, Армен, Ау Лак, Болгар, Камбож, Кантон, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Болгар, Англи, Фин, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Монгол, Непал, Норвег, Перс, Филлипин, Польш, Португал, Румын, Орос, Шри Ланк, Словени, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэлээр хэвлэгджээ.

БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ?

Шуудангийн хайрцаг 9, Шихү, Миаоли, Формоса (36899)
Шуудангийн хайрцаг 730247, Сан Хосе, Калифорни 95173-0247, АНУ

Суприм Мастер Телевиз

И-мэйл: Peace@SupremeMasterTV.com

Утас: 1-626-444-4385

Факс: 1-626-444-4386

Ном орчуулгын алба:

И-мэйл: divine@godsdirectcontact.org

(Та Их Багшийн номыг олон хэл дээр орчуулах ажилд оролцож болно.)

Мэдээний алба:

И-мэйл: lovenews@godsdirectcontact.org

S.M. Celestial Co., Ltd:

И-мэйл: smclothes123@gmail.com;
Vegann@@hotmail.com

Утас: 886-3-4601391

Факс: 886-3-4602857

Веб сайт: http://www.smcelestial.com
http://www.sm-celestial.com

Сүнслэг асуулт хариултын баг:

И-мэйл: lovewish@godsdirectcontact.org

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани

И-мэйл: smchbooks@godsdirectcontact.org

Утас: 886-2-23759688

Факс: 886-2-23757689
http://www.smchbooks.com

Онлайн дэлгүүр

Celestial Shop: http://www.theCelestialShop.com (Англи)
Eden: http://www.EdenRules.com/ (Англи, Хятад)

Цэвэр веган бүтээгдэхүүний онлайн дэлгүүр

http://www.lovingfood.com.tw

"Loving Hut" Олон Улсын Веган Хоолны Сүлжээ ресторан

И-мэйл: service@lovinghut.com
Утас: 886-3-4683345
Факс: 886-3-4681581
Веб сайт: http://www.lovinghut.com/tw/

Гуань Инь веб сайтууд:

Бурхантай шууд холбогдох- Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт хаяг:

http://www.godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm

Энэхүү хаягаар дэлхийн олон хэл дээрх Арьяабалын бясалгалын вэб хаягуудыг олж авахаас гадна 24 цагийн интернэт телевиз болох Суприм Мастер Телевиз болон Урлагийн Ертөнцөөр Аялахуй нэвтрүүлгийг үзэх боломжтой.

Мөн олон орны хэл дээр "Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр" үлгэр дэвтрийг татаж авч болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн мэдээ сэтгүүлийг цахим хэлбэрээр татаж авах болон унших боломжтой.

Суприм Мастер Телевиз

Суприм Мастер Телевиз нь бүтээлч хөтөлбөрүүдийг нэвтрүүлдэг суваг бөгөөд танд сүнслэг дэвшлийг авчирч, амьдралд тань цоо шинэ өнгө төрхийг бэлэглэх болно.

Суприм Мастер Телевизийг 24 цагийн турш онлайнаар үзэх хаяг:

http://suprememastertv.com/mn1/

Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр (үлгэр дэвтэр)-г олон хэл дээр үнэ төлбөргүй татаж авах хаяг (80 орны хэл дээр)

http://sb.godsdirectcontact.net

Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр-1

Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Хэвлэж түгээсэн газар: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани

Хаяг: БНХАУ, Формоса, Тайбэй хот, Жонгжэнг дүүрэг, Жонгсьаогийн баруун зам, 1-р мухар гудам, 16 давхар барилгын 8-р давхар, 72 тоот

Утас: 886-2-23759688

Факс: 886-2-23757689

И-мэйл : smchbooks@Godsdirectcontact.org

http://www.smchbooks.com

Шуудангийн дугаар: 19259438

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 1987~2019

Зохиогчийн эрх: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Энэхүү номын агуулгыг дахин хэвлүүлэх нээлттэй бөгөөд, үүний тулд эхлээд хэвлүүлж түгээсэн компаниас зөвшөөрөл авах ёстойг анхаарна уу.

1 дүгээр боть

Хэвлэсэн хугацаа: 1998 оны 10-р сар
Дахин хэвлэл: 2005 оны 7-р сар
Хялбарчилсан хятад хэлний дахин хэвлэл: 2010 оны 12-р сар
Хялбарчилсан хятад хэлний хөндлөн бичсэн хэвлэл: 2015 оны 8-р сар

Энэхүү хувилбарыг монгол хэлнээ орчуулсан 2019 оны 1-р сар

Цахим хувилбар:http//www.gegeerel.mn/ 2019 оны 4-р сар

Хоёр дахь цахим хувилбар: 2023 оны 10-р сар

Гурав дахь цахим хувилбар: 2026 оны 10-р сар

Та бүхэн номын талаархи санал сэтгэгдлээ Mon.nomiinbag@gmail.com хаягаар ирүүлнэ үү.

Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр
Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай - Дахин хэвлэл-
Тайбей хот: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон Улсын Нийгэмлэг, 1997 “Тайваний он тооллоор 86”
1 –р боть; 13x19 см
ISBN 978-957-98468-1-3 (Боть 1: Хатуу хавтастай)
1. Сүнслэг дадал бясалгал 192.1
2. Оюун санааны амьдрал 86014160

Энэ дэлхийд залран буй Төгс гэгээрсэн Их багштай учрахад хэцүү, жинхэнэ дээд номыг хүртэхэд бэрх гэдгийг үнэнийг эрж хайсан бидний бэрхшээлт замнал гүнзгий ухааруулсан юм. Арьяабалын бясалгалын арга нь эртний жинхэнэ багш нараас уламжлагдан ирсэн охь дээд номын дамжлага мөн учраас хүмүүний мөн чанарын билиг билгүүнийг сэрээж, үнэн ёсыг ухааруулж чадна. Энэхүү номын ёсоор бясалгаад бид хэмжээлшгүй их ач тусыг хүртсэн тул бидний багш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн олон оронд айлдсан дээдийн номын айлдваруудыг эмхэтгэж, энэ төрөлдөө сансрын хүрднээс ангижрахыг хүссэн, жинхэнэ үнэн номыг хайсан, үхэж төрөх, бясалгал, гэгээрэл, үнэн мэдлэгийн тухай асуултууддаа хариулт эрж буй хүмүүст туслахыг зорин энэхүү номыг өргөн барьж байна.